2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс э дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

999 оны 1 дүгээр
арын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 45 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 45 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

"1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Төрийн мэдээлэл" эмхтгэлд албан ёсоор нийтэлнэ.

2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг өвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан сны эхийг баримтлах бөгөөд иймхүү дамжуулан ийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ."

2/46 дугаар зүйл:

"46 дугаар зүйл."Төрийн мэдээлэл" эмхтгэл

."Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их урлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, асгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн тайлаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ. Энэхүү эмхтгэлийг Улсын Их Хурлын Тамгын газар долоо хоног тутам гаргана.

2."Төрийн мэдээлэл" эмхтгэлийг хэвлэн нийтлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь тус эмхтгэлийн эрхлэгч байж, түүнийг хэвлэн нийтлэх хугацаа, журмыг тогтооно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 1 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

999 оны 1 дүгээр
арын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн эцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож эгтэвэр тогтоохоо." гэсний дараа "Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно." гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

999 оны 1дүгээр
арын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦААГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим бараанд ногдуулах кспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай уульд нэмэлт оруулах тухай 1999 оны 1 дүгээр арын 8-ны өдрийн хуулийн 2 дугаар зүйлд "1 дүгээр арын 15" гэснийг "2 дугаар сарын 15" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

КАЗИНО БАЙГУУЛАХ, АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаат хот

КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 **дүгээр зүйл.** Казиногийн тухай 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаат хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, мөн зүйлийн 13 дахь хэсгийн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаат хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 1 дүгээр зүйлд "болон зарим үйл ажиллагаанд" гэснийг,

3 дугаар зүйлд "болон Казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа" гэснийг,

4 дүгээр зүйлийн гарчигт "үйл ажиллагаа" гэснийг, мөн зүйлийн 1 дэх хэсэгт "болон үйл ажиллагаа" гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

99.оны 1 дүгээр
рын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТАН БУУГДСАН "АРДЫН ЭРХ", "ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татан буугдсан "Ардын эрх", асгийн газрын мэдээ" сонины тус бүрийн өмчлөлд йсан хөрөнгийн үндсэн дээр шинээр хувьцаат мпаниуд үүсгэн байгуулж тэдгээрийн хувьцааг далдах замаар хувьчилж, тус бүрийн хувьцааны чин хувийг "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" нинд ажиллаж байсан ажиллагсдад нь давуу хэзр буюу хувьцааны доод үнээр, үлдэж байгаа вьцааг хязгаартай буюу сонин, хэвлэл эрхлэн ргадаг хуулийн этгээд, иргэдэд дуудлага далдаагаар худалдах замаар хувьчилсугай.

2 дугаар зүйл. Иргэний хууль, Нөхөрлөл, компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актад энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

99 оны 1 дүгээр
рын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн техник тусламжааны элийн талаар Монгол Улсын Засгийн газар, лхийн банкны хооронд 1998 оны 10 дугаар сарын ны өдөр байгуулсан Хөгжлийн Зээлийн Гэрээг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

99 оны 1 дүгээр
рын 22-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын дээ" сонины өмчийг хувьчлах тухай хууль тлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их рлаас **ТОГТООХ нь:**

1.Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын дээ" сонины өмчийг дээрх хуульд заасны дагуу энэ ы 4 дүгээр сарын 1-ний дотор хувьчлахыг Засгийн ар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

2."Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонины ч хөрөнгийн байдлыг 1998 оны 12 дугаар сарын ний байдлаар тогтоон шалгаж дүнг 1999 оны 4 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг Төрийн хянан шалгах хороо /Л.Жавзмаа/-д даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /Д.Баттулга/-д даалгасугай.

4. Энэ тогтоолыг Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонины өмчийг хувьчлах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 08** **Улаанбаатар хот**

Хөтөлбөрийн төсөл боловсруулах тухай

Зарим барааны ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай 1999 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Модны чиглэлийн аж ахуйн нэгжүүдийн үндэсний үйлдвэрийг сэргээх, энэ чиглэлээр байгуулагдсан хот, тосгоны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд 1999 оны 1 дүгээр улиралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 09** **Улаанбаатар хот**

Дүрмүүдийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Монголын үндэсний радио, телевизийн Удирдах зөвлөлийн дүрэм, Монголын үндэсний телевизийн дүрэм, Монголын үндэсний радиогийн дүрэм, Монголын үндэсний радио, телевизийн техникийн төвийн дүрэм, Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн дүрмийн төслүүдийг дахин боловсруулахаар төсөл санаачлагчид нь буцаасугай.

2. Дээрх дүрмүүдийн төслийг 1999 оны 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж ажлыг зохион байгуулахыг Төрийн байгууламжийн байнгын хороо /Д.Баттулга/-нд даалгасугай.

ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас тарган.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

329612, 322838
Индекс 14503

Тор, Засгийн Үйлчилгээ аж ахуй
эрхлэх газрын харьяа хэвлэх
үйлдвэрт 3155 ш хэвлэв.

327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

аанбаатар хот | 1999 оны хоёрдугаар сарын 8 | № 6 (85)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

66. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай — *Дугаар 11* 102

67. Л. А. Пучков, В. Н. Попов, В. И. Истомин нарыг <<Найрамдал>> медалиар шагнах тухай — *Дугаар 12* 102

68. Петрос Аклилуг <<Найрамдал>> медалиар шагнах тухай — *Дугаар 13* 103

69. Зарим хүнд дипломат цол олгох тухай — *Дугаар 14* 103

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

70. Төрийн өмчит компанийг татан буулгах тухай — *Дугаар 1* 103

71. Улсын эталон батлах тухай — *Дугаар 2* 104

72. Журам батлах тухай — *Дугаар 4* 104

73. Эрүүл ахуй, халдвар судлалын болон эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын улсын хяналтын дүрэм шинэчлэн батлах тухай — *Дугаар 5* 124

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

9 оны 1 дүгээр ын 22-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Исланд Улсад суух суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэдэнжавын ажлаас чөлөөлсүгэй.
баатарыг тохоон томилсугай.
2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Ишүгийн рбалыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Исланд Улсад

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

9 оны 1 дүгээр ын 25-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

Л. А. Пучков, В. Н. Попов, В. И. Истомин нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх, тэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа нэмрийг нь үнэлж ОХУ-ын Москвагийн уулын их уулийн дор дурьдсан хүмүүсийг "Найрамдал" алиар шагнасугай.

эв Александрович — ОХУ-ын Москвагийн уулын их
учков — сургуулийн ректор

2. Владислав Николаевич Попов — Мөн сургуулийн багш
3. Виктор Владимирович Истомин — Мөн сургуулийн тэнхмийн эрхлэгч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 13 Улаанбаатар хот

Петрос Аклилуг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсад ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэхэд оруулж ирсэн хувь нэмрийг нь үнэлж Дэлхийн банкны хөдөөгийн хөгжлийн секторын ахлагч Петрос Аклилуг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

Зарим хүнд дипломат цол олгох тухай

Монгол Улсын гадаад харилцааны салбарт үр бүтээлтэй ажиллаж, улс орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин цол олгосугай.

1. Булгаагийн Алтангэрэл - Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
2. Дагвын Цахилгаан - Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
3. Тойтогийн Төмөрхүлэг - Гадаад харилцааны яамны Мэдээлэл, мониторингийн газрын ахлах мэргэжилтэн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Дугаар 1 Улаанбаатар хот

Төрийн өмчит компанийг татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний нисэх "Тас" компанийг татан буулгасугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан татан буугдсан компанийн эд хөрөнгө, үйл ажиллагаатай холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээг зохих хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд, Иргэний агаарын тээвэ удирдах газрын дарга М.Дагва нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦР

Хөдөө аж ахуй, үйлдвэр, Дэд бүтцийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр | Дугаар 2 | Улаанбаатар хот

Улсын эталон батлах тухай

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв дэх олон улсын Е1 ангийн нарийвчлал бүхий анхдагч эталон-туухайг массын хэмжлийн нэгжийн, анхдагч эталон-булэг хэвийн элементийг цахилгаан хөдөлгөгч хүчний хэмжлийн нэгжийн улсын эталоноор тус тус тогтоосугай.

2.Улсын эталоныг олон улсын байгууллага болон гадаад орны холбогдох эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулж байхыг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга Н.Баярмагнайд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 4 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг нь үнэлэх журмыг хавсралтаар батлуулсугай.

2.Жилийн эцэст өндөр үнэлгээ авсан аймаг, нийслэл, ямдыг урамшуулах шагналын хөрөнгийг 1998, 1999 онд Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж, цаашид үг шагналын эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайдад зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Гадаад харилцааны сайд бөгөөд Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.ТУЯА

Засгийн газрын 1999 оны 4 дүгээр тогтоолын хавсралт

I.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрхлэн гүйцэтгэнэ.

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ,үнэлгээг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас төр, засгийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийтмийг хөгжүүлэх тухайн оны үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан бодлогын зорилтууд, Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний үүрэгт зөрөг зорилтуудыг хэрхэн биелүүлсэн, Сайд, Засаг даргад зөвлөлгөө өгөх үүрэг бүхий яам, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө ямар байгааг тогтоож, үр дүнг үнэлэхэд оршино.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

2.1. Бодлогын зорилтууд, түүний дотор хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө нь Засгийн газраас хүсэн хүлээж байгаа үр дүнд хүрч хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох;

2.2.Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгөх;
2.3.Бодлогын зорилт зохих үр дүнд хүрч хэрэгжээгүй буюу ямар нэгэн гажуудал гарсан бол засч залруулах чиглэл, арга хэмжээг тодорхойлох;
2.4 Шаардлагатай бол бодлогын шинэ зорилтыг тодорхойлж, танхим, Ерөнхий сайдад танилцуулах.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэл, хүрээнээс хамаарч бодлого, стратеги, үйл ажиллагааны зорилтуудын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн үе шат бүрийг хамарна;
3.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээг яам, Тамгын газрын тухайн жилийн эхний хагасын болон бүтэн жилийн үйл ажиллагаанд, эсвэл бодлогын тодорхой чиглэлээр хийнэ. Хамрах хүрээ, цаг хугацаат удирдамжаар тодорхойлно.

4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга

4.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрхлэн бусад холбогдох газруудтай хамтарч хяналт-шинжилгээ, үнэлгээний багийг тухайн үед хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх яам, аймаг, нийслэлд зориулан байгуулж ажиллуулна:
4.2. Баг үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, энэхүү журам, Хэрэг эрхлэх газраас эрхлэн гаргасан "Хяналт-шинжилгээ, шийдвэр, энэхүү журам, Хэрэг эрхлэх газраас эрхлэн гаргасан "Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай ойлголт, арга зүй", удирдамжийг үндэс болгоно;
4.3.Яам, Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны тайлан бичих үлгэрчилсэн загвар /Энэ журмын Ш, IV, V дахь хэсэг/-ын дагуу яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газар тухайн хугацааны тайланг бичиж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт яамд жил бүрийн 7 дугаар сарын 15 дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор, аймаг, нийслэл жил бүрийн 8 дугаар сарын 01 дараа жилийн 2 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ;
4.4.Тайлантай Засгийн газрын ХЭГ-ын тухайн яам, нутгийн захиргааны асуудал хариуцсан төслийн багийн ажилтан, хяналт-шинжилгээ, үнэлгээний төслийн багийн ажилтантай хамтран танилцаад зориулсан хэрэгжилт, гарсан үр дүнтэй уялдсан судалгаа явуулах бөгөөд хяналт-шинжилгээг гүйцэтгэх ба тодотгол мэдээлэл авах шаардлагатай бол бие гарган газар дээр нь ажиллуулна;
4.5.Судалгаанд яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын дотоод нэгжүүд, түүнчлэн Сайд, Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд ажилладаг зарим агентлаг, төсөвт байгууллагыг хамруулна;
4.6.Хяналт-шинжилгээнд яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээний газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг татан оролцуулж болно. Шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудлаар бусад яам, төрийн захиргааны холбогдох байгууллагаас дэмжлэг авч болно;
4.7.Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ түүнд тусгасан тоон үзүүлэлт болон зарим тоогоор илэрхийлж болох үзүүлэлтүүдийг статистикийн болон судалгаа шинжилгээний бусад байгууллагын, түүнчлэн тухайн үйл ажиллагааны хүрээнийасуудал хариуцсан төслийн багаас урьд нь хуримтлуулсан үзүүлэлтүүд, ажилгалттай харьцуулан үзэж үнэн зөвийг тогтооно;
4.8.Тайлан, судалгааны материалд шинжилгээ хийхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нөөц

5.1. **Цаг хугацааны нөөц**
5.1.1.Хяналт-шинжилгээг тухайн оны турш явуулах бөгөөд яамдын хувьд 7 дугаар сар багтаан эхний хагас жилийн, дараа оны 1 дүгээр сард багтаан жилийн эцсийн аймаг, нийслэлийн хувьд 8 дугаар сарын 15-ны дотор багтаан эхний хагас жилийн дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор багтаан тухайн оны үнэлгээг хийнэ;
5.1.2.Яамдын үнэлгээний дүнг тухайн оны 8 дугаар сар, дараа оны 2 дугаар сарын дахь долоо хоногт, аймаг, нийслэлийн үнэлгээг 8 дугаар сар, дараа оны 3 дугаар сарын 3 дугаар долоо хоногт Засгийн газрын хуралдаанд тус тус танилцуулна.
5.2. **Хүний нөөц**
5.2.1. Засгийн газрын ХЭГ-ын холбогдох газар, нэгжүүд;
5.2.2. Яамдын Мэдээлэл, хяналт-шинжилгээний газар;
5.2.3. Яамд, агентлагийн тодорхой чиг үүрэг хариуцсан зарим ажилтнууд.
5.3. **Санхүүгийн нөөц**
5.3.1. Засгийн газрын ХЭГ, яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төсвийн хөрөнгө;
5.3.2. Эдгээр байгууллагын шагнал, урамшлын сан.

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүлээгдэж байгаа үр дүн

6.1.Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын тухайн оны хагас болон бүтэн жилийн үйл ажиллагаанд гарсан ахиц, дэвшил, гажуудал, бэрхшээлийг үнэлэв тодорхойлно;
6.2.Төр, Засгийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж хүлээсэн үр дүндээ хүрч хэрэгжиж байгаа, эсэх талаар бодитой мэдээлэлтэй болно;
6.3.Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэрэгслийг тодорхойлно;
6.4. Бодлогын хэрэгжилтийн явцад гарсан гажуудал, бэрхшээлийг арилгах, шинэ зорилт дэвшүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, нөөцийг тодорхойлно.

7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн ашиглалт

7.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг яам, аймаг, нийслэл тус бүрээр нэгтгэн гаргаж, танилцуулга бэлтгэнэ;
7.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн тухайд гарах Засгийн газрын хуралдаанд

шийдвэрийн төсөл боловсруулна;

7.3.ХЭГ-аас Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана;

7.4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна;

7.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр өндөр үнэлгээ авсан яам, аймаг, нийслэл болон яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг урамшуулна. Жилийн эцсийн үнэлгээгээр өндөр үнэлгээ авсан таван аймаг, гурван яамыг 5 хүртэл сая төгрөгөөр, тухайн аймгийн Засаг дарга, яамны Төрийн нарийн бичгийн даргыг 500 мянга хүртэлх төгрөгөөр шагнаж байна;

7.6.Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тухайн оны үйл ажиллагааны тайланг эмхэтгэн хэвлэж Улсын Их Хурлын болон Засгийн газрын номын сангуудаар дамжуулан нийтийн хүртээл болгоно.

П. Үр дүнг үнэлэх журам

1.Сайд, Засаг даргын үйл ажиллагааны хүрээнийлогын стратеги, үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт, нд яамны аппарат, Засаг даргын Тамгын газраас үлсэн үйлчилгээ, дэмжлэгийн үр дүнг үнэлнэ.

1.1. Үнэлгээ хийхдээ яамны хувьд энэ жүрмын Ш хэсэгт дурдсан үлгэрчилсэн загварын дагуу бичиж ирүүлсэн тайланд туссан зорилт нэг бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат төлөвлөгөөний дагуу авч үзэж, үр дүнг тооцно. Аймаг, нийслэлийн хувьд VI хэсэгт тодорхойлсон үзүүлэлт нэг бүрийн бодит хэрэгжилт, IV, V хэсэгт дурдсан үлгэрчилсэн загварын дагуу бичиж ирүүлсэн Засаг дарга, түүний Тамгын газрын тайланд үндэслэн Засгийн газар, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Тамгын газраас Засаг даргад үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэгийг авч үзэж үр дүнг тооцно. Үр дүн нь тоон үтгаар /тоо ширхэг, кг, м, м^3 тн, төгрөг, г.м/ буюу нийгмийн үр дүнгээр илэрхийлэгдэж болно;

1.2.Яамны үйл ажиллагааны үнэлгээнд энэ жүрмын IX хэсэгт заасан үзүүлэлтүүд, Засаг даргын үйл ажиллагааны үнэлгээнд VШ дахь хэсэгт заасан үзүүлэлтийг авч үзэх боловч тухайн яам, аймаг, нийслэлийн үйл ажиллагааны хүрээ, чиглэлээс хамаарууллан ялгаартай хандлага байж болно;

1.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаат VП дахь хэсэгт заасан үзүүлэлтээр үнэлнэ. Энэ нь Засаг даргын үйл ажиллагааны үнэлгээний нэг үзүүлэлт болно;

1.4.Үнэлгээ хийхдээ тухайн үйл ажиллагаат хэрэгжүүлсний үр дүнд ямар үр ашиг, үр нөлөө (тухайн салбарт чухам ямар асуудлыг шийдэрлэснээр сонирхогч талын эрэлт хэрэгцээг хэр зэрэг хангав) гарав гэдгийг авч үзнэ.

2.Бодлогын тухайн зорилтыг хэрэгжүүлэхээр эвлэсэн нэг ажил хэрэгжих хүсэн хүлээсэн үр дүндээ сэн байвал түүнийг 100 хувь гэж авч үзэх бөгөөд энэ нь оотой тэнцүү байна.

2.1.Бодлогын тухайн зорилтыг хэрэгжүүлэхээр ямар он үйл ажиллагаа төлөвлөөгүй, үйл ажиллагаа үлаагүй бол 0 оноотой тэнцүү байна;

2.2.Үйл ажиллагаа бүрийн үр дүнгийн гүйцэтгэлийн ийг дараахь томъёогоор олно:

$$P_i = \frac{T_g}{T_p} \cdot 100 ; \quad (1)$$

Энд:

P_i – і дүгээр үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь

T_r - хүрэх үр дүнгийн төлөвлөгөө

T_g - хүрсэн үр дүн

2.3.Үйл ажиллагааны гүйцэтгэлд тохирох оноог дараахь томъёогоор бодож гаргана:

$$K_i = \frac{5}{100} \cdot P_i ; (2)$$

Энд:

K_i - і дүгээр үйл ажиллагааны гүйцэтгэлд тохирох оноо

P_i - і дүгээр үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь

2.4. Зорилт тус бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ооноонуудын нийлбэрийг үйл ажиллагааны нийт тоонд хувааж тухайн зорилтын гүйцэтгэлийн дундаж оноог гаргана. Үүнийг дараахь томъёогоор гаргана:

$$K_a = \frac{\sum_{i=1}^{n} K_i}{n} ; \quad (3)$$

Энд:

K_a - *а дугаар* зорилтын гүйцэтгэлийн дундаж оноо

$\sum_{i=1}^{n} K_i$ - тухайн зорилтод харгалзах үйл ажиллагаануудын оононы нийлбэр

n - үйл ажиллагааны тоо

2.4.1. Жигнэсэн дундаж оноо (ЖДО). Үүнийг бодит гүйцэтгэлийн хувийг оноогоор нь үржүүлсэн нийлбэрийг гүйцэтгэлийн хувийн нийлбэрт хуваж олно. ЖДО нь 0 оноотой үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа хэр зэрэг үр дүнтэй хэрэгсэнийг харуулах юм.

$$K_j = \frac{\sum_{i=1}^{n} P_j K_j}{\sum_{i=1}^{n} P_j} \qquad (4)$$

Энд:

K_i - j *дүгээр* зорилтын жигнэсэн дундаж оноо

$\sum_{i=1}^{n} P_j K_j$ - j дүгээр зорилтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь, түүнд харгалзах дундаж онооны үржвэрүүдийн нийлбэр

$\sum_{i=1}^{n} P_j$ - j дүгээр зорилтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувиудын нийлбэр

2.5. Дээрх томьёонуудаар бодож гарсан үр дүнг Хүснэгт 1-ийн зохих нүдэнд бичнэ;

2.6.Үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил бүрээр тооцож гаргана. Төлөвлөсөн ажлыг тоон утгаар илэрхийлж болох бол томъёо (1)-ээр бодож гаргах ба тоон хэмжүүр байхгүй бол Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд дурдсан болон шинжилгээний бусад аргуудыг ашиглах, тухайн салбарын ажилтан, мэргэжилтний оюуны дүгнэлт гаргах аргуудыг хослуулан хэрэглэж үр дүнгийн үнэлгээний хувь болон ноогдох оноог гаргана. Оюуны дүгнэлт нь тухайн салбарыг хариуцсан ажилтан болон хяналт-шинжилгээний багийн ажилтны мэдлэг, чадварт тулгуурлах тул үнэн зөвийг тухайн ажилтан хариуцна;

2.7.Бодлогын зорилтыг хэрэгжүүлсэн үр дүнгийн ерөнхий үнэлгээг VП-IX хэсэгт дурдсан үзүүлэлтээр гаргах ба тус бүрт нь Хүснэгт 1-ийг ашиглаж гаргасан оноог бичнэ. Харин VI хэсэгт дурдсан үзүүлэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээний нэг үзүүлэлт болгоно;

2.8.Зорилтын хэрэгжилтийн тоог үндэслэн үнэлгээний график (График 1)-ийг байгуулна. Энэхүү графикаас бодлогын зорилтуудын хэрэгжилт төлөвлөгөөнөөс хэр гажиж байгаа, дундаж үзүүлэлтээс аль нь түрүүлж, аль нь хоцорч байгааг харуулах юм.

- Графикийн босоо тэнхлэгт зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны тоо, хэвтээ тэнхлэгт зорилтуудыг тэмдэглэнэ.
- Зорилтын үйл ажиллагааныудыг 100 хувь гүйцэтгэсэн үеийн графикийг төлөвлөгөөний дагуу байгуулна.
- Гүйцэтгэлийн графикийг үйл ажиллагааны бодит гүйцэтгэлээр байгуулна.

2.9.Дараа нь VП-IX хэсэгт заасан үзүүлэлтүүдийн график /График 2/-ийг байгуулна. Энэ нь тухайн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Тамгын газрын үйл ажиллагааны аль хэсэг тэргүүлж, аль хэсэг нь хоцорч байгааг харуулах юм. Үүнд:

- Нэг цэгээс гарсан цацраг нь үнэлгээний үндсэн үзүүлэлтийн шугаман хэмжээс болно.
- Тэдгээрийн төвлөрсөн цэг нь 0 онооны цэ заана.
- Цацрагийн хамгийн гаднахь цэг нь +5 оно цэгийг заана.
- Цацрагийн тэг дунд байх цэг нь дун онооны цэгийг заана.
  Бүх цацрагийн +5, дундаж онооны цэгүүди холбож тус тусын онооны цагирагийг үүсгэ
- Дараа нь Хүснэгт 1-д байгаа зорилтуу бодит оноог тус тусын цацраг д байрлуулан холбох замаар бодит оно цагирагийг үүсгэнэ.

2.10. Тухайн яам, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дундаж оноог VП-IX хэсгийн бүх үзүүлэлт дундаж оноогоор гаргана. Энэхүү оноогоор яам, ай нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллага зэрэгцүүлсэн үнэлгээний графикийг байгуулна. Эн аль яам, аймаг, нийслэлийн ажил түрүүлж, алинь ажил ерөнхийдээ хоцорч байгаар харуулах юм.

- Зэрэгцүүлсэн үнэлгээг График 3-т үзүүл
- Энэ графикийн цацраг бүр нэг байгууллa нийт үйл ажиллагааны шугаман хэмжээ График 2-ын нэгэн адилаар үзүүлж ба болно.

2.11. Яам, Засаг даргын Тамгын газрын ту хугацааны үйл ажиллагааны үнэлгээг VП, IX хэсэгт за чиглэлээр гаргана. Үүнд:

1) Бодлогын зорилт, Сайд, Засаг да зөвлөлгөө өгсөн үнэлгээ
2) Бодлогын зорилтын хэрэгжил зохицуулалтын үнэлгээ
3) Төрийн захиргааны арга бар үнэлгээ
4) Үр дүнг хангасан байдлын үнэлгээ

2.12. Дээрх 4 чиглэлд багтах үйл ажиллагаат VI хэсгээс үзнэ үү;

2.13. Үйл ажиллагааны чиглэлүүдэд хам үзүүлэлтүүдийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг э газраас эрхлэн гаргана;

2.14. Хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн ба үнэлгээний эцсийн үр дүнг яамны Төрийн нарийн би дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын г дарга нартай тохиролцсон байна. Үнэлгээний т санал зөрүүтэй бол дээрх албан тушаалтнууд үндэс гаргасан албан баримтыг Засгийн газрын Хэрэг э газарт ирүүлнэ.

---------- oOo ----------

Хүснэгт 1

Бодлогын зорилтыг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үнэлгээ

Д/Д	Бодлогын зорилт	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хэрэгжилт			Ноогдох оноо $K_u = \frac{S}{100} \cdot P_i$	Жигнэсэн дундаж оноо $K_j = \frac{\sum_{i=1}^{n} P_i K_i}{\sum_{i=1}^{n} P_i}$
			Төлөвлөгөө T_p	Гүйцэтгэл T_g	Хувь $P_i = \frac{T_g}{T_p} \cdot 100$		
1	1. Зорилт 1	1.1. ..	20	20	100	5.00	
2		1.2. ..	40	32	80	4.00	
3		1.3. ..	60	30	50	2.50	
.		1.4.	..	..	150	7.50	
.		Нийт	..	..	380	19.00	
.		Дундаж			95	4.75	5.18
.	2. Зорилт 2	2.1. ..	45	45	100	5.00	
.		2.2. ..	3	3.3	110	5.50	
		2.3. ..	16	2.8	13	0.65	
		.. ..	2	0	0	0.00	
		Нийт	..	..	223	11.15	
		Дундаж	..	..	54.7	2.79	4.99
	3. Зорилт 3	3.1. ..	..	..	0	0.00	
		3.2. ..	..	..	100	5.00	
		3.3. ..	..	..	130	6.50	
		3.4. ..	..	..	120	6.00	
		.. ..					
		Нийт			2350	17.50	
		Дундаж				4.37	5.92
.	п. Зорилт п	п.1 ..					
.		п.2 ..					
.		п.3 ..					
п		Нийт			$\sum P_i$		$\frac{\sum K_j}{n} = 5.33$
		Дундаж					

График 1

Зорилтыг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гарфик




График 2

Үйл ажиллагааны үнэлгээний график





График 3

Яам,аймаг, нийслэлийн засаг дарга нарын үйл ажиллагааг харьцуулсан үнэлгээний график



Бодит оноо

Ш. Яамдын үйл ажиллагааны тайлан бичих үлгэрчилсэн загвар

1. Эрхэлсэн сайдын мэдэгдэл

1.1.Яамнаас тухайн хугацаанд сайдын эрхэлсэн үүдлын хүрээнд явуулсан үйл ажиллагааны гол үр нгүүдийг сайд хэрхэн үнэлж байгаа тухай;

1.2.Яамны үйл ажиллагааны талаархи эрхэлсэн йдын үнэлэлт, дүгнэлт.

2. 0. **Төрийн нарийн бичгийн даргын мэдэгдэл**

2.1 Төрийн нарийн бичгийн даргын манлайлал, ирдлагаар хангасан байдал;

2.2.Байгууллагын хөгжлийн талаар явуулсан үйл иллагаа;

2.3.Яамны үйл ажиллагааны цаашдын төлөв, нэ зорилтын тухай;

2.4.Яамны үйл ажиллагаанд өгөх гол үнэлгээ.

3.0.**Яамны чиг үүрэг, стратегийн зорилтыг рэгжүүлэх талаар:**

3.1. Бодлогын зорилт тодорхойлох, сайдад элгээ өгөх талаар:

3.1.1. Тухайн оны үйл ажиллагааны стратеын гол зорилт;

3.1.2.Гол зорилтыг хэрэгжүүлэхээр боловсулсан бодлого, сайдад өгсөн зөвлөгөө, дгээрийн үр дүн;

3.1.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг стратегийн удирдлагаар хангасан үр дүн;

3.1.4.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй лдсан бодлого, зөвлөгөө, тэдгээрийн үр дүн.

3.2.**Төрийн захиргааны удирдлагын талаар:**

3.2.1.Хүний нөөцийн хөгжил, чадавхийг эшлүүлэх талаар гарсан үр дүн;

3.2.2.Засгийн газрын хуралдааны дэг баримтх, танхимын үйл ажиллагаар дэмжих талаар уулсан үйл ажиллагаа, түүний үр дүн;

3.2.3.Салбарын хэмжээнд мөрдөх хууль тоомж, шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтийн үр ;

3.2.4.Яамны дотоод дүрэм, журам, тушаал йдвэрийн хэрэгжилт, үр дүн;

3.2.5.Нутгийн захиргааны холбогдох байгууллын бодлогын удирдамжаар хангасан үр дүн.

3.3.Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын талаар:

3.3.1.Тухайн оны стратегийн зорилтыг рэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөгөөр хангасан йдал;

3.3.2.Засгийн газраас тухайн салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн үр ;

3.3.3.Төсөв, хөрөнгийн нөөцийн удирдлага, үр ;

3.3.4.Цаг хугацааны нөөц ашиглалт, үр дүн.

3.4. Үр дүн хангах талаар явуулсан үйл ажиллагааны талаар:

3.4.1.Агентлаг, яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн;

3.4.2.Хөндлөнгийн болон дээд байгууллагаас хийсэн хяналт, шалгалт, тэдгээрийн үр дүн;

3.4.3.Мэдээлэл, өгөгдөхүүний сан, ашиглалт, олон нийтэд мэдээлэл хүргэсэн байдал;

3.4.4.Байгууллагын нээлттэй байдлыг хангах, санал, хүсэлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүн.

4. Салбарын онцлог зорилтыг хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагааны үр дүн

5. Яамны үйл ажиллагааны тухайн оны сүүлийн хагас жилийн болон дараа жилийн зорилт

ХАВСРАЛТ: 1. Санхүүгийн тайлан, тэнцэл
2. Үнэлгээний үзүүлэлт (VI хэсэг)
3. Ирэх онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн тодорхойлолт, жагсаалт
4. Холбогдох бусад материал

IV. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТУХАЙН ОНЫ БОЛОН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН БИЧИХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

1. Засаг даргын үйл ажиллагааны талаархи аймаг, нийслэлийн ИТХ-ын үнэлгээ /жилийн эцсээр/

2. Удиртгал

1.1.Тухайн жилийн гол зорилтууд

1.2.Гол зорилтыг хэрэгжүүлэх нөөц

1.3.Зорилтын хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн зохицуулалтын арга хэмжээ

1.4.Үр дүнг хангах хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлага, мэдээллийн арга хэрэгслүүд

3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

4.Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний үр дүн

5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

6.Сум, дүүргийн Засаг дарга нарыг удирдлага, зохицуулалтаар хангасан үр дүн

7.Нутгийн өөрөө удирдах байгууллагатай харилцсан харилцааны үр дүн

8. Засаг даргын Тамгын газраас Засаг даргад үзүүлсэн зөвлөлгөө, дэмжлэг, үйлчилгээний үр дүн

9. Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд хамаарах агентлаг, байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэгийн үр дүн

10.Тухайн хугацаанд явуулсан үйл ажиллагааны талаархи үнэлгээ, дүгнэлт

11. Дараагийн хугацаанд тавих гол зорилт

Хавсралт: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
2. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
3. Ерөнхий сайдтай Засаг даргын байгуулсан гэрээний биелэлт

V.АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТУХАЙН ОНЫ БОЛОН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН БИЧИХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн тухай Засаг даргын мэдэгдэл

1.1.1.Аймгийн Засаг даргын Тамгын газраас тухайн хугацаанд явуулсан үйл ажиллагааны гол үр дүнгүүдийг Засаг дарга хэрхэн үнэлж байгаа тухай;

1.1.2.Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх Засаг даргын үнэлэлт, дүгнэлт.

2. Тамгын газрын үйл ажиллагаар удирдлагаар хангасан тухай Тамгын газрын даргын мэдэгдэл

2.1.1. Тамгын газрын даргын манлайлал, удирдлагаар хангасан байдал;

2.1.2. Байгууллагын хөгжлийн талаар явуулсан үйл ажиллагаа;

2.1.3. Тамгын газрын үйл ажиллагааны цаашдын төлөв, шинэ зорилтын тухай;

2.1.4. Тамгын газрын үйл ажиллагаанд өгөх гол үнэлгээ.

3. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн үр дүн

3.1.Эдийн засгийн хөгжлийн талаар тавьсан гол зорилтууд, тэдгээрийн хэрэгжилт, гол үр дүн;

3.1.1.Төсөв, мөнгө, санхүүгийн талаар тавьсан зорилтын хэрэгжилт, үр дүн;

3.1.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний талаар тавьсан зорилтын хэрэгжилт, үр дүн;

3.1.3.ХАА-н үйлдвэрлэлийн талаар тавьсан зорилтын хэрэгжилтийн үр дүн;

3.1.4.Дэд бүтцийн хөгжлийн талаар тавьсан зорилтын хэрэгжилт, үр дүн;

3.1.5.Аймаг, нийслэлийн хэтийн хөгжлийг хангах талаар тавьсан гол зорилт, түүнийг хангаж байгаа явц.

3.2.Нийгмийн хөгжлийн талаар тавьсан гол зорилтууд, тэдгээрийн хэрэгжилт, гол үр дүн

3.2.1.Нийгмийн хамгаалал, халамж, тэтгэвэр, тэтгэмжийн талаар тавьсан гол зорилтууд, үр дүн;

3.2.2.Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийг бууруулах талаар тавьсан зорилт;

3.2.3.Ядуурлыг бууруулах талаар тавьсан зорилт, үр дүн;

3.2.4.Хүн амын эрүүл мэндийн талаар тавьсан гол зорилтууд, үр дүн;

3.2.5.Боловсролын талаар тавьсан гол зорилтууд, үр дүн;

3.2.6.Шинжлэх ухаан, урлаг, соёл, нийтийн биеийн тамирын хөгжлийн талаар тавьсан зорилт, үр дүн.

4.Төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангасан гол үр дүн

4.1.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх талаар тавьсан зорилт, хэрэгжилтийн үр дүн;

4.2.Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн хөгжлийн талаар тавьсан зорилт, үр дүн;

4.3.Төрийн захиргааны байгууллагын тавьсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэрэгслийн хангалт, үр дүн;

4.4.Төр, Засгийн хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хангасан байдал, үр дүн;

4.5.Төрийн захиргааны төв байгууллага, ИТХ-ын харилцсан харилцааны үр дүн;

4.6.Төрийн бус байгууллагуудтай тогтоосон харилцаа, тэдгээс дэвшүүлсэн асуудал, шийдвэрлэлт, гол үр дүн.

5. Үр дүнг хангах хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн үйл ажиллагааны үр дүн

5.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг, хамаарах төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлсэн байдал;

5.2.Дээд байгууллага, захиргааны бодлогын хөндлөнгийн хяналтын үр дүн;

5.3.Олон нийт, нутгийн хуралд, захиргаанд байгууллагыг мэдээллээр хангасан байдал, үр дүн.

6. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

6.1.Тухайн оны санхүү, төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн бодлогын талаархи мэдэгдэл;

6.2.Тухайн оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, тэнцлийн гол үр дүн;

6.3.Дараагийн жилд санхүү, төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар баримтлах бодлогын мэдэгдэл

7.Үнэлэлт, дүгнэлт, дараагийн хугацааны зорилт

7.1.Тухайн хугацааны гол үр дүн;

7.2.Үнэлэлт, дүгнэлт;

7.3.Дараагийн хугацааны тэргүүлэх чиглэл, зорилт.

Хавсралт: 1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, тэнцэл
2. Ирэх хоёр жилийн төсвийн төлөвлөгөөний тесөл[1]
3. Ирэх онд хэрэгжүүлэх төлөвлөгөө хөтөлбөр, теслийн тодорхойлолт, жагсаалт
4. Үнэлгээний үзүүлэлт (VI хэсэг)

[1] Ирэх хоёр жилийн төсвийн төлөвлөгөөний тесслийг Төсвийн тухай хуульд заасны дагуу Санхийн сайдын 1997оны 441 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн орлого, зарлагын ангиллын дагуу гаргана.

VI. Засгийн газраас аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үзүүлэлт

Үзүүлэлтийг аймаг тус бүрээр хагас, бүтэн жилийн статистикийн болон холбогдох мэдээгээр гаргана.

Үзүүлэлтүүд	Аймаг, нийслэлээс цуглуулсан мэдээ			Статистикийн албан ёсны мэдээ			Үнэлгээ					
	Өмнөх он	Тухайн он	Өөрчлөлт	Өмнөх он	Тухайн он	Өөрчлөлт	Өмнөх он	Тухайн он	Өөрчлөлт	Оноо	Дундаж оноо	Жигнэсэн дундаж оноо
А. Эдийн засаг												
1.Төсвийн нийт орлогод өөрийн орлогын эзлэх:												
а/ хувийн жин /%/												
б/ өсөлтийн хувь												
2. Төсвийн төлөвлөгөөний биелэлт												
а/ орлого /сая төг/												
б/ зарлага /сая төг/												
в/ зарлагын хэмнэлт, хэтрэлт /сая төг/												
г/ өр /сая төг/												
д/ авлага /сая төг/												
3. Нэг хүн амд ноогдох төсвийн зарлага /мян. төг/												
4. Зээлийн нийт өр /сая төг/												
а/хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувийн жин /%/												
б/ өр барагдуулалт /%/												
5. Нийт хөрөнгө оруулалт /сая төг/												
Үүнээс: а/улсын төсвийн /сая төг/												
в/орон нутгийн төсвийн /сая төг/												
6. Хэрэглээгээний үнийн өсөлт, бууралт /%/												
7. Дотоод нийт бүтээгдэхүүн /1995 оны эдэгшүүлэх үнээр сая төг/												
а/ АУБ-ний үйлдвэрлэл /оны үнэ, сая төг/												

б/ МААБ-ний үйлдвэрлэл /оны үнэ, сая төг./													
8. Нийт малын тоо													
а/өсөлт /%/													
б/ хээлтэгчийн хувийн жин /%/													
в/төл бойжилт /%/													
г/том малын хорогдол /%/													
9. 100 эхээс авсан төл													
а/ хурга													
б/ ишиг													
в/ унага													
д/ тугал													
е/ ботго													
10. Тариалсан нийт талбай /га/													
а/ ур тарпа /га/													
б/ төмс /га/													
в/ хүнсний ногоо /га/													
11. Хураасан нийт ургац /тн/													
үүнээс нэг га-аас хураасан													
а/ ур тарпа /цн/га/													
б/ төмс /цн/га/													
в/ хүнсний ногоо /цн/га/													
Б. Нийгэм													
1. Ажилгүйдэл, хөдөлмөр зохицуулалт:													
а/ хөдөлмөрийн биржид бүртгэгдсэн ажил идэвхитэй хайгчдын тоо													
б/ хөдөлмөрийн насны ажиллах чадвартай хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувь													
в/ ажилгүйчүүдийн өсөлт, бууралт /%/													
2. Нийгмийн даатгалын төлөрүүлэлт /сая төг/													
а/төлөвлөгөө													
б/гүйцэтгэл													
3. Халамжийн сангийн ашиглалт													
а/хамрагдсан хүний тоо													
б/зарцуулсан хөрөнгө /сая төг/													
4. Хүн амын өсөлт /%/													

а/ нийт өрх /тоо/
б/ ядуу өрх /тоо/
в/ нийт өрхөд ядуу өрхийн эзлэх хувийн жин /%/
г/ядуу өрхөд нэн ядуу өрхийн эзлэх хувийн жин /%/
д/ ядуурлыг бууруулахад зарцуулсан хөрөнгө
е /малжуулахад зарцуулсан хөрөнгийг оруулаад сая төг./

3. Эрүүл мэнд
а/ Дундаж нас
б/амьд төрсөн 1000 хүүхэд тутамд гарсан нялхсын эндэгдэл /тоо/
в/ төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл /тоо/
г/ халдварт өвчний гаралт /тоо/
Үүнээс: хамуу /тоо/
сүрьеэ /тоо/
брүцеллёз /тоо/
хүйтэн /тоо/
ДОХ, бэлгийн замын халдварт өвчин /тоо/
г/урьдчилан сэргийлэх тарилгад хамарсан байдал:
д/эхчүүдийн төрөхийн өмнөх байрын ашиглалт /%/

4. Боловсрол:
а/ сурлагын чанар /%/
б/ сурлагын амжилт /%/
в/ сургууль завсардалт /%/
г/ албан бус боловсрол олгогт /тоо/
д/ мэргэжлийн багшаар хангагдсан байдал:

1/ нийт багш /тоо/														
2/ мэргэжлийн багш /тоо/														
с/ анги дүүргэлт /%/														
5. Зээл, тусламж /сая төг./														
а/ төслийн тоо														
б/ одгосон зээл /сая төг./														
в/ тусламж /сая төг./														
д/ гарсан үр дүн:														
1/ шинээр бий болсон ажлын байр /тоо/														
2/ байнгын /тоо/														
3/ түр /тоо/														
6. 1/Гэмт хэргийн өсөлт, бууралт /%/														
а/хувь, хэмжээ														
б/16-гаас доош насны хүүхдийн дундаж гэмт хэрэг /тоо/														
в/1000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо														
г/соггуугаар үйлдсэн гэмт хэрэг														
д/нийт хэргийн дотор онц хүнд буюу хүнд хэргийн эзлэх хувь														
2/Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь														
3/Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн хувь хэмжээ														
В. Хогжил														
1. Хувийн салбарын хөрөнгө оруулалт /сая төг./														
а/ жижиг, дунд үйлдвэрлэлд /сая төг./														
б/ орон нуттийн /сая төг./														
в/ гадныи /сая төг./														
2. Хүн амд үзүүлэх халууи усны үйлчилгээ /хувий тоо/														
3. Шинээр бий болсон уст цэг /тоо/														

4. Нийт үйлдвэр, аж ахуйн газар /тоо/ Үүнээс:														
а/ байгууллагатай /тоо/														
в/ нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл /олны үнэлэх, сая төг./														
г/ бордуулалт /сая төг./														
е/ орлого /сая төг./														
ё/ ашиг /сая төг./														
з/ татвар /сая төг./														
5. Эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөлт / мян. кв. цаг /														
6. 1 хүнд ноогдох бараа, гүйлгээний хэмжээ / мян. төг /														

VII. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Аймаг, нийслэлийн Засаг даргын ТГ-ын нэр	Бодлогын зорилт, Засаг даргад өгсөн зөвлөлгөөний хэрэгжилтийн үнэлгээ		Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ			Төрийн захиргааны арга барилын үнэлгээ		
	Боловсруулж, шийдвэрлүүлсэн бодлогын арга хэмжээ	Засгийн газрын тогтоол, шийдвэр, захирамжийн хэрэгжилт	Төсөв, хөрөнгийн зарцуулалт	Боловсон хүчний нөөц ашиглалт	Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэлт	Үйл ажиллагааны төлөвлөлт	Засаг даргын захирамжийн хэрэгжилт	Дотоод дүрэм, тушаал, шийдвэрийн хэрэгжилт
0	1	2	3	4	5	6	7	8
Архангай								
Баян-Өлгий								
Баянхонгор								
Булган								
Говь-Алтай								
Дорноговь								

Дорнод													
Дундговь													
Завхан													
Өвөрхангай													
Өмнөговь													
Сүхбаатар													
Сэлэнгэ													
Төв													
Увс													
Ховд													
Хөвсгөл													
Хэнтий													
Дархан-Уул													
Орхон													
Говьсүмбэр													
Улаанбаатар													
Дундаж													

Үр дүнг хангасан байдлын үнэлгээ				Нийт оноо	Дундаж оноо	Өмнөх оны түхайн үеийн оноо	Үнэлгээний өсөлт	Үнэлгээний бууралт
Хяналт-шинжилгээ, үнэлгээ	Өгөгдөхүүний сан, мэдээлэл	Хөнд-лөнгийн хяналт шалгалт	БНБ /санал, гомдол, өргөдлийн шийдвэрлэлт/					
9	10	11	12	13	14	15	16	17

VIII. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааны үнэлгээ

Дэс дугаар	Засаг даргын нэр	Засгийн газрын үйл ажиллагааны хэтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ[1]	Засаг даргаас Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний биелэлтийн үнэлгээ[2]	Засаг даргын үйл ажиллагааны хэтөлбөрийн биелэлтийн үнэлгээ[3]	Нийгэм, эдийн засаг, хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээ	Аймаг, нийслэлийн ИТХ-ын үнэлгээ[4]	Үнэлгээний нийт оноо	Дундаж оноо
0	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
13									
14									
15									
16									
17									
18									
19									
20									
21									
22									
23									

IX. ЯАМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Яамдын нэр	Бодлогын зорилт, сайдад өгсөн зөвлөлгөөний хэрэгжилтийн үнэлгээ			Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ				Төрийн захиргааны арга барилын үнэлгээ			
	Боловсруулж, шийдвэрлүүлсэн бодлогын арга хэмжээ	Хууль тогтоомжийн хэрэгжилт	Засгийн газрын тогтоол, шийдвэр, захирамжийн хэрэгжилт	Засгийн газрын хуралдааны дэг баримтлал	Төсөв, хөрөнгийн зарцуулалт	Боловсон хүчний нөөц ашиглалт	Цаг хугацааны нөөц ашиглалт	Үйл ажилла-гааны төлөвлөлт	Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэлт	Дүрэм, журам мөрдөлт	Дотоод дүрэм, тушаал, шийдвэрийн хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ГХЯ											
СЯ											
ХЗЯ											
БОЯ											
БХЯ											
ГЭЯ											
ДБХЯ											
ХААУЯ											
ЭМНХЯ											
Дундаж											

Ур дүнг хангасан байдлын үнэлгээ				Нийт оноо	Дундаж оноо	Жигнэсэн дундаж оноо	Үнэлгээний өсөлт, бууралт /өмнөх үетэй харьцуулах/	Салбарын онцлог зорилтын хэрэгжилтйн үнэлгээ
Хяналт-шинжилгээ, үнэлгээ	Өгөгдөхүүний сан, мэдээлэл	Хөндлөнгийн хяналт шалгалт	Байгууллагын нээлттэй байдал /санал, гомдол, өргөдлийн шийдвэрлэлт/					
13	14	15	16	17	18	19	20	21

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

999 оны 1 дүгээ
арын 13-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

Эрүүл ахуй, халдвар судлалын болон Эм,биобэлдмэл,эмчилгээний чанарын улсын хяналтын дүрэм шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн багц хуулийг хэрэгжүүлэх зорилгоор онгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын рэм"-ийг 1 дүгээр хавсралтын, "Эм, биобэлдмэл, чилгээний чанарын улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар всралтын ёсоор тус тус батална.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл ахуй, лдвар судлал, эм, биобэлдмэлийн улсын хяналтын рэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 10 дугаар сарын 30-нд өдрийн 192 дугаар тогтоол, "Эмчилгээний чанарын улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 15-нд өдрийн 213 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын үүрэг гүйцэтгэгч Ш.БАТБАЯР

Засгийн газрын 1999 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР СУДЛАЛЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын налтын зорилго нь нийгэм, ахуй, байгаль чноос хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, бух йтийн ариун цэврийг сахиулах, түүний вийн нөхцөлийг зөрчсөнөөс шалтгаалсан чин эмгэгийг судалж, урьдчилан ргийлэхэд чиглэсэн захиргааны мэргэжлийн налтыг хүлэ тогтоомжид нийцүүлэн явуулах маар нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад шино.

2.Эрүүл ахуй, халдвар судлалын улсын налтыг Эрүүл ахуй, халдвар судлалын сын хяналтын алба болон эрүүл ахуй, лдвар судлалын хяналтын улсын байцаагчид рэгжүүлнэ.

3.Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын сын албаны дарга нь эрүүл ахуй, халдвар цлалын хяналтын улсын ерөнхий байцаагч йна.

4.Эрүүл ахуй, халдвар судлалын улсын налтын албанд ажиллах улсын ахлах йцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий йцаагчийн санал болгосноор эрүүл мэндийн удал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

5. Орон нутагт болон Батлан хамгаалах м, Улаанбаатар төмөр замд ажиллах эрүүл уй, халдвар судлалын хяналтын улсын лах байцаагчийг улсын ерөнхий йцаагчтай зөвшилцсөний үндсэн дээр, улсын байцаагчийг тухайн орон нутаг дахь улсын ахлах байцаагчийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, яам, газрын сайд, дарга томилж, чөлөөлнө.

6. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтад хамрагдах объектын жагсаалтыг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч батална.

7. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь эрүүл ахуй, халдвар судлалын чиглэлээр мэргэшсэн, энэ мэргэжлээр зохих түвшингийн шалгалт өгч тэнцсэн хүмүүс байна.

8. Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын алба, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчид /цаашид байцаагч гэх/ нь Засгийн газраас загварыг нь батална, үнэмлэх, дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын чиглэл

10. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/эрүүл ахуй, халдвар судлалын талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/Монгол улсын олон улсын гэрээ, бусад

улстай байгуулсан эрүүл ахуй, халдвар, нян, хор судлалын холбогдолтой конвенц, гэрээ эрх зүйн бусад актуудын биелэлт;

в/хот суурин, байгууллага, аж ахуйн нэгжийг байршуулах еренхий төлөвлөгөө, барилга байгуламжийн зураг төсөл зохиох, газар сонгох, тэдгээрийг барьж байгуулах, ашиглалтад оруулахад мердөх эрүүл ахуйн хэм хэмжээ, дүрмийн биелэлт;

г/химийн бодис, үндны болон ахуйн хэрэглээний ус ашиглалтаас, түүнчлэн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай тоног төхөөрөмжийн технологийн ажиллагаа, түүнд хэрэглэж байгаа түүхий эд, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээс эсвэл хог хаягдал дахь физик, хими, биологийн нөлөөллөөс агаар, ус, газрын хэрс бохирдсон зэрэг нь хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг холбогдох хяналтын байгууллагатай хамтран илрүүлэх, уг нөлөөллөөс сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

д/үйлдвэрлэлийн, сургалтын, ахуйн хэрэглээний болон хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, түүний эрүүл ахуй, халдвар судлалын ақуулгүй байдлын баталгаажилт;

е/ахуйн хортон шавьж, мэрэгчтэй төмцөх болон ариутгал халдваргүйтгэлийн ажлын чанар.

Гурав. Байцаагчийн эрх, үүрэг

11. Байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

а/холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хийж, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

б/урьдчилан сэргийлэх тарилгын үйлдвэрлэлт, хадгалалт, тээвэрлэлт, тарилгын хөтөлбөрийн хэрэгжилт, хүн амын дархлаын түвшингийн байдалд хяналт тавих;

в/хүн амын эрүүл мэндэд шууд буюу шууд бусаар хохирол учруулж болзошгүй, эсвэл учруулсан нь нотлогдсон үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаат зөрчлийг арилгах хүртэл бүхэлд нь буюу хэсэгчилэн түр хугацаагаар зогсоох буюу бүрмесен хаах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

$$Q_н = H_ч x \frac{S}{100} x /1 + K_3 + K_4 + K_т / + H_{ткм} x \frac{W}{100} + H_ч x (n_я x (1 + m_ц$$

8.3.2. Хүйтний улиралд Алтай хотын төвд ЦКБ- А311 маркийн чиргүүлтэй ажилласан ЗИЛ-ММЗ-555 маркийн өөрөө буулгагч автомашин 352 км гүйлтэнд 11 удаа ачаа буулгахаар нийт 1408 ткм тээврийн ажил гүйцэтгэсэн шатахуун зарцуулах нормыг тодорхойлбол:

Өгөгдсөн нь: $H_ч$ = 37 л, S = 352 км, K_3 = 0.10,

K_x = 0.055, $K_т$ = 0, $H_ч = H_{ткм}$=3.0 л

W=1408 ткм, $H_б$ = 0.3 л, $n_я$ = 11,

$m_ц$ = 1, G = 1.5,

$H_т = H_с + H_ч G$ = 37 +3.0 x 1.5= 41.5 л

$$Q_н = H_ч x \frac{S}{100} x /1 + K_3 + K_4 + K_т / + H_{ткм} x \frac{W}{100} + H_ч x (n_я x (1 + m_ц$$

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас тараг...
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 Төрийн ордон
329612, 322838 Индекс 14503
Тор, Засгийн Үйлчилгээ аж... эрхлэх газрын харьяа... үйлдвэрт 3350 ш хэвлэв.
327806 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны хоёрдугаар сарын 23 | № 8 (87)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

81. Хөтөлбөр батлах тухай — *Дугаар 10* — 136

82. Ойд бэлтгэх, түүнийг тэмдэглэх тухай — *Дугаар 11* — 140

83. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай — *Дугаар 12* — 140

84. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай — *Дугаар 13* — 141

85. Эрүүл мэндийн даатгалын 1999 оны хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай — *Дугаар 14* — 141

86. Казиногийн тухай хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай — *Дугаар 17* — 141

Хоёр. Яам, агентлагийн акт

87. Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал — *Дугаар 11* — 141

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтын, уг хөтөлбөрийг зохион байгуулж хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын, хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын зардлыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлансугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажилларга, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. Содномцэрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажилларааг хариуцах яам, албан тушаалтан хугацаатайгаар төлөвлөн биелэлтийг зохион байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Засгийн газарт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга Ч. Содномцэрэнд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд — **Ч.СОДНОМЦЭРЭН**

Засгийн газрын 1999 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцдсон үеэс манай улсын нийтэн, эдийн засгийн харилцаанд зарчмын өөрчлөлт гарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд олноор бий болж байна.

1998 оны 1 дүгээр сарын байдлаар улсын бүртгэлтэй 33741 аж ахуйн нэгж байгаагийн 96 хувь нь хувийн хэвшлийнх байна.

Манай оронд жижиг, дунд үйлдвэр суулийн жилүүдэд жинхэнэ өөрийн ачуулгаар үүсэн бүрэндэж, ялангуяа хөдөө орон нутгийн хэрэгцээгийн эрэлт хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Өмч хувьчлалын үр дүнд мал аж ахуй, газар тариалангийн салбар үндсэндээ жижиг, дунд үйлдвэрийн бүтцээ шилжээ. Мөн жижиглэн худалдаа, хүн амын ахуйн үйлчилгээ, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өөдөө, суламжлах зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн салбарт жижиг, дунд үйлдвэр онцгой бий болов.

1997 оны хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэжээ. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нийт ажиллагсдын 80 хувь буюу 480 мянган хүн ажилтай байна.

Гэвч дэд бүтэц сул хөгжөөн, үйлдвэрлэлийн бэлэн талбайн хомсдол, санхүүжүүгээ, орон байгаа үйлдвэрүүд нь санхүү, эдийн засгийн хувьд бэхжээгүй, тэдний үйлдвэрлэх боломж байгуулагдын хүрээлэл, ер чадвар хангалттай байгаа зэргээс шалтгаалан жижиг, дунд үйлдвэр эрчимтэй хөгжих чадахгүй байна.

2. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих нийгэм, эдийн засгийн шаардлага

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих нийгэм, эдийн засгийн шаардлагыг дараахь байдлаар тодорхойлж байна:

а/ байгаа нөөц, боломж дээр зүлгүүрдэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар ажлын байрыг шинээр бий болгох, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх;

б/ хөдөлмөрийн чөлөөт үүсэн нөөцийн хуваарилалт, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг сайжруулах;

в/ үйлдвэрлэл, үйлчилгээнд шударга өрсөлдөөний бий болгож, бизнесийн орчинг бүтээлгэ, идэвхитэй ажиллагаанд оруулах;

г/ эдийн засгийн өсөлтийн боломжийг илрүүлэх, бүс, орон нутгийн эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд хангах нөхцөлийг бүрдүүлэх;

д/ зах зээлийн өөрчлөлтөд түргэн зохицох модрэмжтэй үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг бий болгох;

е/ олон түлүүрт эдийн засгийн системийг бий болгож, татвар төлөгчийн бааз нэмэгдүүлэх.

Хоёр. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн зорилго, зорилт, төрүүлэх чиглэл

3.Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

Жижиг, дунд үйлдвэр хөгжих үндэс нь эдийн засаг эрхлэгчийн сайн дурын идэвх санаачилга, өөрөө өөрийгөө дэмжих үйл ажиллагаа мөн.

4. Хөтөлбөрийн зорилт

4.1 Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг шийдвэрлэнэ:

а/ үйлдрлага зохион байгуулалт, хуний хөгжилийн нөөц, мэдээллийн орчинг сайжруулах;

б/ бүс, орон нутаг дээ бүтцийг хөгжүүлж жижиг, дунд үйлдвэр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

в/ жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн техник, технологийг боловсронгуй болгож, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

г/ Жижиг дунд болон том үйлдвэр эрхлэгчийн бие биеэ дэмжин хөгжүүлэх, хамтын ажиллагаат сайжруулах;

д/ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дотоод, гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.

5. Төрүүлэх ач холбогдол өгөх жижиг, дунд үйлдвэрийн чиглэл

5.1 Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлдэг жижиг, дунд үйлдвэрүүдэд төрүүлэх ач холбогдол өгнө:

а/ бүс, орон нутгийн эрэлт хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүн амын ахуйн үйлчилгээ;

б/ дэнлийн зах зээлд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

в/ оюуны өндөр багтаамжтай, дэвшилтэт техник, технологи дээр тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ;

г/ эрчим хүч, зам, үс хангамж, харилцаа холбоо, геодезийн, барилгын материал зэрэг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

д/ байгалийн баялаг, хөрөдөгч түүхий эдийн ашиглах үйлдвэрийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санаачилгыг дэмжих.

5.2. Хөтөлбөрийн 5.1-д заасан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг жижиг, дунд үйлдвэрээс төрүүн эзлэнд дэмжих чиглэлийг жил бүр тодорхойлж улс, аймаг, нийслэлийн онцгийн жилийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх эрх эзэй, санхүүжүүлэх эх үүсвэрлэл, хувиий хөгжил, урамшуулын дараахь таатай орчинг бүрдүүлнэ:

6.1. Эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулж шийдвэрлүүлэх;

6.2. Жижиг, дунд үйлдвэр хөгжихэд саад учруулж буй шийдвэр, дүрэм, журам, заавруын заалтыг хүчингүй болгох;

6.3. Татварын зээлийн үзэл хэтийнгээр судалж төсөл боловсруулах, батлуулж хэрэгжүүлэх;

6.4. Жижиг, дунд үйлдвэрийн үүдирлага, мэргэжилтэнгүй сургах, давтан сургах, жижиг, дунд үйлдвэрийн бизнес төлөвлөгөө төсөл боловсруулах, санхүү бүртгэлийн үйл ажиллагаг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

6.5. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх санал, санаачилга, хөдөлгөөнийг урамшуулан дэмжих, төрийн захиргааны тев, орон нутгийн захиргааны үйл ажиллагаад чиргэдэгүй шуурхай болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.Төрийн захиргааны тев байгуулагаа

7.1 Хөдөө ах ахуй, үйлдвэрийн яам:

а/ жижиг, дунд үйлдвэрийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хөгжүүлэх, дэмжих харилцаг зохицуулах хуулийн төслийг боловсруулах;

б/ Сангийн яамтай хамтран "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-гийн хөрөнгөөр хөнгөлөлттэй зээл, хөрөнгийн батлагаа, даатгалын үйлчилгээ үзүүлэх тухай журам боловсруулж хэрэгжүүлэх;

в/ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхээ төрийн бус байгууллагын үйл ажиллагаат өргөжүүлж, төдэнтэй гэрээ байгуулан ажиллах, биелэлтийг жил бүр хянаж тайлагнах;

г/ улсын төсвөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд олгосон хөрөнгө оруулалтын тодорхой хувийг хөдөлгөөн байгуулагдсан хамтрагч үйлдвэрлэлийн бус байгууллахад зарцуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлэхийг дэмжих;

д/ гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх;

е/ тухайн жилд төрүүн эзлэнд дэмжих жижиг, дунд үйлдвэрийн чиглэлийг тодорхойлж, Үндэсний зөвлөлөөр батлуулж хэрэгжүүлэх;

ж/ аймаг, нийслэлийн засаг даргатай хамтран хадлан бэлтгэх, малын тэжээл үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг зохион байгуулах.

7.2 Сангийн яам:

а/ Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамтай хамтран "Аж ахуйн нэгж, байгууллагын орлогчин албан татварын тухай хууль" нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих татварын таатай орчинг бүрдүүлэх;

б/ жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын тас дотоодын гаралтай жижиг, дунд үйлдвэрт зориулахаар төвлөрсөн төсвөт тусгах байх;

в/ зээл, зээлийн батлагаа, даатгалын үйлчилгээ үзүүлэх банкны бус байгууллагыг бодлогоор дэмжих;

г/ тухайн жилийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлд орсон төрүүлэх чиглэлийн жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалтаар импортоор оруулж ирж байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түүхий эдэд татварын хөнгөлөлт үзүүлэх тухай

хүүлийн теслийг боловсруулах;

д/ Тесвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар санхүүжих тесел, хөтөлбөрийн арга хэмжээнүүдэд жижиг, дунд үйлдвэрүүдийг өргөнөөр оролцох боломжоор ханагах;

е/ Жижиг, дунд үйлдвэрийн дэмжих олгох буй зээлийн 50 хүртэл хүвий орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагаад дэмжихэд хэрэлгэх боломж бүрдүүлэх;

ж/ Монгол банктай хамтран хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг олгох, ашиглах, бачалгаа, эргэн төлөлт, дунд тооцох зээл, тусламжийг үр дүнгүй ашиглаж байгаа бол буцаан авах зэрэг механизмыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэлтэд хяналт тавих ажлыг хүлээн авах;

з/ дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эд хүдалдан авч бэлтгэхэд зориулж, улирлын чанартай хөнгөлөлтгий зээл олгох асуудлыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамтай хамтран судалж хэрэгжүүлэх.

7.3 Иед бүтүйн хөгжлийн яам:

а/ Хөдөө орон нутагт жижиг дунд үйлдвэр эрхлэхэд шаардагдах үйлдвэрийн хүч, уур дулаан, зам тээвэр, холбоог хөгжүүлэхэд бодисго үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх;

б/ Бүс нутагт үйлдвэрлэлийн зориулалтаай төвлөрсөн цахилгаан, дулааны, уур үсны найдвартай эх үүсвэрийг бий болгох;

в/ Хөдөө айл, малчдыг сэргээх эрчим хүчний эх үүсвэрээр хангах хэрилцаа холбоо, тээвийн салбарт жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх.

г/ Тев, орон нутагт зам, барилгын материалын жижиг дунд үйлдвэрийг сэргээж хөгжүүлэх;

д/ Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардагдагай ажлын байрны абсаархаг, хямд үнэтэй газар, барилга, үйлдвэрлэлмж барьж ханагаад анхаарч дэмжлэг үзүүлэх.

7.4. Байгаль орчны яам:

а/ Ой, ус, малтлага, газрын хэвлийн нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэглэх, модон материалыг орлох хөөрдөгч түүхий эд ашиглах чиглэлээр жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх саналыг, санаачлагыг дэмжин хөгжүүлэх;

б/ Бүрсан ойг цэвэрлэн, хог хаягдлыг ашиглах жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх тесел хэрэгжүүлэх.

7.5 Гадаад харилцаяны яам:

а/ Жижиг дунд үйлдвэрийн техник, технологи, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгоход зориулагдсан гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;

б/ Гадаад орнуудад суугаа элчин сайдын яамдад жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүнийг суртаалчилах, түхайн орны жижиг дунд үйлдвэрийн түршлага, шинэ техник, технологийг нэвтрүүлэхтэй холбогдох зөвлөгөө өгөх байгуулагаар дамжуулан үйлдвэрлэгчдэд хүргэх;

в/ Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад орнуудад суртаалчилах, зөвлөлгөө өгөх Төрийн бус байгуулагуудын үйл ажиллагаат дэмжих;

г/ Хөрш орнуудтай гааль, худалдааны татварыг хөнгөлөх асуудлаар хэрилцаа холбоогоо хөгжүүлэх, төрөө санхүүжүүлэх байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

7.6 Төгээрийн яам:

а/ Жижиг дунд үйлдвэрлэлд шаардагдагатай техникийн болон мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох, төдниг давтан сургах, дахин чадавхыг хөгжүүлэх арга хэмжээг боловсруулах;

б/ Жижиг дунд үйлдвэрийн менежмент, зах зээлийн судалгааны чиглэлээр онол, практикийн дадлагаа хийх сургалтын их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх замаар мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх;

в/ Бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанар сайжруулах судалгаа, эрдэм шинжилгээ, сурилтыг ажлыг зохион байгуулах;

г/ Сургууль, цэцэрлэгийн хангамжийг сайжруулах чиглэлээр жижиг дунд үйлдвэр эсвэл хөдөлмөрийн асуудлыг хамтран шийдвэрлэх.

7.7. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын яам:

а/ Жижиг дунд үйлдвэрийн техникийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлд тавих шаардлагыг дээшлүүлэх;

б/ Бүс, орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулах жижиг дунд үйлдвэрт ажиллах шаардлагатай боловсон хүчний судалгаа гаргаж ажлын байраар ханагаад дэмжлэг үзүүлэх;

в/ Эмэгтэйчүүд, хүүхэд, халамжийн байгуулагаын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, нэр төрлийг олшруулах жижиг, дунд үйлдвэрийн дэмжих чиглэл гаргах.

7.8 Хүүль зүйн яам:

а/ Аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагаат сайжруулах, төрөлийг багасгах, харилцагчийг өндөржүүлэх зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний гэрээний харилцагчыг сайжруулах, хүүлийг боловсронгуй болгох;

б/ Хөдөө Аж Ахуй Үйлдвэрийн Яамтай хамтарч жижиг дунд үйлдвэрийн үйл ажиллагаа, хөгжилд хүндрэл учруулж буй хүүль, төгтөөл, дүрэм, журыг судлан, холбогдох шийдвэр гаргуулах.

7.9. Батлан Хамгаалах Яам:

а/ Зэвсэг, хүчний ангиуд, сайбарын хангамжийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөгжүүлж, түүнд бэлтгэгдэх гарсан цэргийн болвсон хүчнийг ажиллуулах боломжийг судлан хэрэгжүүлэх.

7.10. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний яам:

а/ Үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, бүтээгдэхүүний чанарыг үнэлэх, шалгах аргачлал, стандартыг олон улсын төвшинд хүргэх;

б/ Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүнд чанарын бачалгаа хүдалдаг үйлийн хэвлийн аж ахуйн нэгжийн үүсгэл, санаачлагыг дэмжих.

в/ Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн дундаас сонь шинэ санаачлагыг дэмжиж, хэрэгжүүлэхэд урамшуулах үйл ажиллагааг өргөжүүлэх.

7.11. Төрийн өмчийн хороо:

а/ Төрийн өмчийн ашиглагдаагүй байгаа үйлдвэрлэгч үйлчилгээний байр, талбайг жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд хувьчлах арга хэмжээ авах;

б/ Улсын үйлдвэрийн газруудыг болон төрийн өмчийн ороцоотой хувьцаат компанидад хувьцаагаа байгаа төлөө төсөөрөмж, хатас болвсруулсан бүтээгдэхүүн, сав багтаа бооцын хэрэгцээнд тухай мэдээлэл, сурвалжилгаагаар хангах;

в/ Тесвийн байгуулагын захиалгаар үйсчин хэрэгцээнд зориулан авч байгаа бараа, бүтээгдэхүүн, төлөг төлөвлөгөөнд судалгаа гаргаж, түүнийг жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн дунд тендер зарлах замаар худалдан авч хэрэгжүүлэх болдогоо хэрэгжүүлэх.

7.12. Үндэсний статистикийн газар:

а/ Жижиг дунд үйлдвэрийн мэдээллийн сүлбээг бий болгож мэдээллийн санг байгуулах, мэдээллээр үйлчлэх.

8. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар:

а/ Орон нутагтаа жижиг дунд үйлдвэрийг дэмжих дээд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

б/ Жил бүр гарч буй төсвийн зөрүүнд дэмжих жижиг дунд үйлдвэрийн чиглэлд хадлан, тэжээл бэлтгэх, байгалийн баялаг ашиглах, хөдөө аж ахуйн гаралтай эдийг боловсруулах анхан шатны үйлдвэрлэл, хүн амын ахуйн үйлчилгээг өргөжүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;

в/ Жижиг дунд үйлдвэрийг дэмжих дээд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг жил бүрийн төсөвт нүүтийн хэмжээгээр тусгах, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчидийн үйл ажиллагаат дэмжихэд зориулах.

9. Сум, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар, Баг, хороонь Засаг дарга:

а/ Хүн амын өргөн хэрэгцээний бараа, өөрөөр, тар үрлэл, хүнсний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

б/ Орон нутгийн эрчим хүч, тээвэр, харилцаа холбоог хүн амын бэлтгэлээ чиглэлийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх;

в/ Шахмал түлш бэлтгэх, модон материалыг орлох хөөрдөгч үр дүнтэй материал ашиглах чиглэлийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санаачлагыг дэмжих;

г/ Хадлан, малын тэжээл бэлтгэх, түүнийг худалдан борлуулах үйлчилгээ эрхлэх сонирхолтой аж ахуйн нэгж, байгуулагын санаачилгыг, үйл ажиллагааг дэмжлэг үзүүлэх.

10. Төрийн бус байгуулага

а/ Жижиг дунд үйлдвэрийг үүсгэн байгуулах, өргөжүүлэх болон төрөөгөөгөө, аж ахуйн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, аж ахуйн хэлхээ холбоог боловсронгуй болгох, сайжруулахын чадварыг сайжруулах төсөл боловсруулахад зөвлөлгөө өгөх, төслийн үнэлгээ хийх;

б/ Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулан урт, богино хугацааны сургалт зохион байгуулах;

в/ Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулан техник, технологи, эрх зүй, банк санхүү, зах зээл судлалын тухай мэргэжлийн зөвлөгөө өгөх, хэндлэнгийн хэлалт хийх, мэдээллээр хангах;

г/ Гадаад, дотоодын үзэсгэлэн, ярилцаг жижиг дунд үйлдвэр эрхлэгчидийг өргөнөөр оролцуулах.

Дерев. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт,

11. Удирдлага, зохион байгуулалт:

11.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.

Үндэсний зөвлөл нь орон нутгийн салбар зөвлөлтэй байна.

11.2 Үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах бүрэн эрхтэй байна:

а/ Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

б/ Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт, хийх саналыг Үндэсний зөвлөл Засгийн газарт, салбар зөвлөл Үндэсний зөвлөлд тавих;

в/ Үндэсний зөвлөл нь салбар зөвлөлүүдийг арга зүйн удирдлагаар хангах;

г/ Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар зөвлөл Үндэсний зөвлөлд, Үндэсний зөвлөл Засгийн газарт тайлагнах;

11.3 Үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Үндэсний зөвлөл нь улиралд, салбар зөвлөл нь сард нэгээс дээшгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга хуралдааныг зарлан хуралдуулж болно.

11.4 Зөвлөлийн үйл ажиллагаат түүс зөвлөлөөс батална дүрмээр зохицуулна.

11.5.Энэ хөтөлбөрийн 3 дугаар бүлэгт заагдсан үйл ажиллагаат 3 хэрэгжүүлэх яам, агентлаг, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар нь үйл ажиллагааны хэрэгжилтийн явц үр дүнг Үндэсний болон салбар зөвлөлд шаардсан хугацаанд нь тайлагнах үүрэг хүлээнэ.

12. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

а/ Улсын болон орон нутгийн төсөв;

б/ Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сан;

в/ Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж;

г/ Банкны зээл, хувийн хөрөнгө оруулалт;

д/ Бусад.

13. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 1999-2004 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр

гарах үр дүн

14. Гарах үр дүн

а/ Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.5 хувиар нэмэгдэж, бараа, үйлчилгээний нийлүүлэлт сайжирна.

б/ Ажлын бай нэмэгдэж, ажилгүйдэл багасан ажил эрхлэлтийн түвшин 10 хувиар өсөж, нийгмийн тогтвортой байдал бий болно.

в/ Бизнес эрхлэгчдийн идэвхи санаачлага дээшлэн хүмүүсийн нийгмийн амьдрал оролцох оролцоо идэвхжинэ.

г/ Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн бий болж, олсон түлүүрт эдийн засгийн хөгжлийн суурь бүрдэнэ.

д/ Үйлдвэрүүдийн хангамж, борлуулалтын бүтэц, зохион байгуулалт боловсронгуй болж, түүний эд, бараа материалын хангамж тогтворжино.

е/ Аж үйлдвэрийн төвлөрөл багасаж, бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдал бий болно.

ж/ Импорт багасаж, үндэсний үйлдвэрлэл өргөжин хөгжихэд түлхэц болно.

Засгийн газрын 1999 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"Жижиг дунд үйлдвэрийг дэмжих" хөтөлбөрийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга	- Хөдөө аж ахуй үйлдвэрийн сайд	
Орлогч дарга	- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	
Гишүүд:	- Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	
	- Гэгээрлийн яамны төрийн нарийн бичгийн дарга	
	- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга	
	- Байгаль орчин яамны төрийн нарийн бичгийн дарга	
	- Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга	
	- Гадаад харилцааны яамны Гадаад хэлтлийн дарга	
	- Сангийн яамны Бүтцийн	өөрчлөлт, өмчийн хэлтсийн дарга
		- Төрийн өмчийн хорооны Жижиг аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын газрын дарга
		- Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга
		- Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/
		- Монголын бизнес хөгжлийн агентлагын захирал /тохиролцсоноор/
		- Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга /тохиролцсоноор/
Нарийн бичгийн дарга	- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Сайдын боловсруулалт, зохицуулалтын газрын дарга	

Засгийн газрын 1999 оны 10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн үндсэн арга, зохион байгуулалтын зардал

д/д	Гүйцэтгэх ажил	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая. төгрөг/		
		1999	2000	2001
1.	Хөтөлбөрийг сурталчлах: - Хөтөлбөрийг хэвлэлд нийтлэх 1 удаа х 400000	0,4	-	-
	- Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэвлэлээр сурталчлах 1 удаа х 12 х 200000	2,4	2,4	2,4
	- Хөтөлбөрийн үйл ажиллагааг радио, телевизээр сурталчлах 1 удаа х 12 х 200000	2,4	2,4	2,4
2.	Хөтөлбөрийг сурталчилж сургалт зохион байгуулах 1 удаа х 12 х 300000	3,6	-	-
3.	Хөтөлбөрийг хэвлэх, олшруулах зардал	2,0	-	-
4.	Хөтөлбөрийн хэрэгжилтэд судалгаа, шинжилгээ хийх	1,5	1,5	1,5
	Дүн	12,3	6,3	6,3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Өйд бэлэгтэх, түүнийг төмдэглэх тухай

Халхын голын байлдааны ялалтын 60 жилийн ойг төмдэглэн өнгөрүүлэх талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмж, Төрийн болон төрийн бус зарим байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халхын голын байлдааны ялалтын 60 жилийн ойг төмдэглэн өнгөрүүлэх ажлыг ахмад дайчдын гавьяа зүттэлийг алдаршуулан мөнхжүүлэх, Монгол, Орос, Японы найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, ард түмнүүдийн харилцан ойлголцлыг гүнгийрүүлэх үзэл санааны дор зохион байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Халхын голын байлдааны ялалтын 60 жилийн ойд бэлтгэх, түүнийг төмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Засгийн газрын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга – Засгийн, газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Орлогч дарга – Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
Гишүүд – Нийслэлийн Засаг дарга
– Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
– Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
– Гадаад харилцааны яамны Бодлого зохицуулалт, төлөвлөлтийн газрын дарга
– Дорнод аймгийн Засаг дарга
– Радио телевизийн хэрэг эрхлэх газрын дарга
– Энхтайван, найрамдлын байгууллагуудын холбооны гүйцэтгэх хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор)
– Монгол-Японы нийгэмлэгийн дарга (өөртэй нь тохиролцсоноор)
– Монгол-Оросын найрамдлын нийгэмлэгийн дарга (өөртэй нь тохиролцсоноор)
– Монгол-Японы харилцаа дэмжих түшлэлийн холбоо нийгэмлэгийн дарга (өөртэй нь тохиролцсоноор)
– Монголын ахмадын холбооны дэргэдэх дайнд оролцогчдын хорооны дарга (өөртэй нь тохиролцсоноор)
Нарийн бичгийн дарга – Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

3. Халхын голын байлдааны ялалтын 60 жилийн ойд бэлтгэх, түүнийг төмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах төсөв, зардлын тооцоог 1999 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох яам, байгууллагатай тохиролцон шийдвэрлэхийг Халхын голын байлдааны ялалтын 60 жилийн ойд бэлтгэх, түүнийг төмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах комиссын дарга Т. Ихагваад, уг ойд бэлтгэх, түүнийг төмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах хөрөнгийг 1999 оны төвөрсөн арга хэмжээ, төсвийн тодотголд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Я. Очирсүхэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж. НАРАНЦАЦРАЛТ**

Батлан хамгаалахын сайд **Ш. ТҮВДЭНДОРЖ**

Гэгээрлийн сайд **А. БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан

-Булган аймгийн Дашинчилэн сумын Хараат багийн малчин ЦЭРЭНДОРЖИЙН СУХБААТАР;

-Баян-өлгий аймгийн Дөлүүн сумын 2 дугаар багийн малчин ХУМАРХАНЫ МУХАМЕТБАЙ;

-Баян-өлгий аймгийн Буянт сумын Хөх-эрэг багийн малчин ГОНЧИГИЙН ДАМДИНХҮҮ;

-Говь-алтай аймгийн Дэлгэр сумын Баянөндөр багийн малчин ШАРХҮҮГИЙН СУХБААТАР;

-Говь-алтай аймгийн Жаргалан сумын Бүрэн багийн малчин СОНОМЫН ДАМДИНБАЗАР;

-Дундговь аймгийн Гурвансайхан сумын Элгэн багийн малчин ТАВХАЙН ДОНДОВ;

-Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Мөнгөн-аяга багийн малчин ЧӨЖИЛИЙН ПҮРЭВДОРЖ;

-Өвөрхангай аймгийн Бат-өлзий сумын 4 дүгээр багийн малчин СОСОРЫН БОДБҮРЭЛ;

-Завхан аймгийн Яруу сумын Хэш-улаан багийн малчин ДУЛАМЫН СҮХ;

-Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Баянбогд багийн малчин ЦОГТ-ОЧИРЫН ГҮНГАА-ОЧИР нарыг "УЛСЫН САЙН МАЛЧИН"-аар;

-Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Л.Ганболд захиралтай "УРГАЦЫН УНДРАА" ХХК;

-Сэлэнгэ аймгийн Цагаannуур сумын К.Телеухан захиралтай "ТОВХОНХАН" ХХК-ийг "УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН"-оор тус тус шалгаруулсугай.

2.Засгийн газрын 1997 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын тэргүүний тариаланч хамт олон шалгаруулах журам"-ын 10 дугаар зүйлд "...200,0 мянган төгрөгийн үнэ бүхий ..." гэснийг "...350,0 мянган төгрөгийн үнэ бүхий дурсгалын ..." гэж өөрчилсүгэй.

3."Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-ы төмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлийн үнэд зориулж 4.200 /дөрвөн сая хоёр зуун/ мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд **Ч.СОДНОМДЭРЭН**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэрийн хэмжээг 10000 төгрөгөөр, хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг 9000 төгрөгөөр тус тус тогтоож 1999 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцох олгохыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд **С.СОНИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын 1999 оны хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан даатгуулагчийн 1999 онд төлөх эрүүл мэндийн даатгалын сар тутмын хураамжийг тэдний цалин, хөдөлмөрийн хэлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувиар, мөн зүйлийн 1 дэх хэсгийн

3-10-т заасан даатгуулагч, хориглын сар тутмын хураамжийн хэмжээг 300 төгрөгөөр тогтоож 1999 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэгч.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын 1998 оны хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1998 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд **С.СОНИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

Казиногийн тухай хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсад казино байгуулахыг хориглох тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Казиногийн асуудал эрхлэх эвлэлийг татан буулгасугай.

2.Казиногийн асуудал эрхлэх эвлэлийн эд хөрөнгийн тооллого болон тесвийн зарцуулалтын тайланг гаргуулан хянаж, үлдэгдлийг холбогдох газарт шилжүүлэхийг Хууль зүйн сайд П.Цогт үүрэг болгосугай.

3.Казиногийн асуудал эрхлэх эвлэлээс "Монмакао" ХХК-тай байгуулсан гэрээг цуцлах арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд П.Цог, Сангийн сайд Я.Очирсүх нарт даалгасугай.

4."Эвлэлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1998 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 86 дугаар тогтоол, "Онцгой эрхийн эвлэвөрөл олгох тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 113 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Хууль зүйн сайд **П.ЦОГ**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 2 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлалыг батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь заалт, Ойн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалт болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлалыг хавсралтын ёсоор батлагсугай.

2. Аймаг, сум болон ойн нөөц газрынхаа ах асуйн нэгж, байгууллагын ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг энэхүү аргачлалын дагуу егөөгөд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэжүүлэхийг Байгаль орчин жамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар Т. Энэбиш, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Ойн нөөцийн эдийн засгийн үнэлгээний аргачлалыг батлах төлбөрийн мужийн хилийн заагийг тогтоох тухай Байгаль орчны хяналтын улсын хорооны 1991 оны дүгээр сарын 19-ний өдрийн 4 дүгээр тогтоолын хүчингүй болсонд тооцсугай.

САЙД **С. МЭНДСАЙХАН**

Байгаль орчны сайдын
1999 оны 11 дүгээр
тушаалын хавсралт

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал

1. Нийтлэг үндэслэл

1.1. Ойн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилгод нийцүүлэн түүнд экологи-эдийн засгийн үнэлгээ өгөхөд энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь Монгол улсын ойн тухай хууль, бусад холбогдох хэрэгслэлийн мод, түлээ бэлтгэх, ашигласны төлбөрийн тухай хуулийн зорилгод нийцэн ойн нөөцийн байгаль, аж ахуй, эдийн засгийн үндсийг тодорхойлж ойн кадастрын нэг бүрэлдэхүүн хэсэг болно.

1.3. Энэхүү аргачлалын дагуу ойн нөөцөд үнэлгээ өгөх ажлыг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага удирдан гүйцэтгүүлнэ.

1.4. Үнэлгээний ажилд тавигдах бүй зорилго, мөнгөний хэмжээ, мод,ын материалын зах зээлийн үнийн түвшинтэй зайлшгүйлэн зардлагатай гэж үзвэл үнэлгээний холбогдох норм, нормативын үзүүлэлтүүдийг тухай бүр ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төвлөрсөн хэлбэрээр шинэчлэн тогтоох байна.

1.5. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь дараахь зөвтгүүдсэ тулгуурлана:

а. ойн бүх төрлийн модны нөөцийн үнэлгээ
б. ойн дагалт баялгийн үнэлгээ
в. ойн эдэлбэр газрын үнэлгээ
г. ойн бусад ашиг төлөөллийн үнэлгээ

2. Модны нөөцийн эдийн засгийн үнэлгээ

2.1. Ойн нөхөн үйлдвэрлэлийн нөхцөл, мод, модон материалын хэрэгслэх-нийүүлэлтийн одоогийн болон хэтийн чиглэл, ойн нөөцийн хэмжээ, модон материалын тухайн үеийн зах зээлийн үнийн түвшинтэй үндэслэн ойд ургаа модны нөөцөд эдийн засгийн үнэлгээ өгнө.

2.2. Ойн модны нөөцийн газжийн (нэг м') эдийн засгийн үнэлгээг (У) дараахь аргаар тодорхойно:

У=R+З (1)

Зүүн модны нөөцийн жилийн цэвэр өсөлтийн нэгжид ноогдох ойг нөхөн сэргээх, хамгаалах өртөг, м'/тег

R–ойн нөөц ашигталтын нэгжийн рент, м'/тег

2.3. Ойн модны нөөцийн жилийн цэвэр өсөлтийн нэгжид ноогдох ойг нөхөн сэргээх, хамгаалах өртөг зардлыг (З) дараахь аргаар тодорхойлно.

З=(С+Х*Ен) (2)

С–модны нөөцийн цэвэр өсөлтөнд ногдох ойн аж ахуйн арга хэмжээний зардал, м'/тег

Х–модны нөөцийн цэвэр өсөлтөнд ногдох хөрөнгө, м'/тег.

Ен–хөрөнгө оруулалтын нөхөж төлөгдөх үр ашгийн илтгэлцүүр

2.4. Ойн нөөц ашигталтын явцад бий болох мод бэлтгэлийн нэмэлт орлого буюу рентийг дараахь аргаар тодорхойлно.

R=p–C (3)

р–модон бүтээгдэхүүний жишээл нэгжийн зах зээлийн үнэ, м'/тег

С–мод бэлтгэлийн нэгжийн нийт өртөг (нормативт ашгийг оруулсан) м'/тег

2.5. Модон бүтээгдэхүүний жишээл нэгжийн зах зээлийн үнэ (р)–г бэлтгэсэн модны хэрэглэгчний гарцын нормативын дагуу тооцно.

р=0.38 * р3+0.89рт (4)

р3-1м' зүсмэл материалын зах зээлийн үнэ, төгрөг

рт–1м' түлшний модны зах зээлийн үнэ

2.6. Мод бэлтгэлийн нэгжийн нийт өртгийг (С) дараахь аргаар тодорхойлно.

С=0 – Г + Ан (5)

0–мод бэлтгэлийн аж ахуйн нэгжийн мод бэлтгэх, ялгах, зүсмэл үйлдвэрлэх үйл ажиллаганы бүрэн өөрийн өртөг, м'/тег

Г–ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашгласны төлбөр, м'/тег

Ан–мод бэлтгэлийн үйлдвэрийн тухайн жилийн нормативт ашиг, төгрөг

2.7. Мод бэлтгэлийн үйлдвэрийн тухайн жилийн нэгжид ногдох нормативт ашгийг (Ан) өртгөөс тодорхой хувиар тооцно.

Ан=0 * а (6)

а–мод бэлтгэлийн үйлдвэрт байж болох ашгийн норм (тухайн үйлдвэрийн төсөлд өөрөөр тусгаагүй бол ашгийн нормыг 15-22 хувиар авна)

2.8. модны нөөцийн үнэлгээнд есвер, дундаж нас модыг нас гүйцсэн модонд шилжүүлж, нас модны нөөцийн үнэлгээг (Ун) түүний шинж чанарын үзүүлэлтүүдийн дагуу дараах аргаар тодорхойлно.

$$Ун = \sum_{t=0}^{T} \frac{Мс * Y}{(1+e)^t} * К1*К2*К3*К4 * К5 * К6 *К7 \quad (7)$$

Мт–ойн талбай дахь тухайн насны ангиллалд хамаардаг модны нөөц, мян.м'

Т–тухайн насны модны нөөцөд ашиглалт авуулах хугацаа, жил

t–тухайн модны нөөцийн нас,

е–хугацааны үнийн зүйлийн хөнгөлөлтийн илтгэлцүүр (хэлбэлзэл нь 0.02 – 0.08, дундаж нь 0. 05)

Хугацааны хүчин зүйлийн илтгэлцүүрийг энэхүү аргачлалын хэгүүгээр хавсралтад зааснаар авна.

К1–Ойн нөөцийн үнэлгээ, төлбөрийн мужийн ялганы илтгэлцүүр,

К2– Мод төээрийн зайны ялганы илтгэлцүүр,

К3–Модны үүдэр, төрлийн ялганы илтгэлцүүр

К4–Ойн хэсэгчлэлийн талбайн илтгэлцүүр,

К5–Модны дундаж эзэлхүүний илтгэлцүүр,

К6–Модны таваарлаг чанарын илтгэлцүүр,

К7–Модны хэрэгцээний гарцын ялганы илтгэлцүүр

3. Ойн дагалт баялгийн эдийн засгийн үнэлгээ

3.1. ойн дагалт баялагт:

а. тэрэн бүрийн жимс, жимсгэнэ
б. ойн мөөг
в. самар
г. давирхай, хусны шүүс, гэх мэт зүйл багтана.

3.2. Ойн тухайн дагалт баялгийн нэгжийн үнэлгээг түүнийг бэлтгэх нормативт зардал (Зд) болон зах зээлийн үнийн түвшинтэй (Ун) зэрэгцүүлэн (Чд) тодорхойлно.

Чд=Ун – Зд (8)

Ойн дагалт баялгийг бэлтгэх нормативт зардлын талаар тодорхой мэдээ, материалгүй нөхцөлд түүний оронд тухайн дагалт баялгээгээгүйний мөрдөж буй бэлтгэлийн үнийг хэрэглэж болно.

3.3. Ойн дагалт баялгийн нөөцийн эдийн засгийн үнэлгээг (Уд) дараах аргаар тодорхойлно.

Уд=Чд * D (9)

Уд-дагалт баялгийн тухайн төрлийн нэгжийн үнэлгээ, төг

D–тухайн төрлийн дагалт баялгийн хэмжээ, кг

4. Ойн эдэлбэр газрын үнэлгээ

4.1. Ойн эдэлбэр газрын үнэлгээг (Уг) тухайн талбайд бүрдүүлж болох модны болон дагалт баялгийн нөөцийн боломжит дээд хэмжээний дагуу дараах аргаар тодорхойлно.

Уг=па* (Мс * Ун+До * Уд) (10)

Мс–До–тухайн ойн талбайд өсөгж бүрдүүлж болох ашиглалтын насны модны нөөцийн болон дагалт баялгийн боломжит дээд хэмжээ,

5. Ойн ашигт нөлөөллийн үнэлгээ

5.1. Ойн ашигт нөлөөлөлд түүний хэрс хамгаалах, ус чийгийг зохицуулах болон агаарыг зүүлжүүлэн, цэвэршүүлэх шинж чанарууд багтана.

5.2. Ойн хэрс хамгаалах ашигт нөлөөлийн эдийн засгийн үнэлгээг (Ух) тухайн бүсэд орших хөдөө аж ахуйн эдэлбэр газрын үнэлгээний есөлтийг харгалзан дараахь аргаар тодорхойно.

$$Ух = \frac{S * Чх}{e} \quad (11)$$

Чх–ойн бүсэд орших хөдөө аж ахуйн 1 га эдэлбэр газрын нэмэлт орлого, төгрөг

S–хэрс хамгаалах ойн талбайн, га

5.3. Ойн ус, чийгийг зохицуулах ба хамгаалах ашиг нөлөөллийн эдийн засгийн үнэлгээг (Уу) усны нөөцийн нэмэгдэл орлогын есөлтөөс тодорхойлно.

$$Уу = \frac{Уо * Чу}{Sо} \quad (12)$$

Уо-ойн бүсэд орших хөрсний усны есөлт, м^3
Чу-1м усны нөөцийн үнэлгээ, төгрөг
So-тухайн нутгийн ойрхогийн түвшин, %

5.4. Ойн агаар эрүүлжүүлэх, цэвэршүүлэх ашиг нөлөөллийн үнэлгээг (Уэ) модны нөөцийн нэгжийн ялгаруулах хүчилтөрөгчийн дундаж нормативыг (КТ) нийт нөөцийн хэмжээнд харьцуулан хүчилтөрөгчийн зах зээлийн үнийн түвшинтэй (Ү кэ) үялдуулан дараахь аргаар тодорхойлно.

$$Уэ=КТ * Мо * Үкт \quad (13)$$

6. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн нийт үнэлгээ

6.1. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн нийт үнэлгээ нь модны нөөц, дагалт баялаг, ойн эдэлбэр газар болон ойн ашигт нөлөөллүүдийн үнэлгээний нийлбэрээс бүрдэнэ.

$$Уо=Ум+Уд+Ур+Ух+Уу+Уэ \quad (14)$$

6.2. Мэдээлэл, норм-нормативын зохих базыг бүрдүүлж бий болгох хүртэл ойн ашигт нөлөөлийн үнэлгээг (Ух+Уу+Уэ)-г онцлог бүсийн ойд модны нөөцийн үнэлгээг 3 дахин, хамгаалалтын бүсийн ойд 2 дахин, аншилалын бүсийн ойд 1 дахин есөсөнтэй тэнцүүлж авна.

7. Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг хэрэглэх хүрээ

7.1. ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг дараахь зориулалтаар ашиглана.

а. улсын ойн нөөцийг менгөөр илэрхийлэн үндэсний баялаг бүртгэх,

б. ойн нөөцийн хэмдэлын түвшинд өртгийн үнэлгээ өгч салбарын макро эдийн засгийн болон төгөлдөрөөй хөгжлийн үзүүлэлтийг зэрэгцүүлэн тогтоох,

в. ойн нөөцийн ашиглалтын төлбөр, нөхөн төлбөрийн тарифыг үнэлэлтэй тогтоох,

г. ойн нөөцийг түрээслэх нөхцөлд түрээсийн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл болгох,

д. ойн нөөцөд учирсан төрөл бүрийн хохирлыг хэмжээг тооцох,

ж. ойн нөөцийн эзэмшил газрыг ойн аж ахуйд бус зориулалтаар (хөдөө аж ахуй, аж үйлдвэр бариглга, зам зэрэгт) олгох өртөг, үр ашгийг тооцоход ашиглах,

з. ойн зохион байгуулах ажлын үндэслэлийг дээшлүүлэх зэрэг байна.

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлалын хавсралт

Ойн муж, мод төөрийн зай, модны үүлдэр төрлийн үнэлгээний итгэлцүүр

№	Үзүүлэлтүүд	Итгэлцүүр
1.	Ойн нөөцийн үнэлгээ, төлбөрийн муж:	
	- нэгдүгээр муж	1,50
	- хоёрдугаар муж	1,15
	- гуравдугаар муж	1,0
	- дөрөвдүгээр муж	0,70
2.	Мод төөрийн зай:	
	- 50 хүртэл км	1,30
	- 51-70 км	1,20
	- 71-90 км	1,10
	- 91-120 км	1,0
	- 121-150 км	0,9
	- 151-ээс дээш км	0,8
3.	Модны үүлдэр:	
	-гацуур жодоо	1,42
	- нарс	1,25
	- шинэс	1,0
	- хуш	0,60
	- улиас, улиангар	0,51
	- бургас, харгана, заг	0,45
4.	Ойн хэсэглэлийн талбай га:	
	- 1,0 хүртэл	1,4
	- 1,1-3,0	1,12
	- 3,1-5,0	1,1
	- 5,1-10,0	1,00
	- 10,1-15,0	0,99
	- 15,0-оос	0,96
5.	Модны дундаж эзэлхүүн, м^3:	
	0,2 хүртэл	1,2
	0,21-0,29	1,0
	0,30-0,39	0,98
	0,40-0,49	0,96
	0,50-0,75	0,93
	0,76-ба	0,86
6.	Модны тэвээрлэг чанар:	
	- хэрэглээний том	1,2
	- дунд	1,0
	- жижиг	0,80
	- түлээ	0,40-0,50
7.	Модны хэрэглүүлэгийн төрөл, гарц:	
	- хэрэглээний, том	1,20
	- хэрэглээний, дунд	1,0
	- хэрэглээний, жижиг	0,80
	- түлээ	0,40-0,50

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын гаргаж, Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгийн зөвлөл

Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 329612, 322838
Индекс 14503

Төр. Засгийн Үйлдлүүдээ аж ахуйн нэгэж газрын харьяа хэсэг үйлдвэрт 3350-ш хөтөлж

☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны гуравдугаар сарын 2 | № 9 (88)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

88. Үндэсний бүтээмжийн шагнал бий болгох саналыг дэмжих тухай Дугаар 20 148

89. Д.Лхагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 21 149

90. А.Загдсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай Дугаар 22 149

91. Д.Ням-Осорт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 23 149

92. Г.Жамбад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 24 149

93. Ж.Шараад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 25 149

94. Ц.Өлзий-Оршихад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 26 149

95. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 27 150

96. Б.Алданышийг "Шударга журам медалиар шагнах тухай " Дугаар 28 150

97. Ч.Түвшинжаргалыг "Шударга журам медалиар шагнах тухай " Дугаар 29 150

98. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай Дугаар 30 151

99. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай Дугаар 31 151

100. Б.Лигдэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 33 151

101.Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 35 151

102. Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 36 151

Хоёр. Яам, агентлагийн акт

103. Журам батлах тухай (Монгол Улсын Хууль зүйн сайдын тушаал) Дугаар 15 151

104. Журам батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 04 152

105. Журам батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 08 153

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 09-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

Үндэсний бүтээмжийн шагнал бий болгох саналыг дэмжих тухай

Бүтээмж дээшлүүлж, чанар сайжруулах хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх нь үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад ач холбогдолтойг тэмдэглэж ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг дээшлүүлж, улс орны эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Үндэсний бүтээмжийн шагнал" бий болгох тухай Үндэсний бүтээмжийн шагналын сан, Үндэсний бүтээмж, хөгжлийн төвийн саналыг дэмжсүгэй.

2. Үйлдвэр, цех, тасаг, нэгж, ажлын байр бүрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаар хамтын хүчээр идэвхтэй санаачилгатай ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах хүмүүс, ажилчид, малчид, тариаланчид, нийт иргэддээ уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

Д. Лхагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж мал сүргээ өсгөн үржүүлэх, үр шимийг бүрэн ашиглах, иргэдийг малжуулах, сүргүүль, эмнэлгийг ивээн тэтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх Завхан аймгийн Завханмандал сумын Мандал багийн малчин Догсомын Лхагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 22 | Улаанбаатар хот

А.Загдсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Урлаг, боловсролын байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж үндэсний болон дэлхийн сонгодог дуурийн олон шилдэг дүр бүтээж улс ороондоо дуурийн урлагийг үүсгэж хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, дуулаачийн үндэсний дэг сургуулийг төлөвшүүлэхэд оруулж байгаа үнэтэй хувь нэмрийг нь үнэлэх Соёл урлагийн их сургуулийн багш Аюушийн Загдсүрэнд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

Д.Ням-Осорт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбар болон эм хангамжийн албыг олон жил удирдан зохион байгуулж, салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, оношлогоо, эмчилгээ, шинжилгээний шинэ аргуудыг нэвтрүүлэх, манай улсад эм хангамжийн байгууллагыг үүсгэх, туүний нэгдсан тогтолцоог бий болгож хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх "Монголэмимпекс" концерний эвлэлээ мэргүүжилтэн, эм зүйч Дарьсүрэнгийн Ням-Осорт Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

Г.Жамбад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсрол, эрүүл мэндийн байгууллагад үр удаан жил үр бүтээлтэй ажиллаж, эрүүл мэндийн салбарын боловсон хүчин бэлтгэх, анагаах ухааны суурлаг, эрдэм судлалын болон халдварт, нян судлалын мэргэжлийн албыг үүсгэн бий болгож хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх Анагаах ухааны их сургуулийн тэнхимийн эрхлэгч Ганжаагийн Жамбад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

Ж.Шараад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлаг, боловсролын байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж олон арван шилдэг дуу, дан хөгжмийн бүтээл туурвин, нийтийн дуучны урлагийг хөгжүүлэх, хөгжмийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөгжим, бүжгийн колледжийн багш, хөгжмийн зохиолч Жамбалын Шараад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 26 | Улаанбаатар хот

Ц.Өлзий-Оршиход Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын болон зохиолын олон арван дуут өөрийн өвөрмөц өнгө зохиомжтойгоор чадварлаг дуулж, үзэгч сонсогчдын талархал хүлээж, нийтийн дуучны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын ардын дуу, бүжгийн чуулган гоцлол дуучин Цогт-Очирын Өлзий-Оршиход Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, тэр захиргаа, төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласн байгаа болон ахмад настан дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Жамъянгийн Банзрагч - Бизнес эрхлэгч ахмадуудын төвийн гүйцэтгэх захирал
2. Түвдэнгийн Ваанчиг - Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн газрын ерөнхий мал зүйч
3. Санжаагийн Заяа - Нийслэлийн гадаад хэлний сургалттай 18 дугаар дунд сургуулийн англи хэлний багш
4. Дэчинсандуйн Надмид - Нийслэлийн ардын уралгийн "Цэхиүр" хамтлагийн дуучин
5. Хандсүрэнгийн Пүрэвдорж - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга
6. Жанжаахүүгийн Хулганаа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэн, ахмад шатарчин
7. Лувсандамбын Хуушаан - Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбооны ахмад ажилтан
8. Сандүйн Шатар - ШУА-ийн Химийн-технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний төрүүлэгч ажилтан

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Гончигийн Батсуурь - Өвөрхангай аймгийн Барүүнбаянулаан сумын багийн багш эмч
2. Даваагийн Баянмөнх - Нийслэлийн 62 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
3. Шаравын Бурмаа - Цагаатгах ажлыг удирдах зохион байгуулах ажлын комиссын ажилтан
4. Жанлавын Баямбажав - Үндэсний хуулийн цэцийн гишүүн
5. Пандийн Баямбацэрэн - Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч
6. Норовын Дашдондог - Өвөрхангай аймгийн Сант сумын Цахиурт багийн Засаг дарга
7. Самдангийн Дашхүү - Тэр, заслийн үйлчилгээ, аж ахуйн эрхлэх газрын төрийн ордны аж ахуйн эрхлэгч
8. Дэндэвийн Дамбэрэл - Дайнд оролцогсдын монголын хорооны харицуатгатай нарийн бичгийн дарга
9. Сүүрийн Жанцан - Үндэсний хуулийн цэцийн гишүүн
10. Лувсанцэрэнгийн Жигмэд - Нийслэлийн "Сүүг ХК-ийн үйлдвэр" дарга
11. Даваагийн Лхагвацэрэн - Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн төвийн захирал, зөвлөх эмч
12. Дагдангийн Лүндэн - Увс аймгийн Хяргас сумын Бугат багийн малчин
13. Далантайн Мичка - Нийслэлийн үйлдвэр худалдааны "Хөмөг" ХХК-ийн ерөнхий захирал
14. Лувсангийн Монхоорой - Сүхбаатар аймгийн Түвшинширэв сумын иргэн, уран дархан
15. Бэх-Очирын Мягмаржав - Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбооны ажилтан
16. Бадарчийн Нансалмаа - Тэр, заслийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хэвлэх үйлдвэрийн ажилчин
17. Гочоогийн Нямаа - Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн, өндөр настан

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Шагдарын Бужидмаа - Нийслэлийн 129 дугаар цэцэрлэгийн арга зүйч багш
2. Гомбодоогийн Цэцэгсайхан - Тэр, заслийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Хэвлэх үйлдвэрийн ахлах нягтлан бодогч
3. Чулуунбатын Чулуунцэцэг - Мөн үйлдвэрийн ажилчин
4. Зандрагийн Янжмаа - Нийслэлийн 55 дугаар дунд сургуулийн захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Б.Алданшишиг "Шударга журам" медалиар шагнах тухай

Нуурын усанд живсэн хөөр хүний амийг эр зориг, авхаалж самбаа гарган аварч иргэний үүргээ нэр тэртэй биелүүлсэн Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын иргэн Болатханы Алданшишиг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Ч.Түвшинжаргалыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Хүдгийн усанд унасан хүүхдийн амийг эр зориг, авхаалж самбаа гарган аварч иргэний үүргээ нэр тэртэй биелүүлсэн Дорноговь аймгийн Мандах сумын иргэн Чулуунгийн Түвшинжаргалыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 30 — Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Базаррагчаагийн Баярсайханыг тохоон томилсугай.
2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Лувсанжамцын Удвалыг Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 31 — Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Европын Холбоо, Бельгийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг тохоон томилсугай.
2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Жагваралын Ганбаатарыг Монгол Улсаас Европын Холбоо, Бельгийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 33 — Улаанбаатар хот

Б.Лигдэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж, хэвлэлийг ардчилал шинэчлэлтийн шинэ нөхцөлд тохируулан өөрчлөх, залуу сэтгүүлчийг дадлагажуулан сургах, монгол сэтгүүлзүйг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэрийг нь үнэлэн "MN-Өнөөдөр" сонины тойм, ерөнхий редакторын орлогч Батмөнхийн Лигдэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 35 — Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Сономдоржийн Пүрэвсүрэнг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Занын Доржнамжинг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Бадарчийн Сайханцацралыг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчийн, Лamжавын Ганболдыг Өмнөговь аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, өөрийнх нь хүсэлтийг харгалзан Готодоржийн Цагаанцоожийг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 12-ны өдөр — Дугаар 36 — Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Сономдоржийн Пүрэвсүрэнг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Занын Доржнамжинг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн, Дашдамбын Дондовыг Дархан - Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Пүрэвсандагийн Магсаржаламыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Баярын Цэндийг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Чулуунбаатарын Энхтуяг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Ламжавын Ганболдыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намдагийн Нямсүрэнг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бадарчийн Сайханцацралыг Ниислэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 2 дугаар сарын 5-ны өдөр — Дугаар 15 — Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 7 дахь заалтад заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журмыг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Энэ журмын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Мөрөнд үүрэг болгосугай.

САЙД — **Л.ЦОГ**

НЭГ.Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэдэг шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хууль зүйн сайдын 1999 оны 15 дугаар тушаалын хавсралт

2. Цагдаа, гал түймэрэгтэй тэмцэх, төрийн тусгай хамгаалалт, шүүхийн шийдэвр биелүүлэх, хүн, мал эмнэлэг, цахилгаан, дулаан, уус суваг, холбоо, үйлдвэрийн ослын дуудлагын шуурхай ажлын авто машинд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэнэ.

3. Шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх эввэвеерлийг байнын болон түр хугацаагаар огноо болно.

4. Тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглосон шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэл нь стандартад нийцэн тусгай өнгө будаг, бичлэгтэй байхаас гадна өдрийн өнгөтэй байж болно.

5. Шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэгсэл эввэвеерлийг нийслэлд Замын цагдаагийн газар, аймагт цагдаагийн хэлтэс олгоно.

6. Зохих эввэвеерлүүгийгээр авто тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэгээлийг хориглоно.

ХОЁР. Тусгай дуут болон гэрлэн дохиог хэрэглэх

7. Дор дурдсан шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэлд дараахь өнгийн тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэнэ. Үүнд:

7.1. цагдаагийн байгууллагын бүх төрлийн шуурхай албаны авто тээврийн хэрэгсэл, мотоцикл-хөх улаан;

7.2. гал унтраах албаны бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд-хөх;

7.3. хүн эмнэлгийн түргэн тусламжийн авто тээврийн хэрэгсэлд-ногоон;

7.4. мал эмнэлгийн түргэн тусламжийн авто тээврийн хэрэгсэлд-ногоон;

7.5. ослийгаан, дулаан, ус суваг, холбоо, үйлдвэрийн ослын дуудлагын үйлчилгээний авто тээврийн хэрэгсэлд-шар;

7.6. шүүхийн шийдэвр биелүүлэх байгууллагын онц аюултай гэмт хэрэгтэн хүлээн хүргэх, эрэн сурвалжлах албаны авто тээврийн хэрэгсэлд-улаан.

7.7 Төрийн тусгай хамгаалалтын үед хөтөч машингүйгээр хамгаалалтад явах авто тээврийн хэрэгсэлд-улаан.

ГУРАВ. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх эввэвеерлэл олгох

8. Шуурхай ажлын авто тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх байгууллага нь тэр тухай хүсэлтээ нийслэлд Замын цагдаагийн газар, аймагт цагдаагийн хэлтэст бичгээр гаргана.

9. Байгууллагаас хүсэлт, үндэслэлийг хянан үзэж, хуралд нийцэж байгаа бол уг тээврийн хэрэгслийг гэрчилгээн дээр "тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх" тэсэн тэмдэглэл хийж эввэвеерл олгоно.

10. Энэ журмын 7-д заагдсан албан үүргийг байнга гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэлд түр болон байнын эввэвеерл тус тус олгоно.

11. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх эввэвеерл авсан авто тээврийн хэрэгслийн зориулалт өөрчлөгдөх бүр тусгай дуут болон гэрлэн дохиог авч, өнгө будгийг арилган нийслэлд Замын цагдаагийн газар, аймаат цагдаагийн хэлтэст мэдэгдэнэ.

12. Замын цагдаагийн газар, аймагт цагдаагийн хэлтэс тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх эввэвеерл олгосон болон зориулалт өөрчлөгдөөн тухай бүртээл хөтөлнө.

ДӨРӨВ. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглээн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний журам

13. Шуурхай ажлын авто тээврийн хэрэгслийн жолооч нь эввэон хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэх явах үедээ тусгай дуут болон гэрлэн дохиогоо ажиллуулж, хөдөлгөөний аюулгүй байдал бүрэн хангагдсан гэдэгт бүрэнитгэсэн нөхцөлд Замын хөдөлгөөний дүрэмд заасан зохицуулагчийн дохионоос бусад заалтаас гажих болно.

14. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглээн авто тээврийн хэрэгслийн жолооч нь тусгай дохионы хэрэгслийг хөдөлгөөнд ороцдогоос ойлгогдохуйц ойрхон зайд, тэрнийг сандрааж, цочирдуулахгүй, эрэгт урсгалд орж бусдыг шахаж хөдөлгөөнд саад учруулахгүй байвал зохино.

15. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглээн авто тээврийн хэрэгслийн жолооч нь дохионы хэрэглээ ажиллуулсан ч хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөхгүй.

16. Хойшлуулшгүй ажлаас бусад үед шуурхай ажлын авто тээврийн хэрэгслийн дохионы хэрэгслийг ажиллуулахыг хориглоно.

17. Ослын дуудлагын үйлчилгээний авто тээврийн хэрэгслүүд ослын газарт үүрэг гүйцэтгэх үедээ тусгай дуут болон гэрлэн дохиогоо ажиллуулж болно.

ТАВ. Тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

18. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд тусгай дуут болон гэрлэн дохиог хураан гэм буруутай эгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалтыг үндэслэн загасны нөөц баялгийг хамгаалах, ахуйн зориулалтаар загас барих ажлыг жүрамлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Ахуйн зориулалтаар загас барих журам"-ыг хавсралтын ёсоор батална.

2. Энэ журмын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгч нь хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчныг хамгаалах алба, аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хянаатын албад, нийслэлийн Байгаль орчны хянаатын газарт даалгасугай.

САЙД | **С. МЭНДСАЙХАН**

Байгаль орчны сайдын 1999 оны 04 дүгээр тушаалын хавсралт

АХУЙН ЗОРИУЛАЛТААР ЗАГАС БАРИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Ахуйнурын загасны нөөц бүхий гол мөрөн, нуур цөөрөмд монгол улсын эрх иргэн, түүс улсад үр бүтэн байнга оршин суух бүй гадаадын иргэн ахуйн зориулалтаар загас барихад энэхүү жүрмыг мөрдөнө.

Хоёр. Эввэвеерл олгох

2. Ахуйн зориулалтаар загас барих эввэвеерлийг Байгаль орчны сайдын 1995 оны 161 дүгээр тушаалаар батлагдсан ан аңнах, загас барих эрхийн бичгийн маягтаар аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас эрх олгосон ажилтан олгоно.

3. Ахнурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан аңнах, барих эввэвеерлийн хураамжийн тухай хуулийн дагуу Засгийн газраас тогтоосон хэмжээний хураамжийг бэлнээр буюу бэлэн бусаар хураан авсны үндэсэн дээр загас барих эввэвеерлийг олгоно.

4. Эввэвеерл нь 2 хүртэл хоногийн хугацаанд хүчинтэй бөгөөд уг эввэвеерлэд загас барих хүний хаяг, өөрт нэр, загас барих газрын нэр, барих загасны тоо, эввэвеерлийн хүчинтэй байх хугацаа, төлсөн хураамжийн хэмжээ зэргийг тодорхой тусгасан байна.

5. Эввэвеерлийг хөөр хүвь үйлдэх ба загас барих иргэнд хөөрдүгаар хувийг өч нөгдүгээр хувийг эввэвеерл олгосон жилтан авч үлдэх ба эввэвеерлийн хуудсанд олгосон, хүлээн авсан хүний гарын үсгийг зуруулж тэмдэг дарсан байна.

Гурав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчны хянаатын албаны үүрэг

6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчны хянаатын алба нь дараах үүргийг хүлээнэ:

6.1. Ахуйн зориулалтаар загас барихтай холбогдсон хууль тогтоомж, журам заавырт арга иргэдэд сурталчлан таниулж, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиох.

6.2. Тухайн аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрт ахуйн зориулалтаар загас барих бүсийг тогтоолгож анхаарууллага санамж бүхий тэмдэгтэй болгох.

6.3. Загас бүхий гол мөрөн, нууруудад Ан агнуурын хууль тогтоомж болон энэхүү жүрмын биелэлтийг шалгах.

6.4. Загасны нөөц баяршуг хамгаалах, хэвийн өсөлт үржилтийг нь хангахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6.5. Загас барих эрхийн бичгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, бүртгэл, тооцоо, хураамжийн орлого, түүний зарцуулалтад хянаат тавих.

6.6. Загас бүхий гол мөрөн, нуур цөөрмийн ус, эрэг орчмын ой мод, газрын хөрсийг хамгаалах, нэн ховор, ховор загас бүхий загас, мөн төрлөөр загасны нөөц нь хомсдсон газрыг орон нутгийн хамгаалалтад авахуулах.

6.7. Шаардлагатай гэж үзсэн гол мөрөн, нуур цөөрөмд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар загасны нөөц зүйлийн бүрэлдэхүүн, идэш тэжээлийн судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулах, хэрэгжүүлэх

6.8. Загасны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах эрхийн бичиг олгохтой холбогдсон үйл ажиллагааг журмалах асуудлаар санал хүсэлтээ аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүнчлэн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тев байгуулагад тавьж шийдвэрлүүлэх.

Дорөв. Загас сонирхогч иргэний үүрэг

7. Аxуйн зорилалтаар загас барих иргэд нь дор дурдсан үүргийг хүлээнэ:

7.1. Ан агнуурын хууль тогтоомж болон энэхүү журмын заалтыг дагаж мөрдөх.

7.2. Байгаль орчны хэнаатын улсын байцаагч, байгаль хамгаалагчид болон тухайн орон нутгийн эрх бүхий албан тушаалтаны анхны шаардлагаар загас барих эрхийн бичиг, биеийн байцаалт, загас барихад ашиглаж байгаа багаж хэрэгслэл, барьсан загасыг үзүүлэх, тэдний тавьсан шаардлагыг биелүүлэх.

7.3. Гол мөрөн, нуур цөөрөм тэдгээрийн эрэг орчмын газрыг бохирдуулахгүй, мод сөөгийг хүчилж гэмтээхгүй байх, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхаарал, сонор сэрэмжтэй байх

Тав. Хориглох зүйл.

8. Аxуйн зорилалтаар загас барих, зөвшөөрөл олгохд дор дурдсан зүйлийг хориглоно:

8.1. Аxуйн зорилалтаар загас барихад төрөл бүрийн тор, гувчуур, сэрээ, цахилгаан гүйдэл, тэсэрч дэлбэрэх болон химийн бүсад бодис ашиглах, хэрэглэх.

8.2. Гол горхины бэлчрээс 100 мөтрийн зайнаас дотогш загас барих.

8.3. Эрхийн бичигт заасан хугацаа, тоо хэмжээнээс хэтрүүлж загас барих.

8.4. Эрхийн бичигт заасан газраас өөр газарт загас барих.

8.5. Байгаль орчны сайдын тушаалаар загварыг нь батална эрхийн бичгийн маягтаас өөр загварын эрхийн бичгээр, эсвэл албан тоотоор загас барих зөвшөөрөл олгох.

8.6. Тул загасны 40 см-ээс бага, зөвхөр, хадран, цулбуурт, цурхай, гутаарь, бүлүү цагаан загасны 10 см-ээс бага хэмжээтэйг барих /энд дүрсэн хэмжээнээс жижиг загас дэгээнд орсон нөхцөлд дэгээнээс салгаж үсанд нь эргүүлж тавих./

8.7. Дан буюу нэг ширхэг, хоёр, гурван салаа дэгээнээс илүү тооны дэгээтэйэр загасчлах.

8.8. Голын салаа болон тэтүурганд зориудын аргаар хаалт, шахуурга хийж загасчлах.

8.9. Загас агнуур эрхэлдэг мэргэжлийн аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд загасны уярга, сдиннинг, утас, дамар, дэгээнээс бусад үйлдвөрлэлийн зориулалтаар загас барихад хэрэглэдэг тор хэрэгслэлийг худалдаалах.

8.10. Ан агнах, загас барих эрхийн бичгийг дур мэдэн хэвлэх, ашиглаж ашиглах.

Зургаа. Бусад зүйл

9. Загасчлах, загасчлуулах үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийд заасан хугацаа, журмын дагуу шийдвэрлэнэ.

10. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэнд Байгаль орчны хамгаалах тухай, Ан агнуурын тухай болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр — Дугаар 05 — Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Байгаль орчны хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам"-ыг нэгдүгээр, Байгаль орчны мэргэжлийн байгууллагын гэрчилгээний загварыг хөрдүгаар, Итгэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын жагсаалтыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус батална.

2. Уг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хянаалт тавьж ажиллахыг Бодлогын хэрэжилтийг зохицуулах газрын дарга Н.Сарантуяад даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах, мэргэжлийн комисс байгуулах тухай" Байгаль орчны сайдын 1996 оны 177 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.МЭНДСАЙХАН

Байгаль орчны сайдын 1999 оны 08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. "Байгаль орчныг хамгаалах тухай" Монгол улсын хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тев байгууллага /цаашид "төрийн захиргааны тев байгууллага" гэх/-аас байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Энэхүү журмын зорилго нь байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрхлэх байгаль орчны мэргэжлийн байгууллага /цаашид "мэргэжлийн байгууллага" гэх/-ын үйл ажилагааны эрх зүйн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мэргэжлийн байгууллага, түүний эрхлэх ажил.

3. Газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, үргамал зэрэг байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаат эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.

4. Мэргэжлийн байгууллага хариуцан нутаг дэвсгэртээ даралхь үйл ажиллагаагаа хэрэжүүлэх.

4.1. төрийн захиргааны тев байгуулага, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгалийн баялгийг ашиглах гэрээ байгуулах, уг гэрээний дагуу байгалийн баялгийг ашиглах газрыг заажк өгөх гэрээний биелэлтэд хянаалт тавих, гэрээг дүгнэх

4.2. байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэжүүлэх ажлыг зохион байгуулах

4.3. байгалийн баялгийн нөөцийн судалгаа хийлгэх захиалга өгөх

4.4. байгалийн баялгийг өөчин, хөнөөлт мэрэгч амьтан болон шавьж, түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээн хэрэжүүлэх

4.5. байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах,

өхөн сэргээх талаар иргэн, аж ахуйн нэгж, байгуулагын үйл жиллагааны технологийн хяналт тавих, мэргэжил, арга зүйн услалцаа үзүүлэх;

4.6. байгалийн баялгийн болон үс цаг үур, орчны өрчлөлтийн ажиглалт хийж, тоо баримтыг мэдээллийн санд тусгуулах;

4.7. байгалийн баялгийг судлах, хамгаалах, зохистой шиглах, нөхөн сэргээх арга хэмжээний тухай саналаа ргэдийн Төлөөлөгчидийн Хурал, Засаг даргад танилцуулж ийдвэрлүүлэх, шаардлагатай бол төрийн захиргааны төв айгуулагад уламжлах;

4.8. сумын Засаг даргын шийдвэрийн дагуу тусгай өхцөл болзолтой гэрээний үндсэн дээр байгалийн баялгийг шиглан хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ рхлэх.

5. Мэргэжлийн байгууллага нь дараахь ангилалд уваргана:

5.1. Газрын мэргэжлийн байгууллага;

5.2. Газрын хөвлийн мэргэжлийн байгууллага;

5.3. Ойн мэргэжлийн байгууллага;

5.4. Усны мэргэжлийн байгууллага;

5.5. Ан амьтны мэргэжлийн байгууллага;

5.6. Уgrамлын мэргэжлийн байгууллага;

5.7.Ус цаг, уур орчны хяналт шинжилгээний мэргэжлийн зүйгуулага.

6. Төрийн захиргааны төв байгууллага нь байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлын инжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүргэ бүхий тгэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгуулагыг килүүлж болно.

7. Иттэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний айгуулага нь байгалийн баялгийн нөөцийг тоо хэмжээг отлох арга-члал, үр дүнг батлагаажуулах, нөөцийн ашиглаж олох тоо хэмжээний талаар санал, үндэслэл гаргах чиг ргэтэйгээр ажиллана.

8. Мэргэжлийн байгууллага нь тухайн шатны Засаг даргын айгаль орчныг хамгаалах талаархи бүрэн эрхээ эргүүлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах итгэмжлэгдсэн кийлүүлж болно.

9. Мэргэжлийн байгууллага нь энэ журмын "Хоёр"-ын 5-д асан ангиллын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Гурав. Мэргэжлийн байгуулагын эрх олгоход тавих шаардлага, эрх олгох

10. Мэргэжлийн байгуулагын эрх авахыг хүссэн аж ахуйн эгж, байгуулага өргөдлөө дараахь баримт бичиг эвсаргана:

10.1. аж ахуйн нэгж, байгуулагын талаарх зохих атны Засаг даргын тодорхойлолт;

10.2. аж ахуйн нэгж, байгуулагын мэргэжлийн боловсон ичний тодорхойлолт;

10.3 аж ахуйн нэгж, байгуулагын улсын бүртгэлийн рчилгээ, дүрэм;

10.4. аж ахуйн нэгж, байгуулагын санхүүгийн чадавхийг тгалсан татварын албаны тодорхойлолт, банкны баталгаа.

11. Мэргэжлийн байгуулагын эрх хүссэн аж ахуйн нэгж, йгуулага дараахь шаардлага хангасан байна:

11.1. мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;

11.2. хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног хөөремж болон мэдээллийн хангамжийн тухай танилулагтай байх;

11.3. байгалийн баялгийн нөөцийг тогтоох болон үс цаг р, орчны хяналт шинжилгээ хийх батлагдсан арга зүйтэй йх;

11.4. байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөртэй байх.

12. Мэргэжлийн байгуулагын эрх авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгуулагын хүсэлтийг хүлээн авах, хянаж шийдвэрлүүгээх ажлыг Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцан гүйцэтгэнэ.

13. Энэ журмын "Гурав"-ын 10, 11-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй, шаардлагыг хангаагүй бол аж ахуйн нэгж, байгуулагын өргөдлийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хүлээн авахгүй.

14. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар баримт бичгийг хүлээн авснаас хойш жилын 21 хоногийн дотор хянан үзэж, мэргэжлийн байгуулагын эрх олгох эсэх талаар холбогдох албаны дүгнэлтийг үндэслэн санал боловсруулна.

15. Саналыг Байгаль орчны Сайдын зөвөлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, аж ахуйн нэгж, байгуулагад мэргэжлийн байгуулагын эрх олгох, мэргэжлийн байгуулагын эрхийг сунгах асуудлыг шийдвэрлүүлнэ.

16. Аж ахуйн нэгж, байгуулагад мэргэжлийн байгуулагын эрхийн гэрчилгээг Байгаль орчны сайдын тушаалаар 2 жилийн хугацаатайгаар олгоно.

17. Мэргэжлийн байгуулага эрхийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө эрх сунгуулахыг хүссэн өргөдлөл гаргаж, түхайн шатны Засаг даргын тодорхойлолт, гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах талаархи үйл ажиллагааны хөтөлбөрийн хамт Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлсэн байна.

18. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар баримт бичгийг хүлээн авснаас хойш жилын 14 хоногийн дотор хянан үзэж, мэргэжлийн байгуулагын эрхийн хугацаг сунгах эсэх талаар холбогдох албаны дүгнэлтийг үндэслэн санал боловсруулна.

19. Байгаль орчны сайдын тушаалаар мэргэжлийн байгуулагын гэрчилгээг 2 жилийн хугацаатайгаар сунгана.

Дөрөв. Мэргэжлийн байгуулагын эрх, үүрэг

20. Мэргэжлийн байгуулага нь дараахь үүргэ хүлээнэ:

20.1. байгаль орчны хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, ажлынхаа үр дүнг захиалагч болон төрийн захиргааны төв байгуулагын өмнө бүрэн хариулах;

20.2. мэргэжлийн хүмүүсийн мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж байх;

20.3. өөрийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээ баримт, тайланг байгаль орчны мэдээллийн төв санг бүрдүүлэх журмын дагуу холбогдох үзүүлэлтээр гаргаж өгөх;

20.4. дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг тухайн оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан гаргаж, зохих шатны Засаг дарга болон төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлж байх;

20.5. хайгуул судалгааны үр дүн, эрдэм шинжилгээний тайланг итгэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгуулагын эрдмийн зөвөлөлийн хуралаар хэлэлцүүлж батлагаажуулах;

20.6. гүйцэтгэсэн ажил нь Монгол улсын байгаль орчны хууль тогтоомж, холбогдох журам, заавар, захиалагчтай байгуулсан гэрээний нөхцөлийг зөрчсөн, мэргэжлийн шаардлага хангаагүйгээс дахин хийхээр бол гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр хийх.

21. Мэргэжлийн байгууллага дараахь эрх эдэлнэ:

21.1. аж ахуйн нэгж, байгуулагын захиалгаар өөрийн чиглэлийн мэргэжлийн ажлыг гэрээний үндэсэн дээр гүйцэтгэх;

21.2. байгаль орчны чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх, үнэлэлт, дүгнэлт гаргах, сургалт, семинар зохион байгуулах, байгаль орчны талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.3. эрхэлсэн ажлын чиглэлээр технологийн хяналт тавих, тендерт оролцох, улсын захиалгат ажил гүйцэтгэх;

21.4. мэргэжлийн болон холбогдох бусад байгууллагын хүмүүсийг хариулан тохироолцсоны үндэсэн дээр өөрийн ажилд татан оролцуулах.

Тав. Бусад зүйл

22. Мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээг бусдад дамжуулах, гэрчилгээний хугацаа дууссан үед мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа явуулахыг хоригдоно.

23. Төрийн захиргааны төв болон нутгийн захирганы байгууллага нь мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаагаа шалгаж дүгнэх, ажлын үр дүнд шүүмж хийнэ.

24. Мэргэжлийн байгууллагын эрхийг даравэх тохтолдолд төрийн захиргааны төв байгууллага хүчингүй болгоно:

24.1. аймаг, нийслэлийн Засаг даргатай харгалзан үзэх үндэслэлтэй хүсэлт, дүгнэлт гаргасан;

24.2. 24.2. мэргэжлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах хөрөнгө санхүү, боловсон хүчний чадваргүй болсон;

24.3. гэрчилгээнд заагдсан үйл ажиллагаа 1 жилийн хугацаанд явуулаагүй;

24.4. эрхлэх ажлын чиглэл өөрчлөгдсөн;

25.5. мэргэжлийн байгууллага нь өөрийн чиглэлээр.

24.6. гэрчилгээнд заасан хугацаа дууссан;

24.7.өөрийн хүсэлтээр.

25. Мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах асуудлы бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын саналы үндэслэн Байгаль орчны сайдын тушаалаар мэргэжлий байгууллагын гэрчилгээг хүчингүй болгоно.

26. Байгаль орчны мэргэжлийн хяналтын алба нь тө орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаан, хяналт тавьж, мэргэжлийн байгууллагын бурууталт үй ажиллагаагаа таслан зогсоох арга хэмжээ авч төрий захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

27. Газар зохион байгуулалт, газрын төлөв байдаг чанарын хяналт баталгаа хийх мэргэжлийн байгууллагы эрхийг Газар зохион байгуулалтын албаны санал, дүгнэлтий үндэслэн Байгаль орчны сайд шийдвэрлэнэ.

28. Аж ахуйн нэгж, байгууллагад газар зохио байгуулалт, газрын төлөв байдал, чанарын хяналт баталга хийх, газрын хэвлийг ашиглах, нөхөн сэргээх чиглэлээ мэргэжлийн байгууллагын эрх олгох асуудлыг холбогдо хууль тогтоомжоор зохицуулна.

29. Энэ журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Байгаль орчны сайдын 1999 оны 08 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
/загвар, нүүрэн тал/

МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ

ДУГААР .....

.... (аймаг, нийслэл)-ийн .....
(сум, дүүрэг)-ийн ..... тоот регистрийн дугаартай .....
.....
.....

(аж ахуйн нэгж , байгууллагын нэр)

"Байгаль орчныг хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн:

.....
.....
.....
.....
.....

чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаатайгаар олгов.

Байгаль орчны сайд .....

..... оны ... дугаар сарын -ны өдөр Улаанбаатар хот

/загвар, ар тал/

Нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл

Д/Д	Өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		он, сар, өдөр	гарын үсэг

Энэхүү гэрчилгээг хуулбарлах, олшруулахыг хориглоно.

Байгаль орчны сайдын 1999 оны 08 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Итгэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагууд:

Д/Д	Мэргэжлийн байгууллага	Итгэмжлэгдсэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага
1.	Ойн мэргэжлийн байгууллага	Геоэкологийн хүрээлэн. Ойн хайгуул төслийн тө
2.	Усны мэргэжлийн байгууллага	Геоэкологийн хүрээлэн. Ус цаг уур, эрдэм шинжил-гээний хүрээлэн
3.	Ан амьтны мэргэжлийн байгууллага	Биологийн хүрээлэн
4.	Ургамлын мэргэжлийн байгууллага	Биологийн хүрээлэн
5.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэргэжлийн байгууллага	Ус цаг уур, эрдэм шинжилгээний хүрээлэн, Байгаль орчны шин-жл.. эээний тө лаборатори

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргаж, Хаяг: «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн тойрог
Улаанбаатар-12 329612, 322838
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ эж ахуй эрхэлэх газрын харьяа хэвл үйлдэгдэг 3350 ш хэвлэл
327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны гуравдугаар сарын 9 | № 10 (89)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

106. Улсын иргэний хамгаалалтын албаны зарим ажилтныг одон медалиар шагнах тухай — Дугаар 37 — 156

107. Юрий Леонидович Шевченког "Найрамдал" медалиар шагнах тухай — Дугаар 38 — 156

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

108. Хөтөлбөр батлах тухай — Дугаар 25 — 157

109. Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай — Дугаар 26 — 165

110. Хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай — Дугаар 27 — 165

Гурав. Яам, агентлагийн акт

111. Гэрээний загвар батлах тухай (Монгол Улсын Сангийн сайдын тушаал) — Дугаар 15 — 166

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

Улсын иргэний хамгаалалтын албаны зарим ажилтныг одон медалиар шагнах тухай

Улсын иргэний хамгаалалтын албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Паламын Сүндэв - Улсын иргэний хамгаалалтын газрын дарга, хошуучийн генерал
2. Далайн Хангал - Мөн газрын бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх хэлтсийн ахлах офицер, хурандаа

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Чанцалын Намсрайжав - Зэвсэгт хүчний 122 дугаар ангийн захирагч, хурандаа
2. Дүгүйн Пүрэвдорж - Улсын иргэний хамгаалалтын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний албаны ахлах офицер, дэд хурандаа
3. Еидонгийн Цэрэндавва - Мөн газрын дэд дарга бөгөөд штабын дарга, хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

Рэнцэнгийн Пүрэвсүрэн - Улсын иргэний хамгаалалтын газрын төсвийн бодлогыг хэрэгжүүлэх албаны дарга, хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Даваанямын Байгаль - Зэвсэгт хүчний 122 дугаар ангийн штабын сургалт төлөвлөлтийн офицер, хошуучийн
2. Жамдаагийн Батдэлгэр - Улсын иргэний хамгаалалтын газрын материал-техникийн хангалтын хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа
3. Шагдарын Болдбаатар - Мөн газрын эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан ахлах офицер, дэд хурандаа
4. Бадамсандын Дамба-Очир - Хөвсгөл аймгийн Байгалийн гамшиггаа тэмцэх салбарын албаны дарга, ахлагч
5. Агваандоржийн Цогбадрах - Зэвсэгт хүчний 122 дугаар ангийн инженерийн албаны дарга, дэд хурандаа
6. Намжилийн Цэндбазар - Архангай аймгийн Байгалийн гамшиггаа тэмцэх салбарын шүхэрчин-гал сөнөөгч, ахлах ахлагч
7. Хаңдсүрэнгийн Энхбаяр - Дорнод аймгийн Байгалийн гамшиггаа тэмцэх салбарын шүхэрчин-гал сөнөөгч, ахлах ахлагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 2 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

Юрий Леонидович Шевченког "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсад цэргийн эмнэлгийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Санкт-Петербург хот дахь Цэргийн хүн эмнэлгийн академийн захирал, хурандаа генерал Юрий Леонидович Шевченког "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын төрөөс экологийн талаар баримтлах бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтын, үг хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батална.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласыг Байгаль орчны сайд С.Мэндсайхан, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МЭНДСАЙХАН

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ш.ТҮВДЭНДОРЖ

Засгийн газрын 1999 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

БАЙГАЛИЙН ГАМШГИЙН АЮУЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын нөлөөгөөр сүүлийн жилүүдэд манай гаригийн ихэнх бүс нутаг, ялангуяа Аси тивд байгалийн гамшгийн давтагдал ихэсч, учруулж байгаа хор хөнөөл нь жилээс жилд нэмэгдсээр байна.

"Байгалийн гамшиг" гэдэг нь харьцангуй томоохон нутаг дэвсгэрийг хамарсан байгаль, цаг уурын аюулт үзэгдэл тохиолдсоны улмаас хүний амь нас осолдох болон материалаг баялгийн ихээхэн хохирол учирч нийгэм, эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг нөхцөл бэрхшээл үүсгэхийг хэлнэ.

2. Бэлчээрийн мал аж ахуй бөгөөд усалгаагүй газар тариалан эрхэлдэг, дэд бүтэц сул хөгжсөн, далайд гарцгүй, өргөн уудам газар нутагтай Монгол орны хувьд байгалийн гамшгийн болзошгүй аюулаас сэргийлэх, улмаар гамшиг үзэгдэл тохиолдох үед учирч болох хор хохирлыг багасгах талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох нь нэн чухал болж байна.

3. Байгаль-цаг уурын онцлогтос шалтгаалан Монгол оронд ган, зуд, бороо, усны хийгээд урүйн үер, цасан шуурга, мөндөр, ой, хэрийн түймэр, хүн, малын гоц халдварт болон үргамлын өвчин, хөдөө аж ахуйн хөнөөлт хортон шавьж, мэрэгчдийн тархалт, газар хөдлөл зэрэг байгалийн гамшиг жилийн аль ч улиралд тодорхой давтамжтайгаар олонтаа тохиолддогоос гадна үйлдвэрийн болон зам тээврийн осол, химийн хорт бодис, цацраг идэвхжилийн аюул гэх мэтийн бага газар нутгийг хамардаг боловч хоромхон зуурын хугацаанд нийгэмд ихээхэн сөрөг үр дагаварт аюул, гамшиг цөөнгүй бий. Байгалийн гамшгийн улмаас улс орны нийгэм, эдийн засагт жил тутам ойролцоогоор 5-7 тэрбум төгрөгийн хохирол учирч байна. Ган, зудын аюулын улмаас жилд дунджаар 200 гаруй мянган толгой мал хорогдож, усны үер, цасан шуурга, аянга цахилгаан, ой, хэрийн түймрийн улмаас жил бүр 25-40 хүн амь насаа алдаж байна.

4. Бэлчээрийн даац муудсан, хотжих явц идэвхжсэн, гол мөрний эх авсан болон гольдролын дагуухи ой модыг ихээр огтолж үерийн аюулыг ихэсгэх болсон зэргээс хүрээлэн буй орчин доройтож, уур амьсгалын өөрчлөлт болж байгаатай уялдан байгалийн гамшгийн давтагдал өйртөх, эрчимжих хандлагатай болгоо. XXI зуунд дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй хобботойгоор байгаль-цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал улам ихсэх төлөвтэй байна. Нөгөө талаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих явцад байгалийн гамшигтай тэмцэх эдийн засгийн баз суларч, удирдлага, зохион байгуулалтын бүтэц задарч, шинэ бүтэц хараахан бүрэн гүйцэд төлөвшиж чадаагүй байна. Энэ нь байгалийн гамшгийн эрсдэлийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх бас нэг нөхцөл болж байна.

5. Дэлхий дахины хэмжээгээр байгалийн гамшгийн хөнөөл нэмэгдэж, түүний дотор хөгжиж байгаа болон бууралт хөгжилтэй орнууд ихээхэн нэрвэгдэж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 42 дугаар чуулганаас ерээд оныг "Байгалийн гамшгийн аюулыг бууруулах олон улсын арван жил" болгон зарлаж, 1993 онд Иокохамийн, 1996 онд Кобегийн тунхаглал гаргасан нь Монгол улсад "Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр" / цаашид "хөтөлбөр" гэнэ / боловсруулахад түлхэц болж байна.

6. Энэхүү хөтөлбөрийг олон улсын байгууллагаас боловсруулан гаргасан удирдамжийн дагуу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүд, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, бусад хууль тогтоомжуудад нийцүүлэн боловсруулав.

7. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газраас байгалийн гамшгийн аюулыг бууруулах талаар ойрын 15 жилийн хугацаанд баримтлах бодлогын үндэсэн чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг мөн.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах зарчим

8. Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын Үндэсэн хуульд "...хүн ард нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй..." гэж заасныг хэрэгжүүлэх үндэсэн дээр гамшгаас сэргийлэн хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн нийгэм, эдийн засаг, экологид учрах хохирлыг багасгах, гамшиг ертөө эмээг байдлыг бууруулах, гамшгаас хүний амь нас, үндэсний материаллаг баялгийг хамгаалахад чиглэгдсэн тер засгийн бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэл боловсруулах, улмаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

9. Хөтөлбөрийг дараахь хугацаанд хэрэгжүүлнэ:

-нэг дэх үеийг - 1999 - 2000 онд;
-хоёр дахь үеийг - 2001 - 2005 онд;
-гурав дахь үеийг - 2006 - 2015 онд.

10. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчим баримтална:

1/ Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн болон бусад нутгийг хөгжүүлэх бодлого, үндэсэн чиглэл, үйл ажиллагаатай нягт уялдсан байх;

2/ терийн болон терийн бус байгууллага, аж ахуйн нэгж, нийт иргэдийг байгалийн гамшгаас сэргийлэх, түүний аюулыг бууруулах үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах, иргэдийг өөрийгөө болон бусдыг, түүнчлэн эд

хөрөнгө хамгаалах дадлагатай, байгууллага, аж ахуйн нэгж бүрийг гамшгийн үед ажиллахад бариртлах чиглэлтэй болгож, нутгийн захиргааны байгууллагыг байгалийн гамшгаас сэргийлэх, гамшиггай тэмцэх, хор уршгийг арилгах бүхий л үйл ажиллагаанд бие даан ажиллах чадавхитай болгох;

3/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах эрх зүйн үндэс, эдийн засгийн механизмийг бүрдүүлж, гамшгийн аюулыг бууруулахад шаардагдах зардлын эх үүсвэрийг олж ашиглах;

4/ байгалийн гамшгийн аюулыг бууруулахдаа гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажилллагааг гол анхаарлаа хандуулах;

5/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээ нь өөр хоорондоо нягт уялдаатай, иж бүрэн, хэтийн чиг зорилготой байх.

Гурав. Байгалийн гамшгийн аюулыг бууруулах
талаар бариммтлах бодлого

11. Байгалийн гамшгийн аюулыг бууруулах бодлогыг дараахь хүрээнд хэрэгжүүлнэ:

1/ байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх;

2/ байгалийн гамшиггай тэмцэх бэлэн байдлыг хангах;

3/ байгалийн гамшиггай тэмцэх;

4/ байгалийн гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох.

12. Нийгэм, эдийн засгийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах замаар Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг болохоор чиглэсэн дараахь бодлогыг байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд дэс дараатайгаар хэрэгжүүлнэ:

1/ гамшгийн аюулыг бууруулах эрх зүйн орчин бүрдүүлэх;

2/ гамшгийн аюулыг бууруулах эдийн засгийн механизм бүрдүүлэх;

3/ гамшгийн өмнө болон аюул тохиолдох үед ажиллах иргэний хамгаалалтын мэргэжлийн анги,дын бэлэн байдлыг хангах, тэр, засгийн төв болон нутгийн захиргааны байгуулага, аж ахуйн нэгж, иргэдийн гамшгийн үед ажиллах бэлтгэлийг хангах, дадлага сургалт зохион байгуулах;

4/ инженерийн болон хамгаалалтын барилга байгуулалмж, хот төлөвлөлтийг гамшгийн эрсдэлийн үнэлгээнд хамруулах, норм, нормативыг шинэчлэн сайжруулах, тэдгээрт хэналт тавих тогтолцоог төгөлдөржүүлэх;

5/ байгалийн гамшгийн болон эдийн засаг, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийх;

6/ боловсруулэй байгалийн гамшгийн талаар урьдчилан мэдээлэх арга, технологи боловсруулах.

13. Байгалийн гамшгатай тэмцэх бэлэн байдлыг хангах асуудлын хүрээнд дараахь бодлогыг хэрэгжүүлнэ:

1/ байгалийн гамшиг үүсэж болзошгүй нөхцөл бүрдэх, гамшиг тохиолдох үеийн холбоо, зарлан мэдээллийн улсын хэмжээний тогтолцоог төгөлдөржүүлэх;

2/ эрчимшэл, хамрах хүрээгээрээ орон нутгийн мэргэжлийн албад, иргэдийн хүч боломжоос давсан байгалийн гамшгийн аюултай тэмцэх ажилд мэргэжлийн болон цэргийн ангиудын сургалт, бэлэн байдлыг хангуулах үндсэн дээр тэдгээрийг өргөнөөр оролцуулах арга хэмжээ авах.

14. Байгалийн гамшиггай тэмцэх хүрээнд дор дурдсан бодлогыг хэрэгжүүлнэ:

1/ аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа гамшиггай тэмцэх үйл ажиллагаанд шууд оролцон ажиллах мэргэжлийн болон төрийн захиргааны байгуулагуудын гамшгийн үед тогтвортой ажиллах нөхцлийг үе шаттайгар бүрдүүлэх;

2/ байгалийн гамшгийн үеийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох;

3/ байгалийн гамшгийн үүсэл, өрнөл, явцад хэналт-шинжилгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох;

4/ байгалийн гамшиг, ослын үед үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах талаар бүх нутгийн болон олон улсын хамтын ажиллагаа бэхжүүлэх;

5/ байгалийн гамшгийн аюулын эдийн засаг, экологийн үнэлгээ хийх.

15. Байгалийн гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох хүрээнд дараахь бодлогыг хэрэгжүүлнэ:

1/ гамшигт нөрвөдгэсгэд, хүн, мал, эд хөрөнгийг аюулын бүсээс гаргах, аврах, хамгаалах арга хэмжээ авах;

2/ гамшигт нөрвөдгэсгэдэд эмнэлгийн болон бусад яаралтай тусламж үзүүлэх;

3/ гамшгийн бүсэд орсон аж ахуйн нэгж, байгуулагын үйл ажиллагаа сэргээх, барилга байгуламж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангах арга хэмжээ авах.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага,
зохион байгуулалт

16. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төрийн бус байгуллага, аж ахуйн нэж, иргэд, мэргэжлийн байгуллагын хүч оролцоотойгоор төр, засгийн байгуллага дор дурдсанаар удирдан зохион байгуулна:

1/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих үүргийг иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгуллага эрхлэх бөгөөд Улсын байнгын онцгой комисс үйл ажиллагаат нь уялдуулан зохицуулна;

2/ байгалийн гамшгийн эрсдэлийн болон нийгэм эдийн засгийн үнэлгээ хийх, байгалийн гамшигт үзэгдлийн явцад хяналт-шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх мэдээлэл боловсруулж, дамжуулах үндэсний чадавхи бий болгох үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага өөрийн харъяа мэргэжлийн байгуллагуудаар дамжуулан гүйцэтгүүлнэ;

3/ үйлдвэрийн томоохон осол, хүн малын гоц халдварт өвчин, цацраг-химийн хордолт зэрэг гамшгийн үед хяналт-шинжилгээ хийх үүргийг мэргэжлийн зохих албад гүйцэтгэнэ;

4/ хөдөө аж ахуй, үйлдвэр, санхүү, эдийн засаг, хүүль зүй, эрүүгийг хамгаалах, дэд бүтцийн болон бусад асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагууд тус тусын эрхэлсэн ажлын чиглэлээр байгалийн гамшгийн аюулыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж Улсын байнгын онцгой комисс удирдлагын зохицуулна;

5/ нутгийн захиргааны байгуллагууд тус тусын байнгын онцгой комиссын хүрээнд байгалийн гамшгаас сэргийлэх, түүний аюулыг бууруулах урт, дунд, богино хугацааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулна;

6/ Улсын байнгын онцгой комисс, төрийн захиргааны болон төрийн бус бүх шатны байгуллага, аж ахуйн нэж бүр байгалийн гамшгийн аюулыг бууруулах үйл ажиллагааны шуурхай төлөвлөгөөтэй ажиллана;

7/ байгуллага, аж ахуйн нэж бүр байгалийн гамшгийн аюулыг бууруулах, хохиролыг арилгах хөрөнгө зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж байна;

8/ байгалийн гамшгийн хяналт-шинжилгээ хийх, гамшиг ослын тухай зарлан мэдээлэх, хөнөөлийн голомтод аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд мэргэжлийн холбогдох албад гүйцэтгэнэ;

9/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах, ялангуяа байгалийн гамшгаас сэргийлэх, байгалийн гамшиггай тэмцэх бэлэн байдлыг хангах, гамшиггай тэмцэх, гамшийн дараахь сэргээн босгогт хийх, дээрх чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, чадавхи бүрдүүлэх үйл хэрэгт төрийн бус байгуллага, иргэд санаачлагатай оролцно;

10/ иргэд харъяалах төрийн захиргааны байгуллагын удирдлагын дор иргэний хамгаалалтын төлөвлөгөөний дагуу байгалийн гамшиггай тэмцэх ажилд оролцоно.

Тав. Үндэсний хөтөлбөрөөр хэрэгжүүлэх
арга хэмжээ

17. Байгалийн гамшигтай тэмцэх эрх зүйн болон бүтцийн өөрчлөлтийн хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ мал, тариалангийн гамшийн даатгалын хууль, цахилгаан дамжуулах шугамын даатгалын хууль зэрэг байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх багц хууль боловсруулах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдийг Ховд, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Дорнод аймаг, нийслэл хот дахь цэргийн мэргэжлийн онгиудын материаллаг бааз дээр тулгуурлан байгуулж, хүн хүч, техник хэрэгслээр хангаж бэхжүүлэх;

18. Байгалийн гамшгаас сэргийлэх эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ байгалийн гамшгаас хүн, мал, өмч хөрөнгийг хамгаалах ажилд ажмилт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоо бүрдүүлэх;

2/ хот суурин газарт үер үүсэхэд нөлөөлж болох газар, уулын эмзэг экосистемтэй нутагт газар, ой ашиглалтыг хязгаарлах, төлбөрийг ялгаварлагүй тогтоох, түүнчлэн голын эхний ойг сэргээх, нөхөн сэргээлт хийсэн байгуллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, нөөцийн төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээ авах;

3/ бэлчээрийг сэлгээтэй ашиглах, усжуулах зэргээр сэргээн сайжруулсан тохиолдолд татварын хөнгөлөлт үүсгэх асуудлыг боловсруулах, говийн бүсийн заган ойн ашиглалтыг хязгаарлах зэргээр цөлжилтийн аюулыг бууруулахад дэмжлэг үзүүлэх;

4/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах ажлыг сайн зохион байгуулсан тер захирганы байгууллагын албан тушаалтан, албан хаагч, аж ахуйн нэгжийг урамшуулах арга хэмжээ аяч хэрэгжүүлэх.

19. Ой, хээрийн түймрээс сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор дараахь арга хэмжээ авна:

1/ ой, хээрийн түймэр гарах нөхцлийн үнэлгээ хийх, энэ зорилгоор шаардлагатай газар нутгуудад ойн түймрийн судалгаа, хяналтын цэг нэмж байгуулах;

2/ ой, хээрийн түймрийн хяналт-шинжилгээний газар-агаар-самсрын түвшний хяналтын систем тогтоох;

3/ ой, түймэр эсэргүүцэх отрядуудыг Хэнтий, Хангай, Хөвсгөлийн районд байгуулан тоноглох;

4/ үүнээд эсрийдэн агаар үйлчлэх, үүнийг микрофизикийн судалгааны ажилд зорилсан онгоц-лаборатори бүй болгон тоноглох;

5/ хээрийн бүсэд түймрээс хамгаалах зурвас татах;

6/ ой, хээрийн түймрээс сэргийлэх, түймэртэй тэмцэх зорилгоор сум, багуудад морин эргүүл зохион байгуулж, тэдгээрийг гал унтраах, бие хамгаалах болон холбооны хэрэгслээр хангах;

7/ ойн түймрээс сэргийлэх халз зурвас байгуулах, ойн арчилгаа цэвэрлэгээний огцлолт хийх.

20. Байгалийн гамшгийн талаар мэдээлэл дамжуулах холбоо, дохиолын сүлжээ байгуулах хүрээнд дараахь арга хэмжээ авна:

1/ томоохон хот суурин газар, сургууль, эмнэлэг, аж ахуйн нэгж, орон суудны хороололд байгалийн гамшгийн тухай нийтэд мэдээлэх гэрлэн болон дуут дохиоллын систем тавих;

2/ радио өргөн нэвтрүүлгийн сүвгийг цаг агаарын аюултай үзэгдэл, байгалийн гамшгийн тухай мэдээлэл дамжуулахад ашиглах, алслагдсан нутгийн хүмүүст зориулан бага өөрөн хүлээн авагч үйлдвэрлэн тэжээлээр хангах арга хэмжээ авах;

3/ малчид, хөдөөгийн хөдөлмөрчдөд байгалийн гамшгийн мэдээлэл, гамшигтай холбогдсон асуудлаар удирдлагаас гаргасан шийдвэрийг шуурхай дамжуулах ажлыг орон нутагт зохион байгуулах, улмаар улсын нэгдсэн сүлжээнд холбох асуудлыг судлан шийдвэрлэх;

4/ байгалийн аюул гамшиг үүсэх нөхцөл бүрдсэн болон цагийн байдал хүндэрсэн тухай "аюул", "гамшиг" мэдээг холбооны болон мэдээллийн бүх төрлийн хэрэгслээр эхний ээлжинд үнэ төлбөргүй дамжуулах журамд шилжих.

21. Байгалийн гамшгийн эрсдэлийн болон түүний улмаас эдийн засаг, нийгэмд учрах хохирлын үнэлгээг дор дурдсан хэлбэрээр хийнэ:

1/ агаар мандлын гаралтай байгалийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ;

2/ газар хөдлөл, ой, хээрийн түймэр, биологийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ;

3/ гэн, цөлжилтийн эрсдэлийн үнэлгээ;

4/ байгалийн гамшгийн эрсдэлийн иж бүрэн үнэлгээ;

5/ хөдөө аж ахуйд учрах эрсдэлийн үнэлгээ;

6/ дэд бүтцэд учрах эрсдэлийн үнэлгээ;

7/ нийгэмд учрах эрсдэлийн үнэлгээ;

8/ байгалийн гамшгийн мэдээллийн сан байгуулах;

22. Байгалийн гамшгийн хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлэн хөтөлбөрийн хугацаанд дэс дараатай хэрэгжүүлж хяналтын тогтолцоог шинээр бүрдүүлэх арга хэмжээ авна:

1/ агаар мандлын гаралтай байгалийн гамшгийн хяналт-шинжилгээний сүлжээг дараахь байдлаар өргөтгөнө:

- цаг уурын өртөөний тоог нэмэгдүүлж, цаг уурын харуулын тоог цөөрүүлэх;

- цаг уурын өртөөний тоог 2004 онд 300 хүртэл, 2015 онд 400 хүртэл нэмэгдүүлэх;

- эрөологийн өртөөг бүрэн шинэчлэх бодлогыг туушгай хэрэгжүүлж, 2015 он гэхэд 3-5 өртөөг шинээр байгуулах;

- цаг уурын радарын өртөөний тоог 1999 онд 1-ээр, 2004 он хүртэл 1-ээр, 2015 он хүртэл 2-3-ээр нэмэгдүүлж, улмаар эсийн орчны нутаг дэвсгэрийг радарын хяналтын сүлжээнд бүрэн хамруулах;

- усны харуулын тоог 2004 онд 150, 2010 онд 200 болгон өргөтгөх;

- ой, хээрийн түймэр, таримал болон бэлчээрийн хөнөөлт шавьж, мэрэгчид, үргамлын өвчин судлал, цөлжилт, гидробиологи, орчны ажилалт судалгааг цаг уурын өртөөнүүд дээр хийх;

- нарны хэт ягаан туяа, агаар мандлын нийлбэр озон, газар орчмын озон, хүлэмжийн хийн хяналт-шинжилгээний сүлжээг шинээр байгуулах;

- газар хөдлөл, соронзон судлал, орчны цацраг идэвхжил, хил дамжсан агаарын бохирдол, хүчилтөр тунадас, агаарын бүлингаршлын ажигалтын үс цаг үур, орчны хяналт-шинжилгээний сүлжээний хүрээнд хийх;

2/ хүрээлэн бүй орчны биологийн хяналт-шинжилгээний тогтолцоог 2010 он гэхэд бүрдүүлнэ. Энэ зорилгоор дархан болон тусгай хамгаалалттай газар нутгуудад биогеоценозын 10 орчим өртөө байгуулах ба хүнс тэжээл, хүний өвчин дэх хүнд металл, химийн хорт бодисийн байгаын хяналт-шинжилгээ хийнэ.

23. Байгалийн гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх арга зүй, технологийг дор дурдсанаар боловсронгуй болгоно:

1/ өөрийн орны нөхцөлд тохирсон цаг агаарын төөн анализ, төөн прогнозын загвар боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

2/ 28 м/с-ээс дээш хурдтай салхи, 30 мм-ээс их бороо, 10 мм-ээс их цас, 2 хэмээс илүү эрчтэй цочир хүйтэрэл, 1 см-ээс их голчтой мөндөр, 6 цагаас удаан үргэлжлэх цасан шуурга зэрэг цаг агаарын үзэгдлийг 72 цаг хүртэл хугацааны өмнөөс урьдчилан мэдээлэх шинэ арга технологи боловсруулах;

3/ ган, зудыг 2 сараас 1 жил хүртэлх хугацааны өмнөөс

урьдчилан мэдээлэх шинэ арга нэвтрүүлэх;

4/ урийн үерийг урьдчилан мэдээлэх шинэ арга нэвтрүүлэх;

5/ ой, хээрийн түймэр гарах цаг агаарын нөхцөлийг тодорхойлох шинэ арга боловсруулах;

6/ ой, бэлчээр, таримпын хөнөөлт шавьж отцом олшрох явцыг тодорхойлох арга, технологи боловсруулах;

7/ үргамлын гол гол өвчний гаралтыг урьдчилан таамаглах арга боловсруулах;

8/ ус, цаг уурын мэдээлэл боловсруулах техник хангамжийг сайжруулж, орон нутагтай харилцах холбооны хиймэл дагуулын сүлжээнд шилжих, зайнаас тандан судлах аргыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

9/ XXI зууны үүр амьсгалын өөрчлөлтийн прогнозын хувилбар боловсруулж, улс орны нийгэм, эдийн засгийг уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах болон үүр амьсгалын өөрчлөлттэй уялдан экосистемд гарах өөрчлөлтийг үнэлэх, дасан зохицох хувилбар боловсруулах;

10/ үүлний бичил физикийн судалгаа хийж, мөндөр сарниулах, хур тунадас нэмэгдүүлэх үндэсний технологи боловсруулах.

24. Байгалийн гамшигтай тэмцэх бүх нийтийн сургалтыг дор дурдсан хэлбэрээр явуулна:

1/ бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт байгалийн гамшигийн дохио, зарлан мэдээллийн дагуу ажиллах, өөрийгөө болон бусдыг хамгаалах анхны тусламж үзүүлэх, байгалийн гамшгаас сэргийлэх үйл ажиллагааны талаар хичээл 20-50 цагийн хичээл оруулдаг болох;

2/ эмнэлгийн мэргэжил хээмшүүлэх сургуулиудын сургалтын хөтөлбөрт гамшигт нэрвэгдэгсдэд туслamж үзүүлэх дадлага олгох;

3/ цэргийн албан хаагчид, үүний дотор цэргийн дүүцүүлэх албa хаагчдад байгалийн гамшиг, ослын үед ажиллах дадлага олгох, техник хэрэгсэлтэй ажиллах талаар сургалт зохион байгуулж дадлагажуулах;

4/ байгалийн гамшигийн зарлан мэдээлэх, дохиогоор ажиллах дэг жүрмын талаар видеокино, зураг хуудас, телe нэвтрүүлэг бэлтгэхээс гадна байгалийн гамшгас мал сүрэг, амь насаа хамгаласах ардын уламжлалт аргыг судлан сурталчлах, сургалт семинар зохион байгуулах;

5/ байгалийн гамшигтай тэмцэх мэргэжлийн багуудыг аж ахуйн нэгж, байгууллага, сум, дүүрэг, баг, хороогоор зохион байгуулан, жилд 1-ээс доошгүй удаа иргэний хамгаалалтын шугамаар сургууль, дадлага хийлгэж байх;

6/ аймаг, нийслэл, сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллага бүрээр шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулуулан хэрэгжүүлж, гамшиг, осол тохиолдсоны дараа байнга шинэчлэн тодотгож байх.

25. Норм, нормативыг боловсронгуй болгох зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ барилгын зураг төсөл зохиох норм, нормативудыг 2004 оноос өмнө хянан үзэж шаардлага хангахүйг нь шинэчлэн ходоттох байх.

2/ хамгаалалтын барилга байгууламжийн зураг төслийн норм, нормативудыг шинэчлэн мөрдүүлэх;

3/ ой, хээрийн түймрээс хамгаалах зурвас гаргах, ойд ярчилгаа, цэвэрлэгээний отголт хийх зэрэг түймрээс сэргийлэх ажиллагаа явуулах нормативуудыг батлан гаргаж мөрдүүлэх;

4/ орон нутийн байгаль цаг уурын онцлогтой уялдсан малын хашаа, саравчны зураг төслийн норм, нормативыг батлан гаргаж мөрдүүлэх;

5/ услалтын барилга, байгууламжийн зураг төслийн норм, нормативийг шинэчлэх;

6/ барилга техникийн хяналтын улсын албанаас барилга байгууламжийн зураг төсөл бүрт хөндлөнгийн болон төрийн хяналт тогтоох ажлыг сайжруулах.

26. Газар тариаланг байгалийн гамшигийн эрсдэлээс хамгаалж, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хөрсний үржил шим доройтох, хөрс давсжих, намагжихаас сэргийлэх асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг эрчимжүүлж, улмаар хамгаалалтын зурвасгүйгээр шинээр хөрс боловсруулах явдлыг таслан зогсоох арга хэмжээ авах;

2/ усалгаатай тариалангг хөгжүүлж, хөтөлберийн хэрэгжилтийн төгсгөлийн үе шатанд үр тарианы 50 хувь, темс, хүнсний ногооны 70 хүртэл хувийг усалгаатай талбайгаас авах;

3/ хүнсмэжийн аж ахуйг хөгжүүлж, хот орчмын ногооны аж ахуйн үргацын 70 хүртэл хувийг хүнсмжийн аж ахуйгаас хангах;

4/ таримал үргамлыг мендреес хамгаалах, хур тунадас зориудын аргаар нэмэгдүүлэх отрядуудыг газар тариалангийн гол бүсүүдэд байгуулах;

5/ монгол орны хөрс-уур амьсгалын нөхцөлд тохирсон /ганд тэсвэртэй, салхи бороонд налдагтүй/ үр тарианы нутагшсан, шинэ сорт бүй болгох;

27.Байгалийн гамшгийн эрсдэлээс мал аж ахуйг хамгаалах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ малын тэжээлийн баазыг бэжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч, шаардлагатай үед мал сүргийн зохих хэсгийг 2 сар хүртэл хугацаанд тэжээх тэжээлийн нөөцтэй болох;

2/ улсын болон аймаг дундын тэжээлийн нөөцийн санг бүсчлэн байгуулах;

3/ энгийн болон өрөмдмөл худгийг хүрэлцээтэй болгох, цас бороony усыг нөөцлөх, булаг шандыг задгайлах зэргээр малын усан хангамжийг сайжруулах;

4/ жилийн дулаан уриралд отрын малыг зөөврийн хөнгөн хашаагаар хангахад дэмжлэг үзүүлэх;

5/ малчид, тариаланчид, хээрийн нөхцөлд ажиллагсдыг ус үл нөвтрэх дулаан хувцас, халорилог аяны хүнсээр хангах үйлдвэрлэлийг өргөжүүлэх ажил зохион байгуулах;

6/ малчид, тариаланчдыг байгалийн аюул, гамшигийн дохио хүлээн авах тогтмол долгионтой пейжер маягийн хүлээн авагчаар хангахад анхаарах;

7/ хөдөөгийн холбооны найдвартай ажиллагаг хангах.

28. Дэд бүтцийн салбарыг байгалийн гамшигийн эрсдэлээс хамгаалах зорилгоор дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ цахилгаан болон холбооны шугамыг ой, хээрийн түймэр, салхи шуурга, цанталт, мөстөлтөөс хамгаалах ажлыг зураг төсөл зохиохоос эхлэн ашиглалтын явцад хэрэгжүүлэх, салхины чиглэл, ачааллыг бүс нутгийн онцлогт тохируулан /20 жилд 1 удаа тохиолдох дээд ачааллаар/ тооцож аргад шилжих, аянга цахилгааны аюулын үед аянга зайлуулагч хэрэглэх, цанталт, нойтон цасны нөлөөг ашиглалтын явцтай уялдуулах технологи боловсруулж мөрдөх, түймрийн аюултай бус нутагт төмөр бетонон тулгуур ашиглуулах;

2/ авто болон төмөр замыг урийн үерээс хамгаалах, гүүр

хамгаалалтын далангийн гидрологийн тооцоог сайжруулах, уул дабааны замд цас аригласх хуч хэрэгсэл бий болгох;

3/ орон нутгийн шуудан, түргэн туслэмж болон байгалийн гамшигтай тэмцэх ажилд нисдэг тэрэг ашиглах явдлыг өргөжүүлэх, цаг агаарын хүнд нөхцөлд ажиллах чадах эдийн засгийн хэмнэлттэй нисдэг тэрэгний парк бүй болгох;

4/ хот суурин газрыг хөлдөхөөс хамгаалахын тулд цахилгаан-дулааны шугам хоолойн найдвартай ажиллагааг хангах, дулааны алдагдлаас хамгаалах шинэ арга хэрэглэх;

5/ химийн хорт бодис, цацраг идэвхт бодис ашиглагдаг үйлдвэр болон хүнд даацын автомашины паркийг хотын захад, зонхилох салхины доод чиглэлд байршуулах, том хотуудад нүхэн болон хурдны зам барих, монгол гэр, ердийн галлагаатай байшинд утаагаар бохирдуулдаггүй түлш ашиглуулах зэргэгр хотын агаарын бохирдлыг жил даралаан буурууллх арга хэмжээ авах.

29. Гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаанг хөгжүүлэх зорилгоор дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

1/ байгалийн гамшгийн болон байгалийн гамшигтай тэмцэх арга, технологийн тухай мэдээлэл солилцох, байгалийн гамшигтай хамтран тэмцэх талаар ОХУ, БНХАУ, Япон, АНУ, ХБНГУ болоод сонирхсон бусад оронтой холбоо тогтоон, хөрөг болон олон талын хамтын ажиллагаае бэжжүүлэх;

2/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэжжүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн экологийн сан, Дэлхийн цаг уурын байгууллага, НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр (UNEP)-ийн хүрээнд хоёр болон олон талын төсөл санаачлан хэрэжжүүлэх;

3/ байгалийн гамшгийн тухай мэдээлэл солилцох, гамшгийн үед хамтран ажиллах тухай ОХУ, БНХАУ-тай хоёр талын Засгийн газрын түвшинд байгуулсан гэрээг шинэчлэх;

4/ НҮБ-ын хүмүүнлэгийн байгууллагын Женев дэх туслажж зохицуулах хэлтэстэй байнын холбоотой ажиллах;

5/ байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэх, тэмцэх чиглэлээр зээсэгт хүчний болон иргэний мэргэжлийн анги, удирдлага, техникийн ажилтнууд, эрдэмтэн мэргэжилтнүүдийг гадаадад бэлтгэх, давтан сургах арга хэмжээ авах;

6/ олон улсын сайн санааны байгууллагууд, түүний дотор Улаан загалмай, Улаан хавирган сар байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;

7/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төвийн гишүүн орны хувьд хамтын үйл ажиллагаагаа хөгжүүлэн бэжжүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, санхүүжилт, үр дүн

30. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүгнэх ажлыг улсын хэмжээнд Улсын байнын онцгой комисс төвлөрүүлэн, холбогдох яам, агентлагууд эрхлэх бөгөөд аймаг, нийслэл, сум дүүргийн түвшинд орон нутгийн байнын онцгой комисс, хариуцсан хэлтэс, агентлагууд эрхлэн гүйцэтгэнэ. Байгалийн гамшиг тохиолдсон үед авсан арга хэмжээ, зохиосон ажлын дүн, гамшгийн дараахь судалгааны тайланг сумаас аймаст 10 хоногийн дотор, аймгаас Улсын байнын онцгой комисст 20 хоногийн дотор ирүүлэхээр зохион байгуулна.

31. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

1/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээнд зориулан улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгө;

2/ байгалийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаае хангах зорилуулагар үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас төсөвлөсөн хөрөнгө;

3/ байгалийн гамшгийн даатгалын сан;

4/ хандивлагч орон, гадаад, дотоодын байгууллага, иргэдийн туслажжийн хөрөнгө, хандив;

32. Хөтөлбөрийг хэрэжжүүлснээр байгалийн гамшгийн аюулыг бууруулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо бүй болж, байгалийн гамшгийн аюулын хэмжээ ихээхэн буурч дараахь үр дүнд хүрнэ:

1/ хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэжжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрнэ.

- байгалийн гамшгийн аюулыг бууруулах эрх зүй, эдийн засаг, удирдлага, бүтэц зохион байгуулалтын тогтолцоог өөрчлөн шинэчлэх эхний хувилбарыг боловсруулж, байгалийн гамшгийн хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх эхлэл тавигдан, байгалийн аюул гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийнэ;

- байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдийг байгуулж эхэлнэ.

2/ хөтөлбөрийн хоёр дахь үе шатанд дарахь үр дүнд хүрнэ:

- байгалийн гамшгийн аюулыг бууруулах эдийн засгийн механизм төгөлдөржиж, гамшгийн даатгалын системд шилжинэ. Энэ нь цаашид байгалийн гамшигтай тэмцэх стратеги боловсруулах үндэслэл болно;

- байгалийн гамшгаас сэргийлэх, түүний аюулыг бууруулах бүх нийтийн боловсролын тогтолцоо бүрдэнэ;

- байгалийн гамшгийн аюулыг урьдчилан мэдээлэх, үнэлэх шинжлэх ухаан, технологийн үндэс сайжирч, агаар мандлын гаралтай байгалийн гамшгийг аймаг, сумын нутгаар урьдчилан мэдээлэх боломжтой болно;

- байгалийн гамшгийн зарлан мэдээллийн системийг томоохон хот суурин газарт зохион байгуулж дуусгах ба хөдөөгийн хөдөлмөрчдэд зарлал мэдээлэл хүргэх үйл явц боловсронгуй болно;

- байгалийн гамшгийн мэдээллийн санг бүрэн хэмжээгээр байгуулж эхэлнэ;

- биологийн гамшгийн хяналт-шинжилгээний тогтолцооны эхлэлийг тавина;

- биогеоценозын стандцуудыг байгуулж, биологи, экологийн аюул гамшгийн үнэлгээ, прогнозын эхний хувилбарг гарна;

- монгол улсын нутгийг радарын сүлжээнд хамруулах ажил үргэлжилнэ;

- байгалийн гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх дохиолын системийг хот суурин газарт байгуулж дуусгах бөгөөд бүх нутгийг хамарсан радио болон теле сувгийн түсгай нэвтрүүлэгтэй болох эхлэл тавигдана;

- байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдийг байгуулж дуусгах бөгөөд мөндэр сарниулах, зориудын аргаар хур тунадас нэмэгдүүлэх ажлыг томоохон хэмжээний газар нутгийг хамруулан хийнэ.

3/ хөтөлбөрийн гурав дахь үе шатанд дараахь үр дүнд хүрнэ:

- байгалийн гамшигтай тэмцэх чадавхийг хөгжүүлнэ;

- байгалийн гамшгийн менежмент болоовсронгуй болж, байгууллага, аж ахуйн нэгжийн тогтвортой ажиллагаа дээшилнэ;

- нийгэм, эдийн засгийг байгалийн гамшгийн эрсдэлээс хамгаалах материаллаг бааз улам бэжжиж, гамшгийн үлмаас учрах хохирол эрс буурна;

- улс орон тогтвортой хөгжлийн замаар орохын хэрээр байгалийн гамшгийн нөлөөлөл ихээхэн багасч, гамшгийн үлмаас учрах хохирлыг боломжтой доод түвшинд хүртэг бууруулах үндэсэн нөхцөл бүрдэнэ.

БАЙГАЛИЙН ГАМШГИЙН АЮУЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ (1999-2000 ОНЫ) ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн	Хариуцах байгууллага
1	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	а/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөрийг сурталчлах ажил зохион байгуулна.	1999 онд	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулагa, аж ахуйн нэгж, иргэдийн гүйцэтгэх үүрэг, зорилтыг ойлгуулна.	БОЯ, БХЯ, УБОК
		б/ аймаг, нийслэл, сум, дүүргийн дэд хөтөлбөр боловсруулна.	1999-2000 онд	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг, зорилт тодорхой болно.	БОЯ, БХЯ Аймаг, нийслэлийн Засаг дарга
2	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах чиглэлээр төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх асуудлыг төлөвлөн хэрэгжүүлэх	а/ байгалийн гамшгийн даатгалын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар судалгаа хийнэ.	1999-2000 онд	Байгалийн гамшгийн даатгалын тогтолцоонд шилжих нь зах зээлийн харилцааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохыг ойлгуулна.	БОЯ, БХЯ, УИХГ, СЯ, ХААУЯ, ДБХЯ
		б/ ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.	1999 онд	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал, урамшуулах журмын төсөл боловсруулж Засгийн газарт оруулна.	БОЯ, УИХГ
3	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авах	а/ Архангай, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгийн байгалийн гамшигтай тэмцэх салбарууддыг түймэр унтраах машин техник, холбооны хэрэгсэл,	1999-2000 онд	Байгалийн гамшигтай тэмцэх салбарын материаллаг баазыг бэхжсэнээр шаардлагатай үед шуурхай ажиллах нөхцөл бүрдэнэ.	УБОК, УИХГ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он №10 (89)

		шатахуунаар хангах арга хэмжээ авна; б/ Ховд, Архангай, Дорнод аймаг, нийслэлд байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдийг байгуулж, бэхжүүлэх арга хэмжээ авна;	1999-2000 онд	Байгалийн гамшигтай тэмцэх салбарын тоог нэмэгдүүлэх, улмаар тэдний нэгтгэн бүсийн зохион байгуулалтад шилжүүлэх эхлэл тавигдана.	УБОК, УИХГ
		в/ Морин уулын радарын барилгын ажлыг дуусгах, техникийн шинэчлэлийг түргэтгэх арга хэмжээ авна;	1999 онд	Аадрын үүлийг илрүүлж, аянга цахилгаан, үер усны аюулаас сэрэмжлүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах техникийн боломж дээшилнэ.	БОЯ, Японы техник, эдийн засгийн тусламжаар
		г/ "Байгалийн гамшгаас сэргийлэх" төслийн II үе шатны зорилтыг тодорхойлж, санхүүжилтийн асуудлаар Японы талд хандаж санал дэвшүүлнэ.	1999 онд	Манай оронд аэрологийн сүлжээг өргөтгөх ажлыг эрчимжүүлнэ.	БОЯ, Японы техник, эдийн засгийн тусламжаар
4	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	а/ байгалийн гамшгийн мэдээллийн сан байгуулах, ус, цаг уурын холбооны сүлжээг ашиглан мэдээлэл дамжуулах сургалт зохион байгуулна;	1999-2000 онд	Байгалийн гамшгийн сургамжаас санаа авч урьдчилан сэргийлэх, хамгаалах, "аюул" мэдээгээр ажиллах дадлага эзэмшинэ.	БОЯ, УИХГ, ГЯ
		б/ байгалийн гамшгийн холбогдолтой асуудлаар гарын авлага, материал бэлтгэн хэвлүүлнэ;	1999-2000 онд	Байгалийн гамшгийн асуудлаар лавлагааны материалтай болно.	БОЯ, УИХГ

		в/ цэргийн албыг дүйцүүлэн хаагчдыг байгалийн гамшиг-тай тэмцэх дадлага олгох сургалтад хамруулна.	1999-2000 онд	Байгалийн гамшиг тохиолдсон нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломж бүрдэнэ.	БХЯ, УИХГ
5	Байгалийн гамшигт эмзэг байдлын үнэлгээ хийх, норм, норматив, стандартыг шинэчлэх	а/ байгалийн гамшгийн эрсдэлийн болон эдийн засаг, нийгмийн эмзэг байдлын үнэлгээ хийх аргачлал боловсруулна	1999-2000 онд	Байгалийн гамшгийн эрсдэл, гамшигт эмзэг байдлын үнэлгээ хийх нэгдсэн аргачлал хэрэглэх боломжтой болно.	БОЯ, УИХГ, ХААҮЯ, ДБХЯ, ЭМНХЯ
		б/ барилгын норм, норматив, стандартыг хянан үзэж, шаардлагатайг нь шинэчлэх асуудал боловсруулна.	1999-2000 онд	Хуучирсан норм, норматив, стандартыг шинэчлэн мөрдөнө.	УИХГ, ДБХЯ, ХААҮЯ, ЭМНХЯ, СЯ
6	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, гамшигтай тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэх-жүүлэх арга хэмжээ авах	а/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төвийг байгуулах зохион байгуулалтын арга хэмжээнд оролцоно;	1999 онд	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төвийн гишүүн орнуудын анхдугаар уулзалтад оролцож, цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлно.	БОЯ, ГХЯ
		б/ байгалийн гамшгийн аюулыг бууруулах олон улсын арван жилийн ажлыг дүгнэж, тайлан бичнэ.	1999 онд	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах олон улсын арван жилийн арга хэмжээний хүрээнд үндэсний хорооноос зохион байгуулж хийсэн ажлаа дүгнэж, тайлангаа Азийн бүсийн төв болон НҮБ-ын холбогдох хороонд хүргүүлнэ.	БОЯ, УИХГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 26 | Улаанбаатар хот

Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгуллагаар Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг тогтоож, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор шинэчлэн батлуулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр сайшаах тухай" Засгийн газрын 1998 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

САНГИЙН САЙД Я.ОЧИРСУХ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МӨНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 26 дугаар тогтоолын хавсралт

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	- Монгол Улсын Ерөнхий сайд	Улаанбаатар хотын захирагч;
Орлогч дарга	- Сангийн сайд; - Байгаль орчны сайд.	- Архангай аймгийн Засаг дарга; - Дорнод аймгийн Засаг дарга; - Хөвд аймгийн Засаг дарга;
Гишүүд:	- Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны дарга /өөртэй нь тохиролцсоноор/; - Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга /өөртэй нь тохиролцсоноор/; - Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга /өөртэй нь тохиролцсоноор/; - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд - Гэгээрлийн сайд; - Дэд бүтцийн хөгжлийн сайд; - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд; - Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд	- Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын дарга; - Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга; - НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газрынТогтвортой хөгжлийн асуудал хариуцсан зөвлөх /өөртэй нь тохиролцсоноор/; - Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Хөтөлбөрийн үндэсний зохицуулагч; - Тогтвортой хөгжлийн Бизнесийн зөвлөлийн дарга; - Холбоогдох төрийн бус байгууллагын төлөөлөгч.
Нарийн бичгийн дарга		-Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх бөгөөд Тогтвортой хөгжлийн албаны дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

Хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн хяналт шалгах хороонооос Хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалт, эх үүсвэрийн төвлөрүүлэлтийн байдалд хийсэн шалгалтын дүнг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалт, эх үүсвэрийн төвлөрүүлэлтийн байдалд хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах зорилгоор дор дурдсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	-Сангийн сайд
Гишүүд:	- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга - Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга - Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга - Монгол банкны дэд ерөнхийлөгч
Нарийн бичгийн дарга	- Гадаад харилцаа, хамтын ажилладгааны асуудал хариуцсан Засгийн газрын ахлах референт

2. Дор дурдсан арга хэмжээ авахыг ажлын хэсгийн ахлагч Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай:

а/ Гадаадын зээл тусламжийг зохицуулах, хяналт тавих тухай Монгол Улсын хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Гадаадын зээл, тусламжийг зохицуулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах болон Хөгжлийн албан ёсны тусламжийг удирдах, зохицуулах тогтолцоо, оролцогч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох саналыг 1999 оны 1 дүгээр уриралд багтаан боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах;

б/ хөгжлийн албан ёсны тусламжийн ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ашиглаж байгууллагын болон хандивлагч бүрээр гаргаж хэтрүүлэн Засгийн газарт танилцуулан Төрийн хяналт шалгах хороонд мэдээлж байх;

в/ хөгжлийн албан ёсны тусламжийн мэдээлэл, бүртгэлийн компьютержсэн системийг 1999 оны 10 дугаар сарын 1-ний дотор бүрдүүлэн, мэдээллийн санг байгуулах;

г/ хөгжлийн албан ёсны тусламжийн хөрөнгийг нэгдсэн буртгэлтэй болгон улсын төлбөрийн балансад тусгах, валютын ханшийн өөрчлөлтийг тооцох, өрийн дунд хасалт хийж, зээл ашиглагч байгууллагын татвар ногдох орлогыг тодорхойлох жүрмыг 1999 оны эхний хагаст багтаан батлах мөрдлүлэх;

д/ өнөөг хүртэл байгуулагдсй байгаа дамжуулан зээлдүүлэх гэрээг зээл ашиглагч байгууллагуудтай нөхөн байгуулж төлөх хугацаа нь болсон зээл, зээлийн хүүг төлүүлэх, мөргаантай асуудлыг 1999 оны 10 дугаар сарын 1-ний дотор шалгаж шийдвэргэн.

3. Хууль зүйн сайд Л.Цогт даалгах нь:

а/ урьд нь хөгжлийн албан ёсны тусламжийг авааД өнөөг хүртэл төлөөгүй байгаа болон авсан зээлийн үзэн нь тодорхойгуй байгаа ах ахуйн нэгжүүдийг готтоож холбогдох хууль тогтоомжийн дагуу 1999 онд багтаан төлүүлэх арга хэмжээг авах;

б/ Төрийн хяналт шалгах хорооны шалгалтаар илэрсэн зөрчлийг зээл ашиглагч байгууллага нэг бүрээр гаргаж баралдуулах ажлыг зохион бяйгуулах.

4. Хөгжлийн албан ёсны туслажийг ашиглаСан аж ахуйн нэгж, байгууллагыг хувьчлахдаа түүний төлөлтийн байдал, олгогдсон нөхцөлийг харгалзаж байхыг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдод даалгасугай.

5. Хөгжлийн албан ёсны туслажмийн хүрээнд хэрэжүүлж буй төслүүдийн явц, үр дүнд давхар хяналт тавьж, зохих тайлан тооцоог холбогдох яам, байгууллагад цаг тухайд нь гаргаж өгч байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Төрийн хяналт шалгах хорооноос хөгжлийн албан ёсны туслажмийн ашиглалт, эт үүсвэрийн төвлөрүүлэлтийн байдалд хийсэн шалгалтаар ажилдаа хариуцлагагүй хандаж албан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон төрийн захиргааны ажилтнуудад 1999 оны 2 дугаар сард багтаан зохих хариуцлага тооцохыг холбогдох сайд нарт үүрэг болгож, үүнд хяналт тавьж дүгнэлт гаргахыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга Л.Лингоот зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж. НАРАНЦАЦРАЛТ**

САНГИЙН САЙД **Я. ОЧИРСУХ**

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 2 дугаар сарын 1-ний өдөр — Дүгаар 15 — Улаанбаатар хот

Гэрээний загвар батлах тухай

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэжүүлэх зорилгоор ТУШААЖ нь :

Нэг. Инженерийн хийцтэй барилга, байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах талаар Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээний үлгэрчилсан загвартай үлдүүлэн Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сан, гаалийн сангийн хөрөнгөөр хэрэжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, төсөл, арга хэмжээ, их засварын ажлын Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээний загварыг хавсралтын ёсоор батапсугай.

Хоёр. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, төсөл, арга хэмжээний гэрээг Захиалагч аймаг, нийслэлийн Засаг дарга, ямадын Төрийн нарийн бичгийн дарга, түсгай газрын дарга нар батална, түүний гүйцэтгэгч хяналт тавьж байхаар тогтоосугай.

Гурав. Хөрөнгө оруулалтын зарим томоохон төсөл, арга хэмжээний зураг, төсөвт мэргэжлийн байгууллагаар шүүлт хийлгэх, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийн дагуу Захиалагч, Гүйцэтгэчийн хооронд байгуулсан гэрээний гүйцэтгэл, хөрөнгийн эх үүсвэрт хяналт тавьж ажилласуй. Төсвийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс / Г. Хаянхярваа /-т даалгасугай.

САНГИЙН САЙД **Я. ОЧИРСУХ**

Сангийн сайдын 1999 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 15 дугаар тушаалын хавсралт

ТӨВШӨӨРСӨН

САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА _____ /нэр/

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ _____ /тамга, тэмдэг/

_____ /албан тушаал/

_____ /нэр/

ГҮЙЦЭТГЭГЧ _____ /тамга, тэмдэг/

_____ /албан тушаал/

_____ /нэр/

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ЗАМЫН САН, ГААЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭЖҮҮЛЭХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

199 . . оны . . . дугаар сарын ..... -ны өдөр — Дүгаар — Улаанбаатар хот

Төслийн нэр . . . . . .

. . . . . .

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1. Монгол Улсын Иргэний, барилын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах /цашид "барилын үйлдвэрлэл" гэх/-тай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцаог зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний /цашид гэрээ"- гэх/ ач холбогдол оршино.

1.2. Энэхүү гэрээ нь барилын үйлдвэрлэлийн төсөвт өртөг, чанар, ашиглалтад оруулах хугацаа, хүч чадлыг эцэслэн тохирох үндсэн болно.

1.3. _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.мөтр талбай /_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга үүсгэлт, /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, ахилпаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын __ -ны өдөр эхэлж, ____ оны ___ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулахаар энэхүү гэрээг байгуулав.

1.4. Төслийн нийт төсөвт өртөг . . . . сая төгрөг, санхүүжилтийн нийт гүйцэтгэл . . . . сая төгрөг болно.

1999 оны гэрээт ажлыг улсын төсвийн хөрөнгөөр . . . сая төгрөгт багтаан гүйцэтгэхээр тохиролцов. /Хэрэв нэмэлт хөрөнгө шаардагдвал Захиалагч түүнийг ямар эх үүсвэрээс хэрхэн санхүүжүүлэхийг бичнэ./

1.5. _____

/бусад нөхцөл/

Хөөр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Барилга барих эдэлбэр газрын болон барилын талбайд орсон бүх төрлийн барилга, байгуулламж, инженерийн шугам сүлжээ, авто болон темер замыг буулгах, эвэх, шилжүүлэх, хеделгөөнийг зогсоох эвэшеерэл, уг барилын цахилгаан, дулаан, уур, цэвэр, бохир усан хангамж, гал, харилцаа холбооны төхөөрөмжүүдийг шилжүүлэх, буулгах, эвэшеерэл хийхтэй холбогдуулан гарах зардлыг тооцон гаргах, мөн барилга, байгууламжийг ашиглалтанд хүлээлгэн өгөх.

2.2. Барилгын явц, чанарт холбогдох мэргэжилтэн бүхий зохиогчоор хяналт тавиулж, далд ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна.

2.3. Гудамж, зам, талбай сэтгэх, шугам сүлжээнд холболт хийх, мод цэцэрлэгжүүлэлт, хот, нийтийн бусад ажлуудыг хөдөө ажлын нөхөн сэргээх, барилга, байгуулламж бариихаар олгогдсон газрыг тохижуулах хөрөнгийг гаргах бөгөөд барилга, байгуулламж барих талбайг чөлөөлүүлж гүйцэтгэчид хүлээлгэн өгнө.

2.4. Техникийн нөхцлийн хугацаа дуусах бүхэл өөрчлөгдвөл түүнийг дахин шинэчилж зураг төсөвд тусгуулахыг хамт суурилагдах технологийн тоног төхөөрөмжийг харилцан тохиролцсон хугацаанда нийлүүлэх.

2.5. Ажлыг дагалдах талаар гүйцэтгэчээс өгсөн мэдэгдлийг авснаас хойш __ /3/ (кедее орон нутагт /нэг/ долоо хоног) хоногийн дотор захиалагч

үзээгүй бол гүйцэтгэх ажлаа үргэлжлүүлэх бөгөөд дагалдагдсан ажлыг дахин үзэх шаардлага гарсан тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг захиалагч хариуцна.

2.6. Барилын ажлын бэлтгэлийг хангах, үйлдвэрлэлийг шуурхай явуулах үүднээс хүлээн жилийн батлагдсан төсөвт өртийн 30 хүртэл хувьтай танцуу хэмжээний урьдчилгааг нэг удаа гүйцэтгэчид олгож болно. Цаашид авсан урьдчилгааны тайланг бүрэн гаргасны дараа энэхүү гэрээний 2.7-г баримтлан санхүүжүүлнэ.

2.7. Эрх бүхий байгууллагаас батлагдан холбогдох журмын дагуу ажлын гүйцэтгэлийг тухай бүр шалгаж санхүүжүүлэх бөгөөд зураг төсөл зөрчих бүрэлгүй, дутуу, чанаргүй хийсэн ажлыг засах, гүйцэн хийжийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ.

2.8. Зураг төсөл, барилгын норм ба дүрэм, стандартыг зөрчсөн, санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, материал, төөвэр, механизмын зардал, үнийн зөрүүг бүрэн тооцсон зэрэг тохиолдолд захиалагч нь эрх бүхий байгууллагаар хяналт хийлгэх, торгууль нөгдуулах, гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.

2.9. Гүйцэтгэгчээс уг хамаарах нөхцөл, байдлын улмаас барилын ажлыг зогсоох шаардлага гарвал захиалагч нь зогсоохоос өмнө гүйцэтгэсэн ажлын хөлс болон зогсоохтой холбогдон гарах зардлыг гүйцэтгэчид төлнө.

2.10. _____

/Бусад нөхцөл/

Гурав. Гүйцэтгэчийн эрх, үүрэг

3.1. Барилгын үйлдвэрлэлийг батлагдаасан зураг төсөл, барилгын норм ба дүрэм, стандартын дагуу чанартай барьж энэхүү гэрээнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан ашиглалтанд оруулан, захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Бүрэу буюу дутуу хийсэн ажлаа түхай бүр өөрийн хөрөнгөөр засч гүйцэн, ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгахын хамт үгсэрсан тоног төхөөрөмжидэв түршилт тохируулга хийж найдвартай ажиллагаат нь хангана.

3.3. Гэрээт ажлаа гүйцэтгэхэд гуспан гүйцэтгэч авах шаардлагатай бол энэхүү загварыг үндэслэн түүнтэй гэрээ байгуулж ажилаа ба гуспан гүйцэтгэчийн ажлыг ерөнхий гүйцэтгэч захиалагчийн өмнө хариуцна.

3.4. Барьж байгаа барилга, байгуулажа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон бийгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.

3.5. Барилга, байгуулламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь бууруган үйл ажилгааныа улмаас зөрчил илэрвэг түүнийг өөрийн хөрөнгөөр засна.

3.6. Хийж байгаа ажилтай нь холбогдон гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулбал здгээрийг бүрэн хэмжээгээр нөхөн сэргээнэ.

3.7. Барилгын ажлын гүйцэтгэлийг зургийг үнэн зөв гаргаж, дадлагажсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг түршик тохируулсан актыг захиалагчид бүрэн гүйцэд хүлээлгэн өгнө.

3.8. Энэхүү гэрээгээр тохирсон үнэ нь эцсийн бийг бөгөөд гүйцэтгэсэн ажлын өртөг нь энэ үнээс давсан нөхцөлд дутагдах хөрөнгий гүйцэтгэч өөрөө чөлөөлөн санхүүжүүрэх ба эсрэг тохиолдолд уг зөрүү нь гүйцэтгэгчийн вшиг болно. /Суурь үнэ албан ёсоор өөрчлөгдөвөл бүхэ байгалийн болон гэнэтийн аюул, осол үүнд үл хамаарна./

3.9. Материалын үнийн зөрүүг _____ тохиролцов.

3.10. _____

/Бусад нөхцөл/

Дөрөв. Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг

4.1. Захиалагч болон гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадахгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд хийгдсэн ажлын үнийн дүнгийн _____ /0.5/ хувиар бууруулж тапдаа алданги ноогдуулна.

Ана хүлээсэнээр үүрэгийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөнө.

4.2. Талууд гэрээний үүрэгийн биелэлтгэй холбогдсон асуудлаа тохироцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

4.3. Энэхүү гэрээг _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр 4 хувь үйлдэж, Сангийн яам, харилцагч . . . . . банк, захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг хувийг хадгалав.

4.4. Барьж буй барилга, байгуулламжийн дээтэлийн асуудлыг Даатгалын хууль, тогтоомжийн дагуу зохицуулна.

4.5. Гэрээг _____ /_____ жил, улирал, сар тутам ажлын үе шатаар/ _____ дүнээр.

4.6. _____

/Бусад нөхцөл/

Тайлбар: _____ /Хувааръг байгаа дундаж тоог жишиг болгон захиалагч гүйцэтгэгч харилцан тохирсон тоогоо тавина.

/30/

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
_____	_____
/гарын үсэг/	/гарын үсэг/
_____	_____
/албан тушаал/	/албан тушаал/
_____	_____
/овог нэр/	/овог нэр/
_____	_____
/байгууллагын нэр/	/байгууллагын нэр/
_____	_____
/Утас, факс, Е-майл/	/Утас, факс, Е-майл/
_____	_____
/Үйлчүүлэгч банк/	/Үйлчүүлэгч банк/
_____	_____
/Даншны дугаар/	/Даншны дугаар/

_____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 329612, 322838
Төрийн дэлгэр Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ах
эрхлэх газрын харьяа хэв
үйлдвэрт 3350 ш хэвлэв.
327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны гуравдугаар сарын 16 | № 11 (90)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

112. Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай — Дугаар 28

113. Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай — Дугаар 30

Хоёр. Яам, агентлагийн акт

114. Журам батлах тухай (Монгол Улсын Гэгээрлийн сайдын тушаал) — Дугаар 16

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Дэд бүтцийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийг доор дурдсанаар батлуулсугай:

а/ Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газар;
б/ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
в/ Төрийн захиргааны удирдлагын газар;
г/ Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "в" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД — **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 28 дугаар тогтоолын хавсралт

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Дэд бүтцийн хөгжлийн сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2.Үндэслэл

Хөтөлберийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн өөрчлөлтийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүралдахүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөл загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлберийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Орон сууц хувьчлах тухай хууль;
- Дүндын өмчлөлийн орон сууцны тухай хууль;
- Геодези зураг зүйн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлберийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага; үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын өөрчлөлтийн зөрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Дэд бүтцийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын Тамхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Дэд бүтцийн хөгжлийн яам нь салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс ергөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Дэд бүтцийн хөгжлийн яам нь Засгийн газрын дэд бүтцийн хөгжлийн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Дэд бүтцийн хөгжлийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

Дэд бүтцийн хөгжлийн эрх ашгийн нэгж



Дэд бүтцийн хөгжлийн яамны үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгч нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын Танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцаог зохицуулахад чиглэнэ.

Дэд бүтцийн хөгжлийн яамны стратегийн удирдлага зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны төрүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Дэд бүтцийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Дэд бүтцийн хөгжлийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэрэгшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны төрүүлэх чиглэл

Дэд бүтцийн хөгжлийн яам нь үйл ажиллагааны дор дурдсан төрүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Түлш, эрчим хүч, зам, тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоог хөгжүүлэхэд төрүүн эзргийн ач холбогдол өгч, эдийн засгийн өсөлтийг хангахуйц дэд бүтцийн суурьжсэний үндсийг бий болгох;
2. Дэд бүтцийн салбарын удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх;
3. Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийг дэмжих;
4. Барилга, нийтийн аж ахуйн салбарт өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох;
5. Орон нутгийн эрдэс түүхий эдэд тулгуурласан барилын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих;
6. Байгалийн аялал жуулчлалд төрүүн эзргийн ач холбогдол өгч улмаар аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг дээшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
7. Дэд бүтцийн хөгжлийн салбарыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго:

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго:
Эдийн засгийн өсөлтийг хангахуйц
дэд бүтцийн суурьжсэ хөгжүүлэх

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Дэд бүтцийн хөгжлийн яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

- **Дэд бүтцийн салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;**
- **Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;**
- **Дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;**
- **Дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.**

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Дэд бүтцийн хөгжлийн яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Дэд бүтцийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;
1.2. Дэд бүтцийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах.

2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1.Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
2.2. Хуний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1.Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах;
3.2.Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах;
3.3. Гадаад хамтын ажиллагаа хэрэгжүүлэх.

4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:


4.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны үгрэх хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;
4.2. Дэд бүтцийн салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Дэд бүтцийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:


ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА
(БИЗНЕС)- ны СТРАТЕГИЙН ЗАГВАР
Эрхэм зорилго
Үйл ажиллагааны стратегийн зорилт
Үйл ажиллагааны гол зорилт
Үйл ажиллагааны зорилт
Эдийн засгийн өсөлтийг хангахуйц дэд бүтцийн сүлжээг хөгжүүлэх
1.Дэд бүтцийн салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах
1.1 Дэд бүтцийн салбарын урт, дунд,богино хугацааны стратегийн төлөвлөлт,бодлогын удирдамжаар хангах
1.2 Дэд бүтцийн салбарын бодлогын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах
2. Төрийн захиргааны удирдлагын мэдээллээр хангах
2.1 Төрийн захиргааны удирдлагын мэдээллээр хангах
2.2 Хүний нөөцийн удирдлагын мэдээллээр хангах
3. Дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах
3.1 Бодлого,төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах
3.2 Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах
3 .3 Гадаад хамтын ажиллагаг хэрэгжүүлэх
4.Дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх,үнэлгээ өгөх
4.1.Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх
4.2.Дэд бүтцийн салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

3. Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим


Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. *Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим* /тухайн яамны үйл ажилгааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/
2. *Эрх мэдлийн ялгаа заагийг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим* /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажилпах чадвар нь итгэл хүлээхүйц байх/
3. *Үзэдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим* /байгуулагын нэр, бүтээс тухайн байгуулагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/
4. *Бүтцийн хувьд энгийн байх зарчим* /тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээс хүртэл аль болох цөөн /гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх/
5. *Тэнцвэрийг хангах, хяналтын үүргэ тогтоох зарчим* /байгуулагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой харгах зэмлэр, аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/
6. *Үлс төрийн хүчьд төвийг сахисан байх зарчим* /Тухайн яамны Төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч бүюу хэрэглэгчдэд үлс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх/
7. *Хангалттай чадвахи, бодитой үйл ажиллагааны зарчим* /Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэх чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Дэд бүтцийн хөгжлийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжийг санал болгож байна:

1. **Стратегийн удирдлага, нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Дэд бүтцийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээх, дэд бүтцийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган хэрэгжилтийг зохицуулах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдыг шаардлагатай мэдээллэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр ханган замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэгтэгч нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр эн үйлчилгээг хэрэгтэгч нь бусад яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

Энэ нэгжийн үйл ажиллагааны хүрээнд түлш, эрчим хүч; тээвэр, аялал жуулчлал; холбоо мэдээллэхүйлэгт; барилга, хот байгуулалтын болгоо, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төслийн багууд ажиллана.

2. **Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын мэдлэйллыг ханган үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагаар ханган чиглэнэ.

Энэ нь Дэд бүтцийн хөгжлийн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр ханган, удирдлагын соёл, чадвахийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх дүгнэх, ажилтах нөхцөл, нийгмийн баталгаагаар ханган замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэгтэгч нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчад байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэгтэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэгтэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түлш нь Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байна.

3. **Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийн хүлээж, дэд бүтцийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, гадаад хамтын ажиллагаар хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Дэд бүтцийн хөгжлийн сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог ханган, гадаад хамтын ажиллагаар хөгжүүлэхэд чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцох байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаар бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үндсэн хэрэгтэгч нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэгтэгч нь нутгийн захиргааны байгууллага, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийлийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага, бусад хэрэгтэгч байна.

4. **Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлэх дүгнэх нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ егөх үндсэн үүргийг хүлээж, дэд бүтцийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн явц, бэдэлд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ егөх, мэдээллийн сүлжээ байгуулах, сан бүрдүүлэх, хэрэгтэгчдийг мэдээллээр ханган хэрэг эрэгдэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын мэлпайллыг ханган, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварыг ажилах замаар яамны бүтцийн хөгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаат сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь ханган замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэгтэгч нь Дэд бүтцийн хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэгтэгч нь бусад яам, хэрэгтэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түлш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 30 **Улаанбаатар хот**

Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Оросын Холбооны Улстай хиллэсэн хэсэгт гарч байгаа хилийн зөрчил, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, Увс, Завхан, Хөвсгөл аймгийн төрийн захиргааны байгууллага, иргэдээс тавьсан саналыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндоржид даалгах нь:

а/ Увс аймгийн Хилийн төлөөлөгчийг удирдах газарт Хэрэг буртгэх алба байгуулах, мөн аймгийн Баруунтурууны комендатурт хэрэг буртгэгч томилон ажиллуулах асуудлыг 1999 оны 6 дугаар сарын 1-ний дотор багтаан шийдвэрлэсүгэй;

б/ Увс, Завхан, Хөвсгөл аймгийн ОХУ-тай хиллэсэн улсын хилийн хамгаалалтын нягталсыг сайжруулбал зохих хэсгийг нарийвчлан тогтоож, тэдгээрийг мөр хянах зурвас, торон саад, инженерийн бусад байгуулламжтай болгох арга хэмжээг 1999-2000 онд багтаан авсугай;

в/ Хилийн цэргийг удирдах газрын захиалгын дагуу Увс, Завхан, Хөвсгөл аймгийн хилийн застав, отрядыг шаардлагатай автомашин, техник хэрэгслээр хангах арга хэмжээг энэ оны эхний хагаст багтаан авсугай;

г/ хилийн застав, харуулд алба хааж байгаа офицер, ахлагч нарыг хүнсний нормтой болгох асуудлаар тусөл боловсруулж энэ оны 4 дүгээр сарын 1-ний дотор багтаан Засгийн газарт оруулсугай.

2. Гадаад харилцааны сайд Н.Түвад даалгах нь:

а/ Улсын хилийн хамгаалалтын асуудлаар ОХУ-тай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг өөрчлөх, тодотгох, шинэчлэх талаарх саналын тухай төслийг Батлан хамгаалахын сайдтай хамтран боловсруулж энэ оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт оруулсугай;

б/ БНМАУ, ЗСБНХУ /хуучин нэрээр/-ын хооронд 1958 оны 3 дугаар сарын 26, 1976 оны 10 дугаар сарын 19-нд байгуулсан хилийн тухай хэлэлцээрүүдийг буртгүүлэх асуудлыг 2000 онд багтаан НҮБ-д тавьж шийдвэрлүүлсүгэй;

в/ хоёр талын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, хилийн зөрчил, малын хулгайн асуудлыг таслан зогсоохоо дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Төлөөлөгчийн газрыг Кызыл хотод байгуулах талаарх саналаа энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан ОХУ-ын холбогдох байгууллагад зохих жүрмын дагуу тавьж шийдвэрлүүлсүгэй.

3. Увс, Завхан, Хөвсгөл аймгийн ОХУ-тай хиллэсэн хэсгийн хил хамгаалалтыг сайжруулах, бэхжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг тооцож, 1999 оны сүүлийн хагасаас эхлэн жил тутам төвлөрсөн арга хэмжээний тусөвт туслан хэрэгжүүлэх арга хэмжээ авч байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж нарт даалгасугай.

4. Хууль зүйн сайд Л.Цогт даалгах нь:

а/ Увс, Завхан, Хөвсгөл аймгийн төвийн болон Увс аймгийн Сагил, Баруунтуруун сумын цагдаагийн байгууллагын хүчийг бэхжүүлэх, тэдгээрийг шаардагдах техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах замаар хилийн бүсэд малын хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлсүгэй;

б/ Увс, Завхан, Хөвсгөл аймгийн хилийн отряд, заставтай мэдээлэл солилцох холбооны сүлжээ бий болгохын хамтаар хилийн зөрчил, малын хулгайн асуудлаар Хилийн цэргийг удирдах газартай харилцан ажиллах журмыг 1999 оны 4 дүгээр сард багтаан гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авсугай.

5. Хилийн хамгаалалтын холбооны хангалтыг сайжруулах арга хэмжээг гадаад орон, олон улсын байгууллагын төслийн хүрээнд хамруулан 2000 онд багтаан шийдвэрлэхийг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүгд даалгасугай.

6. Гүйцэтгэх ажлын шугамаар хилийн хамгаалалтыг сайжруулах, түүнчлэн харилцан ажиллах, мэдээлэл солилцох ажлыг шуурхай болгохын хамтаар Увс аймгийн Баруунтуруун зэрэг хилийн зөрчил, малын хулгай ихэвчлэн гардаг чиглэлүүдэд гүйцэтгэх ажлын хүч, хэрэгслийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга Ж. Энхнасанд даалгасугай.

7. Увс, Завхан, Хөвсгөл аймгийн Засаг дарга Ц. Баатар, Л. Дашзэвэг, Л. Батсүрэн нарт даалгах нь:

а/ улсын хил хамгаалалтад зориулсан зардлыг "Хилийн тухай" хуулийн дагуу сумдын төсөвт жил тутам тусгуулах, хилийн цэргийн анги, салбарууд бэхжүүлэхэд санхүүгийн болон материалын дэмжлэг үзүүлэх, ажиллагсдынх нь ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч байсугай;

б/ улсын хил хамгаалалтад нутгийн иргэдийн оролцоог өргөтгөх, аймаг, сум, багийн Засаг даргын дэргэдэх хил хамгаалалтад туслах зөвлөлийг бэхжүүлэх, гишүүдийг хил хамгаалалтад идэвхтэй оролцуулж байх арга хэмжээ авсугай;

в/ хил орчимд амьдарч байгаа иргэдийн амгалан тайван байдлыг хангах, хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээг ОХУ-ын хил орчмын төрийн захиргааны байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж байсугай;

г/ малын хулгайн зөрчил, гэмт хэргийг илрүүлэхэд идэвхтэй зүтгэл гаргасан иргэд, хилчдийг урамшуулах журам, болзолыг энэ оны 4 дүгээр сард багтаан Хилийн цэргийг удирдах газартай хамтран гаргаж хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж. НАРАНЦАЦРАЛТ**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ш. ТҮВДЭНДОРЖ**

1999 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Гэгээрлийн сайдын зөвлөлийн 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэгтэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн журам"-ыг хавсралт ёсоор батална.

2. Энэхүү тушаалаар батална үлгэрчилсэн журамд нийцүүлэн элсэлтийн журмаа 1999 оны 2 дугаар сард багтаан батлахыг мэргэжлийн сургуулийн захирал нарт даалгасугай.

3. "Мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн журам"-ыг хэрэгжүүлэх, Мэдлэгийн ерөнхий түвшний тест авах ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч байхыг БХЗГ /С.Алтангэрэл/-т даалгасугай.

САЙД А. БАТТӨР

Гэгээрлийн сайдын 1999 оны 16 дугаар тушаалын хавсралт

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

1. Өмчийн бүх хэлбэрийн их сургууль, коллеж, техникийн болон мэргэжлийн анхан ба дунд шатны сургууль /цаашид "мэргэжлийн сургууль" гэх/-иуд энэхүү үлгэрчилсэн журмыг үндэслэн элсэлтийн журмаа боловсруулж батлан мөрдэнэ.

ТАЙЛБАР: Магистрын болон докторын боловсрол эзэмших хүмүүсийг элсүүлэх журам энэ журамд хамаарахгүй.

2. Дээд боловсрол эзэмшүүлэх мэргэжлээр бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой хүмүүсийг элсүүлнэ.

3. Мэргэжлийн сургуулийн тухайн жилд элсүүлэх элсэгчдийн хязгаарын тоо, сургах чиглэлийг Гэгээрлийн яам тогтооно.

4. Мэргэжлийн сургуулиуд суралцагч элсүүлэх ажлыг бие даан буюу хамтран зохион байгуулна.

Мэргэжлийн сургууль нь тусгай зөвшөөрөл авсагүй мэргэжлийн чиглэл, сургалтын хэлбэрээр элсэлт авч, сургалт явуулахыг хориглоно.

5. Дээд боловсролын сургуулиудад оюутан элсүүлэх шалгалт нь доорх хоёр шатаас тогтоно.

А. Эхний шатанд элсэлтийн шалгалт өгөх нийт хүмүүсээс Мэдлэгийн ерөнхий түвшний тест (МЕТТ) авна. МЕТТ авах ажлыг Гэгээрлийн яамны БХЗГ буюу түүний эрх олгосон байгууллага зохион байгуулна. 1997 оноос хойш Монгол Улсын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн улсын шалгалтын дүнг МЕТТ-тэй адилтгах түл тэд МЕТТ-ээс чөлөөлөгдөнө.

Б. Хоёр дахь шатанд тухайн чиглэлээр шалгуулагчдын суралцах чадвар, авъяас, мэргэжлийн тохиромжтой тодорхойлох зорилго бүхий эвэхон нэг шалгалтыг холбогдох сургууль авна.

6. Хэдээ орон нутгаас МЕТТ-ийн шалгалтад орох хүмүүс жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор аймгийн Боловсрол, соёлын төвд бүртгүүлнэ. Боловсрол, соёлын төвүүд бүртгүүлсэн хүмүүсийн тоог 6 дугаар сарын 10-ны дотор Гэгээрлийн яамны Бодлогын хэрэжилтийг зохицуулах газарт ирүүлнэ.

7. Дээд боловсролын сургуулиуд нь оюутан элсүүлэхдээ сургууль, мэргэжлийнхээ онцлогоос хамаарууллан элсэгчдэд тавих нэг болзол болгон МЕТТ-д авсан байх доод оноо /нийт онооноос хэдэн хувийг нь авсан байх/-г тогтоож нийтэд мэдэгдэнэ.

8. Орон нутагт элсэлтийн ажлыг зохион байгуулахад аймгийн Засаг дарга шалгалт авах нөхцлийг бүрдүүлэх, хүн хүчний түслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

9. Орон нутгаас төрийн өмчийн мэргэжлийн сургуульд суралцагч элсүүлэх хувааръ дээр тухайн орон нутагт албан ёсоор оршин суугаа иргэдээс бүртгэнэ.

10. Мэргэжлийн сургууль, элсэлтийн комиссууд элсэлтийн ажилд олон нийтийн зүгээс хяналт тавих боломж олгох зорилгоор шалгуулагчдын эцэг эх, хөнөөлөнгийн хүмүүсийн төлөөлөлтэй ажиллагдын хэсэг бүлгүүлэн ажиллуулна. Ажиллагчид элсэлтийн ажилд хүндрэл учруулахгүйгээр элсэлтийн явцад хяналт, шаардлага тавих эрхтэй.

11. Гэгээрлийн яамнаас батагсан дүрмийн дагуу явагдаг улсын олимпиадад ерөнхий боловсролын сургууль төгсөх жилдээ 1-3 дугаар бүйр эзэлсэн төгсөгч нь тэр жилдээ тухайн хичээлийн чиглэлийн мэргэжил /Мэргэжлийн чиглэлийн олимпиадын дүрэмд заааж өгнө./-ээр суралцахыг хүсвэг элсэлтийн хоёр дахь шатны шалгалттаас чөлөөлж, шууд элсүүлнэ.

Гэгээрлийн яам улсын хэмжээний уралдаан зарлаж шалгарсан хүмүүст мэргэжлийн сургуульд элсэхэд нь хөнгөлөлт үзүүлж болно.

12. Элсэлтийн шалгалттай холбоотой аливаа маргааныг элсэлтийн шалгалт зохион байгуулсан комисс гаэар дээрэх эцэслэн шийдвэрлэнэ.

13. Элсэлтийн шалгалт авах хугацаог холбогдох мэргэжлийн сургуулиуд жичэд нь тогтооно. Элсэлтийн хоёр дахь шатны шалгалтыг ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалт дууссанаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа явуулахаар тухайн мэргэжлийн сургууль тогтоно.

14. Элсэлтийн шалгалт, эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн хяналтын тоонд багтсан хүмүүст суралцах эрхийн бичиг олгоно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12
Төрийн ордон
329612, 322838
Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуй эрхлэх газрын харьяа хэвлэлийн үйлдвэрт 3400 ш хэвлэв.
327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны гуравдугаар сарын 23 | № 12 (91)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

115. Журам батлах тухай — Дугаар 41 — 176
116. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай — Дугаар 42 — 177
117. Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч нарыг одон медалиар шагнах тухай — Дугаар 43 — 177

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

118. Төрийн өмчийн байрыг худалдах тухай — Дугаар 32 — 178

Гурав. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол

119. Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай — Дугаар 29 — 179

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 41 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

1. Батлан хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн "Цэргийн цол олгох журам"-ыг хавсралтын ёсоор батална.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 71 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Цэргийн цол олгох журмаатай холбогдуулан албан туушаалын дамжааны журам, хөтөлберийг боловсруулж 1999 оны II улиралд багтаан хэрэгжүүлж ахлэхийг Батлан хамгаалахын сайд /Ш.Түвдэндорж/, Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга /Ж.Энхнасанд/ нарт даалгасугай.

4. Цэргийн албан хаагчдын албан туушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг энэхүү журамтай нийцүүлэх, цэргийн цол олгохдоо албан туушаалын дамжаатай уялдуулах арга хэмжээг 1999 оны II улиралд багтаан авахыг Батлан хамгаалахын сайд /Ш.Түвдэндорж/, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга /Ц.Дашзэвэг/, Хилийн цэргийн удирдах газрын дарга /Д.Базарсад/, Дотоодын цэргийн дарга /Д.Мөрөн/, Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга /Ж.Энхнасан/, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга /Ж.Содмандах/ нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1999 оны 41 дүгээр зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Цэргийн цол нь цэргийн албан хаагчийн эрхэлж байгаа албан туушаалын ангилалын илэрхийлэл, түүнийг цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд харгалзуулсан зэрэг дэв мөн.

2. Цэргийн албан хаагчийн албан туушаал бүр цэргийн цолны зэрэглэлтэй байх бөгөөд албан туушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хуульд тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан туушаалтан тогтоно.

3. Цэргийн албан хаагчид, тэдгээрт адилтгах албан туушаалын ангилал, цолны зэрэглэл хэрэглэдэг байгууллагын ажилтанд офицерийн цолыг шат дараалан олгоно.

4. Цэргийн цол, түүний зэрэглэл нь цэргийн албан хаагчдад цэргийн дүрмээр тогтоогдсон эрх, үүрэг, мөнгөн болон материалын хангалтын хэмжээг тодорхойлох үндэслэл болно.

Хоёр. Цэргийн цол олгох

1. Зэвсэгт хүчин, бусад цэргийн офицерийн анхны цолыг Зэвсэгт хүчний Ерөнхий Штабын дарга олгоно.

2. Зэвсэгт хүчин бусад цэргийн ахлагчийн анхны, ахлах, дунд офицерийн дараагийн цолыг Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, Хилийн цэргийн удирдах Газрын дарга, Дотоодын цэргийн дарга нар тус тус олгоно.

3. Цэргийн албан хаагчидтай адилтгах албан туушаалын ангилал, цолны зэрэглэл хэрэглэдэг байгууллагын албан туушаалтанд цэргийн цолыг тухайн байгууллагын дарга нар энэхүү журмыг баримтлан тус тус олгоно.

4. Ахлагчийн дараагийн цол, түрүүч, байдлагчийн цолыг цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар олгоно.

5. Зэвсэгт хүчин, бусад цэргийн ахлах офицерийн "хуран-

да" цолыг Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга Батлан хамгаалах болон Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж олгоно.

6. Цэргийн албан хаагчид "хурандаа" цол олгохдоо цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хасаан хугацаа, цэргийн нэгтгэл, ангид ажилласан байдал болон энэхүү журмын хоёр дахь хэсгийн аравдугаар заалтад заасан шалгуурыг үндэслэн болгоно.

7. Дээд офицерийн цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно.

8. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, түүний орлогч нараас бусад дээд офицерийн албан тушаалын ангилал, цолны зэрэглэл бүхий албан тушаалтанд дээд офицерийн цол олгох саналыг Засгийн газрын батлан хамгаалах асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын Засгийн газарт уламжилна. Монгол Улсын Засгийн газар үг саналыг танхимынхаа хуралдаанаар хэлэлцүүж дэмжвэл Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.

9. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, түүний орлогч нарт дээд офицерийн цолыг олгохоо хоёр дахь хэсгийн 8 дугаар заалт хамаарахгүй.

10. Цэргийн цол олгох эрх бүхий албан тушаалтан цэргийн албан хаагчид цэргийн цол олгохдоо албан тушаалын цолны зэрэглэл, боловсрол, мэргэжилдээ дадлагажсан байдал, ажлын үзүүлэлт, хоёр цолны зэрэглэлийн дараагийн цолыг олгох бол тухайн албан тушаалд тэнцэж буй эсэх, офицерийн ёс зүй зэрэг шалгуурыг бүтээсэн тодорхойлолтыг үндэслэн болгоно.

11. Цэргийн албан хаагч, тэдгээрт адилтгах албан тушаалын ангилал, цолны зэрэглэл зэрэглэдэг байгууллагын албан тушаалтан нь тухайн албан тушаалын дамжаа төгсөөгүй бол цэргийн цолыг албан тушаалын дамжаа төгсөөгүй дараа олгоно.

12. Офицер, ахлагчид цэргийн цол олгох асуудлыг цэргийн нэгтгэл, ангиа, байгууллагын захирагч, дарга нар шийдвэрлэх бүрэн цол олгох үндэслэл, тодорхойлолт, саналаа удирдах дээд байгууллагад уламжилна.

13. Цэргийн болтгэл үүрэгтэнд цол олгохдоо түүний дайчилгааны сургууль, цэгцлээлт, хээрийн сургуульд оролцох эзэмшсэн цэргийн мэргэжил, томилгоот албан тушаалын цолны зэрэглэлийг үндэслэн болгоно.

14. Цэргийн албан хаагчийн офицерийн цол нь томилгоонд буй албан тушаалын цолны зэрэглэлээс хоёр, түүнээс дээш зэрэглэл доогуур байвал түүний цэргийн цолыг эхний эзлэхэд нэг шат ахиулж дараагийн цолыг албан тушаалын дээд зэрэглэлийн цол хүртэл дээ дараалан олгох бөгөөд гэхдээ цол олгох хоорондын хугацаа нь хоёр жилээс доошгүй байна.

15. Цэргийн хоёр цолны зэрэглэлтэй албан тушаалд цэргийн албан хаагчийг томилхдоо дээд зэрэглэлийн цолыг олгосон бол дүнд офицерт 2-3 жил ахлах офицерт 3-4 жил ахласны дараа албан тушаалын дээд зэрэглэлийн цол олгоно. Хэрэв ажлын үзүүлэлт хангалттүй гэж үзвэл цол олгох албан тушаалтан албан тушаалын дээд зэрэглэлийн цолыг олгох хугацаг дахин нэг жилээр хойшлуулж болно.

16. Цэргийн хоёр цолны зэрэглэлтэй албан тушаалд дэвшин томилогдож байгаа цэргийн албан хаагч нь цолны зэрэглэлийн доод цолтой бол энэ цолтой үедээ ажилласан хугацаг албан тушаалын дээд зэрэглэлийн цолыг олгохдоо орууулж тооцно.

17. Иргэний байгууллагад ажилсаж байгаад дүнд, ахлах офицерийн албан тушаалд томилогдвол албан тушаалын цолны зэрэглэсэ хоёр зэрэглэл доогуур цол олгож дараагийн цолыг олгохдоо энэхүү журмын хоёр дахь хэсгийн 14 дүгээрт заасныг баримтална. Хэрэв түүний албан тушаалын цолны зэрэглэл нь дээд офицерийнх байвал "хурандаа" цол олгож, албан тушаалын зэрэглэлийн цолыг 2-3 жил ажилласны дараа олгоно.

Гурав. Цэргийн цолыг хэрэглэх

1. Цэргийн албан хаагч цэргийн жинхэнэ алба хааж байхдаа, цэргийн болтгэл үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үедээ цэргийн цол хэрэглэнэ.

2. Цэргийн болтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө "болтгэл", цэргийн болтгэл албанд байх нас хэтэрсэн, эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй гэж эмнэлгийн дүгнэлт гарсан болтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө "чөлөөнд байгаа" гэсэн тодотгол хэрэглэнэ.

3. Цэргийн албан хаагч, цэргийн болтгэл үүрэгтэн цэргийн цолд хүндэтгэлтэй хандаж, захирах, захирагдах ёсыг чандлан биелүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Цэргийн цолыг буурууллах, хураан авах, сэргээх

1. Цэргийн цол олгох эрх бүхий албан тушаалтан "Цэргийн дисциплин дүрэм"-д заасны дагуу цэргийн албан хаагчийн цэргийн цолыг бууруулна.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч дээд офицерийн цол бүхий албан тушаалтны цолыг бууруулах, хураан авах, болтгэл дээд офицерийн цолыг сэргээн олгоно.

3. Албан тушаалаа тэнцэхүй болсон цэргийн албан хаагч албан тушаал бууруу ажиллахыг зөвшөөрвөл түүний цэргийн цолыг бууруулж, томилогдсон албан тушаалын цолыг эдлүүлнэ. Буурч томилогдсон албан тушаал нь цолны хоёр зэрэглэлтэй байвал дээд зэрэглэлийн цолыг олгож болно.

4. "Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай" Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 4.5-д заасан үндэслэлээр халагдаж байгаа цэргийн албан хаагчийн цэргийн цолыг үүнд цолыг олгосон албан тушаалтан хураан авна.

5. Цэргийн цолоо хураалгаж, цэргийн албанаас халагдсан цэргийн офицерийн албан тушаалд дахин томилогдвол энэхүү журмын хоёр дахь хэсгийн 17 дугаар заалтыг баримтлан цэргийн цол олгоно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Украин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашдавааг Чулуунборжийг тохоон томилсугай.

2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Гүржевын Эрдэнийг Монгол Улсаас Бүгд Найрамдах Украин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүргээ гүйцэлдэг чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 43 Улаанбаатар хот

Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч нарыг одон медалиар шагнах тухай

Зэвсэгт хүчний албанд олон жил үр бүтээлтэй ажилласж эх орноо батлан хамгаалах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан генерал, офицер, ахлагч нарыг одон медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Цэвээндоржийн Ганболд - Зэвсэгт хүчний 026 дугаар ангийн жолоочийн, ахлах ахлагч
2. Хананамадаагийн Давааcамбуу - Барилгын цэргийн 073 дугаар ангийн барилгын бригадын дарга, ахлах ахлагч
3. Ядамын Санжаа - Зэвсэгт хүчний 028 дугаар ангийн захирагч, хурандаа
4. Лувсандоржийн Түмэнжаргал - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч, хурандаа
5. Батдоржийн Хандаа - Зэвсэгт хүчний 026 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
6. Шаравын Эрдэнэбаяр - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн захирагч, хурандаа

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНГООР:

1. Түгжийн Амарбилэг - Зэвсэгт хүчний 137 дугаар ангийн механикийн бүлгийн дарга, ахмад
2. Чимэдийн Батболд - Зэвсэгт хүчний 238 дугаар ангийн штабын дарга, хурандаа
3. Дүйнхэржавын Баянхаа - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн албаны дарга, дэд хурандаа
4. Тогоочийн Болдбаатар - Зэвсэгт хүчний 011 дугаар ангийн өнгөлгөөчин, ахлах ахлагч
5. Цэрэнэдэжидийн Баямбажав - Улсыг аварьшн довтолгоонооос хамгаалах цэргийн командлагч, хошуучин генерал
6. Жамсранжавын Ванчинсүрэн - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч, хурандаа
7. Баяндийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 311 дугаар ангийн биеийн тамирын албаны дарга, хошуучин
8. Жамсранжавын Гантемөр - Зэвсэгт хүчний ерөнхий штабын ар талын газрын офицер, дэд хурандаа
9. Ширэндэвийн Дашдаваа - Цэргийн их сургуулийн багш , хурандаа
10. Сандагийн Даваадорж - Зэвсэгт хүчний 011 дугаар ангийн захирагч, хурандаа
11. Бадамсэдийн Доржүгдэр - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн ар талын дарга, хурандаа
12. Жамцын Дүрэнжаргал - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, хурандаа
13. Төмөрхүүгийн Монхоон - Баримпын цэргийн 073 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа
14. Лувсангийн Ноов - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Тамгын хэлтсийн дарга, хурандаа
15. Санжаажавын Ноов - Батлан хамгаалах ямны мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний гүйцэтгэх дарга, хурандаа
16. Баянсанийн Өлзийбаатар - Баримпын цэргийн 158 дугаар ангийн салхивчийн техник, ахмад
17. Лундэгээгийн Пүрэвдорж - Зэвсэгт хүчний ерөнхий штабын боловсон хүчний хэлтсийн офицер, дэд хурандаа
18. Дашзэвэгийн Цэрэндагва - Зэвсэгт хүчний 011 дугаар ангийн захирагч, хурандаа
19. Мяасүрэнгийн Энхбаатар - Улсыг аварьшн довтолгоонооос хамгаалах цэргийн штабын офицер, дэд хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

Чагнаагийн Очирбат - Баримпын цэргийн 073 дугаар ангийн бригадын дарга, ахлах ахлагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сандагийн Амарсайхан - Баримпын цэргийн 030 дугаар ангийн хорооны захирагч, хурандаа
2. Ишээхүүгийн Батболд - Зэвсэгт хүчний тооцоолох төвийн захирал, хошуун
3. Гончигийн Батжил - Зэвсэгт хүчний шүүх эмнэлгийн шинжээч, ахмад
4. Данигийн Бат-Очир - Улэгэр жишээ үлэзэгэр найрал хөгжмийн орлогч дарга, удирдавч, дэд хурандаа
5. Магсарын Батсүүрь - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн дивизийн захирагч, хошуун
6. Баасанжавын Батсүх - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа
7. Цэвээний Батсүмбэр - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн салааны захирагч, ахлах дээлэн
8. Мижидийн Батцэнгэл - Зэвсэгт хүчний ерөнхий штабын ар талын газрын офицер, дэд хурандаа
9. Доноровын Баатарсүх - Зэвсэгт хүчний 109 дугаар ангийн АН-24 онгоцны нисгэгч, дэд хурандаа
10. Доржийн Баянмөнх - Баримпын цэргийн 158 дугаар ангийн цахилгаанчин, ахлах ахлагч
11. Санжаагийн Буянбаатар - Зэвсэгт хүчний 089 дугаар ангийн жолоочи, ахлах ахлагч
12. Нямсүрэнгийн Баямбасүрэн - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн батальоны захирагч, хошуун
13. Насангийн Баямбадорж - Зэвсэгт хүчний ерөнхий штабын сургалтын хэлтсийн дарга, дэд хурандаа
14. Сандүйжавын Дарьзав - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагчийн орлогч, штабын дарга, хурандаа
15. Гочоогийн Дүнгармаа - Зэвсэгт хүчний 011 дугаар ангийн санхүүлэгч албаны дарга, дэд хурандаа
16. Ендонгийн Дүгэржав - Баримпын цэргийн 173 дугаар ангийн баримпын талбайн дарга, хошуун
17. Мөөгений Жаргал - Зэвсэгт хүчний ар талын материал хангалтын тэв баазын дарга, хурандаа
18. Шагжаагийн Жаргалсайхан - Зэвсэгт хүчний клиникийн тэв эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч, дэд хурандаа
19. Садийн Нэргүй - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагчийн орлогч, штабын дарга, дэд хурандаа
20. Дашзэвэгийн Оюунцацэг - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Тамгын газрын нууцын эрхлэгч, ахлах ахлагч
21. Ороосоогийн Равдандорж - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн батальоны захирагч, хошуун
22. Гүрсэдийн Сайханбаяр - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Мэдээлэл, сөёл суртахчилгаа, хүмүүжлийн ажлын хэлтсийн дарга, дэд хурандаа
23. Тэрбишийн Тайван - Баримпын цэргийн 158 дугаар ангийн нимгэн төмөрчин, ахлах ахлагч
24. Болатханы Хожубай - Баримпын цэргийн засвар механикийн заводын дарга, дэд хурандаа
25. Балсангийн Цог-Эрдэнэ - Зэвсэгт хүчний цэргийн техник шалгах албаны байцаагч, хошуун
26. Дамдингийн Цэвэлмаа - Зэвсэгт хүчний тооцоолох төвийн түслах мэргэжилтэн, ахлах ахлагч
27. Дамдингийн Чагнаадорж - Зэвсэгт хүчний ерөнхий штабын хобоо, цэргийн удирдлага, автомашинтын хэлтсийн ахлах офицер, хурандаа
28. Сүрэнгийн Чулуунбаатар - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Артиллерийн командлалын тагнуулын дарга, дэд хурандаа
29. Дамдингийн Чулуунбат - Зэвсэгт хүчний ерөнхий штабын үйлчилгээ ак ахуйн газрын нярав, ахлах ахлагч
30. Баягасын Эрхэмбаяр - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагч, дэд хурандаа
31. Шийлэгийн Энхбат - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагч, хурандаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

999 оны 2 дугаар сарын 24-ний өдөр | **Дүгээр 32** | **Улаанбаатар хот**

Төрийн өмчийн байрыг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хувай хуулийн 29 дүгээр зүйлийг нэдсэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өмч хувьчлалын хууль тогтоомжид заасан жүрмаар худалдагдахгүй байгаа төрийн өмчийн 14 дүгээр байр /Иргэний аварьшн эзэрийн удирдах газарт байсан зонд буудлын цогцолбор/-ыг Төрийн олон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Иргэний хуулийн 162 дугаар зүйл, 217 дугаар зүйл болон холбогдох бусад заалыг баримтлан нийтийн дуудлагын худалдаанд орууллх зээлээр худалдах, худалдан авах гэрээг байгуулах жүрмаар худалдахаар тогтоосугай.

2. Энэхүү нийтийн дуудлагын худалдааг зохих хууль тогтоомж, зүрх үйлчилгээ хийх аргыг заасан жүрмын дагуу зохион байгуулах эрхийг Төрийн өмчийн хороонд олгосугай.

3. Дуудлагын худалдааны доод үнийг 3,2 тэрбүм төгрөгөөр тогтоож, худалдах, худалдан авах гэрээнд 2 тал гарын үсэг зурснаас хойш 15 хоногийн дотор зээ тогтоолд заасан нөхцөл, байгуулсан гэрээний үүргийн дагуу телэж дуусгахаар тогтоосугай.

4. Төрийн өмчийн 14 дүгээр байр /зочид буудлын цогцолбор/-ыг нийтийн дуудлагын худалдааны орууллх худалдах гэрээний гол өчцөлийг доор дурдсанаар тогтоохыг Төрийн өмчийн хорооны дарга Энхболдод даалгасугай:

а/ Иргэний хуулийн 162 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасанаар эмгийн өндөр үнэ санал болгосны дээр эхний жилд үүн үнийн 30 хувиас доошгүй, гэхдээ хамгийн өндөр жилийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор телехээр санал болгосон хувь хүн, хуулийн этгээдийг ялагаар тооцох.

б/ нийтийн дуудлагын худалдааг орогдсон ялг гэрээ хийсний нотолгоо болгох дэнчинг худалдах доод үнийн 20 хувиар тогтоож, зохих жүрмын дагуу урьдчилан шилжүүлж, эхний жилийн телбэр орууллн тооцох;

в/ худалдан авагч нь худалдан авсан баримпын тохиролцсон үнийн үлдэгдлийг 14 жилд хуваан жил бүрийн телбэрийг төрийн өмчийн хороотой тохиролцсон хугацаа бүрэн сар түгэм зохих дансанд шилжүүлэх жүрмаар телех, хэрэв сар түгмын телбэрийн эцсийн хугацаат хожимдуулбал Иргэний хуулийн 180 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хожимдуулсан сонгогт түгмын телех өстэй телбэрийн 0,5 хувьтай тэнцэх алданги телех;

г/ худалдан авагчаас гэрээний дагуу жил түгамд телех телбэрт хандлаа өөрчлөлтийг тухайн жилийн мөнгөний бодлоготор батлагдсан хэмжээгээр тооцож тусгах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД БОГӨӨД САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Н. ТУЯА**

1999 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн" гэдэгт шүүхээр хянан хэлэлцэх үед тухайн хэрэг Эрүүгийн хуулийн тусгай анги заагдсан боловч ерөнхий ангийн 5 дугаар зүйлд заасан бусад шинж чанараа алдах эсхүл үүл хэргийг үйлдсэн эгтээд нийгэмд аюулгүй болоход хүргэсэн, нийт улс орон даяар буюу тодорхой бус нутгийн хэмжээнд гарсан, нийгэм-улс төрийн буюу нийгэм-эдийн засгийн гүнзгий өөрчлөлт гарсныг хамаарууллж ойлгоно.

Энэхүү өөрчлөлт нь Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлд заасан хэрэгцуулагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал бус агуулга, шинж төрх, цар хэмжээгээрээ тухайн хэргийг гэмт хэрэгт тооцох буюу тухайн эгтээдийг эрүүгийн хариуцлагад татах нь Эрүүгийн хуулийн зорилт, зарчим, гэмт хэргийн тухай ойлголт, ялын зорилгод нийцэхгүйд хүргэсэн нөхцөл байдал болно.

2. Мөн зүйл, хэсэгт заасан "хэрэг нийгэмд аюултай шинж чанараа алдсан" гэдэгт хэрэг үйлдэх үеийн нийгэм-улс төр, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал энэ тогтоолын нэг дэх хэсэгт заасанаар өөрчлөгдснээс тухайн үйлдэл, эс үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай анги гэмт хэрэгт тооцогдсон хэвээр боловч бодит байдалдаа ерөнхий ангийн 5 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бусад шинж чанараа алдсаныг ойлгоно.

Жишээлбэл: Улс оронд ардчилсан өөрчлөлтүүд гарч, зах зээлийн харилцаанд шилжиж, хүний эрхийг дээдлэх болсонтой холбогдуулж тэр, засгийн бодлого шийдвэрийг шүүмжлэх, дамын худалдаа хийх, хувираа хөдөлмөр эрхлэх, нийгмийн тусгай хөдөлмөрээс зайлсхийх зэрэг нилээд үйлдүүд гэмт хэргийн шинж чанараа алдаж, Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан дээрх ойлголтонд хамаарахүйц байснаа үлмаар Эрүүгийн хуульд холбогдох өөрчлөлт орсны дараа гэмт хэрэгт тооцогдохоо больсон зэрэгтэй дүйцэхэгээ нөхцөл байдлууд болно.

3. Мөн зүйл хэсэгт дурьдсан "үг эгтээд нийгэмд аюулгүй болсон" гэдэгт гэмт хэрэг үйлдэснээс хойш хэргийг шүүхээр хэлэлцэх хүртэлх хугацаанд цаг үеийн нөхцөл байдал энэ тогтоолын нэг дэх хэсэгт заасанаар өөрчлөгдснээс Эрүүгийн хуулийн тусгай анги заагдсан боловч энэ тогтоолын 2 дахь хэсэгт заасан хэргийг үйлдсэн гэм буруутай эгтээд нийгэмд аюулгүй болохыг ойлгоно.

4. Энэ тогтоолын 1, 2, 3 дугаар заалтаар тайлбарласан нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд шүүх гэмт хэрэгт холбогдсон тухайн шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг журамлан эрүүгийн хариуцлагас чөлөөлөх буюу оногдуулсан ялыг эдлэхээс хугацааны өмнө суллана. Ингэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгт гэм буруутай гэж шүүх үзсэн, ямар үндэслэл, шалтгаанаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгааг тодорхой дурьдаж, нэг шүүгдэгчтэй нэг хэргийн хувьд шүүх хуралдаанаас тогтоол гаргах замаар, хэд хэдэн шүүгдэгчтэй хэргийн зарим шүүгдэгчтэй холбоотой буюу хэд хэдэн хэрэгтэй нэг шүүгдэгчийн зарим хэргийн хувьд таслан шийдвэрлэх тогтоолын холбогдох заалтаар ял шийтгэл оногдуулахгүйгээр энэ асуудлыг шийдвэрлэж байна.

5. Энэ тогтоолд заасанаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөн буюу эдлээгүй үлдсэн ялаас хугацаны өмнө суллагдсан эгтээдийн гэм буруугаас үчирсан хохирол, төлбөрийн асуудлыг Иргэний хууль тогтоомжид нийцүүлэн шүүх шийдвэрлэж болно.

6. Хэрэв цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсний улмаас хэрэг нийгэмд аюултай шинж чанараа алдсан буюу шийтгүүлсэн эгтээд нийгэмд аюулгүй болсон гэж үзэж Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг журамлан оногдуулсан ялыг эдлэхээс хугацааны нь өмнө суллаж байгаа бол шүүгч үндэслэл бүхий захирамж гаргаж бөгөөд эдлээгүй үлдсэн ял нь хянан харгалзах хугацаа болохгүй, түүнийг өөр хөнгөн ялаар солихгүй. Түгээрээ 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх нь Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд заасан хугацаанаас нь өмнө тэнсэн суллах буюу өөр хөнгөн ялаар солихоос алгадана. Үйлчүү үлдсэн ялаас суллагдан эгтээд ял шийтгэлүй болох асуудал нь Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд заасан нийтлэг журмын дагуу шийдвэрлэнэ.

7. Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хариуцлагас чөлөөлөгдсөн эгтээд тухайн төрлийн буюу бусад хэргийг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг давтан үйлдсэн гэж зүйлчилж болохгүй.

8. Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хариуцлагас чөлөөлсөн ядал у эгтээдэд тухайн хэрэг, зөрчилд нь хууль тогтоомжийн дагу захиргааны болон сахилгын шийтгэл хүлээлгэх, хохирогчруулах асуудлыг үүгийгсэгүй боловч шүүх энэ асуудлыг өөрөө саналчлахгүй, харин эрүүгийн хэрэгт нь холбогдуулагдаагүй гаргасан шийдвэрийнхээ талаар холбогдох байгууллагад албан тушаалтанд мэдэгдэж болно.

9. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж Эрүүгийн хуулийн 46, 47, 48, 49 дүгээр зүйлийг шүүхийн практик хэрэглэхэд тухай "Дээд шүүхийн бүгд хурлын 1987 оны 1 дугаар сарын 9-ний өдрийн 44 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д. ДЭМБЭРЭЛТҮЭРЭН

ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ Ч. ГАНБАТ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын харин Хаант "<<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эдлэл

Улаанбаатар-12 Төрийн ордон

329612, 322838 Индекс: 14503

Төр, хэвлэл, үйлчилгээ, ял, хуулийн эрхлэх газрын харьяа хэвлэлийн үйлдвэрт 3400 та хэлэлцэ

327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл

Улаанбаатар хот | 1999 оны гуравдугаар сарын 30 | № 13(92)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

120. Н.Баялханд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай — Дугаар 45 — 180

121. С.Бавуусүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай — Дугаар 46 — 181

122. Д.Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай — Дугаар 47 — 181

123. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай — Дугаар 48 — 181

124. Хөнгөн аж үйлдвэрийн салбарын зарим ажилтан, ажилчдыг одон, медалиар шагнах тухай — Дугаар 49 — 182

125. Рональд Ламбыг "Найрамдал" медалиар шагнах тухай — Дугаар 50 — 182

Хоёр. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол

126. Монгол Улсын Иргэний хуулийн 8, 25 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай — Дугаар 475 — 182

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

Н. Баялханд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, казах хэл дээр олон ном, сурах бичиг туурвиж багш, сурагчдын хүртээл болгох, сургалт, хүмүүжлийн ажлын ачуулга, арга зүйг боловсронгуй болгох, өсөверийн залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн казах сургуулийн секторын эвлэх, ахмад багш Ниязын Баялханд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

С. Бавуусүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй ажилласан, нооц боловсруулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд олон жилийн турш оруулсан хувь нэмрийг нь үнэлэн "Эрдэнэт хивс" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Содномдоржийн Бавуусүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Д. Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хивсний үйлдвэрлэлд гар хивсчнээр олон жил үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлж, бүтээгдэхүүний үзэмж, чанарыг дээшлүүлэх, залуу ажилчдыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монгол гар хивс" ХХК-ийн хивсчин Доржийн Батчулуунд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Хөдөө аж ахуй, холбоо, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, банкны салбар болон төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Ажханы Болат - УИХ-ын гишүүн
2. Райханы Хасымхан - Хөвд аймгийн Ховд сумын мал эмнэлэг, үржлийн албаны эрхлэгч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Хистаубайн Баян - ХОТШ банкны Баян-Өлгий аймаг дахь салбарын захирал
2. Хошвооны Бисей - Ховд аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын нийтлэг үйлчилгээний албаны дарга
3. Рияны Даривхан - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ахлах сургуулийн биеийн тамирын багш
4. Тохтаубайн Есентей - Мен аймгийн Сагсай сумын дунд сургуулийн багш
5. Жулхагийн Кунат - Мен сургуулийн бага ангийн багш
6. Аятханы Магаш - Хөдөө аж ахуйн их сургуулийн сарлаг судлалын төвийн багш
7. Бушатайн Мурат - Баян-Өлгий аймгийн "Бекентау" ХК-ийн захирал
8. Жалелийн Рисабек - Баян-Өлгий аймгийн Холбооны газрын албаны дарга
9. Раздакийн Сандалхан - УИХ-ын гишүүн
10. Авжатын Хаздолда - Ховд аймгийн Ховд сумын "Көксөрөк" хоршооны захирал

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ыбырайн Аралхан - Баян-Өлгий аймгийн багшийн коллежийн багш
2. Хошайн Генераль - Мен аймгийн Эрүүл мэндийн нэгдсэн төвийн мэс заслын тасгийн сувилагч
3. Шатарбайн Дауей - Мен аймгийн Толбо сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
4. Рустемийн Куншай - Мен аймгийн Өлгий сумын 10 жилийн 4 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч
5. Тилеужаны Мухай - Мен аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мужааны багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр — Дугаар 49 — Улаанбаатар хот

Хөнгөн аж үйлдвэрийн салбарын зарим ажилтан, ажилчдыг одон, медалиар шагнах тухай

Хөнгөн аж үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Зулын Түмэнбаяр - "Монгол гар хивс" ХХК-ийн хивсчин
2. Янсанжавын Энэбиш - "Ээрмэл" ХК-ийн ахлах мастер

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Мэндбаярын Бат-Очир - "Булигаар" ХК-ийн гүйцэтгэх захирал
2. Цэвээндоржийн Баярмаа - Мөн ХК-ийн цехийн дарга
3. Ганжинцоогийн Гаваа - "Монгол савхи" ХК-ийн аж ахуйн нярав
4. Чимэдцээгийн Дарьхүү - "Улаанбаатар хивс" ХК-ийн нэхэгч
5. Цэрэнбатын Сэдванчиг - "Говь" ХК-ийн гүйцэтгэх захирал
6. Навааны Сэсэр - "Бишрэлт индустриал" ХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга
7. Дашцэрэнгийн Туяа - "Монгол шир" ХК-ийн ажилчин
8. Хорчинжавын Цэндмаа - Ноос, ноолуурын холбооны гүйцэтгэх захирал
9. Түдэвдоржийн Цэрэндума - "Бишрэлт индустриал" ХК-ийн өөдолчин

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Бавуугийн Дашпүрэв - "Монноос" ХК-ийн засварын механикч
2. Дуламдоржийн Мэндбаяр - Мөн ХК-ийн чанар шалгагч
3. Баясгалангийн Чимэд - "Монгол эсгий, эсгий гуталь" ХК-ийн токарьчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 17-ны өдөр — Дугаар 50 — Улаанбаатар хот

Рональд Ламбыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Хамтарсан үйлдвэр байгуулалцаж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, монгол ноолуурыг дэлхийн зах зээлд гаргахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн Монгол Улс, АНУ-ын хамтарсан "Монгол Америкал" үйлдвэрийн америкийн талын гүйцэтгэх захирал Рональд Ламбийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1998 оны 12 дугаар сарын 23-ны өдөр — Дугаар 475 — Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хуулийн 8, 25 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Иргэний хуулийн орон сууц өмчлөх болон орон сууцтай холбогдсон эд хөрөнгийн бусад эрх гэсэн 8 дугаар бүлэг, Орон сууц хөлслөх гэсэн 25 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Иргэний хуулийн 8, 25 дугаар бүлгийн зарим зүйл, заалтуудыг дор дурдсанаар тайлбарласугай.

1. Иргэний үүлдэл /даашзд хууль гэх/ 118 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “...Нийтийн зорилгалттай хэд хэдэн суүц бүхий орон суущы байшин” гэдэгт Орон суущ хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 3-д заасчаар бүхэлдээ бүхүу ихэнх хэсэг нь дөрөв ба түүнээс дээш суущы зориулалттай барилгыг, “суущ” гэдэгт нь нийтийн зориулалтай орон суущан дахь нэг гэр бүл аж төрөхэд зориулагдсан нэг бүюу хэд хэдэн өрөө бүхий цогцолбороо тус тус ойлгоно.

2. Хуулийн 118 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Нийтийн зориулалттай хэд хэдэн суущ бүхий орон суущы байшинд суущ өмчлөгч нь түүний дотор хсалган хэрэглэж үй болох эд хөрөнгийг нэгэн адил өмчилнө” гэдгийн “салган хэрэглэж үй болох эд хөрөнгө”-д тухайн суущы дотрохи дулаан, цахилгаан, арийн цэвэр-техникийн болон холбооны нэгээс дээш суущы үйлчилгээнд зориулсан тохөөрөмж, орсон гарсан шугам хамаарна.

3. Хуулийн 121 дугээр зүйлийн 1 дэх хэсгийн “Суущ бүюу хувийн зориулалттай орон суущы байшин гэр бүлийн гишүүн нь уг суущ бүюу байшинг өмчлөгчийн нэг адил эзэмших, ашиглах эрхтэй” гэдгийн “гэр бүлийн гишүүн” гэдэгт өмчлөгчийн ам бүлд бүгэгдэн хамтран амьдарч байгаа эхнэр, нөхөр, хүүхдүүд, эцэг, эх, түүнчлэн өмчлөгчтэй хамтран амьдарч асрамжинд нь байгаа, гэр бүлийн аж ахуй хамтран эрхэлдэг гэр бүлийн нэг төсөвтэй төрөл садан болон төжээн тэтгүүлэгчдийг ойлгоно.

Гэвч Орон суущ хувьчлах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дугээр заалт, 2 гэр бүлийн хуулийн 18, 19 дугээр зүйлийн 2 дэх хэсэг, иргэний хуулийн 95 дугаар зүйлд заасчаар суущыг эхэнэр, нөхөр, хүүхдүүд, эцэг, эх, түүнчлэн өмчлөгчтэй хамтран амьдарч асрамжинд нь байгаа, гэр бүлийн аж ахуй хамтран эрхэлдэг гэр бүлийн нэг төсөвтэй төрөл садан болон төжээн тэтгүүлэгчдийг ойлгоно.

Гэвч Орон суущ хувьчлах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “...орон суущ хөлслөх гэрээ” гэдэг нь нэг талаас нийтийн болон хувийн зориулалттай байшин, нийтийн байран дахь суущыг өмчлөгч бүюу түүнээс эрх олгосон этгээд нөгөө талаас хүн байнга бүюу түр аж төрөх зориулалттай, ариун цэвэр, эрүүл ахуй, техникийн шаардлага хангасан суущыг төлбертэй-гээр эзэмших, ашиглах талаар харилцан эрх, үүрэг хүлээн бичгийн хэлбэргээр хийсэн гэрээ болно.

5. Хуулийн 246 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан “хууль бусаар гэрээнд заасан болон орон суущанд зайлшгүй шаардагдах засварыг цаг тухайд нь хийнэ” гэдгэт хөлслөгч нь суущыг эзэмшиж, ашиглах хугацаандаа суущы зориулалт, бүтэц /зохион байгуулалт/-ийг өөрчлөхгүйгээр үзэмжийг сайжруулах, жижиг гэмтэл, түү зогсолтыг арилгах, цагийн бус элэгдэл, эвдрэлээс урьдчилан сэргийлэх, хэвийн ажиллагаат ханган зорилгор хийсэн тохиолдолд түүнд гарсан зардлыг засварыг ойлгоно. Гэхдээ зайлшгүй шаардлагатай засвар хийх хугацаа, шинж чанар, хэмжээг гэрээнд заавал тусгасан байвал зохино.

6. Хуулийн 247 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн орон суущ хөлслөх гэрээг тодорхой бүюу тодорхой бус хугацаагаар байгуулж болно” гэдгийн “тодорхой хугацаагаар” гэдэгт суущ хөлслөх гэрээ байгуулсны талууд гэрээ дуусгавар болох хугацаат хүчинлийн он, сар, өдөрөөр бүюу зайлшгүй болох үйл явдлаар тодорхойлсныг “тодорхой бус хугацаа” гэдэг нь талууд гэрээ дуусгавар болох хугацаат дээр дурьдсанаар тодорхойлоогүйг ойлгоно.

7. Тодорхой хугацаатай гэрээний хугацаа дуусан болобч суущ хөлслүүлэгч татгалзаагүй, хөлслөгчсуущы цаашид үргэлжлүүлэн эзэмшиж, ашиглах хүсэлт гаргавал гэрээг тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно.8. Хуулийн 247 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...орон суущыг иргэн насаараа эзэмшиж, ашиглах бүюу үр эрхээ өв залгамжлуулж болно” гэдгийн “насаараа эзэмшиж ашиглах” гэдгийг мөн хуулийн 262 дугаар зүйлийн 3, 4, 5 дугаарт заасчаас бусад эвэхэн нийтийн зориулалттай хэд хэдэн суущ бүхий байшингийн хувьчлагдаагүй суущыг эзэмшиж насаараа эзэмшиж ашиглахыг, “үр эрхээ өв залгамжлуулж болно” гэдгийг иймэ орон суущыг эзэмшиж нас барахдаа өөрийн эзэмшиж байсан суущаа гэр бүлийн гишүүдээс тодорхой нэр заасан эсхүл гэр бүлийн гишүүн биш боловч түүний хууль ёсны ев залгамжлах эрх бүхий этгээдэд суущ эзэмшиж эрхээ хуульд заасан үндэслэл, журмаар өвлүүлэхийг тус тус ойлгоно.

9. Хуулийн 249 дугээр зүйлд заасан “...орон суущы дундын ашиглалтын талбай” гэдэгт байшингийн орц, түүний хаалга болон Орон суущ хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4-т заасан цахилгаан болон явган шат, шатны хонгил, суущ хоорондын талбай, түүний тагт дээвэр, тоног төхөөрөмж, довжоо, цонх, хог зайлуулах хоолой, халаат, халуун хүйтэн усны удирдах зангилааны анхны хаалт хүртэл цахилгааны оролтын самбар хүртэл, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэл, шалны ± 0,00 тэмдэгтээс дээш-ээ бохир усны шугам сулжээний талбай хамаар-на. Харин нийтийн байрны хувьд гал тогооны болон ариун цэврийн өрөө, суущы хоорондох талбайг хамаарууллж болно.

10. Хуулийн 261 дугээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “ашиглалтын шаардлага хангахүй болсон орон суущы байшин” гэдэгт ашиглалтын хугацаа дуусснаас ердийн элэгдэлд орсон, техник, ариун цэврийн зохих түвшинд байлгах шаардлагатай арга хэмжээг цаг тухайд авааглүйгээс хүн амьдрах боломжгүй болсон, өөрөөр хэлбэл суйрлийн байдалд орсон байшинг ойлгоно.

11. Хуулийн 262 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “...гэрээний үүргээ байнга зөрчиж хөлслүүлэгчээс урьдчилан удаа дараа сануулсаар байтал” гэдэгт орон суущ хөлслөгч болон түүний гэр бүлийн гишүүд нь суущы эзэмшиж, ашиглах явцдаа хууль бүюу гэрээнд заасан үүргээ гурав бүюу түүнээс дээш удаа зөрчилүүлэгүй байвал мөн эдэ нөхцөл талаар хөлслүүлэгч тухай бүрд урьдчилан сануулсан байхыг ойлгоно. Хөлслүүлэгч дээрх зөрчил гаргасан болон хөлслөгчид урьдчилан сануулсан тухайгаа шүүхэд бичгийн нотлох баримтаар нотолсон байвал зохино.

12. Хуулийн 262 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “хууль бүюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хөдлөмөрийн гэрээгээр ажилласж байхдаа гэрээгээр тохиролцсоны дагуу аж төрж байсан орон суущаа уг гэрээнд заасан хугацаа дуусахад чөлөөлөөгүй” гэдгийн “уг гэрээ” гэдэгт тухайн орон суущыг эзэмших тухай түсгай гэрээ бүюу хөдөлмөрийн бүюу иргэний гэрээний тухайн орон суущы эзэмших тухай заалтыг ойлгоно. Орон суущ эзэмших гэрээгээр тодорхой хугацаагаар хийсэн бол орон суущ эзэмших эрх нь хугацаа дуусмагц, тодорхой бус хугацаагаар хийсэн бол орон суущ эзэмших эрх нь хөдөлмөрийн харилцаа дуусмагц тус тус дуусгавар болно. Хэрэв хуульд заасан бүюу суущ хөлслөх гэрээнд түсгай болсон тавьсан /тэтгэвэр гарсан, тахир дутуу болсон, үйлдвэрлэлийн осолд орсон/ тохиолдолд орон суущыг үргэлжлүүлэн эзэмшиж гэх мэт бол хууль, гэрээний заалтыг хэрэглэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ШҮҮГЧ Д.ТУНГАЛАГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612, 322838

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйн эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт 3400 ш хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот | 1999 оны дөрөвдүгээр сарын 6 | №14(93)

Гарчиг

нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

127. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай — Дугаар 51 — 185

хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

128. Захиалга-даалгавар батлах тухай — Дугаар 35 — 185
129. Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай — Дугаар 36 — 189
130. Журам батлах тухай — Дугаар 37 — 194
131. Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай — Дугаар 38 — 195
132. Тогтоолд нэмэлт оруулах тухай — Дугаар 39 — 196

гурав.Яам,агентлагийн акт

133. Журам батлах тухай (Монгол Улсын Хуульд зүйн сайдын тушаал) — Дугаар 38 — 196
134. Шалгуур үзүүлэлт батлах тухай (Монгол Улсын Гэгээрлийн сайдын тушаал) — Дугаар 34 — 199

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Итали Улсад суух Онц бөгөөд Хасбаярын Бэхбатыг Монгол Улсаас Итали Улсад
онц эрхэт Элчин сайдаар Тогтвордоржийн Луузанг суугаа Онц бөгөөд Бүрэн эрхэт Элчин сайдын үүрэгт
тоон томилсугай. ажлаас чөлөөлсүгэй.
2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

'9 оны 3 дугаар сын 3-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

Захиалга-даалгавар батлах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн эрх хэсгийн 10-т заасныг үндэслэн Монгол Улсын ргийн газраас ТОГТООХ нь:

1. "Зэвсэгт хүчин, бусад цэргийн хэрэгцээнд ийлүүлэх бүтээгдэхүүний захиалга-даалгаврын нийт хэмжээ"-г 1 дүгээр ісралтын, "Зэвсэгт хүчин, бусад цэргийн эргцээнд зориулан аймаг, нийслэлээс 1999 онд элүүлэх бүтээгдэхүүний захиалга-даалгавар"-ыг

2 дугаар хавсралтын, "Хилийн цэргийн хэрэгцээнд зориулан аймаг, нийслэлээс 1999 онд нийлүүлэх бүтээгдэхүүний Захиалга-даалгавар"-ыг 3 дугаар хавсралтын ёсоор зүс зүс батлагдсугай.

2. Энэ тогтоолоор батлагдан захиалга-даалгаварт бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу нийлүүлэх арга хэмжээ авахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — Ж.НАРАНЦАЦРАЛТ
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД — Ш.ТҮВДЭНДОРЖ

Уншигчдын анхаарал!

Компьютерийн программчлагдсан нөхцөлд тохируулж эмхтгэлийн энэхүү дугаарын эхний ідсыг дугаарлахдаа 184-ийг алгасч,185 гэсэн сондгой дугаар өгөв.

Засгийн Газрын 1999 оны 35 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗӨВСӨГӨТ ХҮЧИН, БУСАД ЦЭРГИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН 1999 ОНД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХИАЛГА-ДААЛГАВРЫН НИЙТ ХЭМЖЭЭ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нийлүүлэх нийт хэмжээ	Үүнээс			
				Зөвсөгөт хүчний ерөнхий штаб	Хилийн цэргийг удирдах газар	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар	Цагдаагийн ерөнхий газар
1	Мах /амьдын жингээр/	тн	3643,8	1352,8	1791	–	500
2	Төмс	тн	679,3	679,3	–	–	–
3	Бусад ногоо	тн	381,4	381,4	–	–	–
4	Автобензин А-76	тн	3802	1650	2152	–	–
5	Дизелийн түлш	тн	1904	839	1065	–	–
6	Тослох материал, тусгай шингэн	тн	300,1	106,1	194	–	–
7	Бензин АИ-93	тн	44	44	–	–	–
8	ТС-1 түлш	тн	336	336	–	–	–
9	Спирт	тн	2	2	–	–	–
10	Нүүрс	тн	96190	60896	35294	–	–
11	Түлшний мод	$м^3$	22230	6130	16100	–	–
12	Эсгий гутал	хос	7500	1500	6000	–	–
13	Зуны ботинк	хос	4500	4500	–	–	–
14	Орны бүтээлэг	ш	800	300	500	–	–
15	Каракуль арьс	ш	930	500	210	70	150
16	Хөх цегейк	$дм^2$	455600	95600	110000	–	250000
17	Цагаан нэхий	$дм^2$	2256420	417000	450000	–	1389420
18	Офицер танкийн хар хувцас	хос	100	100	–	–	–
19	Цэрэг нэхий дээл	ш	500	–	500	–	–
20	Уналгын морь	ш	857	–	857	–	–
21	Уналгын тэмээ	ш	50	–	50	–	–

ЗӨВСӨГТ ХУЧНИЙ ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС 1999 ОНД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХИАЛГА-ДААЛГАВАР

№	Бүтээгдэхүүний нэр	хэмжих нэгж	Нийлүүлэх хэмжээ /аймгаар/																			
			Улаанбаатар	Орхон	Баянхонгор	Өвөрхангай	Булган	Сэлэнгэ	Завхан	Дорнод	Говьсүмбэр	Өмнөговь	Ховд	Баян-өлгий	Увс	Дундговь	Төв	Дархан-уул	Хөвсгөл	Сүхбаатар	Дорноговь	Архангай	Хэнтий
1	Мах /амьдын жингээр/	Тн	-	-	-	44,6	0,5	4,3	38,1	63,3	-	107	88	-	-	-	-	-	-	356	175	77	400
2	Тэмс	тн	-	57	-	23	-	522	-	32,5	-	-	45	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Бусад ногоо	тн	-	31	-	12,5	-	86,4	-	16,5	-	-	25	-	-	-	210	-	-	-	-	-	-
4	Автобензин А-76	тн	980	85	20	85	-	-	50	70	-	110	80	10	10	10	-	-	10	20	110	-	-
5	Дизелийн түлш	тн	319	20	54	44	-	-	74	22	-	74	10	10	40	10	-	-	12	40	110	-	-
6	Тослох материал гүсгай шингэн	тн	44,3	8,6	1,1	8,6	-	-	5,1	8,5	-	9,1	8	0,4	0,8	0,5	-	-	0,7	1,1	9,3	-	-
7	Бензин АИ-93	тн	44	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	ТС-1 түлш	тн	336	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Спирт	тн	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Нүүрс	тн	46078	-	397	3484	-	-	-	300	5420	1423	1570	-	36	100	-	1021	784	283	-	-	-
11	Түлшний мод	м³	-	150	-	500	-	4430	350	200	-	-	300	-	100	-	-	50	50	-	-	-	-
12	Эсгий гутал	хос	1500	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Зуны ботинк	хос	4500	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
14	Орны бүтээлэг	ш	300	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
15	Каракуль арьс	ш	-	-	-	-	-	-	-	500	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	Хөх цегейк	дм²	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	95600	-	-	-	-	-
17	Цагаан нэхий	дм²	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	417000	-	-	-	-	-
18	Офицер танкийн хар хувцас	хос	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	100	-	-	-	-	-

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он №14 (93)

Засгийн газрын 1999 оны 35 дугаар тогтоолын
3 дугаар хавсралт

ХИЛИЙН ЦЭРГИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС 1999 ОНД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХИАЛГА-ДААЛГАВАР

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нийлүүлэх хэмжээ /аймгаар/															
			Улаанбаатар	Булган	Сэлэнгэ	Завхан	Дорнод	Говьсүмбэр	Өмнөговь	Хөвсгөл	Баян-өлгий	Увс	Төв	Дархан-уул	Хэнтий	Сүхбаатар	Говь-алтай	Дорноговь
1	Мах /амьдын жингээр/	тн	-	214	88,1	48,7	314,8	-	226,9	157,6	77,8	69,7	30,4	-	17,1	142,3	105,8	289,8	8,4
2	Автобензин А-76	тн	550	55	60	45	280	-	190	130	130	42	-	-	45	250	120	220	35
3	Дизелийн түлш	тн	220	6	15	4	200	-	120	90	35	18	-	-	12	170	80	90	5
4	Тослох материал, тусгай шингэн	тн	100	1	1	2	20	-	5	20	15	3	-	-	1	10	10	5	1
5	Нүүрс	тн	10680	-	-	-	9000	-	4374	3420	2500	500	-	500-	-	2500	1820	-	-
6	Түлшний мод	$м^3$	6800	500	1000	2350	3500	-	-	-	600	350	-	-	500	-	-	-	500
7	Эсгий гутал	хос	6000	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Орны бүтээлэг	ш	500	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Карахуль арьс	ш	-	-	-	-	-	210	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Хөх цегейк	$дм^2$	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	10000	-	-	-	-	-
11	Цагаан нэхий	$дм^2$	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	50000	-	-	-	-	-
12	Цэрэг нэхий дээл	ш	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	500	-	-	-	-	-
13	Уналгын морь	ш	-	-	50	100	150	-	-	50	107	300	-	-	-	-	50	50	-
14	Уналгын тэмээ	ш	-	-	-	-	-	-	50	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тайлбар: Дундговь аймаг Цагдаагийн ерөнхий газрын хэрэгцээнд 500 тн мах /амьдын жингээр/, Говьсүмбэр аймаг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын хэрэгцээнд 70, Цагдаагийн ерөнхий газрын хэрэгцээнд 150 ширхэг карахуль арьс, Дархан-уул аймаг Цагдаагийн ерөнхий газрын хэрэгцээнд 250000 дециметр хөх цегейк, 1389420 дециметр цагаан нэхий түс түс нийлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай, Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулинд заасныг үндэслэн Монгол улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Нийгмийн халамжийн сангийн дүрэм"-нийг 1 дүгээр хавсралтаар, "Түгсгал сургалтын төрийн бус байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл олгох олгох тухай журам"-ыг 2 дугаар хавсралтаар, Ахмад настанд хөнгөлөлт үзүүлэх тухай журам"-ыг дугаар хавсралтаар, "Тахир дутуу иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний тухай журам"-ыг дугаар хавсралтаар тус тус батална уулай.

2.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид нэмэлт оруулсан төсөөх авах эрх үүсэх боломжтой этгэмэл настан нас барсан бол түүний оруулсан нэрлэсэн хэмжээг Нийгмийн даатгалын сангаас олгох тогтоовор, төлөөлөгчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд нэмэлт оруулсан төлөөлөгчийн 75 хувиар тооцох ийн нутгийнхаа төсөөс гарган олгох байхыг сум, дүргийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3.Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх талаар дор дурдсан арга хэмжээ авахыг Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалалын сайд С.Сонинд даалгасугай:

1.2. Ажил төлөвлөлт A_2 =a/n	а-зайлшгүй байх төлөвлөлтийн тоо т-гүнзээс хангалттай үнэлгээ авсан төлөвлөгөө
1.3. Дотоод хяналт шалгалт A_3 = a/n	а-зайлшгүй байх хяналт т-гүнзээс хангалттай үнэлгээ авсан хяналт шалгалтын тоо
1.4. Мэдээ судалгаа A_4= a/n	а-хичээлийн жилд гаргаман зохих мэдээ, судалгаа, тайлангийн тоо т-гүнзээс хүлээлэг нь гүйцэтгэн хангалттай үнэлгээ авсан мэдээ, судалгаа, тайлан
5. Байгуулагчин удирдах зөвлөлийн гишүүдийн үнэлгээ A_5 =a/n	а-самал өгөвөл оролцсон удирдах зөвлөлийн гишүүдийн тоо т- зохигчаны ажлын түвшинд хангалттай үнэлгээ өгсөн гишүүдийн тоо
1 шалгуурын оновчлох дүн A = $(A_1+A_2+A_3+A_4+A_5)$* 1.2	
2. Багц, ажилтан бүрээдэхүүн, чанар	
1. Ажил, мэргэжлийн зэрэг цолтой багш B_1= a/n	а- ажиллах байгаа нийт багшийн тоо т- зэрэг, цолтой багшийн тоо
2. Багш нарын бүтээлч байдлын түвшин B_2= a/n	а- ажиллах байгаа нийт багшийн тоо т- судалгаанд ажил, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн бүтээл гүүрэмтэй багшийн тоо
3. Багш нарын мэргэжлийн ур чадварын түвшин B_3= a/n	а- ажиллах байгаа нийт багшийн тоо т- мэргэжлийн чанарай урамдал тэмцээнд амжилттай оролцсон багшийн тоо
4. Багш нарын сургалтын үйл ажиллагааны хүрээ B_4= a/n	а- ажиллах байгаа нийт багшийн тоо т- сургалтын үйл ажиллагаанд талаар эзэг эх олон нийтээс хангалттай үнэлгээ авсан багшийн тоо
2 шалгуурын оновчлох дүн B=$(B_1+B_2+B_3+B_4)$ * 1.4	
3. Сургалтын агуулга чанар, хүүгээнэх	
1. Хүчин чадлын ашиглалт C_1 = a/n	а- хүүхдийн цэцэрлэгийн хүчин чадал т- цэцэрлэгт хамрагдаг бүй хүүхэд
2. Төйгрийнхоо хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж буй байдал C_2 = a/n	а- хамрах төйгрийн сургуулийн өмнөх насны хүүхдийн тоо т- сургуулийн өмнөх боловсрол олгосон хамрах төйгрийн хүүхдийн тоо
3. Хүүхдийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг үнэлэх шалгалтанд үзүүлсэн дүн C_3 = a/n	а- шалгалтанд хамрагдсан хүүхдийн тоо т-хангалттай үнэлгээтэйлгагдсан хүүхдийн тоо
4. Багш нарааг хүүхдэтэй ажилаа бүй байдал C_4 = a/n	а-шалгалтанд хамрагдсан багшийн тоо т- хангалттай үнэлгээтэй шалгагдсан багшийн тоо
5. Хүүхдийг эрүүлжүүлж чийрэгжүүлэх, өөрт хэгшилтийг хангаж ажил C_5 = a/n	а-цэцэрлэгийн нийт хүүхдийн тоо т-эрүүлжүүлэх чийрэгжүүлэх ажилд хамрагдсан хүүхдийн тоо
3 шалгуурын оновчлох дүн C=$(C_1+C_2+C_3+C_4+C_5)$* 1,6	
4. Цэцэрлэгийн материалаар нөхцөл	
1. Гадна талбайн тохижилт D_1 = a/n	а- талбайн тоо т- шаардлага хангасан талбайн тоо

4.2. Сургалтын төвшгөө хэрэгслийн хангамж
D_2= м/э
n- нийт бүлэг танхимын тоо
m- стандартын төвшгөө, хэрэгслээр хангагдсан бүлэг өрөө тасалгааны тоо

4.3. Осол аюулгүй байх эрүүл ахуй,орчин цэвэрийн шаардлагыг хангасан байдал D_3= м/э
n- нийт бүлгийн тоо
m- шаардлага хангасан бүлгийн тоо

4.4. Тогтоон наадгай,сургалтын хэрэгслэгдэхүүний хангамж
D_4= м/э
n- нийт бүлгийн тоо
m- тогтоон наадгай сургалтын хэрэгслэгдэхүүнээр хангагдсан бүлгийн тоо

4 шалгуурын онооны дүн $D=(D_1+D_2+D_3+D_4)*1$

E- Ерөнхий үнэлгээ
E= A+B+C+D

Гурав. Шалгуур үзүүлэлтүүдийн зорилго, үнэлгээ өгөх заавар

1. Цэцэрлэгийн үйл ажиллагааны түвшинг оноогоор үнэлэхдээ 4 бүлэг шалгуур тус бүрийн нормативэ тоо /n-ийг n-д харьцуулан/-г олж тэдгээрийн нийлбэрийг бүлэг тус бүрд тохирох ач холбогдлын коффициентэр үржүүлж, улмаар ононы нийлбэрийг гаргана.

2. Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны түвшинг авсан оноог үнэлэхэд " Хангалттай сайн", "Хангалттай", "Хангалтгүй" гэсэн зэрэглэлээр дараах байдлаар үнэлнэ.

Зэрэглэл	Авсан нийлбэр оноо
Хангалттай сайн	1. 17- ооc дээш
Хангалттай	2. 12-16
Хангалтгүй	3. 12 оос доош

3. Нягталгээр бүлэг шалгуур үзүүлэлт нь цэцэрлэгийг хөгжүүлэх бодлого, зорилт, цэцэрлэгийн эрхлэгчийн удирдлагын арга барил, чадвар, ажлын төлөвлөлт, туйлбэрлэлийн хяналт шалгалт, мэдээ, тайлан бүрдүүлэх байдалд үнэлгээ өгнө.

3.1. Боловсруулан мөрдөлт зохих бариыг бичүүд
а/ Зааригааны тусалт, шийдвэр, хуулийн төмдөгтэл
б/ Байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр бодлого, үзэл баримтлал
в/ Хөрөнгөмерийн харицаалт зохицуулах бариыг бичиг /хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ г.м/
г/ Цэцэрлэгийн дотоод журам
Бариыг бичгүүйнь боловсруулалт, хэрэгжилтийн байдалд " хангалттай", бө "хангалтгүй" гэж үнэлгээ өгч, "хангалттай" үнэлгээ авсан бариыг бичгийн тоог нийт бариыг бичгийн тоонд харьцуулна.

3.2. Хүүхдийн цэцэрлэгт байгуулагын ажлын төлөвлөлтийг илэрхийлсэн дараах төлөвлөгөө байх болно.
а/урт хугацааны
б/богино хугацааны буюу цаг үеийн ажлын төлөвлөгөө
3.3. Цэцэрлэгийн дотоод хяналтууд:
а/хүүхдийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг үнэлэх зангилагууд
б/цэцэрлэгийн удирдлагаас бага мэрэн сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт
в/эцэг эх, олон нийтийн байгууллагаас бага ажиллагсдын үйл ажиллагаанд тавих хяналт
г/цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, тоо бүртгэл
Эдгээрээс хангалттай сайн нийлбэр байгаагаар нь 1.3 үзүүлэлт үнэлэгдэнэ.
3.4. Хичээлийн жилд тухайн цэцэрлэгийн гаргасан зохих мэдээ тайлан
а/Гэрээрлийн хамаанд ирүүлбэг /Ц-1, Ц-2, Ц-4/ мэдээ
б/ хагас, бүтэн жилийн тайлан

4. Хөөрдүүлэг бүлэг үзүүлэлт нь тухайн цэцэрлэгийн багш нарын бүрэндэхүүн, ажлын чанар, ур дүнг үнэлэх зорилготой бөгөөд багш нарын мэргэжлийн ур чадварын түвшин, сургалтын ажлын хүрээ, багш ажилтны бүтээлч байдалд үнэлгээ өгнө.

4.1.Зэрэг, цолтой багш гэдэгт ахлах багш, арга зүйч багш,зөвлөх багш, гавьяат багш, АБТА зэрэг мэргэжлийн зэрэг,цолтой багшийг ойруулж 2.1. үзүүлэлтийг үнэлнэ.

4.2. Багш нарын бүтээлч хандлагын түвшинг тогтоохдоо:
а/ онол, арга зүйн судалгаа хийж тодорхой ур дүнд хүрч байгаа
б/зөвлөмж, гарын авлага зохиосон болон зохиохоор ороцгосон
в/тогтоон наадгай, сургалтын хэрэгслэгдэхүүний эх зохиосон, энэ нь нийтийн хүртээл болж бүй зэрэгийг авч үзнэ.
Эдгээр дээр тулгуурлан 2.2 үзүүлэлтийг үнэлнэ.

4.3.Багш нарын мэргэжлийн ур чадварын түвшинг тодорхойлохдоо багшийн ур чадварын уралдаан, сургаи хэмүүжүүлэх үншлага, бүтээлч уралдаан зэрэг мэргэжлийн чанартай арга хэмжээнүүдэд амжилттай оролцсон байдлыг авч үзнэ.

4.4.Багш нарын сургалтын үйл ажиллагааны хүрээг тодорхойлохдоо давсан анги бүлгийнхээ болон хамрах төлбөгийнхөө сургуулийн өмч насны хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх талаар эцэг эх, олон нийтэд мэргэжлийн зүслаглаа үзүүлж хэрэгжүүлдэг байдлыг үйлчүүлэгч эцэг эх, олон нийтээс санал асуулга авч үнэлүүлнэ.

5. Гуравдугаар бүлэг шалгуур үзүүлэлт нь тухайн цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааны чанар, ур дүнг тодорхойлоод чиглэгдэнэ.

5.1.Тухайн цэцэрлэгийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах байгааг авч үзнэ.

5.2.Төлбөгийнхөө сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчгүй хүүхдэд хүрч ажиллах байгаа байдлыг авч үзнэ.

5.3.Хүүхдийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх зангилаг ашуулж дүгнэлт гаргана.

5.4.Хөнгөлөх хийх ажлын явцад нийт багш нарын хичээл болон сургалтын бусад үйл ажиллагааг удирдан явуулж буй эрх бариа, эв дүйцэ хангалттай үнэлнэ.

6.Дээрхдүгээр бүлэг шалгуур үзүүлэлт нь тухайн цэцэрлэгийн материалаар мөнцөл, сургалтын орчныг бүрдүүлсэн байдал, тогтоон наадгай, сургалтын хэрэгслэгдэхүүний хангамж зэргийг тодорхойлоод чиглэгдэнэ.

7.Энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээ өгөх аргачлалд нийцүүлэн нэмэгдэл үзүүлэлт, холбогдох судалгаог гаргаж ашиглаж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.
Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн ордон Индекс: 14503

Төр, Засгийн Үйлчилгээ ажахуйг эрхлэх
газрын харъяа Хэвлэх үйлдвэрт
хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны дөрөвдүгээр сарын 12* №15 (94)

ГАРЧИГ

нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

135. Н.А.Логачевыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай — Дугаар 52 — 201

хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

136. Хөтөлбөр батлах тухай — Дугаар 43 — 201

137. Спартакиад зохион байгуулах тухай — Дугаар 45 — 212

гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

138. Заавар батлах тухай (Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаал) — Дугаар А/26,10 — 212

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 3 дугаар сарын 30-ны өдөр — Дугаар 52 — Улаанбаатар хот

Н.А.Логачевыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын шинжлэх ухааны хүрээллагуудын хамтын ажиллагаат хөгжүүлэх, манай ард мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын ШУА-ийн Ерөнхийлөгчийн зөвлөх, академич Николай Алексеевич Логачевыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 10-ны өдөр — Дугаар 43 — Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1998 оны 9 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Усны үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, Усны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат удирдах зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ийг 2 дугаар хавсралтын, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор эхний ээлжинд хийх ажлын төлөвлөгөө"-г 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжаар санхүүжүүлэх боломжийг судалж, санаа гаргаадын холбогдох улс орон, байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Гадаад харилцааны сайд Н.Туяа, Сангийн сайд Я.Очирсүх нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоодын эх үүсвэрээс шаардагдах хөрөнгийг 1999 оноос эхлэн жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Үндэсний зөвлөлийн дарга, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД — **С.МЭНДСАЙХАН**

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД — **Ч.СОДНОМЦЭРЭН**

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД — **Г.БАТХҮҮ**

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД — **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 43 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

УСНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Өнөөгийн байдал

Хүн амын өсөлт, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ тэлэхийн хэрээр ус хэрэглээний хэмжээ нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр нутгийн зарим хэсэгт усыг ихээхэн үрэлгэн ашиглах болсон, томоохон хот суурингийн ойролцоох усны эх үүсвэрийн хомсдол, бохирдол ихээсэн зэрэг нь хүн амын амьдрах орчинд сөрөг нөлөөлсөөр байна. Түүнчлэн голын усны тэжээгдлийн бүсэд тооцоо судалгаагүйгээр мод ихээр огтолсноос Туул, Хараа, Хэрлэн зэрэг голын ус багасч, тэдгээрийн усны бохирдол эвшээрэгдэх аюулламжаас олон дахин давж байгаа нь шинжилгээгээр тогтоогдоод байна.

Одоогийн байдлаар 70 гол, 1 булаг, 9 нуурт ус судлалын 107 харуул, 14 өртөө ажиллаж усны горим, чанар найрлагын судалгаа хийж байгааригийн дотор усны биологийн дээжийг 54, ууршлыг 8, усны өнгөрөлтийг 81 харуулаар холбогдох хэмжилт хийж байна. Энэ нь дэлхийн өнөөгийн түвшнээс 3 дахин доогуур байна.

Манай орны усны нийт нөөц 38.8 шоо км бөгөөд жилд ашиглах боломжит усны нөөцийн хэмжээ 34.6 шоо км, үүний 17.8 хувийг газрын доорхи усны нөөц бүрдүүлдэг. Нийт ус хэрэглээний 80 орчим хувийг газрын доорхи усны нөөцөөс хангаж байна.

Манай улсын нийт хүн амын 30.8 хувь нь төвлөрсөн цэвэр ус түгээгүүрийн системээс, 24.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 35.7 хувь нь ус түгээх цэг, худгаас усаар хангагдаж, 9.1 хувь нь булаг шанд, гол горхи, цас мөсний усыг ууд, ахуйдаа хэрэглэж байна.

Нийт усны эх үүсвэрийн 70 хувьд ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоогоогүй, 30 хувь нь ариун цэврийн паспортгүй байгаа нь хүн амын ууд, ахуйн хэрэглээний усны аюулгүй байдлыг хангах, бохирдолтоос хамгаалах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Ундны усны ариун цэврийн бүсийн дэглэм, түүний шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас хүн амын ууд, ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа худгуудын усны чанар муудах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал, малын ялгадас, бордоо, хатуу хог хаягдлаар бохирдох явдал байнга тохиолдож байна. Хүн амын ууд, ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа худгуудын усны эх үүсвэрийн 10 хувь нь усны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байна.

Орчны бохирдолт, усны хангамж хүрэлцээ, чанарын аюулгүй байдал, хүн амын эрүүл жар төрөх ёсны соёл, боловсролын түвшинтэй холбоотойгоор суулийн жилүүдэд манай улсад вируст гепатит 2.3, цусан суулга 1.4 дахин тус тус нэмэгдэж гэдэсний балнад, урвас тахал зэрэ халдварт өвчнүүд голомтлон гарч, зарим халдварт бү өвчин нутагшмал байдалтай болох хандлагатай байна.

Хот, суурин газрын хөгжилийн хэтийн төлөвтэ уялдуулан ус хангамжийн асуудлыг шийдвэрлэ үйлчилгээний хүрээг өргөтгөх зорилгоор суулийн 20 гару жилд нэлээд арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсн үр дүнд хот, аймгийн төвүүдийн ус хангамжийн барил байгууламжийн хүч чадал 6 дахин өсч, 339 худаг, 1(насосны станц, 783 км шугамаар дамжуулан ус олдворло хоногт 550 гаруй мянган шоо метрт хүрсний зэрэгцээ бохи ус цэвэрлэх байгууламжийн нийлбэр хүч чадал 4 дахи нэмэгдэн хоногт 400 гаруй мянган шоо метр бохир цэвэрлэх боломжтой болсон юм.

Манай улсын хөдөөгийн 345 төв суурингийн 170 гару сумын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагат байгаас дөнгөж 70 сумын төвийн хангамжийн асуудлы шийдвэрлэсэн бөгөөд өнөөгийн байдлаар хоногийг малчдын дийлэнх хэсэг нь бэлчээр усжуулалты зориулалттай уст цэг болон ил задгай усыг ууд, ахуй хэрэглээндээ ашиглаж байна.

Цаашид 109 гаруй сумын ус хангамжийг сайжруул зорилгоор усны эх үүсвэрийн хайгуул, судалгааны ажл хийх шаардлагатай байгаагаас 21 сумын төвийн у хангамжийн асуудал туйлын хүндрэлтэйд тооцогдогий зэрэгцүүлэ манай орны нийт сум, суурин газрын 38.5 хув оршин суугаа хүн амын ууд, ахуйн хэрэглээндээ ашигл байгаа ус найрлагаараа эрүүл ахуйн шаардлагыг хангахгү байна.

Ус сувгийн аж ахуйд ашиглагдаж байгаа тусга зориулалтын техник, тоног төхөөрөмжийн ихэнх нь 196 аад онуудад суурилагдсан, нийт тоног төхөөрөмжийн орчим хувь нь 10-аас дээш жил ашиглагдсан болоо хөрөнгийн эх үүсвэргүйгээс тэдгээрт их болон урсга засвар, шинэчлэл хийгдэхгүй байна. Ус хангамжий барилга байгууламж, тоног төхөөрөмж хуучирч муудс нь цэвэр усны үргүй зардлыг нэмэгдүүлэх гол хүчин зү болж байгаа учраас ус хэрэглээг тоолууржуулах, ус хэмнэлттэй ашиглах зэргийн хөшүүргэ, механизм бий болгон хэрэгжүүлэх шаардлага тулгамдсан асуудлы нэг болж байна.

Монгол Улсад нэг хүнд ногдох ус хэрэглээний хэмж дэлхийн дундажаас 3-4 дахин бага байна. Судалгаан үзэхэд тэр, суурин газруудын болон томоохон хө аймгийн төвүүдийн гэрийн хорооллод амьдарч байгаа н хүнд ногдох дундажаар 8-10 литр ус ногдож байгаа нь эрү ахуйн нормоос 4-5 дахин бага байна. Харин ус хэрэглээн хэмжээ Улаанбаатар хотод хөгжилтэй орнуудын хэрэглээнээс давж байгаа нь усыг маш үрэлгэн ашигла ус түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засв үйлчилгээ тогтмол бус байгаатай холбоотой юм. И

айддаар ундны усны зориулалттай цэвэр усыг үргүй
ардуулбал 2010 онд нийслэл хотыг цэвэр усаар хангах
суудал ихээхэн бэрхшээлтэй болох төлөвтэй байна.

Унд, ахуйн хэрэглээний усны чанарт үйлдвэрлэлийн
нжилгээ хийж, чанарын шаардлага хангасан усыг хүн
мд түгээх шаардлагатай боловч одоогийн байдлаар
лаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Орхон аймгийн
с ашиглалтын байгууллагаас бусад нь усны
аборатогийгүйгээс хүн амын 50 орчим хувь нь чанарын
анлттүй ундны усаар хангагдаж, цаашид шийдэрлэвэл
эхих асуудлын нэг болоод байна.

Улсын хэмжээнд 120 гаруй бохир ус цэвэрлэх
айгууламж ашиглагдаж байгаа боловч ихэнхийнх нь
оног төхөөрөмж хуучирсан, засвар үйлчилгээ,
инэчлэлийн өртөг зардал өндөр зэрэг хүндрэлээс
алттаалан бохир усыг зөвхөн дамжуулан өнгөрүүлэх
айддаар ажилаж, цэвэршүүлэлтийн түвшин шаардлагын
эмжээнд хүрэхгүй байна. Түүнчлэн 1995 оны байдлаар
үйн болон үйлдвэрийн нийт хаягдал усны 35 шахам
йвийг цэвэршүүлэлгүйгээр байгальд хаяж байв.

Хэдийгээр усны салбарт улсын төсвөөс жилд
нджаар 250 гаруй сая төгрөгийг зарцуулж байгаа боловч
ны бохирдлын хэмжээ төдийлэн буурахгүй байгаагийн
эрэгцээгээр цэвэрлэх байгууламжийг барих, өргөтгөх,
ювардах ажлыг гүйцэтгэлд тавих хяналт сулаас
дгээрийг ашиглалтад өгөх хугацаа тодорхойгүй
алттаанаар байнга хойшлогдон серөг үр дагавар
эгэлжилсээр байна. Аймаг, хотуудын усвүйн барилга
йгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил хөрөнгийн
үүсвэр, мэргэжлийн удирдлага дутагдсанаас удаширах,
ловлөгөөт хугацаар бариментлахгүй ажил урсгалаар явах,
лттэгдэн материал, тоног төхөөрөмж, хөрөнгийн эх
сэврийг зориулалт бусаар ашиглах зэрэг дутагдал, зөрчил
илахгүй байна.

Бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариалан
ахлэх зорилгоор инженерийн хийцтэй 29 мянга гаруй
даг, уст цэг, 17 гаруй мянган уурхайн худаг гарган нийт
лчээрийн 64.5 хувийг усжуулж, 50 шахам мянган га
лбайг услах нийлбэр хүч чадалтай энгийн болон
женерийн хийцтэй 150 гаруй услалтын систем барьж
йгуулжээ. Гэвч сүүлийн 10 орчим жилд нийт худгийн 25
вь нь устаж, 18 хувь нь ашиглах боломжгүй орхигдсоны
эр жилд шинэзр гаргах худгийн тоо бараг 10 дахин
гасч, бэлчээрийн худгуудын барилга байгууламж, тоног
хөөрөмж тоноглон зөвхөн цооног үлдэсний хэрэгцээ
000 га талбай бүхий 26 услалтын систем орг
иглагдахгүй байна.

1990 оноос хойш услалтын системийг шинээр
йгуулах, засварлах болон техник, технологийн
инэчлэлийн ажил хийгээгүй, нөгөөтэйгүүр газар өмчлөл,
эмшлийн асуудал бүрэн шийдвэрлэгдэхгүй байгаагаас
алттаалж услалтын системийн ашиглалтын зохистой
тэц бүрэлдээгүй байна. Бэлчээрдэх уст цэгийн тоо жилээс
лд буурч байгаагаас малчдын бэлчээр сэлгэн ашиглах
амжлал хумигдаж ойролцоох уст цэг, булаг шандыг
раадан нутагтаа болсноос нийт бэлчээрийн 3.5 сая га
зар хүчтэй, 5 сая га газар дундаас дээш хэмжээгээр
ихлагдаж цөлжих хандлага эрчимжиж байна. Ингэж
бэлчээрийг сэлгээгүйгээр ашиглаж байгаагаас хөрсний
бүтэц эвдрэх, ус чийгийн хэмжээ багасах зэрэгээр байгалийн
аясаар үргамалжин нөхөн сэргэгдэх нөхцөл алдагдаж
байна.

Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах
бодлогын хүрээнд Усны тухай болон Ус, рашаан
ашигласны төлбөрийн тухай хууль, 20 гаруй эрх зүйн
бусад акт батлагдан гарсан боловч тэдгээрийн нэлээд нь
бүрэн мөрдөгдөхгүй, цаашид боловсронгуй болгох
шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Хөтөлбөрийн зорилго нь хэрэглээгчдийг чанартай,
хүрэлцээтэй усаар найдвартай хангах, усны нөөцийг
нөхөн сэргээх, хомсдох, бохирдохоос хамгаалах замаар
нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжлэг
үзүүлэхэд оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилтод дараахь асуудал хамаарна:

1/ усны нөөцийн хэмжээ, чанарыг тогтоох эрэл
хайгуул, судалгаа, шинжилгээний ажлыг тодорхой үе
шаттайгаар зохион байгуулах, ус хэрэглээний өсөн
нэмэгдэх хэрэгцээг тасралтгүй бүрэн хангах;

2/ ус ашиглалтын уламжлалт арга, дэвшилтэт
технологи, шинэлэг санаачилгыг нийгмийн хөгжлийн
хэрэгцээ, шаардлагатай холбон судалж туршин
нэвтрүүлэх;

3/ ус ашиглалтын болон байгалийн бусад серөг
нөлөөллөөс усны нөөц хомсдож, бохирдохоос урьдчилан
сэргийлэх, хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргэдэх
чадвахийг дэмжих үйл ажиллагаат усны нөөц, чанарын
мэдээллийг үндэслэн хэрэгжүүлэх замаар байгаль орчин,
экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах;

4/ үерийн аюул, гамшиг болон гол мөрөн, булаг
шандны ус татарч, улмаар хатаж шигрэх, усны эх үүсвэр
бохирдох зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх,
учирсан хөнөөлийг арилгах замаар иргэдийн эрүүл,
аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

5/ усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах
үйл ажилагаат оновчтой, тасралтгүй, үр ашигтай зохион
байгуулах эдийн засаг, эрх зүйн тааламжтай нөхцөлийг
бүрдүүлэх.

2.3 Усны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны
тэргүүлэх чиглэлд дараахь асуудал хамаарна:

1/ хүн амын ус хангамжийн хүрэлцээ, чанарыг
сайжруулах, ялангуяа говь, хээрийн бүс нутагт усны эх
үүсвэрийг тогтоох, усны барилга байгууламжийг барих,
шинэчлэх замаар хүн амын эрүүл мэндэд үзүүлэх серөг
нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат
дараалалтайгаар авч хэрэгжүүлэх;

2/ усыг зохистой ашиглах, бохир ус
цэвэрлэгээний түвшинг сайжруулахад чиглэсэн эдийн
засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжилтийг хангах

ажлыг зохион байгуулах;

3/ уст цэг, усны барилга байгууламжийн найдвартай ажиллагаат хангах зорилгоор тэдгээрийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж ашиглалтыг сайжруулах.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

3.1 Хөтөлбөрийг дараахь хугацаанд хэрэгжүүлнэ:

- Эхний үе шатыг 2000 он хүртэл;
- Хоёр дахь үе шатыг 2001-2005 онд;
- Гурав дахь үе шатыг 2006-2010 онд.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1 Усны нөөц, чанарын үнэлгээ, мэдээллийн талаар:

1/ усны нөөцийг ашиглах, хамгаалах төлөвлөгөөг боловсруулан, гидрогеологи, геоэкологийн зураглалыг эдийн засгийн бүсчүүдээр гаргаж, нутаг дэвсгэрийн бүсчлэлэн судалгааны ажлын түвшинг дээшлүүлнэ;

2/ усны найдвартай эх үүсвэрээр хангагдаагүй төв, суурин газарт усны нөөцийн хайгуул, судалгаа хийж, усны чанарыг сайжруулна;

3/ усны нөөц, чанарын өөрчлөлтөд байнгын хяналт судалгаа явуулж, усны хэмжилт хяналтын сүлжээг эргэтгэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ;

4/ усны нөөц, чанар, ус ашиглалтын тоо бүртгэлийг зохих журмын дагуу мэдээллийн төв, дэд сангуудад нэгтгэн хөтөлнө;

5/ усны нөөц, чанарын экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгоно.

4.2 Усыг зохистой ашиглах талаар:

1/ усны нөөц чанар, нөхөн сэргэгдэх чадвар зэргийг харгалзан усны нөөцөд ангилал тогтоосны үндэсн дээр хот, суурин газрын хэгжилийн хэтийн төлөвийг тодорхойлж хэрэгжүүлнэ;

2/ үндны усны нөөц хүрэлцээгүй төв, суурин газруудад ашиглахад хялбар, өртөг хямдтай барилга байгууламж барих, чанар найрлагаараа стандартын шаардлага хангадагүй эх үүсвэрт усны чанарыг сайжруулах төхөөрөмж суурилуулах, малчдыг зөөврийн төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах замаар хүн амын унд, ахуйн хэрэглээний ус хангамжийн өнөөгийн түвшинг сайжруулна;

3/ ус сувгийн барилга байгууламжийг барьж дуусгах, өргөтгөх, шинэчлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ;

4/ орчин үеийн, ашиглалтын зардал хямд, автоматжилт, механикжилт, найдвартай түвшин өндөр, эрчим хүч, шатах тослох материал бага зарцуулдаг, эдэлгээний хугацаа урттай техник, тоног төхөөрөмжө тоноглох замаар ус сувгийн үйлдвэрлэл, үйлчилгээн технологийг шинэчлэх ажлыг дэс дараатай хэрэгжүүлн

5/ ус хэрэглэгчдийг тоолууржуулах замаар ус алдагдал, үргүй зарлыг багасгах үндэсн дээр ус сувги барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүч чадл бүрэн ашиглана;

6/ усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаа үйл ажиллагаат боловсронгуй болгох зорилгоор ус менежментийн бүтцийг бий болгож хэрэгжүүлнэ;

7/ ус ашиглалт, хуваарилалтыг зохицуу зорилгоор ус ашиглалтын зөвшөөрлийн системи боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг зохи байгуулна;

8/ технологийн хэрэгцээндээ ундны ус хэрэг шаардлагагүй үйлдвэрийн ус хэрэглээг ундны хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнээс тусгаарлах а хэмжээг эзлэх дараатайгаар хэрэгжүүлнэ;

9/ хүн амын унд, ахуйн усны чанар бохирдол байдалд тавих хяналтын лабораторийн материал баазыг үе шаттайгаар бэхжүүлнэ;

10/ орон нутгийн төв, суурин газар, малчд ундны усны эх үүсвэрт чанарын шинжилгээ хи зориулалттай зөөврийн лабораториор үе шаттай хан арга хэмжээ авна;

11/ бэлчээр усжуулалтын зориулалттай төв бүрийн хийцийн худаг, уст цэг, услалтын системийн барь байгууламжийг сэргээн засварлах ажлыг зохион байгуу техник, технологийн шинэчлэл хийх, үзэмшүүлэх бо хувьчлах замаар тэдгээрийн ашиглалтын түвш сайжруулна;

12/ говийн бүсийн аймгуудын ус хангамж голлох эх үүсвэр болж байгаа энгийн уурхайн худгийн заах ажлыг мэргэжлийн байгууллагын ерөнхөөтэйг хямд төсөр аргаар зохион байгуулж малчды хангамжийн асуудлыг зохистой шийдвэрлэнэ;

13/ рашаан ашиглалтын ур ашгийг нэмэгдүү термаль ус ашиглах боломжийг судлан илрүү хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна;

14/ усны эрчим хүчний нөөцийг тогтоож, ц цахилгаан станц барьж ашиглах замаар эрчим хүч хэрэгцээг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3 Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх талаа

1/ хүн амын ундны ус хангамжийн усны эх үүс хамгаалалтын бүс тогтоож паспортжуулах, төвлөрсө хангамжийн эх үүсвэрт аюулгүй, найдвартай а ажиллагаат ханган ажиллах зохион байгуулалтын хэмжээг авч хэрэгжүүлнэ;

2/ гадаргын болон газрын доорхи ус ашиглал

рт хугацааны нөлөөллийг тооцож хамгаалалтад авах арга эмжээг зохион байгуулна;

3/ усны нөөцийг хомсдолоос хамгаалж, ус хураах албайн оё, үргамлын нөмрөгийг хамгаалах, гол горхи, улаг шандын эхийг тохижуулах, мод, бут сөөг тарих, ргамалжуулах замаар байгалийн усны нөхөн сэргээх адавхийг сайжруулна;

4/ ус ашиглаасны болон хаягдал усны төлбөрийн рлогыг усны нөөцийг хамгаалах, хомсдох, бохирдохоос рьчилан сэргийлэх, ус суврийн барилга байгууламжийг эргэн засварлах арга хэмжээнд зарцуулах механизмыг рдүүлнэ;

5/ ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн аягдал бохир усыг цэвэршүүлэх барилга байгууламжийг пинээр барих, өргөтгөх, засварлах, дэвшилтэт ехнологийг нэвтрүүлэх, ээсмшлийн асуудлыг одорхойлох замаар тэдгээрийн ашиглалтыг сайжруулж, охир ус цэвэршүүлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ;

6/ төв, суурин газар, жижиг хэрэглэгчдээс гарах аягдал бохир усыг цэвэршүүлэх орон нутгийн нөхцөлд охирсон, цэвэрлэгээний үр дүн өндөр, хямд төсөр ехнологи нэвтрүүлнэ;

7/ үйлдвэрийн бохир усны болон цэвэрлэх айгуламжийн цэвэрлэгээний үр дүнд хяналт тавих ехнологийн буюу үйлдвэрлэлийн хяналтын аборатойн системийн өнөөгийн түвшинг оловсронгуй болгож шинжилгээний түвшинг эошлүүлнэ;

8/ бороо, цас, үерийн ус зэрэг түр урсацыг уримтлуулж тогтоох замаар байгалийн усны нөхөн эргэх чадавхийг нэмэгдүүлж орчны бичил уур амьсгалийг эргэх, томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийх, ны нөөцийн зарим хэсгийг ус хомсдолтой газар нутагт илжүүлэн урсгах, говь, хээрийн бүс нутгийн зарим йлдвэрлэлийн районы усаар хангах асуудлыг судалж, вах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.4 Усны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, оулгуй байдлыг хангах талаар:

1/ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг аардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг асралтгүй зохион байгуулна.

2/ үерийн усны гэнэтийн аюул, гамшигт өртөж олзошгүй газар нутгийн зураглал, схемийг боловсруулах, амшигийг урьдчилан судалж, байнгын хяналтад авах, амгаалалтын барилга байгууламжийг засварлан сэргээх, инээр барих арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ;

3/ ус ашиглалтын явцаддалан нурах, сэтрэх, усны эөц химийн хортой бодисоор бохирдох зэрэг болзошгүй, нэтийн аюул ослоос урьдчилан сэргийлэх, холбогдох арга эмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.5 Эдийн засаг, эрх зүйн талаар:

1/ салбарын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ус ашиглалтын болон хаягдал усны төлбөрийн орлогод тулгуурлан бүрдүүлэх бүтэн зохион байгуулалт, эрх зүйн нөхцөлийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлнэ;

2/ усны өөрийн өртгийг багасгах, нэгж усны үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэргээр ус ашиглалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ;

3/ ус ашиглалтын барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, ус ашиглалтад өөрийн өртгөө нөхөх, зохих хүримтлалыг бий болгохүйц эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ;

4/ хаягдал бохир ус цэвэршүүлэлтийн түвшинг дээшлүүлэх, усны барилга байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагаат хангах, ус, хөрс хаягдал усаар бохирдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хаягдал усны төлбөрийн тухай хуулийн төслийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангана;

5/ хаягдал ус цэвэршүүлэлтийн барилга байгуулламж, техник8 технологийн шийдлийг оловсронгуй болгох, хаягдал усыг бүрэн цэвэршүүлэх, бохир усаар ус, хөрс, орчин бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх эдийн засаг, эрх зүйн хөшүүрэг механизмыг боловсронгуй болгоно;

6/ экологийн цэвэр үйлдвэрлэл эрхлэх, усыг давтан ашиглах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагаат дэмжин урамшуулах эдийн засгийн хөшүүрэг, механизмыг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулна;

7/ хуулийг хэрэгжүүлэх хяналт, зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ;

8/ усны чанар, хүн амын ундны усны эх үүсвэр, ус ашиглалт, үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэлтийн норм, стандартуудыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах, хяналтыг тогтмолжуулах ажлыг зохион байгуулна;

9/усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах талаар төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдгээрийн оролцоог сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.

4.6 Шинжлэх ухаан, техник технологийг боловсронгуй болгох талаар:

1/ байгалийн усны нөөц, чанар, тэдгээрийн өөрчлөлт, экологийн зүй тогтол, оюнлог, байгалийн аясаар нөхөн сэргэгдэх нөхцөл зэргийг цаг уур, газар нутгийн тогтолцоотой холбон судлах судалгааны ажлыг боловсронгуй болгоно;

2/ усны эх үүсвэрийн нөөц, чанарт байгалийн болон хүний үйл ажиллагааны аливаа нөлөөллөөс үүсэх

өөрчлөлтийг судлах, тэдгээрийг урьдчилан тогтоохтой холбогдсон судалгааны ажлын чанарыг сайжруулна;

3/ усыг ариг гамтай, хэмнэлттэй зарцуулах, усыг давтан ашиглах техник, технологийг туршин нэвтрүүлэх, үргүй зардлыг багасгах, ус ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон шинжлэх ухааны үндэслэл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг нэмэгдүүлнэ;

4/ усны чанарын өөрчлөлтийг газар нутгийн байршлаар тогтоож тэдгээрийг үндэсний усны чанарын стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлэх техник, технологийг судлах судалгааны ажлыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

5/ усны чанарын түвшинг хүн амын эрүүл мэндийн байдалтай уялдуулан судлах судалгаа, шинжилгээ, хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно;

6/ хаягдал ус цэвэршүүлэх явцад гарах лагийг боловсруулах процесст шинжлэх ухаан, техникийн дэвшил нэвтрүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулна;

7/ ус сувгийн барилга байгууламжийн төлөвлөлтийн үндэсний норм, дүрмийг боловсронгуй болгоно;

8/ амралт, аялал жуулчлал, хүүхдийн зуслангийн барилга байгууламжаас гарах бохир усыг орон нутгийн нөхцөл, боломжоос шалтгаалсан үрдүн өндөр, хямдтөсөр технологи нэвтрүүлэх судалгаа, зураг төслийн ажлын түвшинг дэмжиллүүнэ;

9/ газрын хөрс намагжих, давсжих, газрын доорхи усны түвшин дээшлэх, халиа тошин үүсэх зэрэг сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаарх судалгааны ажлыг боловсронгуй болгоно.

10/ усны биологийн судалгааны ажлын өнөөгийн түвшинг өргөжүүлж, усны бичил амьтан, ургамлын судалгааг усны чанарын өөрчлөлттэй уялдуулан судлах ажлыг эрчимжүүлнэ.

4.7 Мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх талаар:

1/ усны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг үндэсний их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудын сургалтын агуулгад усны салбарын тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардагдаж буй эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлын чиг хандлагын асуудлыг тусгах ажлыг зохион байгуулна;

2/ усны салбарт ажиллаж байгаа болон бэлтгэгдэн мэргэжлийн боловсон хүчнийг усны аж ахуйн олон талт үйл ажиллагаа, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн болон бусад урт, богино хугацаны дотоод, гадаадын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна;

3/ үндэсний их дээд сургууль, сургалтын төвийн сургалтын хөтөлбөр, бүтцийг боловсронгуй болгох, материаллаг баазыг нь бэхжүүлэх, тэдгээрийг түшиглүүлэн ус ашиглалтын болон хяналтын шинжилгээний лабораторийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургалт арга хэмжээг зөвлөх дараатайгаар зохион байгуулна.

4.8 Улс хоорондын хамтын ажиллагааны талаар:

1/ хил орчмын усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах асуудлаар хэрэлцэх орчуулгын сангийн Засгийн газар хоорондын гэрээг хэрэгжүүлэх, хил дамжин орших гол горхи, нуурын усны нөөцийн болон чанарын мэдээлэл солилцох зэрэг хамтарсан судалгаа, шинжилгээний ажлыг идэвхжүүлнэ;

2/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, дэмжигч орнуудтай идэвхтэй хамтрах ажиллана;

3/ усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад зориулагдсан гадаад орны зээл, тусламж, хандивыг хөрөнгийг зохистой хуваарилж, зарцуулалтын үр өгөөжийг дээшлүүлнэ;

4/ дэлхийн болон бүс нутаг, хөгжилтэй орнуудын усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах талаар баримталж байгаа бодлого, чиглэл, хэрэгжүүлж буй тэргүүн туршлага, дэвшилтэт технологитой танилцах, эдийн асуудлаар зохиогдох олон улсын хурал, зөвлөгөөнд уулзалт, үзэсгэлэнд идэвхтэй оролцоно.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, сапхүүжилт

5.1 Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

1/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдах зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Засгийн газраас байгуулсан Үндэсний Хороо гүйцэтгэн Үндэсний Хороог Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга тэргүүлнэ. Үндэсний хороонд байгаль орчин, дэд бүтэц, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, эрүүл мэндийнийн хамгаалал, төрийн сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга нар орно. Үндэсний хороо нь нарийн бичгийн даргатай байна.

2/ Үндэсний хороо нь орон нутагт салбарт байна.

3/ Үндэсний хороо дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

- хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;
- хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн үнэлгээ өгөх, хөтөлберт өөрчлөлт оруулах саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад оролцох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- орон нутгийн салбарыг арга зүй, удирдамжаар хангах;
- хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг Засгийн газарт жил бүр тайлагнах.

4/Орон нутгийн салбарыг аймаг, нийслэлийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнээ томилж, Үндэсний хороонд танилцуулна. Орон нутгийн салбарын хөтөлбөрт тусгагдсан бодлого, арга хэмжээг нутаг дэвсгэргээ хэрэжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэжилтэд хяналт тавьж үр дүнг Үндэсний хороонд тайлагнах үүрэг хүлээнэ.

5.2 Хөтөлбөрийн санхүүжилт

1/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

2/ усны секторын үйл ажиллагааг сайжруулах, дэмжих, шаардлагатай техник хэрэгслээр хангахад олон улсын байгууллага, гадаад орны зээл, туслажийн хөрөнгийг үр ашиггай зарцуулах асуудлыг Үндэсний хороо хариуцна.

3/ усны нөөц ашигласны болон хаягдал усны төлбөр, хураамжийн орлогын тодорхой хэсгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн арга хэмжээнүүдэд зарцуулна.

4/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, гусламж болон бусад хөрөнгийн эх үүсвэр, нөөц бололцоог хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглана.

5/ нутаг дэвсгэрийн гидрогеологийн бүсчилсэн судалгаа хийх, гадаргын болон газар доорхи усны мониторингийн сүлжээ байгуулах, төв, суурингийн усны нөөцийг эрж хайх, бүс нутаг, аж ахуйн зорилалтаар гадаргын усны урсацыг зохицуулах, хуримтлуулах, гомоохон хотуудын төвлөрсөн ус хангамжийн зориулалт бүхий барилга байгууламжийг барих арга хэмжээг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр гарах үр дүн

1/ Хүн амын унд, ахуйн усны хэрэгцээ хангагдаж, ялангуяа малчид, говь, хээрийн бүс нутгийн хүн амын амьдрах нөхцөл, соёлын түвшин дээшилнэ.

2/ Бэлчээр усжуулалтын үр дүнд мал аж ахуйн болон усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж сайжирна.

3/ Байгалийн усны нөөцийг зохистой ашиглаж, чанарыг хамгаалах удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа сайжирна.

4/ Усны нөөц байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцөлийг дэмжих, хомсдох, бохирдохоос хамгаалах арга ажиллагаа сайжирч, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын өнөөгийн түвшин дээшилнэ.

5/Ус сувгийн зориулалттай барилга байгууламжид шинэ техник, технологи нэвтэрч тэдгээрийн ашиглалтын түвшин нэмэгдэнэ.

6/Усны салбарын байгуулага хоорондын ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалт сайжрах, усыг зохистой ашиглах, хамгаалах нэгдсэн бодлого хэрэгжих, түүнд зарцуулах хөрөнгийг зохистой хуваарилах, ашиглах нөхцөл бүрдэнэ.

Засгийн газрын 1999 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УСНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
Гишүүд:	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны Төрийн нарийн бичгийн дарга.
Нарийн бичгийн дарга	-Засгийн газрын референт (ахлах референт)

Засгийн газрын 1999 оны 43 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

УСНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Усны тухай хуульд усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг зохицуулахтай холбогдсон зарим нэмэлт, өөрчлөлт оруулах	1999- 2000	БОЯ, ДБХЯ, ЭМНХЯ, ХААҮЯ
2	Усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгосны үндсэн дээр усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн мөрдүүлэх	1999	БОЯ,аймаг нийслэлийн ЗДТГ
3	Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувийг усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээнд зарцуулах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох	1999- 2000	БОЯ,СЯ
4	Томоохон хот суурингийн цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн хувьд бие даалгах үндсийг бүрдүүлэх үүднээс бохирдуулагч нь төлбөр төлөх зарчмыг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх	1999- 2000	СЯ, БОЯ, ДБХЯ, аймгуудын ЗДТГ
5	Усны нөөцийг хэмнэлттэй ашигласан, экологийн цэвэр технологи нэвтрүүлсэн үйлдвэрлэл үйлчилгээг тэтгэн урамшуулах эдийн засгийн механизмын оновчтой хэлбэрийг боловсруулж хэрэгжүүлэх	2000- 2001	БОЯ, ДБХЯ, ЭМНХЯ, ХААҮЯ
6	Усны анхан шатны болон улсын тоо бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж усны мэдээллийн төв санд тусгах	1999- 2001	СЯ,БОЯ,ДБХЯ, ЭМНХЯ, ХААҮЯ
7	Гол, горхи, булаг, шандын эхийг тохижуулах, мод, бут сөөг тарих, ургамалжуулах замаар усны нөөцийн байгалийн нөхөн сэргэх чадавхийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	1999- 2001	БОЯ,аймаг нийслэлийн ЗДТГ
8	Хөрш орнуудтай хилийн усыг зохистой ашиглах, хамгаалах талаархи хамтын ажиллагааг өргөтгөж, нөөц, чанарын хяналт шинжилгээ, мэдээллийн системийг хамтран бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	1999- 2001	БОЯ, холбогдох аймгуудын ЗДТГ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 оны №15 (94)

9	Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системийн барилга байгууламжийг барьж дуусгах, өртөгтөх, шинэчлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх	1999- 2002	ДБХЯ, БОЯ
10	Улаанбаатар, Улаангом, Улиастай, Мөрөн, Өдгий, Ховд зэрэг хот суурины гэр хорооллын усан хангамжийн уйлчилгээг сайжруулж, усны хүрэлцээг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	1999- 2002	ДБХЯ, Нийслэлийн ЗДТГ
11	Хөдөөгийн хүн амын усан хангамжийг сайжруулах чиглэлээр, ялангуяа усны эх үүсвэрийн асуудал хүндрэлтэй байгаа 20 гарүй сумын усан хангамжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	1999- 2000	ДБХЯ, аймгуудын ЗДТГ
12	Ус суэгийн барилга байгууламжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор бүсчилсэн ашиглалт, засвар, хангамжийн газрыг хэд хэдэн аймагт бий болгох	1999- 2001	ДБХЯ, аймгуудын ЗДТГ
13	Ус суэгийн инженерийн байгууламжийн найдвартай ажиллагааг өөрийн орны хүчээр хангах, импортын хэрэгцээ гаргах, сэлбэг материал, багаж, тоног төхөөрөмж үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрүүдийг барьж байгуулах	1999- 2001	ДБХЯ, аймгуудын ЗДТГ
14	Нүсэр хийцтэй, өртөг өндөртэй худгийг бага оврын гүний болон гар худгуудаар солих, тэдгээрийг ашиглахад тохиромжтой гар ус өргүүрээр тоноглох	1999- 2000	ДБХЯ, ХААУЯ
15	Хөдөөгийн усан хангамжийг сайжруулах зориулалттай худгийн насосны сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах цех байгуулах	1999- 2000	ДБХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ХААУЯ
16	Хүн амын унд, ахуйн цэвэр ус болон цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усыг халдваргүйжүүлэх байгууламжийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	1999- 2001	ДБХЯ, БОЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ
17	Хатуулаг ихтэй, эрдэсжилт өндөр усны эх үүсвэрт тохирсон ус цэнгэгжүүлэх, зөөгрүүлэх тоног төхөөрөмжийг гуршин нэвтрүүлэхэд гадаадын зээл, туслалцаа, хамтын ажиллагаа чиглүүлэх	1999- 2000	ГХЯ, ДБХЯ, БОЯ, ХААУЯ
18	Бага оврын, зөөврийн лабораториуд байгуулах замаар цэвэр, бохир усанд лабораторийн шинжилгээ явуулахад гарч байгаа үргүй зардлыг багасгах арга хэмжээ авах	1999- 2001	ГХЯ, ДБХЯ, ЭМНХЯ, БОЯ, СЯ

19	Газрын доорхи усны хомсолтой уламлал хэрэглэгчийг усаар найдвартай хангах зорилгоор гадаргын усны эх үүсвэрийг ашиглах боломжийг судалж нэвтрүүлэх	2000- 2001	ДБХЯ, БОЯ, ЭМНХЯ
20	Цэвэр усны тоолуурын лаборатори байгуулах, хэрэглэгчдийг тоолууржуулах ажлыг зохион байгуулах /1 лаборатори, 4 аймгийн усан хангамжийн сүлжээнд тооцуур тавих/	1999- 2001	ДБХЯ, БОЯ
21	Хөдөөгийн сум суурин, амралт сувилал, төмөр зам, багпан хамгаалахын цэвэрлэх байгууламжийн ашиглалтын байдалд үзэлт хийж, дүгнэлт гаргаж гэдэгэрийг сайжруулах талаар дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	1999- 2001	ДБХЯ,БОЯ, ЭМНХЯ
22	Улаанбаатар, Дархан хотуудын бохир усны цэвэрлэх байгууламжаас гарч буй лагийг шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд хийх	1999- 2001	ДБХЯ, БОЯ
23	Усны чанарын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	1999- 2000	ЭМНХЯ, БОЯ, ДБХЯ, УСХЗГ
24	Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас хийж гүйцэтгэх ажлын чиглэл боловсруулж хүргүүлэн, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллах	1999- 2001	ЭМНХЯ
25	Эрүүл ахуй, халдвар, няя судлалын хяналтын албаны лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	1999- 2000	ГХЯ, ЭМНХЯ
26	Усны чанар, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг талаар хүн амын дунд экологи, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулж, сургалтын зарим материал, гарын авлага боловсруулж хүргүүлэх	1999- 2001	ГЯ, ЭМНХЯ, төрийн бус байгууллагууд
27	Ундны усны эрүүл ахуйн журмыг байдал, хяналтын төсөл боловсруулж хэрэгжүүлэх	1999- 2001	ГХЯ, ЭМНХЯ
28	Ундны усны чанар, эрүүл ахуйн байдлыг судлах, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулан явуулах	1999- 2001	ГЯ ,ЭМНХЯ
29	Усны болон ариун цэврийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг жил бүтэн гурваас доошгүй аймагт шалгаж холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	1999- 2001	ЭМНХЯ,БОЯ,ДБХЯ, ХААУЯ
30	Үйлдвэрлэлийн лабораториудын үйл ажиллагаанд тавих хяналтын тушиг дээшлүүлэхтэй холбогдсон арга хэмжээг зохион байгуулах	1999- 2001	ЭМНХЯ, БОЯ, ДБХЯ,ХААУЯ
31	Уст цэвийн тоолгого явуулж, бэлчээрийг түрээсээр зээмшүүлэх, худгийг хувьчлах ажлыг зохион байгуулах	1999- 2002	ХААУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ

32	Говь, хээрийн бүсийн аймгуудын бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтгүй болсон инженерийн хийцтэй /900 орчим/ уст цэгийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж, уст цэг ашиглалтын түвшинг дээшлүүлэх 300 орчим 300 орчим	1999, 2000- 2010	ХААҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ
33	Ус хангамжийн судалгаа хийгдээгүй 15 сумын усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж нөөцийн хэмжээг тогтоох - 5 сум - 5 сум - 5 сум	1999 2000 2001	ХААҮЯ, Аймаг, нийс-лэлийн ЗДТГ
34	Усны үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх судалгаа хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	1999-2010	ХААҮЯ, ДБХЯ, ТИС
35	Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн малчдын ус хангамжийг сайжруулахад чиглэгдсэн хайгуул судалгааны ажлыг хийх	1999- 2001	ХААҮЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ
36	Усны нөөц нь ундны усны чанарын стандартын шаардлага хангадаггүй сум, суурин газруудад ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж усны чанарыг сайжруулах	1999- 2000	ХААҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ
37	Ус хангамж нь хүндрэлтэй говь, хээрийн бүс болон эдийн засгийн хөгжлийн чухал шаардлагатай бүсийг хамарсан 30-40 мян. ам км талбайд 1:200 000-ны хураангуйлалтай гидрогеологийн зураглал хийж усны нөөц баялгийн үнэлгээ өгөх	1999- 2010	ХААҮЯ
38	Томоохон хотын ус хангамжийн эх үүсвэрт алдагдсан горимын болон байгалийн горимын хяналт хэмжилтийн сүлжээг томоохон ай савуудаар байгуулж эхлэх	1999- 2010	ХААҮЯ,БОЯ
39	Алтай хотын ус хангамжийн мастер төлөвлөгөөг зохиож дуусгах,. Мандалговь хотын ус хангамжийн мастер төлөвлөгөө зохиох ажлыг эхлэх	1999- 2000	ДБХЯ, ХААҮЯ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

Спартакиад зохион байгуулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1999 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд биеийн тамир, спортын талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын бүх ард түмний X спартакиадыг 1999 онд орон даяар зохион байгуулж явуулсугай.

2. Монголын бүх ард түмний X спартакиад зохион байгуулалтын өндөр түвшинд бүх нийтийн биеийн тамир, спортын баяр болгон явуулж, шаардагдах хөрөнгийг биеийн тамир, спортын үйл ажиллагаа зорилж батлагдсан төсөвтөө багтаан гаргахыг Эрүүл мэндийн хамгаллын сайд С.Сонин, аймаг, нийслэл Засаг даргад нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД **С.СОНИН**

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 2 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар А/26,10 | Улаанбаатар хот

Зааварт батлах тухай

ТУШААХ НЬ:

Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зааварыг хавсралтын ёсоор батална.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД **С.СОНИН**

ХУУЛЬ ЗҮЙН САЙД **Л.ЦОГ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын Сайд, Хууль зүйн сайд 1999 оны А/26,10 тоот хамтарсан тушаалын хавсра

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАСАН ҮЕД ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Нэг буюу хэсэг бүлэг хүмүүс байгууллага, аж ахуйн нэгж, тэр, байр, гудамж талбайд түүнчлэн хорих анги, цагдан хорих, баривчлах байранд өлсгөлөн зарласан үед эмнэлгийн тусламж үзүүлэх, цагдаагийн байгууллагаас эмнэлгийн байгууллагын ажилтны ажуулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ зааврын зорилт оршино.

2. Хүний биеийн физиологийн хэрэгцээг нөхөхгүй хүнсний бүтээгдэхүүн, хоол тэжээлийг удаан хугацаагаар хэрэглэх өвчин эмгэгийн улмаас хоолны шингэц муудах болон хоол тэжээлийг зориудаар хязгаарлах үед үүсэх байдлыг өлсгөлөн гэнэ. Өлсгөлөнг дотор нь бүрэн өлсгөлөн /хар өлсгөлөн/, хагас өлсгөлөн гэж хоёр хуваана.

Бүрэн өлсгөлөнгийн үед ус болон хоол тэжээлийг хэрэглэдэггүй тул хүнийг 3-6 хоногт үхэлд хүргэх аюултай. Хагас өлсгөлөнгийн үед хүн хэрэгцээнийхээ 50 хүртэл хувийг хангахуйц хоол тэжээлийг авдаг учир удаан хугацаа өлсөж шаналсаар биеийн жингийн 40 хүртэл хувь алдсанаар нас барах аюулд хүргэнэ.

Тогтсон нь дараагийн ду

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.
Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн ордон Индекс: 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эр
газрын харъяа Хэвлэх үйлдвэр
хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны дөрөвдүгээр сарын 13 №16 (95)

ГАРЧИГ

нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

139. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай Дугаар 11 213

хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

140. Д.Намсрайжавыг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 57 213

гурав. Яам, агентлагийн акт

141. Өлсгөлөн зарласан үед эмэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайдын 1999 оны А/26,10 тоот хамтарсан тушаалын хавсралт) Дугаар А/26,10 214

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 11 **Улаанбаатар хот**

Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай

Гаалийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад дор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмсүгэй:

" 2. Бүх төрлийн спирт | оруулах "

2.Энэ тогтоолыг 1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 57 **Улаанбаатар хот**

Д.Намсрайжавыг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал, өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Дэмчигжавын Намсрайжавыг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайдын
1999 оны А/26,10 тоот хамтарсан тушаалын хавсралт

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАСАН ҮЕД ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

Төгсгөл. Түрүүч нь 15 дугаарт

3. Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт:

1) сүрьеэ болон халдварт өвчин;

2) элэгний өвчин (элэгний идэвхт архаг үрэвсэл, элэгний хатуурал, элэгний дутмагшил);

3) хорт хавдар;

4)зүрх судасны өвчин (зүрхний ба архаг дутмагшил, цусны даралт ихдэх, багадах өвчин, зүрхний гажгууд, хэрх өвчин);

5) дотоод шүүрлийн булчирхайн өвчин (хордлогот бахлуур, тулай, чихрийн шижин, бөөрний дээд булчирхайн цочмог, архаг дутмагшилт өвчүүд, тураал);

6) цусны өвчин;

7) мэс заслаар эмчлэгдэх өвчин;

8) бөөрний өвчин (бөөрний дутмагшил);

9) сэтгэцийн өвчин, хямрал.

Эдгээр өвчөөс гадна хүүхэд, өндөр настан, жирэмсэн, хөхүүл эхчүүдийн бие, махбодийн эмзэг онцлогоос хамаарч тэднийг өлсгөлөнд оролцохыг хориглоно.

ХОЁР. Өлсгөлөнгийн үед эмнэлгийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

1. Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж шаардлагатай үед эмнэзгийн тусламжийг үзүүлнэ.

2. Өлсгөлөн зарласан тохиолдолд тухайн дэвсгэр нутгийн Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндэд үзлэг хийж хяналт тавих нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарын бүрийг бүрдүүлэн батална хуваарийн дагуу үзлэг хийх, дэвсгэр нуттийнхаа захиргаа, цагдаагийн байгу,,лагатай хамтран ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна.

3. Өлсгөлөнд оролцохоор шийдсэн хүнд үзлэгийн карт нээж биейн халуун, жин, өндрийг үзэж тэмдэглээд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт орулан шаардлагатай лабораторийн шинжилгээг /цусан дахь уургийн хэмжээг заавал тодорхойлно/ хийж өлсгөлөн зарлахад харшлах өвчин байгаа эсэхийг тогтоон хяналтад авна.

4. Өлсгөлөн зарлагчид өлсгөлөнгөөс үүдэн бие махбодид учрах хор уршиг өлсгөлөнгийн үед баримтлах эрүүл ахуйн дэглэм зэргийг таниулахын зэрэгцээ урьдчилсан бэлтгэлийг хангана.(6 цагийн зайтай 2 удаа бургуй тавина).

5. Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн үзлэгийг батална хуваарийн дагуу өдөр бүр (жингийн алдагдлыг үзэх) цагт, лабораторийн шинжилгээг (цусан дахь уургийн хэмжээг тодорхойлох) 7 хоногт 1 удаа хийж картанд тэмдэглэн хянана.

6. Өлсгөлөн зарлагчид өвчин эмгэг илэрч хүндрэх тохиолдолд өлсгөлөнг зохион байгуулагч болон ар гэрийнхэнд нь яаралтай мэдэгдэж шаардлагатай гэж үзвэл захиргаа болон цагдаагийн байгууллагын хамтын шийдвэрээр уг хүнийг албадан эмчилгээнд оруулна.

7. Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэнд доройтон, эмчилгээнд зайлшгүй орох шаардлагатай болсон тохиолдолд өлсгөлөн зарласан нутаг дэвсгэрт байрлаж буй эмнэлгийн байгууллагад эмчилнэ.

8. Гэнэтийн, амь насанд аюултай байдлаас бусад тохиолдолд өлсгөлөн зарласан газар дээр нь эмчилгээ хийхийг эрүүл ахуйн шаардлагын хэлгахгүй гуд хоригдоно.

9. Өлсгөлөн зарлагчид эмчилгээ, шинжилгээ хийсэнтэй холбогдон гарсан зардлыг өвчний түүх, картад тэмдэглэн зохих хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГУРАВ. Өлсгөлөнгийн үед цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

1. Өлсгөлөн зарлах үйл ажилагаатай холбогдон өлсгөлөн зарлагчид болон орчны хүмүүсгэй холбогдон гарч болзошгүй хэв журмын зөрчлийг харъяа сум, дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу цагдаагийн байгууллага зохицуулна.

2. Өлсгөлөн зарласан хүмүүст энэхүү зааврын дагуу эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд цагдаагийн байгууллага нь эмч, эмнэлгийн ажилчдын ажилгаа аюулгүй байдлыг хангах үүргийг цагдаагийн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд хэрэгжүүлнэ.

3. Эмнэлгийн байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн албадан эмчилгээ хийлгүүлж байгаа өлсгөлөн зарлагчийг цагдаагийн байгууллага тодорхой хугацаанд хянан харгалзаж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.
Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн ордон Индекс: 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны дөрөвдүгээр сарын 14* *№17 (96)*

Гарчиг

нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

142. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай — Дугаар 12 — 215
143. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай — Дугаар 13 — 215
144. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай — Дугаар 14 — 216

хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

145. Зарим тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай — Дугаар 48 — 216
146. Журамд өөрчлөлт оруулах тухай — Дугаар 52 — 216

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр — Дугаар 12 — Улаанбаатар хот

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхийг хүсэх тухай ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газрын А/1204 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Баттулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

2.Сэжигтнээр цагдан хорих арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй болж мөрдөн байцаагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох тухай тогтоол хүчин төгөлдөр болмогц Д.Баттулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх сэргээгдсэнд тооцсугай.

(Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хориг тавьсан тул тогтоолын энэ заалт уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болно.)

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр — Дугаар 13 — Улаанбаатар хот

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхийг хүсэх тухай ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газрын А/1204 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн С.Батчулууны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

2.Сэжигтнээр цагдан хорих арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй болж мөрдөн байцаагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох тухай тогтоол хүчин төгөлдөр болмогц С.Батчулууны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх сэргээгдсэнд тооцсугай.

(Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хориг тавьсан тул тогтоолын энэ заалт уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхгүй болно.)

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр | **Дугаар 14** | **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхийг хүсэх тухай ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газрын А/1204 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбаатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

2.Сэжигтнээр цагдан хорих арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй болж мөрдөн байцаагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох тухай тогтоол хүчин төгөлдөр болмогц Д.Энхбаатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх сэргээгдэнэ тооцсугай.

(Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хориг тавьсан тул тогтоолын энэ заалт үг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцүүж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх гүй болно.)

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 24-ний өдөр | **Дугаар 48** | **Улаанбаатар хот**

Зарим тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Ажлын цагийн эхлэлтийг зохицуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1983 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 51 дүгээр тогтоол, "Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**
ХУУЛЬ ЗҮЙН САЙД **Л.ЦОГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 31-ний өдөр | **Дугаар 52** | **Улаанбаатар хот**

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оролуулан хаах иргэний тоо буртгэл хетлех, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 2 дугаар зүйлийг "2.Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оролуулан хааж болно" гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ш.ТҮВДЭНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.
Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн ордон Индекс: 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны дөрөвдүгээр сарын 20* *№18(97)*

ГАРЧИГ

нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

147. Элчин сайдыг томилох тухай Дугаар 58 217
148. Элчин сайдыг томилох тухай Дугаар 59 217

хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

149. Хөтөлбөр батлах тухай Дугаар 50 217
150. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 51 221
151. Цөм сүргийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 53 231
152. Үр тарианы үрийн тухай Дугаар 54 231
153. Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 55 234

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр — Дугаар 58 — Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсаас Катар Улсад суух Онц Сайрааныг тохоон томилсугай.

бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Кадырын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр — Дугаар 59 — Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсаас Бахрейн Улсад суух Онц Сайрааныг тохоон томилсугай.

бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Кадырын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 24-ний өдөр — Дугаар 50 — Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2.Хөтөлберийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, явц, үр дүнгийн талаар жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчны сайд С.Мэндсайханд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **С.МЭНДСАЙХАН**

Засгийн газрын 1999 оны 50 дугаар тогтоолын хавсралт

"ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ ТУХАЙ " ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хот суурин газарт суулийн жилүүдэд хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл ихэссэнй улмаас орчны агаар, ус, хөрс их хэмжээгээр бохирдож байгаагийн дотор амьдралын нөхцөлийг доройтуулж, орчныг бохирдуулж буй гол хүчин зүйл нь хог хаягдал болоод байна. Өнөөгийн байдлаар дэлхий нийтэд 10 сая гаруй нэр төрлийн химийн бодис бүртгэгдсэний 70 мянга орчим нь өдөр тутам ашиглагдаж байна. Олон улсын зах зээлд жил тутам 1000 нэр төрлийн химийн бодис шинээр гарч байгаагаас үүдэн жилд 300-400 сая тонн аюултай хаягдал гарч байна. Иймээс аюултай хаягдлын хэмжээг багасгах, түүний хор нөлөөнөөс хүн ам, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг дэлхий нийтээр хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж 1989 онд "Аюултай[1] хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн Конвенц"-ийг баталсан бөгөөд энэ Конвенцид манай улс 1997 онд нэгдэн орсон юм. Иймд Конвенциор хүлээсэн үүрэгийнхээ дагуу хог хаягдлыг зайлуулах[2] асуудалд хяналт тавих шаардлага гарч байна.

Манай улсын хэмжээнд бүрэн бус тооцоогоор 3145,4 га талбай бүхий 447 цэгт хог хаягдлыг ил задгай хаяж 11115,4 га газар хог хаягдлаар, 4093,6 га газар химийн бодис, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож, цэвэрлэгээгүй 78000 шоо метр, дутуу цэвэрлэсэн 357 000 шоо метр бохир усыг байгаль орчинд шууд хаяж байна.

Улаанбаатар хот орчимд жилд дунджаар 500 мян.м^3 хог хаягдал гарч, Дарь-Эхийн Овоо, Улаанчулуут, Мориндаваагийн цэгт зөвөрлөн хаяж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд гаргаж буй хог хаягдлын бүтцийг авч үзэхэд ердийн галлагаатай орон сууц, гэрийн хороололд оршин суугчдын хог хаягдлын 55 хувь нь үнс, тохилог орон сууцанд суугчдын хог хаягдлын 37 хувь нь цаас, 20 хувь нь бөс даавуу, албан газар, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хог хаягдлын 40-50 хувийг цаас, бөс даавуу эзэлж байгаа нь хог хаягдлыг боловсруулж эргүүлэн буюу хоёрдогч түүхий эд хэлбэрээр ашиглан хог хаягдлыг ихээхэн багасгах боломжтойг харуулж байна.

Ахуйн гаралтай хог хаягдлын 60 хувь нь цаас, 25-30 хувь нь төрөл бүрийн нийлэг материал, бусад нь төмөр, шил, шаазан, хүнсний зүйлийн хаягдал байгаа бөгөөд бүтэц нь улирлын байдлаас болж өөрчлөгдөн хүйтний улиралд хог хаягдлын ихэнх хувийг үнс эзэлдэг болно.

Хог хаягдлыг эргүүлэн ашиглах, боловсруулах, хаягдал багатай техник, технологи нэвтрүүлэх замаар хог хаягдлын гаралтыг багасгаж, байгаль орчныг бохирдолтоос сэргийлэх, элдэв хортой нөлөөллөөс хүн амыг эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хог хаягдлыг бууруулах зорилтыг бодлогын хэмжээнд авч үзэж шийдвэрлэх шаардлагатай болловоо.

Хог хаягдлыг бууруулах хөтөлбөр нь (цаашид "хөтөлбөр" гэнэ) Монгол Улсын нэгдэн орсон "Аюултай хог хаягдлыг хил дамжуулан зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенц"-ийн зарчим, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн шаардлагыг үндэс болгон хог хаягдлыг бууруулах талаар ойрын хугацаанд хэрэгжүүлэх үндэсний бодлого, шийдвэрлэх зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга замыг тодорхойлсон цогцолбор баримт бичиг мөн.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хог хаягдлыг хүрээлэн буй орчинд халгүйгээр зайлуулах, ялган боловсруулах замаар түүний хэмжээг бууруулах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлэхэд оршино.

2. Хөтөлбөрийн үндсэн зорилт

Хөтөлбөрийн зорилтын хүрээнд дараахь асуудал хамаарна:

1 - тэсэрч дэлбэрэх, галын аюултай, хортой, халдвартай хог хаягдал

2 - хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, эргүүлэн ашиглах, боловсруулах, устгах үйл ажиллагаа хамруулан ойлгоно

1/ хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ялган ангилах, боловсруулах, дахин ашиглах, устгах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

2/ хаягдлын эх үүсвэр, хэмжээ, бүтэц, шинж чанарын байдлыг тогтоож, хог хаягдлын цэгийн байршлыг оновчтойгоор байршуулах;

3/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутгийн захиргааны байгууллага, иргэн, бүхий л хэвшлийн аж ахуйн нэгжийг өргөнөөр татан оролцуулж, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга механизмыг тогтоож хэвшүүлэх;

4/ хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, техник технологийн шинэчлэлт хийх;

5/ байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй хогийн цэгүүдийг дарж устган байгалийн нөхөн сэргээлт хийх замаар тэдгээрийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ялзмагжуулан цэвэршүүлэх байгууламж болгон өөрчлөх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

6/аюултай хог хаягдлыг тусгайлан цуглуулж цэвэршүүлэх, хоргүйжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

7/ хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах замаар түүний хэмжээг багасгах арга хэмжээ авах.

3. Хэрэгжүүлэх хугацаа, үе шат

Хөтөлбөрийг дараахь хугацаанд хэрэгжүүлнэ:

-1999-2000 онд хог хаягдлын хэмжээ, бүтэц, шинж чанарыг тодорхойлон, түүнийг зайлуулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, хог хаягдлыг бууруулах арга хэмжээний эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

-2001-2003 онд хог хаягдлыг орчинд халгүйгээр цуглуулах, тээвэрлэх, хадгалахад чиглэгдсэн техник, зохион байгуулалтын шинэчлэл хийх, хог хаягдлын цэгийг ариун цэврийн шаардлагын дагуу тохижуулах;

-2003-2005 онд хог хаягдлын хэмжээг бууруулах арга хэмжээ авах, хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

-2005-2010 онд хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зайлуулах арга хэмжээг бүрэн хэвшүүлэх;

Гурав. Хөтөлбөрийн үндсэн зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг удирдлага болгоно:

1/ байгаль орчны стратегийн бодлогын баримт бичгүүд болон олон улсын байгууллагаас хог хаягдлыг зохицуулах талаар гаргасан баримт бичгийн үндсэн зорилттой нийцүүлэх;

2/ төр, засгийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааны хэлбэрийг нарийвчлан тогтоох;

3/ хүн амын аж төрөх ёсны соёл, аж ахуйч үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, тэдгээрийн хэрэглээ, сонирхолд тулгуурлан хог хаягдлыг зайлуулах "бохирдуулагч төлнө" гэсэн зарчмаар ажиллах;

4/ хог хаягдлын хэмжээг багасгах, байгаль орчинд халгүйгээр зайлуулах үйл ажиллагаанд төр, олон нийтийн хяналтыг өндөржүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг

4.1. Төрийн захиргааны байгууллагын үүрэг:

1/ хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

2/ хог хаягдлын хэмжээ, бүтэц, шинж чанар, зайлуулалтын байдалд судалгаа хийж, дүгнэлт гаргаж байх;

3/ хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, эргүүлэн ашиглах, боловсруулах, устгах арга ажиллагаанд хэрэглэгдэх стандарт, норм норматывыг боловсруулж мөрдүүлэх;

4/ хог хаягдлын асуудлаар олон улсын хэмжээнд мөрдөж буй баримт бичиг, зөвлөмж, аргачлал, арга туршлагыг судлан нэвтрүүлэх, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, холбогдох гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох үйл ажиллагааг өргөжүүлэх;

5/ аюултай хог хаягдлыг зайлуулах болон түүний экспорт, импорт, тээвэрлэлтийн Базелийн Конвенцийн дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4.2.Нутгийн захиргааны байгууллагын үүрэг:

1/ хог хаягдлыг зайлуулах зөвшөөрлийн системийг бүрдүүлэх;

2/хог хаягдлыг байгаль орчинд

халгүйгээр зайлуулах техник, технологи нэвтрүүлэх, шаардлагатай машин механизмаар хангах;

3/үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхөөс гарах хог хаягдлыг зайлуулалтын байдалд тавих хяналтын үр дүнг сайжруулах;

4/ хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох, хог хаягдлаас хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлон түүнээс хамгаалах арга хэмжээ авах.

4.3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон төрийн бус байгууллагын үүрэг:

1/ аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагааны улмаас агаар, ус, хөрсөнд гаргах хаягдлын зөвшөөрөл авч холбогдох хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх;

2/ хог хаягдлыг боловсруулах, зохистойгоор зайлуулах асуудалд төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг өргөнөөр оролцуулах, идэвхи санаачилгыг өрнүүлэх;

3/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хог хаягдлыг багасгах, зайлуулах асуудлаар сургалт, сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах;

4/ хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулдаг, хаягдалгүй буюу хаягдал багатай үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

Монгол орны цаг уур, газар зүйн байрлал, аж төрөх ёсны өвөрмөц онцлог, олон улсын хэмжээнд баримталж буй нийтлэг жишиг, хөгжлийн хандлагад нийцүүлэн хог хаягдлыг зохицуулах удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр нутгийн захиргаанаас дараахь арга хэмжээ авна:

1/хог хаягдлыг зохицуулах орон нутгийн удирдлагын зохион байгуулалтыг оновчтойгоор шинэчлэн, чадавхийг нь хөгжүүлэх;

2/ орон нутгийн засаг захиргааны нэгж бүр хог хаягдлыг зохицуулах үйл ажиллагааны богино болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3/ хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг өргөнөөр оролцуулах механизмыг бүрдүүлэх, тэдгээрийн дэмжих олон талт үйл ажиллагааг өрнүүлэх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын удирдлага-хяналт болон хяналт-шинжилгээний иж бүрэн системийг шинээр зохион байгуулах;

4/ хог хаягдлыг зохицуулах, зайлуулах асуудлыг хариуцсан орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд дараахь эх үүсвэрийг ашиглана:

1/ улс, орон нутгийн төсвөөс болон аж ахуйн нэгж, байгууллагаас хог хаягдлыг зайлуулах арга хэмжээнд зориулан жил бүр зарцуулах хөрөнгө;

2/ гадаадын улс орон, олон улсын байгууллагын зээл, туслалцаа, хандивын хөрөнгө;

3/ аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдийн хандивын хөрөнгө;

4/ байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогын зохих хувь;

5/ аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг зайлуулах, эзэмшил газрынхаа байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг нь зүй зохистой ашиглах болон эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэн хэвшүүлэхэд зарцуулах хөрөнгө.

Долоо.Хамтын ажиллагаа

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, технологи, тоног төхөөрөмж, арга зүй, аргачлал, мэргэшсэн боловсон хүчний асуудлаар өндөр хөгжил, туршлага бүхий орнуудын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний туслламж дэмжлэгийг оновчтой, үр дүнтэй ашиглана.

Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд бүх талаар бэхжүүлэн уялдаа холбоог сайжруулна.

Найм. Гарах үр дүн

Хог хаягдлыг зайлуулах асуудлыг удирдлага, зохион байгуулалтын болон техник, технологийн түвшинд зохистой шийдвэрлэж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 3 дугаар сарын 24-ний одор | Дугаар 51 | Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг (эхний үе шатанд 1999-2005 онд) хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор батална.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан явцынх нь талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчны сайд С.Мэндсайханд, хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын тусламжийн зохих хэсгийг ашиглахаар Байгаль орчны яамтай хамтран зохицуулж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ
С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 51 дүгээр тогтоолын хавсралт

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ (ЭХНИЙ ҮЕ ШАТ 1999-2005 он) ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ Т Ө Л Ө В Л Ө Г Ө Ө

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр , түүний хэрэгжилтийн явц, үр дүнг олон нийтэд сурталчлах	1999 оноос	Байгаль орчны яам , хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран
	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх талаар		
2.	Холбогдох яам, нутгийн захиргааны байгууллагатай тохиролцсоны үндэсн дээр дараахь газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах санал, үндэслэлийг боловсруулж зохих дээд байгууллагад оруулах:		Байгаль орчны яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, бусад холбогдох яам, аймгийн иргэдийн Хурал, Засаг дарга
	1/ Сийлхэм , Тарвагатай, Хан Хөхийн нурууны зарим салбар уулс, Цамбагарав уул, Хяргас нуур орчмын нутаг ;	1999 он	

	2/ Онон-Балж голын сав, Бүрэн, Хантай, Зэд, Бүтээл, Улаан тайгын нурууны зарим салбар уулс, Шишгэд-Тэнгис голын бэлчир;	2000 он	
	3/ Монгол элс, Хүнгүйн хар нуур, Улаагчны хар нуур, Их хайрхан уул, Эрээн нуур, Гурван богд уул;	2001 он	
	4/ Их газрын чулуу, Бага газрын чулуу, Лаг нуур, Лагийн хоолой;	2002 он	
	5/ Бадарын чулуу, Их Түнэл , Ногоон цав, Баянтехэмийн говь, Ногоон нуур, Бүст нуур.	2003-2005 он	
3.	Экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий зарим тусгай хамгаалалттай газар нутгийг Дэлхийн шим мандлын нөөц газар, Байгаль, соёлын өв, Ус, намгархаг газрын сүлжээнд хамруулах саналыг холбогдох олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх:	1999-2003 он	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам, Гэгээрлийн яам, Хүн ба шим мандал, Байгаль, соёлын өвийн үндэсний хороо
	Дэлхийн шим мандлын нөөц газарт		
	Хан Хэнтий, Дорнод Монголын ДЦГ, Хөвсгөл, Алтай таван богдын БЦГ , Хан Хөхий, Сийлхэмийн нурууны зарим салбар уулс	1999-2001 он	
	Дэлхийн байгаль, соёлын өвд		
	Увс нуурын ай савын ДЦГ, Хөвсгөл нуурын БЦГ , Хэрмэн цав, Бүгийн цав / Говь гурван сайханы БЦГ/ , Оттонтэнгэр, Бурхан Халдун уул, Говийн их ДЦГ-ын "А" хэсэг	1999-2003 он	
	Ус, намгархаг газрын жагсаалтад		

	Хар ус нуур, Хар нуур, Дөргөн, Хяргас, Айраг нуур	1999-2000 он	
4.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн шийдвэрээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах шалгуурыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, тэдгээрээс орон нутгийн ТХГН-ийн сүлжээнд тодорхой үе шаттайгаар хамруулах	1999 оноос	Байгаль орчны яам, аймаг, нийслэл, сумын Засаг дарга
5.	ОХУ-тай хамтран Увс нуурын ай сав, Сийлхэм-Мөнгөн тайга, Хөвсгөл-Саяны хил дамнасан дархан газар байгуулах, БНХАУ, ОХУ-тай хамтарсан Монгол дагуурын ДЦГ-ын хамгаалалтыг бэхжүүлэх арга хэмжээ авах	1999-2001 он	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам
6.	Газар нутгийг улс, орон нутгийн хамгаалалтад авах асуудлыг монгол улсын газар ашиглалтын хэтийн төлөвлөлттэй нягт уялдуулах арга хэмжээ авах	1999 оноос	Байгаль орчны яам, Газар зохион байгуулалтын алба
	Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд		
7.	ТХГН-т геологийн тойм болон палеонтологийн судалгаа явуулах боломжийг өргөжүүлэх чиглэлээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах	1999 он	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Байгаль орчны яам
8.	ТХГН-т аялал жүүлчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх	1999 оноос	Байгаль орчны яам, Дэд бутцийн хөгжлийн яам
9.	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, Дэлхийн өвийн болон Рамсарын конвенцид ТХГН-ийн чиглэлээр заасан заалт, Монголын талын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт-шинжилгээ хийх	1999 оноос	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам
10.	"Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай " олон улсын конвенцид нэгдэн орох	1999 он	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам
	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх талаар		

11.	ТХГН-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах	1999 оноос	Байгаль орчны яам
12.	ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг дараахь тусгай хамгаалалттай газар нутгаар боловсруулах:	1999-2002 он	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба
	-Хан Хэнтий, Монгол Дагуур, Дорнод монгол, Немрөгийн ДЦГ, Говь -гурван сайхан, Горхи-Тэрэлжийн БЦГ, Тосон-Хулстай, Хар ямаат, Яхь нуурын БНГ, Ганга нуурын БДГ, Хустайн БЦГ;	1999 он	
	-Богд хан уулын ДЦГ, Говийн их ДЦГ, Увс нуурын ай савын ДЦГ, Алтай таван богдын БЦГ, Хар ус нуурын БЦГ;	2000-2001 он	
	-Говийн бага ДЦГ, Оттонтэнгэрийн ДЦГ, Хангайн нуруу, Хорго-Тэрхийн цагаан нуур, Ноён хангайн БЦГ;	2001-2002 он	
13.	ТХГН-ийн хамгаалалтын менежментийг олон улсын жишигт хүргэх, орчны бүс нутгийг хөгжүүлэх " Байгаль хамгаалал ба орчны бүсийн хөгжил " болон " Дорнод монголын биологийн төрөл зүйл " төслүүдийг Хан Хэнтийн ДЦГ, Горхи-Тэрэлж, Говь гурван сайханы БЦГ, Дорнод бүсийн ТХГ-дад хэрэгжүүлэх.	1999-2004 он	Байгаль орчны яам
14.	"Хан Хэнтийн ДЦГ-т нутаг дэвсгэр нь хамрагдах Батширээт суманд "Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн баялгийн менежмент" хөтөлберийг туршиж хэрэгжүүлэх	1999-2000 он	Байгаль орчныг хамгаалах алба, Хэнтий аймгийн Засаг дарга
15.	"Гал түймрээс хамгаалах нэгдсэн менежмент " төслийг Хан Хэнтийн ДЦГ, түүний орчмын нутагт хэрэгжүүлэх	1999-2000 он	Байгаль орчныг хамгаалах алба
16.	Ой, хээрийн түймрээс сэргийлэх сурталчилгаа, сургалтын ажлыг эрчимжүүлэх, зарим ТХГ-дад гал түймэртэй тэмцэх хэсгүүдийг байгуулж ажиллуулах, тэднийг шаардлагатай багаж хэрэгслээр хангах	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба
17.	ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын унааны болон хамгаалах хэрэгслийн хангамжийг сайжруулах, холбоожуулах	1999-2004 он	Байгаль орчны яам, Сангийн яам, Гадаад харилцааны

	төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх , шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх		яам
18.	Алтай таван богд БЦГ, Увс нуурын ай савын ДШГ-ын менежментийг бэхжүүлэх төслүүдийн саналыг боловсруулж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам
19.	ТХГН –ийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх	1999 оноос	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба
20.	ТХГН-дад хийгдэх ойжуулалт, доройтсон орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд шаардагдах зардлыг хамгаалалтын захиргаадын төсөвт тусгуулах , ойжуулах ажилд байгаль хамгаалагчид, тэдний гэр бүл болон ТХГН-ийн орчны бүсэд амьдардаг иргэдийг өргөн оролцуулах	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба
21.	Хан Хэнтий, Говь гурван сайханы БЦГ, Дорнодын ТХГ-дад байгаль орчны хяналт шинжилгээ, тооллогын системийг газарзүйн мэдээллийн системийг ашиглан бий болгох	2001 он	Байгаль орчныг хамгаалах алба
22.	Тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн төлөв байдал, орчны өөрчлөлт, нэн ховор, ховор амьтан, ургамлын хэвийн өсөлтийг хангах, хамгаалах, нөөц тогтоох, экологи-эдийн засгийн үнэлгээ өгөх чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилтын ажлын төсөл, арга хэмжээг авч хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи
23.	БНГ болон БДГ-уудын хамгаалалтыг бэхжүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх	2000-2004 он	Байгаль орчныг хамгаалах алба, аймаг, сумдын Засаг дарга
24.	Улсын хил орчмын ТХГН-ийн менежментийн үйл ажиллагаанд хилчдийг өргөн оролцуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба, Хилийн цэргийг удирдах газар
25.	ТХГН, түүний орчны бүсэд хамрагдах түүх соёлын дурсгалын жагсаалтыг	2000 оноос	Байгаль орчны яам, Гэгээрлийн яам

	гаргах, түүхийн зарим дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах, сэргээн завсарлах арга хэмжээ авах		
	Тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх талаар		
26.	ТХГН-ийн мэргэжилтнийг шинээр болон давтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, байгаль хамгаллын боловсрол эзэмшүүлэх асуудлыг сургалтын агуулгын мэргэжлийн хэсэгт тусгах	2000 он	Байгаль орчны яам, Гэгээрлийн яам
27.	Гадаад, дотоодын их, дээд сургууль дээ ТХГН-ийн менежмент, төлөвлөлт болон байгалийн нөөцийн менежмент, орчны бүс нутгийн хөгжил, аялал жуулчлал, газарзүйн мэдээллийн систем, экологийн хяналт шинжилгээний чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх	1999 оноос	Байгаль орчны яам, холбогдох Их, дээд сургууль
28.	Байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх сургалтын төслүүдийг хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчны хамгаалах алба, Монголын дархалсан газрын нийгэмлэг
29.	Сургалтын бүсчилсэн төвүүдийг Хар ус нуур, Хустайн БЦГ, Хан Хэнтий, Дорнодын ДЦГ-дад байгуулж ажиллуулах	2000-2002 он	Байгаль орчны яам, Байгаль орчны хамгаалах алба
30.	ТХГН-ийн менежмент, төлөвлөлт, санхүүжилт, экологийн аялал жуулчлалын чиглэлээр бодлогын удирдамж , заавар, зөвлөмж, сургалтын гарын авлага бэлтгэх	2000 оноос	Байгаль орчны яам
	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар		
31.	Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх үзэл баримтлал боловсруулах	2000 он	Байгаль орчны яам, Дэд бүтцийн хөгжлийн яам
32.	Хөвсгөлийн БЦГ-ын аялал жуулчлалын менежментийн загвар төлөвлөгөө боловсруулах	1999 он	Дэд бүтцийн хөгжлийн яам
33.	Говь гурван сайхан, Горхи-Тэрэлжийн	2000 он	Дэд бүтцийн хөгжлийн яам

	БЦГ-дад Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг байгуулах, аялал жуулчлалын сурталчилгааны материал бэлтгэх төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх		
34.	ТХГН-ийн аяллын замыг тэмдэгжүүлэх, тохижуулах , түр амрах, хоноглох болон бэлэг дурсгалын зүйл худалдах цэг, үйлчилгээний газруудыг байгуулах төслүүдийг хэрэгжүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам, Дэд бүтцийн хөгжлийн яам
35.	ТХГН-ийн аялал жуулчлалын даацыг тогтоох, экологийн хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, байгаль орчинд аялал жуулчлалын үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	1999-2001 он	Байгаль орчны яам
36.	ТХГН-аар аялах жуулчлалын үндэсний болон ОХУ, БНХАУ-тай хамтарсан олон улсын аяллын хөтөлбөр боловсруулах, эрдэм шинжилгээ, шуурхай ажиглах зэрэг аяллын төрөлжсөн хэлбэрийг хөгжүүлэх арга хэмжээ авах	2000-2002 он	Байгаль орчны яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи
37.	ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, жуулчны бүртгэл, мэдээллийн болон түр нэвтрэх төлбөр хураамжийг бүрдүүлэх тогтолцоог боловсронгуй болгох	1999 оноос	Байгаль орчны яам
38.	Аялал жуулчлал эрхлэхэд баримтлах экологийн стандартыг боловсруулж мөрдүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам, Дэд бүтцийн хөгжлийн яам
39.	ТХГН, түүний орчны бүсэд амьдардаг иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын жижиг төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчны яам
	Судалгаа шинжилгээний ажлын талаар		
40.	ТХГН-т 1999-2004 онд хэрэгжүүлэх судалгаа шинжилгээний ажлын стратегийн төлөвлөгөө боловсруулах	2000 он	Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи

41.	Экологийн урт хугацааны судалгааны цэгүүдийг Хөвсгөл нуур, Увс нуурын ай сав, Говийн их дархан газарт байгуулж ажиллуулах	2001-2004 он	Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи
42.	Бөхөн, хавтгай, мазаалай, ирвэс , цаа буга, хүдэр хамгаалах, тахь нутагшуулах төслүүдийг хэрэгжүүлэх	1999-2003 он	Байгаль орчныг хамгаалах алба, Монголын байгаль орчныг хамгаалах холбоо
43.	ТХГН-ийн менежментийн үйл ажиллагааны үндэслэл болоход чиглэгдсэн судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчны яам , Шинжлэх ухааны академи
44.	Олон улсын байгууллага, гадаад орнуудын бүс нутгийн хүрээнд хэрэгжүүлж байгаа судалгааны хөтөлбөр, төслүүдэд идэвхтэй оролцох	2000 оноос	Байгаль орчны яам
45.	ТХГН-ийн газарзүйн мэдээллийн сан байгуулах	2001 он	Байгаль орчны яам, Монголын дархалсан газрын нийгэмлэг
46.	ТХГН-т хийх судалгааны ажлыг Олон улсын төсөл, Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авах	2000 оноос	Байгаль орчны яам, Гэгээрлийн яам
	Байгаль орчны сурталчилгааны талаар		
47.	Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи нийтлэл, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлж тогтмолжуулах	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба, Хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтарч
48.	Гадаад, дотоодын сэтгүүлчдийг оролцуулсан танилцах аяллыг тусгай хамгаалалттай газар нутагт зохион байгуулах, баримтат кино, телевизийн цуврал нэвтрүүлэг бэлтгэх	2000 оноос	Байгаль орчныг хамгаалах алба, хэвлэл мэдээллийн байгууллага
49.	Мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Богдхан уул, Хан Хэнтий, Дорнод монгол, Монгол дагуур, Увс нуур, Отгонтэнгэр, Хасагт хайрхан, Хөх сэрхийн нуруу, Говийн бага ДЦГ, Хорго-Тэрхийн цагаан нуур, Говь гурван сайхан, Алтай таван богд, Харус нуур, Хустайн БЦГ, Нөмрөг, Хөвсгөл , Хангайн	1999-2003 он	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба

	нурууны БЦГ, Хөгнө ханы БНГ -дад байгуулж ажиллуулах		
50.	Мэдээллэл, сурталчилгааны төвүүдэд түшиглэн олон нийтэд экологийн боловсрол олгох сургалт явуулах	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба, Монголын дархалсан газрын нийгэмлэг
	ТХГН-ийн хамгаалалтад олон нийтийн оролцоог дээшлүүлэх , орчны бүсийг хөгжүүлэх талаар		
51.	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийг тогтоох, орчны бүсийн зөвлөлийг байгуулж ажиллуулах	1999 оноос	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба, холбогдох аймаг, сумдын Засаг дарга
52.	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд олон нийтийн оролцоог дээшлүүлэх, орчны бүсийг хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг Говь гурван сайхан, Хан Хэнтий , Горхи-Тэрэлж , Дорнод Монголын ДЦГ-т хэрэгжүүлэх	1999-2004 он	Байгаль орчны яам
53.	ТХГН-ийн менежментийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор " Хөдөөгийн хүн амын оролцоог үнэлэх аргазүй " боловсруулж хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба
54.	ТХГН болон түүний орчны бүсэд амьдардаг иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ТХГН, орон нутгийн хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, байгалийн баялгийг зохистой ашиглалтыг дэмжих жижиг төслүүдийг Говь гурван сайхан, Горхи-Тэрэлжийн БЦГ, Хан Хэнтий, Дорнодын бүсийн ТХГ-дад хэрэгжүүлэх	1999 оноос	Байгаль орчныг хамгаалах алба
55.	Орчны бүсийн сан байгуулж ажиллуулах	2000 оноос	Байгаль орчныг хамгаалах алба, аймаг, сумдын засаг дарга
	Санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох талаар		
56.	Тусгай хамгаалалттай газар нутгийн эдийн засгийн үр ашгийг тооцох аргазүйг боловсруулж 1-2 БЦГ-т туршиж хэрэгжүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам
57.	ТХГН-ийн бүс тус бүрийн байгалийн дагалт болон бусад боломжтой баялгийг	2000 оноос	Байгаль орчны яам

	ашиглах нөөцийг тогтоон мөрдүүлэх, түүний газар ашиглалт, бусад үйл ажиллагааны орлогоос олсон орлогоороо хамгаалалтын захиргаадыг өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх		
58.	ТХГН-ийн төлбөр, татвар ногдуулах орлогын төрлийг нэмэгдүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам
59.	Тусгай хамгаалалттай газар нутгийн сан байгуулах	2000 оноос	Байгаль орчныг хамгаалах алба
60.	Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн үзэсгэлэнт болон өвөрмөц тогтоцтой газар, ховор ан амьтан, ургамлын тухай ном, товхимол, дүрс бичлэгийн кино, ил захидал, газрын зураг болон бэлэг дурсгалын зүйл бэлтгэж түгээх	1999 оноос	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба
	Олон улсын хамтын ажиллагааны талаар		
61.	ТХГН-ийн чадавхийг бэхжүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, орчны бүсийн хөгжил, менежментийн төлөвлөгөө боловсруулах , экологийн аялал жуулчлалын чиглэлээр төслийн санал боловсруулж холбогдох олон улсын байгууллага, хандивлагч орнуудад тавих	1999 оноос	Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам
62.	Олон улсын байгууллага, гадаад орнуудтай тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээр мэргэжилтэн солилцох	2000 оноос	Байгаль орчны яам
63.	ОХУ , БНХАУ-ын болон бусад орны дархан газруудын шууд харилцааг өргөжүүлэх	2000 оноос	Байгаль орчны яам
64	НУБ-ын болон бүс нутгийн төрөлжсөн байгууллага , хөрш орнуудтай тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чиглэлээр хамтарсан уулзалт, сургалт- семинар зохион байгуулах, мэдээлэл солилцох	1999 оноос	Байгаль орчны яам, Байгаль орчныг хамгаалах алба

ТОВЧИЛСОН УГ:

ТХГН-Тусгай хамгаалалттай газар нутаг
ДШГ-Дархан цаазат газар
БЦГ-Байгалийн цогцолборт газар
БНГ-Байгалийн нөөц газар
БДГ-Байгалийн дурсгалт газар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

Цөм сүргийн талаар авах арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасныг үндэслэн цөм сүргийн удмын сангийн хамгаалах, үүлдэрлэг байдлыг дээшлүүлэх, эзэмшилт ашиглалтыг нь сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим аж ахуйн нэгжид үржүүлж байгаа цөм сүргээс нөхөн үйлдвэрлэл явуулах сүргийн бүтэц бүхий зохих тооны малыг хашаа байр, шаардагдах тоног төхөөрөмжийн хамт уг үүлдрийг зохион бүтээсэн эрдэм шинжилгээний байгууллага, тухайн аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албанд 1 дүгээр хавсралтын ёсоор шилжүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд, холбогдох аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Цөм сүргийн мал бүхий төрийн өмчийн өрөлцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох цөм сүргийг үндэсэн болон эргэлтийн хөрөнгийн хамт 2 дугаар хавсралтын ёсоор холбогдох их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, тухайн аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албаны харьяанд шилжүүлэн аж ахуйн тооцоотойгоор ажиллуулах асуудлыг компанийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлд заасны дагуу шинээр зохион байгуулагдсан цөм сүргийн аж ахуйг одоо байгаа орон нутагт нь ажиллуулж, шаардагдах бэлтээр болон хадлан, тэжээлийн үргамал тариалах талбайг ашиглуулах, эзэмшүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэж байхыг холбогдох байгууллагын эрх баригчид, аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Төрийн өмчийн цөм сүргийг шилжүүлж авсан байгууллагуудыг уг малынхаа аж ахуй, биологийн ашитт шинж чанарыг бататтан сайжруулж, арвин ашиг шимт үржлийн мал өсгөн бойжуулан борлуулж бүс нутгийнхаа мал сүргийг сайжруулах чиглэлээр ажиллуулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, холбогдох

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД — **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Ч.СОДНОМЦЭРЭН

Энэ тогтоолын хавсралтуудыг 232, 233 дугаар хуудсанд үзнэ үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Ур тарианы үрийн тухай

"Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд даалгах нь:

а/улсын нөөцөөс 8100 тонн үр тарианы үрийг 1999 оны хаврын тариалалтад зориулан аж ахуйн нэгжүүдэд гэрээний үндэсэн дээр зээлээр олгож, энэ оны 11 дүгээр сард нөхөн бүрдүүлсүгэй;

б/гурилын үйлдвэрүүдэд байгаа дотоодын буудайн чанарт зохих шинжилгээ хийж тарих үрийн шаардлага хангах буудайг тусламжийн буудайгаар сольж үрэнд ашиглах арга хэмжээ авсугай.

2."Тариалангийн хөрсний механик элдэшүүлэлтийг цомхотгох болон тэглэх технологи, техникийн зохистой хувилбарыг судлах" эрдэм шинжилгээний төслийн захиалгыг 2000 оноос зохих журмын дагуу хэрэгжүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Гэгээрлийн сайд А.Баттөр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД — **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 1999 оны 53 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШИЛЖҮҮЛЭХ ЦӨМ СУРГИЙН МАЛ

№	Малын төрөл, үүлдэр, омог, хэвшил	Харьяалж байгаа аймаг, сум	Төрийн өмчийн оролцоо хувь	Цэм сургийн тоо	Үүнээс: шилжүүлэх малын тоо	Аль байгууллагад шилжүүлэх
1	Байдраг хонь	Баянхонгор аймгийн Жаргалант сум Дээд гүн УҮГ	100.0	3150	3150	Баянхонгор аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албанд
2	Өнжүүл ямаа	Төв аймгийн Баян-Өнжүүл сумын мал эмнэлэг,үржлийн алба УҮГ	100.0	3670	3170	Төв аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албанд
					500	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд
3	Ерөө хонь	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын мал эмнэлэг, үржлийн алба УҮГ	100.0	800	800	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд
4	Говь-Алтай хонь	Говь-Алтай аймгийн Цээл сум, Алтайн Бүрэнхайрхан УҮГ	100.0	3000	3000	Говь-Алтай аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албанд
5	Сартуул хонь	Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Хайрхан УҮГ	100.0	5912	5912	Завхан аймгийн Хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн албанд

Засгийн газрын 1999 оны 53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД НОГДОХ ХЭСГИЙГ САЛГАН ЦӨМ СҮРЭГ БҮХИЙ АЖ АХУЙН ТООЦООН ДЭЭР АЖИЛЛАХ НЭГЖ, САЛБАР БОЛГОХ КОМПАНИУД

№	Малын төрөл, үүлдэр, омог, хэвшил	Харьяалж байгаа аймаг, сум	Тухайн аж ахуйн нэгжид байгаа малын тоо	Төрийн өмчийн оролцоо хувь	Төрийн өмчид ногдох хэсгийг аль байгууллагад харьяалуулах
1	Сэлэнгэ үхэр	Булган аймгийн Сэлэнгэ сум, Ингэттолгой ХК	3000	20.0	Хөдөө аж ахуйн их сургуульд
		Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум, Сэлэнгэ сүрэг ХХК	4694	40.0	Хөдөө аж ахуйн их сургуульд
2	Шилмэл адуу	Төв аймгийн Цээл сум, Залуучууд ХК	411	20.0	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд
3	Махны хэвшлийн үхэр	Сүхбаатар аймгийн Түмэнцогт ХК	7400	51.0	Сүхбаатар аймгийн ХАА-н газрын Малын үржлийн албанд
4	Тал нуттийн цагаан хонь	Хэнтий аймгийн Хэрлэн сум, Тахилгат ХК	9494	51.0	Хэнтий аймгийн ХАА-н газрын Малын үржлийн албанд
5	Мухар үхэр	Дорнод аймгийн Халхгол сумын Халх буудай ХХК	572	51.0	Дорнод бүсийн ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнд
6	Эрчим ямаа	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум, Үржил ХХК	500	51.0	Хөвсгөл аймгийн ХАА-н газрын Малын үржлийн албанд
7	Сүмбэр хонь	Говьсүмбэр аймгийн Говьсүмбэр ХК	19476	30.0	Говьсүмбэр аймгийн ХАА-н газрын Малын үржлийн албанд
				30.0	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд
8	Өвөр байгаль хонь	Дорнод аймгийн Чойбалсан сум	6000	46.0	Дорнод аймгийн ХАА-н газрын Малын үржлийн албанд

ТАЙЛБАР: Сүмбэр үүлдрийн каракуль хонь үржүүлж байгаа Сумбэр, Угаа болон аймгийн хөдөө аж ахуйн газрын Малын үржлийн алба зэрэг 3 аж ахуйн нэгжийн төрийн өмчийн 60.0 хувийн оролцоотой нэг хувьцаат компани гэж үзэв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Ойн болон Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төв, орон нутгийн төсөвт, түймэртэй тэмцэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тус тус тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2."Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх арга хэмжээг үр дүнд хүргэсэн аймаг, сумаас гаргасан зардлыг нөхөн олгох журам"-ыг хавсралтын ёсоор батлуулсугай.

3.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх арга хэмжээг үр дүнд хүргэсэн аймгаас гаргасан хөрөнгийн тодорхой хэсгийг нөхөн олгохоД шаардагдах зардлыг 1999 оны сүүлийн хагасаас эхлэн жил бүрийн төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ш.Түвдэндорж нарт, сумдад нөхөн олгох зардлыг тухайн аймгийн төсөөс гаргаж байхыг Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шаардагдах материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Байгаль орчны сайд С.Мэндсайханд даалгасугай.

5.Ой, хээрийн түймрийн шалтгаан, гэм буруутай этгээдийг илрүүлж тогтоох, тэдэнд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох ажлыг шуурхай зохион байгуулж байхыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хурандаа Д.Мөрөнд даалгасугай.

6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх талаар хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, эргүүл харуул ажиллуулах, хариуцлага, урамшууллын тогтолцоо бий болгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

б/ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх талаар авсан арга хэмжээний биелэлтийг жил бүтам нарийвчлан тооцож, зохих журмын дагуу тайлагнаж байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ
С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 55 дугаар тогтоолын хавсралт

ОЙ,ХЭЭРИЙГ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНД ХҮРГЭСЭН АЙМАГ, СУМААС ГАРГАСАН ЗАРДЛЫГ НӨХӨН ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлыг сайн зохион байгуулан, тодорхой арга хэмжээ авч ур дүнд хүрсэн аймаг, сумаас гаргасан зардлын зохих хэсгийг нөхөн олгоход энэ журмыг дагаж мөрдөнө.

2.Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан түймрийн голомтыг томруулалгүйгээр шуурхай унтрааж, хүн ам, нийтэм, эдийн засаг, байгаль орчин, экологид учруулах хохирлыг багасгахад дэмжлэг үзүүлэхэд журмын зорилго оршино.

Хоёр.Зардлыг нөхөн олгох болзол

3.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах зардлыг төлөвлөгөө, тусевтөө тусган, урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг сайн зохион байгуулан ур дүнд хүрсэн аймаг, сумыг дараахь үзүүлэлтээр дүгнэн зардлын зохих хэсгийг нөхөн олгоно:

1/нутаг дэвсгэртээ түймэр гаргаагүй;

2/тухайн жилд гарсан түймрийн тоог өмнөх таван жилийн дунджаас 50-иас доошгүй хувиар бууруулсан;

3/илэрсэн түймрийг ойд 200 га-гаас, хээрт 10000 га-гаас дээш талбайд тархуулалгүйгээр унтраасан.

4.Энэ журмын 3 дугаар зүйлд заасны дагуу аймаг, сумыг дүгнэхдээ дараахь үзүүлэлтийг харгалзан үзнэ:

1/нутаг дэвсгэртээ гарсан ой, хээрийн түймрийн голомтыг хөрш аймаг, сумын нутаг дэвсгэрт оруулалгүй унтраасан байдал;

2/хөрш аймаг, сумын нутгаас дамжин орж ирсэн түймрийг ойд 200 га, хээрт 10000 га-гаас дээш талбайд тархуулалгүйгээр шуурхай унтраасан байдал;

3/өнгөрсөн оны ойжуулалтын төлөвлөгөөг биелүүлсэн, шатсан ойг сэргээсэн байдал.

Гурав.Болзлыг дүгнэх бүсчлэл

5.Ой, хээрийн түймэр гарах магадлал, эрсдэл, тэдгээрийн давтамж аэргийг харгалзан аймгуудын нутаг дэвсгэрийг дараахь бүсчлэлд хамруулан болзлыг дүгнэнэ:

1/түймрийн магадлал, эрсдэл ихтэй бүсэд Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Хэнтий, Архангай, Дорнод, Төв аймгийн нутаг дэвсгэрийг;

2/түймрийн магадлал, эрсдэл багатай бүсэд Увс, Орхон, Дархан-уул, Сүхбаатар аймгийн болон Завхан, Өвөрхангай, Баянхонгор аймгийн ой бүхий нутаг дэвсгэрийг;

3/түймрийн магадлал, эрсдэлгүй бүсэд энэ зүйлийн 1,2-т зааснаас бусад нутаг дэвсгэрийг.

6.Тухайн жилийн байгаль, цаг уурын нөхцөл, цасан бүрхүүлийн төлөв байдлыг жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор ус, цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас аймаг бүрээр өндөр, дунд, бага гэсэн үнэлгээгээр тодорхойлон гаргах бөгөөд энэ нь болзлыг дүгнэхэд харгалзах үндсэн нөхцөл болно.

Дөрөв.Болзлыг дүгнэх, зардлыг нөхөн олгох

7.Байгаль орчны яам аймгуудаас ирүүлсэн материалд магадлан шинжилгээ хийж, аймагт нөхөн олгох зардлын талаархи саналаа жил бүрийн 12 дугаар сард багтаан Улсын байнгын онцгой комисст оруулна.

8.Оруулсан саналыг үндэслэн Улсын

байнгын онцгой комиссын тогтоолоор болзлыг хангасан аймагт гаргасан зардлын зохих хэсгийг нөхөн олгох асуудлыг шийднэ.

9.Аймгаас ирүүлэх материалыг жил бүрийн 11 дүгээр сард багтаан Байгаль орчны яам хүлээн авах бөгөөд түүнд дараахь бичиг баримт багтсан байна:

1/туймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй төмцөх талаар зохиосон ажлын тайлан, гарсан үр дүн, харьцуулсан тоон үзүүлэлт /журамд заасан болзлын дагуу/;

2/ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй төмцөх талаар тухайн жилд гаргасан хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт;

3/төсөвлөсөн хөрөнгө, түүний ашиглалт, зардлын тооцоо, нотлох бусад баримт бичиг.

10.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй төмцөх ажлыг сайн зохион байгуулж, тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнд хүрсэн аймагт нөхөн олгох зардал нь дор дурдсан хэмжээтэй байна:

1/энэ журмын 3 дугаар зүйлийн 1-д заасныг болон харгалзах үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн бол 13,0 сая хүртэл төгрөг;

2/энэ журмын 3 дугаар зүйлийн 2,3-т заасныг болон харгалзах үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн бол 6,5 сая хүртэл төгрөг.

11.Аймгийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн Засаг даргаас гаргасан шийдвэрийн дагуу шалгарсан сумдад дор дурдсан хэмжээгээр зардлыг нөхөн олгоно:

1/энэ журмын 3 дугаар зүйлийн 1-д заасныг болон харгалзах үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн бол 3,0 хүртэл сая төгрөгөөр;

2/энэ журмын 3 дугаар зүйлийн 2,3-т заасныг болон харгалзах үзүүлэлтийг биелүүлсэн бол 1,5 сая хүртэл төгрөгөөр.

Тав.Санхүүжилт

12.Энэ журмын дагуу шалгарсан аймагт нөхөн олгох зардлыг улсын төвлөрсөн төсвөөс, сумдад олгох зардлыг тухайн аймгийн төсвөөс санхүүжүүлнэ.

13.Аймаг, сумд нөхөн олгосон мөнгийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй төмцөх арга хэмжээ, энэ ажилд идэвх зүтгэл гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад зориулан зарцуулна.

Зургаа. Нөхөн олгох зардлын хэмжээг тодорхойлох аргачлал

14.Болзлыг биелүүлсэн аймаг, сумдад нөхөн олгох зардлын хэмжээг дараахь томъёогоор тодорхойлно:

$$З = К1*К2*Зд$$

К1- ой, хээрийн түймрийн давтамж,түймэрт өртөх байдлыг харгалзсан коэффициент

Түймрийн магадлал, эрсдэл ихтэй бүс нутагт К1=1, түймрийн магадлал, эрсдэл багатай бүс нутагт К1=0,5 байна.

К2- тухайн жилийн байгаль, цаг уурын нөхцөл, цасан бүрхүүлийн төлөв байдлыг харгалзсан коэффициент

Түймэр гарах нөхцөл өндөр жилд К2=1, түймэр гарах нөхцөл дунд зэрэг жилд К2=0,5, түймэр гарах нөхцөл бага жилд К2=0,1 байна.

Зд- журамд заасан зардлын дээд хэмжээ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.
Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн ордон Индекс: 14503
Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Улаанбаатар хот 1999 оны дөрөвдүгээр сарын 27 № 19 (98)

ГАРЧИГ

нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

154. Зарим төрлийн үйлчилгээ, бараанд тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон гаалийн тарифийн тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай (1999.04.08-ны хууль) 238

хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

155. 1999 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Дугаар 10 238

156. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай Дугаар 15 240

157. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 16 240

158. Тогтоолуудын заалтыг хүчингүй болгох тухай Дугаар 17 240

159. Зарим сумдыг нийлүүлж, Сайнцагаан сум байгуулах тухай Дугаар 18 241

160. Зарим сумдыг нэгтгэж, нутаг дэвсгэрийн хилийн цэсэт өөрчлөлт оруулах тухай Дугаар 19 241

161. Зарим сумдыг нийлүүлж, Хэрлэн болон Өмнөдэлгэр сумд байгуулах, тэдгээрийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай Дугаар 20 242

162. Сумын нэр өөрчлөх тухай Дугаар 21 243

163. Сайхан сумын төв шилжүүлэх тухай Дугаар 22 244

164. Кадастрын зураглалын тухай хууль болон Газрын кадастрын тухай хуулийн төслүүдийг буцаах тухай Дугаар 23 244

гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

165. Авто машин, түүний резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг батлах тухай Дугаар 77 245

166. Шагналын журам батлах тухай Дугаар А/27 251

167. Нийгмийн халамжийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар А/70 252

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАРИМ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, БАРААНД ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХАМААРУУЛАХГҮЙ БАЙХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний паспортыг иргэний үнэмлэхээр солих үйлчилгээнд Төмдэгтийн хураамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд хамааруулахгүй байхаар тогтоосугай.

Д/д	Бараны нэр		
1.	Үнэмлэхний хавтас	60м боодол	4800
	-наагч	50ш боодол	2400
2.	Халгийн шошго:		
	-шошгоны цаас	ширхэг	500000
	-шошгоны хамгаалагч	-"-	500000
	-шошгоны лац	-"-	22
3.	Персонал ажлын станц:		
	-иж бүрэн компьютер	-"-	25
	-онгот принтер	-"-	25
	-хар болон онгот хор	-"-	88
	-бүл	-"-	24
	-бүлны гол	-"-	36
	-барабан	-"-	33
	-кабель	-"-	25
	-зураг татагч /сканнер/	-"-	25
	-дүрс буулгачийн ламп	ширхэг	26
	-хүчдэлийн залгуур	-"-	25
	-компьютер холбох Би-Эн-Си кабель	-"-	25
	-үнэмлэх зүүсэгч	-"-	23

2 дугаар зүйл. Иргэний үнэмлэх хэвлэхэд шаардагдатай, улсын хилээр нэвтрүүлэх дор дурдсан тоо, хэмжээ бүхий бараанд Гаалийн тарифын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг хамааруулахгүй байхаар тогтоосугай:

	-үнэмлэх наагч төхөөрөмж	-"-	25
	-наагч цаас ороох гол	-"-	25
	-наагчийг цэвэрлэгч	-"-	25
	-модем	-"-	29
	-модемны залгуур	-"-	30
	-түлхүүр	-"-	23
	-бусад залгуурууд	-"-	72
4.	Тог баригч:		
	-толгой машины тог баригч	-"-	2
	-ажлын станцын тог баригч	-"-	25
	-хувиргач кабель	-"-	27
5.	Толгой компьютер:		
	-иж бүрэн толгой компьютер	-"-	2
	-мэдээллийн компресслогч	-"-	2
	-малтипорт карт	-"-	2
6.	Компьютерийн программ хангамж	-"-	74
7.	Лазер-Жэт принтер	-"-	2
	-хор	-"-	4
	-принтерийн цаас	6оодол	100

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

1999 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 1999 оны хаврын эзлэжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай:

Нэг.Төрийн байгуулагтын чиглэлээр:

1/Улсын Их Хурлын 1999 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай;

2/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөл;

3/Зарим сумдын хилийн цэсийн тухай асуудал;

4/Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Засгийн газрын 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай тогтоолын төсөл;

6/Хэвлэл мэдээллийн байгууллагуудын дүрмүүдийн төсөл;

7/ Сонгуулийн хуулийн төсөл;

8/Үлс төрийн намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10/Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12/ Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл;

13/Монгол Улсын Их Хурлыг тараах эсэх асуудлаар ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төсөл;

14/Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл.

Хоёр.Нийгмийн боддлогын чиглэлээр:

15/Хөдөлмөрийн тухай болон түүнтэй холбогдох хуулиудын төсөл;

16/Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах Үндсэн чиглэл, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс, түүнтэй холбогдох хуулиудын төсөл;

17/Нийгмийн салбарын хувьчлалын тухай хуулийн төсөл ;

18/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл;

19/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

20/Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

22/Газар дор болон хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллагсдын салбарын даатгалын тухай хуулийн төсөл.

Гурав.Эдийн засгийн чиглэлээр:

23/Орон сууцны тухай хуулийн төсөл.Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, Орон сууц хувьчлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/Хуулийн заалтыг тодгалзүүлэх тухай хуулийн төсөл;

25/Компанийн тухай хуулийн төсөл;

26/Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл;

27/Автотээврийн тухай хуулийн төсөл;

28/Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

29/Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх тухай хуулийн төсөл;

30/Газар хувьчлах тухай хуулийн төсөл ;

31/Иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл ;

32/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн төсөл

33/а.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал,

б.Монгол Улсын хүн амын нутагшлын байршил, хөгжлийн ерөнхий төсөл ;

34/Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл;

35/Радио долгионы тухай хуулийн төсөл;

36/Үнэт цаасны тухай хуулийн төсөл;

37/Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай ерөнхий хуулийн төсөл;

38/Гадаадын зээл тусламжийг авах, зохицуулах тухай хуулийн төсөл;

39/Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл;

40/Зар сурталчилгааны тухай хуулийн төсөл;

41/Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

42/Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

43/Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх ерөнхий зарчмыг батлах тухай тогтоолын төсөл.

Дөрөв. Төсвийн чиглэлээр:

44/Хязгалз усанд төлбөр ногдуулах тухай хуулийн төсөл ;

45/Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

46/Татварын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл;

47/Монгол Улсын 1999 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

48/Үнэлгээний үйл ажиллагааны тухай хуулийн төсөл.

Тав.Аюулгүй байдал, батлан хамгаалахын чиглэлээр:

49/Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

50/Тагнуулын байгууллагын тухай хуулийн төсөл;

51/Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

52/Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

53/Монгол Улсын гадаад албаны тухай хуулийн төсөл;

54/Төрийн ордны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

55/Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Зургаа. Хууль зүйн чиглэлээр:

56/Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

57/Иргэний бүртгэлийн тухай хуулийн төсөл;

58/Өмгөөллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

59/Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга /;

60/ Эрүүгийн хуулийн төсөл /шинэчлэн боловсруулсан/

61/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл / шинэчлэн боловсруулсан/;

62/Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

63/Хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн төсөл

64/Шүүхийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

65/Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

66/Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

67/Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн төсөл ;

68/Талын аюулгүй байдлын тухай хуулийн төсөл;

69/Харуул, хамгаалалтын тухай хуулийн төсөл ;

70/Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

71/Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

72/Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

73/Шүүхийн байгууллага, шүүгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл;

74/Цагдаагийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

75/Галт зэвсгийн тухай хуулийн төсөл ;

76/Хүний эрхийн комиссын тухай хуулийн төсөл.

Долоо. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн асуудлаар:

77/Газрын кадастрын тухай хуулийн төсөл;

78/Кадастрын зураглалын тухай хуулийн төсөл;

79/Далай ашиглах тухай хуулийн төсөл;

80/Таримал үргамал, үр сортын тухай хуулийн төсөл;

81/Үрийн тариалалт даатгах тухай хуулийн төсөл,

82/Хүнсний үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/

83/Байгаль орчны төлөв байдлын тайлан;

84/Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

85/Газрын хөвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

86/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

87/Амьтны аймгийн тухай хуулийн төсөл ;

88/Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл;

89/Тариалангийн тухай хуулийн төсөл;

90/бусад.

2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Байнгын хороо, чуулганы хуралдаанаар өмнө хэлэлцэж эхэлсэн хуулиудын төслийг хаврын чуулганаар хэлэлцэх бэлтгэл ханган Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

3. Хаврын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн Засгийн газраас санаачлах хуулиудын төслийг нэн даруй өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 15 Улаанбаатар хот

Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулсан тухай

Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын 1999 оны 11 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 1999 оны 11 дүгээр тогтоолыг батлах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж саналуудыг судлан үзээж, төдөөрийн талаар зохих арга хэмжээ авахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Хувьтөгөлдөр/, Эдийн засгийн байнгын хороо /Д.Ганболд/, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо / Ц.Ганхуяг/ -нд тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай асуудлын талаарх зохих шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын 1999 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 16 Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс "Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай" Улсын Их Хурлын 1999 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 12, 13, 14 дүгээр тогтоолуудын 2 дахь заалтад тавьсан хоригийг тус тус хүлээн авах нь зүйтэй гэж үзсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

Тогтоолуудын заалтыг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх

тухай" Улсын Их Хурлын 1999 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 12, 13, 14 дүгээр тогтоолуудын 2 дахь заалтыг тус

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Зарим сумдыг нийлүүлж, Сайнцагаан сум байгуулах тухай

Дундговь аймгийн Сайнцагаан, Мандалговь сумдын иргэд, эдгээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засгийн газрын саналыг харгалзан Үндэсн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан, Мандалговь сумдыг нийлүүлж, шинээр Сайнцагаан сум байгуулж, төвийг нь Мандалговьд байхаар тогтоосугай.

2. Дундговь аймгийн Сайнцагаан сумын хилийн цэсийг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигт заасанаар хөвөрч улдээсүгэй.

3.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/Сайнцагаан сум байгуулсантай холбогдуулан тус сумын иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл хангах;

2/Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох ажлыг 1999 оны 6 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "БНМАУ-ын хотуудын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 252 дугаар зарлигийн 2 дугаар зүйлийн "Мандалговь хот" - д холбогдох заалт, " Сум байгуулах тухай" Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 33 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

Зарим сумдыг нэгтгэж, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулах тухай

Увс аймгийн Хархираа, Тариалан сумдын иргэд, эдгээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засгийн газрын саналыг харгалзан Үндэсн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Хархираа сумыг татан буулгаж, мөн аймгийн Тариалан сумтай нэгтгэсүгэй.

2. Увс аймгийн Тариалан , Улаангом, Наранбулаг, Давст сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг хавсралтын ёсоор өөрчлөн батлуулсугай.

3.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/сумдыг нэгтгэсэнтэй холбогдуулан хүүчин

Хархираа сумын иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл хангах;

2/ Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох ажлыг 1999 оны 6 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 75 дугаар зарлигийн 222 дахь хэсэг, "БНМАУ-ын хотуудын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 252 дугаар зарлигийн 2 дах хэсгийн "Улаангом"-той холбогдох заалт, "Сум байгуулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1986 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 109 дүгээр зарлигийн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 19 дүгээр тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН УЛААНГОМ, ТАРИАЛАН, ДАВСТ, НАРАНБУЛАГ СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЦЭС

Нэг. Улаангом

Хүүш уул /1840.4/, Тун мэнд уул, Шар тэвх, Зүүн хоолойн ам, Зүүн бүцалдаг булаг, Бага нуурын хоолойн хүсны баруун үзүүрээр Увс нуур, нуурын захаар Залангийн нуур, Бор үзүүр /933.4/, Үвш харын зүүн өндөрлөг /979.5/,

Адаргана уулын урд үзүүр /1100.5/, Уралдааны хөтөл /1071.2/, Хархираа голын 1078.4 тоот, Басан уул /1542.1/, Бор тосон уул /2905.7/, Хархираа-Түргэний голын бэлчир /1821.2/, Хархираа голоор өгсөж, Хархираа голын уул салаалны эх, Хархираа нуруугаа 3966.2; 3790.8; 3687.4; 2745.0 тоотуудаар, Хөх нуурын урд үзүүр, 3844.3; 3629.0 тоотуудаар, Бууралт / 3144.0/, Батаан хар /3781.0/, Цэвээчийн хөтөл, Хасан уул /2760.7/, Хэрэг /2541.0/, Шүргүү Улиастайн голоор, Улаантолгой, Тэвх /1330.0/, Таван хар уул /1134.0/, Түнгэний зах /Өгөөмөл хойт адаг/ /961.4/, Хойт шар нуур, Хинар / 835.6/, Хөх модны эх, Зүзаан бүраагийн адаг голоор, Зүзаан Бүраагийн эх /916.0/, Цэнхийн тариганы баруун үзүүр, Баруун хоолойн адгаас 3,7 км-т, Баруун хоолойн адаг, 1383.0 тоот, Баруун Тэрэнсийн уул үзүүр /1420.6/, 1513.1 тоот, Орлогын даваа, 1702.8 тоот, Хүүш уул /1840.4/.

Хөгр. Тариалан

Бор үзүүр /933.4/, Залангийн нуураар, Увс нуурын хөвөөгөөр. Увс нуурын арал, Хэрээ хүүхэлдэй /780.2/, Тээлийн боомын тариалангуудын суурин, Тулгат /1316.0/, Халхаатын худаг, Сүүл хар /1552.0/, Тошилтын баруун дэл /1631.0/, Шар бүрд нуурын зүүн захын /1383.3/, Морьт уул /1814.7/, Бургастайн суурин, Бургастайн голыг өгсөж, Хатуу боом, Горхотын голыг өгсөж, Халхын овоо /2643.2/, 2158.0 тоот, Дэмч /Заверын булингийн зүүн шовгор/, Толь булаг, Ёлын нуруугаа 2882.4 тоот, Ёл /3394.3/, Хархираа нуруугаа 3559.9; 3604.3; 3710.9; 3966.2 тоотуудаар, Хархираа голын урд салаалны эх, Хархираа голоор урсудаж, Хархираа-Түргэний голын бэлчир /1821.0/, Бор тосон уул /2905.7/, Басан уул /1542.1/ Хархираа голын 1078.4 тоот, Уралдааны хөтөл /1071.3/, Адаргана уулын урд үзүүр /1100.5/, Үүш харын зүүн өндөрлөг /979.5/, Бор үзүүр /933.4/.

ГурвэДавст

Улсын хилийн 70 дугаар тэмдэг /1632.3/, улсын хилээр Увс нуур дахь Орхийн голын цуталан, Увс нуурын зүүн ба урд хөвөөгөөр, Залангийн нуур, Зүүн бүцалдаг булаг, Бага нуурын хоолойн хүсэнэ баруун үзүүр, Зүүн хоолойн ам, Шар тэвх, Түн өмнө уул, Хүүш уул /1840.4/, улсын хилийн 70 дугаар тэмдэг /1632.3/.

Дөрөв. Наранбулаг

Увс нуурын арал, Увс нуурын урд хөвөөгөөр, Дэсэл нуурын тушаа Увс нуурын зах, Дэсэл нуурын Зүүн хөвөө, Бага нуурын хойт ба зүүн хөвөөгөөр, Бага нуурын өртөө, 782.9; 814.1; 876.7; 972.1 тоотуудаар, Ирталангийн сайрын 1242.0 тоот, Өлийн хойт бөгж /1361.9/, Дунд хар нүүр /1653.0/, Өмнө хар нүүр /1982.0/, 2063.0; 1621.0 тоотуудаар, Бөөм уул /1756.6/ 1344.0 тоот, Чоно долоох булаг, Хянгас нуурын баруун хойт захын 1025.5 тоот, Хянгас нуурын баруун хөвөөгөөр, Хүрэн шанаа /1058.2/, 1082.9 тоот, Цахирын овоо, Балцаг уул / 1153.0/,Омойн улаан уул /1272.6/, Дэл хар /1276.7/, Минжуул /1355.7/, Хоолойн хар уул /1341.1/, Нарийны худаг, Шар дэл уулын 1405.3 тоот, Жинстийн хар толгой, Галзуутийн шар толгой /1460.1/, Улаан толгой /1522.0/, Гэдгэр хагийн хар дэл /1422.1/, Хүрэн толгой, Хар толгой, 1528.0 тоот, Ширээт худаг, Шивээн Бахлуурын 1710.0 тоот, Холбоо нуурын зүүн захын 1626.0 тоот, Бургастайн уул /1763.8/, Бургастайн суурин, Морьт уул /1814.7/, Шар бүрд нуурын зүүн захын 1383.3 тоот, Тошилтын баруун дэл /1631.0/, Сүүл хар /1552.0/, Халхаатын худаг, Тулгат уул /1316.0/, Тээлийн боомын тариалангуудын суурин, Хэрээ хүүхэлдэй /780.2/, Увс нуурын арал.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 20 Улаанбаатар хот

Зарим сумдыг нийлүүлж, Хэрлэн болон Өмнөдэлгэр сумд байгуулах, тэдгээрийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай

Хэнтий аймгийн Гурванбаян, Өлзийт, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдын иргэд, эдгээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засгийн газрын саналыг харгалзан Үндэсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгүүдээсныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Өлзийт , Хэрлэн сумдыг нийлүүлж, шинээр Хэрлэн сум байгуулж, төвийг нь Өндөрхаанд байхаар тогтоосугай.

2. Хэнтий аймгийн Гурванбаян, Өмнөдэлгэр сумдыг нийлүүлж, шинээр Өмнөдэлгэр сум байгуулж, төвийг нь Баянбулагт байхаар тогтоосугай.

3. Хэрлэн, Өмнөдэлгэр сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг хавсралтын ёсоор батлуулсугай.

4. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/ Хэрлэн, Өмнөдэлгэр сум байгуулсантай холбогдуулан эдгээр сумдын иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх,

2/ Хэрлэн, Өмнөдэлгэр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох ажлыг 1999 оны 6 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сум байгуулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 209 дүгээр зарлигийн 1 дүгээр зүйлийн Өлзийт сумтай холбогдох заалт, " Сум, хороо байгуулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 272 дугаар зарлиг, " Хилийн цэс батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 106 дугаар зарлигийн 1 дүгээр зүйлийн Гурванбаян сумтай холбогдох заалт, "Хэрлэн, Өндөрхаан сумыг нэгтгэж, Хэрлэн сум байгуулах тухай" Улсын Их Хурлын 1995 оны 5 дугаар сарын 30-ний өдрийн 54 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийг түүс нүүх хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 20 дугаар тогтоолын хавсралт

ХЭРЛЭН СУМ

Тал булгийн толгой, Тахилгын овоо /1516.2/ 1521.1; 1387.3; 1421.5; 1377.6; 1295.5; 1418.6; 1290.3; 1369.0 тоотууд, Уртын булаг, Уртын голын зүүн эргээр уруудаж, Уртын гол, Засмал замын уулзвар, Засмал замын урд захаар, Булган точка /271 км/, Шархад /1228.3/, Сэрвэн /1230.0/, Хөх-Өндөр, Бор хушуу /1073.4/, Хэрлэн голын урд эргээр өгсөж, 1028.0; 1035.2 тоотууд, гүн нуурын зүүн үзүүр /2-р шон/, Хоолойн худаг, Землянка /шон № 3/, Баянмөнх толгой, 1082.0 тоот, Царигийн голын зүүн эргээр, Урт худаг, Цагаан дабааны зүүн хойт үзүүр / Дугуйн өвөлжөөний хойт толгой/, Цагаан дабаа, Ар хөв /1465.8/, Хавтгай /1474.4/, Шилийн Чулуу, Бор-Өндөр /1383.8/, Хадат толгой, Замын 1158.7 тоот Өндөрхаан-Улаанбаатарын замаар 1209.5 тоот, Манханы утасны цэгийн суурь, Бумбагарын улаан өндөр /1533.2/, Өндөр толгой /1408.4/, Гацаа, Цагаан толгой /1309.7/, Дунд-Өлгий /1416.6/, Их булаг, Ерөөлтийг чиглэн эгц зүүн тийш Мөрөн гол, Мөрөн голыг 5 км уруудан, эгц зүүн тийш эргэж, Баянцогт /1385.3/, Баруун чандган, Зүүн чандган /1309.0/ Худийн толгой /1264.0/, Хойт зотлог /1460.7/ Тал булгийн толгой.

ӨМНӨДЭЛГЭР СУМ

Хаданцай- Ондолын голын уулзвар, улсын хилээр, 1704.0 тоотоор улсын хилээс гарч, 1576.2 тоот, Сухлэг өндөр /2274.8/, 1453.3 тоот, Өвөр Нэртийн голын зүүн эргээр уруудаж, Онон-Өвөр Нэртийн голын уулзвар, Онон голын урд эргээр уруудаж, Дунд Тарас-Онон голын уулзвар, Дунд Тарасын голын зүүн эргээр өгсөж, Идрэнгийн голын даваа, 1824.2; 1899.8; 2014.5 тоотууд, Сайхан голын эхний даваа, Сайхан голын урд эргээр уруудаж, Барх-Сайхан голын уулзвар /1259.6/, Баянцагааны овоо /1628.8/, Баруун мойлтын даваа, 1503.0; 1562.8 тоотууд, Цагаанчулуут /1558.3/, 1574.5 тоот, Дэлгэр-өндөр /1462.1/, 1148.2 тоот, Хурах-жаргалантын голын уулзвар /1126.4/, Хурх голын урд эргээр уруудаж, Хурх-Зүүнбаян голын уулзвар, Зүүнбаян голын баруун эргээр өгсөж 1140.8 тоот, Зүүнбаян голын дээд салааны уулзвар, Зүүнбаян, Номт, Хайлант голын уулзвар, Тогоот /1463.0/, Овоотын өндөр /1487.2/, 1501.2; 1530.3; 1521.1 тоотууд, Тахилгын овоо /1516.2/, Тал булгийн толгой, Хойт Зотлог /1460.7/, Худгийн толгой /1264.0/, Зүүн чандган /1309.0/, Баруун чандган, Баянцогт /1385.3/, эгц баруун тийш эргэж Мөрөн голд хүрч, голоо 5 км өгсөж, эгц баруун тийш Их булаг, Өлийн даваа, Тэнгэлэг-Зүүнбаян голын уулзвар, Зүүнбаян голын зүүн эргээр өгсөж, Зүүнбаяны даваа, Ар Асгатын голын зүүн эргээр уруудаж, Ар Асгат -Мөрөн голын уулзвар, Мөрөн голын хойт эргээр өгсөж Зүрх хүзүү, 1587.4 тоот, Улаан чулууны даваа, 1528.1; 1664.9 тоотууд, Элэгний овоо, 1613.8; 1886.7 тоотууд, Зоргол голын 1596.8 тоот, Тэнүүн-Ар элэгний голын уулзвар, 1865.1; 1890.7; 1909.6 тоотууд, Их сайхан-Дунд сайхан голуудын хоорондох нуруугаар хяралж, Хэрлэн -Илүүр голын уулзвар /1510.7/, Илүүр голын баруун эргээр өгсөж, Илүүр-Их даваатын голын уулзвар, Их Даваатын голын баруун эргээр өгсөж, Их даваат, Даваатын голын баруун эргээр уруудаж, Унгалж-Даваатын голын уулзвар / 1497.3/, Унгалжийн голын баруун эргээр өгсөж, Унгалжийн даваа, Бэргийн ян сарьдаг /2098.9/, 1724.5; 1610.5; 1461.4 тоотууд, Сандаас уул / 1516.6/, 1048.4 тоот, Минж-Захарын голын уулзвар, 1450.9; 1274.0 тоотууд, Хаданцай-Ондолын голын уулзвар.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр — Дугаар 21 — Улаанбаатар хот

Сумын нэр өөрчлөх тухай

Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засгийн газрын саналыг харгалзан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Завхан аймгийн Булнай сумын нэрийг "Тосонцэнгэл" гэж өөрчилсүгэй.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 22 | Улаанбаатар хот

Сайхан сумын төв шилжүүлэх тухай

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засгийн газрын саналыг харгалзан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төвийг Хөтөл хотод шилжүүлсүгэй.

2. Сумын төвийг шилжүүлсэнтэй холбогдуулан хуучин сумын төв байсан Номгоны иргэдийн ажиллаж амьдрах, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын хэвийн ажиллах нөхцөлийг хангах арга хэмжээ авахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан " Сум , хороо шинээр байгуулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 64 дүгээр зарлигийн 1 дүгээр зүйлийн "6" заалтын "Номгон" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

Кадастрын зураглалын тухай хууль болон Газрын кадастрын тухай хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Отгонбаяр, Р.Сандалхан нараас 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр, Засгийн газраас 1998 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлсэн Кадастрын зураглалын тухай хууль болон Газрын кадастрын тухай хуулийн төслүүдийн хоорондын уялдаа холбоо, давхардал, зөрчлийг арилгаж, дахин боловсруулах шаардлагатай гэсэн үндэслэлээр тэдгээр төслийг хууль санаачлагчдад нь буцаасугай.

2.Газрын кадастр, кадастрын зураглалын талаарх харилцааг зохицуулах хуулийн шинэ төслийг нэн даруй боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар / Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 3 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

Автомашин, түүний резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг батлах тухай

ТУШААХ нь:

1.Электрон техник, машин судлалын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн боловсруулсан "Автомашины эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Автомашины резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Автомашины зай, хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг норм"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлагдсугай.

2.Автомашин, түүний резин дугуй, зай хураагуурын эдэлгээний доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн дотоддоо норм боловсруулан мердеж ажиллахыг авто тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөсүгэй.

3.Автомашин, түүний резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг хэвлүүлэн олшруулж нийтийн хүртээл болгохыг Электрон техник, машин судлалын Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл /в.Сүхбаатар/-д үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан БНМАУ-ын Тээврийн яамны сайдын 1972 оны 49 дүгээр тушаал, БНМАУ-ын Тээврийн яамны сайдын 1982 оны 176 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Тээврийн ерөнхий газрын даргын 1991 оны 107 тоот тушаалуудыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД Г.БАТХҮҮ

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 77 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АВТОМАШИНЫ ЭДЭЛГЭЭНИЙ ГҮЙЛТИЙН ДООД ХЯЗГААРЫН ЖИШИГ НОРМ

№	Автомашины төрөл, загвар	Эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм /мян.км/
	I.Ачааны автомашин	
1.	Зил-130, түүний төрлүүд	380.0
2	ГАЗ-53, түүний төрлүүд	320.0
3.	Краз-257, 255, 258	230.0
4.	Камаз-5320 /5511/, түүний төрлүүд	400.0
5.	Урал-375 /4320/	290.0
6.	УАЗ-452Д, түүний төрлүүд	290.0
7.	ГАЗ-66	260.0
8.	ЗИЛ-131	290.0
9.	МАЗ-5335, 5429, түүний төрлүүд	250.0
10.	УРАЛ-377	310.0
	II.АВТОБУС	
11	ПАЗ-672	270.0
12.	ПАЗ-3205	270.0
13.	ЛАЗ-695	300.0
14.	ЛИАЗ-677	400.0
15.	Кароса-В731, В732	420.0
16.	КАВЗ-685, 3270	350.0

	ШМИКРОАВТОБУС	
17.	РАФ-2203	350.0
18.	УАЗ-2206	300.0
19.	УАЗ-452В	300.0
20.	ВАРКАС-4000	250.0
21.	WOLKSWAGEN	300.0
22.	TOYOTA HAIS	400.0
23.	HUINDAI GRAIS	300.0
24.	KIA VESTA	300.0
	IV.СУУДЛЫН АВТОМАШИН	
25.	HUINDAI Callofer	500.0
26.	HUINDAI PRESTO	350.0
27.	HUINDAI Accent	250.0
28.	HUINDAI Sonata-II, III	275.0
29.	HUINDAI Excel	285.0
30.	CORONDA Famili	280.0
31.	OPEL Acsone	300.0
32.	OPEL Omega	300.0
33	OPEL Cadet	280.0
34.	OPEL Record	280.0
35.	VOLVO, mooyna mfjloo;	400.0
36.	WOLCSWAGEN Passat	350.0
37.	AUDI 80.100.200	300.0
38.	BMW 3161, 3181	350.0
39.	TOYOTA Landcruiser	600.0
40.	TOYOTA Coralla	350.0
41.	TOYOTA Corona	350.0
42.	ISUZU Trooper	600.0
43.	MAZDA 626	320.0
44.	MITSUBISHI Pajero	600.0
45.	NISSAN Patrol	600.0
46.	NISSAN Sunni	350.0
47.	NISSAN Terrano	500.0
48.	DAEWOO Lemans	300.0
49.	BARTBURG 353	250.0
50.	FIAT, түүний төрлүүд	300.0
51.	MERSEDES Benz 190E	350.0
52.	MERSEDES Benz 230E, түүний төрлүүд	400.0
53.	ВАЗ 2101-2109, түүний төрлүүд	250.0
54.	ГАЗ-69А, 69Б	270.0
55.	ГАЗ-3102, 31029, түүний төрлүүд	290.0
56.	ГАЗ-24	250.0
57.	АЗАК-2141 Алеко	200.0
58.	Москвич 408, 412, 2140	220.0
59.	Иж-2715 /Москвич/	200.0
60.	УАЗ-469, 31512, түүний төрлүүд	300.0

Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар,гүйлтийн нормыг тогтоохоод харгалзах нөхцөлүүд:

1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан "Автомашины эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм"-ыг үндэс болгон өөрсдөө тогтооно.

2.Аж ахуйн нэгж, байгууллага нь автомашины эдэлгээний гүйлтийн нормыг тогтоохдоо энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан "Автомашины эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм"-ыг автомашины ашиглалтын бүс, тээвэрлэлтийн нөхцөл ачаалаас хамааруулан доорхи хүчиар хорогдуулан тооцож болно.

а/Авто замын нөхцөлөөс хамааруулж:

-Баян-өлгий,Увс,Хөвсгөл,Завхан,Ховд,Говь-алтай аймгийн нутагт - 10.0

-Өмнөговь, Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн нутагт - 5.0

-Ашиглалтын хүнд нөхцөлд /уулнаас мод цагаалах, тариан талбайд ажиллах, замгүй газраар хайгуулын ажилд явах, уул уурхайн

карьерт ажиллах зэрэг нөхцөлүүд орно/ - 15.0

б/Автомашины төрөл, ачаалаас хамааруулж:
-Хөөр голт чиргүүлтэй ажиллавал - 15.0
-Хөөр голт, хөөр чиргүүлтэй ажиллавал - 25.0

-Зүтгэгч автомашин - 20.0
-Өөрөө буулгагч автомашин - 15.0
-Тусгай зориулалтын автомашин - 5.0

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 77 дугаар тушаалын хөрдүтаар хавсралт

РЕЗИН ДУГУЙН ЭДЭЛГЭЭНИЙ ГҮЙЛТИЙН ДООД ХЯЗГААРЫН ЖИШИГ НОРМ

№	Резин дугуйн төрөл, хэв маяг, хэмжээ, загвар	Үйлдвэр лэсэн ул	Автомашины төрөл, марк, загвар	Эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг /мян.км/
		1. Суудлын автомашин		
1.	6.15R13 /Дор/	ОХУ	ЗАЗ-968, 968А, 968М6	41.0
2.	6.45R13 /Дор/	ОХУ	ВАЗ-2107 lada төрлүүд	41.0
3.	735R14/варнйн/ /Дор/	ОХУ	ГАЗ-24,2402,2403 төрлүүд	44.0
4.	205/70P 14 /өргөн/ Дор/	ОХУ	ГАЗ-2410, 2411,213, Волга	50.0
5.	8.45R15 /Унив /	ОХУ	УАЗ-469,4695,31512	45.0
6.	6.95r16 /Унив/	ОХУ	ВАЗ-1600/2121/НИВА	45.0
7.	6.95R13 /Дор/	ОХУ	Москвич-2136, 2137	45.0
8.	165-330/6.45R/ /Дор/	ОХУ	Москвич-2140	41.0
9.	185/65P/15H	Герман	Mersedes Benz190E,200,260	45.0
10.	195/70R 14H	Солонгос	Huindai Sonata 280R Excel	35.0
11.	195/65R 15H	Герман	Opel Omega, Mersedes Benz 230	40.0
12.	195/65R 14T	Герман	Wolkswagen Passat, Mazda 626	50.0
13.	185/65R 15H	Герман	BMW316, 318, Mazda 626,Mersedes Benz190E	50.0
14.	265/75R 15S	Япон	Toyota Landcruiser, Ki70 spizial	55.0
15.	165/70R 14T	Япон	Toyota coralla	42.0
16.	175/70R 14S	Япон	Toyota Corona 1.8,16V	42.0
17.	175/65R 14T	Япон	Nissan Sunny	42.0
18.	245/70R 14P	Япон	Isuzu Trooper	45.0
19.	235/75R 15H	Япон	Mitsubishi Pajero	55.0
20.	10R15LT109	Япон	Nissan Patrol	50.0
21.	215R15S	Япон	Nissan Terrano	50.0
22.	195/65R15V	Герман	Audi	42.0
		П.АЧААНЫ АВТОМАШИН		
1.	6.45R 13 /Унив/	ОХУ	Иж-2715 түүний төрлүүд	41.0
2.	8.40R 15 /Унив/	ОХУ	УАЗ-451М, 452Д	45.0
3.	8.25r 50 /Унив/	ОХУ	ГАЗ-53, 53-82	60.0
4.	12.0R 18.0	ОХУ	ГАЗ-66, 66-11	46.0
5.	9.0R20 /Дор/	ОХУ	ЗИЛ-130, ЗИЛ-ММЗ-555	55.0
6.	12.0R20	ОХУ	ЗИЛ-131, Урал375, 377	40.0
7.	11.0R20 /ИЯВ-12.5/	ОХУ	МАЗ-500А,503А,504В250Б	54.0

8.	9.0-20Р И-н, 1425 загвар /Унив/	ОХУ	Камаз-5320,5511,5410,54112	50.0
9.	18.0-25; 21.0-33Р /Карьер/	ОХУ	Белаз-540А, 7522, 548А,7523	53.0
10.	12.0R20 /Карьер/	ОХУ	Краз –257,256,255Б1,258Б1	30.0
		ШАВТОБУС		
1.	8.40R15 /Унив/	ОХУ	УАЗ-452А,452В,Фургон	45.0
2.	7.35R 15 /Донор/	ОХУ	РАФ-2203, 22011	44.0
3.	8.25R20 /Унив/	ОХУ	КАВЗ-685,3270,ПАЗ-652,ПАЗ-672	63.0
4.	10.0R20.0 /Дор/	ОХУ	ЛАЗ-695Н,697Р,ЛиаЗ-677	70.0
5.	182/85Р 15 /Дор/	Чех	Шкода-1203	44.0
6.	215р 14/Дор /	Герман	Кароса	85.0
7.	10R20, HR-17	Чех	Mersedes Benz-309	38.0
8.	RIB187,1000R20	Япон	Hino	130.0
9.	RIB18711.00R20	Япон	Nissan	85.0
10.	16Р R/7.00 Т-20	Солонгос	Huindai	80.0

Резин дугуйн гүйлтийн нормыг тогтооход харгалзах нөхцөлүүд

1.Аж ахуйн нэгж, байгууллагын эзэд болон эрх баригчид, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг энэхүү тушаалын .... Дугаар хавсралтаар батлсан "Автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн жишиг норм"-ыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.

2.Резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг аж ахуйн нэгж, байгууллагын эзэд болон эрх баригчид нь уур амьсгал, авто замын нөхцөлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг доорхи хувиар хорогдуулан тооцож болно.

Бүсийн дугаар	Тухайн бүсэд багтах аймгууд	Эдэлгээний нөөцийн доод хязгаарыг хорогдуулах хувь
1 бүс	Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-уул, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Төв, Дорноговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий	-
II бүс	Говь-алтай, Ховд, Баян-өлгий, Увс, Завхан, Хөвсгөл	10.0

3.Мод бэлтгэх, карьерын нөхцөл нь ашиглалтын бүсийн ялгаанаас хамаарахгүйгээр хоёр бүсэд аль алинд нь ижил байх учир энэ нөхцөлд резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормын тооцоонд ашиглалтын бүсийн хорогдуулах хувийг хэрэглэхгүй.

4.Автомашины тээвэрлэлтийн нөхцөлийг харгалзан резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг доорхи хувиар бууруулж хэрэглэж болно.

№	Автомашины тээвэрлэлтийн нөхцөл	Резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь
1	Байнга нэг чиргүүлтэй ажилладаг ачааны автомашинд	15.0
2.	Мод бэлтгэл, уул уурхайн карьерын нөхцөлд тогтмол ажилладаг ачааны автомашинд	30.0
3.	Байнга 2 чиргүүлтэй буюу 10 тн-оос дээш даацтай, олон голт чиргүүл /трейллер/ чирдэг автомашинд	25.0

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД- НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 03 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар А/70 | Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

"Нийгмийн халамжийн тухай", "Ахмад настан, нд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай", хир дутуу хүний нийгмийн хамгаллын тухай" гол Улсын хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор ЦААХ нь:

1. "Асрамжийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийг 1 зэр хавсралтаар, "Нийгмийн халамж, чилгээний төвийн үлгэрчилсэн дүрэм"-ийг 2 дугаар сралтаар, "Нийгмийн халамжийн гэрийн чилгээний журам"-ыг 3 дугаар хавсралтаар, рав ба түүнээс дээш ихэр хүүхдийг терийн длаар өсгөж хүмүүжүүлэх журам"-ыг 4 дүгээр сралтаар, "Жирэмсний болон амаржсаны элгийн хуудас олгох заавар"-ыг 5 дугаар сралтаар, "Жирэмсний болон амаржсаны элгийн хуудасны загвар"-ыг 6 дугаар хавсралтаар, кир дутуугийн үнэмлэх олгох журам"-ыг 7 дугаар сралтаар, "Тахир дутуугийн үнэмлэхийн загвар"-8 дугаар хавсралтаар, "Улсын нийгмийн амжийн газрын дүрэм"-ийг 9 дүгээр хавсралтаар, йгмийн халамжийн улсын байцаагчийн дүрэм"-ийг дугаар хавсралтаар тус тус батална.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нэн ядуу иргэнийг шардлагатай үед өдөрт 1 удаа ігмийн халамж, үйлчилгээний төвд хооллох лын дээд хэмжээг нэг хүнд өдөрт 500 төгрөгөөр оосугай.

3. Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн дасны үнийг 120 төгрөгөөр тогтоосугай.

4. Улсын нийгмийн халамжийн газрын дарга риунсан/-д даалгах нь:

а/ "Нийгмийн халамжийн хуулиудыг эгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн ын 1999 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 36 дугаар оолын 3-ын а, б, в заалтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

б/ Нийгмийн халамжийн тухай хуулийн 23.1.1, 23.1.2, 23.1.3, 23.2-т заасан зардлын норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацаат холбогдох норм, хоол тэжээлийн илчлэг, зах зээлийн үнийн жишигтэй нийцүүлэн жил бүр шинэчлэн тогтоож байх;

в/ Асрамжийн газарт хөдөлмөр эмчилгээг зохицуулахад баримтлах жирмэг боловсруулж батлан мөрдүүлэх;

г/ аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төв тус бүрт 1, Улсын нийгмийн халамжийн газарт 2 нийгмийн халамжийн улсын байцаагч байхаар тооцож зохих шагларалтад орж танцсэн хүмүүсийг нийгмийн халамжийн улсын байцаагчаар томилуулах ажлыг 1999 оны 05 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах.

5. "Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 36 дугаар тогтоолоор болон энэхүү тушаалаар батлагдсан дүрэм, журам, заавыг мөрдлөг болгон нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилж ажиллахыг аймаг, нийслэлийн дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн дарга нарт даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын "Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1996 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 45, "Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай" 1996 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 85, "Эмнэлгийн хуудасны загвар, үнэ, түүнийг олгох журам батлах тухай" 1996 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 130 дугаар тушаалууд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын "Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1997 оны 3 дугаар 14-ний өдрийн А/94 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД **С.СОНИН**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны А/70 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АСРАМЖИЙН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улсын болон орон нутгийн асрамжийн р нь /цаашид Асрамжийн газар гэнэ/ бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие, эсхүл тэжээн тэтгэгч нь

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 02 дугаар сарын 01-ний өдөр | Дугаар А/27 | Улаанбаатар хот

Шагналын журам батлах тухай

Ям, газраас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний 53 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спортын салбарын шагналын журмыг хавсралтаар батлуулсугай.

2. Энэ журмыг 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласугай.

3. Салбарын төрүүний ажилтны үнэмлэх, ямны хүү дэвтэр, гэрчилгээ, жуух бичгийг захиалын дагуу 1999 он эрүүгийн улиралд багтаан хэвлүүлэх, түүнд шаардагдах те хөрөнгө гаргахыг ерөнхий нябо /Б.Базар/-д зөвшөөрсүгэй

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл хамгаалах, нийгэм хангамжийн ямны сайдын 1994 оны 101, Биеийн тамир, спортын улсын хорооны гишүүд хурлын 1987 оны 54 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болс тооцсугай.

САЙД С.СОНИН

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны А/27 тоот тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

1. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх, ард түмний эрүүл мэндийн төлөө үйлст идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилдж хөдөлмөрийн тогтвортой өндөр амжилт гаргаж, хамт олон, ард түмний дунд өндөр нэр хүндтэй хүмүүст Монгол улсын Засгийн газрын болон ямны дараахь шагнал олгоно. Үүнд:

а/ Монгол улсын Засгийн газрын салбарын шагнал:

- Эрүүлийг хамгаалахын төрүүний ажилтан төмдэг, үнэмлэх
- Хөдөлмөр, нийгэм хангамжийн төрүүний ажилтан төмдэг, үнэмлэх
- Биеийн тамир, спортын төрүүний ажилтан төмдэг, үнэмлэх

б/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын ямны шагнал:

- ЭМНХЯ-ны хүндэт дэвтэрт бичиж, дүрсэлсэн гэрчилгээ олгох.
- ЭМНХЯ-ны Хүндэт жуух бичгээр шагнах.

2. Монгол улсын төрийн дээд шагнал /хөдөл-мөрийн баатар, ардын болон гавьяат цол, төрийн соёрхол/ хүртсэн болон тус салбарыг хөгжүүлэхэд түүхэнд үлдэх хувь нэмэр оруулж гавьяа байгуулсан хүмүүсийг ямны Хүндэт дэвтэрт алдаршуулан бичиж, дүрсэлсэн гэрчилгээ олгож, мөнгөн шагналаар шагнана.

3. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спортын салбарт 10-аас дээш жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилдж, хөдөлмөрийн тогтвортой өндөр амжилт гаргаж, хамт олон, ард түмний дунд өндөр нэр хүнд олсон, мэргэжлийн үр чадвар, хүнлэг энэрэнгүй үйлсэрэз тодорсон төрүүний хүмүүсийг сүүлийн 5 жилийн ажлын үр дүнг үндэсн үзүүлэлтээр нь дүгнэж салбарын төрүүний ажилтан төмдэг, үнэмлэх олгож, мөнгөн шагналаар шагнана.

4. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спортын төлөө үйлст 5-аас доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилдж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан төрүүний хүмүүсийг ЭМНХЯ-ны Хүндэт жуух бичиг, онгон шагналаар шагнана.

5. Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт онцгой хувь нэмэр оруулсан үед, хоршоолол, олон нийтийн байгуулалга, хувийн салбарын ажилагсадад болон гадаадын иргэдэд энэхүү шагнал нэгэн адил хамаарна.

6. Шагналыг шат дараалан давхардуулахгүйгээр сүүлийн 5-аас доошгүй жилийн ажлын үр дүнгээр олгоно.

7. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүн амыг нийгмийн баталгаат хан түхайн салбарыг хөгжүүлэхэд онцгой ажилт гарг гавьяатай үйлс бүтээсэн хүмүүсийг зохих шагналаах дараа ажиллаасан хугацаа харгалзахгүйгээр түхайн үед нь шаг болно.

8. ЭМНХЯ-ны шагналаар шагнуулахаар тодорхойло: хамт олны олонхийн саналаар нэр дэвшүүлсэн хур тэмдэглэл, ажлын амжилтын тодорхойлолтыг загварын д үйлдэн Эрүүл мэнд, нийгмийн хамгаалын ямаар /нэг б зүргаадуулар сарын 15-нь дотор/ ирүүлнэ.

9. Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын ямны шагна: шагнуулах хүмүүсийг тодорхойлох загвар:

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын ямны шагна: шагнуулах хүмүүсийг тодорхойлолт

1. Овог нэр_____
2. Регистрийн дугаар _____
3. Хүйс _____
4. Яс үндэс _____
5. боловсрол _____
6. үндсэн захиргаа _____
7. хэзээ, хаана ямар ажил эрхэлж байсан, одоо з ажил эрхэлж байгаа_____
8. ажиллаасан жил_____, үүнээс түхайн хамт о дотор_____
9. урьд нь авч байсан гавьяа шагнал, хаанаас ноуны хэдэн онд
10.шагнуулах гээж байгаа үндэслэл, тодорхойло. дэлгэрэнгүй бичнэ.
11. Түхайн хүний ажлын үндсэн үзүүлэлтийг /сүүл 5жил/ хүснэгтээр гаргаж хавсаргана.
12. Хамт олны саналын хувь_____
13. Аймаг, нийслэлийн Нийгмийн бодлогын хэлт дүгнэлт, санал_____
14. Шагналын нэр_____
15. Тодорхойлсон байгуулагын дарын гарын үсэг, т

Аймаг, нийслэлийн Нийгмийн бодлогын хэлт дарын гарын үсэг, тэмдэг

____он___сар___одор

10. Шагналыг сайдын зөвлөлийн хурлын шийдв үндэслэн Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сай тушаалаар олгоно.

11. Шагналыг хамт олны өмнө хүндэтгэлтэйгээр гарду шагнагдсан хүмүүсийн ажлын арга туршлага, ажи хэвлэл мэдээлийн хэрэгслээр сурталчлан алдаршуулн

5	6Q 75, 6Q 90, 6Q 105, 6Q 120, 6Q 135	БНХАУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 3500-5200 см3 эзэлхүүн бүхий их ангиллын суудлын автомашин, дунд даацын ачааны автомашин, дунд багтаамжийн автобус	23
6	6Q 150, 6Q 165, 6Q 180, 6Q 195	БНХАУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 5200-6400 см3, түүнээс дээш эзэлхүүнтэй их даацын ачааны автомашин, их багтаамжийн автобус	24
7	AKUMA-66, түүний төрлүүд	Чех	Бүх төрлийн суудлын, ачааны автомашин, автобус*	32
8	GRAND-PLUS, Duples-Hoppecer, тэдгээрийн төрлүүд	Герман	Бүх төрлийн суудлын, ачааны автомашин, автобус*	32
9	Deklor-DE90R, 80D26R, 95 D31R түүний төрлүүд	Солонгос	Бүх төрлийн суудлын, ачааны автомашин, автобус*	30
10	FIAMM, түүний бүх төрлүүд	Итали	-"-*	43
11	DOUGLAS-675, TURBO-PLUS-75, American, түүний төрлүүд /24F-54, 66, 78, 24F-66,78,90,4D-150,8D-198,A-5846,A-41510,A-27-700 гэх мэт/	АНУ	-"-*	42
12	HITACHI-50D20R түүний төрлүүд -N-50L-N-150 N-200 -55B24R түүний төрлүүд	Япон	-"-*	36

Тайлбар: * 50-80 хүртэл ампер-цагийн багтаамжтай зай хураагуурыг суудлын автомашин, бага даацын ачааны автомашин, микроавтобусанд;

90-120 хүртэл ампер-цагийн багтаамжтай зай хураагуурыг ачааны автомашин, дунд багтаамжийн автобусанд;

130-200 хүртэл ампер-цагийн багтаамжтай зай хураагуурыг их даацын ачааны автомашин, их багтаамжтай автобусанд

Дэд бүтцийн хөгжлийн сайдын
1999 оны 77 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

АВТОМАШИНЫ ЗАЙ ХУРААГУУРЫН ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААНЫ ДООД ХЯЗГААРЫН ЖИШИГ НОРМ

№	Зай хураагуурын төрөл	Үйлдвэр-лэсэн улс фирм	Хэрэглэх автомашины төрөл, ангилал	Эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг норм /сараар/
1	6СТ 50 ЭМС 6СТ 55 ЭМС 6СТ 60 ЭМС	ОХУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 1200-3500 см3 эзэлхүүн бүхий бага болон дунд ангиллын суудлын автомашин, бага даацын ачааны автомашин, мөн микроавтобус	24
2	6 СТ 70 ЭМС 6 СТ 90 ЭМС 6СТ 105 ЭМС 6СТ 132 ЭМС	ОХУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 3500-5200 см3 эзэлхүүн бүхий их ангиллын суудлын автомашин, дунд даацын ачааны автомашин, дунд багтаамжийн автобус	24
3	6СТ 165 ЭМС 6СТ 182 ЭМС 6СТ 190 ЭМС	ОХУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 5200-6400 см3, түүнээс дээш эзэлхүүнтэй их даацын ачааны автомашин, их багтаамжийн автобус	24
4	6Q 60	БНХАУ	Хөдөлгүүрийн ажлын багтаамж нь 1200-3500 см3 эзэлхүүн бүхий бага болон дунд ангиллын суудлын автомашин, бага даацын ачааны авто-машин, мөн микроавтобус	21

дэмжлэг туслалцаа үзүүлэх боломлогдуй нь тогтоогдсон ахмад настан, тахир дутуу хүн болон хүүль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бүтэн өнчин хүүхдийг төрөөс байгуулах асрамжлах үйлчилгээ үзүүлэх байгууллага мөн.

2. Асрамжийн газрын үйл ажиллагааны зорилго нь асуудалгүйг хоол, хувцас хэрэглэл, эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээгээр хангах, үйлчилгээг гэрийн нөхцөлд аль болох ойртуулах замаар тэдний амьдралын хэвийн нөхцөл, хууль ёсны эрх ашгийг хамгаалахад оршино.

3. Асрамжийн газар үйл ажиллагаандаа Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын нийгмийн халамжийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, энэхүү үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгоно.

4. Асрамжийн газар нь улс, орон нутгийн захиргааны харъяалалд ажиллана. Улсынх нь Улсын Нийгмийн халамжийн газарт, орон нутгийнх нь тухайн аймгийн Засаг дарга, Нийгмийн халамж, үйлчилгээний төвд харъяалагдана.

5. Улсын нийгмийн халамжийн газрын харъяа Улсын асрамжийн газрын даргыг Улсын нийгмийн халамжийн газрын дарга томилно.

6. Асрамжийн газрын дарга Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана. Тушаалыг тухайн асрамжийн газрын болон түүний шууд харъяа нэгжийн нийт ажилтан дагаж мөрдөнө.

7. Асрамжийн газар захиргааны зөвлөлтэй байна. Зөвлөлийн гишүүдийг газрын дарга томилох бөгөөд гишүүд нь газрын даргад зөвлөх эрхтэй байна.

8. Асрамжийн газрын ажиллагчдыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулна.

9. Асрамжийн газар тогтоосон журмын дагуу банкинд харилцах данстай, өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10. Асруулагчдын эрүүл мэндийн байдал, нас хүйсийг харгалзан хэвтрийн, хөдөлмөр эмчилгээний зэрэг тасгуудыг зохион байгуулж болно.

11. Асруулагчдын эрүүл мэнд, ажлын чадварт зохицсон ажил /өдөл, сүлжмэл, хүнсний ногоо тарих, хадлан өвс бэлтэх, мал гахай , шувуу маллах гэх мэт/ хийлгэх зэргээр хөдөлмөр эмчилгээг хослуулан зохион байгуулна.

12. Асруулагчдын дунд соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулах, ариун цэвэр, хэв журам сахиулах, захиргааны ажилд туслах үүрэг бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй асруулагчдын зөвлөлийг нэг жилийн хугацаагаар асруулагчдын хурлаас нь сонгож, зохих журмын дагуу ажиллуулна.

13. Асрамжийн газар нь энэхүү дүрмийг үндэслэн өөрийн дотоод журмаа боловсруулан баталж мөрдөнө.

Хоёр. Асрамжийн газрын даргын эрх, үүрэг

14. Асрамжийн газрын дарга нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

14.1. асрамжийн газрын нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэдтэй шууд харилцан гэрээ байгуулах, хэлцэл хийх;

14.2. асрамжийн газрын эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

14.3. асрамжийн газрын захиргааны албан тушаалтан болон салбар нэгжийн дарга, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.

15. Асрамжийн газрын дарга дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

15.1. нийгмийн халамжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

15.2. байгууллагын аж ахуй, үйл ажиллагааны орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийг хангах;

15.3. асрамжийн үйлчилгээний ажлын чанарыг сайжруулах;

15.4. асрамжийн үйлчилгээг сайжруулах асуудлаар дээд шатны байгууллагад санал оруулах;

15.5. хамт олныхоо санал хүсэлтийг байнга судалж, шаардлагатай арга хэмжээ авч удирдан зохион байгуулж ажиллах;

15.6. хууль тогоомжид заасан бусад чиг үүрэг.

Гурав. Асрамжийн газрын захиргааны үүрэг, эрх

16. Асрамжийн газрын захиргаа дор дурдсан үүрэгтэй. Үүнд:

16.1. улс, орон нутгийн төсвөөс хувааригдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зориулалтын зүйлд зарцуулах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтлөх, тайлан тэнцлийг тогтоосон хугацаанд нь гүнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад тушаах, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг хамт олонд мэдээлж байх;

16.2. үндсэн хөрөнгө, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, түүний эд материал, түлш, эрчим хүчийг хэмнэлттэй зарцуулах, эд хогшил, хувцас хэрэглэлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, эдэлгээний хугацаат хангах;

16.3. асруулагчдыг тогтоосон журмын дагуу аятай тохитой амьдрах зориулалт бүхий орон байр, хоол, хувцас, эм, орны болон ариун цэврийн хэрэглэлээр хангах;

16.4. эмнэлгийн тусламж үзүүлэх шаардлагатай асруулагчдад зохих эмчилгээ, сувилгаа, үйлчилгээ /аланғуяа иллэг, усан, шавар, биений тамир зөрэг эмийн бус эмчилгээ/ -г хийж, тэдний бие эрхтэнийг нөхөн сэргээхэд чиглэгдсэн үйлчилгээг зохион байгуулах;

16.5. асруулагчдад телевизийн нэвтрүүлэг үзүүлэх, кино гаргах, концерт тоглох, лекц ярих хийх, төрөл бүрийн тоглоом /шатар, даам, шагай гэх мэт/ тоглуулах зөрэг соёл хүмүүжлийн ажлыг тогтмол зохион байгуулах, халуун усанд оруулж, хувцас, орны хэрэглэлийг солих, өрөө тасалгаа, бохирын цэвэрлэгээ, хортон мэрэгчид, шавьж устгах ажлыг хуваариар хийлгэж, асруулагчдын байр болон хувийн ариун цэврийг чанд сахиулах;

16.6. асруулагч нэг бүрт хувийн хэрэг нээж жил бүр баяжилт хийж, паспорт, иргэний бусад бичиг, баримтыг нэгдсэн журмаар тусгайлан хадгалах;

16.7. асруулагчдад эмнэлгийн хяналт тогтоолгохын зөрэгцээ нарийн мэргэжлийн эмч /дотор, нүд, шүд, сэтгэл мэдрэл, сурьеэ, арьс өнгө, эмэгтэйчүүд/ нарын үзлэгийг хагас жил тутам хийлгэж, ариун цэвэр, урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авч, асруулагчдыг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх, асрамжийн газартаа эмчлэж, сувилах ажлыг асрамжийн газрын их эмч хариуцан зохион байгуулах;

16.8. сонсголын аппарат, нүдний шил, шүд болон хөл гарын хиймэл эрхтэн, гэмтэл, гажиг засах хэрэгсэл, тэргэнцэр зайлшгүй шаардлагатай асруулагчдад тэдгээр зүйлийг олгох арга хэмжээ авч зардлыг асрамжийн газрын төсвөт зардлаас гаргах;

16.9. асрамж, халамжийн үйлчилгээний ажлыг сайжруулах үйлчилгээнд дэвшилт шинэ техник, технологи, тэргүүний арга хэлбэр нэвтрүүлэх, байгын бус асруулагчдад зохих журмын дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлэх бүх талын бололцоо нөхцөлийг бүрдүүлж ажиллах;

16.10. хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгон ажиллагчдын хариуцлага, сахилга, боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, гар хөдөлмөрийг механикжуулах, үйлчилгээ хөнгөвчлөх ажлыг зохион байгуулах;

16.11. хөдөлмөрийн чадвартай асруулагчдын бие эрхтэнийг нөхөн сэргээх зорилгоор эмчийн хяналтын дор тэднийг өдөрт 6 цагаас илүүгүй хугацаагаар чадварт нь тохирсон хөдөлмөр хийлгэж, олсон орлогыг тэдний ахуй амьдралыг нь дээшлүүлэх, туслах аж ахуй хөгжүүлэхэд зарцуулна. Хөдөлмөр эмчилгээний тасгийн асруулагчдыг хөдөлмөрийн орлогоос газрын захиргааны шийдвэрээр шагнаж урамшуулж болно.

16.12. асруулагч нас барвал тогтоогдсон нормативт баримтлан оршуултын зардлыг асрамжийн газрын төсвөөс гаргана. Асрамжийн газарт нас барсан асруулагчийг оршуулах ажлыг хариуцан зохион байгуулж, тухайн иргэнийг үндсэн захиргааны бүртгэлээс хасуулна. Аймаг, хотын төвд буй асрамжийн газар иргэдийг үйлчлэх байгууллагатай гэрээ байгуулж нас барагчдыг оршуулах ажлыг зохион байгуулж болно.

17. Асрамжийн газрын захиргаа дор дурдсан эрхтэй. Үүнд:

17.1. газрын захиргаа хууль зүйн дагуу эрхээ хамгаалах, хамгаалуулах;

17.2. аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлаар шүүх, арбитр, хуулийн бусад байгууллагад гомдол гаргах түүнийг шийдвэрлэж өгөхийг шаардах;

17.3. холбогдох хууль тогтоомж, дүрэмдээ нийцүүлэн эд хөрөнгөө зээмших, ашиглах, захиран зарцуулах;

17.4. гадаадын орны ижил төрлийн үүрэг гүйцэтгэдэг болон бусад газар, байгууллагатай шууд харилцаа тогтоох асуудлыг мөрдөгдөж

байгаа хууль тогтоомжийн дагуу эрхлэн явуулах;

17.5. улсаас хатуу тогтоосноос бусад ажил үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн жишгийг харгалзан тогтоож мөрдөх;

17.6. асуудлагчдаас түр чөлөөгөөр явахыг хүсвэл асуудлагчдын зөвлөл, эмчийн саналыг үндэслэн асрамжийн газрын дарга зөвшөөрөл олгох бөгөөд 30 хоног хүртэлх чөлөөг харгалзан дэмжигчийн бичгээр гаргасан батлагаар үндэслэн газрын даргын тушаалаар олгоно.

Дөрөв. Асрамжийн газарт асуудлагчдыг хүлээн авах

18. Иргэдийг улсын болон орон нуттгийн асрамжийн газарт хүлээж авахдаа дор дурдсан баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

а/ аймаг, дүүргийн Засаг даргын шийдвэр;

б/ Улсын нийгмийн халамжийн газрын болон аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн зөвшөөрөл;

в/ аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нарын /сэтгэл мэдрэл, арьс өнгө, сурьеэгийн гэх мэт/ хяналтын комиссын шийдвэр;

г/ хурц, архаг, халдварт өвчингүй гэдгийг баталсан лабораторийн шинжилгээнүүд;

д/ хоёр хүвь зураг;

е/ асрамжийн газарт асрамжлуулахыг хүссэн хүний хувийн өргөдөл.

19. Асрамжийн газарт явуулахаар шийдвэрлэгдсэн хүмүүсийг тухайн аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар өөрийн зардлаар, бие хүнээр хүргүүлж, хүлээлгэн өгнө.

20. Асуудлах хүн нь хурц халдварт өвчтэй байвал эмчлүүлж эдгэрүүлсний дараа мэргэжлийн эмч нарын зөвшөөрлөөр энэ журмын 18, 19 дүгээр зүйлд заасны дагуу явуулна.

21. Тэттэвэр авдаг асуудлагчдад Монгол улсын нийгмийн даатгалын хуульд зааснаар тэтгэвэрийнх нь 30 хувийг зохих журмын дагуу тухайн асрамжийн газрын санхүүгээс олгох бөгөөд асуудлагчийн харъяалагдах аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/ байцаагчтай улирал тутам тооцоо хийнэ.

22. Асрамжийн газрын захиргаа асуудлагчдын үнэт зүйлсийг тэдгээрийн хүсэлтээр тусгай жагсаалтаар хүлээн авч хадгалж болох бөгөөд жагсаалтын нэг хувийг өөрт нь өгнө.

23. Асрамжид асуудаж байх үед гарсан хүүхдийг ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежид суралцаж байх хугацаанд нь бүтэн өнчин хүүхдийн нэг адил хангамж эдлүүлнэ.

Тав. Асуудлагчыг асрамжийн газраас гаргах, шилжүүлэх

24. Асуудлагчийг дор дурдсан тохиолдолд асрамжийн газраас гаргана. Үүнд:

а/ биеийн эрүүл мэнд нь сайжирч, хөдөлмөрлөх чадвартай болсон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан;

б/ асуудлагчийг асран хамгаалж, тэжээн тэтгэх хүмүүс илэрч, улмаар тэтгэхийг хүсэх, мөн хууль ёсоор тэдгээрт өгч асуудлах үндэс бүрдсэн;

в/ асуудлагчийг ямар нэгэн аж ахуйн нэгж, байгууллага, компани, албан газар ивээлдээ авч асрахыг хүссэн;

г/ асуудлагчийн хүүхэд нь насанд хүрч сургуулиа төгссөн бүүр цэргээс халагдаж, ажил хөдөлмөр эрхэлсэн. 1*

25. Энэхүү журамд зааснаар асрамжийн газраас гарч байгаа хүмүүст түүнийг хэрэглэж байсан хувцасыг нь өгч аймаг, нийслэл, сумын төв хүртэлх унааны зардал олгоно. Мөн шаардлагатай бол тухайн иргэний асрамжийн газарт асуудаж байсан тухай тодорхойлолт гаргаж өгнө.

26. Асрамжийн газарт асуудаж байгаа хүмүүс нь гэмт хэрэг үйлдэх, ёс суртахууны доголдол гаргах, архи уух, чөлөөний хугацаат хэтрүүлэх, чөлөөгүй явах зэргээр асрамжийн газрын дүрэм, дотоод журмыг зөрчвөл хүмүүжлийн болон захиргааны дараахь арга хэмжээ авна. Үүнд:

а/ дутагдлыг хэлж анхааруулах;

б/ захиргаа болон асуудлагчдын зөвлөлөөр хэлэлцэж сануулах;

в/ асрамжийн газраас хөөхийг сануулах;

г/ асрамжийн газрын даргын тушаалаар эцсийн арга хэмжээ болгон асрамжаас хөөх;

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийгмийн халамж, үйлчилгээний төв нь /цаашид төв гэнэ/ хүн амын эмэгэг хэсэгт тэрээс үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг зохион байгуулан хэрэгжүүлэх үүрэг бүхий орон нутгийн байгууллага мөн.

2. Төвийн зорилго нь хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх, тур хугацаагаар хооллох, тэдэнд хувцас, хоол, хүнс болон ахуй, соёлын наад захын хэрэгцээт зүйлс олгох, мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг тэдний амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн дэмжлэг туслалцаа үзүүлж, үйлчилгээг сайжруулахад оршино.

3. Төв нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль, Тахир дутуу хүний нийгмийн халамжаллын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын нийгмийн халамжийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

4. Төвийн үйл ажиллагааны зардлыг төв, орон нутгийн /сум, дүүргийн/ төсвөөс санхүүжүүлнэ.

5. Төв нь хууль тогтоомжид заасан журмын дагуу өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6. Энэхүү үлгэрчилсэн дүрмийг үндэслэн өөрсдийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан дотоод журмаа боловсруулан тухайн шатны Засаг даргын Тамгын газраар батлуулан мөрдөнө.

Хоёр. Төвийн зохион байгуулалт

7. Аймаг, нийслэлийн дүүргийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтэс нь Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн өдөр дутмын үйл ажиллагааг удирдаж, Улсын нийгмийн халамжийн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган.

8. Төвийн бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, ажиллах журам, дүрмийг орон нутгийн онцлогийг харгалзан аймаг, нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газраас тогтоож мөрдүүлнэ.

9. Аймаг, дүүрэгт байгаа асрамжийн газрыг төвийн бүтэндээ багтаан зохион байгуулж, ганц бие ахмад настан, тахир дутуу хүн, бүтэн өнчин болон байнын асрамжинд байдаг төрөлхийн тахир дутуу 16 хүртэлх насны хүүхдийг байнга асрамжлах үйлчилгээг үзүүлнэ.

10. Аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн халамжийн цэцэрлэг, сувиллын ясли, ахмадын нохөн сэргээлт, протезийн тасаг зэрэг нийгмийн халамжийн арга хэмжээ явуулдаг салбар нэгжүүдийг бүтэндээ нэттэн үйлчилгээ үзүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган.

Гурав. Төвийн гүйцэтгэх үүрэг

11. Төв нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

11.1. нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;

11.2. нэн ядуу амьдралтай иргэн, бүтэн өнчин хүүхдийг тур хугацаагаар хооллох;

11.3. үйлчлүүлэгчдэд наад захын хувцас, хүнс, ахуйн соёлын зүйл олгох;

11.4. хүмүүнлэгийн шугамаар ирсэн олон улсын тусламжийн зүйлийг үйлчлүүлэгчдэд хуваарилан олгох;

11.5. үйлчлүүлэгчдийг эмнэлгийн үйлчилгээнд хам-руулан өрхийн эмчийн хяналтанд байлгах, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн наралтай тусламж үзүүлэх;

11.6. үйлчлүүлэгчдийн ажлын болон оюуны чадварыг харгалзан мэргэжил эзэмшүүлэх, тохирсон ажил хөдөлмөр эрхлүүлэх замаар ажлын байнгын байр бий болгох, зохих цалин, хөлс олгох ажлыг зохион байгуулах;

11.7. үйлчлүүлэгчдийн нас, эрүүл мэндийн байдлыг харгалзан гэрээр нь үйлчлэх график, хуваарь гарган биелэлтэд нь хяналт тавих,

11.8. хүн амын эмзэг хэсэгт туслах, төдний амжиргаагүй дээшлүүлэх талаар олон нийт аж ахуйн байгууллагын үүсгэл санаачилгыг өрнүүлэх, туслалцаа дэмжлэгийг нь авах, хамтран ажиллах;

11.9. нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвартай ажил эрхэлдэггүй иргэдэд холбогдох байгууллагуудтай хамтран хөдөлмөр эрхлэх, амьдрал ахуйгаа дээшлүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;

11.10. нийгмийн халамж үзүүлэх зайлшгүй шаардлагатай иргэдийн бүртгэл судалгаат сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраар гаргуулан авч төдэнд үзүүлэх халамж, үйлчилгээний төрөл чиглэлийг тогтоож хэрэгжүүлэх;

11.11. ахмад настан, тахир дутуу хүн халамжийн төвийн үйлчилгээнд төлбөртэйгээр хамрагдахыг хүссэн тохиолдолд тэдэнд зохих журмын дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

11.12. халамжийн үйлчилгээнд батална тесвят хөрөнгийг зориулалтынх нь дагуу зарцуулж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөж, тайлан тэнцлийг хууль тогтоомжинд заасан хугацаанд гаргаж, үр дүнг нь холбогдох байгууллагад мэдээлж байх;

Гурав. Төвийн эрх

12. Төв нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

12.1. нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зохих журмын дагуу захиран зарцуулах;

12.2. хууль заасны дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоон олгох, хэмжээг өөрчлөх, зогсоох;

12.3. сумын нийгмийн халамжийн асуудал хариуцсан ажилтан нарын ажлыг шалган заавархах;

12.4. үйл ажиллагааныхаа хүрээнд хамрагдах асуудлаар баримт, бичиг, мэдээ, судалгаа, тайлан гаргуулж авах;

12.5. нийгмийн халамжийн хууль тогтоомж зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд захиргааны арга хэмжээ авахуулах санал боловсруулах;

12.6. иргэдийн өөрсдийнх нь буруугаас шалтгаалж илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг хууль заасны дагуу буцаан суутгах;

12.7. сумын нийгмийн халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд төвлөрүүлэн авч нийгмийн халамжийн арга хэмжээнд зуваарилан зарцуулах.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Улсын болон орон нуттийн асрамжийн газарт асруулдаггүй, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, ганц бие ахмад настан, тахир дутуу хүн гэрээр үйлчлүүлэх хүсэлт гаргавал асрамжийн газар болон аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвөөс төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтлана.

2. Дор дурдсан үйлчилгээг гэрээр үзүүлж болно. Үүнд:

- орон байрыг нь цэвэрлэх, гэр барих, цонх хаалга угаах, дулаалах;
- ор дэрний хэрэглэл, хувцсыг угаах, угаалга цэвэрлэгээнд хүргэх авчирч өгөх;
- эм, тариаг эмийн сангаас авч хүргэж өгөх;
- үс засах, усанд оруулах;
- түлээ хөрөвдөж, хагалах;
- хэвлэл шуудан хүргэх;
- хоол, хүнсний бараг нь хүргэж өгөх гэх мэт.

3. Асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв нь нийгмийн халамжийн гэрийн үйлчилгээг үзүүлэхдээ төрийн бус байгууллага, сайн дурын туслагч, оюутан, сурагчдыг өөрсдийнх нь хүсэлтээр гэрээгээр ажиллуулж болно.

4. Шаардлагатай бол асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төвөөс гэрийн

байгшн үйлчлэгчийг гэрээгээр ажиллуулж болно. Байгшн үйлчлэгчийн сарын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй байх бөгөөд тухайн иргэнд үзүүлэх гэрийн үйлчилгээний төрлийг тогтоож байгшн болон сайн дурын үйлчлэгчтэй тохиролцон ажиллана.

5. Гэрийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэн, гэрийн үйлчилгээг үзүүлэх үйлчлэгчтэй Асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд үйлчилгээ үзүүлэх хугацаа, үйлчилгээний төрлийн талаар тодорхой тусгасан байна.

6. Гэрийн үйлчлэгч нарын ажилд асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв байгшн хяналт тавьж ажиллахын өмнөхдөө хуурч мэхлэх, үйлчилгээг чанаргүй хийх, үйлчлүүлэгчээс гомдол гаргасан тохиолдолд цалин хөлсийг хасах, гэрээг цуцлах, хуулийн байгууллагад хандах хүртэл арга хэмжээг авна.

7. Асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв нь төлбөртэй үйлчлүүлэгч иргэдийн талаар бүртгэл хөтөлж, график гарган гэрээнд заасны дагуу чанартай үйлчлэх үүрэгтэй.

Хоёр. Төлбөргүй үйлчилгээ үзүүлэх

8. Өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, ядуу, нэн ядуу амьдралтай, нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настан, тахир дутуу иргэд нийгмийн халамжийн гэрийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргавал тэдэнд төлбөргүй үйлчилгээ үзүүлнэ.

9. Нийгмийн халамжийн гэрийн төлбөргүй үйлчилгээнд хамруулахдаа тухайн иргэний оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

10. Ядуу, нэн ядуу амьдралтай ахмад настан, тахир дутуу иргэдийг нийгмийн халамжийн гэрийн үйлчилгээнд төлбөргүй хамруулсан тохиолдолд үйлчлэгчийн сарын цалин, тээврийн болон бусад холбогдох зардлыг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангаас олгоно.

Гурав.Төлбөртэй үйлчилгээ үзүүлэх

11. Орон байртай, ядуу бус боловч өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй ганц бие ахмад настан, тахир дутуу хүн гэрийн үйлчлэгч шаардлагатай тухай хүсэлтээ албан ёсоор тавьсан тохиолдолд асрамжийн газар болон нийгмийн халамжийн үйлчилгээний төвөөс гэрийн байгшн төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно.

12. Ахмад настан, тахир дутуу хүн асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төвд тодорхой хугацаанд байрлан асруулахаар бол ор хоногийн хөлс төлнө. Ор хоногийн хөлсөнд хоолны үнэ болон бусад бүх төрлийн үйлчилгээний хөлс багтсан байна.

13. Асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв нь өөрсдийн үзүүлэх төлбөртэй үйлчилгээний төрөл тус бүрт тохирсон үнэ тарифыг тогтоон харъяалагдах сум, дүүргийнхээ Засаг даргын Тамгын газартай зөвшилцөн батална мөрдөнө.

14. Төлбөртэй үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлт гаргасан иргэнтэй асрамжийн газар болон Нийгмийн халамж, үйлчилгээний төв гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд үйлчилгээ үзүүлэх хугацаа, үйлчилгээний төрөл, төлбөрийн тооцооны талаар тодорхой тусгасан байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны А/70 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ГУРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ИХЭР ХҮҮХДИЙГ ТӨРИЙН ЗАРДЛААР ӨСГӨЖ, ХУМҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

1. Энэхүү журмаар гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг /цаашид "ихэр хүүхэд" гэнэ/ 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжлан өсгөж, хумүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

2. Ихэр хүүхдийг асрамжлан өсгөж, хумүүжүүлэх үйлчилгээг хүүхэд асрах байгшын болон өдрийн үйлчилгээтэй /асрамжийн газар, ясли, цэцэрлэг/ байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.

3. Аймаг, хот, сумын эмнэлэг, төрөх газар ихэр хүүхдийг төрсөн өдрөөс эхлэн 1 сартай болох хүртэл хугацаанд эмнэлгийн хяналтанд эхтэй нь хамт асрамжилна. Энэ хугацааны эхийн хоолны зардлыг эмнэлэг, төрөх газар хариуцна.

4. Эцэг, эх нь хүсэлт гаргавал ихэр хүүхдийг 4 настай болтол нь аймаг, хотын

хүүхэд асрах газарт эхтэй нь хамт шилжүүлэн асарч болно.

5. Эцэг, эх нь ихэр хүүхдээ гэртээ эсэн мэнд асрамжлан өсгөж байгаа бол ихэр хүүхэд төрснөөс хойш 3 сарын дараа хүүхэд тус бүрт 20000 төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

6. Ихэр хүүхдийг 4 настай болтол нь эмнэлгийн байгууллагын хяналтанд байлгах ба үүнтэй холбогдон гарах зардлыг эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухайн эмнэлгийн байгууллага хариуцна.

7. Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг бөгөөд амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой болон хөдөлмөр эрхэлдэггүй нэн ядуу амьдралтай эх, ихэр хүүхдээ гэртээ асрамжлан өсгөж хүмүүжүүлж байгаа бол (3 нас хүртэл) жирэмсний болон амаржсаны амралтаа эдэлсний нь дараа хүүхэд асарсны тэтгэмж (хүүхэд тус бүрт) олгоно.

8. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг төрийн зардлаар өсгөж хүмүүжүүлэхэд шаардагдах зардлын норматив нийгмийн халамжийн төв байгууллага жил бүр тогтоож байна.

9. Төрийн зардлаар асрамжлан өсгөж хүмүүжүүлж байгаа ихэр хүүхдийн хоол тэжээл, хувцасны зардлыг зохих нормативийн дагуу болон хүүхдээ харж байгаа эхийн хоолны зардлыг асрамжийн газрын нэг асруулагчийн /байгууллагын/ нормативийн дагуу санхүүжүүлнэ.

10. Энэ журмын 4, 5, 6, 7-д заасан зардлыг болон эх, хүүхэд, төдийг хүргэж өгөх эмнэлгийн 1 ажилтны орон нуттаас нийслэлд хотод ирэх, буцах үнааны зардлыг тухайн аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төв нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангаас санхүүжүүлэх бөгөөд жил бүрийн төсөвт тусган батлуулна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ заавраын зорилго нь нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нийгмийн халамжийн сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох үндэсэн бичиг баримт болох жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас /цаашид эмнэлгийн хуудас гэнэ/ хэвлүүлэх, бичиж олгох, хяналт тавих үйл ажиллагаанд зохицуулахад оршино.

2. Эмнэлгийн хуудсыг Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, амаржих газруud, Нийслэлийн эрүүл мэндийн зөвлөх төв, эрүүл мэндийн төв, Клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлэг, поликлиник, Төмөр замын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлгийн поликлиник, нийгмийн эрүүл мэндийн төв, сум дундын болон сумын эмнэлэг, бусад эмнэлгийн амбулатори / цаашид эмнэлгийн байгууллага гэнэ/ бичиж олгоно.

3. Эмнэлгийн хуудас нь улсын нэгдсэн дугаартай хэвлэмэл маягт байна. Эмнэлгийн хуудсыг улсын хэмжээний хэрэгцээг үндэслэн хэвлүүлж, аймаг, нийслэл, дүүргийн захиалгын дагуу хуваарилж тараах ажлыг Улсын нийгмийн халамжийн газар хариуцна.

Хоёр. Эмнэлгийн хуудас олгох журам

4. Нийгмийн халамжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3 дугаарт заасны дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхчүүдэд жирэмсэн эхийн хяналтын карт, төрөлтийн түүх, баг, хорооны Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэн эмнэлгийн хуудсыг олгоно.

5. Аймгийн эмнэлгийн эмчилгээ чанарын хяналтын комиссын шийдвэрээр аймаг, нийслэлийн нэгдсэн болон клиникийн эмнэлэг, нарийн мэргэжлийн төвд ирсэн тохиолдолд тухайн эмнэлгийн байгууллага эмнэлгийн хуудсыг олгоно.

6. Эмнэлгийн хуудсыг жирэмсэн болон амаржсаныг тодорхойлсон эмч, төрөх тасаг, амаржих газрын бичлэгийг үндэслэн эмнэлгийн дүн бүртгэлийн их, бага эмч бичиж олгох ба энэ талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

7. Эмнэлгийн хуудсыг тухайн эмнэлгийн байгууллагын дарга /эрхлэгч, захирал/ гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

8. Эмнэлгийн хуудсыг буруу бичсэн,

засварласнаас хүчингүй болсон, мөн үрэгдүүлсэн тохиолдолд буруутай этгээдээр хуудасны үнийг төлүүлнэ. Энэ нөхцөлд эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгоогүй тухай Нийгмийн халамжийн байгууллагын тодорхойлолт, уг хуудсыг хүчингүй болгон зарлуулсан тасалбар, үнийг төлсөн баримтыг үндэслэн анх хуудас бичсэн эмнэлгийн байгууллага дахин бичиж олгоно.

9. Аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төв нь сум, хорооны нийгмийн халамжийн байдлагчаас эмнэлгийн хуудасны сарын мэдээг нийгмийн халамжийн сангийн сарын мэдээний хамт дараа сарын 2-ны дотор авч 3-нд Улсын нийгмийн халамжийн газарт ирүүлнэ.

Гурав. Эмнэлгийн хуудас бичих журам, хугацаа

10. Эмнэлгийн хуудсанд жирэмсэн болон амаржсаны аль нь болохыг доогуур нь зурж, эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлсэн өдрөөс арав хоногийн дотор, амаржсаны дараа мөн арав хоногийн дотор эмнэлгийн байгууллага тус бүрт нь 60 хоногоор бичиж олгоно.

11. Эмнэлгийн хуудсыг эмчийн хяналтаас зайлсхийсэн, энэ зааврын 10 дугаар зүйлд заасан хугацааанаас хүндэтгэх шалтгаангүйгээр хоцорсон, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн тохиолдолд олгохгүй.

12. Их, дээд сургууль, коллежид суралцдаг эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сургууль нь олгож нийгмийн халамжийн байгууллагатай тооцоо хийнэ.

Дөрөв. Эмнэлгийн хуудасны бичилтэд тавих хяналт

13. Эмнэлгийн байгууллагаас олгож буй жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудасны олголт, бичилт, зарцуулалт, мөн нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэмжийн хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын алба, нийгмийн халамжийн улсын байцаагч, Улсын нийгмийн халамжийн газар, аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төв /байцаагч/ хяналт тавина.

14. Эмнэлгийн хуудасны онош, оношийн үндэслэл, жирэмсэн эхийн хяналтын карт болон төрөлтийн түүхийн бичилт, хөтлөлтөд эмнэлгийн байгууллагын дарга /эрхлэгч/, эмчилгээ, чанарын улсын байцаагчид, Эрүүл мэндийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам хяналт тавина.

Эрүүл мэнд нийгмийн хамгаллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ЭМНЭЛГИЙН ХУУДАСНЫ ЗАГВАР

/нүүрэн тал/

НХТ-1

Жирэмсний болон амаржсаны
эмнэлгийн хуудас №

1. Овог_____нэр _____
нас_____
2. Паспортын № _____ Регистрийн № _____
3. Тэтгэмж авагчийн оршин суугаа хаяг _____
4. Хаана, ямар ажил эрхэлдэг _____
5. Жирэмсний болон амаржсаны аль нь болох /зуур/
6. Эхэлсэн ____ он ____ сар ____ өдөр
7. Дууссан ____ он ____ сар ____ өдөр
8. Хуудас олгосон ____ он ___ сар ___ өдөр
9. Эмнэлгийн нэр _____

Ерөнхий эмч /_____/_____/
гарын үсэг нэр
Эмчлэгч эмч /_____/_____/
гарын үсэг нэр

/ар тал/

ТЭТГЭМЖ ОЛГОСОН
ТУХАЙ ТОДОРХОЙЛОТ

1. Засгийн газрын ____ оны ___ дугаар тогтоолоор тогтоогдсон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ _____төгрөг
2. Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс _____ төгрөг
3. Тэтгэмж олгох хоног _____
4. Олгох тэтгэмж /2х3/ _____ төгрөг

Тэтгэмж хүлээн авсан эх
/_____/_____/
гарын үсэг нэр
Дарга_____/_____/
/гарын үсэг/ /нэр/
Тамга
Нягтлан Бодлогч_____/_____/
/гарын үсэг/ /нэр/
Хянасан: Нийгмийн халамжийн байцаагч
Тамга
/гарын үсэг/ /нэр/
_____ оны _____ сар_____өдөр

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

ТАХИР ДУТУУГИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

1. Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дахь заалтын дагуу тахир дутуугийн үнэмлэх олгоход энэхүү журмыг баримтлана.

2. Иргэний тахир дутуу болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, түүний хугацаат тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

3. Тахир дутуу хүнийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар бүрттэж үнэмлэх олгоно.

4. Тахир дутуугийн үнэмлэх олгохдоо дор дурдсан баримт бичгийг үндэслэл олгоно. Үүнд:

а/ аймаг, сум, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

б/ тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

в/ иргэний паспорт (иргэний үнэмлэх) буюу төрсний гэрчилгээ;

5. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар /Нийгмийн халамж, үйлчилгээний төв, халамжийн байцаагч/ тахир дутуу хүн бүрт хувийн хэрэг нээж, ямар хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдсан тухай тэмдэглэл хөтөлнө.

6. Тахир дутуугийн үнэмлэхийн улсын хэмжээний хэрэгцээг үндэслэн хэвлүүлж, аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвд захиалгын дагуу хүвааралж тараах үүргийг Улсын нийгмийн халамжийн газар гүйцэтгэнэ.

7. Тахир дутуугийн үнэмлэхийг бүсдад дамжуулахыг хориглоно.

8. Тахир дутуугийн үнэмлэхийг гээгдүүлсэн, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд зохих журмын дагуу зарлуулан хүчингүй болгож, аймаг, сум, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвд бүрттүүлнэ.

9. Тахир дутуугийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэн хохирол учруулсан иргэн, бүрүү олгосон албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 8 дугаар хавсралт

ТАХИР ДУТУУГИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

Дугаар_____ Овог _____ Нэр _____ Паспорт _____ Регистр _____ Эмнэлэг хөдөлмөрийн магад-лах комиссын .. тоот шийдвэрийг үндэслэн тахир дутуугийн үнэмлэх олгов.	___ оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хүчинтэй. _____аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга _____( )
	___ оны __ дугаар сарын__-ныг дуустал хүчинтэй. _____аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга _____ ( )

Тайлбар: Үнэмлэхийн өргөн 6 см, урт нь 17 см байна.
Үнэмлэх цэнхэр өнгөтэй байна.
Үнэмлэхийн гадна нүүрэн талд "ҮНЭМЛЭХ" гэж бичсэн байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт

УЛСЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улсын нийгмийн халамжийн газрын /цаашид газар гэнэ/ үндсэн зорилт нь Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн халамжийн санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, хяналт тавих, халамжийн сангаас тухайн төрлийн төтгөвэр, төтгөмж, төлбөрийг цаг тухайд нь олгох, улсын нийгмийн халамжийн тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулах, сургалт сурталчилгаа явуулах, орон нутгийн нийгмийн халамжийн байгууллага, ажилтан нарын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад чиглэгдэнэ.

2. Улсын нийгмийн халамжийн газар нь газрын нийгмийн халамжийн зөвлөлтэй /орон тооны бус/ байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг газрын даргын тушаалаар батална.

3. Газар нь бие даасан үйл ажиллагаа явуулж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлагын дор ажиллана.

4. Газар нь аймаг, нийслэлийн дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

5. Газрын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

6. Газрын дарга нь нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч байна.

7. Газар нь тогтоосон журмаар хийсэн төмдөг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8. Газар нь Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжуудын дагуу дотоод журмаа баталж мөрдөнө.

Хоёр. Улсын нийгмийн халамжийн газрын үүрэг, эрх

9. Газар дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

9.1. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга чалал, журам гаргах, хэрэгжилтэнд хяналт тавих;

9.2. Нийгмийн халамжийн санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

9.3. Нийгмийн халамжийн сангаас тухайн төрлийн төтгөвэр, төтгөмжийг цаг тухайд нь олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

9.4. Нийгмийн халамжийн доод шатны байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, хяналт тавих, шаардан зааварлах, төрөүүний арга барилыг сурталчлах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

9.5. Нийгмийн халамжийн тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

9.6. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, тэдгээрт дэмжлэг туслалцаа үзүүлэх;

9.7. Олон улсын болон гадаад орны нийгмийн халамжийн байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллах;

9.8. Нийгмийн халамжийн хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, иргэдийг нийгмийн халамжийн талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах;

9.9. Нийгмийн халамжийн холбогдолтой маягт, бичиг баримтын загвар боловсруулж батлуулах, хэвлүүлж хэрэглэх;

9.10. Иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг хянаж шийдвэрлэх;

9.11. Нийгмийн халамжийн байгууллагыг өндөр мэргэжил, мэдлэгтэй, үнэнч шударга, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдгээрийн мэргэжлийг дээшлүүлэх;

9.12. Халамжийн сангуудын жилийн орлого, зарлагын төсөв, халамжийн санд улсын төсвөөс олгох татаас болон нийгмийн халамжийн байгууллагын төсвийг жил бүр зохиож улс, орон нуттийн төсвийн төсөлд тусгуулах;

9.13. Нийгмийн халамжийн төвлөрсөн санд улсын төсвөөс шилжүүлсэн хөрөнгийг аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн халамжийн санд цаг тухайд нь хүргэж, зарцуулалтад нь хяналт тавих;

9.14. Нийгмийн халамжийн сангуудын болон байгууллагын төсвөт зардлын нэгдсэн тайланг улирал бүр, мэдээг сар бүр гаргаж, санал дүгнэлтийн хамт холбогдох байгууллагад танилцуулах;

9.15. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг ядуурлыг бууруулах үйл ажиллагаатай нягт уялдуулан явуулах.

10. Нийгмийн халамжийн газар нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

10.1. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өөрчлөх санал боловсруулж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;

10.2. Аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд төвлөрүүлэн авч, нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах;

10.3. Нийгмийн халамжийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам гаргах, норм норматив тогтоох хэрэгжилтэд хяналт тавих;

10.4. Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн албан тушаалтны гаргасан шийдвэр нь үнэлэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

10.5. Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох бусад баримт бичгийг үнэ төлбөргүй гаргуулан авах;

10.6. Нийгмийн халамжийн байгууллагын ажилтнуудын ажилд үнэлэлт дүгнэлт өгөх;

10.7. Олон улсын болон гадаад орны нийгмийн халамжийн байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоож хамтран ажиллах.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын
1999 оны А/70 дугаар тушаалын 10 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилт нь Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, нийгмийн халамжийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагаа түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар санал тавих, сургалт сурталчилгаа явуулах, хууль тогтоомж зөрчигчдэд арга хэмжээ авах эрх бүхий нийгмийн халамжийн улсын байцаагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд оршино.

2. Нийгмийн халамжийн улсын байцаагч нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүн амын эмзэг хэсгийнхний хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах зарчим баримтална.

3. Төрийн захиргааны төв, орон нуттийн байгууллага, тэдгээрийн ажилтан нь нийгмийн халамжийн хяналтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр ханган нийгмийн халамжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй.

4. Бүх шатны нийгмийн халамжийн байгууллага нь нийгмийн халамжийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийгмийн халамжийн улсын байцаагчтай байна.

5. Нийгмийн халамжийн улсын байцаагчийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилно.

6. Улсын нийгмийн халамжийн газрын дарга нь нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч байна.

7. Нийгмийн халамжийн улсын байцаагч нь үнэмлэхтэй байх бөгөөд хувийн төмдэг, шаардах хуудас хэрэглэнэ.

Хоёр. Нийгмийн халамжийн улсын байцаагчийн үүрэг

8. Нийгмийн халамжийн улсын байцаагч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

8.1. Нийгмийн халамжийн холбогдолтой хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах;

8.2. Нийгмийн халамжид хамрагдын баримт бичгийн бүрдэл, төтгэвэр, төтгэмжийн олголт, асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах;

8.3. Нийгмийн халамжийн сан болон халамжийн үйл ажиллагаанд олгосон хөрөнгө, зээл, тусламж, хандивын орлогын зарцуулалтад хяналт, шалгалт хийх;

8.4. Нийгмийн халамж, үйлчилгээний төв, орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаат шалгаж мэргэжлийн зөвлөгөө, удирдамж, чиглэл өгөх, мэдээллээр хангах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн гомдол, мэдээллийг шалгаж дүгнэлт гаргах;

8.5. Халамжийн сангуудын орлого, зарлагын төсвийг жил бүр хугацаанд нь боловсруулж сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төсөвт тусгуулах, улирал, жилийн тайлан тэнцэл, сарын мэдээ, төсвийн төлөвлөгөөний үндэслэлийг зохих журмын дагуу гаргасан байдлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт гаргах;

8.6. Нийгмийн халамжийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

Гурав. Нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх

9. Нийгмийн халамжийн улсын байцаагч дараах эрхтэй байна. Үүнд:

9.1. Нийгмийн халамжийн хөрөнгийн зарцуулалт, тайлан тэнцэл болон санхүүгийн бусад бариментай хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

9.2. Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

9.3. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг нийгмийн халамжийн талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах;

9.4. Төтгэвэр, төтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг буруу олгож байсныг гэрчлэх баримтыг олгогч байгууллага, ажилтан болон төтгэвэр, төтгэмж, хөнгөлөлт авагч иргэнээс хураан авах, хуулбарлах;

9.5. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, халамжийн тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, санал боловсруулах;

9.6. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж зөрчсөн болон хуурамч бичиг баримт бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр нийгмийн халамжийн төтгэвэр, төтгэмж авсан, нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд хамрагдсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх;

9.7. Нийгмийн халамжийн сангийн бүртгэл тооцоог будлиантуулах, хөрөнгийг буруу олгох, зориулалтын бус зүйлд зарцуулах, хэзээ хахууль авах, сангийн хөрөнгийг хувийн зорилгодоо ашиглах зэргээр албан тушаалтны үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нийгмийн халамжийн ажилтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРААС ГАРГАВ.

Хаяг: "ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар 12 Утас: 329612, 322838
Төрийн орон Индекс: 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын хэрлэх Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Утас: 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны дөрөвдүгээр сарын 30 №20 (99)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

168. Конвенцид нэгдэн орох тухай (1999-4-22-ны хууль) 265

169. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-4-22-ны хууль) 266

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

170. Нөхөн олговрын талаар зарим арга хэмжээ авах болон нөхөн олговрын доод хэмжээ тогтоох тухай Дугаар 24 267

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

171. Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 60 268

172. Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 61 268

Дөрөв. Яам, агентлагийн акт

173. Фенацитинийг эмчилгээнд хэрэглэхийг хориглох тухай (Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын сайдын тушаал) Дугаар А/16 268

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Конвенцид нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. Вена хотод 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай" нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

1999 он № 20 (99)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"3. Зөвлөлийн төргүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч байна. Зөвлөлийн төргүүн нь Зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдаж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

2/ Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэмэх-дүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулах;

3/ төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэхэд Зөвлөлийг тогтоолох;

4/ Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

5/ хуульд заасан бусад бүрэн эрх.

4. Зөвлөлийн гишүүн нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ үндэсний аюулгүй байдал болон төрийн гадаад, дотоод бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс улс орны төр, нийгмийн амьдралд дун шинжилгээ хийлгэж, авах шаардлагатай арга хэмжээний талаар санал боловсруулан Зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

2/ Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллага, түүний дотор үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагын ажилтай танилцах, чиглэл зөвлөгөө өгөх;

3/ Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг эрхэлсэн ажлын хүрээнд зохион байгуулах;

4/ Зөвлөлийн ажлын хэсэгт чиглэл, үүрэг, даалгавар өгөх;

5/ өөрийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахын өмнө Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж байх;

6/ хуульд заасан бусад бүрэн эрх."

2/8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна."

3/10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"3. Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээлийн нэгдсэн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалттай байна.

4. Зөвлөлийн ажлын алба нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй байна.

2 дугаар зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "хяналтдаа авах" гэснийг дараа "эрдэм шинжилгээний теслийн хэлбэрээр санхүүжүүлэх", 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Зөвлөлийн" гэсний дараа "ажлын албаны болон" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 2 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 1, 5, 6 дахь заалт, 5 дугаар зүйлийн нэр, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 2, 3, 6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдснаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйл:

"2 дугаар зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь /цаашид "Зөвлөл" гэх/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрэхэн хангагдаж байгааг хянаж төрийн зөвлөлдөх байгууллага мөн."

2/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

1. "Зөвлөл нь дараахь асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй:"

3/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

"1/ өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дун шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндэсэн хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгуулалт бататтгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах:"

4/4 дүгээр зүйлийн 5, 6 дахь заалт:

"5/ гадаад орон, олон улсын байгууллагатай төр, засгийн дээд хэмжээний хэлэлцээрийн үед бариитлах чиглэл, гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой асууллаар төр, засгийн дээд хэмжээнд байр суурия илэрхийлэхдээ төрийн гадаад бодлогод нийцүүлэн зөвлөлдөн тогто х:

6/ төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зо-

хион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;"

5/5 дугаар зүйлийн нэр:

"5 дугаар зүйл. Зөвлөлийн төрүүн, гишүүд, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг."

6/5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Хууль тогтоомжид заасан үндэслэлээр Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал зохих өөрчлөлт оруулж болно."

7/6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн чиг үүргэгт хамаарах асуудлаар судалгаа хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдэрийн үндэслэлийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн гишүүд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах, тэднийг үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа, мэдээллээр хангах дотоод ажлыг эрхэлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга уг албан тушаалыг хаших хугацаанд түүний улс төрийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

3. Улсын Их Хурлын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ахлагч нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно."

8/6 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Зөвлөл нь үндэсний аюул сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий чиглэл, дотоодын болон олон улсын үйл явдал зэрэг шаардлагатай гэж үзсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, судалгаа явуулах эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй байж болно."

9/8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Зөвлөл нь ажлын албатай байна."

10/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийн нэгдсэн сантай байна. Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн холбогдох байгууллагууд, иргэд, гадаадын эх сурвалжаас ирүүлсэн бүх төрлийн мэдээллээс бүрдэнэ."

4 дүгээр зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс "/Зөвлөлийн тэргүүн/" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 24 **Улаанбаатар хот**

Нөхөн олговрын талаар зарим арга хэмжээ авах болон нөхөн олговрын доод хэмжээ тогтоох тухай

Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар тогтоолын 1-ийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл болзлыг хангаагүй нөхөн олговор авч байгаа иргэдийн нөхөн олговрын хэмжээг аминжиргааны доод түвшингийн хэмжээ, тэдний бодит орлого, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өөрчлөлттэй уялдуулан өөрчлөх саналаа Улсын төвлөрсөн төсвийн төсөлд тухай бүр тусган, Улсын Их Хурлаар батлуулж байхыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

2. Нөхөн олговрын доод хэмжээг 11000 төгрөг байхаар тогтоож 1999 оны5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

3. Энэ тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн нөхөн олговорт шаардагдах нэмэгдэл эх үүсвэрийг 1999 оны Улсын төвлөрсөн төсвийн тодотголд тусгахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

4. Энэ тогтоолыг 1999 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот

Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Бэгзийн Дамбыг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн Цогбадрахын Мөнхтүвшинг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Санжаажавын Дорждагвыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Золзаяагийн Золзаяа Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Мандаагийн Барсболдыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Баадгайн Чулуунсүхийг Дорноговь аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Бадарчийн Бямбахорлоог Булган аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн албан тушаалаас түр туг чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Санжаажавын Дорждагвыг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчийн, Дашдоржийн Золзаяаг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Базаргүрийн Нүрээдмаар Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн, Цэвгээгийн Ганбатыг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Лхан-Аагийн Баасангэрэлийг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Бадарчийн Бямбахорлоог Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Өлзийсүрэнгийн Рэнцэнгэлжидийг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Баадгайн Чулуунсүхийг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд түр туг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар А/16 | Улаанбаатар хот

Фенацитинийг эмчилгээнд хэрэглэхийг хориглох тухай

Хүний эмийн салбар зөвлөлийн 1998 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 02 тоот тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний биед үзүүлэх гаж нөлөө ихтэйг харгалзан фенацитинийг 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн эмчилгээнд хэрэглэхийг хориглосугай.

2. Фенацитин найрлагад нь орсон эм үйлдвэрлэхийг 1999 оны 2 дугаар сарын 1-нээс зогсоохыг эмийн үйлдвэр эрхэлдэг бүх байгууллагын захирал /дарга/ нарт үүрэг болгосугай.

3. Фенацитин болон түүний найрлага бүхий эмийн үйлдвэрлэл, худалдаа, импортод хяналт тавьж, гаж нөлөөний талаар сурталчилгаа хийж ажиллахыг Эм биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын алба /А.Дамдинсүрэн/-д даалгасугай.

САЙД С.СОНИН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны тавдугаар сарын 12 №21 (100)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

174. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-4-22-ны хууль) 270

175. Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх байгуулах, зарим шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөх тухай (1999-4-22-ны хууль) 271

176. Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-4-22-ны хууль) 272

177. Орон сууцны тухай (1999-4-22-ны хууль) 272

178. Орон сууц хувьчлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-4-22-ны хууль) 276

179. Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-4-22-ны хууль) 276

180. Хэлэлцээр соёрхон батлах тухай (1999-4-30-ны хууль) 277

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

181. Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогыг батлах тухай Дугаар 25 277

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

182. Ж.Ядамсүрэнд албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 62 281

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт

183. Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 282

Тав. Яам, агентлагийн акт

184. Журам батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 32 283

185. Хөтөлбөр батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 39 285

186. Заавар батлах тухай (Монгол Улсын Гэгээрлийн сайдын тушаал) Дугаар 49 289

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Нэхэмжлэл гаргах үед түүний үнийг шууд тогтоохоо бэрхшээлтэй байвал шүүгч улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг урьдчилан тогтоож, тухайн хэрэг шийдвэрлэгдэнийг дараа шүүхээс тогтоосон нэхэмжлэлийн үнэд тохируулан нөхөн төлүүлэх буюу урьд илүү төлөгдсөн бол зөрүүг буцааж олгоно.";

2/56 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Зохигчдын эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу хүчадаг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлж болно.";

3/57 дугаар зүйл:

"57 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийг буцаах

1.Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг хураасан хэмжээгээр буцаан олгоно.

2.Нэхэмжлэгч шаардлагаа багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, зохигчид эвлэрэн хэлэлцэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.";

4/172 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"8/энэ хуулийн 37 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг шийдвэрлээсэн.".

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "56" гэсний дараа "57,";

60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "нэхэмжлэлд" гэсний дараа "улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт,";

65 дугаар зүйлийн "үзвэл" гэсний дараа "нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор";

72 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "14 хоногийн дотор" гэсний дараа ", эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд";

94 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "татгалзан гаргасан" гэсний дараа ", эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй болсон" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/56 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй буюу хуульд заасан бусад үндэслэлээр түүнийг төмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.";

2/71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Хуулиар тусгай хугацаа тогтоогоогүй бол хэргийг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, дахин шийдвэрлүүлэхээр иргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.";

3/87 дугаар зүйл:

"87 дугаар зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдааны оролцогчдод мэдэгдэх хүүдас хүргүүлэх, шүүх хуралдаан явуулах байр, танхимыг бэлтгэх, шүүх хуралдааны ирцийг бүртгэж шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, хуралдааны ажиллагаат тэмдэглэл үйлдэж баталгаажуулах, шүүхийн шийдвэрийг хүргүүлэх, хэргийг цэгцлэж үдэх, архивт шилжүүлэх ажиллагаат хийж гүйцэтгэнэ."

4 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах шаардлагатай гэж үзвэл" гэснийг "нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн";

122 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "10" гэснийг "5";

129 дүгээр зүйлийн "захирамжийг хэргийн байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан" гэснийг "захирамж нь илт үндэслэл муутай гарсан буюу, эсхүл хэргийн байдал өөрчлөгдсөн бол";

177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шүүгч" гэснийг "Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч";

178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шүүгчийн" гэснийг "Улсын

дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн , Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр ажиллагаанд байгаа хэргийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийг бүцаан хэрэглэхгүй.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН 2 ДУГААР ШҮҮХ БАЙГУУЛАХ, ЗАРИМ ШҮҮХИЙН БАЙРШИЛ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ХАРЬЯАЛЛЫГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийг байгуулж, Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 24[1] дэх заалт нэмсүгэй:

"24[1].Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх	Бор-Өндөр хот	Галшар, Дэлгэрхаан Баянмөнх, Дархан сум, Бор-Өндөр хот"

2 дугаар зүйл. Дорноговь аймаг дахь сум дундын 1, 2 дугаар шүүхүүд, Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөн тогтоож, Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн "Сум дундын шүүх" гэсэн 2 дахь хэсгийн 6, 7, 24 дэх заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх	Сайншанд хот	Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх, Айраг, Даланжаргалан, Сайхандулаан, Мандах сум, Хажуу-Улаан, Зүүнбаян хороо, Сайншанд хот
7.Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх	Замын-Үүд	Өргөн, Эрдэнэ, Хөвсгөл, Улаанбадрах, Хатанбулаг, Замын-Үүд сум",
"24.Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх	Хэрлэн сум	Цэнхэрмандал, Мөрөн, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр,Баян-Адарга, Дадал, Норовлин, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сум"

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 1 дэх заалт:

"1/ эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд:

Нэхэмжлэлийн үнэ /төгрөгөөр/	Хураамжийн хувь хэмжээ
0-3000	50 төгрөг
3001-10000	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2 хувь
10001-50000	200 төгрөг дээр 10000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3,5 хувийг нэмнэ.
50001-500000	1500 төгрөг дээр 50000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4 хувийг нэмнэ.
500001-1000000	19500 төгрөг дээр 500000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2,1 хувийг нэмнэ.
1000001-10000000	30000 төгрөг дээр 1000000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 1,4 хувийг нэмнэ.
10000001-ээс дээш	156000 төгрөг дээр 10000000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0,5 хувийг нэмнэ."

2/19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Шүүхэд нэхэмжлэл гаргагч хураамжийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлж энэ тухай баримтыг нэхэмжлэлийн хамт ирүүлнэ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх сан, түүнийг захиран зарцуулах, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Орон сууцны тухай хууль тогтоомж

2.1.Орон сууцны тухай хууль тогтоомж нь Үндэсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, Дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."орон сууц" гэж хүн сууршин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг;

3.1.2."орон сууцны дэд бүтэц" гэж орон сууцны цахилгаан, холбоо, дулаан, усан хангамж, бохир, хог хаягдлын зайлуулалт болон инженерийн бусад шугам сүлжээ, орон сууцны орчны зам, талбайг;

3.1.3."орон сууц хөгжүүлэх сан" гэж орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх зориулалттай мөнгөн санг;

3.1.4."орон сууц өмчлөгч" гэж тухайн орон сууцыг захиран зарцуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагыг.

4 дүгээр зүйл.Төрөөс орон сууцны талаар баримтлах зарчим

4.1.Төрөөс орон сууцны талаар дараахь зарчим баримтална:

4.1.1. иргэд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан орон сууцаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлж өгөх;

4.1.2.орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд зах зээлийн эдийн засгийн үндэсн шаардлагад тулгуурлах;

4.1.3.орон сууц, түүний дэд бүтцийг төлөвлөх, барих, засварлах ажилд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, үүрэг хариуцлагыг нь дээшлүүлэх;

4.1.4.гэр хорооллын орон сууцыг тохижсон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОРОН СУУЦНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮРЭН ЭРХ

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Улсын Их Хурал орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хүн амын эмзэг хэсэг, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах төрийн бодлогыг тодорхойлж,хэрэгжилтэд нь хяналт тавих;

5.1.2.орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэхэд төрөөс олгох хөрөнгийн хэмжээг тогтоох.

6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогын хүрээнд орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

6.1.2.орон сууцны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах.

7 дугаар зүйл.Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.2.орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, стандарт боловсруулж батлах;

7.1.3.орон сууц хөгжүүлэх улсын сангийн үйл ажиллагааг зохицуулан удирдаж, хяналт тавих;

7.1.4.орон сууцны тухай хууль тогтоомж, дүрэм, заавар, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.5.орон сууцны мэдээллийн нэгдсэн сан байгуулах.

8 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

8.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.нутаг дэвсгэртээ орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах болон хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

8.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах;

8.1.3.орон сууц хөгжүүлэх орон нутгийн санд аймаг, нийслэлийн төсвөөс оруулах хөрөнгийн хэмжээг тогтоох.

8.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.2.1.нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөл боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

8.2.2.орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.2.3.орон сууцны мэдээллийн сан эрхлэн хөтөлж, холбогдох мэдээллийг орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өгөх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН СУУЦ ТӨЛӨВЛӨХ

9 дүгээр зүйл.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө

9.1.Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

9.2.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөнд төв, суурин газрын гэр хороолол, барилгажсан хэсэг дэх орон сууцны хорооллуудыг хамруулна.

9.3.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөнд орон сууц, түүний дэд бүтэц, зам

талбай, сургалт хумүүжлийн болон үйлчилгээний байгууллагуудын байршлыг иж бүрнээр тусгана.

9.4.Орон суутны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

9.4.1.тухайн нутаг дэвсгэрт орон суутны дэд бүтцээгээ нь хамт төлөвлөж хөгжүүлэх, орон суутн нэмж барихад түүнийг дэд бүтцийн сүлжээнд ур ашигтайгаар холбох;

9.4.2.оршин суугчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханагах;

9.4.3.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, үр дагавар гаргуулахгүй байх.

9.5.Орон суутны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэлийн орон суутн хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулна.

9.6.Иргэдэд орон суутны зориулалтаар газар олгоход орон суутны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөг үндэс болгоно.

9.7.Тухайн төв, суурин газарт орон суутны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөгүй бол орон суутны зориулалтаар газар олгоход энэ хуулийн 9.4-т заасан шаардлагыг биелүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОРОН СУУЦ ХӨГЖҮҮЛЭХ САН

10 дугаар зүйл.Орон суутн хөгжүүлэх сан, түүнийг эрхлэх байгууллага

10.1.Орон суутн хөгжүүлэх санг орон суутны хангамж нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд ашиглана.

10.2.Орон суутн хөгжүүлэх улсын сан нь орон суутны асуудал хариудсан төрийн захиргааны эрх бүхий байгууллагын; орон суутн хөгжүүлэх орон нутгийн сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд тус тус байна.

10.3.Орон суутн хөгжүүлэх улсын болон орон нутгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журмыг Засгийн газар тогтооно.

11 дүгээр зүйл.Орон суутн хөгжүүлэх сангийн орлогын эх үүсвэр

11.1.Орон суутн хөгжүүлэх сангийн орлого дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

11.1.1.орон суутн хөгжүүлэх санд улсын төвлөрсөн болон аймаг, нийслэлийн төсвөөс олгох хөрөнгө;

11.1.2.сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

11.1.3.олон улсын байгууллага, гадаад улс, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс орон суутн хөгжүүлэх санд оруулсан хандив, тусламж;

11.1.4.эдлийн үйл ажиллагааны орлого;

11.1.5.үнэт цаас худалдсанаас олсон орлого;

11.1.6.бусад эх үүсвэр.

12 дугаар зүйл.Орон суутн хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах

12.1.Орон суутн хөгжүүлэх сангийн хөрөнгийг дор дурдсан зардал санхүүжүүлэхэд зарцуулна:

12.1.1.дундын болон хувийн өмчийн орон суутн, түүний дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах, шинээр барих;

12.1.2.энэ хуулийн 12.1.1-д заасан зориулалтаар иргэд, хуулийн этгээдэд зээл олгох;

12.1.3.хүүлэд заасан бусад зардал.

12.2.Орон суутн хөгжүүлэх сангийн хөрөнгийг энэ хуулийн 12.1-д зааснаас өөр зориулалтаар ашиглахыг хоригломо.

13 дугаар зүйл.Орон суутн хөгжүүлэх сангийн төсвийг батлах

13.1.Орон суутн хөгжүүлэх улсын санд улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал жил бүр тогтооно.

13.2.Орон суутн хөгжүүлэх орон нутгийн санд аймаг, нийслэлийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвт тусгайлан заяж батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИН АШИГЛАХ

14 дүгээр зүйл. Нийтийн зориулалттай орон суутны байшингийн засвар, үйлчилгээ

14.1.Суутц өмчлөгч нь дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээ, дэвсгэр газар, орчны зам, талбайн тохижилтын ажлыг тогтмол хийж, Дундын өмчлөлийн орон суутны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу холбогдох зардлыг хариудна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан засвар, үйлчилгээ, тохижилтын ажлыг суутц өмчлөгч өөрөө хийж, эсхүл эрх бүхий мэргэжлийн байгууллага буюу хувь хүнээр Иргэний хуульд заасан гэрээний үндэсэн дээр гүйцэтгүүлж болно.

14.3.Орон суутны инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан тухай бүр оршин суугч нь эрх бүхий мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэж засвар, үйлчилгээ хийх хүнийг саадгүй нэвтрүүлж, түүнд шаардлагатай тусламцаа үзүүлэх үүрэгтэй.

14.4.Оршин суугч нь эзгүй үед суутанд ус алдах, гал гарах зэрэг бусад оршин суугчдын аюулгүй байдал, эд хөрөнгөд хохирол учруулахуйц эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл тухайн суутанд нэвтрэн орж эвдрэл, гэмтлийг арилгаж болох бөгөөд энэ тухай Суутц өмчлөгчидийн холбоо буюу оршин

суугчдын төлөөлөгчийг байлцуулан акт үйлдэж эзгүй байсан оршин суугчийн эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна.

14.5.Орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учуулахыг хориглоно.

15 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх

15.1. Сууц өмчлөгч нь эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд орон сууцны зориулалт, төлөвлөлт, барилгын үндсэн бүтээц, хийц болон инженерийн шугам сүлжээг орон сууцны барилгын анхны зураг төслөөс өөрчлөхийг хориглоно.

15.2. Нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь сууцны зориулалтыг өөрчлөх, уг сууцыг орон сууцны сангаас хасах, түүнчлэн сууцны төлөвлөлт, үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг өөрчлөхөд тавих шаардлага, зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг орон сууцны асуудал хариуцан төрийн захиргааны төв байгуулага тогтооно.

16 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх

16.1.Сууц өмчлөгч нь бусад оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр энэ хуулийн 17.1-д зааснаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ суууандаа эрхэлж болно.

16.2.Тусгай зөвшөөрөл авах шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ суууандаа эрхлэх тохиолдолд сууц өмчлөгч нь хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсан байна.

16.3.Мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь орон сууцны тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, тухайн орон сууцны Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасны дагуу суууандаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаат хянан шалгана.

16.4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн эрх бүхий байгууллага нь сууц өмчлөгчийн эрхийг шууд буюу шууд бус хэлбэрээр хязгаарлахыг хориглоно.

17 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглох

17.1. Нийтийн зориулалттай орон сууцны байшинд барилгын төлөвлөлт, эрүүл ахуй, аюулгүй байдлын норм зөрчсөн, мөн дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно:

17.1.1.химийн хорт бодистой харьцах;

17.1.2. ахуйн хэрэгцээнд шаардагдахаас бусад тэсэрч дэлбэрэх, галд амархан шатдаг материал хадгалах, худалдах;

17.1.3.хүрц үнэртэй материал, бодис хадгалах, худалдах;

17.1.4.цацраг идэвхт бодис, цахилгаан соронзон орон үүсгүүр, нянгийн амьд өсгөвөр, пестицид ашиглах;

17.1.5.даралтат сав, уурын тоног төхөөрөмж ашиглах;

17.1.6.арьс шир, түүхий эд хүлээн авах, худалдах;

17.1.7.саун болон угаалгын газар ажиллуулах;

17.1.8.согтуурууллах ундаа үйлдвэрлэх;

17.1.9.хууль тогтоомжоор хориглосон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

18.1.Орон сууцны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээл-гэхээргүй бол мүүгч буюу улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

18.1.1.орон сууцны дэвсгэр газар болон орчны зам, талбайг зориулалтын бусаар ашиглаасан, зам, талбайн хөдөлгөөнийг хаасан иргэнийг 15000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

18.1.2.ус алдах, цахилгаан таслах зэргээр орон сууц ашиглалтын журам зөрчсөн иргэ-нийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

18.1.3.төв, суурин газарт зөвшөөрөл-түйгээр орон сууц барьсан иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

18.1.4.орон сууцны төлөвлөлт, барилгын үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслөөс өөрчилсэн иргэнийг 40000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

18.1.5.энэ хуулийн 17.1-д заасныг зөрчсөн иргэнийг 40000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

18.2.Орон сууцны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэсэн эсэхийг харгалзахгүйгээр бусдад учруулсан хохирлыг нь хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх буюу арилгуулна.

18.3.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл.Маргаан хянан шийдвэрлэх

19.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо ерөнхий байцаагчид гаргана.

19.2.Ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Орон сууц хувьчлах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь заалтын "бүртгэл хөтлөх" гэсний дараа "магадлан шинжлэх хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Орон сууц хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4/"орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө" гэж Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг;"

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төгсгөлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"Төрийн эрх бүхий байгууллагын төлөөлөгч гишүүдийн хуралд төрийн өмчийн сууц бүрийн тоогоор саналын нэг эрхтэй оролцоно. Харин дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг хуваарилах асуудлаар шийдвэр гаргахад хуралд оролцож буй бусад сууц өмчлөгчдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар шийдвэрлэнэ."

2 дугаар зүйл.Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн эхэнд "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 /4 дүгээр зүйл:

"4 дүгээр зүйл.Дундын өмчлөлийн эд хөрөнгө

1.Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд дараахь зүйл хамаарна:

1/нийтийн зориуллаттай орон сууцны байшингийн гадна хана, даацын хана, багана, зоорийн давхар, дээвэр, цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууцны бус зориуллаттай техникийн өрөө, сууц хоорондын талбай, түүний тагт, тоног төхөөрөмж, орцны цонх, хаалга, довжоо, саравч, хог зайлуулах хоолой, халаалт, халуун, хүйтэн усны удирдах зангилааны анхны хаалт хүртэлх, цахилгааны ороолтын самбар хүртэлх, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, орон сууцны байшингийн ±0.00 тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээнүүд;

2/хязгаартай ашиглах дундын өмчлөлийн эд хөрөнгө: тухайн сууцны гадна буюу дотор байгаа нэг буюу хэд хэдэн сууцанд үйлчлэх инженерийн шугам сүлжээ, салхижуулалтын хоолой, давхрын хаалга, цонх, төрөл бүрийн хаалт, довжоо, саравч, тагт, сэрүүн тавцан болон бусад тоног төхөөрөмж;

3/орон сууцны дэвсгэр газрыг эзэмших, ашиглах эрх.

2.Сууц өмчлөгчид нь дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчилнө.

3.Орон сууцны дэвсгэр газрын өмчлөлийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасан бол дундын өмчлөлийн эд хөрөнгийг Иргэний хуульд заасан гэрээний үндэсэн дээр тодорхой нэг этгээдэнд эзэмшил, ашиглалтад олгож болно.

5.Сууц өмчлөгчид нь орон сууцны байшингийн доторх дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх, орон сууцны дэвсгэр газрыг эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхдээ инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхэлж буй эрх бүхий мэргэжлийн байгууллагад саад учруулахыг хориглоно.";

2/5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл.Дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилах

1.Орон сууцны байшингийн гадна хана, даацын хана, багана, зоорийн давхар, цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын талбай, түүний тагт, тоног төхөөрөмж, орцны цонх, хаалга, довжоо, сарвэн, хог зайлуулах хоолойн засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлоход уг зардлыг тухайн орон сууцны байшин дахь нийт сууцны тоонд хуваана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд сууц, сууцны бус зориулалттай хэсгийн өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлоход түүний өмчилж байгаа сууц, сууцны бус зориулалттай хэсгийн талбайг тухайн орон сууцан дахь сууц, сууцны бус зориулалттай хэсгийн нийт талбайн нийлбэрт харьцуулсан харьцаагаар тодорхойлно.

3.Хязгаартай ашиглах дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг тухайн эд хөрөнгийг ашиглаж байгаа сууц өмчлөгчид хуваах төлнө.

4.Хувьчлагдсан орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн их засварт зориулан сууц өмчлөгчдийн холбоонд төрөөс зохих хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлттэй, удаан хугацааны зээл олгож болно.

5.Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасан бол дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг дараахь тохиолдолд дор дурдсан сууц өмчлөгчдөөр бусад сууц өмчлөгчдөөс илүү өндөр хэмжээгээр төлүүлж болно:

1/дундын өмчлөлийн зарим эд хөрөнгийн засвар, үйлчилгээ нь тодорхой сууц өмчлөгчийн ашиг сонирхолд бусдынхаас илүү нийцэж байгаа;

2/сууц, сууцны бус зориулалттай хэсэгт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа.

6.Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн ашиглалт /халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг/-ын төлбөрийг эрх бүхий мэргэжлийн байгууллагад, дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг сууц өмчлөгчдийн холбоонд тус тус төлнө."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хооронд 1998 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан дор дурдсан хэлэлцээрүүдийг Засгийн газрын өргөн мэдүүлснийг дагуу соёрхон батлагдсугай:

1/"Харилцаа холбоо П" төслийн Зээл, санхүүжилтийн болон Төслийн хэлэлцээр;

2/"Харилцаа холбоо Ш" төслийн Зээлийн болон Төслийн хэлэлцээр.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 25 **Улаанбаатар хот**

Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогыг хавсралтаар батлагдсугай.

2.Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогын хүрээнд орон сууцны хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999
оны 25 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ОРОН СУУЦНЫ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Орон суущны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл энх, сайн сайхан амьдрах, үр бүтээлтэй хөдөлмөрлөх язгуур нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй нэг хэсэг юм.

Монгол Улсын иргэн "..эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй..." гэсэн Үндсэн хуулийн заалт нь хүний амьдарч, аж төрох ахуй орчныг бүрдүүлэгч орон суущанд тавигдаж байгаа үндсэн шаардлага бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын төрөөс орон суущны талаар баримтлах бодлого чиглэнэ.

2.Монгол Улсын төрөөс орон суущны талаар баримтлах бодлого нь зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх орон суущны салбарын үүрэг хариуцлагыг тодорхойлж орон сууц, түүний дэд бүтцийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, гэр бүл бүрийг эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан тохилог орон суушаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

3.Одоо байгаа орон суущны санг нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд зөв ашиглах, хүн амын орон суущны эрэлт, хэрэгцээг хангахад Монгол орны байгаль, цаг уурын онцлог уламжлал, эдийн засгийн чадавх, орчин үеийн шаардлагад нийцсэн орон суущны нэгдсэн бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүгийн боломж, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.Төрөөс орон суущны талаар баримтлах эрхэм зорилго нь тус улсын гэр бүл бүрийг эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан тохилог орон суушаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

5.Төрөөс орон суущны талаар баримтлах эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь үндсэн зорилт тавина:

1/орон суущны газар өмчлөл, ашиглалт болон орон сууц барих, ашиглах, засвар үйлчилгээ хийхтэй холбогдсон харилцаанд төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагууд, хувийн хэвшил, гэр бүл, хүн бүрийн оролцоо, эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоох;

2/одоо байгаа орон суущны чанарыг сайжруулах, орон суущны хангамжийг нэмэгдүүлэх;

3/орон суущны талаарх улсын нөрм, стандарт, дүрэм, журам нь орон суущны чанарын түвшин, хувь хүн ба гэр бүл, тэдгээрийн орлогын хэмжээ, худалдан авах чадварт тохирсон байх;

4/орон суущны талаар төрийн хүлээсэн үүрэг, ялангуяа санхүүгийн аваллыг аль болох хөнгөвчилж, хариуцлагыг хувийн хэвшил рүү түлхүү шилжүүлж, нийт хүн ам, үүний дотор төрийн албан хаагчын орон суущыг хялбар, дөхөм аргаар санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлэх;

5/төрөөс нийгмийн эмээр хэсгийн орон суущны хангамжийн талаар тусламцаа үзүүлэх;

6/орон суущны дэд бүтэц барих, ашиглах, засвар, үйлчилгээ хийх ажилд хувийн хэвшлийг түлхүү оролцуулж, үүнд төрөөс тавих хяналтыг сайжруулах.

6."Орон сууц" гэдэгт нийтийн болон хувийн зориалттай орон суущны байшин болон хүн амын ихэнх хэсэг нь амьдарч байгаа үндэсний гэр, төв, суурин газрын гэр хорооолдл барьсан хувийн байшинг хамруулна.

Монгол орны нөхцөлд хүн амын амьдарч байгаа орон суущны төрлүүдийг хамруулан "орон сууц" гэсэн нэр томьёог хуулиар тодорхойлно.

7.Орон суущны асуудлыг түүний дэвсгэр газар, дэд бүтцийн асуудлын хамт иж бүрэн шийдвэрлэж, хүн амын төвлөрлийн бусад хэсэг болох албан газар, сургууль, цэцэрлэг, дэлгүүр зэрэг соёл, боловсрол, үйлчилгээний газруудын зохистой харьцаа, байршилтын харилцан уялдаат харгалзан төлөвлөнө.

8.Орон суущны чанарыг хот байгуулалт, архитектур, барилгын эрүүл ахуй, экологи, аюулгүй байдал, оршин суугчдын эрх ашигт нийцсэн байдал зэрэг үзүүлэлтээр тодорхойлох бөгөөд түүнийг орон сууц төлөвлөх, барих үйл ажиллагааны үр дүнгийн гол хэмжүүр гэж үзнэ.

9.Төрөөс орон суущны талаар баримтлах бодлого нь орон суущны талаарх олон улсын чиг хандлага, тус улсын нөхцөл байдал, эдийн засгийн хөгжилтэй төлөв, орон сууц худалдан авах Засгийн газрын болон гэр бүлийн чадавх, орон суущны бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурласан орон суущны холбогдолтой эрх зүйн болон удирдлага, зо-

хион байгуулалтын тогтолцоо, төв, суурин газрын төлөвлөлт, газар зохион байгуулалттай уялдсан орон сууц, түүний дэд бүтцийн төлөвлөлт, шинэчлэлт болон санхүүжилтийн хүрээг хамарна.

10.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганаар 1988 онд батлагдсан "Дэлхий нийтийн хэмжээнд 2000 он хүртэл баримтлах орон сууцны ерөнхий стратеги"-ийн баримт бичигт: "Хөгжиж буй бүх орнуудын орон сууцны бодлогын цөм нь хүн амын худалдан авах чадавх, амьдралын наад захын шаардлагад нийцэх орон байраар хангах асуудал бөгөөд хүн амд орон сууцны зориулалтаар газар, барилгын материал, зээл тусламж олгох, барилга барих шинэ технологид сургах замаар амьдралаа дээшлүүлэхэд нь туслах явдал юм" гэжээ.

Монгол Улс нь орон сууцны талаарх олон улсын санаачилгыг дэмжин хэрэгжүүлэхдээ төв, суурин газрын гэр хороолыг шинэчлэх, төлөвлөлтийг нь сайжруулахад анхаарна.

Хоёр.Орон сууцны хангамж, төлөвлөлт, санхүүжилт, эрх зүйн зохицуулалт

11. Орон сууцны хөрөнгө оруулалт нь ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, эдийн засгийг хөгжүүлэхэд тулхэц өгнө. Хүн ам өөрсдийн хүч боломжоор орон сууц барих явдлыг дэмжих нь хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

12. Орон сууцны зориулалтаар газрыг хувьчлах нь иргэд орон сууцандаа хөрөнгө оруулалт хийх, өөрсдийн хүчээр орон сууц барьж өмчтэй болох сонирхлыг төрүүлж, улмаар орон сууцны чанар сайжрах гол хөшүүрэг мөн.

13. Орон сууцны талаарх төрийн хүлээсэн үүрэг, алангуяа санхүүгийн ачааллыг хөнгөвчилж, одоо байгаа орон сууцны чанарыг сайжруулах, шинээр орон сууц, түүний дэд бүтцийг барихад хувийн хэвшлийнхний оролцоог нэмэгдүүлж, хувь хүн ба гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлж төрөөс тавих хяналтыг сайжруулна.

14. Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого нь зах зээлийн харилцааны үндэсн шаардлагад нийцэж, хувь хүн болон гэр бүлийн орлогын хэмжээ, тэдгээрийн худалдан авах чадварт тохирч, хүн амын олонх болох бага орлоготой бөгөөд орлогын эх үүсвэр нь найдвартай, зээл авах чадавхгүй хүн амын хэсэгт чиглэнэ.

15. Орон сууц шинээр барих болон орон сууцны нөхцөл сайжруулах зориулалтаар иргэдэд урт хугацааны зээл олгох боломжийг судлан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

16. Улсын хэмжээнд нийт хүн амын 44 хувь нь төв, суурин газрын гэр хороололд, 33 хувь нь гэрт, 23 хувь нь зураг төслөөр баригдсан орон сууцанд амьдарч, өөрөөр хэлбэл нийт хүн амын 77 хувь нь зүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангаагүй, зохицуулалтаас гадна баригдсан орон сууцанд амьдарч байна.

Төрийн зүгээс Монгол үндэсний уламжлалт сууц болсон гэрийг хөгжүүлэхдээ суурин хэвшлийн амьдралын зүүл ахуй, хүрээлэн байгаа орчин, хот байгуулалтын үндэсн шаардлагуудтай уялдуулан хөгжүүлнэ.

17.Нийтийн зориулалттай орон сууцны өмчлөлийн харилцаа өөрчилж, орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцааны үндэсн шаардлагад нийцүүлэн шинэчилж, орон сууцыг хэвийн, найдвартай үйлчилгээгээр хангах ашиглалт, засвар, үйлчилгээний тогтолцоо бүрдүүлнэ.

18.Нийтийн зориулалттай орон сууцны барилгад хийх шаардлагатай их хэмжээний хөрөнгө шаардсан засварын ажлыг санхүүжүүлэхэд орон сууц хөгжүүлэх сангаас зээл олгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

19.Ерөнхий төлөвлөгөөний дагуу зураг төслөөр баригдсан орон сууцны хороолол болон урьдчилсан төлөвлөлттүйгээр барьсан гэр хорооллын хоорондын ялгаар багасгана. Ойрын ирээдүйд шинээр барих болон шинэчлэн сайжруулах орон сууцны дийлэнх хувь нь иргэд өөрсдийн хүч бололцоогоор төв, суурин газрын гэр хороололд барьсан хувийн орон сууц эзлэх болно.

Гэр хорооллыг хүн төвлөрөн суурьшсан газрын төлөвлөлт, дэд бүтэцтэй уялдуулан хороо, гудамж, хашааны орчин, орон сууцны нөхцөлийг сайжруулж соёл, боловсрол, худалдаа, үйлчилгээгээр хангагдах нөхцөлийг бүрдүүлж, хот суурин газрын гэр хорооллыг тохилог орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

20.Хот орчмын зуслангийн байшинг байнга оршин суух амьдрах орон сууц болгон сайжруулах, тэдгээрийг инженерийн шугам сүлжээгээр хангах боломж болон газар өмчлөх асуудлыг судалж шийдвэрлэнэ.

21.Орон сууцны бодлого нь нийгмийн халамжийн бодлогын салшгүй нэг хэсэг мөн. Төрийн өмчид байгаа орон сууцны зарим

хэсгийг нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэхэд зориулна.

Нийгмийн халамжийн зориулалтаар нэмж шаардагдах орон сууцыг хувийн түрээсийн зах зээлээс авч түрээсийн зардлыг орон сууцны тэтгэмжээр дамжуулж буюу шууд халамж хүртэгсдэд олгоно.

22.Нийгэм, эдийн засгийн шинэ тогтлоонд орон сууцны удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, ашиглалт, үйлчилгээг зохицуулж, орон сууцны салбарыг бие даан хөгжих эрх зүйн үндсийг тогтооно.

23.Үндсэн хуулийн "...Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Иргэний орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална..." гэсэн заалтуud нь орон сууцны хувьчлалын үр дүнд үүсэх нийгмийн харилцааг зохицуулах, хуульчлах үндэс болно.

24.Орон сууцны тухай хууль тогтоомжоор орон сууц, түүний дэд бүтцийг санхүүжүүлэх, төлөвлөх, барих, ашиглах засвар, үйлчилгээ хийх болон орон сууцны газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцаанд бүх шатны төрийн байгууллага, хувийн хэвшил, хувь хүн ба гэр бүлийн оролцоо, эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

25.Төрийн өмчийн орон сууцны хувьчлалыг зохион байгуулж, хувьчлалын явцыг түргэтгэх, сууц өмчлөгчдийн холбоод үүсгэн байгуулагдаж ажиллахад эрх зүйн болон мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

26.Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын зорилт, үүрэг хариуцлагыг шинээр тодорхойлж, бүтэц, зохион байгуулалтыг нь шинэчлэн өөрчилнө.

27.Монгол Улсын хүн амын суурьшилт, төв, суурин газрын сүлжээ нь эдийн засаг, нийгмийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын ая тухтай амьдарч ажиллах нөхцөл, хэрэгцээг бүрэн хангахад чиглэнэ.

28.Төв, суурин газрын төлөвлөлтийг мэргэжлийн хүмүүс болон хэрэглэгчидийн харилцан уялдаа бүхий үйл ажиллагаанд үндэслэн орон нутгийн оршин суугчдад мэргэжлийн зохих туслалцаа, зөвлөгөө өгөх замаар дооросс дээш чиглэсэн байдлаар боловсруулна. Төв, суурин газрыг хөгжүүлэх төлөвлөгөөг хүний хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцүүлж, газар зохион байгуулалтын асуудалтай нягт холбоотой боловсруулна.

29.Төв, суурин газрын ерөнхий төлөвлөгөөг төлөвлөлтийн норм, стандарт, улсын эдийн засаг болон хүн амын эд хөрөнгийг бодит нөөц, бололцоог тухайн төв, суурин газрын хэрэглэгчидийн эрэлт, хэрэгцээ, ашиг сонирхолтой уялдуулан тусгаж шинэ орчинд уян хатан дасан зохицох боломжтойгоор төлөвлөнө.

30.Хүн амын хуваарилалт, боломж, орон сууцны эрэлт, хэрэгцээнд тулгуурлан орон сууц барих шинэ талбайг бэлтгэх, одоо байгаа орон сууцны болон гэр хорооллын нөхцөлийг сайжруулахад зориулан орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дооросс дээшээ төлөвлөх хэлбэрээр боловсруулна.

Энэ төлөвлөгөө нь орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хүн амын суурьшлын салшгүй хэсэг болох амралт, сургалт, соёл, хуваалцах, үйлчилгээний дэд хэсгүүдийг иж бүрнээр төлөвлөж, ашиглагдаж байгаа дэд бүтцийг бүрэн дүүрэн ашиглах, хөрөнгийн янз бүрийн чадахуйд тохирсон орон сууц барих газраар хангахад чиглэгдэх бөгөөд тухайн төв, суурин газрын ерөнхий төлөвлөгөөний тодотгол болж өгнө.

31.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад тухайн нутаг дэвсгэрт орон сууцыг дэд бүтэцтэй нь хамт төлөвлөж хөгжүүлэх, орон сууц нэмж барихад түүнийг дэд бүтцийн сүлжээнд үр ашигтайгаар холбох, оршин суугчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, үр дагавар гаргуулахгүй байх шаардлагуудыг хангана.

32.Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцсэн хот байгуулалтын энгийн ба уян хатан төлөвлөлтийн норм, дүрэм, стандартыг боловсруулах, энэ чиглэлээр мэргэжилтнүүдийг сургахад тэргүүн эзэлжинд анхаарна.

33.Хэрэглэгчдийн эрх ашиг, эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган үүднээс орон сууцны төлөвлөлт, ашиглалтад тавих үндсэн шаардлага, хэм хэмжээ, тогтоосон норм, стандартыг тогтмол боловсронгуй болгоно.

34. Орон сууцны дэд бүтцийг төв, суурин газрын хөгжлийн хэтийн төлөв, хүн амын өсөлт, орон сууцны бодит хэрэгцээтэй уял-

дулан төвөлөх бөгөөд шинээр орон сууны хороолол байгуулахад эхлээд одоо байгаа дэд бүтэц бүхий бариигажсан хэсгийн хүчин чадлыг бүрэн ашиглахад голлон анхаарч, цаашид инженерийн бэлтгэл ажлыг гүйцэтгэсний дараа барилга байгууламж байгуулна.

35.Орон сууцны дэд бүтэц нь Монгол орны байгаль цаг уурын онцлогт тохирсон, хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, ашиглахад хялбар, амьдрах ая тухтай, хэвийн орчинг найдвартай хангахад чиглэгдэнэ.

36.Шинээр барих орон сууцны хорооллын инженерийн бэлтгэл ажлыг хувийн хөрөнгө оруулагчдыг тулхүү ороллуулах замаар гүйцэтгэж, иргэдийн худалдан авах чадавхид тохируулан орон сууц барих талбайг худалдах ажлыг зохион байгуулна.

37.Төв, суурин газрын барилгажсан хэсгийн нягтрал, дэд бүтцийн ашиглалтыг сайжруулж, байрлал сайтай орон сууцны зориалаттай газрыг дуудлагаар худалдах замаар шинээр барих орон сууцыг нэмэгдүүлнэ. Аймаг, нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа дэд бүтцийн үйлчилгээнд хамруулан шинээр орон сууц барих боломжтой газрыг тодорхойлж барилгажуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

38.Инженерийн төвлөрсөн хангамж түгээгч байгууллагууд нь өөрийн үйлчилгээ эцсийн хэрэглэгч хүртэл хүргэх бөгөөд ажил, үйлчилгээнийхээ зарим хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

39.Гэр хорооллын орон зайн ашиглалтыг зохистой, үр ашигтай болгон төлөвлөх төлөвлөлтийн шинэ стандартыг боловсруулж орон сууцны болон гэр хорооллын ялгаг багасгана.

40.Шинээр баригдах болон шинэчлэн сайжруулах орон сууцны ихэнх хувь нь төв, суурин газрын гэр хороолодд байх бөгөөд цаашид гэр хорооллыг хувийн орон сууцны тохилог хороолол болгох явдлыг хөхүүлэн дэмжинэ.

41.Төв, суурин газрын гэр хорооллыг дэд бүтэцтэй нь уялдуулан төлөвлөж, хороо, гудамж, хашааны орчин, орон сууцны нөхцөлийг сайжруулж, соёл, боловсрол, хуудалдаа үйлчилгээгээр бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

42.Аймаг, нийслэл, орон нутгийн түвшинд орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

Төв, суурин газрын орон сууц төлөвлөлтийн зөв алхмыг хүн амын бодит эрэлт, хэрэгцээг үндэслэн боловсруулсан орон сууцны хөтөлбөрүүдээр тодорхойлно.

43.Орон сууцны хөтөлбөр нь:

1/орон сууцны ойрын болон хэтийн эрэлт, хэрэгцээг бүрэн тооцоолсон;

2/орон сууцны хорооллыг нягтруулж, төв, суурин газрын дэд бүтцийн үр ашгийг дээшлүүлэх талаар оновчтой хувилбар сонгосон;

3/орон сууц барих болзлоогоо бодит байдалтай уялдуулсан;

4/зураг төслийн дагуу орон сууц барих ажилд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн;

5/шинээр хамгийн их орон сууц баригдах боломжтой гэр хорооллыг анхааралдаа авсан байна.

44. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцсэн орон сууцны санхүүжилтын оновчтой горлолоо бий болгох нь хүн амын орон сууцны хангамж, үүний дотор төрийн албан хаагчид, нийгмийн эмзэг хэсгийн орон сууцны асуудлыг цоцолборооор шийдвэрлэх үндэс юм.

Орон сууцны санхүүжилтын горлолоог одоогийн бодит боломжид тулгуурлан орон сууц хөгжүүлэх сан байгуулах замаар бүрдүүлэх нь орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах суурь болох бөгөөд улс орны эдийн засгийн байдал сайжрах хирээр орон сууцны хөгжлийн хэтийн хандлагыг зөв чиглүүлэх нөхцөл болно.

45.Орон сууц хөгжүүлэх сан нь улсын төвлөрсөн болон аймаг, нийслэлийн төсвөөс олгох хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад, дотоодын зээл, тусламж, хандив, зээлийн хүү, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг орон сууц, түүний дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах, шинээр барих, иргэд, хуулийн этгээдэд зээл олгоход зарцуулна.

46.Орон сууцны борлуулалтын болон түрээсийн зах зээлийн мэдээллийн сан байгуулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг шуурхай мэдээллээр хангах ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор явуулна. Орон сууцны өртөг, үнэ, үнийн өөрчлөлтийн талаарх үнэн зөв мэдээллийг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар албан ёсоор гаргаж байх бөгөөд хөрөнгийн арилжааны үнэлгээг бүртгэлийн үнэлгээтэй нийцүүлэх арга хэмжээ авна.

47.Орон сууцны зориалаттаар жижиг зээл олгох, мөн цалин хөлс нэмэгдүүлэхийн оронд төрийн албан хаагчдад орон сууцны асуудлаа шийдвэрлэхэд нь тусламж үзүүлэх явдлыг хөхүүлэн дэмжинэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 62** **Улаанбаатар хот**

Ж. Ядамсүрэнд албан тушаалын зэрэг дэв олгох тухай

1. Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Үнэт цаасны хорооны дарга Ж.Ядамсүрэнд төрүүгүн түшмэлийн тэргүүн зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 1999 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр **Дугаар 01** **Улаанбаатар хот**

Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдээд Ж.Амарсанаа, С.Жанцан /илтгэгч/, Ж.Бямбажав, В.Удвал нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүү, өргөдөл даргагч иргэн Х.Доржпалам, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид Улсын Их Хурлын гишүүн С.Төмөр, Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх Ж.Батдэлгэр нарыг оролцуулан Төрийн ордны Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны танхимд хийв.

Баянзүрх дүүргийн нэгдүгээр хорооны иргэн Х.Доржпалам Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: "Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т "Иргэний ... орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэж заасан. Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 12 дугаар зүйлд "Иргэний орон байрны халдашгүй эрхэд халдаж нууц үзлэг хийхээр болон түүний хэмжээ хязгаарыг нарийвчлан заагаагүй байхад мөн хуулийн 23 дугаар зүйлд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд иргэний орон байранд прокурорын зөвшөөрөлтэйгөөр нууц үзлэг хийж болохоор хуульчлахдаа иргэний орон байрыг барилга байгууламж, ... тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлтэй адилтган нэг зиндаанд авч үзжээ. Ингэснээр орон байр халдашгүй байх тухай Үндсэн хуулийн дээрхи заалтыг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т "Хууль заасан үндэслэл, журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэж заасан. Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд "... өөрт байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ гүйцэтгэх ажил явуулах тухай заалт нь гүйцэтгэх байгууллага, ажилтан өөртөө мэдээлэл байсан ч, эс байсан ч, бодит үндэслэлтэй, үндэслэлгүйгээр үл харгалзан өөрийн таалlaapaa, санааныхаа дур зоргоор хууль заасан үндэслэл журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч мөрдөн мөшгих, гүйцэтгэх ажил зохиож, тагнаж болохоор хуульчилж өгсөн нь Үндсэн хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн эдгээр заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсэнийг хянаж үзэхийг хүсье" гэжээ.

Иргэн Х.Доржпалам өргөдөлдөө өгсөн нэмэлт тайлбартаа: "Ер нь орон байрны халдашгүй байдал гэдгийг хэн ч хэзээ ч халдах ёсгүй гэдэг туйлын утгаар, хуулиар хамгаална гэдгийг ямар ч хууль гарлаа, түүний халдашгүй байдалд халдаж болох тухай ойлголт, яриа байж болохгүй гэсэн утгаар ойлгох ёстой. Гүйцэтгэх ажил зохиох хүрээг хуульчилж өгсөн 12 дугаар зүйлд "орон байранд нууц үзлэг хийх талаар нэг ч үг үсэг байхгүй. Энэ зүйлд орон байранд нууц үзлэг хийх хэмжээ хязгаарыг нарийвчлан заах ёстой. Гүйцэтгэх ажлын хуулийн дээрх заалт Үндсэн хууль тодийгүй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн. Энэ үгтаараа түүхэнд хар толбо болж үлдсэн хэлмэгдүүлэгтийг дахин давтаж болох хамгийн аюултай заалт юм" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Төмөр Үндсэн хуулийн Цэцэд бичгээр өгсөн тайлбартаа: "Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн "Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтын дагуу Гүйцэтгэх ажлын тухай хууль гаргаж гүйцэтгэх ажил явуулах үндэслэлийг тодорхойлж өгсөн. Тухайлбал мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаарх төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна" гэж заасан. Энэ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаас өмнөх шаганд зохиох гүйцэтгэх ажилд хамаарч байгаа бөгөөд эрх бүхий байгууллагууд нь гадны байгууллагын зөвшөөрөлгүйгээр холбогдох мэдээллийг үндэслэн явуулна гэсэн хэрэг юм. Дээр дурьдсан мэдээлэл нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасанаар "Үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгод чиглэсэн байх ёстой. Тэгээд ч хуульд заасан үндэслэлгүйгээр гүйцэтгэх ажил явуулж, иргэн хуулийн эгтээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол хуулийн хариуцлага хүлээлгэх заалт ч бий. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нууцлалын шаардлагаас холбогдох бүх хэм хэмжээг нэг бүрчлэн заах бололцоогүй бөгөөд гүйцэтгэх ажлын зааварт нууц үзлэг явуулах үндэслэл, журмыг нарийвчлан зааж өгсөн байдаг" гэжээ.

Нэхэмжлэгч иргэн Х.Доржпалам Үндсэн хуу-

лийн Цэцийн хуралдааны оролцож өгсөн тайлбартаа: "Гүйцэтгэх ажлын тухай хуульд орон байранд нууц үзлэг хийх үндэслэл, журмыг заагаагүй учир хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хүний эрх зөрчигдөх боломжтой болсон. Өөрийн үзэмжээр гүйцэтгэх ажил явуулах тухай хуулийн заалт нь гүйцэтгэх байгууллага, ажилтан дур зоргоороо, хууль бус үйл ажиллагаа явуулах боломж олгож байгаагаараа Үндсэн хууль зөрчиж байна" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Төмөр Цэцийн хуралдааны оролцож өгсөн тайлбартаа: "Улсын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг илрүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод нийцүүлэн хуульд заасан журмын дагуу орон байранд нууц үзлэг хийхгүй байх юм бол гүйцэтгэх ажил гэж байх нь уттагүй юм. "халдашгүй" гэдгийн тухайд тодорхой шалтгааны улмаас хуульд заасан бол эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно гэж ойлгож байна" гэжээ.

ХЭНАВАЛ:

Нэхэмжлэгч иргэн Х.Доржпаламын өргөдөлд дурьдсан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн иргэний орон байранд нууц үзлэг хийж болох тухай заалт, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн гүйцэтгэх ажлыг өөрт нь байгаа болон иргэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ явуулах гэсэн заалтуудад хууль зүйн хувьд болзошгүй болгох зүйл байгаа боловч үүнээс асуудал нь Үндсэн хуулийн Цэцийн шууд харъяалан шийдвэрлэх асуудал биш болохыг дурьдсугай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаархи төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д "хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хоригломо" гэсэн заалтыг, мөн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд иргэний орон байранд прокурорын зөвшөөрөлтэйгөөр нууц үзлэг хийж болох тухай заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д буй "... орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална", 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахийн ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор авч хэлэлцэн хариу өгүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА Н.ЖАНЦАН
ГИШҮҮД Ж.АМАРСАНАА
С.ЖАНЦАН
Ж.БЯМБАЖАВ
В.УДВАЛ

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 3 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 32** Улаанбаатар хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 9, 14 дүгээр зүйлийг -ыг хавсралтын ёсоор баталсугай.
хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТУШААХ нь:

" Голын голдрил өөрчлөхөд мөрдөх журам"- САЙД С. МӨНДСАЙХАН

Байгаль орчны сайдын 1999 оны
32 дугаар тушаалын хавсралт

ГОЛЫН ГОЛДРИЛ ӨӨРЧЛӨХӨД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Усны нөөцөд хомсдолт үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор уснаа эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд уснаа нөөц, чанарт сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулах, голын голдрилыг түр өөрчлөх, голын голдрилд элс хайрга олборлох, ашигт малтмал ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Гадаргын болон газрын доорхи уснаа нөөцийн хомсдолын үндэсэн шалгуур үзүүлэлт гадаргын уснаа хувьд олон жилийн дундаж урсац, газрын доорхи уснаа хувьд хүдгийн үндрагын бууралт болно.

1.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа голын голдрилыг түр өөрчилсөн, салаалуулан урсгасан, голдрилд газар шороонд ажил гүйцэтгэсний улмаас тухайн усны эх үүсвэрээс усаар хангагддаг хүн, малын усан хангамжийн нөхцөл муудсан, гол мөрнөөс авч ашиглаж болох уснаа хэмжээнээс хэтрүүлэн ашигласан тохиолдолд тэдний ус ашигдалтын хэмжээг хязгаарлах, улмаар хэрцлэх хүртэл арга хэмжээг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын бүх шатны байцаагч авна./Голын уснаас авч ашиглаж болох уснаа хэмжээг хавсаргав./

1.4. Усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа голын голдрилыг түр өөрчилсөн, салаалуулан урсгасан, голдрилд элс хайрга олборлосон, ашигт малтмал ашигласнаас гадаргын болон газрын доорхи уснаа нөөц багассан, чанар нь алдагдсан бол аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны бүх шатны байцаагч үйлдвэрлэлийн ажиллагааг зогсоож, уснаа нөөцийг нөхөн сэргээх ажлыг аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар гүйцэтгэнэ.

1.5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаргын болон газрын доорхи уснаа нөөцийн байгалийн тогтоцыг өөрчлөн үйлдвэрлэл үйлчилгээ, аж ахуйн ажиллагаанд зориулан 3 жилээс дээш хугацаагаар ашиглах бөомт, далан, ус авах барилга байгуулах, голын голдрил өөрчлөх, суваг шуудуу татах, 3.6м^3/цаг-аас дээш хэмжээний ус авах үүч чадалтай худаг гаргаж ашиглах тохиолдолд зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.Зураг төслийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тэв байгууллагаас эрх олгогдсон Мэргэжлийн байгууллага зохионо.

1.6. Гол мөрний усны эрэг голдрилыг түр хугацаагаар өөрчлөх, голдрилд элс хайрга олборлох, ашигт малтмал ашиглах, голыг салаалуулан урсгах бол энэхүү журамд заасны дагуу зохих зөвшөөрлийг авсан байна.

Хоёр. Голын голдрил түр өөрчлөх, салаалуулан урсгах, голдрилд газар шорооны ажил гүйцэтгэх

2.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь голын голдрил түр өөрчлөх, салаалуулан урсгах, голдрилд газар шорооны ажил гүйцэтгэхдээ дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.1.усны нөөцөд хомсдол үүсгэх үйл ажиллагаа эхлэхийн өмнө ашиглаж болох нөөцийн хэмжээг тогтоно.

2.1.2. ашиглалтын явцад ашиглаж буй усны хэмжээг хэмжих хэрэгсэл болон техникийн хүч чадлыг үндэслэн нарийвчлан тооцож байна.

2.1.3. усны алдагдал, үргүй зарцуулалт, хөрсний алдагдал гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.4. голдрилыг өөрчилж буй сувгийг үе үл нэвтрүүлэх биетээр хучилт хийсэн, эсхүл даггаршуулсан байна.

2.1.5. усны амьтан, загас, ургамлын нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхгүй, экологийн тэнцэлийг алдагдуулахгүй байх үүднээс эхний жилд голын усны урсацын 50-аас илүүгүй хувийг, дараагийн жил урсацыг бүтнээр нь голдрил өөрчилж буй сувгаар урсгана.

2.1.6. голын урсацыг голдрил өөрчилж буй сувгаар урсгах ажлыг 4дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэхийг хориглоно.

Дархадын цагаан загас, Буйр нуурын загас, омуль, зарам, алтан сугас загас бүхий гол мөрний голдрилыг өөрчлөхдөө "Ан агнуурын тухай" Монгол улсын хуулийн 23 дугаар зүйлд зааснаас бусад хугацаанд гүйцэтгэнэ.

2.1.7.Ажил гүйцэтгэсний дараа байгалийн унаган төрх байдалд нь буцаож оруулах, засаж тохижуулах нөхцөлийг бүрэн хангаж энэ талаар үйл ажиллагааны болон байгаль орчны хамгаалах төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.2. Газар тариалан эрхлэх, усалгаатай тариаланд ашиглах зорилгоор голын урсацыг салаалуулан ашиглах тохиолдолд энэхүү журмын хавсралтад заасан хэмжээнээс ашиглаж болох усны хэмжээг хэтрүүлэхийг хориглоно.

Голын урсацыг салаалуулан урсгахдаа усны амьтан, ургамлыг хамгаалах шүүлтүүр тавьж, эргүүлэн голд оруулах санг байгуулсан байна.

Гурав. Голын голдрилыг өөрчлөх, голыг салаалуулан урсгах болон голдрилд газар шорооны ажил гүйцэтгэхэд тавих хяналт, зөвшөөрөл

3.1.Голын голдрилыг түр өөрчлөх, салаалуулан урсгах болон зөвшөөрөл, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон голын голдрилд газар шорооны ажил гүйцэтгэх зөвшөөрлийг үйлдвэлэлийн үе шатны туршид хүчинтэй байхаар олгох бөгөөд үе шат бүрт аймаг, нийслэлийн байгаль орчны хяналтын байцаагчид хяналт тавина.Үүнд:

3.1.1.голын голдрилыг өөрчлөхөөр байгуулсан сувагт голыг салаалан урсгахыг өмнө,

3.1.2. усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон голын голдрилд газар шорооны ажил гүйцэтгэхийн өмнө,

3.1.3.голдрилыг өөрчлөн хиймэл сувагаар ус урсгахын өмнө,

3.1.4. голын голдрилд элс хайрга болон бусад ашигт малтмал олборлох үйлдвэрлэл явуулж дуусснаы дараа байгалийн унаган төрхөд оруулах арга хэмжээ авч голыг хуучин голдрилоор урсгахын өмнө,

3.2.Голын голдрилыг түр өөрчлөх, салаалуулан урсгах, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон голын голдрилд элс хайрга олборлох, ашигт малтмал ашиглах тухай зөвшөөрөлийг Байгаль орчны хамгаалах алба, аймгийн Мэргэжлийн хяналтын алба, нийслэлийн байгаль орчны хяналтын газар олгоно.

Хэд хэдэн аймаг болон нийслэлийн нутаг дамжин урсдаг болон сумын төвийн ус хангамжид ашигладаг томоохон голын хувьд Байгаль орчныг хамгаалах алба, тухайн голын голдрилыг өөрчлөх газраас урсгалын доор 50 км дотор голыг усан хангамжид ашиглахгүй тохиолдолд аймгийн Мэргэжлийн хяналтын алба, нийслэлийн Байгаль орчны хяналтын газар олгоно.

3.3.Зөвшөөрлийг олгохдоо дараахь бичиг баримтыг үндэслэнэ.Үүнд:

3.3.1. төсөлд хийгдэсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,

3.3.2. голын голдрилыг өөрчлөх зураг, шинээр суваг тавих газрын хөрсний шинжилгээний дүн,

3.3.3. хөрсний үгаагдал, усны алдагдлаас хамгаалах зураг төсөл.

3.4.Газар тариалан эрхлэх, усалгаатай тариаланд ашиглах зорилгоор голын урсацыг салаалуулан урсгах зөвшөөрлийг аймгийн Мэргэжлийн хяналтын алба, нийслэлийн Байгаль орчны хяналтын газар олгоно.

3.5.Зөвшөөрлийг албан бичгээр олгох бөгөөд голдрилыг өөрчлөх үед хяналт тавих хугацаг тодорхой заасан байна.

3.6.Аймгийн Мэргэжлийн хяналтын алба, нийслэлийн Байгаль орчны хяналтын газар нь голын голдрилыг түр өөрчлөх, салаалуулан урсгах, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон голын голдрилд элс хайрга олборлох, ашигт малтмал ашиглах тухай зөвшөөрөл олгосон тухай тайланг жил бүрийн 12дугаар сарын 15-ны дотор Байгаль орчныг хамгаалах албанд ирүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Голын голдрилыг өөрчлөх, салаалуулан урсгах, дэлхийн Байгаль орчны хяналтын алба тус тус зөвшөөрөл олгоно.

голдрилд газар шорооны ажил гүйцэт-гэхтэй холбогдсон аливаа маргааныг зөвшөөрөл олгосон байгууллагын дээд шатны мэргэжлийн хяналтын байгууллагад, шаардлагатай гэж үзвэл шүүхэд тавьж шийдэврлүүлнэ.

Голын голдрил өөрчлөх, салаалуулан урсгах, голдрилд газар шорооны ажил гүйцэтгэхэд мөрдөх журмын хавсралт

ГОЛЫН УСНААС АВЧ АШИГЛАЖ БОЛОХ УСНЫ ХЭМЖЭЭ

№	Голын сав	Голын		
		дээд	дунд	адаг
1.	Дархадын хотгор		0-15	5-10
2.	Хөвсгөл уудсын өмнөд хажуу	3-5	8-10	5-10
3.	Сэлэнгэ мөрөн /Монгол- ОХУын хил хүртэл/	5-6	6-10	11-15
4.	Сояны нуруугы дорнод үзүүрийн өмнө хажуу		10-12	5-8
5.	Эг гол	5-6	10-12	12-15
6.	Хангайн нуруугы баруун, баруун хойд хажуугийн		5-8	
7.	Хангайн нуруугы ар		5-10	4-8
8.	Орхон гол		10-12	12-15
9.	Хангайн нуруугы өмнөд хажуу		5-8	
10.	Таац, Онги гол		3-5	
11.	Хэнтийн нуруугы баруун хойд ба зүүн хойд хажуу	8-10	10-15	15-20
12.	Хэнтийн нуруугы өмнөд хажуу/Туул, Хараа/	4-6	7-10	5-7
13.	Хэрлэн гол	4-6	6-8	9-12
14.	Халх гол		6-8	10
15.	Увс нуур		3-5	
16.	Хар ус нуур		4-6	
17.	Монгол Алтайн нуруугы өмнө хажуу		3-5	
18.	Говь-Алтайн нуруугы хойт, өмнөд хажуу, жижиг гол, горхи.		5-10	

Жич:Усны нөөц бүрэн нөхөн сэргэгдэгүй бус нутагт голын уснаас авч болох хэмжээг мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлтийг үндэслэн тухайн аймаг, сумын Засаг дарга тогтооно.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 39 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, үр дүнг нь сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний хөтөлбөрийг хавсралтын ёсоор батализгай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, байгаль орчны мэдээлэл, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, нийт иргэдийн үйл ажиллагааны хэвшил болгохоо чилээсэн арга хэмжээ авч ажиллахыг газар, хэлтсийн дарга, харьяа агентлагийн захирлуудад даалгасугай.

САЙД **С.МЭНДСАЙХАН**

Байгаль орчны сайдын 1999 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 39 тоот тушаалын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Нэгдсэн үндэсний байгууллагаас зохион байгуулсан "Байгаль орчин ба хөгжил" сэдэвт дэлхийн дээд хэмжээний уулзалтаас гаргасан "XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр", "Риогийн тунхаг", "Хил дамжсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай Эспугийн конвенц", "Байгаль орчны мэдээллийг чөлөөтэй солилцох тухай Европын хамтын нийгэмлэгийн удирдамж" болон Монгол улс одоогоор нэгдэн ороод байгаа байгаль орчны чиглэлийн олон улсын 7 конвенц зэрэг баримт бичиг байгаль орчны холбогдолтой шийдвэр гаргах ажлыг олон нийтэд нээлттэй байлгах, иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах асуудал тусгагдсан бөгөөд манай улс энэ асуудлаар олон улсын өмнө үүрэг хүлээдэг билээ.

Монгол улсын байгаль орчны хууль тогтоомж, төрөөс экологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд байгаль орчны мэдээлэл суртачилгааны асуудал тусгалаа олж, энэ ажлын чиглэл, үйл ажиллагааны эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн юм. Түүнчлэн "Байгаль орчныг хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн", "Монгол улсын иргэн, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэсэн Үндэсн хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа бодитой үүрэг гүйцэтгэнэ.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зөв зохистой ашиглуулах үйл ажиллагаа эрчимжиж байгаа боловч, энэ чиглэлийн мэдээлэл, сурталчилгаа олон нийтэд, мөн иргэдийн санал, мэдээлэл төр засагт хүрэх бололцоо хязгаарлагдмал байгаагаас төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байна.

Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны ажлыг төр засгийн бодлогын түвшинд төлөвлөн зохион байгуулах шаардлага гарч байгаар харгалзан, Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний хөтөлбөрийг /цаашид "Хөтөлбөр" гэх / боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тавигдан юм.

Хөтөлбөр нь байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны талаар өйрын 7 жилийн хугацаанд баримтлах бодлогын чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг мөн.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт хэрэгжүүлэх зарчим

2.1. Хөтөлберийн зорилго нь байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр , хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд иргэдийн экологийн ухамсар, сэтгэл зүйг дээшлүүлэх орчныг бүрдүүлэх, оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлберийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг тавьж хэрэгжүүлнэ:

2.2.1. байгаль орчны бодлого , хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийн явцыг нийтэд сурталчлан мэдээлэх;

2.2.2. иргэдэд байгаль орчны бодлого чиглэлийн талаар үнэн зөв мэдээлэл өгч, тэдний экологийн мэдлэгийг дээшлүүлэх;

2.2.3. байгаль орчны асуудлаар олон нийтийн санал бодлыг төрийн болон төрийн бус байгууллагын бодлого, шийдвэрт тусгаж, байгаль орчныг хамгаалах иргэдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ;

2.2.4. байгаль орчноо хамгаалах үндэсний уламжлалыг сэргээж, залуу үед экологийн хүмүүжил олгох.

2.3. Хөтөлберийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.3.1. байгаль орчны мэдээлэл, сурталчилгаар бүх нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байлгах;

2.3.2. байгаль орчны сурталчилгаанд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

2.3.3. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах асуудлаар иргэн бүр эрх ашиг, сонирхлоо чөлөөтэй илэрхийлэх.

2.4. Хөтөлберийг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

2.4.1 **Нэг дэх үе шат.** 1999-2000 он. Энэ үе шатанд хөтөлберийн зорилтыг хэрэгжүүлэх үгтвар нөхцлийг бүрдүүлнэ.

2.4.2. **Хоёр дахь үе шат.** 2001-2005 он. Энэ үе шатанд хөтөлберийн зорилтыг ханган биелүүлнэ.

Гурав. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны талаар баримтлах бодлогын чиглэл

3.1. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааг төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгслийн нэг хэмээн үзэж, энэ ажилд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэл баримтална.

3.2. Байгаль орчны мэдээлэл сурталчилгаань байгаль орчиндоо зохицсон нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд олон нийтийн үйл ажиллагааг чиглүүлэхэд туслана.

3.3. Байгаль орчны мэдээлэл бэлтгэгч, түгээгч, хэрэглэгчдийн харилцан уялдсан хамтын үйл ажиллагааг хангах явдлыг хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн арга зам гэж үзнэ.

3.4. Сурталчилгаанд нийт иргэдийг бүрэн хамруулахын зэрэгцээ эмэгтэйчүүд, хүүхэд залуучуудыг өргөнөөр оролцуулах, байгаль орчноо хамгаалах үндэсний уламжлалыг сэргээн хэвшүүлэхэд түлхүү анхаарна.

3.5. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааг уулзалт, ярилцлага, хурал, зөвлөлгөөн, семинар, кино, ном, товхимол, зураг хуудас, урлагийн тоглолт, утга зохиол, уран зохиол, дүрслэх урлаг, дуу, шүлэг, үлгэр, үзэсгэлэн, музей, номын сан, аялал жуулчлал болон сурталчилгааны бусад хэлбэрээр зохион байгуулна.

3.6. Байгаль орчны мэдээлэл сурталчилгаанд гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцааг өргөжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратегийн удирдлага, төлөвлөлтөөр ханган, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний зөвлөл эрхэлнэ.

4.2. Байгаль орчны мэдээлэл сурталчилгаг улсын түсгай хамгаалалттай газруудын мэдээлэл сурталчилгааны төвүүдээр дамжуулан тухайн орон нутгийн иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар ханган, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үүргийг Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний зөвлөл, хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд хариуцан гүйцэтгэнэ.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг үе шатаар хийж, энэ ажилд холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн аж ахуйн нэгж, байгууллагыг өргөн оролцуулна.

4.5. Байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа, сургалт хүмүүжлийн ажил эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын боловсон хүчнийг давтан бэлтгэх, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэдээлэл болон арга зүйн удирдлагаар ханган ажлыг Байгаль орчны яам, төрийн захиргааны болон төрийн бус байгууллага зохион байгуулна..

4.6. Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт, хомсдол, нөхөн сэргээлт, байгаль орчны доройтол, хувьсал өөрчлөлтийн мэдээ бариментыг нэгттэсэн мэдээллийн төв сан бүрдүүлэх, боловсруулалт хийж мэдээллээр ханган, сурталчилах ажлыг Байгаль орчны яам, холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.7. Байгаль орчны мэдээллийг төв орон нутгийн сүлжээгээр дамжуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байнгын мэдээлэл хүргэн сурталчилна.

4.8. Байгалийн музей, номын сангийн байгаль орчны мэдээллийг баяжуулах, байгалийг сурталчилсан соёл, урлагийн төрөл бүрийн арга хэмжээг өргөжүүлэх, экологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг байгаль орчны төрийн болон төрийн бус холбогдох байгууллага хамтран зохион байгуулна.

4.9. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны асуудлаар сумдын Засаг дарга болон аж ахуйн нэгж, байгууллагын илтгэл, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт өгч байна.

4.10. Сум, дүүргийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчны мэдээллийг тогтоосон хугацаанд хүлээн авч нэгттэн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, цаг үеийн чанартай олон нийтийн мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.

4.11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгаль орчны мэдээлэл, сурталчилгаг тухайн дэвсгэр нутагт зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн бүх хэрэгслээр сурталчилна.

4.12. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгаль орчны мэдээлэл сурталчил-

гааны дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

4.13. Төрийн бус байгууллагууд байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны ажлыг өөрийн дүрмийн дагуу эрхэлнэ.

4.14. Төрийн бус болон хэвлэл, мэдээлэл, соёл, урлаг, шашны байгууллагууд байгаль хамгаалах уламжлалыг сэргээх чиглэлээр сургалт, уулзалт, хурал, зөвлөлгөөн зохион байгуулна.

Тав. Хөтөлбөрийн хяналт, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, үр дүн

Хөтөлбөрийн хяналт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүгнэх ажлыг Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний зөвлөл, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд Байгаль орчны яам, аймаг, нийслэл, сум , дүүргийн Засаг дарга үнэлгээ өгнө.

5.3. Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаанд орон нутгийн өөрөө удирдах болон төр захиргааны байгууллагууд хяналт тавина.

Хөтөлбөрийн санхүүжилт

5.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.4.1. байгалийн баялгийн нөөц ашигласны болон байгаль орчны хууль тогтоомж зөрчигчийн нөхөн төлбөрийн орлогын тодорхой хувь хэмжээ;

5.4.2. байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих зориулалтаар гадаад улс, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгч буй тусламж, дэмжлэг, хандивын хөрөнгө;

5.4.3. Байгаль орчныг хамгаалах болон байгаль орчны итгэмжлэгдсэн сан.;

5.4.4 Иргэн аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчны мэдээллэл сурталчилгаа явуулснаас орох орлогын тодорхой хувь хэмжээ.

Олон улсын хамтын ажиллагаа

5..5. Төрийн болон төрийн бус байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар олон улсын байгууллагатай нягт хамтран ажиллаж, улс ор-нууд, олон улсын байгууллагаас мэдээлэл хүлээн авах, өөрийн орны байгаль орчны мэдээллийг дэлхийд түгээх тогтолцоог бүрдүүлнэ.

5.6. Олон улсын байгууллага болон бусад оронтой байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу төрийн захиргааны төв орон нутгийн байгууллага, мэргэжлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай хамтран ажиллаж, тэднээс үүгүлэх дэмжлэг туслалцааг байгаль орчны мэдээлэл сурталчилгаанд зориулан үр дүнгээ ашиглана.

5.7. Төрийн болон төрийн бус байгууллага байгаль орчны мэдээлэл сурталчилгааны төслүүдийг олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Хөтөлбөрийн үр дүн

5.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

5.8.1. Байгаль орчны холбогдолтой мэдээлэл сурталчилгаа бүх нийтийн хэрэгцээ болгон төрийн болон төрийн бус байгууллага орон нутгийн байгууллагын мэдээллийн нэгдмэл үйл ажиллагааг хангана.

5.8.2. Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны ажлыг манай орны нийт сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, байгаль орчны байцаагчид, мэргэжилтний байнгын үйл ажиллагаанд хэвшүүлнэ.

5.8.3. Бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний уламжлалыг сэргээн хэвшүүлэх ажилд бодит ахиц гарна.

5.8.4. Иргэдийн байгаль орчноо хамгаалах сэтгэхүй төлөвшиж, байгалийн нөөцийг ариг гамтай ашиглах үйл ажиллагаа идэвхижиж, үр өгөөж нэмэгдэж, бодлого шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 3 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль, уг хуулийг хэрэгжүүлэх талаар батлагдсан журмуудыг биелүүлэх, музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтын технологийн горимыг мөрдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Уг зааврыг мөрдөж ажиллахыг улс, орон нутгийн музейн захирал, эрхлэгч нарт, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Соёл,урлагийн газар (Г.Мэнд-Ооёо)-т, зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн хяналтын алба (Н.Пүрэвжав)-д тус тус даалгасугай.

САЙД А. БАТТӨР

Гэгээрлийн сайдын 1999 оны 49 тоот тушаалын хавсралт

МУЗЕЙН ҮЗМЭРИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ ЗААВАР

Музейн сан хөмрөгт байгаа түүх, соёлын дурсгалт зүйл (цаашид "дурсгалт зүйл" гэх)-ийн хадгалалт хамгаалалтын горимыг баримтлах, дурсгалт зүйл гэмтэж муудах, устаж үгүй болохоос сэргийлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

Нэг. Гэрэл ба хэт ягаан туяанаас хамгаалах

Гэрлийн нөлөөгөөр дурсгалт зүйлийн өнгө гандаж цайх, харлах, хэт хатсаны улмаас хугарамтгай болохоос сэргийлэх зорилгоор гэрлийн хурц тусгалыг бууруулах, гэрэлтүүлгийн хугацааг богиносгох зэрэг арга хэмжээг авна.

1.1. Дурсгалт зүйлийн орчны гэрлийг дараахь хэмжээнд байлгана. Үүнд:

а) гэрэлд мэдрэмтгий цаас, гэрэл зураг, усан будгийн болон байгалийн гаралтай будгаар будсан зураг, бөс даавуун дурсгалт зүйлийг 50 люкс буюу түүнээс доош гэрэлд;

б) гэрлийг бага мэдэрдэг арьс шир, яс, модон дурсгалт зүйлийг 150 люкс буюу түүнээс доош гэрэлд;

в) гэрэлд тэсвэртэй шил, керамик, металл, чулуун дурсгалт зүйлийг 500 люкс буюу түүнээс доош гэрэлд тус тус хадгална.

1.2. Гэрэлд өртөмтгий материалаар бүтсэн дурсгалт зүйлийг хэт хурц гэрэлд байлгаснаас үнэт чанараа алдах хугацаа нь эрс хурдасдаг тул нарлаг өдөр өрөөний доторх гэрэл 200 орчим люкс ба гадаа нарны гэрэл хэдэн мянган люкс байдгийг харгалзан гэрлийн хэт хурц тусгалаас сэргийлэхийн тулд үзмэр байрласан танхимын гэрлийг үзмэрт нь тохируулан багасгана.

1.3. Хэт ягаан туяа нь байгалийн болон зарим гэрэл үүсгэгчдээс цацран гардаг нүдэнд үл үзэгдэх өндөр давтамжтай туяа болохын хувьд ердийн гэрэлтэй адилаар дурсгалт зүйлд гэмтэл учруулдаг тул үзмэрийн танхим дахь хэт ягаан туяаны хэмжээ 75 микроватт/ люменээс хэтрэхгүй байвал зохино.

1.4. Дурсгалт зүйлийг гэрлийн гэмтлээс хамгаалахын тулд дараахь арга хэмжээг авна:

а) үзмэрийн танхимын цонхонд хаалт, хөшиг хийж хурц гэрэлтэй үед гүйцэд хаах;

б) үзмэрийг дэглэхдээ гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг цонхны гэрлээс хол байрлуулах;

в) гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрлийн хэмжээ бага өрөөнд буюу хоргонд байрлуулах;

г) үзэгчүй үед үзмэрийн танхимын гэрлийг унтраах;

д) гэрэл мэдрэмтгий үзмэрийг тогтмол үзэж, ялангуяа бөс даавуун эдлэлийн нугалаасыг өөрчилж, өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгаж байх;

е) гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг үзмэрт аль болохоор байнга тавихгүй байхын тулд үе үе солих, өөр зүйлээр орлуулах, хуулбарыг нь байрлуулах арга хэмжээ авч байх;

ж) үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулах;

з) хэт ягаан туяа нь 75 микроватт/люменээс илүүгүй байвал гэрлийн шилэнд хэт ягаан туяаны тунгалаг хуванцар шүүлтүүр хэрэглэх;

и) цонхны гэрэл зохих шаардлагатай нийцэхгүй бол хэт ягаан туяанаас хамгаалах өнгөт болон тунгалаг шүүлтүүр байрлуулах.

Хоёр. Харьцангуй чийг ба дулааныг тэнцвэртэй байлгах

2.1. Агаарын найрлаган дахь чийгийн их, багаас болж дурсгалт зүйл гэмтэхээс сэргийлж тухайн температурт байгаа чийгийн хэмжээг мөн температурт байх ханасан чийгийн хэмжээнд харьцуулж тодорхойлдог харьцангуй чийгийг тогтмол хянана.

2.2. Харьцангуй чийг бага байхад цаас, мод, даавуу, арьс шир, яс зэрэг материалууд агшиж хатах ба үүний улмаас хагарч хугарамтгай болно. Харьцангуй чийг их байхад металл эдлэл зэврэх ба цаас, мод, даавуу, арьс шир, яс хөвн тэлж, хөгцөрдөг. Эдгээр органик материалууд нь их чийг авахдаа хөөж, бага чийгтэй үед агшин хөдөлж байдгаас дурсгалт зүйл гэмтэхийн гол шалтгаан болно.

2.3. Үзмэрийн танхим, сан хөмрөгийн өрөө сэрүүн байхад агаарын чийгийн хэмжээ ихсэж, дулаан нэмэгдэхэд агаарын чийг багасдагийг харгалзан дурсгалт зүйлийг аль болох сэрүүн нөхцөлд байлгана.

2.4. Холимог материалуудаар хийсэн дурсгалт зүйлийг хадгалах агаарын харьцангуй чийгийг 35%-65%-ийн хооронд байлгана.

2.5. Үзмэрийн танхимын дулааныг 20^0С түвшинд тогтмол байлгана.

2.6. Цонх, хаалга, халаагуур болон барилгын хананаас хамааран нэг өрөөн дотор агаарын чийг, дулаан янз бүр байдгийг анхаарч музейн барилга, сан хөмрөгийн өрөөнүүдийн агаарын чийг, дулааныг байнга хэмжиж байна.

2.7. Агаарын чийг, дулааныг хэмжиж тохируулахдаа дараахь зарчмыг баримтална. Үүнд:

а) хэрэв музей олон байшинд байрладаг, олон сан хөмрөгтэй бол хэд хэдэн хэмжигчийг хэрэглэх ба хэмжигчийн байршлыг жил бүр солих;

б) хэмжигч тус бүрийн дулаан, чийгийн заалтыг өдөр бүр тэмдэглэх;

в) тэмдэглэлийг жилийн турш хөтлөх бөгөөд музейн удирдлага уг тэмдэглэлийг сард нэг удаа шалгаж байх;

г) үзмэрийн хадгалалтын нөхцөл тохирч байгаа эсэх талаар музейн удирдлага тогтмол танилцах;

д) улирлын чанартай буюу өвөл нийтэд зориулсан үйлчилгээ явуулдаггүй музейнүүдэд дурсгалт зүйлийг харьцангуй чийгийн хэлбэлзлээс хамгаалж барилгын гадна хананаас үзмэрийг хол байлгах;

е) хавар, намрын сэрүүн улиралд агаарын чийг их хэлбэлзэх тул хяналтын горимыг чангатгах;

ж) нар шарж огцом халахаас урьдчилан сэргийлж цонхны хаалтыг хааж байх;

з) музейг гэнэт халаах, хөргөхөөс болгоомжилж, өвөлд хоёроос гурван өдөр алгуур халааж, халаалт ихэссэн үед аажмаар бууруулж сэрүүн болгох;

и) музейн орчны тохиромжтой нөхцлийг бүрдүүлэхийн тулд дулаан, чийг тохируулагчийг ашиглах.

Гурав. Агаарын бохирдолтоос хамгаалах

3.1. Хөрсний эвдрэл, замын хөдөлгөөн, ойр орчмын үйлдвэр, гэр хорооллын утаа тортогноос үүссэн тоос, шороо нь бохирдолтын түгээмэл хэлбэрүүд учир тэдгээрийн хэсгүүд дурсгалт зүйлийн гадаргууд тогтож бохирдуулах, хорхой шавьж үржих нөхцлийг бүрдүүлэхээс сэргийлнэ.

3.2. Дурсгалт зүйлийг агаарын бохирдолтоос хамгаалахдаа дараахь зүйлийг мөрдлөг болгоно. Үүнд:

а) тоос шороог багасгахын тулд гадна үүдэнд гутлын чийгтэй алчуур байнга тавих;

б) цонх, хаалганы онгорхой цоорхойгоор тоос шороо орохоос сэргийлж ан цавыг засварлаж, цонхонд шүүлтүүр тор хийх;

в) музейн байшин барилга дотор тамхи татахыг хориглох;

г) музей ажиллахгүй үед дурсгалт зүйлийг хөвөн даавуу бүтээлгээр бүтээх, бүтээлгийг улирал тутам угааж цэвэрлэх;

д) дурсгалт зүйл дээр нарийн тоос суухаас урьдчилан сэргийлж цемент, тоосгон шалыг будах буюу дэвсгэр дэвсэх ба үзмэрийн хоргоны зай завсрыг бөглөх;

е) зам талбай, үзмэрийн танхим, сан хөмрөгийн өрөөг тогтмол цэвэрлэх;

ж) бохирдсон дурсгалт зүйлийг цэвэрлэхдээ зориуллатын болон зөөлөн материалыг ашиглаж, шаардлагатай үед мэргэжлийн байгууллага хүмүүст хандах.

Дөрөв. Хортон шавьжнаас хамгаалах

4.1. Хортон шавьж нь харанхуй, чийгтэй, дулаан газар байрлаж үслэг эдлэл, ноос, арьс шир, торго, даавуу, цаас зэрэг түүх, соёл, байгалийн болон угсаатны зүйн дурсгалт зүйлийг идэж устгадаг болохыг анхаарч дараахь шаардлагыг мөрдлөг болгоно. Үүнд:

а) музейн ажилтан бүр хорхой идэж болох үзмэрийг байнга хянаж, хорхойноос гадна гуужсан арьс өндөг, эрвээхэй байгаа эсэхийг тогтмол шалгах;

б) үзмэрийн танхим, сан хөмрөгийн өрөөг байнга цэвэрлэж, хог хаягдлыг нэн даруй зайлуулж байх;

в) үзмэрийн танхим болон сан хөмрөгт хүнсний зүйл байлгахыг хориглох;

г) цонх, хаалганы ан цавыг бөглөж, онгорхой цонх, хаалганд торон хаалт хийх;

д) хорхой шавьж өсөж үржих нөхцлийг бүрдүүлдэг харанхуй, дулаан, чийглэг орчин бий болгохоос урьдчилан сэргийлэх ба хаврын улиралд илүү анхаарах;

е) музейн барилгын дээвэрт тагтаа, шувуу үүрлэхээс болгоомжлох;

ж) музейн барилгын хэсгүүдэд мөөг, мөөгөнцөр үүсэхээс сэргийлэх;

з) гаднаас оруулж байгаа аливаа дурсгалт зүйлд хорхой шавьж байгаа эсэхийг нарийн шалгаж, үг дурсгалт зүйлийг 2 сарын турш тусгай уут, саванд тусгаарлаж, хорхой шавьж байгаа эсэхийг дахин шалгасны дараа үзмэрт байрлуулах;

и) хорхой шавьж орохоос сэргийлж үзмэрийн хорго, сан хөмрөгийн шүүгээ, шургуулгын нүх сувийг битүүлэн, үзмэрийг уут болон битүү саванд хийж хадгалах.

4.2. Музейд хортон шавьж илэрсэн тохиолдолд тэдгээрийг цаг алдалгүй устгаж цэвэрлэх талаар дараахь арга хэмжээг авна. Үүнд:

а) хорхой шавьжинд идэгдсэн дурсгалт зүйлийг бусад дурсгалаас яларалтай тусгаарлаж, тусгай уут, саванд хийж, амсрыг нь битүүмжлэн уях;

б) хорхой шавьжинд идэгдсэн дурсгалт зүйл байсан газрын ойр орчмын тавиур, хорго, шал болон бусад дурсгалт зүйлд шавьж тархсан эсэхийг шалгах;

в) хорхой шавьж тархаагүй тохиолдолд ч тусгайлан бэлтгэсэн найдвартай газарт дурсгалт зүйлүүдийг түр шилжүүлж, түүний орчныг цэвэрлэх;

г) хорхой шавьжтай газар болон тэдгийг устгасан газрын орчныг тоос сорогчоор соруулах;

д) тоос сорогчийн утаан доторхи хог хаягдлыг сайтар битүүмжлэн хаях ба тоос сорогчийн уутыг савантай усанд угааж, тоос сорогчид хийхээс өмнө гүйцэд сайн хатаах;

е) дурсгалт зүйл байрлаж байсан хорго, тавиур, шүүгээ, савны бүх гадаргуур савантай халуун усаар угаж, цэвэр усаар зайлж, алчуураар хаттал арчиж дурсгалт зүйлийг бүцаж тавихаас өмнө тавиурыг бүрэн хатаах ба тоосны бүтээлгийг угаах.

4.3. Дурсгалт зүйлд үүрлэсэн хорхой шавьжийг тоос сорогчоор соруулах буюу хатуу үстэй сойзоор нямбай цэвэрлэх ба энэ тохиолдолд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

а) дурсгалт зүйлд байгаа амьд болон үхсэн хорхой шавьж, өндгийг тоос сорогчийн сойзоор цэвэрлэж соруулах ба үслэг болон өдөн үзмэрийг сөрүүлэн сойздож соруулах (Үслэг эдлэлийн үс унахаас болгоомжлох ба унасан үсийг гүйцэд соруулж авна);

б) хорхой шавьж дахин илэрсэн эсэхийг 4-6 долоо хоногийн турш хоёр хоног тутамд ажиглах ба хорхой шавьж дахин илэрвэл дээрхи журмын дагуу давтан цэвэрлэх.

4.4. Дурсгалт зүйлд үүрлэсэн хорхой шавьжийг хөлдөөж устгахдаа дараахь зарчмыг баримтална. Үүнд:

а) дурсгалт зүйл тус бүрийг хөлдөөгч уут буюу гялгар уутанд хийх ба жижиг овортой дурсгалт зүйлийг тус тусад нь хийж хөлдөөх;

б) дулааны улиралд хөргөгч болон хөлдөөгчийг ашиглах ба хөргөгчид уутыг байрлуулахдаа уутны орчимд агаарын эргэлт сайн байхаар тооцож хөлдөөлтийг -20^{0}C температурт 4 цагаас багагүй хугацаагаар үргэлжлүүлэх;

в) өвлийн улиралд дурсгалт зүйлийг гадаа гаргаж хөлдөөх;

г) хөлдөөсөн дурсгалт зүйлийг уутгай нь аажмаар гэсгээх;

д) хөлдөөж, гэсгээх ажиллагааг давтан хийх ба дараа нь тоос сорогчоор соруулах.

Тав. Дурсгалт зүйлийн аюулгүй байдлыг хангах

5.1. Музейн ажилтнуудын зүй бус үйлдлээс шалтгаалан дурсгалт зүйлд гэмтэл учирдаг тул тэдгээрийг байрлуулах, зөөж тээвэрлэх, боож баглах зэргээр хөдөлгөөнд оруулахдаа аюулгүй байдлыг бүрэн хангана. Үүнд:

а) музейн ажилтнууд дурсгалт зүйлтэй харьцахдаа гараа цэвэр байлгаж, зориулалтын бээлий өмсөх (Хүний гараас байнга тос, давс ялгарч эд зүйлсийг гэмтээхэд хүргэдэг);

б) ихэнх дурсгалт зүйл нь хэврэгшсэн буюу урьд өмнө сэргээн засварлагдсан байгилгийг харгалзан тэдгээрийн байршлыг солих тохиодолд үргэлж хоёр гараараа барих;

в) дурсгалт зүйлийг доргио чичиргээнд аль болох өртөхгүй байхаар бэхэлж байрлуулах;

г) дурсгалт зүйлтэй харьцахдаа ярах, хүчлэх, хурдан хөдөлгөөн хийхээс болгоомжлох;

д) дурсгалт зүйлийг хөдөлгөхийн өмнө түүнийг байрлуулах байр, савыг урьдчилан бэлтгэж, замд саад болох зүйлийг зайлуулах;

е) дурсгалт зүйлд гэмтэл учруулж болох гинж, оосор зэргийг хувцандаа зүүхгүй байх;

ж) дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх, боож баглахдаа зориулалтын багаж, тоног төхөөрөмж, материал хэрэглэх;

з) дурсгалт зүйлтэй харьцахад гарч болзошгүй аливаа гэмтлийг сан хөмрөгч буюу захиралд даруй мэдэгдэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

5.2. Музейн удирдлага нутаг дэвсгэрийнхээ холбогдох байгууллагуудтай хамтран дурсгалт зүйлийг гал, усны аюулаас хамгаалах урьдчилсан арга хэмжээ авна. Үүнд:

а) галын аюулын үед дурсгалт зүйлийг аврах төлөвлөгөө, ажиллах дүрмийг батлан гаргаж, ажилтнуудыг түүний дагуу дадлага хийлгэсэн байх;

б) галын аюулаас хамгаалах болон хортон шавьжтай тэмцэх мэргэжлийн байгууллагуудын үзлэг шалгалтыг жилд нэг удаа хийлгэх.

5.3. Музейн цуглуулгад байгаа төрөл бүрийн материал нь музейн ажилтнууд болон үзэгчдийн

эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдгийг харгалзан дараахь онцлог дурсгалт зүйлтэй анхаарал болгоомжтой харьцвал зохино. Үүнд:

а) Органик дурсгалт зүйл. Нэхмэл, арьс шир, цаас зэрэг (органик) дурсгалт зүйл нь чийг авбал амархан үнэр орох бөгөөд энэ нь хүнд харшил өгөх, ханиалгуулах зэрэг сөрөг нөлөө үзүүлж болно.

б) Галт болон бусад зэвсгүүд. Галт зэвсэгтэй хамт сумыг дэлгэн үзүүлж болохгүй. Сумыг галт зэвсгээс тусад нь хадгална. Зэвсгийн сан хөмрөг найдвартай цоожлогдсон байх ёстой.

в) Хортой ургамлын үзмэр. Хорт ороонго ургамал хатсаны дараа тосондоо хороо үлдээдэг тул тодорхой хаяглаасан битүү уутанд хатаамлыг хадгалах, үзмэрийг хоргонд буюу үзэгчид хүрэхгүй газар байлгах ба үзмэртэй харьцахдаа резинэн бээлий өмсөх шаардлагатай.

г) Хортой эрдэс бүхий үзмэр. Зэвтэй төмөр нь төмрийн улаан гүрийн тоос гаргадаг бөгөөд түүнийг уушгины хорт хавдар үүсгэж болохыг анхаарч сан хөмрөг, үзмэрийн танхимыг тоос дэгдэлтээс хамгаалсан байна. Тоосыг соруулахдаа хамгаалалтын баг хэрэглэнэ. Зэс, гууль, хүрэл дурсгалт зүйлийг зэврэлтээс урьдчилан сэргийлэгч бодис (бензотриазол)-оор нэг удаа арчина. Энэ бодисыг хорт хавдар үүсгэж болох талтай гэж үздэг. Металл дурсгалт зүйлийн ногоон нунтаг хөгц, зэс, гууль чимэглэлтэй арьс ширэн эдлэл дээрхи ногоон лав шиг бодис биед орвол хортой. Хүний арьсанд энэ бодис хүрвэл савантай усаар даруй угаана.

д) Эм, мэс заслын багажууд. Ийм төрлийн дурсгалт зүйлтэй байнга резинэн бээлийтэй харьцана. Шингэн, нунтаг, үрэл эм, химийн бодисыг үзүүллэгт үзэгчдийн гар хүрэхээргүй газар байрлуулах, сан хөмрөгт хадгалахдаа хөдөлгөөнгүй тавиур дээр сайн бөглөөтэй шилэн саванд хийнэ. Хатуу цаасан хайрцагтай буюу боодолтой эмийг битүү уутанд хийж, тодорхой хаяглан тусгайлан тавибал зохино.

е) Хорхой шавьж устгадаг бодисын аюулгүй байдал. Хорхой шавьж устгадаг бодисыг хэрэглэхдээ хүний арьсанд хүрэхээс болгоомжлох. Музейн хортон шавьжийг устгахдаа вапона, зурдаг хор, нафталин, парадихлоробензин, рэйд, бөөрөнхий хорыг өргөн ашигладаг. Эдгээр бодисууд нь мэдрэлийн төв системд янз бүрийн хэлбэрээр нөлөөлдөг. Тухайлбал, парадихлоробензин, нафталин, рэйд (пиретин) элэг, бөөрөнд нөлөөлдөг бол вапона2 (дихлорвос) хорт хавдар үүсгэдэг гэж үздэг. Иймд хорхой шавьж устгах хороор амьсгалахаас болгоомжлох, хамгаалалтгүй гараар барихгүй байх, бодисыг хэрэглэх үед ил задгай тавихгүй байх зэргийг анхаарвал зохино.

ж) Уусмалын аюулгүй байдал. Музейд байвал зохих цорын ганц уусмал бол ацетон бөгөөд түүнийг бөх бат, галд тэсвэртэй саванд хадгалж, хаягийг тодорхой бичсэн байх шаардлагатай. Хэрвээ ацетоныг асгавал дурсгалт зүйлийг нэн даруй холдуулах буюу өөр өрөөнд шилжүүлж, өрөөний хаалгыг хааж, "орохыг хориглоно" гэсэн анхааруулга тавина. Асгарсан ацетоныг 24 цагийн дотор арилгавал зохино.

Лакан дотор байдаг крилон гэдэг уусмал нь эрүүл мэндэд аюултай. Крилон сүрчигийг хэрэглэхдээ тусгаарласан өрөө байранд шүршсэний дараа уг байрнаас нэн даруй гарч хаалгыг хааж, нэг цаг орчим өрөөнд орохыг хориглоно. Арьсанд хүргэхээс болгоомжил. Эдгээр уусмалыг сайн агаажуулсан орчинд буюу гадаа байлгаж, задгай гал, цахилгаан хэрэгслээс хол хадгалбал зохино.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны тавдугаар сарын 18 №22 (101)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

187. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 26 294

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

188. Х.Болдбаатар, С.Дашдулам нарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 63 294

189. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 64 294

190. Ц.Гантулгыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 65 296

191. Ч.Өлзийбаярыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 66 296

192. Р.Цэзэнг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 67 296

193. Түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Дугаар 68 296

194. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай Дугаар 69 296

195. Элчин сайдыг томилох тухай Дугаар 70 297

196. "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг батлах тухай Дугаар 71 297

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 26** **Улаанбаатар хот**

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1998 оны 10 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг шүүн таслах ажиллагаатай холбогдсон бусад хуулиудтай уялдуулах нь зүйтэй гэж үзэж уг төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 63** **Улаанбаатар хот**

Х.Болдбаатар, С.Дашдулам нарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Бөхийн самбо, жу-до барилдааны төрлөөр дэлхий, тив, олон улсын болон Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, 1998 онд бөхийн самбо барилдааны дэлхийн аварга болж, эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяаг нь үнэлж дор дурдсан бөхчүүдэд Монгол улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

1. Халиуны Болдбаатар - Бөхийн самбо барилдааны эрэгтэйчүүдийн улсын шигшээ багийн тамирчин
2. Самбуугийн Дашдулам-Бөхийн самбо барилдааны эмэгтэйчүүдийн улсын шигшээ багийн тамирчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 64** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, биеийн тамир, спорт, шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл, хууль хяналт, төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дашцэрэнгийн Балдорж - Дорнод аймгийн Баяндун сумын "Тоонот нутаг" нөхөрлөлийн дарга
2. Чойжилжавын Буян - Архангай аймгийн Биеийн тамир, спортын төвийн ахлах дасгалжуулагч
3. Дамдинжавын Ванданмагсар - Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл, сургалтын төвийн орлогч захирал
4. Хорлоогийн Ёндон - "Монгол цэргийн дайчин алдар" чуулгын дарга, ахмад бүжигчин
5. Лувсан-Ишийн Жамсран - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн зөвлөх эмч
6. Жамбалын Мөнхжаргал - Говь-Алтай аймгийн Бигэр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Гөлгөөгийн Аварзэд	- Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
2. Авирмэдийн Биньеэ	- Увс аймгийн Боловсрол, соёлын төвийн аргазүйч багш
3. Цогтын Галсандорж	- Дундговь аймгийн Луус сумын малчин
4. Бумбын Ганбаатар	- Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын хяналт, телевизийн хураамжийн албаны дарга
5. Эрдэнэчимэгийн Гэрэлтуяа	- "Монгол охид" бөхийн клубийн тамирчин
6. Дэмчигийн Дашдооров	- Өмнөговь аймгийн Прокурорын орлогч дарга
7. Өсөхбаярын Дашдулам	- Нийслэлийн "Автобус-1" ХК-ийн кондуктор
8. Жамбын Жүгдэр	- УИХ-ын Тамгын газрын зохион байгуулагч
9. Тогтаалын Какен	- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Засаг даргын Тамгын газрын туслэл
10. Вандангийн Ламжав	- Сэлэнгэ аймгийн "Урсгал-Ус" УҮГ-ын засварчин
11. Гонгорын Лхагвасүрэн	- Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн захирал
12. Бямбадоржийн Лувсангончиг	- Архангай аймгийн Батцэнгэл сумын малчин
13. Долгорсүрэнгийн Манал	- Төрийн хянан шалгах хорооны хянан байцаагч
14. Базаржавын Мэндбаяр	- Анагаах ухааны хүрээлэнгийн клиникийн III эмнэлгийн зөвлөх эмч
15. Баттогтохын Намжил	- Ховд аймгийн Зэрэг сумын "Ундрал" хоршооны дарга
16. Аюудайн Очир	- ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал
17. Буянтогтохын Оюунбаатар	- Нийслэлийн "Автобус-1" ХК-ийн жолооч
18. Ишдоржийн Рэнцэндорж	- Мөн компанийн жолооч
19. Гэжбалын Санжид	- Нийслэлийн Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
20. Жаргалын Сүрэнжав	- Увс аймгийн сум дундын шүүхийн ерөнхий шүүгч
21. Загдын Түмэнжаргал	- "Өдрийн сонин"сонины албаны дарга, хүүхдийн зохиолч
22. Гүрвэвын Хишигхүү	- Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрийн дарга
23. Жаалайн Цагаанбанди	- Завхан аймгийн барилгын "Алтан харш" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
24. Далхаагийн Цэвэгжав	- Ховд аймгийн эрчим хүчний барилга угсралтын "Алтай" трестийн орлогч дарга
25. Мөнхийн Шаарийбуу	- Өвөрхангай аймгийн Тараат сумын малчин
26. Шоовойн Шажинбат	- Монголын хөдөөгийн зохиолчдын холбооны сонины эрхлэгч
27. Дорлигийн Шомбодон	- Монголын бизнесийн хөгжлийн агентлагийн зөвлөх
28. Сэр-Одын Эрдэнэбат	- Бөхийн самбо барилдааны эмэгтэйчүүдийн улсын шигшээ багийн дасгалжуулагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Доржийн Даваг	- Төв аймгийн Заамар сумын соёлын төвийн эрхлэгч
2. Цоодолын Жаргал	- Өвөрхангай аймгийн хэвлэлийн "Ундрах эрдэм" ХХК-ийн захирал
3. Цагаадайн Идэш	- Ховд аймгийн Мөст сумын цаг уурын харуулын ажиглагч
4. Гончигийн Машбат	- Нийслэлийн Багануур дүүргийн хот тохижуулах конторын трактерчин
5. Пүрэвдаваагийн Отгонсүрэн	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 4 дүгээр яслийн эрхлэгч
6. Батсүхийн Очирхуяг	- Хэнтий аймгийн хянан шалгах хорооны дарга
7. Зургаанбайн Рысбек	- Баян-Өлгий аймгийн "Жана Өмир" сонины эрлэгч
8. Гэндэнгийн Сэлэнгэ	- Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн улсын байцаагч
9. Чойжилсүрэнгийн Цагаан	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
10. Норовын Чүлтэм	- Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр — **Дугаар 65** — **Улаанбаатар хот**

Ц.Гантулгыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан багийн иргэн Цэнд-Аюушийн Гантулгыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр — **Дугаар 66** — **Улаанбаатар хот**

Ч.Өлзийбаярыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн уснаас хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн ХӨТШ банкны Өвөрхангай аймаг дахь салбарын жолооч Чимэддоржийн Өлзийбаярыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр — **Дугаар 67** — **Улаанбаатар хот**

Р.Цэзэнг "Шударга журам" медалиар шагнах тухай

Хүний амь аврах, эрүүл мэндийг хамгалаах энэрэнгүй үйлст олон жил хувь нэмэр оруулж, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Увс аймгийн Улаангом сумын иргэн, донор Рэнцэнгийн Цэзэнг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр — **Дугаар 68** — **Улаанбаатар хот**

Түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Есүхэйн Тэмүжин Хамаг Монголын хаан сууж "Чингис хаан" хэмээн өргөмжлөгдсөний 810 жилийн ойг тэмдэглэхээр Чингис хаан судлалын олон улсын төв, "Чингис хааны дурсгалын цогцолбор сан" - гаас гаргасан санаачилгыг дэмжсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр — **Дугаар 69** — **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Нидерландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг тохоон томилсугай.

2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Жагваралын Ганибалыг Монгол Улсаас Нидерландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 70 | Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсаас Перу Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содовжамцын Хүрэлбаатарыг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 5 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 71 | Улаанбаатар хот

"Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг батлах тухай.

"Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг хавсралтын ёсоор батална.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЦОЛ ХҮРТЭЭХ, ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулах, цолны тэмдэг, одон, медаль, эдгээрийн үнэмлэхийг нөхөн болон сольж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Монгол Улсын төрийн шагнал, цэргийн болон дипломат цол, "Алдарт эх" I, II одон, ойн медальд нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх нь энэхүү журамд үл хамаарна.

Хоёр. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнахад нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх

3. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнахад төрийн ба төрийн бус байгууллагын болон улс төрийн нам, аж ахуйн нэгжийн анхан, дунд, дээд шатны удирдлага, Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар нэр дэвшүүлэхээр санал аргаж болно.

4. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар анхан шатанд дараахь урлуудаар хэлэлцэж нэр дэвшүүлнэ.

а/ материаллаг үйлдвэрлэл, үйлчилгээ, соловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, урлаг, шашин, эвлэл мэдээллийн болон бусад салбаруудад жиллагсад, орон нутгийн бүх шатны төр, ахиргааны байгууллагын ажилтныг ажлын газрынх нь хамт олны /томоохон үйлдвэр, аж ахуйн газрын хувьд цех, тасгийн ажилчдын / хурлаар;

б/ бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, засаг даргыг тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаар;

в/ Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн нам, төрийн бус байгууллагын ажилтнуудыг холбогдох шатны /сум, дүүрэг, аймаг, нийслэлийн г.м./ хамтын удирдлагын байгууллага /тэргүүлэгчид, зөвлөл гэх мэт/-ын хурлаар;

г/ энэ зүйлийн а, б, в-д зааснаас бусад иргэдийг баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар.

5. Хурлын ирц шагналд нэр дэвшигчдийн харьяалагдаж буй нэгжийн хамт олны 70-аас доошгүй хувь байх шаардлагатай бөгөөд хуралд оролцогсдын 80-аас дээш хувь нь шагналд нэр дэвшүүлэхээр зөвшөөрвөл тодорхойлолт гаргаж байгууллагын захиргаанд уламжилна. Байгууллагын захиргаа хамтын удирдлагын хурлаараа хэлэлцэж шийдвэрлэн тодорхойлолт гаргана.

6. Тодорхойлолтод шагналд нэр дэвшигч эрхэлсэн ажилдаа ямар содон санаачилга, бүтээл гаргасан, түүнийг хэрэгжүүлснээр улс, нийгэмд ямар ашиг тус өгснийг баримтаар дурдан тусгаж, ил амжилтанд тохирох цол, одон, медалийн нэр заасан саналаа бичиж, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга дарна.

7. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшигчийн анкет, тодорхойлолтыг хурлын албан тэмдэглэлээ, шийдвэрийн хамт сум, дүүргийн Засаг даргад уламжилна.

8. Сум, дүүргийн Засаг дарга саналаа тухайн шатны ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, зөвшөөрөгдсөн хүний материалыг аймаг, нийслэлийн Засаг даргад уламжилна.

9. Аймаг, нийслэлийн Засаг дарга бичиг баримтын бүрдэлт, шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, шагналд уламжлах эсэхийг нарийвчлан шүүж, холбогдох яам, харьяа дээд газар, төрийн бус байгууллага, улс төрийн нам, мэргэжлийн эвсэл, холбоодын орон нутгийн ба төв байгууллагын хамтын удирдлагын дүгнэлт, саналыг бичгээр авч хавсарган саналаа аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

10. Аймаг, нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчийн хуралдаан албан тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдсөн нэр дэвшигчийн асуудлаар тогтоол гаргаж, холбогдох материалын хамт Монгол Улсын Ерөнхий-лөгчид өргөн мэдүүлэх шийдвэр гаргана.

Өргөн мэдүүлэх бичигт аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга гарын үсэг зурж, тамга дарна.

11. Дараах албан тушаалд ажиллаж байгаа хүмүүс болон иргэдийг дор дурдсан албан тушаалтан Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

а/ Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас томилогддог бусад албан тушаалтныг **Монгол Улсын Их Хурлын дарга**; Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудыг Улсын Их Хурлын **Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга**;

б/ Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтнуудыг **Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;**

в/ Монгол Улсын Засгийн газраас томилдог албан тушаалтнуудыг **Ерөнхий сайд**, яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажилтнуудыг Монгол Улсын **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга**;

г/ Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг **Үндсэн хуулийн цэцийн дарга**;

д/ Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг төрийн төв байгууллагад ажиллагсдыг **холбогдох байгууллагын дарга**;

е/ Монгол Улсын бүх шатны шүүхийн шүүгчийг **Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга**;

ж/ Улсын Ерөнхий прокурорын орлогч, бүх шатны прокурор, гүйцэтгэх болон техникийн ажилтнуудыг **Монгол Улсын Ерөнхий прокурор**;

з/ цэргийн албан хаагчдыг **Батлан хамгаалахын сайд;**

и/ Улсын аюулгүй байдлыг хангах газарт ажиллагсдыг **тус газрын дарга**;

к/ цагдаагийн албан хаагчдыг **Хууль зүйн сайд;**

л/ тэтгэвэрт гараад аль нэг байгууллагад ажиллахгүй байгаа ахмадуудыг аймаг, нийслэлийн **ИТХ-ын тэргүүлэгчийн**

дарга;

м/ дипломат ажилтан, гадаадын иргэдийг **Гадаад харилцааны сайд**.

12. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхдээ дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

а/ нэр дэвшигчийн анкет /нэгдүгээр хавсралтаар/;

б/ тодорхойлолт;

в/ цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар анхан шатанд хурлаар хэлэлцсэн тухай албан тэмдэглэл;

г/ сум, дүүргийн Засаг даргын санал, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын албан тэмдэглэл, тогтоол;

д/ холбогдох дээд байгууллагын дүгнэлт, санал;

е/ аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн албан тэмдэглэл, гаргасан тогтоол, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргын гарын үсэг бүхий өргөн мэдүүлэх бичиг.

13. **Монгол Улсын Их Хурлын даргаас** өргөн мэдүүлсэн албан тушаалтанд бүрдүүлэх баримт бичиг нь Улсын Их хурлын даргын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет; Тамгын газрын ажилтнуудын хувьд хамт олны хурлын албан тэмдэглэл, УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет.

14. **Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын** өргөн мэдүүлсэн албан тушаалтны тухайд Тамгын газрын даргын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет; Тамгын газарт ажиллагсдын хувьд тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет, хамт олны хурлын албан тэмдэглэл.

15. **Монгол Улсын Ерөнхий сайдаас** өргөн мэдүүлсэн хүмүүсийн тухайд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн албан тэмдэглэл, тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет; Хэрэг эрхлэх газрын ажилтнуудын хувьд хамт олны хурлын албан тэмдэглэл, тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет; гадаадын иргэдийн тухайд Гадаад харилцааны сайдын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет; дипломат ажилтны хувьд хамт олны болон сайдын зөвлөлийн хурлын албан тэмдэглэл, Гадаад харилцааны сайдын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет.

16. **Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг** өргөн мэдүүлэхдээ цэцийн ажил хэргийн зөвлөлгөөнөөр хэлэлцсэн албан тэмдэглэл, Цэцийн даргын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, нэр дэвшигчийн анкет.

17. **УИХ-д аажлаа тайлагнадаг төрийн төв байгууллагад** ажиллагсдын хувьд хамт олны хурлын албан тэмдэглэл, байгууллагын даргын тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, анкет.

18. **Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, Батлан хамгаалахын сайд, Улсын ёоулгүй байдлыг хангах газрын даргын** өргөн мэдүүлсэн хүмүүсийн хувьд анкет, тодорхойлолт, өргөн мэдүүлсэн бичиг, тухайн байгууллагын зөвлөлийн хуралдааны албан тэмдэглэл, холбогдох шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн санал.

Тайлбар: Бүх шатны шүүх, прокурорын төв, орон нутгийн байгууллагад ажиллагсдын тухайд Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор өргөн мэдүүлнэ. Эдгээр ажиллагсдын тухайд энэ журмын 12-ын "а", "б", "в"-д заасан бичиг баримт, өргөн мэдүүлсэн бичиг болон тухайн байгууллагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн албан тэмдэглэл, холбогдох шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн саналыг бичгээр бүрдүүлнэ.

19. **Тэтгэвэрт гаргаад аль нэг байгууллагад ажиллахгүй байгаа ахмадуудын** тухайд ажиллаж байсан газар буюу мэргэжлийн

харьяа байгууллагын тодорхойлолт, аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргын өргөн мэдүүлсэн бичиг, анкет, Монголын ахмадын холбооны гүйцэтгэх хорооны тэргүүлэгчдийн хурлын албан тэмдэглэл, санал.

20. Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан ямар нэгэн албан тушаалтан, иргэнийг шагнахаар нэр дэвшүүлбэл Ерөнхийлөгчийн Тамгын газар хариуцаж тухайн хүнийг судалж зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Гурав. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах асуудлыг шийдвэрлэх, гардуулах, мэдээлэх

21. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнахад Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргана.

22. Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар өргөн мэдүүлсэн, холбогдох баримт бичгийн бүрдэлт, агуулгыг судлан, санал боловсруулж, шийдвэрийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.

23. Монгол Улсын цолны тэмдэг, одон, медаль, дагалдах мөнгөний чекийг үнэмлэхийн хамт Ерөнхийлөгч төрийн ордонд болон орон нутагт ёслол төгөлдөр гардуулна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн даалгавраар шагналыг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Ерөнхийлөгчийн зөвлөх, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга гардуулж болно.

24. Гадаадад суугаа Монгол Улсын болон гадаадын иргэний шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн даалгавраар тухайн улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, консул гардуулж болно.

25. Монгол Улсын цолны тэмдэг, одон, медаль гардуулах ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, шагнагдагчийн холбогдох салбарын сайд, байгууллагын удирдлага оролцох ба аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга оролцож болно.

26. Монгол Улсын цолны тэмдэг, одон, медалийг гардуулсан тухай албан тэмдэглэл /2 дугаар хавсралтаар/ үйлдэж Ерөнхийлөгчийн Тамгын газарт хадгална. Ерөнхийлөгчийн даалгавраар төрийн дээд шагналыг энэхүү журмын 23, 24 дүгээр зүйлээр эрх олгосон албан тушаалтан гардуулбал албан тэмдэглэлд гарын үсгээ зурж баталгаажуулан 1 сарын дотор Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.

27. Монгол Улсын цол хүртээсэн, одон, медалиар шагнасан, гардуулсан тухай хэвлэл, радио, телевизээр мэдээлнэ.

Дөрөв. Цолны тэмдэг, одон, медаль, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

28. Монгол Улсын цолны тэмдэг, одон, медаль, үнэмлэхийг ямар нэг шалтгаанаар үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүд нь зохих үнээр нь нөхөн сольж олгож болно.

29. Цолны тэмдэг, одон, медаль, үнэмлэхийг шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нөхөн сольж авахыг хүсвэл үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдлөө үнийг банкинд тушаасан баримт, эвдэрч гэмтсэн зүйлийн хамт Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.

30. Ерөнхийлөгчийн Тамгын газар өргөдлийг хянан үзэж цолны тэмдэг, одон, медаль, үнэмлэхийг нөхөн сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Хавсралт1

Зураг

МОНГОЛ УЛСЫН ЦОЛ ХУРТЭЭХ, ОДОН, МЕДАЛИАР ШАГНУУЛАХААР ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Овог: _____ 2. Нэр: _____ 3. Төрсөн огноо_____
/он, сар, өдөр/

4. Хүйс: _____ 5. Төрсөн аймаг, сум, хот _____

6. Одоогийн харьяалал: _____
/оршин суугаа аймаг, сум, хот/

7. Нийгмийн байдал: _____ 8. Регистр№ _____
/эхний хоёр үсгийг заавал бичнэ/

9. Боловсрол: _____ 10. Ажилладаг салбар: _____

11. Мэргэжил: _____

12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	: Хугацаа	: Эрхэлсэн ажил

13. Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /Монгол Улсын цол, одон, медаль/

№	Шагналын нэр	: Хэдэн онд

14. Шагнуулах үндэслэл: _____

15. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал _____

16. Хамт олны саналын хувь _____

Хавсралт 2

МОНГОЛ УЛСЫН ЦОЛНЫ ТЭМДЭГ, ОДОН, МЕДАЛЬ ГАРДУУЛСАН ТУХАЙ АЛБАН ТЭМДЭГЛЭЛ

НЭГ. Цолны тэмдэг, одон, медаль гардуулсан тухай

№	Шагнагдсан хүний овог, нэр	Шагналын нэр	Цолны тэмдэг, одон, медалийн дугаар	Зарлигийн он, сар, өдөр дугаар

Шагналыг хаана гардуулсан _____

Гардуулсан хүний нэр, албан
тушаал, гарын үсэг _____

ХОЁР. Гардуулаагүй цолны тэмдэг, одон, медалийн тухай

№	Шагнагдсан хүний овог, нэр	Шагналын нэр	Цолны тэмдэг, одон, медалийн дугаар	Зарлигийн дугаар он, сар, өдөр	Гардуулаагүй шалтгаан	Цолны тэмдэг, одон, медаль хаана байгаа

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны тавдугаар сарын 26 №23 (102)

Гарчиг

Нэг. Монгол Улсын хууль

197. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-5-12-ны хууль/ 304

198. Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /1999-5-12-ны хууль/ 304

199. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-5-12-ны хууль/ 304

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

200. Банкнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 28 304

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

201. Зарим шүүгчийг чөлөөлж, томилох тухай Дугаар 72 305

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

202. Дүрэм батлах тухай Дугаар 56 306

203. Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Дугаар 57 309

204. Дүрэм батлах тухай Дугаар 58 309

205. Хөтөлбөр батлах тухай Дугаар 64 311

206. Хөтөлбөрт нэмэлт оруулах тухай Дугаар 65 319

207. "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 66 321

Тав. Яам, агентлагийн акт

208. Журам батлах тухай /Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн сайдын хамтарсан захирамж, тушаал/ Дугаар 29,121,80 328

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт "4 дэх" гэснийг "5 дахь"; мөн зүйлийн 12 дахь хэсэгт "10 дахь" гэснийг "11 дэх" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

"

6.Пиво	-	литр тутмаас 0.50	литр тутмаас 0.50

"

2 дугаар зүйл.Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "архи, дарсанд" гэснийг "архи, дарс, пивонд" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"13.2.Импортын барааны болон улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжээс төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 100 хувийг улсын төвлөрсөн төсөвт; орон нутгийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжээс төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 80 хувийг улсын төвлөрсөн төсөвт, 20 хувийг орон нутгийн төсөвт тус тус оруулна."

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "15 сая" гэснийг "10 сая" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 28 **Улаанбаатар хот**

Банкнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Банкнуудын талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/, Монголбанк /Ж.Үнэнбат/-нд даалгасугай:

1/банкны салбарыг бэхжүүлэх, банкнуудын төлбөрийн чадварыг сайжруулах, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай байршуулах чад-

вартай банкны систем бүрдүүлэх, олон нийтийн зүгээс банкны салбарт үзүүлэх итгэлийг дээшлүүлэх, банкнаас эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор Төрөөс мөнгөний бодлогын талаар 1999 онд баримтлах чиглэлийн хүрээнд банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг зрчимжүүлэх;

2/банкны салбарт хийх бүтцийн өөрчлөлтийн асуудлаар олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, бүтцийн өөрчлөлтийн явцын талаар зохих мэдээлэл, саналыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, зохицуулах зөвлөлд ирүүлж зөвлөмж авч байх;

3/санхүү, төлбөрийн чадвар нь муудсан банкнуудын талаар дор дурдсан арга хэмжээ авах:

а/Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк, Сэргээн босголтын банк, Хөдөө аж ахуйн банкны 1998 оны санхүүгийн тайланг олон улсын хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулах;

б/хөндлөнгийн хяналтын дүгнэлт болон газар дээрх шалгалтын дүнг үндэслэн Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк, Сэргээн босголтын банк, Хөдөө аж ахуйн банкны бүтцийн өөрчлөлтийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

в/эдгээр банкнуудын бүтцийн өөрчлөлтөд зориулж Засгийн газраас гаргасан өрийн бичгийн төлөгдөөгүй үүний өглөгийг барагдуулах, цаашид хүний төлбөрийг хугацанд нь барагдуулж байх, бүтцийн өөрчлөлтийн өрийн бичгийг түргэн борлогдох чадвар бүхий үнэт цаасаар солих;

г/ Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк, Сэргээн босголтын банк, Хөдөө аж ахуйн банкны хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулж, дутагдаж байгаа өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломж олгох, Монголбанкнаас тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгийг зохих түвшинд хүртэл нэмэгдүүлээгүй банкны гишүүдэд санхүүгийн хариуцлага хуулийн дагуу хүлээлгэж дүрмийн сангаар нь алдагдлыг нөхүүлэх;

д/ Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк, Сэргээн босголтын банк, Хөдөө аж ахуйн банк санхүү, төлбөрийн чадвар муудсан шалтгааныг судалж, дүгнэлтээ энэ оны 5 дугаар сард багтаан Улсын Их Хуралд танилцуулах.

2.Банкны салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэхэд шаардлагатай дараахь чиглэлийн хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж 1999 оны 5 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/банк байгуулах зөвшөөрөл олгоход тавигдах шалгуур үзүүлэлт, нөхцөл, жүрмыг чангатгах, банкинд авах албадлагын арга хэмжээний зорилго, үндэслэл, Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч болон эрх хүлээн авагчийн эрх, үүргийг тодорхой болгох, хугацаа хэтэрсэн зээлийг шуурхай төлүүлэх, зээл төлөхөөс зайлсхийж байгаа зээлдэгчдэд албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн актыг боловсронгуй болгох;

2/банкууд дахь шууд болон шууд бус төрийн өмчийн хувь хөрөнгийг хувьчлах үзэл баримтлал, эрх зүйн байдлыг тодорхойлох.

3.Энэ тогтоолын биелэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Ганболд/-нд даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 72 **Улаанбаатар хот**

Зарим шүүгчийг чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Сосорбарамын Энхжаргалыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, мөн аймгийн шүүхийн шүүгчээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр **Дугаар 56** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2."Агентлагууд байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 300 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 6-г "6.Иргэний нисэхийн ерөнхий газар" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г.БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны 56 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "Ерөнхий газар" гэх) нь иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаархи Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд бүтцийн салбарын бодлого, Иргэний нисэхийн тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын агентлаг мөн.

2.Ерөнхий газрын үндэсн зорилго нь Монгол Улсад иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангуулахад оршино.

3.Үндэсн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд иргэний нисэхийн эрх зүйн орчинг бүрдүүлж, Монгол Улсын агаарын зайд хамгийн аюулгүй, үр дүнтэй зохицуулалтыг хийх, хяналт тавих замаар Ерөнхий газраас үзүүлж буй үйлчилгээг дэлхий нийтийн жишигт хүргэх, улмаар үндэсний эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх явдлыг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгоно.

4.Ерөнхий газар нь үйл ажиллагаандаа Үндэсн хууль, Иргэний нисэхийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Чикагогийн конвенци болон иргэний нисэхийн холбогдолтой Монгол Улсын олон улсын гэрээ, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

5.Ерөнхий газар нь Дэд бүтцийн хөгжлийн сайдын өмнө өөрийн ажлыг хариуцаж, тайлагнана.

6.Ерөнхий газар нь зохих журмын дагуу үйлдсэн тамга,тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Ерөнхий газрын нислэгийн аюулгүй байдлыг хариуцсан алба нь иргэний нисэхийн бичиг баримтыг баталгаажуулах зорилгоор тусгай тэмдэг хэрэглэж болно.

7.Ерөнхий газрын билэгдлийн загвар болон хэрэглэх журмыг Дэд бүтцийн хөгжлийн сайд батална.

Хоёр.Ерөнхий газрын үндэсн үүрэг, эрх

8.Ерөнхий газар нь Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заагдсан бүрэн эрхээс гадна дор дурдсан үндэсн үүргийг хэрэгжүүлнэ:

а/Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт тус улсын нутаг дэвсгэрт болон хилийн гадна нислэг-техникийн хэрэг тохиолдсон нөхцөлд түүнийг шинжлэн шалгахад оролцох;

б/агаарын тээврийн компаниудаас авах нисэх буудлын болон навигацийн үйлчилгээний хураамжийн хэмжээг олон улсад дагаж мөрдөж байгаа тарифт нийцүүлэн тогтоох;

в/агаарын харилцааны болон иргэний нисэхийн салбарт хамтран ажиллах олон улсын гэрээний төслийг Засгийн газраас өгсөн чиг үүргийн дагуу боловсруулах;

г/Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын агаарын хөлөгт нислэгийн аюулгүй байдлын шалгалт хийх;

д/иргэний нисэхийн асуудлаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/ болон гадаад улсын иргэний нисэхийн асуудал эрхэлсэн байгууллагуудтай хамтран ажиллах;

е/батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг гүйцэтгэж, уг үйлчилгээг боловсронгуй болгох арга механизмыг боловсруулах;

ж/Иргэний нисэхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албыг Ерөнхий газрын харьяанд байгуулж ажиллуулах;

з/аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн хяналтын шаардлагыг үндэслэн ӧмчийн хэлбэр харгалзахгүйгээр агаарын тээврийн компанидын бүтцэд зохих ӧөрчлөлт оруулах, шаардлагатай гэж үзвэл тодорхой мэргэжлийн удирдах албан тушаалтанг ажилд тэнцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, энэ талаар компанийн удирдлагад мэдэгдэл ӧгөх, шаардлага тавих;

и/Иргэний нисэхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан холбоо, навигацийн хангалтыг нислэгийн аюулгүй байдлыг хангах түвшинд хийж гүйцэтгэх.

Гурав. Ерөнхий газрын үйл ажиллагааны зохион байгуулалт

9.Ерөнхий газар нь дараахь үндсэн ажил, үйлчилгээг эрхлэн явуулна:

а/иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт боловсруулж мөрдүүлэх;

б/нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хянах, зохицуулах;

в/нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх;

г/аэродром, нисэх буудлуудын үйлчилгээ үзүүлэх.

10.Ерөнхий газар нь үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын шаардлагад нийцсэн,нислэгийн аюулгүй байдлыг хангуулахад чиглэсэн тогтолцоо бүхий бүтэцтэй байна.

11.Ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг Дэд бүтцийн хөгжлийн сайд батална.

12.Ерөнхий газрын албад, харьяа байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тоо, цалингийн санг холбогдох байгууллагуудтай зөвшилцөж захирал батална.

13.Ерөнхий газрын захирлыг Дэд бүтцийн хөгжлийн сайдын санал болгосноор Засгийн газар, дэд захирлыг захирлын санал болгосноор Дэд бүтцийн хөгжлийн сайд томилж, чөлөөлнө.

14.Албад, харьяа байгууллагын дарга нь тухайн салбарын үндсэн үйл ажиллагааны чиглэлийн мэргэжилтэй байх бөгөөд түүнийг захирал томилж, чөлөөлнө.

15.Ерөнхий газрын захирал нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/Ерөнхий газрын нэрийн ӧмнөөс бусад байгууллагатай харилцах;

б/Ерөнхий газрыг гадаад, дотоодод төлөөлөх;

в/олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах, Ерөнхий газрын дотоод журмыг баталж мөрдүүлэх;

г/батлагдсан төсвийг захиран зарцуулах;

д/дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэх зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор шаардлагатай бол гадаад, дотоодын шинжлэх ухааны байгууллага, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах, тэдгээрт цалин, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

е/Иргэний нисэхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл заасан нислэгийн аюулгүй байдлын хяналт хариуцсан байцаагчийн бүрэн эрх;

ж/захиралд хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

16.Захирал нь Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу нислэгийн аюулгүй байдалд хамаарах бүрэн эрхээ Ерөнхий газрын дэд захирал, ажилтнуудад албан ёсоор гэрээ байгуулан шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

17.Ерөнхий газрын нислэгийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хариуцан хэрэгжүүлнэ:

а/иргэний агаарын хөлгийг бүртгэх, гэрчилгээ олгох;

б/нисэхийн мэргэжлийн ажилтнуудаас шалгалт авах, үнэмлэх олгох;

в/агаарын тээврийн байгууллагуудад гэрчилгээ олгож тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих;

г/агаарын навигацийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

д/аэродром, нисэх буудалд гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

е/нисэхийн аюулгүй байдлыг хангах байгууллагуудад гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

ж/сургалт,засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлт эрхлэх байгууллагуудад гэрчилгээ олгож, тэдгээрийн үйл ажиллагаанд нь хяналт тавих;

з/иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж боловсруулах;

и/нислэгийн аюулгүй байдлын холбогдолтой эрх зүйн актуудыг сурталчлах, сургалт явуулах.

18.Ерөнхий газрын нисэхийн үйлчилгээ хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хариуцан хэрэгжүүлнэ:

а/нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ;

б/эрэн хайх, авран туслах үйлчилгээ;

в/холбоо, навигацийн үйлчилгээ;

г/агаарын навигацийн мэдээллийн үйлчилгээ;

д/цаг уурын мэдээгээр хангах үйлчилгээ;

е/аэродром байгуулах, засварлах болон иргэний нисэхтэй холбоотой бусад байгууламж барих, ашиглах;

ж/олон улсын нисэх буудлын үйлчилгээ;

з/орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;

и/агаарын хөлгийн газрын тоног төхөөрөмжийн үйлчилгээ;

к/шатах тослох материалаар хангах үйлчилгээ;

л/нисэхийн мэргэжлийн сургалт;

м/иргэний нисэхийн үйлчилгээний хөгжлийн стратеги төлөвлөлтийг боловсруулах;

н/захиргаа, хүний нөөцийн болон ажиллагсдын нийгмийн асуудал.

19.Ерөнхий захирлын дэргэд түүнд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн болон түүний ажиллах журмыг захирлын тушаалаар батална.

20.Зөвлөл нь Ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа холбоог шуурхай ханган зохицуулах, байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

21.Зөвлөл нь захиралд дараахь асуудлаар шийдвэр гаргахад нь зөвлөх үүрэгтэй:

а/агаарын тээвэрлэгчийн эрх олгох, эрхийг хасах;

б/агаарын шинэ хаалга, маршрутыг нээх, хаахтай холбогдох асуудал;

в/тогтмол үйл ажиллагаатай аэродром, нисэх буудал байгуулах, татан буулгах;

г/гадаадын агаарын тээвэрлэгчдэд Монгол Улсад тогтмол нислэг үйлдэх зөвшөөрөл олгох;

д/иргэний нисэхийн хууль, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Дэд бүтцийн хөгжлийн яаманд санал оруулах;

е/нислэгийн аюулгүй байдлын байцаагч томилох, түүнд эрх шилжүүлэх асуудал;

ж/агаарын навигацид холбогдолтой үйлчилгээ;

з/байгууллагын нэгдсэн төлөвлөгөө, тайлан;

и/гадаад арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө;

к/захирлын шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

22.Ерөнхий газар нь салбарын хөгжлийн урт, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөн дээр үндэслэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд үйл ажиллагааныхаа орлогоор зарлагаа нөхөх зарчмаар ажиллана. Дээрх төлөвлөгөөнүүд дараахь хугацаат хэмарна:

а/урт хугацааны стратеги төлөвлөгөө (10-15 жил);

б/дунд хугацааны төлөвлөгөө (3-5 жил);

в/жилийн төлөвлөгөө (1 жил) гаргаж мөрдөнө.

23.Урт ба дунд хугацааны төлөвлөгөөг Ерөнхий газрын хэмжээнд, жилийн төлөвлөгөөг алба, харьяа байгууллагын хэмжээнд боловсруулна.

24.Ерөнхий газрын жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Дэд бүтцийн хөгжлийн сайдаар батлуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Дугаар 57 **Улаанбаатар хот**

Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дэд бүтцийн хөгжлийн сайдын саналыг үндэслэн Г.Доржид түлш, эрчим хүчний хяналтын улсын ерөнхий байцаагчийн, Д.Чулуунд авто замын хяналтын улсын ерөнхий байцаагчийн, Б.Баасанд барилга, техникийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн, Л.Сандагт авто тээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг тус тус олгосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 237 дугаар тогтоолоор Н.Лхагваа, Л.Лантуу, Ц.Манлажавт олгосон улсын ерөнхий байцаагчийн эрхийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г.БАТХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Дугаар 58 **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай дүрмийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн захирал, дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД Л.ЦОГ

Засгийн газрын 1999 оны 58 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛТНЫ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Төрийн захиргааны албан тушаалтан /цаашид "албан хаагч" гэнэ/ сайдын эрхлэх асуудлын хүрээнд болон тухайн байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтыг /төрийн бодлогыг/ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүргээ биелүүлэх үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

2. Энэ дүрэм нь төрийн албыг зөв явуулах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ албан хаагчдыг Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээ чанд биелүүлэх, мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан

төрийн албан хаагчийн үйл ажиллагааны хориглох үйлдлийг гаргуулахгүй байлгах, улмаар тэднийг аливаа зөрчил, гажуудлаас сэргийлж, нэр төрийг нь хамгаалахад чиглэгдэнэ.

Хоёр. Албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

3. Албан хаагч үүргээ мэргэжлийн өндөр түвшинд шударгаар гүйцэтгэх зарчим баримтална:

1/ албан хаагч төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэхээс гадна бодлого боловсруулахад туслах үүргэтэй оролцогийн хувьд мэргэжлийн өндөр түвшинд судалж боловсруулсан санал, иж бүрэн, үндэслэлтэй зөвлөлгөөгөө удирдлагыг хангаж, удирдлагын саналыг бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг хэлж анхааруулж байна;

2/ бодлогын чанартай эцсийн шийдвэр гаргах нь удирдлагын онцгой эрхэд хамаарах учир албан хаагч тодорхой асуудлаар өөр саналтай байлаа ч гэсэн хуульд нийцүүлэн гаргасан удирдлагын шийдвэрийг биелүүлнэ;

3/ албан хаагч нь ажилд төрөлд холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах буюу удирдлагас шийдвэр гаргахад аливаа байдлаар саад учруулж, цаг алдагдуулахыг цээрлэнэ;

4/ албан хаагч удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн дагуу эрхэлж буй ажил үүргийнхээ хүрээнд Засгийн газраас явуулж буй бодлого, түүний хэрэгжилт, тухайн байгууллагас хийж байгаа ажил, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэвтэл мэдээллийн хэрэгслээр тайлбар хийж болох боловч албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тарааж дэлгэрүүлэхийг цээрлэнэ;

5/ албан хаагч ажил үүргийн дагуу удирдах албан тушаалтанд өгсөн зөвлөлгөө болон нийтэд мэдээлэхүй бусад мэдээллийг тараах, тухайн байгууллагаас явуулж буй бодлогыг албан хаагчийн хувьд гүйвуулан шүүмжлэх, эсхүл тэдгээр бодлого, үйл ажиллагаанд өөрийн саналчилга мэтээр ярьж сайрхахыг цээрлэнэ;

6/ албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ аль нэг улс төрийн хүчин, намыг илт дэмжих буюу шүүмжлэх байдлаар ялгавартай хандах ёсгүй бөгөөд улс төрийн хувьд төвийг сахиж, зөвхөн төр, засагтаа үйлчилж ажиллана;

7/ албан хаагч төрийн бус байгууллагад сонгогдож, томилогдож болох боловч тэрхүү сонгууль, томилолт нь албан хаагчийн хувьд албан үүргээ гүйцэтгэхэд нь саад болохгүй байвал зохино;

8/ албан хаагч Улсын Их Хурлын гишүүн болон улс төр, төрийн бус байгууллагын орон тооны албан тушаалд өөрийн нэрийг дэвшүүлж болох бөгөөд энэ тухайгаа байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн байна.

4. Албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэх, төр, засгаас хүлээлгэсэн итгэлийг дааж ажиллах зарчим баримтална:

1/ албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлэхдээ иргэдийг ялгаварлахгүй хандаж, хууль болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмыг чанд мөрдөж ажиллах бөгөөд хүнд суртал гаргах, чирэгдүүлэх зэргийг цээрлэнэ;

2/ албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ танил тал харахгүй, аливаа хувь хүн болон байгууллагын эрх ашгийг илүүд үзэхгүй, хувь хүний холбогдолтой мэдээллийг нийтэд тараахгүй, зөв үйл ажиллагаагаараа төр, засаг, олон түмний холбоог бэхжүүлнэ;

3/ албан хаагч тухайн байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, эд зүйл, байгууллагын албан хэрэгцээний мэдээ, материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахыг цээрлэнэ;

4/ албан хаагч төрийн албан хаагчийн хувьд өөрийн албан тушаалын давуутай тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах, аль нэг этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хүлээх байдалд түүнийг оруулж болзошгүй бэлэг, шагнал, урамшуулал авахыг цээрлэнэ.

5. Албан хаагч хувийн үйл ажиллагаагаараа төрийн байгууллага, төрийн ажилтны нэр хүндийг хамгаалж, итгэлийг нь дааж ажиллах зарчмыг баримтална:

1/ албан хаагч төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн заавар, шийдвэрийг биелүүлж ажиллана;

2/ албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтуурууллах удаа, мансууруулах бодис хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэнэ;

3/ албан хаагч эрхэлж буй ажлынхаа холбогдолтой асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн зэрэг улс төрийн албан тушаалтантай саналаа солилцож болох боловч ярилцах асуудлын чиглэлийг удирдлагадаа урьдчилан танилцуулсан, эсхүл удирдлагатай тохиролцсон байр суурийг төрийн захиргааныалбан хаагчийн хувьд баримталж, ярианы дүнг удирдлагад мэдээлж байна;

4/ албан хаагч ажиллаж байгаа байгууллага, түүний удирдлага болон үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа байдал гаргахыг цээрлэнэ;

5/ албан хаагч хууль, дүрэм, заавар, журмыг чанд мөрдөж ажилласнын хамт зан харьцааны дутагдал гаргахгүй ажиллахыг эрхэмлэвэл зохино.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын малын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх ажлыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын, уг хөтөлбөрийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батална.

2.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг Хөтөлбөрийн зөвлөлд тайлагнаж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт мэдээлж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 1999 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг . Монгол улсын мал сүргийн эрүүл мэндийн өнөөгийн байдал

1. Манай улсад Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын "А" ангиллын гоц халдварт өвчнүүд сүүлийн 20 гаруй жил илрээгүй байна. Иймд манай мал сүрэг ихэнх гоц халдварт өвчний эсрэг өвөрмөц хамгаалалтын дархлаагүй болж байна. Гадаад худалдаа, аялал, жуулчлал, иргэдийн зорчих хөдөлгөөн өргөжиж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд гадаадаас мал, амьтан, мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд импортлох нь ихэслээ. Энэ нь хилийн чанадаас мал, амьтны гоц халдварт өвчнүүд орж ирэх, тархан дэлгэрэх нөхцөлийг эрс нэмэгдүүлж байна.

Малын халдварт, паразиттах өвчний гаралт, өвчлөлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал мал сүрэгт сүүлийн жилүүдэд цусан халдвар, бруцеллёз, галзуу, сүрьеэ, адууны халдварт цус багасах өвчний гаралт 1,2-19,2 дахин өсч, халдварт өвчнөөр хорогдсон малын тоо нийт хорогдлын 30 хувийг эзэлж байна. Малаас хүнд халдварладаг бруцеллёз, сүрьеэ, ям, лейкоз зэрэг өвчнийг оношлох шинжилгээг зохих ёсоор хийхгүй байгаагаас эдгээр өвчнийг хянаж чадахгүй байна. Судалгаанаас үзэхэд манай улсын хэмжээнд үхэр, тэмээ, бог малын бруцеллёз бүх сумын 11-43 хувийг хамарсан нь өргөн тархалттай байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд Хөвсгөл, Завхан, Төв, Өвөрхангай зэрэг аймаг, Улаанбатаар хотын нутагт малын боом, галзуу өвчний гаралт эрс нэмэгдэж, тархалтын хүрээ тэлж шинээр голомтууд бүртгэгдэж байна.

Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

2. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах, хүн амын физиологийн хэрэгцээг хангахуйц амин дэм, уураг, бичил махбодоор баялаг хоол, хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлэхэд мал сүргийн эрүүл мэндийн асуудлаагаалах, малаас хүнд дамжин халдварладаг элдэв өвчнөөс эрүүлжүүлэх нь шийдвэрлэх ач холбогдолтой байна.

Монгол улсын эпизотологийн байдал тайван бус, ялангуяа малаас хүнд дамжин халдварладаг " зооантропонози" өвчин манай орны мал сүрэгт ихээхэн тархсан нь эдгээр өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээг төр, засгаас зориуд анхаарч, урт хугацааны зорилтот хөтөлбөртэй, дэс дараалалтайгаар хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Монгол улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэснээр тус байгууллагаас тавьж байгаа шаардлагуудыг хангаж, өөрийн орны мал сүрэгт тархсан халдварт өвчнийг бүртгэж, тэдгээрийн голомтыг тогтоон хяналтад авч түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг шинжлэх ухааны батлагдсан арга зүйн дагуу хэрэгжүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний ариун цэвэр,

аюулгүй байдлын магадлан шинжилгээ, баталгаажуулалтыг олон улсын шаардлагын түвшинд аль болохоор ойртуулах хэрэгтэй байна.

Мал, амьтан, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд үндэсний мал эмнэлгийн байгууллагаар үнэн зөв баталгаажуулалт хийдэг болгохын тулд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын үндэсний мал эмнэлгийн албыг магадлан итгэмжлэл олгодог тогтолцоонд дэлхий нийтээрээ шилжихээр бэлтгэж байгаа энэ үед манай улс өөрийн үндэсний мал эмнэлгийн тогтолцоогоо урьдчилан бэлтгэх зайлшгүй шаардлагатай юм.

Сүүлийн үед мах экспортлох сонирхол өсч байна. Гэтэл малын өвчлөлийн байдал, мал, амьтан, бүтээгдэхүүн, түүний эдэд ариун цэврийн хяналт шинжилгээ хийгдэхгүй, мал эмнэлгийн байгууллага, мэргэжилтний мэдлэг, нэр хүнд ч сайнгүй байна. Өнөө үед олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мал эмнэлгийн байгууллага, өндөр мэдлэг, ур чадвартай малын эмч нарын хэрэгцээ шаардлага улам бүр өсч байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3. Мал сүрэг, аж ахуйн зориулалтаар үржүүлж буй амьтдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үндэсэн дээр Монгол орон Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын "А" ангилалын гоц халдварт өвчнүүдээс тайван байгаагт хадгалан бататгах, нийгэм, эдийн засгийн үлэмж хохирол учруулдаг халдварт, паразиттах өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, мал, амьтны өвчлөл, халдварын хэмжээг аюулгүй түвшинд хүргэх, улмаар Монгол улсын экспортын боломжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

4. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

а/ хилийн мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал, амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хил нэвтрэхээс сэргийлэх;

б/ мал, амьтны халдварт өвчин илэрсэн, дамжин орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг мал эмнэлгийн албаны бүх шатанд бататгах, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамж, нөөцийг сайжруулах;

в/ мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, халдвар судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний мал эмнэлгийн албыг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх;

г/ мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, энэ чиглэлийн нэгжүүдийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

д/ мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, бүх шатанд бэхжүүлэх, үйл ажиллагаагаа нь жигдрүүлэх;

е/ нийгэм, эдийн засгийн хөгжилд ноотой хор хохирол учруулдаг халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

5. Хөтөлбөрийн зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

1/ Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам:

а/ хяналтад байх мал, амьтны өвчнийг бүртгэж, мэдээлэх, тэдгээртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өвчин тус бүрээр гаргаж, шаардагдах зардал, нөхөн олговыг санхүүжүүлэх эрх зүйн үндэс бүрдүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

б/ мал эмнэлгийн оношилгоо, судалгаа, мэдээллийн ажлыг Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үндэсэн дээр үхрийн шүлхий, цээж, бог малын цэцэг зэрэг "А" ангиллын өвчнүүдээр манай улс бүрэн тайван болохыг олон улсын түвшинд баталгаажуулах;

в/ мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр дамжин импортлогдож болох өвчнүүдийн жагсаалтыг гаргаж, нийтэд зарлан тодорхой бүс нутгийг хамруулан эдгээр өвчний талаар эрсдэлийн үнэлгээ хийж аюулгүй түвшинд байгаа тохиолдолд импор-

тын зөвшөөрөл олгодог журам тогтоох;

г/ эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж буй орнуудтай мал эмнэлгийн хорио цээр, арчун цэвриин салбарт хамтран ажиллах талаар Засгийн газар болон мэргэжлийн байгууллага хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах;

д/ шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр мал эмнэлэг, арчун цэврийн чиглэлээр суулийн жилүүдэд гүйцэтгэсэн шинжлэх ухаан, технологийн төслүүд, тэдгээрийн хүрээнд бий болгосон эм бэлдмэл, вакцин, оношлуур, багаж хэрэгсэл зэргийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, энэ талаар цаашид баримтлах бодлого, чиглэл, төслийн талаар шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

е/ хөтөлбөрийн удирдлага, зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах.

2/ Гэгээрлийн яам:

а/ мал аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог нийгэм, үйлдвэрлэлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн өөрчлөх, мэргэжилтнүүдийг хөгжингүй орнуудад сургаж бэлтгэх, чадваржуулах, хүний нөөцийн ашиглалтыг сайжруулах;

б/ мал аж ахуйн мэргэжилтэн, менежер бэлтгэх сургуулиудын сургалтын агуулгад олон улсын байгууллагаас батлан гаргасан шинжлэх ухааны ололт, чиглэлийг тусгах замаар сургалтыг олон улсын түвшинд хүргэх;

в/ мал сүргийг эрүүлжүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, оношилгоо шинжилгээний арсын боловсролтуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх;

3/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалын яам:

а/ мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс сэргийлэх, хүн, мал, амьтдыг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн болон мал эмнэлгийн байгууллагуудын хамтын ажиллагаог сайжруулах;

б/ Монгол улсад бүртгэгдсэн хүн, мал, амьтны нийтлэг халдварт өвчнүүдийн халдварын тархалтын хяналт, судалгааны тогтолцоог бий болгох, мал, амьтнаас халдварладаг өвчнөөс өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалах арга ажиллагаанд хүн амыг сургах ажлыг өргөн далайцтай явуулах.

4/ Сангийн яам:

- малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх зорилгоор жил бүрийн улсын төсөвт тусгаж байгаа зардлыг нэмэгдүүлэхийн дээр энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, арга хэмжээг дунд болон урт хугацаны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн төсөвт тусгах, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.

5/ Батлан хамгаалах яам:

а/ мал, амьтны гоц халдвар гарсан үед хорио цээр тогтоох, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх оператив төлөвлөгөөг Иргэний хамгаалалтын газар дээр боловсруулж, жил бүр тодотгол хийж байх;

б/ аймаг, нийслэлийн иргэний хамгаалалтын нарийн мэргэжлийн хүмүүс, техник хэрэгслийн судалгаа, бүртгэлийг гаргаж жил бүр шинэчлэн тодотгож байх, мэргэжлийн хүмүүсийг болзошгүй гамшгийн үед ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх сургалтыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх.

6/ Хөдөө аж ахуйн улсын хяналтын байгууллага:

а/ хилийн боомтууд дээр амьд мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг хорио цээрт оруулан саатуулах, ариутгах болон халдваргүйжүүлэлт хийх байгууламжийг барих, хил, гүний хяналтын улсын байцаагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэдний ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар түгсаг төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

б/ мал эмнэлгийн эм бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд тавих улсын хяналтыг хүчтэй болгож, эм бэлдмэл шалгах байгууллагын хүчин чадлыг нь нэмэгдүүлэх.

7/ Хөдөө аж ахуйн хэрэгжүүлэгч агентлаг:

а/ малын брученеллёз, ям, сүрьеэ, лейкоз өвчний тархалтыг аж ахуйн нэгж, хот айлын түвшинд нарийвчлан тогтоох, эрүүлжүүлэх арга хэмжээний дунд, урт хугацааны асуудал боловсруулж хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран хөрөнгийн эх үүсвэр олж хэрэгжүүлэх;

б/ адууны ям өвчин олон жил илрээгүй, мэдээлэгдэхгүй байгаа аймгуудад улсын комисс томилон ажиллуулж, эрүүлжилтийг баталгаажуулах, өвчний голомт хадгалагдсаар

байгаа аймгийн адууг ям өвчнөөс эрүүлжүүлэхийн зэрэгцэн адууны халдварт цус багасах өвчинтэй тэмцэх арга хэмжээний төсөл боловсруулж хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

в/ мал, амьтанд тохиолдож байгаа вирус, микоплазм, риккетси, бактери, мөөгөнцрөөр үүсдэг өвчнүүд, цусны паразиттах болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнийг бүрэн оношилж, бүрттэх, тархалтыг тогтоох, мэдээллийн сүлжээ бүй болгох арга хэмжээ авах;

г/ мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн сүлжээг бэхжүүлж, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, гоц халдварт, экзотик, зооантропоноз өвчнүүдийг оношлох, сэргийлэх чадварыг нэмэгдүүлэх;

д/ төв, орон нутгийн мал эмнэлгийн албадын бүтэц, тогтолцоог зах зээлийн нөхцөлтэй уялдуулан оновчтой, шуурхай байхаар зохион байгуулан бэхжүүлэх;

е/ мал эмнэлгийн эм бэлдмэл, багаж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг дэмжих, одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, багажийн нийлүүлэлт, борлуулалтыг сайжруулах;

ж/ гахай, шувуу зэрэг суурин мал аж ахуйн цогцолбор, гоц халдварт өвчний голомт бүхий газруудад, стратегийн ач холбогдол бүхий цэгт хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх болон үхсэн мал, амьтныг устгах байгууламжуудыг нэгдсэн зураг төслийн дагуу бариулах ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

8/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

Нутаг дэвсгэртээ энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/ малын эрүүл мэнд дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

б/ мал эмнэлгийн хяналт, үйлчилгээний нэгжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаар хэрэглэгчид ойртуулах, жигдрүүлэх, үнэлж дүгнэх, гүйцэтгэлд хяналт тавих;

в/ мал сүргийг бруцеллёз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчнөөс эрүүлжүүлэх, халдварлалтын түвшинг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

г/ мал сүргээ өргөн тархсан, хохирол ихтэй халдварт, паразиттах өвчнөөс сэргийлэх талаар оновчтой арга хэмжээ авах замаар мал аж ахуйд учруулж буй хохирлыг багасгах;

д/ малын гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг сум, дүүргийн төсөвт тусгаж санхүүжүүлэх;

е/ мал эмнэлгийн байгууллагыг бэхжүүлэхэд дотоодын санхүүгийн эх үүсвэр гаргаж төсөл хэрэгжүүлэх, гадаад орон, байгууллагатай төслийн хамтын ажиллагаа хөгжүүлэх;

ж/ аймгийн онцгой комиссын төсөв, хийх ажлын чиглэлд мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх зардал, болзошгүй тохиолдолд шуурхай ажиллах арга хэмжээг тодорхой тусгах, иргэний хамгаалалтын мэргэжлийн бүлгийн бэлэн байдлыг хангуулах;

з/ мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнөөс хамгаалах арга ажиллагаанд хүн амыг сургах ажлыг өргөн далайтай явуулах.

9/ Төрийн бус байгууллага:

а/ мал эмнэлгийн чиглэлээр дотоод, гадаадад мэргэжилтэн сургахад туслалцаа үзүүлэх;

б/ малын эмч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, тэднийг шинжлэх ухааны орчин үеийн мэдээллээр шуурхай хангах, ёс зүйн байдал, мэргэжлийн чадавхийг үнэлж дүгнэх асуудлыг хэрэгжүүлэх.

10/ Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж:

а/ мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлэх;

б/ малын эм, биобэлдмэл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох арга хэмжээг хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргэтэй Үндэсний хөтөлбөрийн зөвлөл ажиллана. Зөвлөл нь орон тооны бус байна.

7. Хөтөлбөрийн зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, дүгнэлт гаргах;

б/ хөтөлберт өөрчлөлт, тодотгол хийх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

в/ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбогдох асуудлыг Засгийн газар болон холбогдох яам, агентлагуудад тавьж шийдвэрлүүлэх.

8. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүргэтэй аймаг, нийслэлийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг үүргийг Засаг дарга батална.

9. Аймаг, нийслэл, сум, дүүргэт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах, сургалт, сурталчилгаа явуулах үүргийг Хөдөө аж ахуйн газар хариуцна.

10. Хөтөлбөрийн зөвлөл болон орон нутаг дахь салбар зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нуттийн зөвлөл жил бүрийн 4 дүгээр улиралд Хөтөлбөрийн зөвлөлд, Хөтөлбөрийн зөвлөл

нь дараа оны 1 дүгээр улиралд Засгийн газарт тус тус тайлагнаж байна.

11. Үндэсний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг хөтөлбөрийн нэгдүгээр хавсралтад заасан хугацаа, шалгуур үзүүлэлтээр Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам хариуцан дүгнэж байна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

12. Хөтөлбөрийг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

а/ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгө;

б/ гадаадын хөрөнгө оруулалт;

в/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

г/ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

д/ шинжлэх ухаан, технологийн сан;

е/ иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, сангийн хандив, тусламж, үйлчилгээний төлбөр.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

13. Хөтөлбөрийг 1999-2010 оны хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүр дүгнэхдээ дараахь шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан дүгнэнэ:

Нэгдүгээр үе шат - 1999-2000 оныг хамруулна. Энэ үе шатанд шаардлагатай хууль эрхийн актуудыг боловсруулан батлуулж, мал эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно. Сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагуудыг хувийн хэвшилд бүрэн шилжүүлэх, материалаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна.

Лабораторийн нэгдсэн сүлжээг бэхжүүлж, эпидемиологийн нэгжийн үйл ажиллагаог сэргээн хэвшүүлнэ. Мөн хөтөлбөрт тусгагдсан урт, дунд хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд энэ хөтөлбөрийн 2 дугаар хавсралтад заасан төслүүдийн баримт бичгийг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлсэн байна. Санхүүжүүлэх эх үүсвэр нь шийдэгдсэн төслүүдийг хэрэгжүүлж эхэлнэ.

Хоёрдугаар үе шат - 2000-2005 оныг хамруулна. Энэ үе шатанд малын брүцеллёз, ям, сүрьеэ, адууны халдварт цус багадах өвчний тархалтын байдлыг нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд тогтоож дуусна. Шүлхий, мялзан, цээж, бог малын цэцэг өвчнөөр бүрэн тайван статустай орны олон улсын жагсаалтад орсон байх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хилийн боомт дахь мал эмнэлгийн хорио цээрийн байгууламжуудыг тусгай зураг төслийн дагуу барьж дуусгана. Биоүйлдвэр, малын эм бэлдмэл шалгах лабораторийг бэхжүүлэх төслийг хийж, санхүүжүүлэх үүсвэрийг олж, хэрэгжүүлэх арга хэмжээг эхлүүлнэ.

Гуравдугаар үе шат - 2005-2010 оныг хамруулна. Энэ үе шатанд брүцеллёз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний голомтыг устгах, дээрх өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Монгол улсад тохиолдож байгаа бактер, мөөгөнцөр, риккетси, микоплазм, вирусын гаралтай өвчнүүд, цусны паразиттах болон цус сорогч үе хөлтөөр дамжин халдварладаг өвчнийг бүрэн оношлон бүртгэж, эдгээр өвчнийг хянах, тэдгээртэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулна. Биоүйлдвэр, Малын эм бэлдмэл шалгах лабораторийг шинэчлэх ажлыг дуусгана. Мал эмнэлгийн лаборатори, хил, гүний хяналтын салбарт ажиллаж байгаа эмч нарыг нарийн мэргэжлийн дамжаагаар сургаж, мэргэшүүлсэн байна.

Найм. Хөтөлбөрөөс гарах үр дүн

14. Ойрын /шууд/ үр дүн:

а/ мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эдийн засаг, эрх зүйн орчин бүрдэж, аж ахуйн талаар бие даан ажиллах боломж дээшилнэ;

б/ мал эмнэлгийн хорио цээр, ариун цэврийн хяналтын бүтэц, зохион байгуулалт сайжирч, улмаар мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын түвшин дээшилнэ;

в/ мал амьтныг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болно;

г/ гадаад орноос мал, амьтны гоц халдварт өвчин дамжин орж ирэхээс сэргийлэх эрх зүй, нийгэм, эдийн засгийн орчин бүрдэж, хилийн хорио цээр, ариун цэврийн хамгаалалт сайжирч, мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван байгаа одоогийн түвшин баталгаажина;

д/ мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг дэмжихэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвхтэй оролцоо, хамтач ажиллагаа, зорилт, чиг үүрэг, хариуцлагын шинэ тогтолцоо бүрдэнэ.

15. Хэтийн /шууд бус/ үр дүн:

а/ мал, амьтнаас хүнд халдварлах өвчний тархалт хумигдаж, хүн амын эрүүл мэндэд таатай нөлөөлнө;

б/ малын өвчлөлт, алангуяа ужиг халдварт болон паразиттах өвчний түвшин, тэдгээрээс үүдэн гарах хохирлын хэмжээ буурна;

в/ мал эмнэлгийн ажил, үйлчилгээ гүйцэтгэх хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, үндэсний мал эмнэлгийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх үнэлэмж дээшилнэ;

г/ улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал түлхэц болж экспортын боломж дээшилнэ.

"Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн
1 дүгээр хавсралт

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДУГНЭХ ХУГАЦАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлтүүд	Дүгнэх хугацаа	Хэрэгжилтийг нотлох баримт
1	Зах зээлийн эдийн засгийн орчинд малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн үйлчилгээ явуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.Үүнд: 1/ малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулинд өөрчлөлт оруулах; 2 /шаардлагаар нядалж буй мал, амьтдын үнийг нөхөн төлөх эрх зүйн асуудлыг шийдвэрлүүлэх; 3/ бүртгэлтэй өвчний жагсаалт, тэдгээрийг мэдээлдэг журам; 4/ хорио цээр, хязгаарлалт тогтоох журмыг шинэчлэх; 5/ мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг импортлоход эрдэлийн үнэлгээ хийх журам; 6/ мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн хорио цээрийн хууль; 7/ малын шилжилт хөдөлгөөнд хорио цээрийн хяналт тавих журам	2001 он	Холбогдох хууль эрхийн баримт бичгүүд
2	Мал эмнэлгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно	2001 он	Мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагыг бүрэн хувийн хэвшилд шилжүүлж, мал эмнэлгийн хяналт, үйлчилгээг дагнасан бие даасан агентлагууд ажиллана.
3	Мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулагдана	2001 он	Лабораторийн 3 шаттай нэгдсэн тогтолцоо бий болж, зохих дүрэм, журам нь батлагдан, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.
4	Хилийн боомт дахь мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын албыг удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчин, материаллаг баазын талаар бэхжүүлсэн байна	2001 он	Албаны бүтэц, зохион байгуулалт төгөлдөржиж, өндөр мэдлэг чадвартай боловсон хүчнээр хангагдсан байна. Хилийн боомт дээр хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлэх байгууламжууд зохих ёсоор баригдсан байна.
5.	Малын бруцеллёз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах зэрэг өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний шатны үр дүн гарна	2005 он	Бруцеллёз, сүрьеэ, ям, адууны халдварт цус багадах, лейкоз зэрэг өвчний халдварлалтын байдлыг хот айл нэг бүрийн түвшинд албан ёсоор тогтоож, мал эмнэлгийн байгууллагын хяналтад бүртгэн авч, өвчний халдварлалттай хот айлыг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

6	Монгол улс шүлхий, мялзан, цээж, бог малын цэцэг өвчнөөр тайван статустай орны Олон улсын жагсаалтад орсон байна	2005 он	Олон улсын амьтны халдварт өвчний байгууллагаас гаргасан албан ёсны жагсаалтад орж дэлхий дахинд зарлагдсан байна
7	Бруцеллёз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний голомтуудыг устгах, мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ	2010 он	Өвчний голомт устсан, хот айл эрүүлжсэн тухай улсын комиссын дүгнэлт, баталгаа гарсан байна
8	Монгол оронд тохиолдож байгаа бактери, мөөгөнцөр, риккетси, микоплазм, вирусын гаралтай өвчнүүд, цусны паразитийн болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнүүдийг бүрэн оношлож, мал эмнэлгийн бүртгэл, хяналтад бүрэн авч тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2010 он	Өвчнүүдийг оношлож, бүртгэсэн тайлан, жагсаалт, тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга зам, заавар гарсан байна
9	Мал эмнэлгийн хүрээлэн, Биоүйлдвэр, Малын эм бэлдмэл шалгах улсын нэгдсэн лаборатори, Хөдөө аж ахуйн их сургуулийн мал эмнэлгийн факультет зэрэгт их засвар өргөтгөл хийсэн байна	2010 он	Хүрээлэн, сургууль, үйлдвэр, лабораторийн судалгаа, сургалт, техник, технологийн шинэчлэлт, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар дээшилсэн байна
10	Шинжлэх ухаан, технологийн сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг гаргана	2000 2005 2010	Үр дүнгийн эдийн засгийн үнэлгээ тогтоогдоно

"Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн
2 дугаар хавсралт

"МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХИ САНАЛ

№	Төслийн нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах хөрөнгө (тэрбум төгрөг)
1	Малын зооантропоноз өвчнүүдээс (бруцеллёз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багасах) эрүүлжүүлэх, мал эмнэлгийн лабораторийн сүлжээг бэхжүүлэх төсөл	6 дэд төсөлтэй 2000-2010 он	12,0
2	Мал эмнэлгийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах төсөл	1999-2010 он	3,6
3	Мал эмнэлгийн биобэлдмэл, эмийн үйлдвэрлэл, түүний хяналтыг хөгжүүлэх төсөл	2000-2005 он	4,0
4	Хилийн мал эмнэлгийн хорио цээрийн салбарыг бэхжүүлэх төсөл	1999-2002 он	0,140

5	Мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	2000-2010 он	1,0
Дүн			20,2

Засгийн газрын 1999 оны 64 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

"МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд
Орлогч дарга:	- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Гишүүд:	- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга; - Сангийн яамны төсвийн бодлогын газрын дарга; - Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; - Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга; - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах албаны дарга; - Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал; - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Эрүүл мэндийн сургалт боловсрол, урьдчилан сэргийлэх вакцин, халдварт өвчний сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн; - Хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны Мал эмнэлгийн хяналтын улсын ерөнхий байцаагч; - Улсын Иргэний хамгаалалтын газрын хөдөө аж ахуй, үйлдвэрийн хамгаалалт хариуцсан мэргэжилтэн.
Нарийн бичгийн дарга:	- Хөдөө аж ахуйн хэрэгжүүлэгч агентлагийн мал эмнэлгийн албаны дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

Хөтөлбөрт нэмэлт оруулах тухай

Дэлхийн эмэгтэйчүүдийн IY бага хурлаас гаргасан тунхаглалын үзэл санаат хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 1996 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр"-т "Эмэгтэйчүүд ба хүрээлэн байгаа орчин" бүлгийг хавсралт ёсоор нэмсүгэй.

2. Мөн хөтөлбөрийн "62-68" гэсэн дугаарыг "67-73" гэж өөрчлөн хөтөлбөрийн 17-д "Л.Эмэгтэйчүүд ба хүрээлэн байгаа орчин" гэсэн хэсэг нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД С.СОНИН

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 65 дугаар
тогтоолын хавсралт

Л. ЭМЭГТЭЙЧҮҮД БА ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИН

Өнөөгийн байдал

62. Монгол Улс иргэнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг Үндсэн хуулираа баталгаажуулж, газар нутаг, байгалийн баялгаа нийт ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад авсан билээ. Монгол орны байгаль харьцангуйгаар унаган төрхөө хадгалж үлдсэн хэдий ч аж ахуйн болон хэрэглээний зохисгүй үйл ажиллагаа, хүрээлэн байгаа орчны хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрт харьцаанд үлэмж өөрчлөлт орж, байгаль орчин бохирдох, нөөц баялаг хомсдох, зарим газарт экологийн тэнцэл алдагдах хандлага ажиглагдаж байна.

Шинэ зууны босгон дээр хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах нь хүн төрөлхтөний нийгмийн тогтвортой хөгжлийн шийдвэрлэх асуудлын нэг болон тавигдаж байна. Энэхүү өргөн цар хүрээтэй зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг нэн чухал болохыг дэлхий нийтийн хэмжээнд нэгэнт хүлээн зөвшөөрсөн билээ. Өнөөдөр Монгол улсын байгаль орчны салбарт ажиллагсдын 39,9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа боловч байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, орчны доройтлыг бууруулах талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй доогуур байгаа юм. Байгаль хамгаалах үйлсэд эмэгтэйчүүдийн оролцоог өргөжүүлэх талаар төрийн зохицуулалт үгүйлэгдэж байна. Түүнчлэн экологийн асуудлаар идэвхтэй ажилладаг эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэх явдал чухал асуудал болж байна.

Бодлогын үндэсн чиглэл

63. Монгол Улсын Засгийн газраас явуулж байгаа байгаль орчны бодлого нь байгалийн унаган төрх байдлыг хадгалах, байгалийн болон түүх, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, экологийн даацад нийцүүлэн нөөц баялгийг иж бүрэн, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр өгөөжийг нь ард иргэдэд адил тэнцүү хүртээх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэн, амьдрах орчныг сайжруулахад чиглэгдэж байна. Төр засгийн бодлого зорилтыг амьдралд хэрэгжүүлж, нийгмийн хөгжил, дэвшлийн тогтвортой байдлыг бий болгоход эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог бодитойханган, улмаар энэхүү чухал үйлсэд эмэгтэйчүүд, эхчүүдийн оролцоог идэвжүүлэн өрнүүлэх зорилгоор дараахь бодлогыг баримтлан явуулна:

а) эмэгтэйчүүд, гэр бүлийн гишүүдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох сургалт сурталчилгаа явуулах, мэдээллээр хангах;

б) байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд эмэгтэйчүүдийн оролцоог идэвжүүлэх, тэдгээрийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих, урамшуулах эдийн засаг, эрх зүйн нөхцөл боломжийг бүрдүүлэх;

в)экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орчинд халгүй үйлдвэрлэл, цэвэр технологийг нэвтрүүлэхэд эмэгтэйчүүдийн хувь нэмрийг хөхүүлэн дэмжих.

ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛТ Л.1

Эмэгтэйчүүд, гэр бүлийн гишүүдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох, сургалт сурталчилгаа явуулах, мэдээллээр хангах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

64.Боловсрол, байгаль орчны асуудал эрхэлсэн төв, орон нуттийн байгууллагаас бүх шатны Засаг дарга, эмэгтэйчүүдийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран дараахь үйл ажиллагаар хэрэгжүүлнэ:

а)эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, гэр бүлд экологийн боловсрол, мэдлэг эзэмшүүлэх сургалтыг өргөн хүрээнд явуулах агуулга, хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, уг ажлыг "Бүх нийтийн экологийн боловсрол" үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтой уялдаа холбоотойгоор явуулах;

б)байгаль орчны асуудлаарх албан болон албан бус сургалтад эмэгтэйчүүдийг, ялангуяа хөдөөгийн болон төв суурин газрын захын хороололд оршин суугчдыг түлхүү оролцуулах;

в)хүн амын экологийн боловсролыг дээшлүүлэхэд эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагаас зохиож буй үйл ажиллагаат бүх талаар дэмжих;

г)байгаль, эх дэлхийгээ хайрлан хамгаалах талаархи монгол үндэснийхээ уламжлалт ёс заншлыг дээдлэх, үр хүүхэд, хойч үедээ өвлөн уламжлахад эхчүүд, өрхийн тэргүүн эрэгтэйчүүд, айл өрхийн санаачилга, идэвхи чармайлт чухал болохыг үйл ажиллагаандаа тусган хэрэжүүлэх, шинэ дэвшилттэй эхлэл, хөдөлгөөнийг дэмжин хөгжүүлэх;

д)экологийн талаар танин мэдэхүй, сургалт, мэдээлэл, сурталчилгааны олон төрлийн нийтлэл, нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслэгч нөгтмол явуулж хэвшүүлэх;

е)экологийн талаар зохиож буй ажлынхаа талаар шуурхай мэдээлж танилцуулж байх.

ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛТ Л.2

Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд эмэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэх, тэдгээрийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих, урамшуулах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

65.Байгаль орчны төв, орон нуттийн байгууллагаас бүх шатны Засаг даргатай хамтран олон нийтийн дэмжлэгтэйгээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а)байгаль орчны салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн мэргэжлийн бэлтгэл, ур чадварыг дээшлүүлэх, байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг ашиглах асуудлаар хөтөлбөр боловсруулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх;

б)байгаль орчны доройтол, бохирдлыг бууруулах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж буй эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн байгууллагуудыг урамшуулах, сурталчлах, тэргүүний арга туршлагыг дэлгэрүүлэхийн зэрэгцээ тэдгээрт үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх;

в)байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд эмэгтэйчүүдийн сайн дурын үйлдвэрлэл, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэхэд эмэгтэйчүүдийн хувь нэмрийг хөхиүлэн дэмжих.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

66.Байгаль орчны болон салбарын бусад яам, орон нуттийн төр захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр дараахь үйл ажиллагаанг хэрэгжүүлнэ:

а)байгаль орчинд ээлтэй, чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг татан оролцуулж, тэдний мэдлэг, чадварыг ашиглах;

б)үр ашиггүй үрэлгэн хэрэглээг багасгах, арилгах зорилгоор эмэгтэйчүүдэд хэрэглээний соёлыг эзэмшүүлж, ухаалаг хэрэглээг төлөвшүүлэх;

в)экологийн цэвэр бүтээгдэхүүнийг бүх нийтийн хэрэглээ болгоход эмэгтэйчүүдийн хүчийг ашиглах, сурталчилгаа явуулах;

г)их, дээд сургуулийн бизнесийн удирдлага, инженер, эдийн засаг зэрэг мэргэжлийн хичээлийн хөтөлбөрт орчинд халгүй үйлдвэрлэл, цэвэр технологийн асуудлыг тусгах.

ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛТ Л.3

Байгалийн нөөцийн менежментийг боловсронгуй болгох, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орчинд халгүй үйлдвэрлэл, цэвэр технологийг нэвтрүүлэх, эмэгтэйчүүдийн хувь нэмрийг хөхиүлэн дэмжих.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Дугаар 66 Улаанбаатар хот

"Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлах тухай

Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар авах нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг зүчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батална уу.

2. . "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээний зардлыг 2000 оноос эхлэн төлөв жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд С.Сонин, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж явцыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яаманд мэдээлж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.СОНИН

Засгийн газрын 1999 оны 66 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

I. Хөтөлбөрийн үндэслэл

Нэг.Хүн амын амны хөндийн эрүүл мэндийн байдал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх нь хүний биеийн бүх эрхтэнд хамаарагдах байнгын голомтот халдварыг багасган эрүүлжүүлэх чухал хүчин зүйл гэж үзэж байна. Иймээс дэлхийн бүх оронд шүдний зонхилох өвчнөөс сэргийлэх, өвчлөлийг бууруулах талаар 2000-2025 он хүртэл зорилтот хөтөлбөрийг гарган хэрэгжүүлж байна.

Манай хүн амын дунд шүд цоорох өвчин, шүдний тулгуур эдийн эмгэг, шүдний гажиг, шүд толботох, шүдний паалангийн дутмагшил зэрэг шүдний зонхилох өвчний тархалт 76-80 хувь байгаа бөгөөд эдгээрийн дотроос шүд цоорох өвчний тархалт ихсэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал 1974 онд хот суурин газар шүдний өвчний тархалт 64 хувь байсан бол 1994 онд 96 хувь болж жилд дунджаар 1,6 хувиар өсч, эрчим нь 2,9-өөс 5,8 болж 2 дахин нэмэгдсэн байна.

Хоёр. Хүн амын амны хөндийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйл

Амьдралын хэв загвар, үндэсний уламжлалт дадал заншил өөрчлөгдөн хүн амын дийлэнх хувь нь хот суурин газар амьдрах болж фторын агууламж багатай ундны ус хэрэглэж, сүү, цагаан идээг тогтмол бус бага хэрэглэж чихэр, чихэрлэг хүнсний зүйлийн хэрэглээ ихэсч хүн ам, ялангуяа хүүхэд, залуучуудад шүдээ арчлах эрүүл ахуйн мэдлэг, дадал дутагдалтай байгаа нь шүд, амны хөндийн төрөл бүрийн өвчин үүсч даамжрахад нөлөөлж байна.

Амны хөндийн эрүүл мэндийн асуудалд хангалттүй анхаарч өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн цэгцтэй арга хэмжээ авч байгаагүй, оношилгоо, эмчилгээнд шаардлагатай эм, материал, тоног төхөөрөмж хүрэлцээгүй, мэргэжлийн боловсон хүчний хангамж болон ашиглалт муутайгаас шалтгаалан өвчилсөн хойно нь эмчилдэг арга барил зонхилж, эрт илрүүлэн эмчлэх явдал хангалтгүйгээс өвчин даамжирч, 26,7 /хотод/-гоос 27,8 хувь /хөдөөд/ нь "шүд авах"-аас өөр эмчилгээ-

гүй болсны гадна судалгаанд хамрагдсан 18 настай залуучуудын 37,5 хувь нь дутуу шүдтэй байна.

Шүд цоорох өвчин хүндэрснээс шүд, эрүү нүүр орчмын идээт үрэвсэл үүсч тэдгээрийн 2 хувь нь амь насанд аюултайгаар хүндэрч байна. Шүд цоорох өвчний улмаас гүйлсэн булчирхайн үрэвсэл, зүрх судас, үе мөч, бөөрний өвчин зэрэг бие махбодийн бусад эрхтэний халдвар, харшлын өвчнүүд үүсч даамжирдаг.

Иймээс орчин үед шүд цоорох өвчнийг шүдээ арчлах, зүй зохистой хооллох зэрэг хүний амьдралын хэвшлээс шалтгаалахын зэрэгцүү үг өвчинг нягшийн халдвараар үүсдэг, өвчтэй хүнээс эрүүл хүнд дамжин халдварладаг халдварт өвчин, халдварын голомт гэж үзэх боллоо. Иймд нэг талаас иргэд амны хөндийн эрүүл ахуй, ариун цэврийн дэглэмийг баримталж хэвших, нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг халдвар хамгаллын дэглэмийг чандлан сахих явдал чухлаар тавигдаж байна.

Шүд нь хоол боловсруулах, өгүүлэхүй, гоо сайхан, мэдрэхүйн эрхтэн бөгөөд шүд, амны хөндий эрүүл байх нь хоол боловсруулах замын болон халдвар, харшлын олон өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Эдгээрээс үндэслэн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нийгмийн эрүүл мэндийн цогцолбор арга хэмжээг өөрийн орны өвөрмөц нөхцөлтэй уялдуулан үе шаттайгаар авч хэрэгжүүлэх явдал зүй ёсоор шаардагдаж байна.

П.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

1.Урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ давамгайлсан, хүртээмж, чанар сайтай шүдний эрүүл мэндийн тусламжийг зохион байгуулж шүд цоорох өвчний тархалтыг бууруулж, хүн амын амны хөндийн эрүүл мэндийн байдлыг сайжруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.Шүд цоорох өвчний тархалтыг 10 хувиар бууруулна.

3.Шүд цоорох өвчний эрчмийн үзүүлэлтийг 1 пунктээр бууруулна.

4.Бүрэн шүдтэй 18 хүртэлх насны хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жинг 10 хувиар нэмэгдүүлнэ.

5.Хөтөлбөрийг 2000-2005 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Ш.Үндэсний хөтөлбөрийн удирдлага, хяналт, санхүүжилт, хамтын ажиллагаа

6.Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хяналт тавьж үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор гүйцэтгэнэ.

7.Аймаг, нийслэл, сум, дүүргэт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулах үүргийг Засаг даргын Тамгын газрын нийгмийн боддогын хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газар, нэгдэл, төв тус тус эрхлэн гүйцэтгэнэ.Уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцна.

8.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутаг болон үндэсний хэмжээнд хийх ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж, дүнг Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яам нэгтгэн Засгийн газарт тайлагнаж байна.

9.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

1/Өргөн олныг хамарсан анхдагч урьдчилан сэргийлэх-нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, шүдний эрүүл мэндийн анхны тусламжид түлхүү анхаарах;

2/Хөтөлбөрийн үйл ажиллагааг юуны түрүүнд хүүхэд, залуучууд руу чиглүүлэх;

3/Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвх, оролцоо, нэгдмэл үйл ажиллагааны тулгуурлах.

10.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

11.Олон улсын байгууллага, гадаад орны дэмжлэг туслалцаа, төслийн хөрөнгө болон Үндэсний хөтөлбөрийг дэмжин аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулсан хандив нь санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр болно.

12.Амны хөндийн эрүүл мэндийн асуудлаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газрын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, олон улсын хэмжээнд мөрдөж буй урьдчилан сэргийлэх болон эмчилгээний дэвшилтэт аргаас өөрийн орны нөхцөлд тохи-руулан хэрэгжүүлж, олон улсын байгуул-лага, гадаад орнуудаас үзүүлэх дэмжлэг туслалцааг өргөжүүлэхийг зорино.

IV. Хөтөлбөрийн арга хэмжээнүүд

Нэг. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх /анхдагч/- нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг өөрийн орны онцлогтой уялдуулан хэрэгжүүлнэ:

13.Хүүхэд, залуучууд, нийт хүн амыг шүд, амны хөндийн эрүүл мэндээ хамгаалах эрүүл ахуйн дадал заншилтай болгоход чиглэгдсэн албан болон албан бус сургалтыг эрчимжүүлэх:

1/Хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх албан болон албан бус сургалтын агуулга, хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэндийн дараахь асуудлууд хэрхэн тусгагдсаныг хянан үзэж үнэлгээ өгч шаардлагатай арга хэмжээ авах:

а/амны хөндийн эрүүл ахуй, шүд угаах арга;

б/фтор агуулсан ооны ач холбогдол, хэрэглээ;

в/шүдэнд аюулгүй хоол хүнс;

г/хүний биед чихэр, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн, ундааны үзүүлэх нөлөө, тэдгээрийн хэрэглээг багасгах, зөв зохистой хэрэглэх /хэрэглэсний дараа шүдээ угаах, зайлах/;

д/сүү, цагаан идээний ач холбогдол, хэрэглээ;

е/хатуу, чанар сайтай хоол, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийн ач холбогдол;

ж/шүд бэхжүүлэхэд чиглэгдсэн дасгал хөдөлгөөн;

з/шүдээ өөрсдөө хянаж эмчид хандаг арга барил эзэмшүүлэх.

2/Амны хөндийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд шаардлагатай сурах бичиг, гарын авлага, сургалтын материалын хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх.

3/Амны хөндийн эрүүл мэндийн талаар явуулах сургалт сурталчилгаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах, нийтлэл, нэвтрүүлгийн давтамж, төрөл, чанарыг нэмэгдүүлэх.

14.Хүн амын фторын хэрэглээг зохицуулах:

1/Хүн амыг нийтээр нь фторжуулах:

а/ундны усан дахь фторын агууламж багатай орон нутагт фторгой ооны хангамжийг нэмэгдүүлж хэрэглээг сайжруулах;

б/ундны ус, шүдний ооны чанар, фторжилтын зэрэгт эрүүл ахуйн хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч байх;

в/хүн амын фторын хангамж, хэрэглээг сайжруулах боломжтой аргыг судлах.

2/Хүн амыг хэсэг, бүлгээр нь фторжуулах арга хэмжээ авах:

а/фортой гель, уусмалаар шүд арчих;

б/шүдний зажлах гадаргуугийн ховил, хонхорхойг фторгой материалаар таглах;

в/фторын шахмал уулгах.

15.Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх орчин үеийн эм, материал, багаж хэрэгслийн хангамжийг сайжруулах.

16.Хүн амын хоол, хүнсний бүтэц, чанарыг сайжруулах:

1/Ундаа, чихэр, чихэрлэг хүнсний зүйлийн найрлага дахь саахарын бүтэц, чанарт эрүүл ахуйн хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч байх;

2/Чихэр, чихэрлэг хүнсний зүйлийг зүй зохистой хэрэглэх, тэдгээрийн хэрэглээг багасгахад чиглэгдсэн ажлыг зохион байгуулах;

3/Сүү, цагаан идээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хэрэглээг сайжруулах.

Хоёр. Шүдний өвчлөл мэргэжлийн тусламжийн хүртээмж, чанарыг дээшлүүлнэ:

17.Хүүхэд, залуучуудын дунд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авч байх;

18.Шүд цоорлын хөнгөн үеийг өвчлөлгүйгээр эмчлэх /дахин эрдэсжүүлэн бэхжүүлэх/ зэрэг шинэ арга технологи нэвтрүүлэх;

19.Хөдөө орон нутагт сум, багийн хэмжээнд шүдний яаралтай тусламжийн хүртээмжийг сайжруулах;

20.Шүдний зонхилох эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт боловсруулж мөрдүүлэх;

21.Өөрийн орны нөхцөлд тохирсон шүдний эмгэгийг оношлож эмчлэх арга/ эмнэлгийн тусламжийн шатлал бүрээр тодорхойлж, аргачлалаар хангах;

22.Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд шүд цоорох өвчний оношилгоо, эмчилгээний аргыг өргөжүүлж, технологийг сайжруулах;

23.Шүд цоорох өвчнийг эрт оношлож эмчлэх орчин үеийн эм материал, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх;

24.Шүд цоорох өвчний хэлбэр, явцыг хүн нэг бүр дээр тогтоож ялгавартай товлооп үзлэг хийж эрүүлжүүлэх арга хэмжээг цаг тухайд нь авч байх.

Гурав. Шүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх, чанар сайтай мэргэжилийн тусламж үзүүлэх боловсон хүчнийг бэлтгэнэ:

25.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, эцэг, эхчүүд, сум, өрхийн эмч, сувилагч, бага эмч-сувилагчийг богино хугацаагаар сургалтад хамруулан сургагч бэлтгэн амны хөндийн өвчлөлөөс сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ /эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, анхан шатны тусламж/-нд оролцуулах;

26.Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр сувилагч, бага эмч-сувилагчийн мэдлэг, дадлагыг дээшлүүлэн амны хөндийн эрүүл ахуйч-сувилагч бэлтгэн баг, сум, албан газар, сургууль, цэцэрлэгт ажиллуулах;

27.Сумын эмч, багийн бага эмч, бага эмч-сувилагчид шүдний анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэх мэдлэг, дадлага зээмшүүлэх;

28.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, ерөнхий мэргэжлийн эмч, сувилагч, бага эмч-сувилагч бэлтгэх бүх шатны сургалтын агуулга, хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэндийн асуудал хэрхэн тусгагдсаныг хянан үзэж холбогдох арга хэмжээ авах;

29.Шүдний мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн үйлчилгээний нэгдмэл бүтэц, зохион байгуулалтыг бий болгон бүх шатны сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх;

30.Амны хөндийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн асуудлаар шүдний мэргэжлийн боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах;

31.Амны хөндийн эрүүл мэндийн асуудлаар эрүүл мэндийн анхны тусламжийн ажилтнууд /сум, баг, өрхийн эмч, сувилагч, бага эмч, бага эмч-сувилагч/ болон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эцэг, эхчүүдэд зориулсан сурах бичиг, гарын авлага, зөвлөмж гаргах.

Дөрөв. Амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг боловсронгуй болгох:

32.Амны хөндийн эрүүл мэндийн тусламжийг төлөвлөх, хянах, үнэлэхэд шаардлагатай мэдээллийн шинэ үзүүлэлтийг боловсруулж эрүүл мэндийн мэдээллийн сүлжээнд нэвтрүүлэх.

Тав. Эрдэм шинжилгээ, судалгааны талаар:

33.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дараахь чиглэлээр гүйцэтгэнэ:

1/Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэхэд уламжлалт хүнсний зүйлийн ач холбогдол, түүний шинжлэх ухааны үндэслэлийг судлах;

2/Шүд цоорох өвчич үүсгэгч хүчин зүйлүүд, фтортой ооны чанар, хэрэглээний түвшин, фторын хангамж, хэрэглээг сайжруулах боломжтой аргыг судлах;

3/Шүд цоорох өвчний эмгэг жамыг судалсны үндэсэн дээр эрт оношлох, түүний эрчмийг тодорхойлох аргыг боловсруулж өөрийн орны байгалийн түүхий эдээр шүд цоорлоос урьдчилан сэргийлэх эмийн бэлдмэл хийх асуудлыг судлах;

4/Хүн амын амны хөндийн эрүүл мэндийн байдал, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, цаашдын хэрэгцээг судлах.

Ү.Хөтөлбөрийн үр дүнгийн үзэлгээ

34.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтүүдээр харьцуулан дүгнэнэ:

№	Үзүүлэлтүүд	Он	
		1999	2005
1	Шүд цоорох өвчний тархалт	96%	86%
2	Шүд цоорох өвчний эрчмийн үзүүлэлт /шүд цоорох өвчтэй нэг хүнд ногдох цоорсон, ломбодсон, авахуулсан шүдний дундаж тоо/	5,8	4,8
3	Бүрэн шүдтэй 18 хүртэлх насны хүмүүсийн эзлэх хувийн жин	62,5%	72,5%

Засгийн газрын 1999 оны 66 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2000-2005 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцагч
	1. Удирдлага, зохион байгуулалтын талаар		
1	Хөтөлбөр, түүний хэрэгжилт, үр дүнг сурталчлах	1999-2005	ЭМНХЯ, хэвлэл мэдээллийн болон нутгийн захиргааны байгууллага
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр гаргаж шаардлагатай төсвийг зохих журмаар шийдвэрлүүлэх	Жил бүр	ЭМНХЯ, Сангийн яам, нутгийн захиргааны байгууллага
3	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийг ЭМНХЯ, Засгийн газарт тайлагнах	2001 оноос жил бүрийн I улиралд	ЭМНХЯ, холбогдох сайд, бүх шатны Засаг дарга
4	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2-3 аймаг буюу дүүрэгт шалгаж дүгнэх	Жил бүр	ЭМНХЯ
	П. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар		
5	Амны хөндийн эрүүл мэндийн талаар явуулах сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, нийтлэл, нэвтрүүлгийн тоо, төрлийг нэмэгдүүлэх	2000 оноос	ЭМНХЯ,Гэгээрлийн яам, хэвлэл мэдээллийн байгууллагууд
6	Амны хөндийн эрүүл мэндийн талаар явуулах албан болон албан бус сургалтад шаардагдах сурах бичиг, гарын авлага, сургалтын материалын хуртээмж, төрлийг нэмэгдүүлэх	2000 оноос	ЭМНХЯ,Гэгээрлийн яам, хэвлэл мэдээллийн байгууллага
7	Хүн амыг хэсэг, бүлгээр нь фторжуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2001 оноос	ЭМНХЯ
8	Импортоор оруулж ирж буй фтортой ооны чанар, фторын агуулламжид байнгын хяналт тавьж хэрэглээг сайжруулах	2000 оноос	ЭМНХЯ, Гэгээрлийн яам, айл өрх, иргэд
9	Шүдний анхан шатны тусламжийн багаж, материалаар хангах	2001-2004	ЭМНХЯ, Сангийн яам
10	Бага эмч-сувилагч, сувилагч нарыг богино хугацааны сургалтад хамруулан шүдний эрүүл ахуйч сувилагчийг бэлтгэн, сум, баг, албан газар, сургууль, цэцэрлэгт ажиллуулах	2000-2003	Гэгээрлийн яам, ЭМНХЯ, АУИС, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв
11	Сум, өрхийн эмч, бага эмч-сувилагч, сувилагч нарыг сургалтад хамруулан амны хөндийн эмгэгээс сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд оролцуулах	2000 оноос	ЭМНХЯ, Анагаах ухааны их сургууль, Анагаах ухааны коллеж

12	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэх	2000 оноос	ХААҮЯ, ЭМНХЯ, Гэгээрлийн яам, айл өрх, иргэд
13	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, эцэг, эхчүүдэд сургалт явуулж, амны хөндийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд оролцуулах	2000 оноос	Гэгээрлийн яам, ЭМНХЯ
14	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, ерөнхий мэргэжлийн эмч, сувилагч, бага эмч-сувилагч бэлтгэх сургалтын агуулга, хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэндийн асуудал хэрхэн тусгагдсаныг хянан үзэж арга хэмжээ авах	2000-2001	Гэгээрлийн яам, ЭМНХЯ
15	Хүүхэд, залуучудыг шүд, амны хөндийн эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг тогтмолжуулах	Жил бүр	ЭМНХЯ, Гэгээрлийн яам, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэд
16	Ундны усны фторын агууламжид байнгын хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч байх	2000 оноос	ЭМНХЯ, Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын алба, БОЯ
17	Ундны усан дахь фторын агууламжийг харгалзан фтортой ооны хангамж хэрэглээг орон нутагт ялгавартай зохион байгуулах талаар зөвлөмж гарган хэрэгжүүлэх	2000-2001	ЭМНХЯ
18	Ундаа, чихэр, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь саахарын бүтэц, чанарт эрүүл ахуйн хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч байх	2000 оноос	ЭМНХЯ, ХААҮЯ
19	Хүүхдүүдийн чихэр, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг багасгахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ /сүү, жимс, ногоо, махан зууш, өдрийн хоолоор үйлчлэх зөрэг/-г холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	2000 оноос	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, айл өрх, иргэд
20	Хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх албан болон албан бус сургалтын агуулга, хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэндийн асуудал хэрхэн тусгагдсаныг хянан үзэж, үнэлгээ өгч, холбогдох арга хэмжээ авах	2000 онд	Гэгээрлийн яам, ЭМНХЯ
	III. Шүд цоорох өвчний үед үзүүлэх мэргэжлийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах талаар		
21	Шүдний мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн үйлчилгээний нэгдмэл бүтэц, зохион байгуулалтыг бий болгон, бүх шатны сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх	2000-2001	ЭМНХЯ, Гэгээрлийн яам, Сангийн яам
22	Шүд цоорох өвчний хэлбэр явцыг хүн нэг бүр дээр тогтоож ялгавартай товлосон үзлэг хийж байх	2000 оноос	ЭМНХЯ

23	Сумын эмч, багийн бага эмч, бага эмч-сувилагч нарт яаралтай тусламжийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалт явуулах	2001 оноос	ЭМНХЯ, Гэгээрлийн яам, Анагаах ухааны их сургууль, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв, Анагаах ухааны коллеж
24	Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд шүдний оношилгоо, эмчилгээний аргыг өргөжүүлж, технологийг сайжруулах	2000-2005	ЭМНХЯ, Сангийн яам
25	Шүдний эмчилгээнд шүд цоорлын хөнгөн үеийг өрөмдөлгүйгээр эмчлэх зэрэг шинэ арга технологи нэвтрүүлэх, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эмчлэх орчин үеийн эм, материал, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх	2001-2005	ЭМНХЯ, Сангийн яам
26	Шүдний зонхилох эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандарт боловсруулж мөрдүүлэх	2000	ЭМНХЯ, Анагаах ухааны их сургууль, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв
27	Амны хөндийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн асуудлаар шүдний эмч, техникч, сувилагчийн мэргэжлийг дээшлүүлэх	2000-2001	Анагаах ухааны их сургууль, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв, Анагаах ухааны коллеж
28	Өөрийн орны нөхцөлд тохирсон шүд цоорох өвчнийг оношлож эмчлэх аргыг эмнэлгийн тусламжийн шатлал бүрээр тодорхойлж, аргачлалаар хангах	2000 онд	ЭМНХЯ
	IV. Амны хөндийн эрүүл мэндийн талаархи мэдээлэл, судалгааны талаар		
29	Амны хөндийн эрүүл мэндийн талаархи мэдээллийн шинэ үзүүлэлтийг боловсруулж нэвтрүүлэх	2000-2001	ЭМНХЯ
30	Шүд цоорох өвчний тархалт, эрчим, эмчилгээний төлөв, үр дүн, шүд цоорох өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд, эмгэг жам, фторын хангамж, хэрэглээг сайжруулах боломжтой арга, шүд цоорох өвчнөөс сэргийлэхэд зарим уламжлалт хүнсний зүйлийн ач холбогдол, түүний үндэслэл, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэл бүтээх асуудлыг судлах	2000-2005	Гэгээрлийн яам, ЭМНХЯ
	V. Хөтөлбөрийн санхүүжилт, хамтын ажиллагааны талаар		
31	Шүдний тусламжийн санхүүжилтийн механизмийг оновчтой болгох асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх	2000-2001	Сангийн яам, ЭМНХЯ
32	Амны хөндийн эрүүл мэндийн асуудлаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газрын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах / төсөл хэрэгжүүлэх сургалт, семинар зохион байгуулах, судалгаа хийх, мэргэжилтэн солилцох зэрэг/	2000 оноос	ЭМНХЯ, ГХЯ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ, ТУШААЛ

1999 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр **Дугаар 29, 121, 80** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАН ТУШААХ нь:

1."Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг устгах журам"-ыг хавсралтын ёсоор баталж, 1999 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Хил, гааль, мэргэжлийн хяналтын албаны болон цагдаа, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан спирт, согтууруулах ундааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авах, устгах талаар тогтоосон журмыг ноцтой зөрчсөн нь тогтоогдвол уг гэмт бууруулах хүнийг ажлаас нь холбогдох хууль тогтоомж, дүрмийн дагуу халж байсугай.

3.Хил, гааль, цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр биелүүлэх болон мэргэжлийн хяналтын байгууллагад эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хураагдан шүүхийн шийдвэр гаралгүйгээр одоо бэлэн хадгалаж буй спирт, согтууруулах ундааны зүйлийг энэ тушаалаар тогтоосон журмын дагуу 1999 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор устгасугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэд байнга хяналт тавьж, дүнг хагас жил тутам нэгтгэн танилцуулж байхыг Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ерөнхий прокурорын газрын I газрын дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН

ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ЕРӨНХИЙ ПРОКУРОР Н.ГАНБАЯР

ХУУЛЬ ЗҮЙН САЙД Л.ЦОГ

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн сайдын 1999 оны 29, 121, 80 дугаар захирамж, тушаалын хавсралт

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН УЛМААС ХУРААГДСАН СПИРТ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗҮЙЛИЙГ УСТГАХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.Энэ журам нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 172[1], 175[1] дүгээр зүйлд заасан эрүүгийн хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан захиргааны зөрчлийн улмаас хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг хэрэг бүрттэх, мөрдөн байцаах болон захиргааны зөрчлийг илрүүлж шалгах шатанд устгахтай холбогдсон асуудлыг зохицуулна.

2.Энэхүү журмын биелэлтэд тус тусын эрх хэмжээний хүрээнд бүх шатны Засаг дарга, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын хил хамгаалах болон гаалийн байгууллагын удирдлага болон мэргэж-

лийн хяналтын улсын албаны дарга нар хяналт тавьж ажиллана.

3.Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авч устгах явцад холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад Мон-гол Улсын Ерөнхий прокурор, аймаг, нийслэл, тээвэрийн болон сум буюу сум дундын, дүүргийн прокурор хяналт тавина.

ХОЁР.Спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авч, устгах үндэслэл

4.Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг дараахь үндэслэлээр шууд хураан авна:

1/ Улсын хилийн байцаан өнгөрүүлэх, Гаалийн байгууллагын хяналт шалгалт, бүрдүүлэлтийн явцад хил, гаалийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн, гаалийн бусад горимд байгаа спирт, согтууруулах ундааны зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн эсхүл хориглосон, хязгаарласан спирт, согтууруулах ундааны зүйлийг хил нэвтрүүлсэн бол;

Тайлбар:

Энэхүү хууль бусаар хил нэвтрүүлэх гэдэгт Дээд шүүхийн 1994 оны 180 дугаар тогтоолд заасснаар зохих зөвшөөрөлгүйгээр гаалийн үзлэгээс гадуур, хилийн боомт, гарцгүй хэсгээр, эсхүл гаалийн үзлэгээс нуун далдлах, гаалийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлах, гаалийн мэдүүлэгт бичихгүй орхих, худал бичих зэрэг аргаар спирт, согтууруулах ундааны зүйлийг хил, гаалийн үзлэг шалгалтад хамруулахгүйгээр гаргасан, оруулсан, дамжин өнгөрүүлсэн үйлдэл хамаарна.

Хориглосон гэдэгт: Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр улсын хилээр гаргах, оруулахыг, зөвхөн гаргахыг буюу оруулахыг, дамжин өнгөрүүлэхийг хориглосон спирт, согтууруулах ундааны зүйлийг ойлгоно.

Хязгаарласан гэдэгт: Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр тодорхой болзол хангасан, эсхүл зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр гаргах, оруулахаар, эсхүл зөвхөн гаргахаар буюу оруулахаар заасан спирт, согтууруулах ундааны зүйлийг хэлнэ.

2/ худалдаа үйлчилгээнд хэрэглэж байгаа болон улсын хил, гаалийн үзлэг шалгалтад зохих журмын дагуу хамруулан оруулж ирсэн боловч уг спирт, согтууруулах ундааны зүйл нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болох нь мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан хяналт шинжилгээгээр батлагдсан бол;

3/ спирт, согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх талаар Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон журмыг гажуудуулсан, хэрэглэхийг хориглосон нэр төрлийн спирт, согтууруулах ундааг үйлдвэрлэсэн, худалдаа үйлчилгээнд гаргасан бол.

5.Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас дээр дурдсан үндэслэлээр хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг ээлэд нь буцааж өгөхгүйгээр энэ журамд заасны дагуу устгана. Тэгэхдээ тухайн эзтэгэд уул спирт, согтууруулах ундааг хууль бусаар оруулж ирсэн буюу түүнийг үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх журмыг гажуудуулсан нь эрүүгийн хэрэг үүсгэн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, захиргааны зөрчлийг шалгах явцад тогтоогдсон байвал зохино.

6.Дээр дурдсан үндэслэлээр эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас спирт, согтууруулах ундааны зүйлийг илрүүлсэн байгууллага болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хил, гааль, эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагч, болон хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан уг спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээллийн байгууллагын болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөгчийг байлцуулж болно.

7.Хураан авсан тухай тэмдэглэлд холбогдох этгээдийн овог, нэр, гэрийн хаяг, хувийн баримт бичгийн дугаар, тээвэрийн хэрэгслийн дугаар, марк, үйлдвэр, дэлгүүр, баар, цэнгээний газрын байршил нэр, хэзээ, хаана, ямар үндэслэлээр, хэний авч явсан буюу эзэмшилд байсан спирт, согтууруулах ундааг хураан авсан, уг зүйлийн хэмжээ, чанар, зориулалт, өнгө, үнэ, улсын хилээр оруулсан буюу үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх явцад үйлдсэн гэрээ, хэлцэл, зөвшөөрөл, шинжилгээний бичиг, гаалийн мэдүүлэг, орлого, зарлагын баримт болон дагалдах бусад баримт бичгийн тухай дэлгэрэнгүй тусган хураах тухай тэмдэгэглэл хийхэд биеэр байлц-

сан хүн бүрийн овог, нэр, албан тушаал зэргийг тодорхой бичиж гарын үсэг зуруулна.

8.Спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авсан албан тушаалтан нь түүний бүрэн бүтэн байдлыг биечлэн хариуцна.

9.Спирт, согтууруулах ундааны зүйлийг үнэлэхдээ тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Үнийн комиссоор тогтоосон жишгийг баримтална.

ГУРАВ.Хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг устгах

10.Спирт, согтууруулах ундааны зүйлийг хураан авснаас хойш эрүүгийн хэрэгт 21 хүртэл хоног, захиргааны зөрчилд 3 хоногийн дотор уг зүйлийг устгах тухай эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг бүртэгч, мөрдөн байцаагч тогтоол, захиргааны зөрчлийг ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан акт гаргана.

11.Спирт, согтууруулах ундааны зүйлийг устгах тухай тогтоол, акт гарснаас хойш 24 цагийн дотор эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, захиргааны зөрчлийг илрүүлсэн эрх бүхий албан тушаалтан нь хил, гааль, эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагч, прокурор, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан /эдгээрээс байгааг нь оролцуулна/ хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас тогтоосон цэгт болон бохир үс зайлуулах шугамд асгах, шатаах зэрэг аргаар устгаж тэмдэглэл хөтөлнө. Спирт, согтууруулах ундааг устгах ажиллагааны хэвлэл мэдээллийн төлөөлөгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн идэвхтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчийг аль болох байлцуулбал зохино.

12.Устгах тухай тэмдэглэлд хэзээ, хаана, ямар үндэслэлээр спирт, согтууруулах ундааг ямар албан тушаалтан аних хураан авсан, улмаар түүнийг устгах болсон шалтгаан, устгах тухай ямар албан тушаалтан, ямар шийдвэр гаргасан, шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, уг зүйлийн хэмжээ, чанар, зориулалт, өнгө, үнэ, уг зүйлийг авч яваа буюу түүнийг үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх ажиллагаар эрхэлж буй хүний овог нэр, оршин суух хаяг, хувийн баримт бичгийн дугаар, тээврийн хэрэгслийн дугаар, марк, жолоочийн нэр, үйлдвэр, дэлгүүр, баар, цэнгээний газрын байршил, нэр, улсын хилээр оруулсан буюу үйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх явцад үйлдсэн гэрээ, хэлцэл, зөвшөөрөл, шинжилгээний бичиг, гаалийн мэдүүлэг, орлого, зарлагын баримт зэрэг дагалдах бүх баримт бичгийн тухай дэлгэрэнгүй тусган устгах тухай тэмдэглэл хийхэд биеэр байлцсан хүн нэг бүрийн овог нэр, албан тушаал зэргийг тодорхой бичиж гарын үсэг зуруулна.

13.Устгах тухай тэмдэглэл гарсны дараа уг спирт, согтууруулах ундааны зүйлийг нэн даруй устгана.

14.Устгах тухай тэмдэгдэлд хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг хэзээ, хаана, яаж устгасан болох, устгах ажиллагааны явц, байдал, устгах явцад байлцсан хүмүүсээс гаргасан санал, хүсэлт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай дэлгэрэнгүй тусгана. Энэхүү тэмдэглэлд устгахаар тогтоол гарсан болон акт тавигдсан спирт, согтууруулах ундааны зүйлийн биет байдал, устгах ажиллагааны явцын тухай гэрэл зураг заавал авч, шаардлагатай бол дүрс, дууны бичлэг хийж хавсаргана.

15.Спирт, согтууруулах ундаа хураалгасан этгээд өөрөө хүсэлт гаргавал спирт, согтууруулах ундааны зүйлийг устгахад байлцуулах буюу уг спирт согтууруулах ундааны зүйлээс дээж авч болох бөгөөд энэ тухайгаа тэмдэглэлд тусгана.Дээжийг эрүүл ахуй, халдвар судлалын мэргэжлийн хүн авна.

16.Хураан авснаас хойш гарсан болон устгахгай холбогдсон бүх зардлыг хэрэг, зөрчил үйлдсэн этгээдээс гаргуулна.

17.Спирт, согтууруулах ундааны зүйлийг хураасан, устгасан тухай тэмдэглэл, устгах тухай тогтоол, акт болон түүнд холбогдох бүх баримтыг хэрэг, зөрчлийн материалд хавсаргана.

18.Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд шууд хор нөлөө учруулах буюу шаардлага хангаагүй цэг, байранд спирт, согтууруулах ундааны зүйлийг устгахыг хориглоно.

19.Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хураагдсан спирт, согтууруулах ундааны зүйлийг илрүүлсэн байгууллага уг зүйлийг бүслад шилжүүлэхийг хориглоно.

20.Спирт, согтууруулах ундааны зүйлийг хураж устгасан тухай материалыг захиргааны зөрчилд 10 хоног, эрүүгийн хэрэгт 30 хоногийн дотор харьяа прокурорт заавал хянуулна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны тавдугаар сарын 28* *№24 (103)*

Гарчиг

Нэг. Монгол Улсын хууль

209. Монгол Улсын 1999 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-5-21-ний хууль) 331

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

210. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль товлон зарлах тухай Дугаар 32 332

211. Сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай Дугаар 33 332

Гурав. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

212. Ажлын төлөвлөгөө батлах тухай Дугаар 67 332

213. Үндэсний хөтөлбөрийг батлах тухай Дугаар 68 334

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН 1999 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 1999 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "1.1.2.ж. Монголбанкнаас төсөвт орох орлого" гэсэн заалт нэмж, уг зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвийн 1999 оны орлогын нийт дүн болон дараахь нэр төрлийн орлогыг дор дурдсан хэмжээгээр тус тус нэмэгдүүлж буюу хорогдуулж өөрчилсүгэй:

/мянган төгрөгөөр/

1.1.Орлого бүгд	16.065.816.2
1.1.1.Албан татварын орлого	6.474.257.0
1.1.1.а.орлогын албан татвар	-550.601.9
1.1.1.б.гаалийн албан татвар	6.928.600.0
1.1.1.в.нэмэгдсэн өртгийн албан татвар	-158.806.2
1.1.1.г.онцгой албан татвар	3.623.004.2
1.1.1.д.автобензин, дизелийн түлшний ба авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	-3.439.597.3
1.1.1.е.бусад албан татвар	-10.221.5
1.1.1.ж.нийгмийн даатгалын шимтгэл	81.879.7
1.1.2. Татварын бус орлого	591.159.2
1.1.2.а.хувьцааны ногдол ашиг	-699.185.2
1.1.2.б.бусад орлого	2.101.280.0
1.1.2.в.түрээсийн орлого	-32.286.3
1.1.2.д.төсөвт байгууллагын өөрийн орлого	-778.649.3
1.1.2.е.навигаци /өнгөрөлт/-ийн орлого	-1.500.000.0
1.1.2.ж.Монголбанкнаас төсөвт орох орлого	1.500.000.0
1.1.3.Хөрөнгийн орлого	9.000.400.0
1.1.3.а.өмч хувьчлалын орлого	9.000.400.0

2 дугаар зүйл. Монгол Улсын 1999 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвийн 1999 оны зарлагын нийт дүн болон цалин, хөрөнгө оруулалт, нийтийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсөвт өгөх татаасыг дор дурдсан хэмжээгээр тус тус нэмэгдүүлж буюу хорогдуулж өөрчилсүгэй:

2.1.Зарлага бүгд	-4.391.007.4
2.1.1.цалингийн сан	126.038.1
2.1.2.хөрөнгө оруулалт	-8.111.200.0

Үүнээс:-шинээр эхлэх барилга объектын төсөвт ертөг	-3.966.200.0
Үүний дотор:-1999 онд санхүүжүүлэх хэмжээ	-2.530.000.0
2.1.3.нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	-283.479.6
2.1.4.батлан хамгаалах арга хэмжээний зардал	-463.000.0
2.1.5.Улсын Их Хурлын төсөв	31.450.0
2.1.10.Улсын дээд шүүхийн төсөв	10.000.0
2.1.12.Прокурорын байгууллагын төсөв	-40.000.0
2.1.13.Улсын аюулгүй байдлыг хангах газрын төсөв	-5.000.0
2.1.14.тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	-127.700.0
2.1.15.аймгийн төсөвт өгөх татаас	-1.692.542.0

3 дугаар зүйл. Монгол Улсын 1999 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасыг дор дурдсан хэмжээгээр тус тус нэмэгдүүлж буюу хорогдуулж өөрчилсүгэй:

Архангай	-118.364.2
Баян-Өлгий	-149.025.6
Баянхонгор	-162.511.9
Булган	-284.773.8
Говь-Алтай	-118.440.1
Дорноговь	-204.322.2
Дорнод	-161.620.5
Дундговь	-18.084.4
Завхан	278.221.1
Өвөрхангай	524.509.9
Өмнөговь	-103.499.3
Сүхбаатар	-33.644.6
Сэлэнгэ	-515.544.7
Төв	-335.721.1
Увс	-142.973.0
Ховд	-154.262.1
Хөвсгөл	-130.821.3
Хэнтий	313.160.4
Дархан-Уул	-109.082.7
Говьсүмбэр	-65.741.9

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр — **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ** — **Улаанбаатар хот**

Дугаар 32

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль товлон зарлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Сайнцагаан, Увс аймгийн Тариалан, Хэнтий аймгийн Хэрлэн, Өмнөдэлгэр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг 1999 оны 6 дугаар сарын 27-ны өдөр явуулахаар товлон зарласугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр — **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ** — **Улаанбаатар хот**

Дугаар 33

Сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Сайнцагаан, Увс аймгийн Тариалан, Хэнтий аймгийн Хэрлэн, Өмнөдэлгэр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 2337140 /хоёр сая гурван зуун гучин долоон мянга нэг зуун дөч/ төгрөгөөр тогтоосугай.

2.Дээрх зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

1999 оны 4 дугаар сарын 21-ний өдөр — **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ** — **Улаанбаатар хот**

Дугаар 67

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол оронд ардчилсан хөдөлгөөн үүсч хөгжсөний 10 жилийн ой үтгэн ажлын ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор батална.

2.Ерөнхий төлөвлөгөөний дагуу ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Гэгээрлийн сайд, Монгол оронд ардчилсан хөдөлгөөн үүсч хөгжсөний 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах Засгийн газрын комиссын дарга А.Баттөрд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ГЭГЭЭРЛИЙН САЙД А.БАТТӨР

Засгийн газрын 1999 оны 67 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ ОРОНД АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 10 ЖИЛИЙН ОЙ УГТСАН АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа /сараар/	Хариуцсан Засгийн газрын комиссын гишүүн
1	Ой угтсан сурталчилгааны ажлыг зохион байгуулах	IV-XII	Б.Билигт
2	Ойд зориулсан үзэсгэлэнгийн концепци боловсруулах, үзмэрийг бэлтгэж, үзэсгэлэн ажиллуулах, музей байгуулах	IV-XII	А.Баттөр Б.Билигт
3	Ойн гадаад арга хэмжээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	IV-XII	О.Очиржав
4	Эрдэм шинжилгээний цуврал хурал зохион байгуулах	IV-XII	А.Баттөр Б.Билигт
5	Ой угтсан ажлын төлөвлөгөөг үндэслэн төв, орон нутгийн байгууллагуудад зөвлөмж боловсруулж хүргүүлэх	IV	Н.Батбаяр
6	Ойд зориулсан баримтат кино хийх	IV-XII	Б.Билигт
7	Ардчилсан хөдөлгөөний алдрыг мөнхжүүлэх хөшөө, гэрэлт самбар байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх	IV-XII	А.Баттөр М.Энхболд Б.Билигт Д.Махвал
8	Ойд зориулсан түүх, дурсамжийн ном, гэрэл зургийн цомог хэвлүүлэх	IV-XI	Б.Билигт Д.Махвал
9	Ардчилсан хөдөлгөөний анхдагчийн үнэмлэх бий болгож, олгох	IV-XI	Н.Батбаяр
10	Ардчилсан хөдөлгөөний архивыг нэгтгэн бүрдүүлж, бий болгох	IV-XI	Н.Батбаяр Б.Билигт
11	Монгол оронд ардчилсан хөдөлгөөн үүсч хөгжсөний 10 жилийн ойг орон даяар ёслон тэмдэглэх төлөвлөгөөг тусад нь гаргаж, хэрэгжүүлэх	X-XII	А.Баттөр Н.Батбаяр М.Энхболд Д.Мөрөн
12	Ой угтсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохицуулан, зохион байгуулж ажиллах	IV-XII	А.Баттөр Н.Батбаяр Д.Мөрөн
13	Ой угтаж зохиох болон ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнүүдийн төсвийг нэгтгэн батлуулж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах	IV-XII	А.Баттөр Н.Батбаяр Д.Махвал
14	Ойг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайлан бэлтгэж Засгийн газарт танилцуулах	XII	А.Баттөр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрийг батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтын, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

2. Хөтөлбөрийн 1999 оны хэрэгжилтэд шаардагдах 9.3 сая төгрөгийг Соёл, урлагийн сангийн энэ оны төсөвт багтаан зохицуулж гаргах, Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Гэгээрлийн сайд А.Баттөрд даалгасугай.

3. "Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт, уг хөтөлбөрийн дагуу зохиогдох арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд өргөн сурталчилж байхыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

ГЭГЭЭРЛИЙН САЙД А.БАТТӨР

Засгийн газрын 1999 оны 68 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АРДЫН УЛАМЖЛАЛТ УРЛАГИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Аливаа улс орны үндэсний уламжлалт урлаг нь үндэстэн,ястны амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийн нэгэн илэрхийлэл болдог бөгөөд өргөн утгаараа тухайн улс, үндэстний үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлж байдаг учраас дэлхийн олон орон үндэсний уламжлалт урлагаа өвлөн уламжлулах, дэмжихэд ихээхэн анхаарч байна. Мөн үндэстний уламжлалт урлагийг хамгаалах, уламжлан өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлахын чухлыг ЮНЕСКО, түүний салбар байгууллагуд онцлон үзэж, энэ талаар дэлхий нийтэд хандсан уриалга, удирдамж, зөвлөмж, тогтоолыг гаргасан билээ.

Үндэсний уламжлалт урлагаа хойч үедээ өвлүүлэх, түүнийхээ судалгаа, сурталчилгааг эрчимжүүлэх, давтагдашгүй дэг сургууль, арга барилыг уламжлуулах асуудлыг тусгасан ойрын болон хэтийн чиглэлийг боловсруулах нь соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн өндөр ач холбогдолтой юм.

Уламжлалт урлагийг судлах, түүнийг өвлүүлэх бодитой судалгаа, шинжилгээний ажил төдийлөн хийгдэж чадахгүй байгаа нь үгсаатнуудын урлагийн зарим төрөл мартагдах, уламжлагдах байдал нь алдагдахад хүрч байна. Түүнчлэн зарим үгсаатнуудын уламжлалт урлагийн төрлүүд нийлж саармагжих явдал гарч байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Ялангуяа монголчуудын авьяас билгээр уламжлагдаж ирсэн үлгэр туулиас эхлээд уртын дуу, хөөмий, уран нугаралт, морин хуурын татлага, дурслэх урлагийн давтагдашгүй ур хийц бүхий ардын урлалын бүтээлүүд нь сурталчлагдаж үгүй төрөлхтөнд танил болсон билээ. Үндэсний урлагийн бүхий л төрлүүдийг судлан шинжлэх, сэргээн сурталчлах, өвлүүлэн уламжлуулах асуудлыг төрөөс дэмжих нь иргэдийг уламжлалт урлагаараа бахархах, өвлөн уламжлах сонирхол, санаачилгыг өрнүүлэхэд бодитой алхам болох юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

I. Хөтөлбөрийн зорилго

Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлогод монголын үгсаатан, ястны өв соёл, түүх, ёс заншлыг хадгалан хамгаалах, харилцан баяжуулж хөгжүүлэх нөхцөл бололцоог ханган талаар тусгагдсан асуудлууд, Монголын төрт ёс, соёл, зан заншлын дэвшилттэй бүхнийг өвлөн авч, хүн төрөлхтний соёлын дээжистэй хослуулан хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

II. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

1. Үндэсний уламжлалт урлагийг өвлөн билиг авьяастны үйл ажиллагаог дэмжих, тэдгээрийн авьяас билиг, арга барил, дэг сургуулийг хамгаалах, өвлүүлэх;

2. Үндэсний уламжлалт урлагийн төрөл, зүйлийн ангилал, шинж чанарын талаар судалгаа, сурталчилгаог эрчимжүүлэх, уламжлалт урлагийг өвлүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн хэмжээнд явагдах уралдаан, наадмын зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

3. Үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэх, язгуур урлагийг дэмжих орчин бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын шинэ тогтолцоо бүрдүүлэх;

4. Үндэсний уламжлалт урлагийн талаарх бүртгэл-мэдээлэл, сургалт, сурталчилгаа, аудио, видео санг бүрдүүлэх ажлыг боловсронгуй болгох;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- утга соёлын өвийг өвлөсөн билиг авьяастны талаар судалгаа хийж, мэдээллийн санд төвлөрүүлэн, авьяастан, урчуудын талаарх бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох;
- утга соёлын өвийг өвлөсөн билиг авьяастны авьяас билиг, арга барил, дэг сургуулийг нийтэд сурталчлах, өвлүүлэх;
- утга соёлын өвийг өвлөсөн авьяастны мэдлэг, ур чадварыг хойч үедээ өвлүүлэн үлдээх үйл ажиллагаог улс, орон нутгийн хэмжээнд саналчлан зохион байгуулах, шавь сургалт зохион явуулахад нь мэргэжлийн болон зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- билиг авьяастны ур чадвараар хэлбэржсэн бүтээлүүдийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, хадгалах, сурталчлах;
- авьяастан, урчуудын хөдөлмөр зүтгэл, авьяас чадварыг бодитой үнэлэх, тэдгээрийг төрийн болон бусад шагнал урамшууланд хамруулах, алдаршуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах.

2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүнэ:

- үндэсний уламжлалт урлагийн төрлүүдийн хоорондын ялгааг нийтэд ойлгомжтой болгох талаархи судалгаог өргөжүүлэх;
- үндэсний уламжлалт урлагийн төрлөөр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран улс, орон нутгийн хэмжээнд уралдаан, наадам, үзэсгэлэнг зохион байгуулах, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг төсөвт тусгах;
- үндэсний уламжлалт урлагийг сурталчлахад шаардагдах баримтат кино, дуу, дүрс бичлэгийг бүтээх, үзэсгэлэнгийн цомог, сурталчилгааны товхимол, ил захидал, марк хэвлүүлэх, радио, телевизийн нэвтрүүлэг хийх, уулзалт ярилцлага зохион байгуулах;
- үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэх зорилгоор түүнийг цэцэрлэг, бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах, зайны болон шавь сургалтаар хэрэгжүүлэх;
- судлаачид, мэргэжилтэнг бэлтгэж, гадаад, дотоодод гэрээгээр ажиллуулах;
- утга соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орон болон гадаадын байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах;
- гадаад орнуудад ардын уламжлалт урлагийн тогтолт хийх, үзэсгэлэн гаргах;
- монголчуудын зан заншил, уламжлалт өв соёлын талаарх сурталчилгааг өргөжүүлэх, түүнтэй уялдсан ажил, арга хэмжээнүүдийг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах.

3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэд дараахь үүрэг, хариуцлага хүлээнэ:

Монгол Улсын Засгийн газар:

- үндэсний уламжлалт урлагийг үндэстэн угсаатны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь салшгүй уялдаатайгаар судлан сурталчлах, өвлөн уламжлуулах, хамгаалах талаархи төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэл, төвлөрсөн төсөвт тусгах;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

- салбарын хэмжээнд үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэн уламжлуулах, сурталчлах ажлыг зохимжүүлэх, үндэсний урлагийг дэмжих орчин бүрдүүлэх асуудлыг мэргэжлийн удирдлагаар хангах;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа, түүнд зарцуулах хөрөнгийг жил бүр төсөвт тусган хэрэгжүүлэх.

Төрийн захиргааны орон нутгийн байгууллагууд:

- хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлан хэрэгжилтэд нь хяналт тавих;
- хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд орон нутгийн хэвлэл, мэдээлэл, соёл, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаат уялдуулан зохицуулж удирдлагаар хангаж ажиллах;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нутаг дэвсгэртээ язгуур, уламжлалт урлагийн бага, бэсрэг наадам, урчуудын бүтээлээр үзэсгэлэн, дуудлага-худалдаа, сурталчилгааны аян, сургалт зохион байгуулах.

Хэвлэл, мэдээллийн байгууллага:

- үндэсний болон орон нутгийн хэвлэлийн нийтлэлийн болон радио, телевизийн нэвтрүүлгийн бодлого, хөтөлберт үндэсний уламжлалт урлагт холбогдох нийтлэл, сурталчилгаа, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлж, арга хэлбэрийг боловсронгуй болгох;
- утга соёлын өвийг өвлөсөн билиг авьяастныг дэмжих, алдаршуулах, тэдний бүтээл, авьяас чадвар, аргачлалыг нарийвчлан заасан сургалтын нэвтрүүлэг бэлтгэж нийтэд сурталчлах.

Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж:

- төв, орон нутгийн соёл урлагийн байгууллага, сонирхогчдын нэгдэл, утга соёлын өвийг өвлөсөн сод авьяастнуудтай хамтран ажиллах;
- үндэсний уламжлалт урлагийг дэмжих орчин бүрдүүлэх талаар жил бүр тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тооцож байх;
- үндэсний уламжлалт урлагийг өвлөн уламжлуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулдаг хамтлаг, нэгдэл, ажил-тан, авьяастнуудыг урамшуулан дэмжих;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бусад байгууллагуудаас зохиож байгаа ажилд идэвхтэй оролцох, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Гэр бүл, иргэдийн оролцоо:

- үр хүүхэд, гэр бүлийнхээ гишүүдийн авьяас чадварыг түшиглэн үндэсний уламжлалт урлагийг өвлөн уламжлах талаар санаачилга гаргах, тэдгийг энэ чиглэлийн сургалтад хамруулах, өөрсдийнх нь идэвхтэй үйл ажиллагаат дэмжих;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажилд идэвхтэй оролцох, өөрсдийн өвлөсөн авьяас чадвараа өвлүүлэх, уламжлуулах талаар үлгэр дууриалал үзүүлэх.

4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтыг хэрэгжүүлэх талаархи ажлын чиглэл:

- үндэсний уламжлалт урлагийн суурь болон хавсарга судалгаат өргөжүүлэн, судалгааны түвшинг дээшлүүлэх;
- үндэсний уламжлалт урлагийг үндэстэн, угсаатан, ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдуулан судлах;
- язгуур болон дүрслэх урлагуудын төрлүүдээр явуулсан нарийвчилсан судалгаат эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиуд хамтран зохион байгуулах, оюутны диплом, магистрантур болон докторантурын ажлын сэдвэт хамруулах;
- язгуур урлаг, дүрслэх урлагийн утга соёлын өвийн судалгааны асуудлаар экспедиц зохион байгуулах;
- улс үндэстний соёлын өвийг хөгжүүлэх, хамгаалахад чиглэсэн олон улсын арга хэмжээнд мэргэжилтнүүдээ оролцуулах;
- монгол орны нутаг дэвсгэрийг уугуул хүн ам, угсаатны бүтээц, зан заншил, нийтлэг ба өвөрмөц байдал, түүх уламжлалаар судалгааны бүсүүдэд хуваах, тэдгээрийн язгуур урлаг, дүрслэх урлагийн өвийг

сурвалжлан цуглуулах, аудио, видео бичлэгээр баримт-жуулах, судалгааны тодорхойлолтыг хийх судлаачдыг томилон тогтвортой ажиллуулах;

- язгуур урлаг, дүрслэх урлагийн утга соёлын өвийн хосгүй ховор төрлийг өвлөсөн билиг авьяастнууд болон ястан угсаатан, үндэстний цөөнхийн ёс заншил, зан үйлийн онцлогийг язгуур шинжээр нь тусгасан цуврал баримтат кино бүтээх төслийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад цуглуулсан материал хэрэглэгдэхүүнд тулгуурлан судалгаа, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттай зохион байгуулах, сурвалжлан цуглуулсан материалыг утга соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сүлжээнд оруулж, дуу, дүрс бичлэгийн архив бүрдүүлэх;
- язгуур урлаг, дүрслэх урлагийн утга соёлын хосгүй ховор өвийг өвлөсөн билиг авьяастнуудыг судлан тогтоож, цол өргөмжлөл олгох, билиг авьяасыг нь хойч үед уламжлуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- язгуур урлагийн чуулга, хамтлагууд, ардын билиг авьяастнуудын урын сангийн үзлэг шалгаруулалт явуулах, дуу, дүрс бичлэг хийх;
- утга соёлын өвийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах явцад цуглуулсан материал, хэрэглэгдэхүүнийг түшиглэн аман зохиол, угсаатны дуу хөгжмийн музей байгуулах;
- үндэсний уламжлалт урлагийн утга соёлын өвийг сурталчлах, хойч үедээ уламжлан үлдээх албан бус төрөлжсөн сургалтыг зохион байгуулж, ардын авьяас билигтнийг дагалдуулан сургах, шавь сургалт, гадаад орны сонирхогчид, судлаачдад зориулсан семинар зохиох, хөгжмийн зэмсэг, ноот хэрэглэгдэхүүнийг нийтэд хуваалцаалах цэг ажиллуулж ажил үйлчилгээг явуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл эрхэлнэ. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат улсын хэмжээнд мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

3. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүрэгтэй аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл ажиллана. Үндэсний хөтөлбөрийг Орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг үүргийг Засаг дарга батална.

4. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулах үүргийг нийслэлийн соёлын газар, аймгийн боловсрол , соёлын төв, судалгаа, сургалт, сурталчилгаа явуулах үүргийг орон нутгийн соёл, урлагийн байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.

5. Үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан ажлаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн 4 дүгээр улиралд орон нутгийн зөвлөл үндэсний зөвлөлд, үндэсний зөвлөл Засгийн газарт тус тус тайлагнаж байна.

6. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

а/ Монгол Улсын соёл урлагийн талаар гарсан хууль тогтоомж болон стратегийн баримт бичиг, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нийцүүлэх;

б/ боловсрол, соёл, хүүхдийн байгууллагуудын сургалт хүмүүжлийн ажлаар дамжуулан уламжлалт урлагийг өвлөн уламжлуулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны арга барил, уялдаа холбоог өөрчлөн шинэчлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа


Хөтөлбөрийг 1999-2006 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг хөтөлбөрийн хүрээнд нэгдүгээрт улс, орон нутгийн хэмжээнд уралдаан, наадам, үзэсгэлэн зохион байгуулах, хөөрдугаарт уламжлалт урлагийн төрөл зүйлүүд, тэдгээрийг өвлөсөн сод билиг авьяастны судалгааг эрчимжүүлэх, гуравдугаарт сурталчилгаа өргөжүүлэх гэсэн гурван үндсэн хэсэгт хуваан төлөвлөж байна.

Олон ястны уламжлалт урлагийн голлох төрлүүдийг хамруулах, нутаг дэвсгэрийн байршил, дэд бүтцийн онцлог, уламжлалт ур-

лагийн зарим уламжлагдах чанар нь алдагдахад хүрч бүй төрлийг сэргээн сурталчлах, өвлүүлэх асуудалд дүгнэлт хийж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалагч байгуулагатай, хэрэгжүүлэх хугацаат тодорхойлон, шаардагдах хөрөнгийн хэмжээг урьдчилан тогтоож байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн санхүүжилтийг Соёл урлагийн сангаар дамжуулан зарцуулах бөгөөд санхүүжилтийн нөхцөл байдал, үйл ажиллагаанаас хамаарч жил бүр "Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөө гаргаж, хөрөнгө, санхүүжилттэй холбогдох тодотгол хийж болно.



Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- улсын төвлөрсөн болон орон нуттийн төсөв;
- соёл, урлагийг дэмжих тусгай зориулалт бухий сан;
- гадаад орон болон олон улсын байгууллагын хөрөнгө;
- дотоод, гадаадын байгуулагга, иргэдээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгө.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

1. Ардын уламжлалт урлагийн суурь болон хавсарга судалгаа, сурталчилгааны ажил өрөгжиж, нийт хүн амын уламжлалт урлагийн тухай ойлголт, төлөвшилтийн түвшин дээшилнэ.
2. Үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгуулагын оролцоо сайжирч, хамтын үүрэг, хариуцлагын шинэ тогтолцоо төлөвшинө.
3. Үндэсний уламжлалт урлагийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн тогтолцоо бүрдэж, уламжлалт урлагийг дэмжих гадаад, дотоодын байгуулага, хамт олны тоо өсч түүнийг өвлүүлэн уламжлуулахад чиглэсэн тусламж, дэмжлэг нэмэгдэнэ.
4. Үндэсний уламжлалт урлагийн төрлүүд болон үндэстэн, угсаатны чиглэлээр улс, орон нуттийн хэмжээнд зохион байгуулагдах урлагийн наадам, уралдаан, үзэсгэлэнгийн арга хэмжээний зохион байгуулалт боловсронгуй болно.
5. Ардын урлагийг сурталчлах ажлын зохицуулалт, үр ашиг дээшилнэ.

Засгийн газрын 1999 оны 68 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"АРДЫН УЛАМЖЛАЛТ УРЛАГИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга
Гишүүд:
- Гэгээрлийн сайд
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Дэд бүтцийн хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын яамны Залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн газрын дарга;
- Гэгээрлийн хяналтын албаны дарга;
- Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын үүрээлэнгийн захирал;
- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын дарга;
- Ардын дуу, бүжгийн чуулганы дарга;
- Соёл, урлагийн хүрээлэнгийн захирал;
- Соёл, урлагийн сангийн гүйцэтгэх захирал;
- Монголын урлагийн ажилтны нийгэмлэгүүдийн холбооны хорооны дарга /тохиролцсоноор/;

Нарийн бичгийн дарга
-Монголын хөгжмийн зохиолчдын эвлэлийн хорооны дарга /тохиролцсоноор/;
-Соёл урлагийн дарга.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14503
Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны зургадугаар сарын 9* *№25 (104)*

Гарчиг

Монгол Улсын Хууль

214. Хөдөлмөрийн тухай / 1999-5-14-ний хууль/ 339

215. Хууль хүчингүй болсонд тооцох тухай / 1999-5-14-ний хууль/ 366

216. Хууль хүчингүй болсонд тооцох тухай / 1999-5-14-ний хууль/ 366

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

999 оны 5 дугаар
арын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн рээний үндсэн дээр хөдөлмөрийн харилаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн йтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, дөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж

2.1.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж нь ндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй йцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад таас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр мьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "ажил олгогч" гэж хөдөлмөрийн рээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж йгаа этгээдийг ;

3.1.2. "ажилтан" гэж ажил олгогчтой дөлмөрийн гэрээ байгуулан ажилласйгаа иргэнийг ;

3.1.3. "хөдөлмөрийн гэрээ" гэж нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог;

---

[1] ндсэн хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.4. "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог;

3.1.5. "хамтын хэлэлцээр" гэж иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамтран хамгаалах зорилгоор улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, салбар, мэргэжлийн хүрээнд ажил олгогч, ажилтны төлөөлөгчид, төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан тохиролцоог;

3.1.6. "ажил олгогчийн төлөөлөгчид" гэж аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, ажил олгогчоос эрх олгосон этгээд буюу дүрэмдээ ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үүрэг хүлээсэн байгууллагыг;

3.1.7. "ажилтны төлөөлөгчид" гэж ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үүрэг хүлээсэн үйлдвэрчний эвлэл, хэрэв ийм байгууллага байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон төлөөлөгчдийг;

3.1.8. "хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан" гэж хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хүрээнд хөдөлмөрийн гэрээний талууды хооронд үүссэн саналын зөрүүг;

3.1.9. " хөдөлмөрийн хамтын маргаан гэж хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах биелүүлэх, биелэлтэд нь хяналт тавих явцад гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг;

3.1.10."хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл" гэж хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй хөдөлмөрийн стандартад нийцээгүй ажлын байрны нөхцөлийг;

3.1.11. "үйлдвэрлэлийн осол" гэж ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхийг;

3.1.12. "мэргэжлээс шалтгаалсан өвчин" гэж хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг ;

3.1.13. "ажил хаялт" гэж хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх зорилгоор ажилтнаас үүрэгт ажлаа сайн дурын үндэс дээр тодорхой хугацаагаар бүрэн буюу хэсэгчлэн зогсоохыг.

4 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах харилцаа

4.1.Энэ хуулиар дор дурдсан талуудын хооронд хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулна:

4.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага болон Монгол Улсын иргэн хооронд;

4.1.2.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон Монгол Улсын иргэн хооронд;

4.1.3.дотоодын аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн хооронд;

4.1.4.Монгол Улсын олон улсын гэрээ өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн харьяалалгүй хүн хооронд.

4.2.Эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчид нь хөдөлмөрийн харилцаагаа талаар журам тогтоогоогүй, эсхүл энэ хуулийг мөрдөхөөр тохиролцсон бол энэ хуулийн холбогдох заалтыг хэрэглэнэ.

5 дугаар зүйл.Ажил олгогчийн эрх, үүрэг

5.1. Ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам батлах мөрдүүлэх, ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй.

5.2. Ажил олгогч нь ажилтныг ажлаа хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.

6 дугаар зүйл.Ажилтны эрх, үүрэг

6.1. Ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй.

6.2. Ажилтан нь үнэнчээр хөдөлмөрлөх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг чанд сахин биелүүлэх үүрэгтэй.

7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцааны ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох

7.1. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.

7.2. Хөдөлмөрийн харилцааны үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.

7.3.Ажил олгогч нь иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлог шаардлагын улмаас ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол энэ тухай үндэслэлээ цотлох үүрэгтэй.

7.4.Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашныхь нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.

7.5.Энэ хуулийн 7.4-т заасныг зөрчиж асуулт тавьсан тохиолдолд ажилтан түүнд хариулах үүрэгтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

8 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах үндсэн зарчим

8.1.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулахад дараахь зарчим баримтална:

8.1.1. ил тод байх;

8.1.2. хууль тогтоомжид нийцсэн байх;

8.1.3. талуудын төлөөлөгчдийн тоо адил байх;

8.1.4. талууд эрх тэгш байх;

8.1.5. хамтын гэрээ, хэлэлцээрт тусгах асуудлаа чөлөөтэй сонгож хэлэлцэх;

8.1.6. сайн дурааран үүрэг хүлээх;

8.1.7. хүлээх хариуцлагыг тодорхой заах

9 дүгээр зүйл.Мэдээллээр хангах

9.1. Хамтын гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, хэлэлцээ хийх үед төрийн холбогдох байгууллага, ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

9.2. Талууд хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ биелэлт, явцын талаар өөрт байгаа бүх мэдээллийг харилцан солилцох үүрэгтэй.

10 дугаар зүйл.Хөндлөнгийн оролцоог хориглох

10.1.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжүүлэх явцад төрийн ба төрийн бус, шашны байгууллага, улс төрийн нам, иргэн, албан тушаалтны зүгээс талуудын хууль ёсны эрхийг хязгаарлах буюу эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулах, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

11 дүгээр зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийг санаачлах

11.1. Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг аль ч тал санаачилж болно.

11.2.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэлэлцээ хийх санал гаргаж байгаа тал энэ тухайгаа нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

11.3.Ажил олгогчийн өмнөөс хэлэлцээ хийх эрхийг энэ хуулийн 3.1.6 -д заасан ажил олгогчийн төлөөлөгчид эдэлнэ.

11.4.Энэ хуулийн 3.1.7-д д заасан ажилтны төлөөлөгчид ажилтны нэрийн өмнөөс хэлэлцээ хийх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхтэй.

11.5.Улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, салбар, мэргэжлийн түвшинд, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагад хэд хэдэн үйлдвэрчний эвлэл байвал тэдгээр нь гишүүдийнхээ тооны харьцааг үндэслэн нэгдсэн төлөөлөгчид томилж хэлэлцээ хийх болон хамтын гэрээ, хэлэлцээр байгуулахад оролцоно.

12 дугаар зүйл.Хэлэлцээ хийх

12.1. Хамтын гэрээ, хэлэлцээрийг талууд хэлэлцээ хийх замаар байгуулна.

12.2. Хэлэлцээг санаачлагч тал нь хэлэлцээ хийх бүрэлдэхүүн, хамтын гэрээ, хэлэлцээрийн болон тэдгээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, хэлэлцээ хийх тухай мэдэгдэлдээ хавсарган нөгөө талдаа хүргүүлнэ.

12.3.Мэдэгдэл хүлээн авсан тал ажлын таван өдрийн дотор хариуг бичгээр өгнө.

12.4.Хэлэлцээ хийх тухай мэдэгдэл хүлээн авсан тал дор дурдсан хугацаанд хэлэлцээг эхлэх үүрэгтэй:

12.4.1.хамтын гэрээ байгуулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор;

12.4.2.хамтын хэлэлцээр байгуулах тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор.

12.5.Мэдэгдэл хүлээн авсан тал нь энэ хуулийн 12.3, 12.4-т заасан хугацаанд хариу ирүүлээгүй буюу хэлэлцээг эхлээгүй, эсхүл хэлэлцээний явцад тохиролцоонд хүрээгүй саналын зөрүүг энэ хуулийн Аравдугаар бүлэгт заасан хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах журмын дагуу зохицуулна.

12.6.Хэлэлцээнд оролцогчид нь хэлэлцээний явцад мэдэж авсан албаны болон худалдаалын нууцад хамаарах мэдээ сэлтийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

12.7.Хэлэлцээ хийхтэй холбогдсон зардал болон түүнд талуудын урьдчилан тохиролцсоноор оролцож байгаа мэргэжилтэнд олгох хөлс, бусад зардлыг хамтын гэрээ, хэлэлцээрт заасан жүрмын дагуу гаргана.

12.8.Хэлэлцээнд оролцож байгаа, үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуульгүй тандэ зохих дээд шатны байгууллагаас нь урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулж сахилгын шийтгэл ногдуулах, тэдний хэлэлцээнд оролцсоных нь төлөө өөр ажилд шилжүүлэх буюу ажил олгогчийн санаачилгаар хэлэлцээний туршид болон хэлэлцээ дуусанаас хойш нэг жилийн дотор ажлаас халахыг хоригломо.

12.9.Хэлэлцээ нь талуудын бүх төлөөлөгч хамтын гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурснаар дуусгавар болно.

13 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийн үйлчлэх хүрээ

13.1. Хамтын гэрээ, хэлэлцээр нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь төлөөлөн хамгаалж байгаа гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын нийт ажил олгогч, ажилтныг хамаарч үйлчилнэ.

14 дүгээр зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах

14.1.Хамтын гэрээ, хэлэлцээрийг байгуулахад энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

14.2. Аж ахуйн нэгж, байгууллагад түүний нэгж, хэсгийг хамруулан хамтын нэг гэрээ байгуулна.

14.3.Хэлэлцээр байгуулах санаачилга гаргасан этгээдийн тооноос үл хамааран тухайн түвшинд нэг хэлэлцээр байгуулна.

14.4.Ажил олгогч нь хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах үед өөрт байгаа мэдээлэл, бичиг хэргийн техник хэрэгсэл, ажлын бус цагаар хурал, зөвлөгөөн хийх байр гаргаж өгөх, ухуулга сурталчилгаа явуулахад туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

14.5.Хамтын гэрээг нэг жил, түүнээс дээш; хэлэлцээрийг хоёр жилийн хугацаагаар тус тус байгуулна.

15 дугаар зүйл. Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх

15.1.Ажил олгогч нь өөрийн оршиж байгаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хамтын гэрээг түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлэхээр хүргэнэ.

15.2.Салбар /салбар дунд/-ын, бүсийн, аймаг, нийслэлийн түвшний болон мэргэжлийн тарифын хэлэлцээрийг түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор холбогдмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхээр хүргэнэ.

15.3.Сум, дүүргийн түвшинд байгуулсан хэлэлцээрийг сум, дүүргийн Засаг дарга нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 15 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлэхээр хүргэнэ.

15.4.Энэ зүйлд заасан бүртгэх эрх бүхий этгээд нь хамтын гэрээ, хэлэлцээрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянаж, хууль тогтоомжид нийцэж байвал түүнийг бүртгэх бөгөөд хэрэв нийцэгүй бол бүртгэхээс татгалзана.

15.5.Бүртгүүлээгүй буюу хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл ажилтны эрхийн байдлыг хууль тогтоомжид зааснаас дордуулсан хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг хүчин төгөлдөр бус гэж үзэх бөгөөд түүнийг биелүүлэхгүй.

16 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийг дагаж мөрдөх

16.1. Хамтын гэрээ, хэлэлцээр нь энэ хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

16.2.Аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

16.3.Аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, өмчлөгч өөрчлөгдөх тохиолдолд хамтын гэрээг хэвээр мөрдөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хамтын гэрээг шинэчлэн байгуулах асуудлыг ажил олгогч буюу ажилтны төлөөлөгчид хэлэлцүүлэх хийж шийдвэрлэнэ.

16.4.Хуульд заасан нөхцөл, журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах үед хамтын гэрээг татан буугдах хугацааны туршид дагаж мөрдөнө.

16.5.Хамтын гэрээ, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг түүнд тодорхойлсон нөхцөл, журмын дагуу талуудын тохиролцсоноор шийдвэрлэх бөгөөд хэрэв хамтын гэрээ, хэлэлцээрт энэ тухай тодорхой заагаагүй бол түүнийг анх байгуулахад хэрэглэсэн журмыг баримтална.

17 дугаар зүйл.Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд талууд хяналт тавих

17.1.Хамтын гэрээний биелэлтэд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид хяналт тавина.

17.2.Бүх түвшинд байгуулагдсан хэлэлцээрийн биелэлтэд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид, түүнчлэн холбогдмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

17.3.Талууд хяналт хэрэгжүүлэхдээ хамтын гэрээ, хэлэлцээрт холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг харилцан солилцох үүрэгтэй.

17.4.Талууд хамтран ба дангаар хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлт, түүний явцыг хагас жил тутам буюу хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд дүгнэж, нийт ажилтанд мэдээлнэ.

18 дугаар зүйл.Хамтын гэрээгээр зохицуулах харилцаа

18.1.Хамтын гэрээнд энэ хуулиар шууд зохицуулагдаагүй дараахь харилцааг зохицуулна:

18.1.1.үндсэн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх, түүний хэлбэр, олгох хугацаа, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил,

нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох, өөрчлөх;

18.1.2.ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, түүнд шинэ мэргэжил эзэмшүүлэх болон ажлын байрны баталгаат хангах;

18.1.3.ажил, амралтын цагийн горим тогтоох;

18.1.4.ажилтан, үүний дотор жирэмсэн, насанд хүрээгүй, тахир дутуу болон одой хүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах;

18.1.5.аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгжийг хувьчлах, өөрчлөн байгуулах тохиолдолд ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

18.1.6.үнийн өсөлт, мөнгөнийханшийн бууралтын түвшнээс хамааруулж цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх;

18.1.7.ажилтны нийгмийн хамгаалалд зориулах хөрөнгийн хэмжээг тогтоох;

18.1.8.экологийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах;

18.1.9.ажиллахын зэрэгцээ суралцаж байгаа ажилтанд ажил олгогчийн зүгээс хөнгөлөлт үзүүлэх;

18.1.10.аж ахуйн нэгж, байгууллагын орон сууц, хүүхдийн цэцэрлэг, ясли, нийгэм, соёлын зориулалттай барилга, байгууламж барих, ашиглах, олон хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эх буюу ганц бие эцэг, тахир дутуу хүүхэдтэй ажилтанд хөнгөлөлт үзүүлэх, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан ахмад настан, тахир дутуу хүн, үйлдвэрлэлийн осол, хорц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс эрүүл мэнд нь хохирсон ажилтны амьжиргаагаа сайжруулах;

18.1.11.үйлдвэрчний эвлэл, түүний ажилтан, сонгуультнаас үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоог хангах.

18.2.Энэ хуулиар ажилтанд олгосон баталгааг илүү нөхцөлөөр хамтын гэрээнд тогтоож болно.

18.3.Хамтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг дүгнэх, мэдээлэх, хоёр болон гурван талт харилцааг хөгжүүлэх асуудлыг хамтын гэрээнд тусгана.

19 дүгээр зүйл. Хамтын хэлэлцээрээр зохицуулах харилцаа

19.1.Хамтын хэлэлцээрээр дараахь харилцааг зохицуулна:

19.1.1 улсын хэлэлцээрээр улсын хэмжээнд дагаж мөрдөх хүн амын нийгмийн хамгаалалын болон иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хангах;

19.1.2. салбар /салбар дунд/-ын хэлэлцээрээр тодорхой ажил, мэргэжлийн ажилтны цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн норм, нормативын асуудал;

19.1.3. бүсийн хэлэлцээрээр тухайн бүс нутгийн хэмжээнд дагаж мөрдөх хүн амын амьжиргааны болон цалин хөлсний доод хэмжээ, нөхөн олговор, иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нийтлэг асуудал;

19.1.4. аймаг, нийслэл, сум, дүүргийн хэлэлцээрээр тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид дагаж мөрдөх хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудал;

19.1.5. мэргэжлийн тарифын хэлэлцээрээр тодорхой ажил, мэргэжлийн хүрээний хөдөлмөрийн харилцааны асуудал.

20 дугаар зүйл.Хамтын хэлэлцээрт оролцогч талууд

20.1.Хамтын хэлэлцээрт энэ хуулийн 3.1.6, 3.1.7-д заасан ажил олгогчийн болон ажилтны төлөөлөгчдөөс гадна төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчид оролцож болно.

20.2.Хамтын хэлэлцээр нь түүнд оролцогч талуудаас хамааран хоёр талын, гурван талын байна.

20.3.Хамтын хэлэлцээр нь оролцогч талууд, хэлэлцэх асуудлын хүрээнээс хамаарч, улсын хэмжээнд улсын, салбар /салбар дунд/-ын; засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд бүсийн, аймаг, нийслэл,сум, дүүргийн; тодорхой ажил, мэргэжлийн түвшинд мэргэжлийн тарифын гэсэн төрөлтэй байна.

20.4.Хамтын хэлэлцээрт түүний төрлөөс хамааран дор дурдсан талууд оролцоно:

20.4.1.улсын хэлэлцээрт Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллага;

20.4.2.салбар /салбар дунд/-ын хэлэлцээрт тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах салбарын байгууллага;

20.4.3.бүсийн хэлэлцээрт тухайн бүс нутгийн аймаг, нийслэлийн Засаг дарга, ажил

олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах бүс нутгийн байгууллага;

20.4.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн хэлэлцээрт тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах тухайн нутаг дэвсгэрийн байгууллага;

20.4.5.мэргэжлийн тарифын хэлэлцээрт төрийн захиргааны холбогдох байгууллага, тухайн мэргэжлийн ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

21 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээ

21.1.Хөдөлмөрийн гэрээнд дараахь гол нөхцөлийг тохирно:

21.1.1.ажлын байрны буюу албан тушаалын нэр;

21.1.2.гүйцэтгэх ажил, үүрэг;

21.1.3.үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ;

21.1.4.хөдөлмөрийн нөхцөл.

21.2.Аль нэг тал дангараа хөдөлмөрийн гэрээний заалтыг өөрчилж болохгүй.

21.3.Хөдөлмөрийн гэрээ байгуулах үед талууд энэ хуулийн 21.1-д заасан гэрээний гол нөхцөлийн аль нэгийг тохироогүй бол хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцохгүй.

21.4.Хөдөлмөрийн гэрээ нь хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байна.

21.5.Хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт заасан нөхцөлөөс дордуулсан хөдөлмөрийн гэрээний нөхцөл хүчин төгөлдөр бус байна.

21.6.Талууд гэрээнд энэ хуулийн 21.1-д заасан гол нөхцөлөөс гадна бусад нөхцөлийг тохирч болно.

21.7. Хөдөлмөрийн гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

22 дугаар зүйл.Контракт

22.1.Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэгийг хэрэгжүүлэхдээ бусдын хөдөлмөрлөх үйл ажиллагаг, мөн ажил олгогч нь иргэний гоо буюу ховор авьяас, өндөр ур чадварыг хөлсөн авч ашиглах зорилгоор иргэнтэй контракт байгуулна.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасны дагуу контракт байгуулж иргэнийг авч ажиллуулж болох ажил, албан тушаалын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл.Хөдөлмөрийн гэрээний хугацаа

23.1.Хөдөлмөрийн гэрээ нь хугацаатай буюу хугацаагүй байна.

23.2.Хөдөлмөрийн гэрээний хугацаг гүйцэтгэх ажил, үүргийн онцлогоос хамааран талууд тодорхойлно.

23.3.Хөдөлмөрийн хугацаатай гэрээний хугацаа дуусмагц талууд түүнийг цуглах санал тавиагүй бөгөөд ажилтан ажлаа гүйцэтгэсээр байгаа бол уг гэрээг анх заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.

24 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээ байгуулах

24.1.Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, гэрээний хувийг ажилтанд өгнө.

24.2.Ажил олгогч нэг ажлын байранд хэд хэдэн ажилтан ажиллуулах тохиолдолд ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.

24.3.Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.

25 дугаар зүйл. Контракт байгуулах ба түүний агуулга

25.1.Контрактыг бичгээр байгуулна.

25.2.Контракт нь таван жил хүртэл хугацаатай байна.

25.3.Талууд контракт байгуулах үедээ хугацаа, ажилтны гүйцэтгэх ажлын эцсийн үр дүн, ажил олгогчийн өмнө хүлээх үүрэг, контрактыг дүгнэх журам, ажилтны мэдэлд олгож буй хөрөнгийн

хэмжээ, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам, ажилтанд олгох урамшуулал, хангамж, хөнгөлөлт болон үйл ажиллагааны хүрсэн үр дүн, ашгаас олгох хувь хэмжээ, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан байна.

25.4.Контрактыг дүгнэх үед ажилтан үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэж үзвэл цаашид сунгаж болно.

26 дугаар зүйл. Хэд хэдэн ажил, үүргийг зэрэг гүйцэтгэх

26.1.Ажилтан ажлын цагтаа багтаан өөрийн буюу бусад байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх, өөрийн байгууллагад өөр ажил хослон гүйцэтгэх болон ажил олгогч ажилтантай тохиролцсоноор эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх буюу түүний ажлын ачааллыг нэмэгдүүлэн ажиллуулж болно.

26.2.Энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд ажилтан хэд хэдэн ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ байгуулан ажиллаж болно.

27 дугаар зүйл. Ажил, албан тушаалд хамт ажиллахыг хориглох

27.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд нэг гэр бүлийн буюу төрөл, садангийн хүмүүс бие биедээ хяналт тавих болон захирах, захирагдах ажил, албан тушаалд хамт ажиллахыг хориглоно.

28 дугаар зүйл. Хэд хэдэн ажил олгочид нэгэн зэрэг ажиллахыг хориглох

28.1.Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсүүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно.

28.2.Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна.

28.3.Энэ зүйлийг зөрчсөнөөс ажил олгогчид учруулсан хохирлыг ажилтан энэ хуульд заасны дагуу арилгах үүрэгтэй.

29 дүгээр зүйл. Эрхийн чадамжгүй этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох цаг

29.1.Эрхийн хязгаарлагдмал чадамжтай буюу бүрэн чадамжгүй этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг уг ажилтан ажил үүргээ гүйцэтгэхгүй болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

30 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээний зарим заалт хүчин төгөлдөр бус байх

30.1.Хөдөлмөрийн гэрээний зарим заалт хүчин төгөлдөр бус байх нь түүнийг бүхэлд нь хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

31 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгүүлэхийг хориглох

31.1.Ажил олгогч нь энэ хуульд зааснаас бусад тохиолдолд ажилтнаас хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгэхийг шаардаж болохгүй.

32 дугаар зүйл.Ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд түр шилжүүлэх

32.1.Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан болон байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахад хүргэсэн урьдчилан мэдэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд 45 хүртэл хоногийн хугацаагаар шилжүүлж болно.

33 дугаар зүйл.Сул зогсолтын үед өөр ажилд түр шилжүүлэх

33.1.Сул зогсолтын үед ажилтныг байгууллага дотроо хөдөлмөрийн гэрээнд заагаагүй ажилд, эсхүл өөр байгууллагад түр хугацаагаар өөртэй нь тохиролцсоны үндэсэн дээр шилжүүлэн ажиллуулж болно.

34 дүгээр зүйл.Ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх

34.1.Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд түүнтэй тохиролцон шилжүүлнэ.

35 дугаар зүйл. Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг хэвээр хадгалах

35.1.Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг дараахь тохиолдолд хэвээр хадгална:

35.1.1.төрийн байгууллагын сонгуульт үүрэг гурван сар хүртэл хугацаагаар гүйцэтгэж байгаа;

35.1.2. ээлжийн амралттай байгаа;

35.1.3.эмнэлгийн шинжилгээ хийлгэх, донорын үүрэг гүйцэтгэх, эмчийн магадлагаагаар болон захиргааны чөлөөтэй байгаа;

35.1.4. жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа;

35.1.5.хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэлэлцээ хийхэд болон хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан ажил хаялтад оролцож байгаа;

35.1.6. цэргийн зарлан дуудах хуудас авсан ажилтныг цэргийн жинхэнэ албанд татсан тухай цэрэг татлагын комиссын шийдвэр гартал;

35.1.7. хууль тогтоомж, хамтын болон хөдөлмөрийн гэрээнд заасан бусад тохиолдол.

36 дугаар зүйл.Урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авах

36.1. Ажил олгогч нь ажилтныг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь дараахь тохиолдолд эгүүлэн авах үүрэгтэй:

36.1.1. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон ажилтан эдгэрснийхээ дараа нэг сарын дотор эргэж ирсэн;

36.1.2. ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг өмнө нь эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

36.1.3.хуульд заасан бусад тохиолдол.

36.2.Ажилтны урьд эрхэлж байсан ажлын байр, албан тушаал нь цомхотгогдсон бол ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндэсэн дээр адил чанарын өөр ажил, албан тушаалд ажиллуулах үүрэгтэй.

36.3.Энэ хуулийн 40.1.1.-д заасанаар орон тоо хасагдсан тэх боловч түүнийг гурван сарын дотор дахин бий болгож, орон тоо хассан нь үндэслэлгүй болох нь тогтоогдвол тухайн ажилтныг ажилд нь эгүүлэн тогтооно.

37 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох үндэслэл

37.1.Хөдөлмөрийн гэрээ дараахь үндэслэлээр дуусгавар болно:

37.1.1.талууд харилцан тохирсон;

37.1.2.ажил олгогч иргэн, ажилтан нас барсан;

37.1.3.хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;

37.1.4.хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;

37.1.5.ажлаас буруу халагдсан ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон;

37.1.6.ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсан;

37.1.7.ажилтан гэмт хэрэг үйлдсэний улмаас уг ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

37.1.8.хөдөлмөрийн гэрээг ажилтны буюу ажил олгогчийн санаачилгаар цуцалсан.

38 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл

38.1.Хөдөлмөрийн гэрээг дараахь үндэслэлээр цуцална:

38.1.1.ажилтан санаачилсан;

38.1.2.ажил олгогч санаачилсан.

39 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээг ажилтны санаачилгаар цуцлах

39.1. Хууль болон хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай өргөдлөө ажил олгогчид өгсөн өдрөөс хойш 30 хоног өнгөрөөгүй ажлын байраа орхих эрхтэй, энэ тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлагдсанд тооцно.

39.2. Хүндэтгэн үзэх шалтгаантай, эсхүл ажлаас чөлөөлөх хугацааг ажил олгогчтой тохиролцсон бол хөдөлмөрийн гэрээг энэ хуулийн 39.1-д заасан хугацаанаас өмнө цуцалж болно.

40 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлах

40.1. Хөдөлмөрийн гэрээг дараахь үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцалж болно:

40.1.1. аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;

40.1.2. ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон:

40.1.3. ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн;

40.1.4. ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцаанг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;

40.1.5. мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан бүрүүтай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон;

40.1.6.сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;

40.1.7. контрактад заасан үндэслэл буй болсон.

40.2. Ажлаас буруу халагдсан ажилтныг шүүхийн шийдвэрээр ажилд нь эгүүлэн тогтоосон тохиолдолд түүний эрхэлж байсан ажил, албан тушаалд шинээр орсон ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, бололцооны дагуу өөр ажил олж өгнө.

40.3.Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглоно.

40.4.Аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, өмчлөгч өөрчлөгдсөн нь хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болохгүй.

40.5.Ажил олгогч энэ хуулийн 40.1.1, 40.1.2-т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд нэг сарын өмнө мэдэгдэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажилтны төлөөлөгчдөд 45 хоногийн өмнө мэдэгдэж, энэ хуульд заасны дагуу хэлэлцээ хийнэ.

41 дүгээр зүйл. Контрактыг цуцлах үндэслэл, журам

41.1.Контрактыг энэ хуульд зааснаас гадна дараахь үндэслэлээр ажил олгогч санаачлан цуцалж болно:

41.1.1. контрактыг дүгнэх үед ажилтан контрактад заасан хийвэл зохих ажлынхаа үр дүнг хүндэтгэх шалтгаангүйгээр хангаагүй буюу хангалттай ажиллаж чадаагүй гэж өмчлөгч үзсэн;

41.1.2.энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг зорчиж өөр ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээтцсэн гэрээ буюу контракт байгуулсан;

41.1.3.ажил олгогч өмчлөх эрхээ бусад этгээдэд бүрмөсөн шилжүүлсэн;

41.1.4.контрактаар ажилтанд шилжүүлсэн эд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь нотлогдсон.

41.2.Энэ хуулийн 41.1.3-т заасан үндэслэлээр контрактыг цуцалж байгаа тохиолдолд ажил олгогч энэ тухайгаа ажилтанд хоёр сар, түүнээс дээш хугацааны өмнө мэдэгдэх үүрэгтэй бөгөөд гурван сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх төлбөр олгоно.

42 дугаар зүйл.Ажлаас халагдсаны тэтгэмж

42.1. Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

42.2. Бөөнөөр халах үед ажил олгогч нь ажлаас халагдсаны тэтгэмжийн хэмжээг ажилтны төлөөлөгчидтэй хийсэн хэлэлцээгээр тохирч тогтооно.

43 дугаар зүйл.Ажлаас халах, ажил хүлээлцэх

43.1.Ажил олгогч нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил хүлээлгэн өгөх хугацааг тогтоож, үг хугацааг ажлаас халах тухай шийдвэрт заана.

43.2.Ажилтан ажил хүлээлгэн өгсөн сүүлчийн өдрийг ажлаас халагдсан өдөр гэж үзнэ.

43.3. Ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн гэрээ цуцалсан тухай шийдвэр, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хуульд заасан бол ажлаас халагдсаны тэтгэмжийг халагдсан өдөрт нь өгөх үүрэгтэй.

43.4.Ажил олгогч нь ажилтны хүсэлтээр ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, цалин хөлсний тухай тодорхойлолтыг гаргаж өгөх үүрэгтэй.

44 дүгээр зүйл. Ажил, албан тушаал эрхлэхийг түдгэлзүүлэх

44.1.Хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага шаардсан бол ажилтныг тухайн ажил, албан тушаал эрхлэхийг түдгэлзүүлж, цалин хөлс олгохыг зогсооно.

45 дугаар зүйл. Үйлдвэрлэл дээрх сургалт

45.1. Ажил олгогч нь ажилтанд мэргэжил эзэмшүүлэх, түүний мэргэжлийг дээшлүүлэх сургалт зохион байгуулж, суралцах нөхцөлөөр хангана.

45.2. Үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулах үед онолын болон даддлагын хичээлийг ажлын цагаар явуулж болно.

46 дугаар зүйл. Нийгмийн даатгалд даатгуулах

46.1. Ажил олгогч болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, хуульд заасан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй.

46.2. Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтанд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээж, түүнд зохих жүрмын дагуу сар тутам шимтгэл, хураамж төлсөн тухай бичилт хийж үүрэгтэй.

46.3. Улирлын шинжтэй ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийг цалин хөлсний доод хэмжээгээр тооцож ажил олгогч төлнө.

46.4. Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийн тооцоог хууль тогтоомжид заасны дагуу хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЦАЛИН ХӨЛС, ОЛГОВОР

47 дугаар зүйл.Цалин хөлс

47.1.Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл,шагнал урамшууллаас бүрдэнэ

48 дугаар зүйл.Цалин хөлсний зохицуулалт

48.1. Цалин хөлсний доод хэмжээг хуулиар тогтооно.

48.2. Мэргэжил, албан тушаалын тариф-мэргэшлийн лавлах зохиох аргачлал, мэргэжил, албан тушаалын нэрийн нэгдсэн жагсаалт, хөдөлмөрийн норм, норматив тогтоох журмыг ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндсний байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

48.3. Ажил олгогч нь хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн дараахь журмыг баталж мөрдүүлнэ:

48.3.1. ажил, албан тушаалын жагсаалт;

48.3.2. ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах;

48.3.3. хөдөлмөрийн норм, норматив;

48.3.4.үндэсн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох нөхцөл, журам.

49 дүгээр зүйл.Цалин хөлс олгох зарчим, хэлбэр

49.1. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно.

49.2. Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно.

49.3. Нарийн мэргэшил, мэдлэг, мэргэжил шаардагдах болон онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн үнэлгээ илүү байна.

50 дугаар зүйл.Нэмэгдэл хөлс

50.1. Ажилтанд үндсэн цалин дээр нь ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгож болно.

50.2. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.

50.3. Нэмэгдэл хөлсийг энэ хууль болон хамтын гэрээгээр тогтоосон хэмжээгээр ажил олгогч ажилтантай тохиролцон тогтооно.

51 дүгээр зүйл.Нэмэгдэл

51.1.Ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно.

52 дугаар зүйл.Нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс

52.1.Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дунаж цалин хөлсийг нь 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

53 дугаар зүйл.Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс

53.1.Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.

53.2.Энэ хуулийн 53.1-д зааснаар олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

54 дүгээр зүйл.Шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс

54.1.Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

55 дугаар зүйл.Ээлжийн амралтын олговор

55.1. Ажилтанд ээлжийн амралтын олговор олгоно.

55.2. Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн жилын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно.

56 дугаар зүйл.Сул зогсолтын үеийн олговор

56.1.Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол хамтын гэрээнд заасан хэмжээний олговор олгоно.

56.2.Хамтын гэрээгээр тодорхойлсон сул зогсолтын олговрын хэмжээ нь уг ажилтны үндсэн цалингийн 60 хувь, түүнээс дээш байх ба цалин хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.

56.3.Тухайн ажилтны буруугаас сул зогсон бол түүнд олговор олгохгүй.

56.4. Сул зогсолтын хугацаанд өөр ажил гүйцэтгэсэн тохиолдолд уг ажилд нь тохируулан цалин хөлс олгох бөгөөд энэ нь урьд авч байсан дундаж цалин хөлсний хэмжээнээс бага байж болохгүй.

56.5.Сул зогсолтын хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөр ажил гүйцэтгэхээс татгалзсан ажилтанд олговор олгохгүй.

57 дугаар зүйл.Ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд түр шилжүүлэх үеийн цалин хөлс

57.1.Энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан үндэслэлээр ажилтныг өөр ажилд шилжүүлсэн үед гүйцэтгэсэн ажилд нь тохирсон цалин хөлс олгох бөгөөд урьд авч байсан дундаж цалин хөлс буурах тохиолдолд зөрүүг олгоно.

58 дугаар зүйл.18 насанд хүрээгүй ажилтны цалин хөлс

58.1. 18 насанд хүрээгүй ажилтны цалин хөлсийг цагаар, эсхүл хийснээр нь бодож, ажлын өдрийн хорогдуулсан цагт нь ногдох үндсэн цалинг нэмж олгоно.

59 дүгээр зүйл.Ажил хүлээлцэх хугацааны олговор

59.1. Ажил хүлээлцэх хугацааны олговрыг ажилтны ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага олгоно.

59.2.Ажил олгогчийн буруугаас ажил хүлээлцэх хугацаа хэтэрвэл уг хугацааны олговрыг ажилтанд олгоно.

59.3.Ажилтны буруугаас ажил хүлээлцэх хугацаа хэтэрвэл ажилтанд уг хугацааны олговрыг олгохгүй.

60 дугаар зүйл.Цалин хөлс олгох хугацаа

60.1. Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно.

60.2. Ажилтны цалин хөлсийг цаг, өдөр, долоо хоногоор тооцон олгож болно.

60.3. Ажилтны хүсэлтээр цалин хөлсийг нь урьдчилан олгож болно.

61 дүгээр зүйл.Цалин хөлсийг төлөх хэлбэр

61.1. Ажилтны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, олговрыг мөнгөн хэлбэрээр олгоно.

62 дугаар зүйл.Цалин хөлсний өөрчлөлтийн тухай мэдэгдэх

62.1. Ажил олгогч нь нийт ажилтны цалин хөлсний хэлбэр, хэмжээг хамтын гэрээний дагуу өөрчилсөн тухай шийдвэрийг мөрдөж эхлэхээс 10, түүнээс дээш хоногийн өмнө мэдэгдэж, хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулна.

63 дугаар зүйл.Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах

63.1. Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно:

63.1.1. ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан;

63.1.2.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

63.2.Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгалыг /орлогын албан татварыг оролцуулахгүйгээр/ цалин хөлсний 20 хувиас, харин хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон хэд хэдэн суутгал нэгэн зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрүүлж болохгүй.

63.3. Ажилтан нь түүний цалин хөлснөөс суутгал хийх тухай шийдвэр буюу суутгалын хэмжээг эс зөвшөөрвөл гомдлоо хөдөлмөрийн маргаан таслах комисст гаргаж болно.

63.4. Ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтэрсэн хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

63.5. Ажил олгогч ажилтны цалин хөлснөөс хууль бусаар суутгал хийсэн бол уг суутгасан мөнгийг эгүүлэн олгох тухай гомдлыг хөдөлмөрийн маргаан таслах комисст гаргана.

64 дүгээр зүйл.Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтанд олгох тэтгэмж, олговор

64.1.Энэ хуулийн 35.1.3-т зааснаар эмнэлгийн шинжилгээ хийлгэх, донорын үүрэг гүйцэтгэх, 35.1.5-т зааснаар хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэлэлцээ хийх үед болон 35.1.1, 35.1.6-д заасан тохиолдолд ажилтанд дундаж цалин хөлстэй тэнцэх олговор олгоно.

64.2.Энэ хуулийн 64.1-д зааснаас бусад 35 дугаар зүйлд заасан тохиолдолд олгох тэтгэмж, олговрыг энэ хууль, холбогдох бусад хууль болон хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

65 дугаар зүйл.Өөр орон нутагт ажиллахаар шилжих үед олгох нөхөх олговор

65.1. Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор нэг сум, хорооноос нөгөө сум, хороонд шилжин сонгогдсон буюу томилогдсон ажилтанд уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн гишүүдэд уналга, ачаа тээшийн зардлыг хүлээн авч байгаа байгууллага олгоно.

66 дугаар зүйл. Хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор

66.1. Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ажилдаа ирж чадаагүй ажилтанд үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний олговор олгоно.

66.2.Ажилдаа ирээгүй ба энэ хуулийн 66.1-д заасан гамшиг, саатлын хор уршгийг арилгахад биеэр оролцсон ажилтанд үндсэн цалингийн хэмжээгээр олговор олгоно.

67 дугаар зүйл.Ажлын цагийг богиносгосон үеийн цалин хөлс

67.1.Энэ хуулийн 71.1, 71.2, 71.4-т заасан ажилтны ажлын богиносгосон цагийг ажилласан цагт тооцож дундаж цалин хөлсийг олгоно.

67.2.Энэ хуулийн 71.3, 71.5-д заасны дагуу ажлын цагийг нь богиносгосон ажилтанд зургаан сарын хугацаанд түүний урьд авч байсан дундаж цалин хөлсийг олгоно.

68 дугаар зүйл.Ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн үеийн цалин хөлсний зөрүү

68.1.Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүнийг энэ хуулийн 107.1-д зааснаар эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн хугацаанд цалин хөлс нь буурсан бол түүний урьд авч байсан болон одоо авч байгаа цалин хөлсний зөрүүтэй тэнцэх олговор олгоно.

68.2.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн үед цалин хөлс буурахад хүрвэл зургаан сарын хугацаанд түүний урьд авч байсан болон одоо авч байгаа дундаж цалин хөлсний зөрүүтэй тэнцэх олговор олгоно.

69 дүгээр зүйл.Буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор

69.1. Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан бүх хугацаанд нь урьд авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх олговрыг олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГ

70 дугаар зүйл. Ажлын цаг

70.1.Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна.

70.2. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна.

70.3. Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна.

71 дүгээр зүйл.Ажлын цагийг богиносгох

71.1. Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байна.

71.2.Хөдөлмөрийн стандарт болон мэргэжлийн байгууллагаас хийсэн үнэлгээг баримтлан ажлын байрны хэвийн бус нөхцөлийг эрх бүхий байгууллагаас тогтоосон бол ажил олгогч нь түүнийг үндэслэн ажилтны ажлын цагийг богиносгох үүрэгтэй.

71.3. Ажилтны ажлын цагийг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн дагуу богиносгоно.

71.4.Үйлдвэрлэл дээр мэргэжил эзэмшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь ажил олгогч богиносгох үүрэгтэй.

71.5.Тахир дутуу болон одой хүний гүйцэтгэж байгаа ажлын шинж байдлаас хамааран ажилтны саналыг харгалзан ажлын цагийг богиносгож болно.

72 дугаар зүйл.Шөнийн цаг

72.1.Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно.

73 дугаар зүйл.Ажлын цагийг нэгтгэн бодох

73.1.Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй бол ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэглэж болно.

73.2.Энэ хуулийн 73.1-д заасан тохиолдолд нэгтгэн бодсон цаг нь тооцоот хугацаанд ногдох ажлын цагийнн нийлбэрээс хэтэрч болохгүй.

73.3.Ажлын цагийг нэгтгэн бодох журмыг Засгийн газар батална.

73.4.Ажлын цагийг нэгтгэн бодсон нь ажилтанд эрүүжийн амралт олгох, нийгмийн даатгалд шимтгэл төлсөн хугацааг тооцох зэрэг асуудлаар хууль тогтоомжид заасан нөхцөлийг хэрэглэхэд хязгаарлал болохгүй.

74 дүгээр зүйл.Илүү цагаар ажиллуулахыг хязгаарлах

74.1. Энэ хуульд заасан үндэслэлийн дагуу хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсан гэж үзнэ.

74.2.Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:

74.2.1.улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх;

74.2.2.байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгах;

74.2.3. нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагаат алдагдуулсан гэмтлийг арилгах;

74.2.4. урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэх.

74.3. Ажилтныг хоёр ээлжинд дараалан ажиллуулахыг хориглоно.

75 дугаар зүйл.Амрах, хооллох завсарлага

75.1.Ажилтанд амарч, хооллоход нь зориулан завсарлага олгоно.

75.2.Завсарлага эхлэх, дуусах цагийг хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно.

75.3.Ажил, үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтай ажилтныг ажил олгогч хооллох бололцоогоор хангана.

76 дугаар зүйл.Нийтээр амрах баярын өдөр

76.1.Дараахь баярын өдөр нийтээр амарна:

76.1.1.Шинэ жил: нэгдүгээр сарын 1;

76.1.2.Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1,2;

76.1.3. Эх үрсийн баяр: зургадугаар сарын 1;

76.1.4.Үндэсний их баяр наадам. Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13;

76.1.5.Бүгд Найрамдах Удс тунхагласны баяр: арван нэгдүгээр сарын 26.

77 дугаар зүйл.Долоо хоног бүрийн амралт

77.1. Бямба, Ням гаригт нийтээр амарна.

77.2. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан Бямба, Ням гаригт амрах боломжгүй ажилтныг долоо хоногийн өөр дараалсан хоёр өдөр амруулна.

78 дугаар зүйл.Нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хязгаарлах

78.1. Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно:

78.1.1. энэ хуулийн 74.2.1, 74.2.2, 74.2.3, 74.2.4-т заасан;

78.1.2.тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл, хүн амын үйлчилгээний болон хойшлуулшгүй засвар, ачиж буулгах ажил гүйцэтгүүлэх.

78.2. Ажил олгогч ажилтантай тохиролцсоноор нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулж болно.

78.3.Энэ хуулийн 78.2-т заасан тохиолдолд ажилтныг өөр өдөр нөхөн амруулах, эсхүл амралтыг ээлжийн амралттай нь хамтатган олгож болно.

79 дүгээр зүйл.Ээлжийн амралт, түүний хугацаа

79.1. Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ.

79.2. Ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна.

79.3. 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна.

79.4. Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн жилдээ багтаан хэсэгчлэн эдлэж болно.

79.5.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацаанд харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл амралт олгоно:

79.5.1. 6-10 жилд ажлын 3 өдөр;

79.5.2. 11-15 жилд ажлын 5 өдөр;

79.5.3. 16-20 жилд ажлын 7 өдөр;

79.5.4. 21-25 жилд ажлын 9 өдөр;

79.5.5 26-31 жилд ажлын 11 өдөр;

79.5.6 32, түүнээс дээш жилд ажлын 14 өдөр.

79.6.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл амралтыг хамтын гэрээнд зааснаар олгоно:

79.6.1. 6-10 жилд ажлын5,түүнээс дээш өдөр;

79.6.2. 11-15 жилд ажлын7, түүнээс дээш өдөр;

79.6.3. 16-20 жилд ажлын9, түүнээс дээш өдөр;

79.6.4. 21-25 жилд ажлын12,түүнээс дээш өдөр;

79.6.5. 26-31 жилд ажлын15,түүнээс дээш өдөр;

79.6.6. 32, түүнээс дээш жилд ажлын 18, түүнээс дээш өдөр.

79.7 Төрийн албан хаагчийн нэмэгдэл амралтын хугацаагхолбогдох хуулиар тогтоож болно.

80 дугаар зүйл.Чөлөө олгох

80.1. Ажил олгогч нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгож болно.

80.2. Чөлөөтэй байгаа хугацаанд тэтгэмж олгох, эсэх асуудлыг хамтын ба хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд зааснаар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СТАНДАРТ

81 дүгээр зүйл.Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал

81.1.Ажлын байрны нөхцөлийг хөдөлмөрийн хэвийн нөхцөл, хэвийн бус нөхцөл гэж ангилна.

81.2.Ажил олгогч нь ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

81.3.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоох нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

82 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг тогтоох

82.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн стандартын асуудал эрхэлсэн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу батална.

82.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

83 дугаар зүйл.Ажлын байранд тавих ерөнхий шаардлага

83.1.Ажлын байрны зохион байгуулалт нь үйлдвэрлэлийн технологийн шаардлагад зохицсон, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

83.2. Ажлын байранд үйлдвэрлэлийн явцад үүсч болзошгүй хими, физик, биологийн сөрөг хүчин зүйл нь энэ хуулийн 82.1-д заасан байгууллагаас батлагдсан хөдөлмөрийн эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хязгаараас хэтрэхгүй байна.

83.3. Ажлын байранд ажилтанд зориулсан ахуйн байгыг эрүүл ахуйн шаардлагын хэм хэмжээний дагуу төхөөрөмжилнө.

84 дүгээр зүйл.Үйлдвэрлэлийн барилга байгууламжид тавих шаардлага

84.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зураг төслийг зохиох, барьж байгуулах болон шинэчлэх, өргөтгөх, ашиглалтад өгөхийн тулд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авна.

85 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хамтран эзэмшихэд тавих шаардлага

85.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хоёр буюу түүнээс дээш ажил олгогч хамтран эзэмшиж байгаа тохиолдолд эзэмшигчид дараахь шаардлагыг хангах үүрэгтэй:

85.1.1.өмчлөгч буюу эзэмшигчид хамтран журам тогтоож мөрдүүлэх;

85.1.2. үйлдвэрлэлийн явцад химийн, хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхтэй бодисыг хэрэглэх тохиолдолд барилга байгууламж эзэмшигчид харилцан бие биедээ мэдээлж аюулгүй байдлыг хангах.

85.2. Энэ хуулийн 85.1 -д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хамтран эзэмшихийг хориглоно.

86 дугаар зүйл.Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага

86.1. Машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглалт, аюулгүй ажиллагааны журмын дагуу ажиллуулж, техникийн паспортыг бүрэн хөтөлсөн байна.

86.2. Машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад өгөхийн тулд мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж, зөвшөөрөл авна.

86.3. Өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд зохих журмын дагуу туршилт, тохируулга, баталгаажуулалт хийсэн байна.

86.4. Цахилгаан, тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

87 дугаар зүйл.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага

87.1. Ажил олгогч нь ажилтныг түүний хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллага, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангана.

87.2. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг цэвэрлүүлэх, ариутгуулах, засварлуулах үүрэгтэй.

88 дугаар зүйл. Химийн, хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага

88.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа химийн, хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа тухай хөдөлмөрийн хяналтын байгууллагад зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагаас баталсан журмыг мөрдөж ажилдана.

89 дүгээр зүйл.Галын аюулгүй байдалд тавих шаардлага

89.1. Ажил олгогч нь галын аюулгүй байдлыг хангах дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

89.2. Галын дохиолол болон гал унтраах түгээй тоноглолоор хангагдсан аж ахуйн нэгж, байгууллага нь тэдгээрийг тогтмол ажилдаагаатай байлгаж, ажилтнуудаа уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

89.3. Ажил олгогч нь галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

90 дүгээр зүйл.Цаг уурын тохиромжгүй нөхцөлд ажиллахад тавих шаардлага

90.1.Ажил олгогч нь хэт халуун буюу хүйтэн, салхитай, хур тунадастай зэрэг цаг уурын нэн тохиромжгүй нөхцөлд задгай газар, халаалттүй байранд ажиллаж байгаа ажилтан хөдөлмөрийн стандартын дагуу түр завсарлагын үед амрах, дулаацах, хоргодох зориулалт бүхий ахуйн байр байгуулж, тоноглож, тохижуулна.

91 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах

91.1. Ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн аятай нөхцөл бүхий ажлын байраар хангах бөгөөд үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

91.2.Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцас, хор саармагжуулах бодис, хоол, хүнсний бүтээгдэхүүн зэргийг олгоно.

91.3. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж зарцуулна.

92 дугаар зүйл.Эрүүл мэндийн үзлэг

92.1.Ажил олгогч ажилтныг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулна.

92.2.Энэ хуулийн 92.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.

93 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба, зөвлөл

93.1.Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба /жилтан/, эсхүл ажил олгогч, ажилтны төлөөлөл бүхий орон тооны бус зөвлөл ажиллуулна.

93.2.Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ.

94 дүгээр зүйл.Амь бие, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоох

94.1.Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн тухай бүр болон амь бие, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиол долд ажлаа зогсоож, энэ тухай ажил олгогчид мэдэгдэнэ.

94.2. Ажил олгогч нь энэ хуулийн 94.1-д заасан зөрчил, нөхцөл байдлыг нэн даруй арилгах үүрэгтэй.

95 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

95.1. Ажил олгогч нь осолд өртсөн ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, ослын шалтгаан, хор уршгийг арилгах арга хэмжээг нэн даруй авна.

95.2. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол гарах бүрд Засгийн газраас тогтоосон жүрмын дагуу ослыг судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд үйлдвэрлэлийн ослыг тогтоох орон тооны бус байгныи комиссыг байгуулж ажиллуулна.

95.3. Үйлдвэрлэлийн ослын тухай комиссын актыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч батална.

95.4.Ажил олгогч энэ хуулийн 95.2, 95.3-т заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл осол гарсан шалтгаан нөхцөлийн тухай дүгнэлтийг ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн улсын хяналтын байгуулагад гаргах эрхтэй.

95.5.Энэ хуулийн 95.4-т заасны дагуу гаргасан гомдлыг хянасан шийдвэрийг ажил олгогч биелүүлэх үүрэгтэй.

95.6. Үйлдвэрлэлийн ослыг судалж бүртгэхтэй холбогдсон зардлыг осол гарсан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

95.7. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг хөдөлмөрийн хяналтын алба, албан тушаалтан тогтоосон жүрмын дагуу судалж, үйлдвэрлэлд гарсан осолтой адилтган үзэж бүртгэн, энэ зүйлд заасан болон бусад холбогдох арга хэмжээг авна.

95.8. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын тухай мэдээг тогтоосон жүрмын дагуу гаргаж мэдээлнэ.

95.9.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг нуун дарагдуулахыг хориглоно.

95.10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг Засгийн газар батална.

96 дугаар зүйл.Мэргэжлээс шалтгаалсан өвчин

96.1. Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага батална.

96.2.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг холбогдох мэргэжлийн байгууллага тогтооно

97 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх

97.1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан болон эдгэрэн шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч нь дор дурдсан хэмжээний нөхөн төлбөр олгоно: 97.1.1.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа хагас алдсан ажилтанд ес, түүнээс дээш, бүрэн алдсан ажилтанд 18, түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг бө түүнээс дээш удаа;

97.1.2.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт 36, түүнээс дээш сарын цалинтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа.

97.2.Энэ хуулийн 97.1-д заасны дагуу нөхөн төлбөр олгох нь хохирогч нийгмийн даатгалын болон бусад хууль тогтоомжийн дагуу төтгөвэр, тэтгэмж авахад нөлөөлөхгүй.

97.3.Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.

98 дугаар зүйл.Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс

98.1. Тахир дутуу болсныг тогтоох, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хэмжээг тодорхойлох асуудлыг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс шийдвэрлэнэ.

98.2.Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг Засгийн газар батална.

99 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангагүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох, хаах

99.1.Аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгжийн үйл ажиллагаа ажилтны эрүүл мэнд, амь насанд сөрөг нөлөө, аюул учруулж байгаа нь нотлогдвол хөдөлмөрийн хяналтын алба буюу эрх бүхий албан тушаалтан /улсын байцаагч/ нь зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

99.2.Энэ хуулийн 99.1-д заасан зөрчлийг

арилгахгүй бол хөдөлмөрийн хяналтын алба буюу эрх бүхий албан тушаалтан /улсын байцаагч/ нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах хүртэлх хугацаанд байгууллагын үйл ажиллагааг бүрэн, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох буюу хааж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР

100 дугаар зүйл.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийг ажлаас халахыг хориглох

100.1.Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон энэ хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно.

100.2.Энэ хуулийн 100.1 нь гурав хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

101 дүгээр зүйл.Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажил

101.1.Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

102 дугаар зүйл.Шөнийн буюу илүү цагаар, албан томилолтоор ажиллуулахыг хязгаарлах

102.1.Жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглоно.

102.2.Энэ хуулийн 102.1 нь 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

103 дугаар зүйл.Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлага нэмж олгох

103.1. Амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно.

103.2.Энэ хуулийн 103.1 нь ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

103.3. Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажилласан цагт оруулан тооцно.

104 дүгээр зүйл.Жирэмсний болон амаржсаны амралт

104.1. Эхэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгоно.

104.2. Хүүхдээ 196, түүнээс дээш хоног төрсөд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, 196 хоног төрсөөгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эмэгтэй хүнд энэ хуулийн 104.1-д заасан жирэмсний болон амаржсаны амралт олгоно.

104.3.Хүүхдээ 196 хоног хүртэл төрсөгүй дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан эмэгтэй хүнд өвчний үчир чөлөөлөх ердийн жүрмыг баримтлан ажлаас чөлөө олгоно.

105 дугаар зүйл.Нярай хүүхэд үрчлэн авсан ажилтанд чөлөө олгох

105.1. Нярай хүүхэд үрчлэн авсан эхэд хүүхдийг нь 60 хоногтой болтол хугацаагаар амаржсан эхийн нэг адил чөлөө олгоно.

105.2. Энэ хуулийн 105.1 нь нярай хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.

106 дугаар зүйл.Хүүхэд асрах чөлөө олгох

106.1.Ажил олгогч нь амаржсаны болон эзэлжийн амралтаа эдэлсэн, гурав хүртэлх насны хүүхдэтэй эх өөрөө хүсвэл түүнд хүүхэд асрах чөлөө олгоно.

106.2. Хүүхэд асрах чөлөө дуусан, эсхүл дуусаагүй боловч эх өөрөө хүсвэл ажил олгогч нь түүнийг ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилгүй тоог цөөрүүлсэн бол түүнд өөр ижил олж өгнө.

106.3. Энэ хуулийн 106.1, 106.2 нь гурав хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, мөн насны хүүхэд үрчлэн авсан ганц бие хүнд нэгэн адил хамаарна.

107 дугаар зүйл.Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу өөр ажилд шилжүүлэх

107.1.Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно.

108 дугаар зүйл. Эмэгтэй хүний өргөх, зөөх ачааны хэмжээг хязгаарлах

108.1 Хөдөлмөрийн асуудал хариуцсан засгийн газрын гишүүний батлалсан хэмжээнээс илүү хүнд ачааг эмэгтэй хүнээр өргүүлэх, зөөлгөхийг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

НАСАНД ХҮРЭЭГҮЙ, ТАХИР ДУТУУ, ОДОЙ ХҮНИЙ БОЛОН АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР

109 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүний хөдөлмөр

109.1. 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.

109.2.Энэ хуулийн 109.5-д харшлахгүй бол 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

109.3. Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

109.4.Насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

109.5.Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

110 дугаар зүйл.Насанд хүрээгүй ажилтны эрүүл мэндийг хамгаалах

110.1.Насанд хүрээгүй хүнийг эмнэлгийн үзлэгт орсны дараа ажилд авах бөгөөд түүнийг 18 насанд хүртэл нь хагас жил тутам эмнэлгийн үзлэгт хамруулна.

110.2. Насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно.

110.3.Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно.

110.4.Хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний батлалсан хэмжээнээс илүү хүнд ачаар насанд хүрээгүй ажилтнаар өргүүлэх, зөөлгөхийг хориглоно.

111 дүгээр зүйл.Тахир дутуу буюу одой хүний хөдөлмөр

111.1.Ажил, үйлдвэрлэлийн онцлогт харшлахгүй тохиолдолд 50, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа гүрав, түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулна.

111.2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.

111.3.Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.

111.4.Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэн, уг хөрөнгийг тахир дутуу буюу одой хүнд зориулах ниигмийн хамгаллын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

111.5.Тахир дутуу, одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохоогүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол тэдгээрийг үг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг хориглоно.

112 дугаар зүйл.Ахмад настны хөдөлмөр

112.1.Тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болно.

112.2.Ахмад настан тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг хязгаарлах үндэслэл болохгүй.

112.3.Ажил олгогч нь ахмад настны хүсэлтээр түүний ажлын өдрийн үргэлжлэлийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй ажилд шилжүүлж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААДЫН ИРГЭНИЙ БОЛОН ГАДААДЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАЖ БАЙГАА ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР

113 дугаар зүйл.Гадаадын иргэний хөдөлмөр

113.1. Ажил олгогч хөдөлмөрийн гэрээний үндэсэн дээр гадаадын иргэнийг ажиллуулж болно.

113.2. Гадаадын иргэн энэ хууль болон бусад хуульд заасны дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхлэх асуудлыг зохицуулах журмыг Засгийн газар тогтооно.

113.3.Энэ хуулийн 113.1, 113.2 нь харьяалагүй хүнд нэгэн адил хамаарна.

114 дүгээр зүйл. Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа иргэний хөдөлмөр

114.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын иргэнийг авч ажиллуулж болно.

114.2. Энэ хуулийн 114.1-д заасан тохиолдолд ажил олгогч нь ажилтантай энэ хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулна.

114.3. Ажилтныг гэрээгээр ажиллуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын талаар урх бүхий байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

АРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН ЗОХИЦУУЛАЛТ

115 дугаар зүйл.Хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх, шаардлага тавих, түүнд хариу өгөх

115.1.Энэ хуулийн 12.5-д заасны дагуу хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах явцад үүссэн санал зөрүүтэй асуудлаар болон хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг биелүүлэх талаар шаардлага тавьж хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг ажилтны төлөөлөгчид эдэлнэ.

115.2.Шаардлагыг гэрээ, хэлэлцээрт оролцуулаагүй нэг тал нь мөгөө талд бичгээр өгнө.

115.3. Шаардлагын хувийг тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

115.4. Шаардлага авсан тал ажлын гурван өдрийн дотор хариуг мөгөө талд бичгээр өгнө.

116 дугаар зүйл.Хөдөлмөрийн хамтын маргаан эвлэрүүлж зохицуулах хэлбэр

116.1. Хөдөлмөрийн хамтын маргааныг дор дурдсан арга хэмжээгээр эвлэрүүлж зохицуулна:

116.1.1. зуучлагч урьж оролцуулах;

116.1.2. хөдөлмөрийн арбитраар хэлэлцэх.

116.2. Талууд энэ хуулийн 116.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээнд оролцохоос татгалзах эрхтэй.

116.3. Эвлэрүүлэх арга хэмжээний үед ажилтны төлөөлөгчид тавьсан шаардлагаа дэмжих зорилгоор хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан хийх эрхтэй.

116.4.Талуудын төлөөлөгчид, зуучлагч, хөдөлмөрийн арбитрч нь хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахын тулд хууль тогтоомжоор олгосон бүх боломжийг ашиглах үүрэгтэй.

117 дугаар зүйл.Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулахад зуучлагч урьж оролцуулах

117.1.Энэ хуулийн 115 дугаар зүйлд зааснаар тавьсан шаардлагыг ажил олгогч хүлээж аваагүй, хүгацаанд нь хариу өгөөгүй, эсхүл ажилтны төлөөлөгчид ажил олгогчоос өгсөн хариуг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулахад зуучлагч урьж оролцуулна.

117.2. Талууд зуучлагчийг тохиролцон сонгох бө ажлын гурван өдөрт тохиролцоонд хүрээгүй бол талууд тухайн сум, дүүргийн Засаг даргад хандаж зуучлагч томилуулах тухай хүсэлт тавина.

117.3.Сум, дүүргийн Засаг дарга зуучлагчийг ажлын гурван өдөрт багтаж томилно.

117.4. Засаг даргын томилсон зуучлагчийг талууд татгалзах эрхгүй.

117.5. Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

117.6. Зуучлагч нь хөдөлмөрийн хамтын маргаанд холбогдох бичиг баримт, мэдээллийг талуудаас шаардан авах эрхтэй.

117.7. Талууд зуучлагч урьснаас хойш ажлын тав хүртэл өдрийн дотор түүний оролцоотойгоор маргааныг хянан хэлэлцэх бөгөөд харилцан тохиролцсон шийдвэрийг бичгээр гаргаснаар буюу санал зөрүүтэй хэвээр байгаа тухай тэмдэглэж уллөэснээр уг үйл ажиллагаа дуусна.

118 дугаар зүйл.Хөдөлмөрийн хамтын маргааныг хөдөлмөрийн арбитраар хэлэлцэх

118.1. Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотой хэлэлцээд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд тухайн шатны Засаг дарга ажлын гурван өдөрт багтаан хөдөлмөрийн хамтын маргааныг хэлэлцэх хөдөлмөрийн арбитрыг байгуулж, арбитрчдыг томилно.

118.2.Хөдөлмөрийн арбитр нь хөдөлмөрийн хамтын маргаанд оролцогч талууд болон Засаг даргын санал болгосон гурван арбитрчаас бүрдэнэ.

118.3.Засаг даргын томилсон арбитрчдыг талууд татгалзах эрхгүй.

118.4. Хөдөлмөрийн хамтын маргаанд оролцогч талуудын төлөөлөгчидийг хөдөлмөрийн арбитрын бүрэлдэхүүнд оруулахгүй.

118.5. Хөдөлмөрийн арбитр нь байгуулагдсан өдрөөс хойш ажлын тав хүртэл өдрийн дотор хөдөлмөрийн хамтын маргааныг талуудын төлөөлөгчидийг оролцуулан хянан хэлэлцэж зөвлөмж гаргана.

118.6.Хөдөлмөрийн хамтын маргаанд оролцогч талуудын төлөөлөгчид зөвлөмжийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хэлэлцэж, зөвлөмжийг хүлээн авах эсэхээ мэдэгдэнэ.

118.7.Зөвлөмжийг хүлээн авсан тухай мэдэгдсэн талууд зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.

118.8.Зөвлөмжийг хүлээн авсан тухай мэдэгдсэн талууд зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.

118.9.Зөвлөмжийг хүлээн авсан тухай мэдэгдсэн талууд зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.

цогц талууд хөдөлмөрийн арбитрын зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлээгүй тохиролцооноо хүрсэн бол энэ тухай шийдвэр гаргана.

118.7.Энэ хуулийн 118.6-д заасан шийдвэрийг талууд биелүүлээх үүрэгтэй.

118.8.Хөдөлмөрийн арбитрын дүрмийг Хөдөлмөр, нийгмийн зөвлөлийн гурван талт Үндэсний хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

119 дүгээр зүйл. Ажил хаях эрхийг хэрэгжүүлэх

119.1.Ажилтны төлөөлөгчид дор дурдсан тохиолдолд ажил хаях эрхтэй:

119.1.1. ажил олгогч энэ хуулийн 116.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээнд оролцох үүргээ биелүүлээгүй;

119.1.2. ажил олгогч зуучлагчийн оролцоотой тохиролцсон шийдвэрийг биелүүлээгүй;

119.1.3. ажил олгогч хөдөлмөрийн арбитрын зөвлөмжийг хүлээн авч гаргасан шийдвэрээ биелүүлээгүй;

119.1.4.хөдөлмөрийн хамтын маргааныг хөдөлмөрийн арбитраар хэлэлцсэн боловч түүний зөвлөмжийг хүлээн авч шийдвэр гаргаагүй.

119.2. Ажилтан ажил хаялтад сайн дураараа оролцоно.

119.3. Ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг ажилтанд тулган шаардаж болохгүй.

119.4. Ажил олгогчийн төлөөлөгч ажил хаялтыг зохион байгуулах, түүнд оролцохыг хориглоно.

120 дугаар зүйл.Ажил хаялт зарлах, ажлын байрыг түр хаах

120.1. Ажил хаях тухай шийдвэрийг ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын гишүүдийн буюу нийт ажилтны хурлаас гаргана.

120.2.Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын гишүүд буюу тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны дийлэнх олонхи /гуравны хоёр/ нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

120.3.Хуралд оролцогчдын олонхи /талаас илүү/ нь ажил хаяхыг дэмжсэн бол ажил хаялт зарлаж болно.

120.4. Ажил хаях тухай шийдвэрт дор дурдсан асуудлыг тусгана:

120.4.1. ажил хаяхад хүргэсэн санал зөрүүтэй асуудал;

120.4.2. ажил хаялт эхлэх он, сар, өдөр, цаг, ажил хаялтын үргэлжлэх хугацаа, оролцох хүний урьдчилсан тоо;

120.4.3. ажил хаялтыг зохион байгуулж удирдах эттээд, маргааң шийдвэрлэхэд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүн;

120.4.4. ажил хаялт зохион байгуулах үед хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон ажлын жагсаалт.

120.5.Ажил хаялтыг удирдах эттээд ажил хаялт эхлэхээс ажлын тав, түүнээс дээш өдрийн өмнө ажил хаях тухай шийдвэрийг нөгөө талд хүргүүлэх үүрэгтэй.

120.6. Ажил олгогч ажилтны шаардлагыг хүлээж авах боломжгүй гэж үзвэл ажил хаялтын эсрэг арга хэмжээ болгон ажил хаялтад оролцож байгаа ажилтны ажлын байрыг тэдний хувьд түр хааж (локаут) болно.

120.7.Ажил хаялтад оролцогчын ажлын байранд ажилтан түр ажиллуулахгүй байх зорилгоор ажилтны төлөөлөгчид нь аж ахуйн нэгж, байгууллагыг түр хааж / пикет / болно.

120.8. Ажил олгогч нь ажил хаях, ажлын байрыг түр хаах тухай хэрэглэгч, бэлтгэн нийлүүлэгч болон холбогдох бусад этгээдэд ажлын гурав, түүнээс дээш өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

120.9. Ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах, санал зөрүүтэй асуудлаар талуудад санал солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хуульд заасанаас бусад тохиолдолд хөндлөнгийн этгээд оролцохыг хориглоно.

120.10. Ажил хаялт үргэлжилж байх үед талууд хөдөлмөрийн хамтын маргааныг эвлэрүүлж зохицуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

120.11. Ажил хаялтыг зохион байгуулсан буюу ажлын байрыг түр хаасан тал эдгээр арга хэмжээг бэлтгэх болон үргэлжлэх хугацаанд ниймийн дэг журам, хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө хамгаалах арга хэмжээг холбогдох үүрэг бүхий төрийн байгууллагын туслалцаатайгаар авна.

121 дүгээр зүйл. Ажил хаялтыг удирдах эттээд, ажил хаялтыг түр зогсоох, сэргээх, ажил хаялт дуусгавар болох

121.1. Ажил хаялтыг ажилтны төлөөлөгчид удирдана.

121.2. Ажил хаялтыг удирдах эттээд ажилтны хурал хийх, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар ажил олгогчоос мэдээлэл авах, маргаантай асуудлаар дүгнэлт гаргахад мэргэжилтэн урьж оролцуулах эрхтэй.

121.3. Ажил хаялтыг удирдах эттээд нь ажил хаялтыг түр зогсоох эрхтэй.

121.4.Түр зогсоосон ажил хаялтыг сэргээхэд энэ хуулийн 116.1-д заасан зуучлагч, хөдөлмөрийн арбитраар дахин хэлэлцүүлэхгүй.

121.5.Ажил хаялтыг сэргээхээс ажлын гурван өдрийн өмнө ажил олгогчид энэ тухай мэдэгдэнэ.

121.6. Талууд хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэхэн тухай тохиролцоонд гарын үсэг зурснаар буюу ажил хаялтыг хууль бус гэж тооцсоноор ажил хаялт дуусгавар болно.

122 дугаар зүйл. Ажил хаяхыг хориглох, хойшлуулах, түр зогсоох

122.1. Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, ниймийн дэг журам сахихулах үүрэг бүхий байгууллагад ажил хаялт зохион байгуулахыг хориглоно.

122.2. Санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг зуучлагч, хөдөлмөрийн арбитр, шүүхээр шийдвэрлэх шатанд ажил хаяхыг хориглоно.

122.3. Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд шүүх 30 хүртэл хоногийн хугацаагаар ажил хаялтыг хойш луулах, ажил хаялт эхэлсэн бол мөн хугацаагаар түр зогсоох эрхтэй.

122.4. Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн тээвэр, олон улс, хот хоорондын болон хотын цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллага ажил хаях нь улс орны аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хохироохоор байвал Засгийн газар шүүхийн шийдвэр гарах хүртэл, гэхдээ 14 хүртэл хоногийн хугацаагаар уг ажил хаялтыг хойшлуулж болно.

123 дугаар зүйл. Ажил хаялт зохион байгуулсан, ажлын байр түр хаасныг хууль бус гэж тооцох

123.1. Хөдөлмөрийн хамтын маргааны улмаас зохион байгуулсан ажил хаялтыг дор дурдсан тохиолдолд хууль бус гэж үзнэ:

123.1.1. энэ хуулийн 119.1-д заасныг зөрчсөн;

123.1.2. энэ хуулийн 122.1 -д дурдсан байгууллагад ажил хаясан;

123.1.3. энэ хуулийн 18,19 дүгээр зүйлд заасан хамтын гэрээ, хэлэлцээрээр зохицуулах харилцаанд хамаарахгүй асуудлаар шаардлага тавьж ажил хаясан.

123.2. Ажил хаялт зохион байгуулсан, ажлын байр түр хаасныг хууль бус гэж үзэж байгаа тал энэ тухай хүсэлтээ шүүхэд гаргана.

123.3. Ажил хаялт зохион байгуулсан, ажлын байр түр хаасныг хууль бус гэж тооцох эсэх талаар шүүх шийдвэр гаргана.

123.4. Ажил хаялт зохион байгуулсан, ажлын байр түр хаасныг шүүх хууль бус гэж тооцсон шийдвэр гаргасан бол талууд уг үйл ажиллагаагаа нэн даруй зогсооно.

124 дүгээр зүйл. Ажилтны хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхтэй холбогдсон эрхийн баталгаа

124.1.Зуучлагч, хөдөлмөрийн арбитрчийг хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхэд оролцсон хугацаанд үндэсэн ажлаас нь чөлөөлж, дундаж цалин хөлстэй тэнцэх олговор олгоно.

124.2.Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхэд оролцсон ажилтны төлөөлөгчидийг хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх үед сахилгын шийтгэл ногдуулах, өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

124.3. Хууль бус гэж тооцогдогүй ажил хаялтад оролцсон ажилтныг хөдөлмөрийн сахилга зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

124.4. Ажил хаялтад оролцсон ажилтанд олговор олгохоор талууд хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх явцад тогтоож болно.

124.5.Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил, үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан буюу ажлын байрыг түр хаасныг шүүх хууль бус гэж тогтоосон тохиолдолд түүнд хамрагдсан ажилтанд дундаж цалин хөлстэй тэнцэх олговор олгоно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ГАНЦААРЧИЛСАН МАРГААН ЗОХИЦУУЛАЛТ

125 дугаар зүйл. Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх

125.1. Ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс, шүүх тус тусын харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

126 дугаар зүйл. Хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэх маргаан

126.1. Шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх дутам хянан шийдвэрлэнэ.

126.2. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмийг Засгийн газар батална.

127 дугаар зүйл. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг давж заалдах

127.1. Ажил олгогч буюу ажилтан нь хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл, түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих сум, дүүргийн шүүхэд давж заалдах эрхтэй.

128 дугаар зүйл. Шүүхээр хянан шийдвэрлэх маргаан

128.1.Дараахь маргааныг шүүхээр хянан шийдвэрлэнэ:

128.1.1. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг энэ хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу давж заалдсан гомдол;

128.1.2. ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдол;

128.1.3.ажилтнаас хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байхдаа аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл;

128.1.4. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үед эрүүл мэнд нь хохирсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажилтны нэхэмжлэл;

128.1.5. энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан асуудлаар гарсан маргаан;

128.1.6. иргэн хоорондын хөдөлмөрийн гэрээтэй холбогдон гарсан маргаан;

128.1.7. сахилгын шийтгэл буруу ногдуулсан тухай ажилтны гомдол;

128.1.8. хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хууль тогтоомж болон хамтын гэрээнд зааснаас дордуулсан тухай ажилтны нэхэмжлэл;

128.1.9.хөдөлмөрийн дотоод журам хууль тогтоомжид нийцээгүй тухай ажилтны нэхэмжлэл;

128.1.10.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчдын хооронд хөдөлмөрийн маргаан;

128.1.11.хууль тогтоомжоор шүүхэд харьяалуулсан бусад маргаан.

129 дүгээр зүйл.Маргааны талаар гомдол гаргах хугацаа

129.1. Хөдөлмөрийн гэрээний талууд энэ хуулийн 129.2-т зааснаас бусад тохиолдолд эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш гурван сарын дотор хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдлоо гаргах эрхтэй.

129.2. Ажилтан ажлаас бууруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай гомдлоо ажил олгогчийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шүүхэд гаргана.

129.3. Энэ зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн тохиолдолд шүүх уг хугацааг сэргээн тогтоож, хэргийг хянан шийдвэрлэж болно.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ, ХӨДӨЛМӨРИЙН САХИЛГА, ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГА

130 дугаар зүйл.Хөдөлмөрийн дотоод журам

130.1. Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчидтэй саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батална мөрдүүлнэ.

130.2. Хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тусгана.

130.3.Төрийн зохих байгууллагаас сахилгын түгэвч дүрэм батлан мөрдүүлж болно.

131 дүгээр зүйл.Хөдөлмөрийн сахилгын шийтгэл

131.1. Ажил олгогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч, эрх олгогдсон албан тушаалтан нь хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн ажилтанд дор дурдсан хэлбэрийн сахилгын шийтгэлийг шийдвэр гаргаж ногдуулна.

131.1.1. сануулах;

131.1.2. цалин хөлсийг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

131.1.3. ажлаас халах.

131.2. Сахилгын зөрчил гаргаснаас хойш зургаан сар, илрүүлснээс хойш нэг сарын дотор сахилгын шийтгэл ногдуулна.

131.3.Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй.

131.4. Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно.

132 дугаар зүйл.Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

132.1. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

132.2.Хохирлын хэмжээг учирсан шууд хохирлоор тодорхойлох бөгөөд орох байсан орлогыг түүнд оруулан тооцохгүй.

132.3. Туршилт, тохируулгын явцад гарсан зайлшгүй хохирлыг ажилтнаар төлүүлж болохгүй.

132.4. Ажил олгогч нь ажилтанд хариуцуулсан эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах шаардлагатай нөхцөлийг бүрдүүлээгүйгээс учирсан хохирлыг ажилтнаар төлүүлж болохгүй.

133 дугаар зүйл. Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага

133.1.Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилтан энэ хуулийн 135 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээх бөгөөд тэр нь уг ажилтны нэг сарын дундаж цалин хөлсөөс хэтэрч болохгүй.

134 дүгээр зүйл.Контрактаар хүлээлгэх эд хөрөнгийн хариуцлага

134.1.Контрактаар ажиллаж байгаа ажилтан нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруугаас ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлоо энэ хуулийн 135 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд зургаан сарын дундаж цалин хөлсөөс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан арилгах үүрэгтэй.

135 дугаар зүйл. Эд хөрөнгийн бүрэн хариуцлага

135.1. Ажилтан дор дурдсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ:

135.1.1. ажилтны хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг болохыг тогтоосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

135.1.2. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан ажилтан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид заасан;

135.1.3. дараа тайлан гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг эзүүлж төлөөгүй;

135.1.4. эд хариуцагч биш боловч эрхэлсэн ажилтай нь холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар олгосон ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн;

135.1.5. согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ байгууллагад хохирол учруулсан.

135.2. Зарим төрлийн эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ашиглан шамшигдуулсан, дутагдуулснаас байгууллагад учирсан хохирлыг төлүүлэх өөр журмыг гагцхүү хуулиар тогтоож болно.

135.3.Ажил олгогч нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болох ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ байгуулна.

135.4.Ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ байгуулаагүй болон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй бол түүнд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болохгүй.

136 дугаар зүйл.Байгууллагад учирсан хохирлын хэмжээг тодорхойлох

136.1. Байгууллагад учирсан хохирлын хэмжээг эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийн нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийн өртгөөс зохих нормоор бодсон элэгдэл, хорогдлыг хасаж, жинхэнэ гарсан алдагдлаар тооцно.

136.2. Эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ашиглан шамшигдуулсан, санаатайгаар устгасан, гэмтээсэн үед хохирлын хэмжээг тухайн үеийн зах зээлийн үнийн ханшаар тодорхойлно.

136.3. Хэд хэдэн ажилтны буруугаас учирсан хохирлын хэмжээг тэдгээрийн гэм буруугийн хэмжээ, эд хөрөнгийн хариуцлагын төрлийг харгалзан ажилтан тус бүрээр тодорхойлно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ҮДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

137 дугаар зүйл.Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо

137.1. Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн болон хяналтын байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн алба, сумын хөдөлмөрийн байцаагч /ажилтан/-аас бүрдэнэ.

137.2. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллага нь Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллага нь Засаг даргын удирдлагын дор ажилдана.

137.3. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь орон нутгийн байгууллагаа мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

137.4. Бүх шатны Засаг дарга бүрэн эрхийнхээ хэмжээнд хөдөлмөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

138 дугаар зүйл.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо

138.1. Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо /орон тооны бус/-г Засгийн газрын дэргэд байгуулж ажиллуулна.

138.2.Үндэсний хорооны гурван талын төлөөлөгчдийн тоо адил байна

138.3. Үндэсний хорооны дүрмийг ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн Засгийн газар батална.

138.4.Үндэсний хорооны дарга, дэд дарга, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд зургаан жилийн хугацаагаар батлах бөгөөд дэд даргыг гурван тал зөвшилцөж, аль нэг талын төлөөлөгчөөс хоёр жилийн хугацаагаар томилно.

138.5. Үндэсний хороо дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

138.5.1. хөдөлмөрийн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх, нийгмийн зөвшлийн гурван талт тогтолцоог хөгжүүлэх;

138.5.2. иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон эдийн засаг, нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд үүссэн хамтын маргааныг зохицуулах;

138.5.3.хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, эдийн засаг, нийгмийн бодлогын нийтлэг асуудлаар зөвлөлдөх;

138.5.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТ

139 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

139.1. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд дараахь эгтээд хяналт тавина:

139.1.1. улсын хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгуулагa, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ;

139.1.2. орон нутагт хөдөлмөрийн улсын хяналтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний хяналтын алба хэрэгжүүлнэ;

139.1.3. ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах болон төрийн бус байгуулагa, олон нийт нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд эрх хэмжээнийхээ дагуу олон нийтийн хяналт тавина.

140 дүгээр зүйл.Хөдөлмөрийн улсын хяналтын үйл ажиллагаа

140.1. Хөдөлмөрийн хяналтын улсын алба нь хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний, орон нутгийн алба, улсын байцаагч нь тухайн шатны Засаг даргын удирдлагын дор ажиллана.

140.2. Хөдөлмөрийн улсын хяналтын үйл ажиллагаа хөдөлмөрийн улсын хяналтын дүрмээр зохицуулна.

140.3.Хөдөлмөрийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

141 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

141.1. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бууруатай эгтээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

141.1.1. ажилтныг хууль бусаар албадан хөдөлмөрлүүлсэн албан тушаалтныг 5000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгуулагыг 100000-250000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.2. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг нуун дарагдуулсан албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгуулагыг 100000-250000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох;

141.1.3. хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, орлогоор, эмэгтэй, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварласан, ялгаварласан, давуу байдал тогтоосон, өргөнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлогтой холбоогүйгээр ажилтны эрх, эрх чөлөөг ялгаварласан бол албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгуулагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.4. тахир дутуу болон одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохоорүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй байгаа тохиолдолд уг шалтгааныг түүнийг ажилд авахаас татгалзсан албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгуулагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.5.энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг төлөөгүй аж ахуйн нэгж, байгуулагыг 50000-100000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох;

141.1.6.эмэгтэй болон насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил гүйцэтгүүлсэн, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд аваар өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг хэвийн бус нөхцөлтэй болон түүний ойуун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах ажлын байранд, эсүл амралтын өдөр, шөнө буюу илүү цагаар ажиллуулсан, ажилтныг энэ хуулийн 74 дүгээр зүйлийн заалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан албан тушаалтныг 15000-30000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох;

141.1.7. хөдөлмөрийн аюулгүй ажилагаа, эрүүл ахуйн журмыг сахин хангаагүй аж ахуйн нэгж, байгуулагыг 150000-250000 төгрөгөөр, энэ хуулийн 85 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүйгээр үйлдвэрлэх-лийн барилга байгууламжийг хамтран ээлжлэн аж ахуйн нэгж, байгуулагыг 50000-100000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч тус тус торгох;

141.1.8.хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хийх хэлэлцээнд оролцохоос зайлсхийсэн, хуга-цаанд нь эхлүүлээгүй, хамтын маргааныг зуучлагч болон хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлэхээс үндэслэлгүй татгалзсан албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.9. Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхэд оролцсон ажилтны ажлын байранд гаднаас ажилтан авч ажиллуулсан, хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх, хэлэлцээ хийхэд оролцсон ажилтны төлөөлөгчдөд энэ хуулиар хориглосон заалтыг зөрчиж сахилгын шийтгэлногдуулсан, ажлаас нь өөрчилсөн, халсан албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.10. хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах, санал зөрүүтэй асуудлаараа талуудаас санал солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хөндлөнгөөс оролцсон иргэн, албан тушаалтныг 5000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.11.хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажил гүйцэтгүүлсэн албан тушаалтныг 5000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох;

141.1.12.ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар цуцалсан албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.13.ажилтны цалин хөлсийг тогтоосон хугацаанд нь олгоогүй, саатуулсан болон ажилтны бууруу биш шалтгааналар гарсан сул зогсолтын олговрыг олгоогүй эсхүл түүнийг хуулиар тогтоосон хэмжээнээс доогуур тогтоож олгосон албан тушаалтныг 5000-15000 төгрөгөөр шүүгч торгох;

141.1.14.энэ хуулийн 122.1-д заасныг зөрчиж, ажил хаяхыг хориглосон байгууллагад ажил хаялт зохион байгуулсан иргэн, албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр шүүгч торгох.

141.2.Энэ хуулийн 141.1.6-д заасан үйлдлийн улмаас ажилтны эрүүл мэндэд гэм хор учирсан бол Иргэний хууль[1]-ийн гэм хорын тухай холбогдох заалтаар хохирлыг нөхөн төлүүлнэ.

141.3.Ажилтны цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгоогүй, саатуулсан нь нотлогдсон тохиолдолд хожимдуулсан хоног тутамд 0,3 хувийн алданги ажил олгогчид шүүх ногдуулж, ажилтанд олгоно.

142 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

142.1.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1- ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

[1] Иргэний хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 258;1995 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1; 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1991 оны 2 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэл үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны зургадугаар сарын 10* *№26 (105)*

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

217. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /1999-5-12-ны хууль/ 368

218. Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-5-12-ны хууль/ 368

219. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /1999-5-14-ний хууль/ 369

220. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-5-14-ний хууль/ 369

221. Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /1999-5-14-ний хууль/ 370

222. Протокол соёрхон батлах тухай /1999-5-28-ны хууль/ 370

223. Конвенци соёрхон батлах тухай /1999-5-28-ны хууль/ 370

224. Протокол соёрхон батлах тухай /1999-5-28-ны хууль/ 370

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

225. Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 30 371

226. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 31 371

227. Төрийн хянан шалгах байгуулагын чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 34 371

228. "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай" тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 35 372

229. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 36 372

Гурав. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

230. Үндсэн чиглэл батлах тухай Дугаар 69 372

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн ".. орлогын .." гэсний дараа "..нэмэгдсэн өртгийн .." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг "1/импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар;", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг "5/ус, рашаан ашигласны төлбөр;", мөн зүйлийн 4 дэх хэсгийн 11 дэх заалтыг "11/агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;", мөн хэсгийн 13 дахь заалтыг "13/байгалийн ургамал ашигласны төлбөр;", мөн хэсгийн 17 дахь заалтыг "17/ус, рашаан ашигласны төлбөр;" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 7, 10, 14 дэх заалтыг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.Монгол Улсад байнга болон түр оршин суугч татвар төлөгчийн энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 9, мөн хэсгийн 5 дахь заалтын "в"-д заасан орлогын жилийн дунд дарааҳь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулна:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь, хэмжээ
0-2400000	10 хувь
2400001-4800000	240000 төгрөг дээр 2400000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ
4800001, түүнээс дээш	720000 төгрөг дээр 4800000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 40 хувийг нэмнэ

2 дугаар зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 5 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 1 дэх хэсэг; 41 дүгээр зүйлд 2 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны талаар ажил олгогч нийтэд мэдээлж, иргэдийг сонгон шалгаруулах замаар ажилд авна.";

2/41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд иргэнийг ажилд авахад энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн албан тушаалтныг шүүгч 10000-30000 төгрөгөөр торгох бөгөөд уг зөрчлийг давтан үйлдэж торгуулбал түүнийг ажил, албан тушаалаас халах саналыг эрх бүхий этгээдэд тавина.".

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн "1","2","3","4","5" гэсэн дугаарыг "2","3","4","5", 6" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 149 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"149 дүгээр зүйл. Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй эх буюу ганц бие эцгийг аджлаас халах

Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй эх буюу ганц бие эцгийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан, хөдөлмөрийн сахилгын зөрчил давтан гаргасан, хөдөлмөрийн харилцаагүй шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан, мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдагдуулах буруутай үйлдэл, эс үйлдэл хийснээс бусад шалтгаанаар аджлаас халсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу жаран мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т дор дурдсан агуулгатай "н","о","п" заалт нэмсүгэй:

"н/ажлын цагийн үргэлжлэл, бүтээмж;

о/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого;

п/хөдөлмөрийн маргаан."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан "Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенци"-ийн нэмэлт, өөрчлөлт болох дараахь Протоколуудыг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлсугай:

1/Монреаль хотноо 1980 оны 10 дугаар сарын 6-ны өдөр гарын үсэг зурсан "Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол";

2/Монреаль хотноо 1984 оны 5 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан "Олон Улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол";

3/Монреаль хотноо 1990 оны 10 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан "Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн 50 дугаар зүйлийн а/хэсгийг өөрчлөх Протокол".

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монреаль хотноо 1991 оны 3 дугаар сарын 1-ний өдөр үйлдсэн "Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэглэл хийх тухай Конвенци"-ийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсныг соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн зөвшөөрсөн "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай Конвенци"-ийн нэмэлт болох Монреаль хотноо 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр үйлдсэн "Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай Протокол"-ыг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр | **Дугаар 30** | **Улаанбаатар хот**

Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл бупаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг дагалдуулан 1998 оны 2 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны улс төрийн албан тушаалтны нэмэгдэл амралтын хугацааг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тэдгээрт тусгасан асуудал нь шинээр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд зохицуулагдсан байх тул хэлэлцэх шаардла-гагүй гэж үзэж хууль санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр | **Дугаар 31** | **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөдөлмөрийн тухай хууль батлагдсантай холбогдуулан "БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай" Улсын Бага Хурлын 1991 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 1999 оны Хөдөлмөрийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 34** | **Улаанбаатар хот**

Төрийн хяналт шалгах байгууллагын чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн хяналт шалгах хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн хяналт шалгах байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, хяналт шалгалтын чанар, үр нөлөө, хяналт байцаагчдын нийгмийн баталгаа, мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, урамшууллын хөшүүрэг бий болгох зорилгоор хяналт шалгалтаар илрүүлж, барагдуулсан, хууль тогтоомжийн дагуу ногдуулах шимтгэл, хураамж, захиргааны шийтгэлээр ногдуулсан торгуулиас бусад төлбөрийн 20 хувийг төрийн хяналт шалгах байгууллагын мэдэлд үлдээж, түүнийг зарцуулах журмыг баталж мөрдүүлэхийг Төрийн хяналт шалгах хороо /Л.Жавзмаа/-нд зөвшөөрсүгэй.

2.Хяналт байцаагчийн тавьсан акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын данснаас уг төлбөрийг хураан барагдуулж, улс, орон нутгийн төсөвт оруулах болон холбогдох байгууллагыг хохиролгүй болгож байх эрхийг төрийн хяналт шалгах байгууллагад олгох асуудлыг хамтран боловсруулж шийдвэрлүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/, Монголбанк /Ж.Үнэнбат/-нд даалгасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 35** | **Улаанбаатар хот**

"Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай" тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаатай адилтгах албан тушаалын зэрэглэл"-д Төрийн хяналт шалгах хорооны даргын зэрэглэл "ТӨ-VA" байсныг "ТӨ-IVA" болгон өөрчилсүгэй.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 36** | **Улаанбаатар хот**

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрмааг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс, Улсын Их Хурлын гишүүн О.Энхтуяаг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн О.Энхтуяаг Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээр батлагдсугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | **Дугаар 69** | **Улаанбаатар хот**

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэл /1999-2000/"-ийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2.Үндсэн чиглэл батлагдсантай холбогдуулж орон тооны бус Дизайны зөвлөлийг байгуулж, тодорхой үе шаттай хөтөлбөр, төслийг шалгаруулах, түүний дагуу арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн сайд А.Баттөрд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

ГЭГЭЭРЛИЙН САЙД **А.БАТТӨР**

Засгийн газрын 1999 оны 69 дүгээр тогтоолын хавсралт

ДИЗАЙНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нэг. Үндэслэл

Хот суурин газар, ахуй орчноо тохижуулах, иргэдийн ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, хэрэглээний соёлыг нэмэгдүүлэх, гоо зүй, уран сайхны таашаалыг дээшлүүлэх асуудал өсөн нэмэгдэж байна. Эдгээрийг шийдвэрлэхэд дизайныг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, түүгээр уламжлан хүмүүсийн хандлага, төлөвшилд үзүүлэх нөлөөг дээшлүүлэх явдал чухал үүрэгтэй юм.

Үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, бараа болон үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах нь эдийн засгийн хөгжилд шийдвэр-лэх үүрэг гүйцэтгэгийг харгалзаж хот байгуулалт, амьдрах орчин, үйлдвэрлэл, сургалтыг хамарсан нэгдсэн бодлого, зохицуулалт бүхий дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан хэрэгжүүлэх нь хойшлуулшгүй чухал зорилт болж байна.

Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэл нь улс орны хөгжлийг харуулах барилга байгууламж, ахуй орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, уран бүтээлийг орчин үеийн өндөр шаардлагад нийцүүлэн бүтээн туурвихад шинжлэх ухаан, техникийн ололт, үндэсний уламжлалт болон олон улс орны урлахуйн ухааны шилдэг арга хэрэгслийг ашиглах, тэдгээрийг дэлгэрүүлэн түгээх, хойч ирээдүйдээ өвлүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Зорилго

Иргэдийн амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэх, хүн бүрийн дизайн, гоо зүйн боловсролыг дээшлүүлэхэд "Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн зорилго оршино.

Амьдралын бүхий л хүрээнд дизайныг нэвтрүүлэх нь:

1. Хот, суурин газрын өнгө төрхийг өвөрмөц байдлаар өөрчлөх;

2. Хүн бүр амьдрах, ажиллах орчноо тохилог, уран сайхнаар бүрдүүлэх;

3. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлснээр нийт бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

4. Иргэдийн соёл урлагийн талаархи мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, дэлхий дахины болон үндэсний дизайны ололт, арга ухаанд суралцах, орчин үеийн шилдэг арга хэрэгслийг ашиглан бүтээн туурвихад туслах зорилготой юм.

Гурав. Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэл

Монгол улсад дизайныг хөгжүүлэхэд дараахь үндсэн чиглэл баримтална:

1. Хот байгуулалтын хүрээнд архитектурын дизайны түвшинг дээшлүүлэх, гоо зүй, уран сайхны таашаалд нийцэхүйц үндэсний агуулгаар баяжуулах, байгалийн тэнцлийг хадгалсан, түүний үр өгөөжийг ашигласан, хүрээлэн буй орчныг иж бүрэн тохижуулсан, бат бөх барилга байгууламжуудыг бүтээн босгох;

2. Тохилог сайхан орчинд ажиллаж амьдрахын тулд дизайны бүх төрлийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, иргэн бүр идэвхтэй санаачлагч

байж, ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй орчинг бүрдүүлэх, ахуйн соёлоо дээшлүүлэх;

3. Үйлдвэрлэлийг хүрээлэн буй орчинтой нь зохицуулах, үйлдвэрлэлд үндэсний уламжлалт болон орчин үеийн тэргүүний технологийг ашиглах, хүний хөдөлмөрлөх нөхцөлийг бүхий л талаар сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанар, үзэмжийг дээшлүүлэх, нэр төрөл, хэв загварыг олшруулах, үйлдвэрлэл, үйлчилгээнд харилцааны соёлыг нэвтрүүлэх;

4. Иргэн бүрийн дизайны болон урлагийн боловсролыг нэмэгдүүлэх, төрөл бүрийн чиглэлээр дизайнерыг бэлтгэх, уран бүтээлчидийн авьяас чадварыг дээшлүүлэх, шилдэг уран бүтээлийг түүрвих нөхцөлийг бүрдүүлэх.

Дөрөв. Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Дизайныг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд хот байгуулалт, амьдрах, ажиллах орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалтын чиглэлээр дизайны уралдаан, үзэсгэлэн зохион байгуулах, бүтээл шагаруулах талаар журам боловсруулахын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд дараахь үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1. Хот байгуулалтын хүрээнд /Төрийн захиргааны төв байгууллагууд, хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн байгууллагуудад/:

- бүс нутаг, нийслэл хот, аймаг, сум, дагуул хотуудын архитектур, хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хөшөө дурсгал, хот чимэглэлийн бүтээлийн хамт цогц боловсруулах;

- шинээр барьж байгуулах иргэний үйлдвэрийн, нийтийн барилга байгууламжуудын байршилт, ач холбогдлыг харгалзан нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үндэсний уран барилгын өвөрмөц хэв загвартай төлөвлөх, тэдгээрийн төсөвт өртгийн 3-аас доошгүй хувийг чимэглэлийн дизайны бүтээлд зориулах;

- түүхийн дурсгалт болон одоо ашиглаж буй барилга байгууламжуудыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, ашиглах болон шинэчлэхдээ тэдгээрийн дизайн, чанарт онцгой анхаарах;

- монгол үндэсний орон сууцны "гэр" хорооллын ахуйн нөхцөлийг сайжруулах бодлогыг тодорхойлсон иж бүрэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

- хотын доторхи сул талбайг үр ашигтай хэлбэрээр тохижуулах /ногоон байгууламж, усан оргилуур г.м./;

- оршуулгын газрыг орчин цагийн газар ашиглалтын бодлого, үндэсний өвөрмөц онцлогтой хослуулан шийдэх;

- уран барилгын жижиг хийц болох машины зогсоол, автобусны буудал, шатахуун түгээгүүр, худалдаа, үйлчилгээний цэгүүдийг орчинтой нь уялдуулан өвөрмөц хэв загвар, онцлог таних тэмдэг,енгө, хэлбэрийн төгс зохиолтой төлөвлөх;

- гудамж, талбайн гэрэлтүүлэг, замын хөдөлгөөний гэрлэн дохио, тэмдэг, хот, аймаг, сум, дүүрэг, гудамж, талбай, байшингийн нэр, дугаарыг олон улсын жишигт нийцүүлж чанар, үзэмжтэй, бүх нийтэд ойлгомжтой дизайнаар шийдвэрлэж байрлуулах;

- автомашины зогсоол, галт тэрэг, нисэх онгоц, тээвэрийн буудлуудыг дэлхийн жишигт нийцүүлэн үндэсний онцлог хэв загвартай тохижуулах;

- хот, дүүргүүд дэх үйлчилгээний цогцолбор газруудыг нутаг дэвсгэрийн хүрээлэн

буй орчны онцлогт зохицуулан уран сайхнаар иж бүрэн шийдэх;

- иргэд чөлөөт цаг, амралтаа соёлтой, сонирхолтой өнгөрөөхөд зориулагдсан биеийн тамир, тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнг сонгомол загвар, зориулалтын бөгөөд шилмэл дизайнтай тоног төхөөрөмж бүхий цогц хэлбэрээр байгуулах;

- нийслэл хотын ойролцоох болон орон нутаг дахь улирлын чанартай аялал жуулчлал, амралт зугаалгын газруудыг тухайн байрлалын онцлог, байгалийн тэнцвэрийг хадгалсан, орон зайн оновчтой зохион байгуулалттай иж бүрэн тохижуулах.

2. Амьдрах орчны хүрээнд / Төрийн захиргааны төв байгууллагууд, нийслэл, аймаг, сум, дүүргийн засаг даргын тамгын газарт /:

- айл өрх, хүн бүр өөрийн таашаал сонирхолд нийцсэн тохилог сайхан орчинд амьдрахад туслах бүх төрлийн дизайны сурталчилгаа, сургалтыг боловсронгуй болгох;

- аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх бүр эзэмшлийн газраа тохижуулахдаа ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх;

- орон сууц, гэр хороллын доторхи зам, талбай, автомашины зогсоолыг хүмүүсийн амгалан тайван, аюулгүй байдалд зохицуулан үзэгдэх орчинг тооцоолон төлөвлөх;

- сургууль, цэцэрлэг, орон сууцны дэргэдэх хүүхдийн тоглоомын талбайг танин мэдэхүй, гоо сайхан, бие бялдрын хөгжил олгохуйц тоглоом хэрэгслээр тохижуулахдаа аюулгүй байдал, өнгө үзэмжид онцгой анхаарах;

- гэр хороллын цахилгаан, холбоо, ус, хог хаягдлыг ахуйн шаардлагын дагуу иж бүрэн шийдвэрлэх;

- гэрийн нөхцөлд болон нүүдлийн байдалд зохицохуйц ахуйн хэрэглээний эд зүйлсийн дизайныг сайжруулах талаар гарсан санаачилгыг тал бүрээр дэмжих, нийтэд түгээн дэлгэрүүлэх;

- санаачилга, идэвх зүтгэл гарган хүрээлэн бүй орчноо үлгэр жишээ үзэмжтэй сайхан тохижуулсан албан байгууллага, айл өрх, иргэдийг урамшуулж, туршлагыг бусдад нэвтрүүлэх / машины зогсоол, ногоон байгууламж, хүлэмж, цэцгийн мандал, хашаа, саравч, худаг, гэрэлтүүлэг г.м /;

- иргэдийн ахуйн болон хэрэглээний соёлыг дээшлүүлэхэд зориулсан дизайны төрөл бүрийн зөвлөмж, сургалтыг хэвлэл мэдээллээр түгээх;

- бүх төрлийн үйлчилгээний хүрээнд тэргүүний соёл, гоо сайхны мэдрэмж, уран сайхны таашаалыг бий болгох, хэвшүүлэх;

- хот суурин газар, гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн, барилга байшин, зам гүүрийн байгууламжийн тохижолтод монголын дурслэх уламгийн бүтээлээс өргөн хүрээтэй сурталчлах, уран бүтээлчдийн алдар нэрийг мөнхжүүлэх.

3. Үйлдвэрлэлийн хүрээнд / бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээг эрхлэгчдэд /:

- үйлдвэрлэлд мэдээллийн дизайн болон тэргүүний ололт, туршлага, хүрээлэх орчиндоо нийцсэн тоног төхөөрмжийг нэвтрүүлэх;

- хөдөлмөр хамгааллын талаархи шаардлагатай бүх арга хэмжээг авч тохирсон багаж, зориулалтын хувцаар хангахдаа өнгө, хийц, үзэмжийг анхаарах;

- нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангах түүхий эдийг дотооддоо боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

- үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг цэвэрлэх, дахин боловсруулалт хийх төхөөрөмжийг боловсронгуй болгох;

- үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага, чанар, үзэмж, хэв загвар

сав, баглаа боодлыг сайжруулах / хүнсний бүтээгдэхүүн, эм тариа, гоо сайхны бүтээгдэхүүний хэрэглэх заавар, хугацаа нарийн заасан, хэлбэр, жинд тохирсон янз бүрийн өвөрмөц хэв загвар бүхий битүүмжилсэн, хайрцаг, сав, уураар үйлдвэрлэх / ;

- мал, амьтан, ургамлын гаралтай болон байгалийн агуулгатай экомаркийн үндэсний өвөрмөц цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг улам боловсронгуй болгохын сацуу дэлхий нийтэд сурталчлах;

- үйлдвэрийн бүтээгдэхүүний хэв загвар, ур хийц, өнгө үзэмж, уран сайхныг улам бүр нэмэгдүүлэхэд мэргэжлийн уран бүтээлчдийг татан оролцуулах;

- гэрийн тавилга, дүрэмт хувцас, сургалтын материал, сурах бичиг, бэлэг дурсгал, гоёл чимэглэл зэрэг олноор үйлдвэрлэх бүтээгдэхүүний эх загварын уралдааныг нийт уран бүтээлчдийн дунд тогтмол зохион байгуулах замаар нэр төрөл, хэв загвар, ур хийцийг баяжуулах, шилдэг загваруудыг үйлдвэрлэлд нэн даруй нэвтрүүлж байх;

- шинэ бүтээгдэхүүн, шинэчилсэн болон шинээр зохиосон, боловсронгуй болгосон загвар хийцийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх санаачилгыг дэмжих, урамшуулах эдийн засгийн хөшүүрэг механизмыг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;

- монголын эртний болон орчин үеийн дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүдийг таниулах, сурталчлах үүднээс үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн зар сурталчилгаанд зохих журмын дагуу ашиглах.

4. Боловсролын үйлчилгээний хүрээнд / бүх шатны сургуулиуд, мэргэжлийн байгууллагууд, уран бүтээлчдэд / :

- бүх шатны сургуулиудад дизайны болон гоо зүйн сургалтыг үе шаттай явуулах хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний уламжлалт болон орчин үеийн технологийн ололтыг өргөн цар хүрээтэй тусгах;

- сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд дизайны анхны мэдэгдэхүүн олгох, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх;

- ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ахуйн дизайны чиглэлийг тусгаж, сургалтыг боловсронгуй болгох;

- дүрслэх урлаг, дизайны мэргэжлийн анхан, дунд, дээд шатны боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрийг дизайныг хөгжүүлэх үндэсн чиглэлтэй нягт уялдуулах, түүний тодорхой заалтуудаас хэрэгжүүлэхэд оюутны хичээл болон курс, дипломын ажлыг чиглүүлэх;

- дизайны сургалтыг бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох үндэсний хөтөлбөртэй уялдаатай хэрэгжүүлэх;

- мэргэжлийн сургуулиудын дизайны багш нарын болон уран бүтээлчдийн мэргэжлийг дээшлүүлэх, олон улсын зөвлөлгөөн, уралдаан, үзэсгэлэнд оролцоход тал бүрийн дэмжлэг үзүүлэх;

- дизайнеруудийн ажлын уялдаа холбоог сайжруулах, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, хамтарсан сургалт, семинар, уулзалт, зөвлөлгөөн, туршлага солилцох үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй зохион байгуулах;

- дизайны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс мэдээллийн дизайныг шуурхай нэвтрүүлэх, тэдгээр хилийн чанадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллахад тал бүрийн дэмжлэг үзүүлэх;

- эртний болон орчин цагийн монгол үндэсний дахин давтагдашгүй дизайны сэтгэлгээ, арга ухаан, ололт амжилтын үзүүлэлттэй зохиогчийн эрхэд хамаарах бүтээлүүдийг улсын санд бүртгэн авч хамгаалах, сурталчлах, өөрийн оронд болон олон улсын хэмжээнд зохиогчийн эрх олгох.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

албан ажлын хэрэгцээнд
хомын санд

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны зургадугаар сарын 16 №27 (106)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

231. Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / 1999-5-21-ний хууль/ 377

232. Патентийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / 1999-5-21-ний хууль/ 379

233. Далай ашиглах тухай /1999-5-28-ны хууль / 382

234. Иргэний хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 386

235. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 386

236. Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 386

237. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 386

238. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 387

239. Галын аюулгүй байдлын тухай / 1999-5-28-ны хууль / 387

240. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 394

241. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 394

242. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 394

243. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай / 1999-5-28-ны хууль / 394

244. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 395

245. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай / 1999-5-28-ны хууль / 395

246. Гаалийн тарифын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай /1999-6-3-ны хууль/ 395

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

247. Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай Дугаар 27 396

248. Комисс байгуулах тухай Дугаар 39 404

249. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 40 404

250. Прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэх тухай Дугаар 41 404

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 6^1 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5/Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нэгдэн орсон бусад улсын иргэн, хуулийн этгээд болон харьяалалгүй хүн."

2/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

"13/оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах."

3/ 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална."

4/ 6^1 дугаар зүйл:

"6^1 дугаар зүйл.Хамтын удирдлагын байгууллага

1.Зохиогч, уран бүтээлчид эрхээ хамгаалуулах зорилгоор төрийн бус байгууллага болох Хамтын удирдлагын байгууллага байгуулж болно.

2.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа Оюуны өмчийн газартай гэрээ байгуулж ажиллана. Хамтын удирдлагын байгууллага, Оюуны өмчийн газар хамтран ажиллах жүрмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3.Хамтын удирдлагын байгууллага нь өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах талаар дараахь үйл ажиллагаа явуулах эрхтэй:

1/бүтээлийг нь ашиглуулах талаар гишүүдтэй гэрээ байгуулах;

2/бүтээл ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гишүүний нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

3/Оюуны өмчийн газартай хамтарч бүтээл ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох;

4/бүтээл ашиглуулсны төлбөр хураах, гишүүдэд хуваарилах;

5/гишүүдийн бүтээлийг хууль бусаар ашигласан тухай мэдээллийн дагуу Оюуны өмчийн газартай хамтарч шалгалт хийх, холбогдох арга хэмжээ авах.

4.Хамтын удирдлагын байгууллага нь гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулснаас олсон орлогын 10 хувийг Оюуны өмчийн газарт үлдээнэ."

5/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5/төлбөртэй ашиглуулах. Зохиогч бүтээлээ бусдад төлбөртэй ашиглуулах онцгой эрхтэй."

6/ 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Гэрэл зургийн болон хавсарга урлагийн бүтээлийн хамгаалалтын хугацаа бүтээл туурвисан өдрөөс хойш 25 жил байна."

7/ 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Энэ зүйлд заасан дуу авиа, дүрс бичлэгийн хамгаалалтад дор дурдсан зүйл хамаарна:

1/Монгол Улсын иргэний үйлдвэрлэсэн дуу авиа, дүрс бичлэг;

2/Монгол Улсад анх үйлдвэрлэгдсэн дуу авиа, дүрс бичлэг;

3/Монгол Улсад анх нийтийн хүртээл болгосон дуу авиа, дүрс бичлэг."

8/ 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Энэ зүйлд заасан радио, телевизийн нэвтрүүлгийн хамгаалалтад дор дурдсан зүйл хамаарна:

1/төв байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрладаг радио, телевизийн байгууллагын нэвтрүүлэг;

2/Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрладаг дамжуулагчаас дамжуулсан радио, телевизийн нэвтрүүлэг."

2 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12 дахь заалт, мөн зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12 дахь заалт:

"11/өөрийн зорилго, бүтээц, агуулгаараа оюуны бүтээл болох лавлах, толь бичиг, зохиолын цоморлиг, бусад мэдээллийн сангийн эмхтгэл. Ингэхдээ тэдгээрийг агуулж байгаа эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй;

12/урьд туурвисан бүтээлийг ашиглан түүний үндсэн дээр бий болгосон хялбаршуулсан бичвэр, орчуулга, хөгжмийн болон урлагийн бусад бүтээлийн зохиомж, най-

руулга зэрэг үүсмэл бүтээл."

2/ 3 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

"2.Дараахь зүйлийг зохиогчийн эрхийн бүтээлд тооцохгүй:

1/хууль тогтоомж, эрх зүйн бусад акт;

2/шүүхийн шийдвэр, албан ёсны баримт бичиг;

3/шүүх хуралдаан болон улс төрийн хурал, цуглаанд хэлсэн үг;

4/энэ хэсгийн 1, 2, 3 дахь заалтад заасан баримт бичгийн орчуулга;

5/тоо, баримт бухий сонордуулгын шинжтэй аливаа мэдээ;

6/аливаа санаа, арга ажиллагаа, ажлын арга барил буюу математикийн үзэл баримтлал.

3.Ардын урлагийн бүтээлд тулгуурлан бүтээсэн, өөрчлөн сайжруулсан, үзүүлбэр болгон тоглосон, эмхэтгэсэн, кино, дуу авиа, дүрс бичлэг болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх нь энэ хуулиар хамгаалагдана.

4.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл нь туурвисан өдрөөс эхлэн хамгаалагдах бөгөөд зохиогч хүсвэл өөрийн бүтээл, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх гэрээ, хэлцлийг Оюуны өмчийн газарт бүртгүүлж болно."

3/ 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Албан үүргээ гүйцэтгэх журмаар бүтээл туурвисан зохиогч тухайн байгууллагатай хийсэн гэрээнд өөрөөр заагаагүй бол уг бүтээлийн зохиогчийн эрхийг эдэлнэ."

4/ 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Бүтээлийн хэвийн ашиглалтыг зөрчих-гүйгээр, түүнчлэн зохиогчийн эрх, эзэмшигчийн хууль ёсны эрхийг хөндөхгүй-гээр түүнийг хуулбарлаж болно."

5/ 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

"1.Энэ хуулийн уран бүтээлчид холбогдох заалт нь дараахь хүмүүст хамаарна:

1/Монгол Улсын иргэн-уран бүтээлч: дуучин, жүжигчин, циркчин, удирдаач, бүжигчин, уран уншигч, хөгжимчин;

2/тоглолт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болж байгаа, энэ хуулиар хамгаалагдсан дуу авианы бичлэгт бичигдэн, дуу авианы бичлэгт бичигдээгүй боловч энэ хуулиар хамгаалагдсан радио, телевизийн нэвтрүүлэгт орсон гадаадын иргэн буюу харьяалалгүй хүн.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан уран бүтээлч бүтээлийнхээ хувьд дараахь эрх эдэлнэ:

1/нэр хэрэглэх буюу нэрээ дурдуулах;

2/бүтээл нь халдашгүй байх;

3/бүтээлээ гэрээний үндсэн дээр аливаа арга хэлбэрээр бусдад ашиглуулах, түүний төлөө үнэ хөлс авах;

4/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх;

5/өөрийн бүтээл /тоглолт/-ийг бичлэгт буулгах, уг бичлэгийг бусад этгээд олшруулахад зөвшөөрөл олгох;

6/өөрийн бүтээл /тоглолт/-ийг нийтэд танилцуулах зорилгоор нэвтрүүлэх зөвшөөрөл олгох."

6/ 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Уран бүтээлч, дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зохиогчийн эрхийг хамгаалах хугацаа нь бичлэг хийгдсэн өдрөөс, эсхүл тоглолт болсон өдрөөс хойш 50 жил байна."

7/ 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч иргэнийг 5000 хүртэл **төгрөгөөр**, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 хүртэл төгрөгөөр торгох, шүүгч иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл **төгрөгөөр** торгох, эсхүл гэм буруутай иргэн, албан тушаалтныг 7-14 хүртэл хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, зохиогчийн эрх зөрчсөн бүтээлийг хураана."

3 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн тавдугаар бүлгийн нэрийг "Уран бүтээлч, дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч, радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрх" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 3 дугаар **зүйлийн** 1 дэх хэсгийн "чансаа" гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар **зүйлийн** 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Патентийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 3 дугаар зүйлийн 9, 10, 11 дэх заалт, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт догол мөр, мөн зүйлийн 4 дэх хэсэгт догол мөр, мөн зүйлийн 9, 10 дахь хэсэг, 6[1] дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт догол мөр, мөн зүйлийн 8 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 9, 10, 11 дэх заалт:

"9/"патент үзэмшигч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашиглай загварын гэрчилгээ, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийг;

10/"Монгол Улсын олон улсын гэрээ" гэж Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц /1883/ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Бүтээгдэхүүний загварыг олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр /1960/, Патентийн хамтын ажиллагааны гэрээ /1970/, Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр/1994/-ийг;

11/"Патентийн хамтын ажиллагааны гэрээнд нийцсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг" гэж конвенцийн давамгайлах огноо бүхий Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загвар, мэдүүлгийг тус тус ойлгоно."

2/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт:

"15/оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах."

3/ 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн догол мөр:

"Шинэ бүтээлийн тодорхойлолт нь шинэ бүтээлээр дэвшүүлсэн зорилгод хүрэхэд тухайн шийдлийн урьдах техникийн түвшингээс онцгой ялгарах шинж чанарыг илүүлж, шийдлийн хамаарах салбарын мэргэжлийн хэрэглэгчдэд түүний давуу байдал болон шинэ бүтээлийг ашиглах аргыг хангалттай, бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулна.

Шинэ бүтээлийн томъёолол нь тухайн шинэ бүтээлийн онцгой ялгарах шинж чанарыг илүүлэн гаргаж, эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон бөгөөд ойлгомжтой, товч, тодорхой байна. Нэг шинэ бүтээл нь нэг буюу хэд хэдэн томъёололтой байж болно.

Тодорхойлолт, зураг нь томъёоллын агуулгыг дэлгэрэнгүй тайлбарлана.

Товч тайлбар нь зөвхөн техникийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд түүнийг шинэ бүтээлийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтооход ашиглахгүй."

4/ 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн догол мөр:

"Бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг мэдүүлэг гаргагч Оюуны өмчийн газарт гаргана."

5/ 6 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэг:

"9.Олон улсын нэг ангиладд хамаарах адил төстэй 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

10.Мэдүүлэг гаргагч мэдүүлгийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд мэдүүлгээ бүцаан авч болно."

6/ 6[1] дугаар зүйл:

"6[1] дугаар зүйл.Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

1.Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын бүртгэлийн огноогоор тогтооно.

2.Монгол Улсын иргэн буюу Монгол Улсад оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний гаргасан олон улсын мэдүүлгийн хувьд Оюуны өмчийн газар буюу Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага нь хүлээн авагч байгууллага болно.

3.Хүлээн авагч байгууллага олон улсын мэдүүлгийг гэрээнд заасан хэл дээр хүлээн авч, хураамж авна.

4.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авахаар Монгол Улсын нэрийг заасан бол Оюуны өмчийн газар нь нэр заагдсан байгууллага болно.

5.Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтээ олон улсын урьдчилсан магадлан

шүүлт хийлгэхээр Монгол Улсыг сонгосон бол Оюуны өмчийн газар сонгогдсон байгууллага болно.

6.Сонгогдсон байгууллага нь мэдүүлэгт хийх урьдчилсан магадлан шүүлтийн тайланг гэрээнд заасан хугацаанд хүлээж авна.

7.Монгол Улсыг сонгосон олон улсын мэдүүлгийн хувьд мэдүүлэг гаргагч Патентийн хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу урьдчилсан магадлан шүүлтийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хураамж төлнө.

8.Оюуны өмчийн газар олон улсын мэдүүлэгт хийгдэх бүх үйл ажиллагааг зохих гэрээ, журам, зааврын дагуу гүйцэтгэнэ."

7/ 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн догол мөр:

"Шинэ бүтээлээр дэвшүүлсэн шийдлийн мэдүүлгийг эцсийн шийдвэр гарахаас өмнө ашигтай загварын гэрчилгээ авах мэдүүлэг болгон, ашигтай загварын гэрчилгээ хүссэн мэдүүлгийг шинэ бүтээлийн мэдүүлэг болгон тус тус хөрвүүлж болох бөгөөд анхдагч огноог анхны мэдүүлгээр хадгална."

8/ 10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"8.Мэдүүлж буй бүтээгдэхүүний загвар урьд танил болсон загварууд буюу тэдгээрийн онцлог шинжийн нэгдлээс мэдэгдэхүйц ялгарахгүй бол уг загварыг шинэ ба эх загвар гэж үзэхгүй."

9/ 19 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

"8.Лицензийн гэрээг шударга өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн нөхцөлтэйгээр байгуулж болохгүй."

10/ 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Лиценз албадан хэрэглэх тухай гэрээ хийх нөхцөлд патент бүхий бүтээл ашигласны төлбөрийг лиценз авагч тал патент эзэмшигчид төлнө."

2 дугаар зүйл.Патентийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "патент эзэмших эрхийг" гэсний дараа "патент эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндэсн дээр"; 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн эхэнд "Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Патентийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3, 5 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 6 дахь заалт, 7, 9, 11, 13, 16 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3 дахь заалт:

"3/"ашигтай загвар" гэж аливаа үйлдвэрлэлийн арга, хэрэгсэл, бүтээгдэхүүн, тэдгээрийн үндсэн хэсэг, зохион байгуулалтад хамаарах, шинэ, үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой ашигтай шийдлийг;"

2/ 3 дугаар зүйлийн 5 дахь заалт:

"5/"ашигтай загварын гэрчилгээ" гэж ашигтай загварыг улсын бүртгэлд бүртгэн авч, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож буй баримт бичгийг;"

3/ 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 6 дахь заалт:

"6/бичил биетээс өөр амьтан, ургамал болон тэдгээрийг гаргаж авах биологийн арга. Үүнд биологийн бус ба микробиологийн үйл ажиллагаа хамаарахгүй."

4/ 7 дугаар зүйл:

"7 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэг гаргах

1.Ашигтай загварын мэдүүлгийг зохиогч болон түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд Оюуны өмчийн газарт гаргана. Мэдүүлэг нь өргөдөл, тодорхойлолт, томъёолол, тайлбарлах зургаас бүрдэнэ. Ашигтай загварын томъёолол нь уг шийдлийн ялгарах шинжийг тодорхойлж, эрхийн хамгаалалтын хүрээг тогтооно.

2.Мэдүүлэг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй, эсхүл мэдүүлэг гаргагч нь ашигтай загварын хууль ёсны зохиогч, өв залгамжлагч биш байвал түхайн ашигтай загварыг бүртгэхгүй."

5/ 9 дүгээр зүйл:

"9 дүгээр зүйл.Ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

Ашигтай загварын бүрдэл хангасан мэдүүлгийг Оюуны өмчийн газарт хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтооно."

6/ 11 дүгээр зүйл:

"11 дүгээр зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх

1.Мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 1 сарын дотор ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой эсэхэд шинжээч магадлан шүүлт хийж дүгнэлт гаргана.

2.Дараахь тохиолдолд ашигтай загвараар бүртгэж гэрчилгээ олгохгүй:

1/ашигтай загварыг бүртгэхээс өмнө Монгол Улсад тухайн шийдэл нийтэд илэрхий болсон;

2/ашигтай загварыг бүртгэхээс өмнө Монгол Улсад тухайн шийдэл нэвтэрч ашиглагдсан;

3/ урьд нь үндэсний болон гадаадын хэвлэлд нийтлэгдсэн."

7/ 13 дугаар зүйл:

"13 дугаар зүйл.Ашигтай загварын гэрчилгээ олгох

Ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан өдрөөс хойш 1 сарын дотор Оюуны өмчийн газар ашигтай загварын гэрчилгээ олгоно."

8/ 16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл.Ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрх

1.Ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч дараахь эрх эдэлнэ:

1/ашигтай загвараа өмчлөх, эзэмших, ашиглах;

2/ашигтай загварыг бусдад төлбөртэйгээр ашиглуулах.

2.Ашигтай загварын гэрчилгээг хэд хэдэн этгээд хамтран эзэмшиж байгаа нөхцөлд өмчлөх эрхийг хамтран эдэлнэ."

9/ 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Лицензийн гэрээ нь гуравдагч этгээдийн ашиг сонирхолд харшлахгүй байх бөгөөд гэрээний талууд гэрээний нууцыг чанд хадгална."

10/ 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/лицензийн гэрээгээр патент бүхий бүтээлийг ашиглаж байгаа байдал нь шударга бус өрсөлдөөний шинжийг агуулсан гэж патент эзэмшигч үзвэл."

11/ 21 дүгээр зүйл:

"21 дүгээр зүйл.Ашигтай загварыг ашиглах

1.Ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч тухайн бүтээлийг бусдад ашиглуулахдаа гэрээ байгуулна.

2.Гэрээнд бүтээл ашиглах нөхцөл, хүрээ, хугацаа, төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журам зэргийг тусгана."

12/ 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч өөрчлөгдөхөд энэ тухай бичгээр Оюуны өмчийн газарт мэдэгдэх ба энэ өөрчлөлт нь гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөхгүй."

13/ 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Патентийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч иргэнийг 5000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 хүртэл төгрөгөөр торгох, шүүгч иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл гэм буруутай иргэн, албан тушаалтныг 7-14 хүртэл хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгон, тухайн барааг устгаж, үйлдвэрлэлийг зогсооно."

4 дүгээр зүйл.Патентийн тухай хуулийн "оновчтой санал" гэснийг "ашигтай загвар"; 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "товч мэдээлэл" гэснийг "томъёолол"; мөн зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг

"Парисын конвенцийн болон Дэлхийн худалдааны байгууллагын аль нэг гишүүн оронд давамгайлах огноо хүсэж гаргасан мэдүүлгийн хуулбарыг Оюуны өмчийн газрын хүсэлтэрж хавсаргана"; 14 дүгээр зүйлийн "оновчтой саналын гэрчилгээ 5 жилийн" гэснийг "ашигтай загварын гэрчилгээ 7 жилийн" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Патентийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын "тус тус ойлгоно"; 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ", бүтээгдэхүүний загвар" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Патентийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн сүүлчийн догол мөр, 19 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж

2.1.Далай ашиглах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжид өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйлчилнэ.

3.2.Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцон дээр зөвхөн Монгол Улсын хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."хөлөг онгоц" гэж далай ашиглах үйл ажиллагаа явуулахад зориулагдсан хөдөлгүүртэй буюу хөдөлгүүргүй инженерийн хөвөгч байгууламжийг;

4.1.2."бүртгэлийн боомт" гэж Монгол Улсын хөлөг онгоцыг бүртгэх байгууллагыг;

4.1.3."гарц боомт" гэж далай ашиглах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн түрээсэлсэн далайн боомтын зогсоолыг;

4.1.4."Олон Улсын Регистр" гэж бүх төрлийн хөлөг онгоцыг барих, барихад хэрэглэх материал, хөлөг онгоцны тоног төхөөрөмж, түүнчлэн галын аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, бусад хэрэгслээр тоноглох журмыг боловсруулан гаргаж, хөлөг онгоцны зураг төсөл зохиох, барих, ашиглах явцад тэдгээрийн мөрдөлтөд хяналт тавих үүрэг бүхий олон улсын байгууллагыг;

4.1.5."хөвөлтөд тохирсон" гэж тухайн төрөл, зориулалтын хөлөг онгоц экологи, аюулгүйн болон техникийн дүрмийн шаардлага хангасан, аюулгүй аялахад зайлшгүй шаардлагатай бүрэн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг, бүх төрлийн нөөц, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдлыг;

4.1.6."нийтлэг осол" гэж байгалийн онцгой аюул, давагдашгүй хүчин зүйлийн улмаас хөлөг онгоц, түүний ачаанд учирсан аюулыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Далай ашиглах үйл ажиллагаа

5 дугаар зүйл. Далайн баялаг олборлох, загас агнах

5.1.Хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах үйл ажиллагаат олон улсын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

6 дугаар зүйл. Далайд тээвэр хийх

6.1.Хөлөг онгоцоор тээвэр хийх асуудлыг Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.

7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх

7.1.Хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл. Далай ашиглах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн үүрэг

8.1.Аж ахуйн нэгж нь далай ашиглах үйл ажиллагааг олон улсын гэрээгээр тогтоосон хэм хэмжээ, хязгаарын дотор явуулна.

8.2.Далай ашиглах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь дараахь үүрэг хүлээнэ:

8.2.1.хөлөг онгоцны техникийн бүрэн бүтэн байдлыг мэргэжлийн байгууллагаар хянуулах;

8.2.2.хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авах;

8.2.3.хөлөг онгоцыг зориулалтаар нь ашиглах;

8.2.4.багийн бүрэлдэхүүнийг олон улсын зохих конвенцид нийцүүлэн бүрдүүлэх, ахмадыг томилох, чөлөөлөх;

8.2.5.ахмадын зөвшөөрлөөр хөлөг онгоны багийн бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, чөлөөлөх;

8.2.6.хөлөг онгоны аюулгүй байдлыг хангах зорилгоор боомтын мэргэжлийн байгууллагатай тохиролцон шаардлагатай үед далайн газарчинг ажиллуулах.

8.3.Далай ашиглах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь гарц боомтын мэргэжлийн байгууллагаар дараахь хяналтын үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ:

8.3.1.багийн бүрэлдэхүүний тоо тухайн төрөл, зориулалтын хөлөг онгоцонд тогтоосон доод хэмжээнээс цөөнгүй бөгөөд бүх төрлийн нөөц байгаа эсэх;

8.3.2.хөлөг онгоны баримт бичиг, багийн бүрэлдэхүүний диплом, мэргэжлийн гэрчилгээ, далайчны үнэмлэхийг олон улсын зохих конвенцийн шаардлагын дагуу бүрдүүлсэн эсэх;

8.3.3.хөлөг онгоны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал олон улсын зохих конвенцийн шаардлагад нийцсэн эсэх;

8.3.4.хөлөг онгоны холбооны тоног төхөөрөмж олон улсын зохих конвенцийн шаардлагад нийцсэн эсэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөлөг онгоны бүртгэл

9 дүгээр зүйл. Хөлөг онгоны бүртгэлийн боомтын байршил

9.1.Монгол Улсын хөлөг онгоны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хотод байна.

9.2.Монгол Улсын хөлөг онгоны бүртгэлийн боомт байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

9.3.Хөлөг онгоц бүртгэх журмыг Засгийн газар тогтооно.

10 дугаар зүйл. Бүртгэлийн боомтын бүрэн эрх

10.1.Монгол Улсын хөлөг онгоны бүртгэлийн боомт нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоны бүртгэлд бүртгэх, тухайн хөлөг онгоцон дээр Монгол Улсын төрийн далбааг мандуулан хөвөх эрхийн гэрчилгээ олгох, бүртгэлээс хасах;

10.1.2.хөлөг онгоны бүх төрлийн гэрчилгээ, үнэмлэх, бусад баримт бичгийн загвар боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

10.1.3.олон улсын зохих конвенцид нийцүүлэн хөлөг онгоотой холбоо барих олон улсын дохиолол ашиглах асуудлыг зохицуулах;

10.1.4.хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах боловсон хүчний ойрын болон хэтийн хэрэгцээг тодорхойлох, түүнийг олон улсын зохих конвенцид нийцүүлэн бэлтгэх ажлыг зохион байгуулах;

10.1.5.олон улсын зохих конвенцид нийцүүлэн хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүний эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлд тавих шаардлагыг боловсруулж мөрдүүлэх;

10.1.6.хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүний мөрдөх сахилгын дүрмийг батлах.

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл

11.1.Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл нээлттэй байна.

11.2.Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлэх хөлөг онгоц нь Олон Улсын Регистрийн шаардлага хангасан байна.

11.3.Энэ зүйлийн 11.1-д заасны дагуу бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

11.4.Хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан, ашиглалтаас хассан, өөр улсад шилжүүлсэн, сүүлчийн удаа холбоо тогтоосон өдрөөс хойш гурван сар дайн, эзвэсэгт мөргөлдөөн болж буй бүсэд зургаан сараас дээш хугацаагаар сураггүй алга болсон тохиолдолд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хасна.

12 дугаар зүйл. Хөлөг онгоцон дээр Монгол Улсын Төрийн далбаа мандуулах

12.1.Тухайн хөлөг онгоц Монгол Улсад харьяалагдаж буйг тодорхойлох бэлгэ тэмдэг нь Монгол Улсын Төрийн далбаа байна.

12.2.Монгол Улсын Төрийн далбаа мандуулах эрхийг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц эдэлнэ.

12.3. Хөлөг онгоцон дээр Төрийн бэлгэ тэмдгийн тухай[2] хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Төрийн далбааг мандуулах ба дүрсэлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Хөлөг онгоц, түүний баг

13 дугаар зүйл. Хөлөг онгоц

13.1.Хөлөг онгоц нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, тээвэрлэх ачааны бүрэн бүтэн байдлыг хадгалах, далайн усыг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

13.2.Далайн аялалд зөвхөн хөвөлтөд тохирсон хөлөг онгоц гарна.

14 дүгээр зүйл. Хөлөг онгоцны баг

14.1.Хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд мэргэшлийн өндөр чадвар, бэлтгэлтэй, эрүүл мэндээр тэнцэх Монгол Улсын иргэн буюу гадаад улсын иргэн, харьяалагүй хүнийг олон улсын зохих конвенцид нийцүүлэн гэрээгээр ажиллуулна.

15 дугаар зүйл. Хөлөг онгоцны ахмад, түүний үүрэг, эрх

15.1.Хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнийг ахмад удирдана.

15.2.Ахмад нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг хамгаалах, хөлөг онгоцон дээрх ачааны аюулгүй ба бүрэн бүтэн байдлыг хадгалах үүрэгтэй.

15.3.Ахмад нь багийн бүрэлдэхүүнийг урамшуулах, сахилгын дүрмийн дагуу арга хэмжээ авах эрхтэй.

[2] Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 116, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 6 дугаарт тус тус нийтлэгдсэн.

16 дугаар зүйл. Хөлөг онгоцонд аюул учрах

16.1.Ахмад нь багийн бүрэлдэхүүн болон зорчигчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хөлөг онгоц ба түүн дээрх ачаанд учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгахад шаардлагатай арга хэмжээ авна.

16.2.Ахмад нь аюул осол учирсан үед хөдөлмөрийн чадвартай зорчигчийг дайчлах, зорчигчийн эд хөрөнгө, хөлөг онгоцон дээрх ачааг зохицуулна.

16.3.Аюул ослын улмаас хөлөг онгоцон дээрх ачаа, эд хөрөнгөд учирсан хохирлыг олон улсын хууль тогтоомжид заасан нийтлэг ослын дүрмийн дагуу нөхөн төлнө.

17 дугаар зүйл. Далайн мэдэгдэл гаргах

17.1.Хөлөг онгоц далайд аялах, боомтод зогсох үед байгалийн болон техникийн аюул ослын улмаас үүссэн нөхцөл байдал нь хөлөг онгоц эзэмшигч эд хөрөнгийн нэхэмжлэл гаргах үндэслэл болохоор байвал ахмад нь хөлөг онгоц эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор уг боомтын тогтоосон журмын дагуу өөрийн улсын консулд буюу тухайн улсын эрх бүхий албан тушаалтанд далайн мэдэгдэл гаргаж болно.

17.2.Далайн мэдэгдэлд аюул ослын нөхцөл байдал, итгэмжлэгдсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах талаар ахмадын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан байвал зохино.

18 дугаар зүйл. Тусламж үзүүлэх

18.1.Аялалын үед тусламж хүссэн тухай мэдээг хүлээн авмагц ахмад өөрийн хөлөг онгоцны дээд хурдаар хүрэлцэн очиж, шаардлагатай тусламж үзүүлэх, аврах ажиллагаа явуулах үүрэгтэй.

18.2.Хөлөг онгоц мөргөлдсөн тохиолдолд боломжтой бол хөлөг онгоцны ахмадууд харилцан тусалцах аргыг хамтран тодорхойлж, болодцоотой бүх арга, хэрэгслээр бие биедээ тусламж үзүүлэх үүрэгтэй.

18.3.Хөлөг онгоц мөргөлдсөний улмаас болон түүнийг аврах ажиллагааны үед учирсан эд хөрөнгийн хохирлыг олон улсын хууль тогтоомжид заасан нийтлэг ослын дүрмийн дагуу нөхөн төлнө.

19 дүгээр зүйл. Хөлөг онгоцыг орхих

19.1.Хөлөг онгоц сүйрэх нь гарцаагүй болсон тохиолдолд ахмад нь зорчигч, багийн бүрэлдэхүүнийг аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, хөлөг онгоцыг орхих шийдвэр гаргана.

19.2.Ахмад нь зорчигч, багийн бүрэлдэхүүн хөлөг онгоцыг орхисны дараа хөлөг онгоцны баримт бичгийг авч, хамгийн сүүлд хөлөг онгоцыг орхино.

20 дугаар зүйл. Хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарах

20.1.Хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарсан тохиолдолд ахмад нь хэрэг бүртгэх ажилла-гааг гүйцэтгэнэ.

21 дүгээр зүйл. Хөлөг онгоцон дээр хүн төрөх, нас барах

21.1.Хөлөг онгоцон дээр хүүхэд төрсөн буюу хүн нас барсан тохиолдолд ахмад нь хоёр гэрч болон хөлөг онгоцны эмчийг байлцуулан баримт үйлдэж, энэ тухай хөлөг онгоцны дэвтэрт тэмдэглэл хийнэ.

21.2.Ахмад нь нас барсан хүний эд хөрөнгийн жагсаалтыг хоёр гэрчийг байлцуулан үйлдэж, эд хөрөнгийг эрх бүхий байгууллага, этгээдэд хүлээлгэн өгөх хүртэл хадгална.

21.3.Ахмад нь хөлөг онгоц боомтод хүрэлцэн ирсэн даруйд тухайн улсад суугаа уг нас барагчийн харьяалагдах улсын консулд шарилыг эд хөрөнгийн хамт хүлээлгэн өгнө.

21.4.Хөлөг онгоц далайд удаан хугацаагаар аялах болон шарилыг хадгалах боломжгүй байгаа онцгой тохиолдолд ахмад нь зохих баримт бүрдүүлэн шарилыг далайчдын ёс заншлын дагуу далайд оршуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ
Бусад зүйл

22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдод хүлээлгэх хариуцлага

22.1.Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 407 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмсүгэй:

"3/хөлөг онгоцны зорчигч болон багийн гишүүний гэрээслэлийг хөлөг онгоцны ахмад гэрчилсэн."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 8 дахь заалтын "усжуулалтын асуудал" гэснийг "усжуулалт болон гол, мөрөн, нуур, далайд загас агнах, далайн баялаг олборлох асуудал." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмсүгэй:

"3/хөлөг онгоцыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 20000 төгрөг."

2 дугаар зүйл. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Агаарын хөлөг," гэсний дараа "хөлөг онгоц," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмсүгэй:

"8/хөлөг онгоцны ахмад хөлөг онгоцон дээр гарсан гэмт хэргийн талаар."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "барилга байгууламж," гэсний дараа "хөлөг онгоц," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь галын аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох, галын аюулгүй байдлыг хангах талаархи нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж

2.1.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1] энэ хууль, Ой хэзрийг түймрээс хамгаалах тухай [2] хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."гал түймэр" гэж хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг;

3.1.2."гал түймрийн гамшиг" гэж объектын болон ой, хээрийн гал түймэр өргөжин дэлгэрч олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, байгалийн баялаг, эд хөрөнгө их хэмжээгээр сүйрэхэд хүргэх нөхцөл байдлыг;

3.1.3."гал унтраах удирдагч" гэж гал түймэр гарсан анхны дуудлагаар гал унтраах нэгжийг удирдаж ирсэн, гал унтраах ажлыг газар дээр нь удирдан зохион байгуулах галын байгууллагын алба хаагчийг;

3.1.4."галын аюулгүй байдал" гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг.

[1] Монгол Улсын Үндсэн хууль."Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны № 1-д нийтлэгдсэн.

[2] Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны № 12-т нийтлэгдсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гал түймэртэй тэмцэх байгууллага, түүний алба хаагч

4 дүгээр зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллага

4.1.Гал түймэртэй тэмцэх байгууллага нь гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах үүрэг бүхий мэргэжсэн байгууллага мөн.

4.2.Гал түймэртэй тэмцэх байгууллага нь нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулагдана.

4.3.Гал түймэртэй тэмцэх байгууллага нь гал түймэртэй тэмцэх төв байгууллага /цаашид "Гал түймэртэй тэмцэх газар" гэх/, түүний харьяа аймаг, нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадаас бүрдэнэ. Гал түймэртэй тэмцэх хэлтэс, албад нь гал унтраах анги, салбартай байж болно.

4.4.Гал түймэртэй тэмцэх газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

4.4.2. гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар аймаг, нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадыг мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

4.4.3.гал түймэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон ажлыг улсын хэмжээнд нэгттэн зохион байгуулж, чиглүүлэх;

4.4.4.гал түймрийн үүсэлт, шалтгаан нөхцөлийг судлах, арилгах;

4.4.5.гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний хангалтын асуудлыг зохион байгуулах;

4.4.6.гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх.

4.5.Аймаг, нийслэлийн гал түймэртэй тэмэх хэлтэс, албад харьяалах нутаг дэвсгэртээ дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.5.1.гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах;

4.5.2.объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах;

4.5.3.гал түймрийн хэрэг бүртгэлт явуулах;

4.5.4.ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх агаарын хяналтыг зохион байгуулах;

4.5.5.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4.6.Гал түймэртэй тэмцэх газрын даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

4.7.Гал түймэртэй тэмцэх газрын дэд даргыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

4.8. Гал түймэртэй тэмцэх газрын дүрмийг Засгийн газар батална.

4.9.Гал түймэртэй тэмцэх байгууллагын дотоод болон түүний албан хаагчийн сахилгын дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5 дугаар зүйл.Гал түймрийн улсын хяналт

5.1.Улсын галын аюулгүй байдлыг хангахад хяналт тавих чиг үүргийг Гал түймэртэй тэмцэх газар хэрэгжүүлнэ.

5.2.Гал түймрийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

5.3.Гал түймрийн улсын хяналтын эрх бүхий албаа хаагчийн хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, албан тушаалтан, иргэд биелүүлэх үүрэгтэй.

5.4.Гал түймрийн улсын хяналтын Ерөнхий байцаагч нь Гал түймэртэй тэмцэх газрын дарга байна.

6 дугаар зүйл.Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх талаархи Гал түймэртэй тэмцэх газрын бүрэн эрх

6.1.Гал түймэртэй тэмцэх газар гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэхдээ дараахь бүрэн эрхтэй байна:

6.1.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

6.1.2.гал түймрийн судалгаа, тоо бүртгэлийг хөтөлж гал түймэр гарсан шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогцолбор арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

6.1.3.барилга, объектыг ашиглалтад авах эвөвлөл, комиссын бүрэлдэхүүнд оролцох, бүрэн эрхийнхээ асуудлаар санал дүгнэлт гаргах;

6.1.4.гал түймэр гарах аюултай нөхцөл бий болсон үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах, үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг ашиглахыг хэсэгчлэн буюу бүрмөсөн зогсоох;

6.1.5.аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект болон иргэдийн орон сууцанд нэвтрэн орох, гал түймрийн аюулгүй байдлын болон галын техникийн үзэгэ хийх, илэрсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага бичих, биелэлтийг хангуулах;

6.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч

7.1.Гал түймэртэй тэмцэх байгууллагад 18 нас хүрсэн, Монгол Улсын иргэнийг өөрийнх нь хүсэлтэрэ авч ажиллуулна.

7.2.Тайван цагт гал түймэртэй тэмцэх байгууллагад алба хааж буй иргэнийг цэргийн жинхэнэ албанд татахаас чөлөөлнө.

7.3.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчаар хуульд заасан чиг үүргэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

7.4.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч нь мэргэжлийн зэрэг дэвтэй байна. Мэргэжлийн зэрэг дэв болон түүнийг олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Гал түймэртэй тэмцэх байгууллагад ажил хаялт зохион байгуулахыг хориглоно.

8 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчийн тангараг, цол, дүрэмт хувцас

8.1.Монгол Улсын иргэн гал түймэртэй тэмцэх байгууллагад анх ороходоо:

"Монгол Улсын иргэн би галын албанд ажиллахдаа төрийн хуулийг дээдлэн сахиж, хүний амь нас, эрүүл мэнд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалах үйлст чин шударгаар зүтгэж, шаардлага гарвал амь биеэ үл хайрлахаа батлан тангараглая.

Би энэ тангарагаасаа няцвал төрийн хуулийн цээрлэл хүлээнэ" хэмээн Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

8.2.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн батална цол, ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэнэ.

8.3.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчид цол олгох журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

9 дүгээр зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч үүргээ биелүүлэх баталгаа

9.1.Үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг гал түймэртэй тэмцэх байгууллага төлж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

9.2.Гал түймэртэй тэмцэх байгуулагын алба хаагч өндөржүүлсэн бэлэн байдалд байх, шөнийн эзлэжид ажиллах болон хээрийн сургууль, дадлага хийх үеийн зардлыг төр хариуцна.

9.3.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үед эрүүл мэнд нь хохирсон, эсхүл амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дор дурдсан тэтгэвэр, тэтгэмж олгоно:

9.3.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж болон авч байсан үндсэн цалингийн зөрүү;

9.3.2. хиймэл эрхтэн хийлгэсэн тохиолдолд түүний зардал;

9.3.3.амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж.

9.4.Энэ хуулийн 9.3.1-д заасан тэтгэвэр тогтоосноос хойш хохирогчийн тухайн үед авч байсан цалинд өөрчлөлт орсон бол зөрүү шинээр тогтоосон хэмжээнээс тооцож олгоно.

9.5.Энэ хуулийн 9.3.1-д заасан цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацаанд олгоно.

9.6.Энэ хуулийн 9.3-т заасан тэтгэвэр ба цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэх зардлыг гал түймэртэй тэмцэх байгууллага олгоно.

9.7.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчийг шилжүүлэн томилсон бол түүнд дараахь зардлыг олгоно:

9.7.1.удирдлагын шийдвэрээр алба хаагчийг шилжүүлэн томилсон, эсхүл томилогдсон газраасаа буцах үед түүний гэр бүлийн гишүүд болон 5 тонн хүртэл ачаа тээшийн хамт оршин суух газар нь хүргэх тээврийн хэрэгслийг байгууллагаас нь гаргах, эсхүл зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгох;

9.7.2.удирдлагын шийдвэрээр алба хаагчийг өөр газар шилжүүлэн томилсноос түүний эхнэр /нөхөр/ нь ажлаас халагдаж хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийг гал түймэртэй тэмцэх байгууллагаас олгох.

10 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчид үзүүлэх хөнгөлөлт

10.1.Гал түймэртэй тэмцэх байгууллагын зөвхөн гал түймэр унтраах ажиллагаанд оролцдог алба хаагч дараахь хөнгөлөлт эдэлнэ:

10.1.1.улсад ажиллаган хугацааг нь тогтооход гал унтраах ажилд оролцсон нэг

жилийг нэг жил хоёр сараар тооцох;

10.1.2. жил бүр ажлын 20 өдөр амрах;

10.1.3.алба хаасан таван жил тутам ажлын хоёр өдрийн нэмэгдэл амралт авах.

10.2.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчийн цалин дээр нэмж олгох зэрэг дэв, удаан жил ажилласны нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

10.3.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч эзлэжийн амралтаараа өөрийн төрсөн нутаг явах бол түүнд ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгоно.

11 дүгээр зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчдыг улсын даатгалд хамруулах

11.1.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч улсын даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

12 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын санхүүжилт

12.1.Гал түймэртэй тэмцэх газар улсын төвлөрсөн төсвөөс, аймаг, нийслэлийн хэлтэс, алба орон нутгийн төсвөөс тус тус санхүүжинэ.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан байгууллага гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллагад төлбөртэй үйлчилж болох бөгөөд орлогыг техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулна.

13 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчид хүлээлгэх хариуцлага

13.1.Хууль тогтоомж, өргөсөн тангарагаа зөрчсөн гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчид хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Галын аюулгүй байдлын талаархи нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх, үүрэг

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

14.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийг зохион байгуулах, нутаг дэвсгэртээ галын аюулаас урьдчилан сэргийлэх;

14.1.2.гал түймэртэй тэмцэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар зохиох арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах;

14.1.3.хот, суурин газрын төлөвлөлт, газар олголтод Улсын гал түймэрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагыг татан оролцуулах;

14.1.4.гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сурталт, сурталчилгаа явуулах ажлыг хэрэгжүүлэх.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гал түймэртэй тэмцэх байгууллагын дотоод дүрмээр зохицуулагдсан болон хэрэг бүртгэх, туршилт, шинжилгээ хийх, гал түймэр унтраах ажлаас бусад асуудлаар нутаг дэвсгэрийн гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадыг удирдана.

14.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн шатны гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангана.

15 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах талаархи иргэдийн эрх, үүрэг

15.1.Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь эрхтэй байна:

15.1.1.гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтоохоод биечлэн оролцох;

15.1.2. гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээ авах;

15.1.3.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах.

15.2.Галын аюулгүй байдлыг хангах талаар

Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь үүрэгтэй байна:

15.2.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

15.2.2.гал түймэр гарч байгаа тохиолдолд гал түймэртэй тэмцэх байгууллагад нэн даруй мэдэгдэх;

15.2.3.гал түймэр унтраах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх;

15.2.4.гал түймрийн талаархи зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх.

16 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

16.1.Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

16.1.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг чандлан сахих;

16.1.2.тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах;

16.1.3.галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, хэм хэмжээ, стандартыг хангаж ажиллах;

16.1.4.барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх болон хийц, бүтээц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлахдаа гал түймэртэй тэмцэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах;

16.1.5.ажилтан, ажилчдынхаа гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

16.1.6.гал унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг туслалцаа үзүүлэх;

16.1.7.шинээр баригдаж байгаа барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэргийг байрлуулан ашиглахдаа гал түймэртэй тэмцэх байгууллагын мэргэжлийн дүгнэлтийг гаргуулах.

16.2.Галын аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлнэ:

16.2.1.галын аюулгүй байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зааварчилга, зөвлөгөө авах;

16.2.2.гал түймрийн аюулаас хамгаалах зорилгоор гал унтраах гэрээт нэгж ажиллуулах.

17 дугаар зүйл.Галын гэрээт алба

17.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь өөрийн эд хөрөнгөө гал түймрийн аюулаас хамгаалах зорилгоор галын гэрээт албыг ажиллуулж болно.

17.2.Галын гэрээт алба нь тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр санхүүжинэ.

17.3.Гал түймэртэй тэмцэх газар нь галын гэрээт алба ажиллуулах журмыг батална, тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

17.4.Галын гэрээт алба нь түүний хариуцсан объектод гарсан галын мэдээг Гал түймэртэй тэмцэх газарт өгөх үүрэгтэй.

17.5.Цэргийн анги байгууллагын дэргэдэх галын гэрээт албаны албан хаагч тухайн төрлийн цэргийн албан хаагчийн тангараг өргөж, цол, дүрэмт хувцас хэрэглэж үүргээ биелүүлэх баталгаа, хөнгөлөлтөөр хангагдана.

17.6.Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад галын гэрээт албаны ажилтан энэ хуулийн 9.3-т заасан болон бусад баталгаагаар хангагдах бөгөөд зардлыг тухайн байгууллага хариуцна.

17.7.Энэ хуулийн 17.6-д заасан бусад галын гэрээт албаны ажилтан гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөж, дүрэмт хувцсыг хэрэглэж болох бөгөөд зардлыг тухайн байгууллага хариуцна.

17.8.Гэрээт албаны ажилтанд түүний мэргэжил, даддлага туршлагыг харгалзан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгож болно.

17.9.Галын гэрээт албыг шаардлагатай тохиолдолд гал унтраах үйл ажиллагаанд дайчилж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Галын аюулгүй байдлыг хангах

18 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага

18.1.Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах боломлоог хангасан байна.

18.2.Галын аюултай болон тэсэрч дэлбэ-

рэх бодис, материал хадгалж /шатахуун түгээх станц, шатах хий хадгалах зэрэг/, ашиглахад гал түймэртэй тэмцэх байгууллагын албан ёсны зөвшөөрлийг авсан байна.

19 дүгээр зүйл.Галын аюулгүй байдлын норматив, стандарт

19.1.Галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, бусад техникийн нормативыг албан тушаалтан, иргэд үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах үүрэгтэй.

19.2.Галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, бусад техникийн нормативыг Гал түймэртэй тэмцэх газартай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

20 дугаар зүйл.Барилга байгууламж, объектын зураг төсөл зохиох, хянахад галын аюулгүй байдлыг хангах

20.1.Барилга байгууламж, объектын зураг төсөл зохиох, барилга барих, засварлах, хийц бүтээцийг өөрчлөх, техник тоноглолыг шинэчлэхэд галын аюулгүй байдлын шаардлага /стандарт, техникийн норматив/-ыг дагаж мөрдөнө.

20.2.Галын аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахыг хориглоно.

21 дүгээр зүйл.Бүтээгдэхүүнд тавих галын аюулгүй байдлын шаардлага

21.1.Галын аюултай бүтээгдэхүүн гэж галын аюулын ангилал, зэрэглэлийн дагуу гал асаах эх үүсвэрээс дөлөөж авалцан асах буюу үгүйг асах бүтээгдэхүүнийг хэлнэ.

21.2.Галын аюултай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах иргэн болон хуулийн этгээд нь энэ тухайгаа гал түймэртэй тэмцэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах үүрэгтэй.

21.3.Галын аюултай бүтээгдэхүүний жагсаалт, ангилал, зэрэглэлийг Гал түймэртэй тэмцэх газартай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

22 дугаар зүйл.Гал түймрийн аюулгүй байдлын талаархи мэдээ мэдээлэл

22.1.Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэхтэй холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараалал үл харгалзан төлбөртэйгээр нийтэлж нэвтрүүлнэ.

22.2.Хүчтэй салхи шуурга, усны үер, хуурайшилт, газар хөдлөлт зэрэг байгалийн аюултай үзэгдэл гарч болзошгүй нөхцөл байдлын талаар цаг уурын болон бусад холбогдох байгууллагууд гал түймэртэй тэмцэх байгууллагад нэн даруй, үнэ төлбөргүй мэдээлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Гал түймэр унтраах ажлын зохион байгуулалт

23 дугаар зүйл.Гал түймэр унтраах үйл ажиллагааны зохион байгуулалт

23.1.Гал түймэр унтраах ажлын зохион байгуулалт гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгалийн баялагийг гал түймрийн аюулаас авран хамгаалах, гал түймрийг унтраах арга ажиллагаа хэлнэ.

23.2.Гал түймэр унтраах ажлыг зохион байгуулж гүйцэтгэхдээ гал унтраах дүрмийг удирдлага болгоно. Гал унтраах дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3.Гадаад улсын элчин сайдын яам, консулын болон худалдааны төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, түүнчлэн цахилгаан эрчим хүчний объектуудад гарсан гал түймрийг унтраах асуудлыг тэдгээрийн бүрэн эрхт төлөөлөгч, хэргийг түр хамааргч болон тухайн объектын удирдлагын албан ёсны зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл.Гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулах

24.1.Гал унтраах удирдагч нь гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, техникийн бүрэн байдлыг хариуцна. Гал түймэр унтраах

хүч, техник хэрэгсэл нь зөвхөн гал унтраах удирдагчид захиргдана.

24.2.Гал түймэр унтраах удирдагчийн хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

24.3.Гал түймэр унтраах ажлыг зохион байгуулж байгаа гал унтраах удирдагчийн шийдэрийг эсэргүүцэх, түүнд хөндлөнгөөс саад хийхийг хоригломо.

24.4.Гал түймэр унтраах удирдагч нь гал гарсан объектын байршлын зураг, онцлог, агуулж буй бодис материалын талаар мэдээлэл авах, хойшлуулшгүй тохиолдолд засаг захиргааны харьяалал, өмчийн хэлбэрийг үл харгалзан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээвэр холбооны хэрэгсэл, хүн хүчийг дайчлах, ашиглах эрхтэй.

24.5.Гал түймэр унтраахад усны аливаа эх үүсвэрийг шууд дайчилж үнэ төлбөргүй ашиглана.

24.6.Гал түймэр унтраах ажлыг гүйцэтгэхэд хүн амын аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг хориглох, гал түймэр гарч байгаа газарт шаардлагатай хязгаарлалт тогтоох, иргэдийг нэвтрэн орохыг түр хугацаагаар хязгаарлана.

24.7.Энэ хуулийн 24.4-т заасан дайчилгааны зардлыг гал түймэртэй тэмцэх байгууллага хариуцна.

24.8.Гал унтраах ажиллагааны явцад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирсан хохирлыг төр хариуцна.

25 дугаар зүйл.Хойшлуулшгүй ажиллагаа

25.1.Гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтоох үед гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий албан хаагч дараахь хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрхтэй:

25.1.1.иргэний нэр, хаягийг тодруулах зорилгоор биеийн байцаалт, бусад бичиг баримтыг үзэж шалгах;

25.1.2.иргэний биед, тээврийн хэрэгсэл болон ачаа тээшид үзлэг хийх;

25.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд хөрөнгө, мөнгө агуулсан байр, савыг битүүмжлэх;

25.1.4.гэмт хэрэг, захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хураан авах;

25.1.5.согтуурууллах ундаа, мансууруулах болон хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгуулах;

25.1.6.гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээ өгч чадах баттай үндэслэл байгаа нөхцөлд иргэнээс тодорхойлолт авах;

25.1.7.гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюулыг таслан зогсоох зорилгоор замын хөдөлгөөний чиглэлийг өөрчилж, энэ тухай нэн даруй орон нутгийн засаг захиргааны байгууллагад илгээх.

25.2.Энэ хуулийн 25.1.2, 25.1.3, 25.1.4-т заасан тохиолдолд тэмдэглэл хөтөлж, түүнд гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий албан хаагч болон холбогдох этгээд гарын үсэг зурна.

26 дугаар зүйл.Гал түймрийн гамшиг

26.1.Гал түймэртэй тэмцэх байгууллага гал түймэр гарсан тухай анхны дуудлагаар хүрэлцэн очиж гал унтраах дүрмийн дагуу ажиллана.

26.2.Гал түймэр ергөжиж энэ хуулийн 3.1.2-т заасан нөхцөл байдал бий болсныг гал унтраах удирдагч зохих журмын дагуу тодорхойлж энэ талаар тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэний хамгаалалтын штабад нэн даруй мэдэгдэнэ.

Энэ журмыг Гал түймэртэй тэмцэх газар иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөөний үндсэн дээр батална.

26.3.Ой, хээрийн түймрээс хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3-т заасан журмын дагуу ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд гал түймэртэй тэмцэх байгууллага бусад мэргэжлийн албадын хамт оролцоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

27 дугаар зүйл.Гал түймэртэй тэмцэх байгууллагын үйл ажиллагааны тавих хяналт

27.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллага, Засаг дарга нар тус тусын эрх хэмжээний хүрээнд гал түймэртэй тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

27.2.Гал түймэртэй тэмцэх байгууллагын хэрэг бүртгэх ажиллагаанд прокурор хяналт тавина.

27.3.Гал түймэртэй тэмцэх газар нь гал түймэртэй тэмцэх байгууллагын нийт алба хаагчийн үйл ажиллагаанд, гал түймэртэй тэмцэх байгууллагын дарга, захирагч нь тухайн байгууллагын алба хаагчдын өдөр тутмын ажилд дотоодын хяналт тавьж, хууль тогтоомж зөрчих явдлыг урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

28.1.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын "шүүхийн шийдвэр биелүүлэх" гэсний дараа", гал түймэртэй тэмцэх" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмсүгэй:

"8/гал түймэртэй тэмцэх байгууллага Эрүүгийн хуулийн 185, 186, 244 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "хорих" гэсний дараа ", гал түймэртэй тэмцэх" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ОЙ, ХЭЭРИЙГ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

"3.Гал түймэртэй тэмцэх байгууллага ой, хээрийг түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/түймрээс сэргийлэх зорилгоор тухайн бүс нутагт байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагаог хязгаарлах, зогсоох;

3/онцгой болон хамгаалалтын бүсийн ойг цэвэрлэх, арчлах, шороон болон халз зурвас гаргах зэрэг түймрээс хамгаалах арга хэмжээний улсын захиалга өгч мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

4/түймрийн шалтгаан, нөхцөл болон хохирлыг тогтоох.

2 дугаар зүйл.Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтаас "тогтоох" гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмсүгэй:

"7/гал түймэртэй тэмцэх байгуулагын албан хаагч."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр **Улаанбаатар хот**

ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 6, 7, 8, 12 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 3-ны өдөр **Дугаар 27** **Улаанбаатар хот**

Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Импортын барааны гаалийн албан татварын тухай" Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24, "Импортын зарим бараанд гаалийн албан татвар тогтоох тухай" 1998 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралт

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ

Бүлэг	Зүйл №	Үндэсний код	Барааны бичиглэл	Албан татварын хувь, хэмжээ
01			Амьд мал, амьтад	5
		0101.11.00	Цэвэр үүлдрийн үржлийн адуу	0
		0102.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн үхэр	0
		0103.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн гахай	0
	01.04		Хонь, ямаа	0
02			Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн	5
03			Загас, хавч, нялцгай биетэн ба усны бусад сээр нуруугүй амьтан	5
04			Сүү, цагаан идээ, өндөг, зөгийн бал ба бусад газар заагдаагүй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн	5
05			Бусад газар заагдаагүй, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн	5
06			Мод, сөөг, модлог үргамал суулгах материал, булцуу, үндэс ба үргамлын бусад хэсэг, амьд цэцгийн баглаа ба гоёлын үргамал	5
07			Хүнсний ногоо, зарим үргамлын үндэс, булцуу	5
			Төмс	
	07.01		9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
			4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5
			Сонгино	
		0703.10.00	9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
			4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5
			Байцаа	
		0704.90.10	9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
			4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5
			Шар лууван	
		0706.10.10	9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
			4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5
			Шар манжин	
		0706.10.20	9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
			4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5

08			Хүнсэнд хэрэглэдэг жимс, самар, жүрж ба гуаны хальс	5
09			Кофе, цай, парагвай цай, өвөрмөц амт, үнэр оруулагч ургамал	5
10			Үр тариа	5
11			Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн; амуу соёолж; цардуул; инулин; буудайн цавуулаг	5
			Гурил	
	11.01		9-р сарын 1-нээс 4-р сарын 1 хүртэл	15
	11.02		4-р сарын 1-нээс 9-р сарын 1 хүртэл	5
12			Тослог ургамлын үр ба жимс; бусад үр жимс; үйлдвэрлэлийн буюу эмнэлгийн зориулалттай ургамал, сүрэл ба малын тэжээл	5
13			Лак, нунжгай, давирхай болон ургамлын гаралтай бусад шүүс болон ханд	5
14			Сүлжих зорилгоор ашиглах ургамал; бусад газар заагдаагүй ургамлын гаралтай бүтээгдэхүүн	5
15			Мал, амьтны болон ургамлын гаралтай тос, түүнийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх, тос; мал, амьтан, ургамлын гаралтай лав	5
16			Махан зүйлс ба загас, далайн хавч, нялцгай биетэн буюу усны бусад сээр нуруугүй амьтдаар хийсэн хүнсний зүйл	5
17			Саахар, саахран бүтээгдэхүүн	5
18			Какао болон какаоны бэлдмэл	5
19			Үр тариа, гурил, цардуул, сүүн бэлдмэл; гурилан бүтээгдэхүүн	5
20			Хүнсний ногоо, жимс, самар буюу ургамлын бусад эд хэсгийн бэлдмэл	5
21			Төрөл бүрийн хүнсний бэлдмэл	5
22			Ус, ундаа, спирт, архи, дарс, цуу	5
		2207.10.00	80% буюу түүнээс дээш хатуулагтай этилийн хувилаагүй спирт	хориглох
		2207.20.00	Этилийн хувилсан спирт ба бусад спирт	хориглох
		2208.90	80%-иас бага хатуулагтай этилийн хувилаагүй спирт	хориглох
23			Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл ба хаягдал, малын бэлдмэл тэжээл	5
24			Тамхи, түүнийг орлуулагч бүтээгдэхүүн	5
25			Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент	5
26			Хүдэр, баяжмал, шаараг болон үнс	5
27			Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс; эрдэс лав	5
		2716.00.00	Цахилгаан эрчим хүч	5
28			Органик биш нэгдэл; үнэт ба газрын ховор металл, цацраг идэвхт элемент ба изотопын органик буюу органик биш нэгдэл	5

29			Органик химийн нэгдэл	5
30			Эм зүйн бүтээгдэхүүн	5
31			Бордоо	5
32			Идээлэгч буюу будагч бодисын ханд; таннин, түүний уламжлал; нөсөө, будагч, өнгө оруулагч бусад бодис; найруулсан будаг, чий /лак/; чигжээс, шаваас; бэх	5
33			Эфирийн тос, давирхайн үнэрт охь; үнэртэн, гоо сайхан, ариун цэврийн бэлдмэл	5
34			Саван, гадаргуугийн идэвхт органик бодис, угаалгын бэлдмэл, тосолгооны материал, хиймэл ба бэлтгэсэн лав, цэвэрлэгээ буюу өнгөлгөөний бэлдмэл, лаа ба түүнтэй төстэй зүйлс, баримлын шавар, "шүдний хэвний лав" ба гөлтгөнөд суурилсан шүдний бэлдмэл	5
35			Уургийн бодис; хувиргасан цардуул; цавуу; фермент	5
36			Тэсрэмтгий бодис; пиротехникийн бүтээгдэхүүн; шүдэнз; шатамхай хайлш; зарим төрлийн шатагч бэлдмэл	5
37			Гэрэл зураг ба кино зургийн зориулалттай бараа	5
38			Бусад газар ангилагдаагүй төрөл бүрийн химийн бүтээгдэхүүн	5
39			Хуванцар болон хуванцар эдлэл	5
40			Каучук болон каучукан эдлэл	5
41			Арьс, ширэн түүхий эд /ангийн үснээс бусад/ ба боловсруулсан арьс шир	5
42			Боловсруулсан арьс ширэн эдлэл; суран эдлэл ба тоног хэрэгсэл; аяны хэрэгсэл; эмэгтэй хүний цүнх ба түүнтэй төстэй уут сав; амьтны өлөн гэдсээр /төөлүүр хорхойн утаснаас бусад/ хийсэн зүйлс	5
43			Үслэг арьс ба хиймэл үслэг арьс тэдгээрээр хийсэн эдлэл	5
44			Мод ба модон эдлэл; модны нүүрс	5
45			Үйс ба үйсэн эдлэл	5
46			Сүрэл, сийрс буюу бусад сүлжих материалаар хийсэн эдлэл; сагсан зүйлс ба сүлжээсэн бусад эдлэл	5
47			Мод буюу бусад целлюлоз материа-лан зутан; сэргээн боловсруулсан /хаягдал ба өөдөс/ цаас буюу картон	5
48			Цаас ба картон; цаасны зутан, цаас буюу картоноор хийсэн зүйлс	5
49			Ном, сонин, зурагт хуудас ба хэвлэх үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн, гар бичмэл, машинаар бичсэн материал ба шуудан зураг	5

50			Торго	5
51			Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас, адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу	5
52			Хөвөн	5
53			Ургамлын гаралтай нэхмэлийн бусад ширхэг; цаасан ээрмэл, түүгээр нэхсэн даавуу	5
54			Химийн мяндас	5
55			Химийн штапель мяндас	5
56			Зулмал хөвөн, эсгий ба нэхээсгүй материал; өвөрмөц ээрмэл; олс, оосор, дээс татлага ба тэдгээрээр хийсэн зүйлс;	5
57			Хивс ба бусад нэхмэл дэвсгэр	5
58			Өвөрмөц нэхээстэй даавуу; шивсэн үстэй даавуу; торон нэхмэл; гоёлын материал, гоёлын нэхмэл; хатгамал	5
59			Нэвчүүлсэн, хучсан, бүрсэн, үелүүлсэн нэхмэл даавуу; тэдгээрээр хийсэн техникийн зориулалттай нэхмэл эдлэл	5
60			Машины болон гар сүлжмэл даавуу	5
61			Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл	5
62			Оёмол хувцас ба хувцасны оёмол тоног хэрэглэл	5
63			Бусад нэхмэл бэлэн эдлэл, иж бүрдэл: хуучин хувцас ба хуучин нэхмэл эдлэл, хаягдал даавуу	5
64			Гутал, салдаг түрий болон түүнтэй төстэй зүйлс, тэдгээрийн эд анги	5

65			Малгай, малгайн эд анги	5
66			Шүхэр, нарны халхавч, таяг, тулгуур, шилбүүр, ташуур болон тэдгээрийн эд анги	5
67			Боловсруулсан өд, ноолуур, тэдгээртэй хамт хийсэн зүйлс; хиймэл цэцэг; хүний үсээр хийсэн зүйлс	5
68			Чулуу, гөлтгөнө, цемент, шөрмөсөн чулуу, гялтгануур буюу тэдгээртэй төстэй материалаар хийсэн зүйлс	5
69			Керамик эдлэл	5
70			Шил ба шилэн эдлэл	5
71			Жинхэнэ буюу таримал сувд, үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс; дуураймал гоёлын зүйлс; зоос	5
72			Хар төмөрлөг	5
73			Төмөр буюу гангаар хийсэн эдлэл	5
74			Зэс ба түүгээр хийсэн эдлэл	5
75			Никель ба түүгээр хийсэн эдлэл	5
76			Хөнгөн цагаан ба түүгээр хийсэн эдлэл	5
77*				
78			Хар тугалга ба түүгээр хийсэн эдлэл	5
79			Цайр ба түүгээр хийсэн эдлэл	5

80			Цагаан тугалга ба түүгээр хийсэн эдлэл	5
81			Бусад үндсэн металл; металл-керамик, тэдгээрээр хийсэн эдлэл	5
82			Үндсэн металлаар хийсэн багаж, хэрэгсэл, огглогч, халбага, сэрээ; тэдгээрийн үндсэн металлаар хийсэн эд хэсэг	5
83			Үндсэн металлаар хийсэн төрөл бүрийн эдлэл	5
84			Цөмийн реактор, уурын тогоо, машин ба механик төхөөрөмж, тэдгээрийн эд анги	5
	84.71		Мэдээлэл боловсруулах автомат машин ба түүний бүрдэл хэсэг, соронзон буюу оптик уншигч, мэдээллийг код хэлбэрт оруулан бичих машин болон бусад газар заагдаагүй мэдээлэл боловсруулах машин	0
		8473.30.00	Зүйл № 84.71-д заагдсан машины эд анги, тоног хэрэгсэл	0
85			Цахилгаан машин, тоног төхөөрөмж, хэрэгсэл болон тэдгээрийн эд анги, дуу бичигч болон дуу сэргээх төхөөрөмж, телевизийн дүрс, дуу бичих ба сэргээх төхөөрөмж, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	5
	85.41		Диод, транзистор ба тэдгээртэй ижил төстэй хагас дамжуулагч, гэрэлд мэдрэмтгий хагас дамжуулагч, модульд оруулсан буюу оруулаагүй фотогальваник элемент, гэрлийн эмиссийн диод, угсрагдсан пьезо-цахилгаан талст	0
	85.42		Цахим интеграл схем болон цахим микросхем	0
86			Төмөр замын буюу трамвайн зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүн болон тэдгээрийн эд анги; төмөр зам буюу трамвайн замын хэрэгсэл, төхөөрөмж болон тэдгээрийн эд анги; бүх төрлийн механик /цахилгаан механик/ замын дохиоллын төхөөрөмж	5
87			Төмөр зам буюу трамвайн замын хөдлөх бүрэлдэхүүнээс бусад тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	5
88			Агаарын хөлөг, сансрын хөлөг болон тэдгээрийн эд анги	5
89			Хөлөг онгоц, завь болон хөвөгч байгууламж	5

90			Оптик, гэрэл зураг, кино зураг, хэмжүүр, хяналт, нарийвчлал, эмнэлэг буюу мэс заслын багаж ба аппарат; тэдгээрийн эд анги ба тоног хэрэглэл	5
	90.18		Эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг ба мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, цацраг хэмжих, бүрттэх багаж ба эмнэлгийн бусад эрдэм шинжилгээ, туршилтын цахилгаан төхөөрөмж ба хараа шалгах хэрэгсэл	0
		9018.31.00	Зүүтэй буюу зүүгүй тариур	5
	90.22		Хүн эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг буюу мал эмнэлгийн зориулалттай буюу зориулалтгүй рентген туяа, альфа, бета, гамма цацрагийн аппарат, радиографын буюу цацраг эмчилгээний аппарат, рентген хоолой, рентген үүсгүүр, хянах тохируулах самбар, үзлэг эмчилгээний ширээ, сандал, дэлгэц зэрэг хэрэгсэл	0
91			Цаг, бугуйн цаг, тэдгээрийн эд анги	5
92			Хөгжмийн зэмсэг, түүний эд анги болон тоног хэрэглэл	5
93			Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги ба тоног хэрэгсэл	5
94			Тавилга: ор дэрний зөөлөн эдлэл, матрац, матрацны тулгуур, зөөлөвч ба тэдгээртэй төстэй гэр ахуйн чихмэл зөөлөн эдлэл; бусад газар заагдаагүй гэрэлтүүлэгч, гэрэлтүүлэх хэрэгсэл; гэрлэн хаяг, гэрлэн самбар ба тэдгээртэй төстэй зүйлс; барилгын угсармал хийц	5
95			Тоглоом, наадгай ба спортын хэрэглэл; тэдгээрийн эд анги ба тоног хэрэглэл	5
96			Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	5
97			Урлагийн бүтээл, цуглуулгын зүйлс ба эртний үнэт ховор зүйлс	5

77* -Энэ бүлгийн бараа байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 39 **Улаанбаатар хот**

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 6 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллогыг удирдан зохион байгуулах улсын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:

1/ Монгол Улсын Ерөнхий сайд

Комиссын орлогч дарга:

2/ Үндэсний статистикийн газрын дарга

Гишүүд:

3/ Батлан хамгаалахын сайд

4/ Гадаад харилцааны сайд

5/ Дэд бүтцийн хөгжлийн сайд

6/ Сангийн сайд

7/ Хууль зүйн сайд

8/ Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд

Нарийн бичгийн дарга:

9/ Үндэсний статистикийн газрын дэд дарга

2.Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогыг тогтоосон хугацаанд нь чанартай явуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг комисс /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 1999 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 40 **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай" Улсын Их Хурлын 1996 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтын Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд: "13[1].Гал түймэртэй тэмцэх газар" гэх нэмсүгээ.

2.Энэ тогтоолыг Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 41 **Улаанбаатар хот**

Прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсад прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойг 2000 оны 8 дугаар сарын эхний долоо хоногт тэмдэглэхээр тогтоосугай.

2.Прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахтай холбогдсон зардлыг 2000 оны улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны зургадугаар сарын 23 №28 (107)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

251. Радио долгионы тухай /1999-6-4-ний хууль/ 405
252. Автотээврийн тухай хууль / 1999-6-4-ний хууль/ 411
253. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-6-4-ний хууль/ 417
254. Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-6-4-ний хууль/ 417
255. Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /1999-6-4-ний хууль/ 417

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

256. Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 37 418

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

257. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 100 418
258. Жонни Балтзерсенийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 102 418
259. Зарим хүмүүст албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 104 418

Дөрөв. Монгол Улсын засгийн газрын тогтоол

260. Бэрхийн уулын үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 74 420

Тав. Яам, агентлагийн акт

261. Заавар, журам батлах тухай /Монгол Улсын Хууль зүйн сайдын тушаал/ Дугаар 73 424

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эдэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Радио долгионы тухай хууль тогтоомж

2.1. Радио долгионы тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндэсэн хууль[1], Харилцаа холбооны тухай хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "радио долгион" гэж агаарын орон зайд тархаж байгаа цахилгаан соронзон орны 3000 гега герц хүртэлх давтамжтай хэсгийг;

3.1.2."радио давтамжийн зурвас" гэж бүлэг радио давтамжийг;

3.1.3."радио холбоо" гэж радио төхөөрөмж ашиглан төрөл бүрийн мэдээллийг тэмдэгт, дохио, дуу, дүрс болон бусад хэлбэрээр нэвтрүүлэх, хүлээн авахыг;

3.1.4. "үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт" гэж радио давтамжийн нийт зурвасыг радио холбооны үйлчилгээний төрөлд хуваасан хуваарилалтыг.

4 дүгээр зүйл. Радио долгионы өмчлөл

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссөн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн.

4.2. Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, болзолтойгоор радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглах эрхийг бусад этгээдэд олгоно.

5 дугаар зүйл. Радио долгионы талаар төрийн байгууллагын бүрэн эрх

5.1.Засгийн газар нь радио долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.Монгол Улсад хуваарилсан сансарын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар шийдвэр гаргах;

5.1.2.радио давтамжийн хуваарилалтыг төрийн нууцад хамруулах, нууцлалын зэрэглэлийг тогтоох асуудлыг боловсруулах.

5.2. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1.радио давтамжийн зурвас ашиглалтын талаархи төрийн бодлого боловсруулах;

5.2.2. хил залгаа улстай радио долгионы асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын цахилгаан холбооны байгууллагаас тогтоосон журмын дагуу зохицуулах;

5.2.3.радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл гаргах, радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам батлах;

5.2.4.радио давтамж зохицуулалт, хяналтын албаны зардал, техник хэрэгслэлээр хангах санхүүжилтийн хэмжээг тогтоож батлах;

5.2.5.олон улсын радиогийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Радио давтамж ашиглах

6 дугаар зүйл. Радио давтамжийн зурвасын ангилал

6.1.Радио давтамжийн зурвасыг ашиглаж буй зориулалтаар нь дараахь байдлаар ангилна:

6.1.1. тусгай хэрэглээний;

6.1.2. нийтийн хэрэглээний.

6.2. Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг тусгай хэрэглээний гэнэ.

6.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг нийтийн хэрэглээний гэнэ.

[1] Монгол Улсын Үндэсэн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны № 1-д нийтлэгдсэн.

[2] Харилцаа холбооны тухай хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны № 1-д нийтлэгдсэн.

7 дугаар зүйл. Радио давтамжийн зурвас эзэмших эрх бүхий этгээд

7.1.Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу радио давтамж зохицуулалт, хяналтын албанаас тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

7.2.Тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасыг радио давтамж зохицуулалт, хяналтын албанд бүртгүүлж ашиглана.

7.3.Монгол Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгуулагын төлөөлөгчийн газар нь Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг энэ хуулийн 7.1-д заасны дагуу ашиглана.

7.4.Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах байгуулалга нь нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвас ашиглах бол энэ хуулийн 7.1-д заасны дагуу ашиглана.

8 дугаар зүйл. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглох

8.1.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

9.1.Төрийн эрх бүхий байгууллагаас радио холбоо зохион байгуулах, түүнийг ашиглан үйлчилгээ эрхлэх, нийтийн үйлчилгээний зориулалтаар радио төхөөрөмж ажиллуулахын тулд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрх олгосон баримт бичигийг тусгай зөвшөөрөл гэнэ.

9.2.Тусгай зөвшөөрөлд радио төхөөрөмжийн байршил, хамрах нутаг дэвсгэр, ашиглах радио давтамж, хүчин чадал, үйл ажилагаа эхлэх дуусах хугацаа, ашиглалтын зориулалт зэргийг заана.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах

10.1.Тусгай зөвшөөрөл авах өргөдөлд Харилцаа холбооны тухай хуулийн 9.2-т заасан баримт бичгээс гадна дараахь баримтыг хавсаргана:

10.1.1. гэрчилгээний хуулбар;

10.1.2.радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио давтамжийн зурвас, радио давтамж, технологи;

10.1.3.радио төхөөрөмжийг баталгаажуулж эрх бүхий байгуулагаас олгосон баримт бичиг;

10.1.4. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөл.

10.2.Тусгай зөвшөөрөл авах өргөдөлд өргөдөл гаргагчийн нэр, харилцах хаяг, утас ба факсны дугаар, шийдвэр гаргах эрх бүхий хүний албан тушаал, нэрийг тусгана.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

11.1.Радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авмагц өргөдөл болон түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 10.1-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана.

11.2. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

11.2.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох;

11.2.2. тухайн радио давтамж нь тусгай хэрэглээний ангилалд орсон, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглагдаж байгаа, радио давтамжийн үйлчлэх хүрээтэй давхацсан, харилцан нөлөөлөл үүгээс бол радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах.

11.3.Тухайн радио давтамжийг ашиглах асуудлыг олон улсын байгуулагатай зохицуулдаг бол уг радио давтамжийг олон улсын байгуулагаас санал авсны үндсэн дээр энэ хуулийн 11-д заасны дагуу ашиглана.

11.4.Ижил радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд өрсөлдүүлэн шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгож болно.

11.5.Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө. Жилийн төлбөр төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохгүй.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

12.1.Радио давтамж зохицуулалт, хяналтын алба өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор тусгай зөвшөөрлийг 15 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

12.2.Тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь хугацаа сунгах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 ба түүнээс дээш хоногийн өмнө радио давтамж зохицуулалт, хяналтын албанд гаргана.

12.3. Хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэхийг хянаж биелүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, нэгдсэн бүртгэлд тэмдэглэж эзэмшигчид нь бугааж олгоно.

13 дугаар зүйл. Эрхийн бичиг

13.1.Иргэн, хуулийн этгээд хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио холбоо зохион байгуулах, эрдэм шинжилгээ, туршилтын ажиллагаа явуулах бусад бүх төрлийн радио төхөөрөмжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглахад радио давтамж ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичиг /цаашид "эрхийн бичиг" гэх/олгоно.

13.2.Эрхийн бичиг авах өргөдөл өргөдөл гаргагчийн нэр, албан ёсны хаяг, утасба факсны дугаар, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг тусгана.

13.3.Эрхийн бичгийг шилжүүлэх, түүний хугацааг сунгах, хүчингүй болгох асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу радио давтамж зохицуулалт, хяналтын алба шийдвэрлэнэ.

13.4.Эрхийн бичигт радио төхөөрөмжийн байршил, хамрах нутаг дэвсгэр, радио давтамж, дуудлагын нэр, хүчин чадал, үйл ажиллагаа эхлэх, дуусах хугацаа, ашиглалтын зориулалт зэргийг заана.

13.5.Ижил радио давтамж ашиглах эрхийн бичиг авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд эхний эзэнжид өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд түүнийг олгоно.

14 дүгээр зүйл. Радио давтамж тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй ашиглах

14.1. Дараахь төрлийн радио төхөөрөмж ашиглахад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй:

14.1.1.бүх төрлийн зураг радио, радио хүлээн авагч;

14.1.2.эмчилгээ, оношилгооны радио төхөөрөмж;

14.1.3.техникийн шаардлага хангасан гаралтын чадал нь 0.01 ваттаас ихгүй радио телефон утас, радио төхөөрөмж, гэр ахуйн электрон цахилгаан хэрэгсэл;

15 дугаар зүйл. Бүртгэл

15.1.Нэгдсэн бүртгэлд радио давтамжийн ангилал, зориулалт, ашиглагчийн нэр, хаяг, ашиглахыг зөвшөөрсөн радио давтамжийн зурвас, түүний өргөн, үйлчлэх хүрээ, газар зүйн байршил, ажиллуулах хугацаа, хүчин чадал, төлбөр төлөлтийн байдал зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр тусгана.

15.2.Нэгдсэн бүртгэлийг радио давтамж зохицуулалт, хяналтын алба хөтлөх бөгөөд түүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр танилцуулна.

16 дугаар зүйл. Үйлчилгээний төлбөр

16.1. Эрхийн бичиг авах, шилжүүлэх, тусгай зөвшөөрөл авах, тэдгээрийн хугацааг сунгах, бүртгүүлэх, харилцан нөлөөллийг шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргахад энэ хуулийн 5.2.3-т заасан журмын дагуу үйлчилгээний төлбөрийг өргөдөл гаргагч төлнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацаа дуусгавар болох

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацаа дуусгавар болох үндэслэл

17.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг тусгай зөвшөөрөл болон түүнд заасан эрх, үүргээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, уг эрх, үүргийг өөрчилсөн гэрээ байгуулахыг хориглоно.

17.2.Эрхийн бичиг бүхий радио төхөөрөмжийг бусдад шилжүүлэх, хуваалдах зэргээр эзэмшигч, өмчлөгч өөрчлөгдөх бол эрхийн бичгийг радио давтамж зохицуулалт, хяналтын албанд шинээр бүртгүүлнэ.

17.3.Тусгай зөвшөөрөл болон эрхийн бичгийн хугацаа Харилцаа холбооны тухай хуулийн 11-д заасан үндэслэлээр дуусгавар болгоно.

17.4.Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд уг радио давтамжийг ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг энэ хууль заасны дагуу бусдад шинээр олгож болно.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах

18.1.Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг Харилцаа холбооны тухай хуулийн 12-т заасан үндэслэл болон дараахь үндэслэлээр цуцална:

18.1.1.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь энэ хуульд заасны дагуу эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

18.1.2.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь тусгай зөвшөөрөл, радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

18.1.3.тусгай хэрэглээний ангилалд ашиглаж байгаа радио давтамжийн зурвасыг ашиглаагүй, санаатайгаар шуугиан үүсгэсэн буюу сонссон.

18.2.Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах үндэслэл байгааг тогтоовол радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь энэ тухай тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид мэдэгдэл өгнө. Уг мэдэгдэлд тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах болсон үндэслэлийг нотлох баримтын хамт заана.

18.3. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь мэдэгдэлд заасан үндэслэл байхгүй гэж үзвэл уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор өөрийн өргөдөл, гомдлыг нотлох баримтын хамтаар радио давтамж зохицуулалт, хяналтын албанд ирүүлж хянуулж болно.

18.4. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж хариу мэдэгдэнэ.

18.5. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн ирүүлсэн нотлох баримт бичгийг хүлээн зөвшөөрөх үндэсгүй гэж үзвэл радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид өөрийн дүгнэлтийн тухай мэдэгдэж, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцална.

18.6. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь цуцалсан тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

18.7. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшиг шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр гартал тухайн радио давтамжид шинээр тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгож болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг

19.1.Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь дараахь эрхтэй:

19.1.1.стандарт, техникийн нөхцөлийг хангаж, баталгаажуулсан радио төхөөрөмжийг сонгон ашиглах;

19.1.2.эрх олгосон радио давтамжийг энэ хуульд заасан нөхцөл, болзлын дагуу ашиглах, хамгаалах, харилцан нөлөөллийг арилгахыг шаардах;

19.1.3.энэ хуульд заасан журмын дагуу радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацааг сунгуулах, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх;

19.1.4.хуульд өөрөөр заагаагүй бол радио давтамж ашиглах талаар сонирхсон мэдээллийг радио давтамж зохицуулалт, хяналтын албанаас авах.

19.2. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

19.2.1 энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд радио төхөөрөмж импортлох, үйлдвэрлэх, худалдахыг сонирхогч этгээд радио давтамж зохицуулалт, хяналтын албатай радио давтамжийн талаар урьдчилан тохирох;

19.2.2.радио төхөөрөмжийг тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт заасан нөхцөл, хугацаа, зориулалтын дагуу ашиглах;

19.2.3.тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дараа жилийн төлбөрийг тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгосон тухайн ажлын өдрөөр тасалбар болгон жил бүр төлөх;

19.2.4.тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт заасан техникийн болон ашиглалтын нөхцөлд өөрчлөлт оруулах асуудлыг эрх олгосон байгууллагаар шийдвэрлүүлэх;

19.2.5.бусад радио холбоо, радио төхөөрөмжид харилцан нөлөөлөл үүсгэхгүй байх;

19.2.6.олон улсын хэмжээнд хэрэглэдэг ачуулын дохио (SOS, MAYDAY зэрэг) бусад радио станцаас ирсэн тохиолдолд энэ тухай холбогдох газарт даруй дамжуулах, мэдэгдэх;

19.2.7. тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацаа дуусгавар болсон буюу тэдгээрийг цуцалсан тохиолдолд радио станцынхаа антенныг буулгах;

19.2.8.зөвхөн зөвшөөрөгдсөн радио давтамж, давтамжийн зурваст ажиллах, өөрийн эзэмшилд байгаа радио төхөөрөмжийн гаралтын чадал, давтамжийг тогтмол хянаж байх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Хяналт

20.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг радио давтамж зохицуулалт, хяналтын алба болон харилцаа холбооны улсын байцаагч хэрэгжүүлнэ.

20.2. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь харилцан нөлөөллийг арилгах, хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хайх, илрүүлэх үйл ажиллагааг радио давтамж эзэмшигчийн үйл ажиллагаанд саад хохирол учруулахгүйгээр зохион байгуулна.

20.3. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь олон улсын стандартын дагуу лабораторитой байж болно.

20.4.Төлбөрөө төлөөгүй радио давтамж ашиглагчид хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн дүнгийн 0,3 хүртэл хувьтай тэнцэх алданги ногдуулна.

20.5.Радио долгионы тухай хууль тогтоомжийг зөрчсөн дараахь тохиолдолд радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох эрхийг радио давтамж зохицуулалт, хяналтын алба эдэлнэ:

20.5.1.радио төхөөрөмж нь стандарт, чанарын үзүүлэлт, техникийн нөхцөлийн шаардлага хангаагүй;

20.5.2.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг аваагүй, бүртгүүлээгүй;

20.5.3.төлбөр төлөөгүй, хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

20.5.4.бусад хэрэглэгчийн үйл ажиллагаанд харилцан нөлөөлөл үүсгэсэн, тэдний хэвийн ажиллагааг алдагдуулсан;

20.5.5.радио давтамж зохицуулалт, хяналтын албанд мэдэгдэлгүйгээр радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, давтамж болон ажиллах цагийн хуваарийг өөрчилсөн;

20.5.6.улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй;

20.5.7. радио төхөөрөмжийг зориулалтын бусаар ашигласан.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1. Радио долгионы тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд харилцаа холбооны улсын байцаагч буюу шүүгч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

21.1.1.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг аваагүй, бүртгэлгүйгээр радио төхөөрөмж ажиллуулсан иргэнийг 20000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.2.тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт зааснаас өөр зорилгоор радио төхөөрөмж ажиллуулсан, байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлт, нөхцөл, радио давтамжийг зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн иргэнийг 10000-40000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.3.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч энэ хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд хууль бусаар саад учруулсан гэм буруутай иргэнийг 10000-40000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.4.тусгай хэрэглээний зориулалтаар хуваарилагдсан давтамжийн зурваст ажилласан болон түүнд харилцан нөлөөлөл учруулсан иргэнийг 10000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.5.бусад радио холбоо болон радио төхөөрөмж хэрэглэгчдийн ажиллагаанд харилцан нөлөөлөл учруулсан, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, баталгаажуулаагүй төхөөрөмж ашигласан иргэнийг 10000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.6.улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй, хяналт шалгалт хийхэд нь саад учруулсан иргэнийг 10000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр торгох;

21.1.7.радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох, бүртгэх журмыг зөрчсөн албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь автотээвэрийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажилагаа болон автотээвэрийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээвэрийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Автотээвэрийн тухай хууль тогтоомж

2.1.Автотээвэрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын хуулийн этгээд, иргэн автотээвэрийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."автотээвэрийн хэрэгсэл" гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээвэрийн хэрэгслийг;

3.1.2."зорчигч" гэж автотээвэрийн хэрэгслийн бүхээг дотор, эсхүл түүний тэвшин дээр зорчиж байгаа хүнийг;

3.1.3."ачаа" гэж автотээвэрийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлсийг;

3.1.4 "тээвэрлэлт" гэж автотээвэрийн хэрэгслээр зорчигч болон ачааг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг;

3.1.5."тээвэрлүүлэгч" гэж тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгчийг;

3.1.6."тээвэрлэгч" гэж тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг;

3.1.7."улс хоорондын тээвэрлэлт" гэж Монгол Улсын хилийг нэвтрэн хийх тээвэрлэлтийг;

3.1.8."хот хоорондын тээвэрлэлт" гэж хот, аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин хийх тээвэрлэлтийг;

3.1.9."орон нутгийн тээвэрлэлт" гэж тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг;

3.1.10."хот доторх болон хот орчмын тээвэрлэлт" гэж тухайн хотын нутаг дэвсгэрт хийх тээвэрлэлтийг;

3.1.11."нийтийн тээвэр" гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн үйлчилгээний замын чиглэл, цагийн хуваарийн дагуу болон зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа зорчигч тээвэрлэлт, таксийн үйлчилгээг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Автотээвэрийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1. Монгол Улсын Их Хурал автотээвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.автотээвэрийн талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

4.1.2.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар олон улсын автотээвэрийн холбогдолтой гэрээ соёрхон батлах;

4.1.3.автотээвэрийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах.

[1] Монгол Улсын Үндсэн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны № 1-д нийтлэгдсэн.

5 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

5.1.Засгийн газар автотээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, бүх төрлийн тээврийн оновчтой бүтэц, тээвэрлэлтийн үр ашигтай нэгдсэн сүлжээг хөгжүүлэх;

5.1.2.автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

5.1.3.автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, автотээврийн улсын хяналтын дүрмийг батлах;

5.1.4.хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд хот хоорондох зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх.

6 дугаар зүйл.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.автотээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

6.1.2.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

6.1.3.нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам боловсруулж батлуулах, тусгай зөвшөөрөл олгох;

6.1.4.тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;

6.1.5.автотээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх ачаа, зорчигчдын хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай хоорондоо тохиролцох;

6.1.6.автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх.

6.2.Энэ хуулийн 6.1.3-т заасан журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь автотээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.нутаг дэвсгэртээ автотээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах;

7.1.2.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.3.автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;

7.1.4. нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;

7.1.5.хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тээвэрлэлт

8 дугаар зүйл.Тээвэрлэлтийн ангилал, зохицуулалт

8.1.Тээвэрлэлт нь түүнийг гүйцэтгэх нутаг дэвсгэрийн хүрээгээр улс хоорондын, хот хоорондын, орон нутгийн, хот доторх болон хот орчмын гэж ангилагдана.

8.2.Улс хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг олон

улсын тээврийн харилцааны гэрээг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд түүнийг автотээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага хэрэгжүүлнэ.

8.3.Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг автотээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага холбогдох аймгийн Засаг даргатай хамтран гаргаж хэрэгжүүлнэ.

8.4.Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төв, хотын дотоох болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл.Тээвэрлэлт гүйцэтгэх

9.1.Тээвэрлэлтийг Иргэний хууль[1] болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

9.2.Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл.Тээвэрлэгчийн эрх, үүрэг

10.1.Тээвэрлэгч нь дараахь эрх эдэлнэ:

10.1.1.автозамын байгууллагаас автозам, гүүрийг тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй байлгахыг шаардах, автозам, гүүрийн ашиглалтын нөхцөл хангаагүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

10.1.2.зорчих тасалбарыг урьдчилан авааруй буюу жолооч, кондуктор шаардахад тээврийн хөлс төлөхгүй байгаа зорчигч, мөн тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бэлтгээгүй ачаат тээвэрлэхээс татгалзах;

10.1.3.нийтийн тээврийн хэрэгслийн жолооч, кондуктор нь зорчигчид нийгмийн хэв журам сахих, тээврийн үйлчилгээний дүрэм, журмыг биелүүлэх шаардлага тавих.

10.2.Тээвэрлэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

10.2.1.өөрийн тээвэрлэлтийн үйлчилгээний талаархи үнэн зөв мэдээллээр тээвэрлүүлэгчийг хангах, зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаанд аюул, хохирол учруулахгүй байх ;

10.2.2.зорчигчийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх;

10.2.3.нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэхдээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагатай тохиролцсон цагийн хуваарь, чиглэлийг баримтлах;

10.2.4.өөрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ, үйл ажиллагааны мэдээ, тайланг тогтоосон үзүүлэлт, загвараар хугацаанд нь тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад гаргаж өгөх;

10.2.5. автозам, замын байгууламжийг техникийн нөхцөл шаардлагын дагуу ашиглах;

10.2.6.автотээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагыг хангах;

10.2.7.автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолооч нь автотээврийн хэрэгслийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан, зориулалтын, зөвшөөрөгдсөн байр, зогсоол, талбайд тавих.

11 дүгээр зүйл.Тээвэрлүүлэгч, зорчигчийн эрх, үүрэг

11.1.Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь эрх эдэлнэ:

11.1.1.тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;

11.1.2. нийтийн тээврийн тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;

11.1.3.тээвэрлэлтийн үнэ тариф, замын чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь, ачаа хүргэх хугацааны талаар үнэн зөв мэдээлэл авах;

11.1.4.тээвэрлэлтийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өвчлөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар худал-

[1] Иргэний хууль. -"Ардын эрх" сонины 1994 оны 12 дугаар сарын ЗО-ны өдрийн 258; 1995 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1; 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2; Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны № 4-т тус тус нийтлэгдсэн.

дан авсан зорчих тасалбарт заасан чиглэлд зорчиж чадахгүй болсон буюу хүрэх газартаа хүрээгүй буусан тохиолдолд замын үлдсэн хэсэгт ногдох тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцааж авах;

11.2.Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь үүрэг хүлээнэ:

11.2.1.ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх;

11.2.2.ачаар ачих, буулгах зам, талбайг автотээврийн хэрэгсэл явахад саадгүй байлгах;

11.2.3.ачих, буулгах машин механизм, нэмэгдэл төхөөрөмж, хүн хүчийг бэлэн байлгаж ачаар тогтоосон хугацаанд ачих, буулгах, өөрийн хаягтай буюу гэрээт ачаар хүлээн авах;

11.2.4.ачаар тээвэрлэх, хадгалах тухай мэдээллээр тээвэрлэгчийг хангах;

11.2.5.ачаар ачсан, хүлээн авсан тухайгаа тээврийн баримт бичигт тэмдэглэж баталгаажуулан тээвэрлэгчид олгох;

11.2.6.нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь зорчих_тасалбарыг худалдан авах;

11.2.7.нийтийн тээврээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;

11.2.8.нийтийн тээврээр зорчихдоо автотээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй байх;

11.2.9.зорчигч нь улс, хот хооронд, орон нутагт зорчихдоо иргэний паспорт, холбогдох бусад баримт бичиг, зорчих тасалбарыг биедээ авч явах, тэдгээрийг жолооч, кондуктор болон шалгах эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар үзүүлэх.

12 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үнэ, хөнгөлөлт

12.1.Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ хөлсний хэмжээг оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно.

12.2. Нөхөх олговор олгосны үндсэн дээр хотын доторх нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр хөнгөлөлттэй буюу үнэ төлбөргүйгээр зорчигчийг тээвэрлэж болно. Нөхөх олговрыг тухайн иргэнд олгосон тохиолдолд нийтээр мөрдөж байгаа үнэ тарифыг хэрэглэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-д заасан нөхөх олговрыг олгох журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

12.4.Тээвэрлэгч нь автотээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих хөлсийг төлсөн зорчигчид энэ хуулийн 16-д заасан журмын дагуу хэвлэсэн зорчих тасалбар олгоно.

13 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийн дайчилгаа

13.1.Автотээврийн хэрэгслийг хууль тогтоомжид заасны дагуу дайчилж болно.

13.2.Хууль тогтоомжид зааснаас бусад нөхцөлд автотээврийн хэрэгслийг дайчлахыг хориглоно.

14 дүгээр зүйл.Тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах

14.1.Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гал түймэр зэрэг гэнэтийн аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг дараахь эрх бүхий албан тушаалтан гаргаж нийтэд мэдээлнэ:

14.1.1.улс, хот хоорондын тээвэрлэлтийн чиглэлд улсын байнгын онцгой комиссын шийдвэрийг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

14.1.2.орон нутгийн тээвэрлэлтийн чиглэлд нийслэл, тухайн аймаг, сумын Засаг дарга.

14.2. Хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр тээвэрлэлтийн ажлыг зогсоох, хязгаарлах, автотээврийн хэрэгслийг саатуулахыг хориглоно.

15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл

15.1.Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тусгай зөвшөөрөл олгоно.

15.2.Улс хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

15.3.Хот хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг автотээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага олгоно.

15.4.Аймаг хооронд, орон нутаг, хотын доторх болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн аймаг, сумын Засаг дарга олгоно.

15.5.Энэ хуулийн 6.1.3-д заасан тусгай зөвшөөрөл олгох журамд дараах шаардлага, нөхцөлийг тусгана:

15.5.1.тусгай зөвшөөрөл авахыг сонирхогч этгээдэд тээвэрлэлтийг болон техникийн хяналтын үзлэгийг бүрэн, үнэн зөв гүйцэтгэх санхүү эдийн засаг, мэргэжлийн боловсон хүчний чадавхи, үйл ажиллагааны үндсэн чиглэл, нэвтрүүлэх технологи, тээвэрлэн хэргэсэл, ажлын байр, тоног төхөөрөмжийн талаар тавих шаардлага;

15.5.2.тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах, түүнд хавсаргах баримт бичиг, тэдгээрийг хянаж шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, дуусгавар болгох, цуцлах үндэслэл;

15.5.3.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг.

15.6.Энэ хуулийн 15.2; 15.3; 15.4-т заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулж ажиллана.

15.7.Нийтийн тээврийн тодорхой чиглэл, ангилалыг заасан үйлчилгээ болон тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэхээр хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд, уг ажил, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг харгалзан сонирхогчдыг сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрлийг олгож болно.

15.8.Тээвэрлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан нийтийн тээврийн үйлчилгээг бүрэн хангаж чадахгүй байгаагаас бусад тохиолдолд түүний тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд өөр аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд адил нөхцөлөөр тухайн тээвэрлэлтийн чиглэлд тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

16 дугаар зүйл.Тээвэрлэлтийн баримт бичиг

16.1. Автотээврийн хэрэгслээр зорчих тасалбар, ачааны дагалдах хуудас зэрэг тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт, стандартчилал

17 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт

17.1.Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жил бүр техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно.

17.2.Техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй автотээврийн хэрэгслийг /байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

17.3.Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг автотээврийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

18 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийн стандартчилал

18.1.Автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон улсын стандартыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн стандартчиллын төв байгууллага батална.

19 дүгээр зүйл.Автотээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх

19.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа автотээврийн болон замын хөдөлгөөнд оролцдог өөрөө явагч хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загварыг автотээврийн болон гэгээрлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

20 дугаар зүйл.Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоо

20.1.Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

20.2.Автотээврийн салбарт захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч нь автотээврийн үйлчилгээнд мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах үүрэгтэй ажиллана.

20.3.Автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийг Монгол Улсын автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

20.4.Автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж чөлөөлнө.

20.5.Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын автотээврийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндэсн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

20.6.Төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан тэдгээрт автотээврийн хяналтын улсын байцаагчийг ажиллуулж болно.

20.7.Энэ хуулийн 20.6.-д заасан улсын байцаагчийг автотээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндэсн дээр тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

21 дүгээр зүйл.Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх чиглэл

21.1.Автотээврийн хэрэгслийг ашиглах, тээвэрлэлтийн үйлчилгээг хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэхтэй холбогдсон захиргааны хяналтыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

21.1.1. хууль тогтоомж, түүнд нийцүүлж автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан стандарт, дүрэм, журмыг сахиулах;

21.1.2.автотээврийн хэрэгслийн техникийн хяналт, нийтийн тээвэр эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан үүргийн биелэлтийг хангуулах;

21.1.3.улсын захиалга, даалгавар, цаг үеийн шуурхай тээвэрлэлтийг хэрэгжүүлэх;

21.1.4.нийтийн тээврийн чиглэл, цагийн хуваарь, үйлчилгээний жүрмыг мөрдүүлэх;

21.1.5.автотээврийн хэрэгслийн ашиглалтын шаардлага, тээвэрлэлтийн нөхцөлийг хангуулах, тээвэрлэлтийн баримт бичгийн бүрдүүлэлтийг зохих шаардлагын дагуу гүйцэтгүүлэх;

21.1.6. тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигчийн үүргийн биелэлтийг хангах;

21.1.7.автозам, замын байгууламж, шатахуун, тосолгооны материалын чанар нь автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

22 дугаар зүйл.Автотээврийн хяналтын улсын байцаагчийн эрх

22.1.Автотээврийн хяналтын улсын байцаагч нь дараахь эрх эдэлнэ:

22.1.1.энэ хуулийн 21-д заасан чиглэлийн дагуу хяналт, шалгалт хийж захиргааны хяналтыг хэрэгжүүлэх;

22.1.2. Төрийн хяналт шалгалтын тухай хууль[1], Захиргааны хариуцлагын тухай хууль[2] болон бусад хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

22.1.3. хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ автотээврийн хэрэгслийг түр зогсоож шалгах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тухайн автотээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэх, талон, тээвэрлэлтийн баримт бичгийг уг зөрчлийг шийдвэрлэж дуустал түр хураах;

22.1.4. автозам, замын байгууламж нь нийтийн тээврийн үйлчилгээг саатуулсан, автотээврийн хэрэгсэл болон ачаа бараанд гэмтэл учруулсан зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох автозамын байгууллага, аж ахуйн нэгжид албан шаардлага өгч, зөрчлийг арилгуулах;

22.2.Автотээврийн хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах техник хэрэгслээр хангагдана.

22.3.Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[1] Төрийн хяналт шалгалтын тухай хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны № 4-т нийтлэгдсэн.

[2] Захиргааны хариуцлагын тухай хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны №4,5-д нийтлэгдсэн.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Автотээврийн тухай хууль тогтоомж дараахь байдлаар зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол автотээврийн хяналтын улсын байцаагч буюу шүүгч гэж бууруулах эгтээдэд дор дурдсан шийтгэл ногдуулна:

23.1.1.энэ хуулийн 10.2, 11.2.1, 11.2.2; 11.2.3, 11.2.4, 11.2.5, 12.4, 15.6, 17.2 дахь заалтыг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, иргэнийг 5000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

23.1.2.энэ хуулийн 11.2.6, 11.2.7, 11.2.8; 11.2.9 дахь заалтыг зөрчсөн иргэнийг 1000-5000 төгрөгөөр торгох;

23.1.3.энэ хуулийн 15.2; 15.3; 15.4-т заасан тусгай зөвшөөрөлгүйгээр автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн жолоочийг 10000-30000 төгрөгөөр торгож, тухайн үйлчилгээнээс олсон орлогыг хураах;

23.1.4.энэ хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтныг 1000-60000 төгрөгөөр, иргэнийг 1000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 4, 6, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Автотээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр **Улаанбаатар хот**

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай

2 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 37** **Улаанбаатар хот**

Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 09-ний өдөр **Дугаар 100** **Улаанбаатар хот**

Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн гишүүнээс Ж.Амарсанаар чөлөөлж, хууль зүйн сайд Л.Цогийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 09-ний өдөр **Дугаар 102** **Улаанбаатар хот**

Жонни Балтзерсенийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол улсын бага, дунд боловсролын салбарт хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулж, сургалтын арга зүйг боловсронгуй болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монголын бага, дунд боловсролын салбарыг дэмжих Монгол-Данийн хамтарсан төсөл"-ийн Данийн талын зохицуулагч Жонни Балтзерсенийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 09-ний өдөр **Дугаар 104** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүст албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын "Төрийн албаны тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн захиргааны тэргүүн тушмэлийн албан тушаалын зэрэг дэв олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол улсын Ерөнхийлөгчийн
1999 оны 104 дүгээр зарлигийн
хавсралт

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОСОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Ажилласан хугацаа		Үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингийн үнэлгээ	Албан тушаалын зэрэг дэв
				төрийн албанд	тухайн албанд		
1	Рэгсүрэнгийн Бат-Эрдэнэ	ГЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	17	3	А	гутгаар зэрэг
2	Цэрэнбалжирын Бүжинлхам	Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн дарга	ТЗ-12	35	1	Б	дэд зэрэг
3	Дуламын Сугар	ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	18	3	Б	гутгаар зэрэг
4	Равсалын Ринчинбазар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	ТЗ-13	17	2	А	гутгаар зэрэг
5	Чулууны Батжаргал	Төрийн ёслолын албаны дарга	ТЗ-12	26	11	Б	тэргүүн зэрэг
6	Даваадоржийн Дэлгэрцогт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлагын газрын дарга	ТЗ-12	15	2	А	дөтгөөр зэрэг
7	Даваагийн Басандорж	БОЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	10	3	А	дөтгөөр зэрэг
8	Очирын Очиржав	ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	15	3	Б	дөтгөөр зэрэг
9	Галсангийн Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга	ТЗ-13	10	1	А	гутгаар зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 5-ны өдөр | **Дугаар 74** | **Улаанбаатар хот**

Бэрхийн уулын үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9,58 дугаар зүйл, Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн Зөвлөлийн ээлжит бус XXYI хурлын протоколын 6.2 дугаар заалтын дагуу Бэрхийн уулын үйлдвэрийг Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн бүрэлдэхүүнээс гаргаж, Монголын талд иж бүрнээр нь шилжүүлэн өгч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газрыг 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн байгуулагдсанаар тооцсугай.

2."Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг 1 дүгээр хавсралтын ёсоор батлалсугай.

3.Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод даалгах нь:

а/бүтээгдэхүүний өртөг зардлыг хямдруулах зорилгоор "Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газарт "Чандган талын нүүрсний уурхай" төрийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэн, удирдлага зохион байгуулалтын шинэ бүтцэд шилжүүлэн аж ахуйн тооцоон дээр ажиллуулах арга хэмжээ авсугай;

б/"Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газрыг цаашид менежментийн хэлбэрээр хувьчлах нь зүйтэй гэж үзэж, холбогдох саналыг боловсруулж Засгийн газарт оруулсугай;

в/Бэрхийн уулын үйлдвэрийн нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламжуудыг 2 дугаар хавсралтын ёсоор Хэнтий аймгийн Бэрх хотын Захирагчийн албанд хүлээлгэн өгсүгэй;

г/Бэрхийн уулын үйлдвэр ажиллах хугацаанд тэтгэвэрт гарсан, мөн үйлдвэрлэлийн хүнд нөхцөлөөс шалтгаалан группэд орсон 286 хүний нийгмийн хамгаллын асуудлыг 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгож урьд өмнө мөрдөж байсан журмын дагуу "Монголросцветмет" нэгдэл хариуцаж байх асуудлыг Хамтарсан үйлдвэрийн Зөвлөлийн ээлжит хуралд тавьж шийдвэрлүүлж ажилласугай.

4.Бэрхийн уулын үйлдвэрийн нийгэм-соёлын зориулалттай объектуудыг санхүүжүүлэхэд шаардагдах 350,0 /гурван зуун тавин/ сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт нэмж тусгаж, энэ хэмжээгээр Хэнтий аймгийн 1999 оны татаасыг нэмэгдүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

5.Өндөрхаан-Бэрхийн хоорондох 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг Бэрх хотын дизель станц, барилга байгууламж, цахилгаан хангамжийн шугам сүлжээний хамт Дэд бүтцийн хөгжлийн яамны Эрчим хүчний удирдах газарт шилжүүлсүгэй.

6.Өндөрхаан-Бэрхийн хоорондох 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг барьж байгуулахад "Монголросцветмет" нэгдлээс оруулсан 974 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг "Монголросцветмет" нэгдлээс улсын төсөвт төлөх орлогоос 5 жилийн хугацаанд суутган тооцох гэрээ байгуулах замаар шийдвэрлэхийг Сангийн сайд Я.Очирсүх, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Эрчим хүчний удирдах газрын дарга Г.Ёндонгомбо нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

САНГИЙН САЙД Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 74 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"БЭРХ-УУЛ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Ашигт малтмалын олборлолт, хайгуул, худалдаа, үйлчилгээний үндсэн чиглэлтэй ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах "Бэрх-уул" нэртэй төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид "Бэрх-уул" үйлдвэрийн газар гэх/ -ын үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

2."Бэрх-уул" үйлдвэрийн газрын албан ёсны хаяг: Хэнтий аймаг Батноров сумын 7 дугаар баг "Бэрх" хот.

Хоёр. Эрх хэмжээ

3."Бэрх-уул" үйлдвэрийн газар нь энэхүү дүрэмд заасан болон хуулиар олгосон эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд шүүх, арбитрт нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

4."Бэрх-уул" үйлдвэрийн газар нь ашигт ажиллагааны зорилтот түвшинг тодорхойлсон урт болон ойрын хугацааны бизнес төлөвлөгөөг холбогдох яамаар хянуулж, Төрийн өмчийн хороогоор батлуулан ажиллана.

5.Үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, сэлбэг, шатах тослох материалаа бие даан бэлтгэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ борлуулалтыг хариуцна.

6.Өөрийн хөрөнгө, эзэмшилд байгаа төрийн өмчийг хэмжих, ашиглах, захиран зарцуулахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.Үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хууль тогтоомжийн дагуу татвар төлж эрх бүхий байгууллагаас батлагдсан нормативын дагуу өөрт үлдэх ашгийг захиран зарцуулна.

8."Бэрх-уул" үйлдвэрийн газар нь өөрийн тэмдэг, билэгдэл, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл

9."Бэрх-уул" үйлдвэрийн газар нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхээр дараахь үйл ажиллагааг явуулна:

а/ ашигт малтмалын олборлолт, хайгуул;

б/ дотоод, гадаад худалдаа;

в/ хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагаа.

10.Эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүн нь улсын чанар, стандартын шаардлагыг хангасан байна.

11.Үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл хэлбэрийг өөрчлөхдөө тухай бүр Төрийн өмчийн хороо болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийг авна.

12.Хэрэв шаардлагатай бол өөрийн үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх зорилгоор үйлдвэрийн салбар, төлөөлөгчийн газыг Төрийн өмчийн хорооны зөвшөөрлөөр байгуулан ажиллуулна.

Дөрөв. Дүрмийн сан

13."Бэрх-уул" үйлдвэрийн газрын дүрмийн сан нь зөвхөн төрийн өмчийн эд хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ нь 5547794000 /таван тэрбум таван зуун дөчин долоон сая долоон зуун ерэн дөрвөн мянган/ төгрөг байна. Үүнээс:

а/үндсэн хөрөнгө нь 5220365000 /таван тэрбум хоёр зуун хорин сая гурван зуун жаран таван мянган/ төгрөгний хэмжээтэй;

б/эргэлтийн хөрөнгө нь 327429000 /гурван зуун хорин долоон сая дөрвөн зуун хорин есөн мянган/ төгрөгний хэмжээтэй.

14.Хэрэв дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх шаардлагатай бол Төрийн өмчийн хорооны шийдвэрийг удирдлага болгоно.

Тав. Удирдлага

15."Бэрх-уул" үйлдвэрийн газрын удирдах байгууллага нь "Удирдлагын зөвлөл" байна. Удирдлагын зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг Төрийн өмчийн хороо томилно.

16.Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд Гүйцэтгэх захирал удирдана.

17.Гүйцэтгэх захирал нь Төрийн өмчийн хороотой гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд дараахь нөхцөлүүдийг тусгана:

-үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн түвшин тогтоох;

-техник, технологийг сайжруулах, шинэчлэх даалгавар;

-хамт олны хөдөлмөр, нийгмийн асуудлын талаар авах арга хэмжээ;

-менежмент, маркетингийн бодлого;

-захирал болон Төрийн өмчийн хорооны хүлээх үүрэг;

-үйлдвэрт өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ, эд хөрөнгийн хариуцлага;

-ажлын нөхцөл, нэмэгдэл цалин, урамшуулал;

-гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, түүний хугацаа;

-бусад нөхцөлүүд.

18. Гүйцэтгэх захирал нь дараахь бүрэн эрхтэй:

-үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

-үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг хууль тогтоомж, гэрээ, дүрэмд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

-үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож батлуулах, албан тушаалтныг томилох, чөлөөлөх;

-ажиллагсдын цалин, шагнал урамшууллын журмыг тогтоон мөрдөх;

-эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тусгасан зорилтот бизнес төлөвлөгөөг холбогдох газруудтай хамтран боловсруулах ажлыг зохион байгуулж, Төрийн өмчийн хороогоор батлуулан, биелэлтийг хангах;

-боловсон хүчний бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;

-үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох;

-үйлдвэрийн дотоод журмыг боловсруулан мөрдүүлэх;

-тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулан тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

-улсаас чиглэл өгч тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифыг тогтоох;

-эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх зорилгоор тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газарт даган мөрдөх тушаал, заавар гаргах;

-гадаадад томилолтоор ажиллах төсөв, удирдамжаа батлуулан тайлагнах.

19."Бэрх-уул" үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлогтой холбоотой бусад бүрэн эрхийг гүйцэтгэх захиралд эдлүүлэх талаар гэрээнд тусгаж болно.

20.Гүйцэтгэх захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулж болох бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар баталж мөрдөнө. Зөвлөлийн гишүүд нь гүйцэтгэх захиралд зөвхөн зөвлөх эрхтэй байна.

21.Захирал өөрийн гэм бурууташ үйл ажиллагаагаараа хууль болон гэрээнд заасан эрхээ хэтрүүлсэн буюу урвуулан ашигласан зэргээр үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмч, хөрөнгөөр бүрэн хариуцна.

Зургаа. Эдийн засгийн үйл ажиллагаа,
бүртгэл, хяналт

22."Бэрх-уул" үйлдвэрийн газрын эдийн засгийн үйл ажиллагаа нь жил бүрийн үйлдвэрлэл, түүний үр ашиг, орлогыг тодорхой тусгаж, зохих газруудаар батлуулсан зорилтот бизнес төлөвлөгөөний дагуу явагдана.

23.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

24.Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу ногдол ашгийг тооцон төсөвт оруулна.

25.Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж Төрийн өмчийн хороо, татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

26.Тогтоосон журам, загварын дагуу Төрийн өмчийн хороонд мэдээ тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлнэ.

27.Ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн,3-аас доошгүй жил нягтлан бодогчоор ажиллаасан байх бөгөөд түүнийг Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.

28.Гүйцэтгэх захирал өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих өдөр тутмын дотоод хяналтыг зохион байгуулж, үр дүнг хариуцна.

29.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хөдөлгөөнд бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

30.Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий тушаалтны шийдвэрээр тавьж олгох үүргийг захирлын тушаалаар томилогдсон эд хариуцагч хүлээнэ.

31.Эд хөрөнгийн дотоод тооллогыг зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан журмын дагуу үйлдвэрийн газрын захиргаа явуулж тайлан тэнцэлд тусгана.

Долоо. Өөрчлөх, татан буулгах

32. Үйлдвэрийн газрыг холбогдох яам болон Төрийн өмчийн хорооны санал болгосноор Засгийн газар өөрчлөх ба татан буулгана.

33.Үйлдвэрийн газрыг татан буулгахад Иргэний хууль болон хууль тогтоомжийн бусад актад заасан журмыг баримтална.

Засгийн газрын 1999 оны 74 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНД ХУЛЭЭЛГЭН ӨГӨХ БЭРХИЙН УУЛЫН ҮЙЛДВЭРИЙН НИЙГЭМ-СОЁЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ Үнэ/мян.төг/

№	Үзүүлэлт	Барилга	Тоног төхөөрөмж	ДҮН
1	Эмнэлэг	144600.0	7573.0	152173.0
2	Ясли, цэцэрлэг	112667.0	1539.0	114206.0
3	10 жилийн сургууль	106159.0	3509.0	109668.0
4	Соёлын ордон	189156.0	3874.0	193030.0
5	Орос сургууль	41871.0		41871.0
6	Гал команд	3528.0		3528.0
7	Оша /цэцэрлэг/	64613.0		64613.0
8	Хотын захиргаа	33767.0		33767.0
	ДҮН	696361.0	16495.0	712856.0

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Дугаар 73 **Улаанбаатар хот**

Заавар, журам батлах тухай

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн1, Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн
5 дугаар зүйлийн 3, 6 дугаар зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 3,5 -д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Тээврийн хэрэгслийг албадан зогсоох заавар" -ыг 1, "Тээврийн хэрэгслийг түр саатуулах журам"-ыг 2, "Тээврийн хэрэгслийн тоо бүртгэлийг хөтлөх, улсын дугаар олгох журам"-ыг 3, "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ыг 4, "Жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам" -ыг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 1991 оны б/ 243, 1996 оны 189 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л.ЦОГ

Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Зөвшөөрөв. Монгол Улсын ерөнхий прокурор төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Н.Ганбаяр

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АЛБАДАН ЗОГСООХ ЗААВАР

1.Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан тээврийн хэрэгсэл албадан зогсооход галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэхэд энэхүү зааврыг удирдлага болгоно.

2. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох зорилгоор ашиглах дохио, багаж, эд зүйл, зэвсэг хэрэгслийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ. Үүнд:

а/ цагдаагийн байгууллагын алба хаагчаас тээврийн хэрэгслээ зогсоох талаар жолоочид шүгэл , дохиур модоор өгсөн ойлгогдохуйц дохио, марк, дугаар, өнгийг зааж чанга яригчаар тавьсан зогсох шаардлага;

б/ тээврийн хэрэгслээр хөөж, хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг гүйцэж зэрэгцэн очиж зогсох дохио өгч замын зах руу шахан урдуур хөндлөн зогсож хаах;

в/ автомашины дугуй хагалах зориулалттай багаж " зараа" зугатаж яваа тээврийн хэрэгслийн замд тавьж дугуйг хагалан зогсоох;

г/ ачааны авто машин , трактор , чиргүүл болон бусад саад хийх зүйлийг ашиглан зам дээр хөндлөн тавьж хаалт хийж зогсоох;

д/ галт зэвсэг хэрэглэн зогсоох эдгээр болно.

3.Тээврийн хэрэгслийг албадан зогсоохоос тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ.

а/ цагдаагийн байгууллагын алба хаагчаас жолоочид тээврийн хэрэгслээ зогсоох талаар өгсөн ойлгогдохуйц дохио, шаардлагыг биелүүлээгүй, сэжигтэй байдлаар зугатсан;

б/ гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтан өөрөө жолоодон зугатсан, эсвэл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан , мөн онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газраас зугатан зайлахдаа тээврийн хэрэгслийг ашигласан, эсхүл дээрэмдэх, барьцаалах хэлбэрээр авч яваа тухай цагдаагийн байгууллагаас зарлан мэдээлсэн;

в/ хулгайд алдагдсан тухай зарлагдсан тээврийн хэрэгслийг жолоодож яваа болон хулгайд алдагдсан эд зүйлийг тээвэрлэн зугатсан;

г/ хүний амь нас , эрүүл мэндэд бодит аюул учруулж болзошгүй яваа жолоочийн үйл ажиллагааг таслан зогсоох;

4. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох үндэслэл нь энэ зааврын 3 дугаар зүйлийн а, б, в, г -д заасан тээврийн хэрэгслийг зогсоох талаар цагдаагийн албан хаагчаас жолоочид ойлгогдохуйцаар өгсөн дохио, шаардлагыг мэдэж, харсаар байгаад зогсоогүй, зугатсан үйл ажиллагаа болно.

5. Цагдаагийн байгууллагын албан хаагч нь тээврийн хэрэгслийг албадан зогсоохдоо доорхийг удирдлага болгоно.

а/ жолоочид тээврийн хэрэгслээ зогсоох талаар өгсөн ойлгодохуйц дохио, шаардлагыг мэдэж, харсаар байтал биелүүлээгүй зугатсан тээврийн хэрэгслийн марк, дугаар, өнгийг тухайн тээврийн хэрэгсэл явсан чиглэлд ажиллаж байгаа байгын болон түр постод радио станц; холбоогоор мэдээлж зогсоож саатуулах арга хэмжээг авахуулна;

б/ тээврийн хэрэгслээр хөөж зогсоох шаардлагатай бол зугатсан тээврийн хэрэслийн чиглэлийн дагуу ойртон ирж яваа тээврийн хэрэгслийг зогсоон суух, аль чиглэлд яваа, ямар марк, дугаартай, ямар өнгийн тээврийн хэрэгслийн араас хөөх тухайг жолоочид хэлж, хурдыг тохируулах, болзошгүй аюул, ослоос сэргийлэхийг анхааруулж, аюулгүй байдлыг хангуулна.

Харин дипломат төлөөлөгчийн болон албан тушаалын, түүнчлэн түүргэ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламжийн, гал унтраах албаны, техникийн ослын дуудлагын автомашин болон өндөр настан, нялх балчир хүүхэд, өвчтэй хүмүүс тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг дайчлахгүй.

Дайчлахаар зогсоосон тээврийн хэрэгсэлд жолоочоос өөр бусад зорчигч яваа бол тэдгээрийг буулгасан байна.

Тээврийн хэрэгслийг хөөж яваа тухайгаа цагдаагийн байгууллагын жижүүр, чиглэлийн дагуух пост, эргүүлд радио станц, холбооны хэрэгсэлээр мэдэгдэнэ.

Зугатсан тээврийн хэрэгслийг бусад тээврийн хэрэгслээр хөөж зогсоохдоо хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг гүйцэж хэрэгцээ эгнээнд орох үедээ жолоочийн нь тээврийн хэрэгслээ зогсоохыг дохиогоор болон чанга яригчаар мэдэгдэхүйц өгч, хөөж яваа тээврийн хэрэгслээр замын зах руу шахах үйлдлийг хийж урд нь орж хааж зогсооно.

Гэхдээ хөөгдөж яваа тээврийн хэрэгслийг хурдаа сааруулж, зогсох боломжийг ойлгохуйц зайнд өгч зогсоох нь зүйтэй.

Тээврийн хэрэгсэл ашиглан зугатаж яваа этгээд галт хэвсгээр эвдэсгэлсэн, түүнийгээ хэрэглэх магадлалтай, эсвэл жолоочийг юмуу өөр бусад гэмгүй хүмүүсийг барьцаалан амь насанд нь илтээр аюул заналхийлж яваа гохиолдолд цагдаагийн байгууллагын дарга, кижүүрт радио станц, холбоогоор мэдэгдэж, түүний шийдвэрээр ажиллана;

в/ тээврийн хэрэгслийн дугуйг хагалах багаж "зараг" -г ашиглахдаа зугатаж яваа тээврийн хэрэгслийн өмнө зам дээр өнөдлөн буюу дагуу хэлбэрээр сунгаж байрлуулна;

г/ ачааны автомашин , трактор, чиргүүл, болон бусад саад хийх зүйлээр хаалт хийж тээврийн хэрэгслийг албадан зогсооходоо албадан зогсоох гэж байгаа тээврийн хэрэгслийн замыг үгтуулан ачааны автомашин, тракторын толгой / бүхээгний / -н хэсгийг замын гадна талруу харуулж рам , тэвшээр нь хоёр талаас уулзуулах маягаар зам дээр хөндлөн хаалт хийнэ.

Хаалтад тавигдсан тээврийн хэрэгслийн бүхээгт жолооч зорчигч байлгахыг хоригломо.

Зугатаж яваа тээврийн хэрэгслийн өмнө дугуй хагалах багаж "зараа" болон тээврийн хэрэгслээр хаалт хийсэн тохиолдолд ойролцоо нь цагдаагийн алба хаагчийг байрлуулж тойрч гарах боломжийг хаалгахын зэрэгцээ зугатаж яваа этгэдэл урьдчилан сануулж, зогсох дохиог өгүүлнэ.

Замын хаалт, хаплагад тавигдах зүйл нь алсаас харагдахаар овор хэмжээтэй байвал зохино;

д/ галт зэвсэг хэрэглэн албадан зогсоохдоо зөвхөн энэ журмын 3-ын "Б", "Г" -д заасан тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг жолоодож яваа этгэдэд урьдчилан сануулсны дараа хэрэглэж, галт зэвсэг хэрэглэхдээ хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас сэргийлэх, аль болох хүнгүй, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнгүй замд хэрэглэх нь зүйтэй.

6. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох " зараа " болон тээврийн хэрэгсэл, эд зүйлээр хаалт хашлага, галт зэвсэг хэрэглэсэн тухай бүрт / хэдэн сарын хэдний өдрийн хэдэн цаг хэдэн минутад, хаана, ямар зайнд, ямар марк, дугаар өнгийн тээврийн хэрэгслийг юуны учир албадан зогсооход хэрэглэсэн, уг багаж, хэрэгслийг ямар албан тушаалын, хэний шийдвэрээр хэрэглэсэн тухай / тэмдэглэл үйлдэж 24 цагийн дотор прокурорт танилцуулна.

7.Тээврийн хэрэгслийг хөөхөд ашигласан тээврийн хэрэгслийн жолоочид уг автомашин дайчлан ашигласан алба хаагч ЦЕГ-ын даргын 1996 оны 313 дугаар тушаалаар батлагдсан " Замын хөдөлгөөний хяналтын байцаагчаас хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгах журмын 6 дугаар бүлгийн 38 дугаар зүйлд зааснаар авто тээврийн хэрэгслийг дайчилж ашигласан тухай" тэмдэглэл үйлдэж өгнө.

8. Зугатсан тээврийн хэрэгслийг хөөж явсны улмаас хөвсөн жолооч болон цагдаагийн байгууллагын алба хаагчид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

Хууль зүйн сайдын 1999 оны
73 тоот тушаалын 2 дугаар
хавсралт

Зөвшөөрөв. Монгол Улсын ерөнхий прокурор
төрийн хууль цаазын төргүүн
зөвлөх Н.Ганбаяр

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТҮР СААТУУЛАХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл:

1. Монгол улсын хуульд заасан үндэслэлээр саатуулахаар шилжүүлсэн тээврийн хэрэгслийг цаашид" саатуулагдсан тээврийн хэрэгсэл" гэнэ. Хүлээн авч, шийдвэрийг хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын харьяанд байгаа нэгжийг "тээврийн хэрэгсэл түр саатуулах байр" гэнэ.

2. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байр нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүтцэд багтан, Замын цагдаагийн албаны өдөр тутмын удирдлагад ажиллана.

3. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны үйл ажиллагаанд Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, бусад хууль тогтоомж, энэ журмыг мөрдөнө.

4. Хууль тогтоомж зөрчсөн тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтны тэмдэглэл нь тээврийн хэрэгслийг түр саатуулах үндэслэл болно.

5. Энэ журам нь өмчийн ялгаа харгалзахгүй бүх төрлийн тээврийн хэрэгсэлд хамаарна.

6. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байр нь байнгын харуул, хамгаалалттай байна. Харуул хамгаалалт нь энгийн болон гэрээт байж болно. Уг байр нь галын аюулгүй байдлыг хангасан байхын зэрэгцээ нормативын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлтэй байна.

Тээврийн хэрэгсэл түр саатуулах үндэслэл:

7. Дараах үндэслэлээр тээврийн хэрэгслийг түр саатуулж болно.

Үүнд:

а/ гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, учирсан хохиролыг арилгах зорилгоор цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлалт зарласан тээврийн хэрэгсэл;

б/ шаардлагатай гэж үзсэн зам тээврийн осол, гэмт хэрэгт өртсөн хэрэгсэл;

в/ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн жолоочийн жолоодсон тээврийн хэрэгсэл;

г/ эрхийн үнэмлэхтэй боловч түүнийг авч яваагүй, эрхийн үнэмлэхгүй буюу ангилал тохирохгүй үнэмлэхтэй хүн жолоодсон тээврийн хэрэгсэл;

д/ улсын дугааргүй, техникийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэргүй техникийн улсын үзлэг тооллогод ороогүй тээврийн хэрэгсэл;

е/ техникийн стандартын шаардлага хангахгүй бүрэн бус, эсхүл хүрээлэн байгаа орчныг бохирдуулсан.

Тээврийн хэрэгслийг түр саатуулах байранд хүлээн авах журам

8. Эрх бүхий албан тушаалтан тээврийн хэрэгслийг түр саатуулах үндэслэлээ нийслэл хотод Замын цагдаагийн газрын жижүүрт, аймагт цагдаагийн газар, хэлтсийн жижүүрт танилцуулна.

9. Цагдаагийн байгууллагын жижүүр уг тээврийн хэрэгслийг түр саатуулах үндэслэл байгаа эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийг бүртгэлд / маягт-1 / бүртгэнэ.

11. Тээврийн хэрэгслийн түр саатуулж буй алба хаагч жолоочийг нь /бололцоотой бүх тохиолдолд/ байлцуулан тээврийн хэрэгслийн гадна тал, эд ангийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, бүртгэлд тодорхой тэмдэглэн түр саатуулах байрны жижүүрт хүлээлгэн өгнө.

Тээврийн хэрэгслийн хаалга, шатахууны савны таг, ачаа ачих хэсэг, цоожгүй бол доторх эд анги, агрегат, нэмэгдэл тоноглол, шатахууны хэмжээг шалгаж тэмдэглэнэ. / маягт-2 /

12. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байранд хүлээн авснаас хойш түүний бүрэн бүтэн байдлыг уг байрны жижүүр, харуул хариуцна.Харин журам зөрчиж тээврийн хэрэгслийг хариуцлагагүй хүлээлцсэнээс болж учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

13.Хүйтний улиралд хөргөлтийн систем нь хөлдөх шингэнтэй тээврийн хэрэгслийг түр саатуулсан алба хаагч, тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны жижүүр нар хамт байж хөргөлтийн шингэнийг асгуулах, хургаагуурын гүйдлийг салгах арга хэмжээ авна.

14. Түргэн муудаж, чанараа алдах, тэсэрч дэлбэрэх, өвлийн цагт хөлдөх зүйл тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг түр саатуулсан тохиолдолд жижүүр, харуул нь холбогдох байгууллага, албан тушаалтанд яаралтай мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл хөтлөнө.

Хэрэв тодорхой арга хэмжээ аваагүйн улмаас хохирол учирвал хэн буруутай нь иргэний хуульд зааснаар материалын хариуцлага хүлээнэ.

Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэх журам

15. Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн жолоочид холбогдох зөрчлийг эрүүгийн болон захиргааны хэрэг бүтгэх хугацаанд шийдвэрлэнэ.

16. Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулах, зохих хариуцлага, хураамж тооцох асуудлыг Замын цагдаагийн байцаагч хариуцна. Байцаагч нь хэрэг зөрчлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, хураамж тооцсон тухай баримтыг цагдаагийн байгууллагын жижүүрт ирүүлнэ.

Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийг буцаан олгох журам

17. Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн жолоочид холбогдсон асуудлыг хянан шийдвэрлэж, холбогдох материал бүрдсэн тохиолдолд ерөнхий жижүүр тээврийн хэрэгслийг байрнаас гаргах зөвшөөрлийг түр саатуулах байрны жижүүр, харуулд өгнө.

18. Түр саатуулах байрны жижүүр нь тээврийн хэрэгслийг хүлээн авсан тэмдэглэлтэй тулган эзэнд нь хүлээлгэн өгч, тэр тухай тэмдэглэл хөтлөн хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулна.

19. Түр саатуулагдсан тээврийн хэрэгслийг хүлээн авсан эзэн нь түр саатуулах байрнаас гарахын өмнө тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авна.

Бусад зүйл

20. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны жижүүр, харуул нь цагдаагийн байгууллагын ерөнхий жижүүрийн шууд удирдлагад ажиллана.

21. Түр саатуулах байранд хүлээн авсан тээврийн хэрэгслийн бүхээг болон тэвшинд хүн байлгах, хонуулахыг хориглоно.

22. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд байсан хугацааны шууд зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

23. Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны дотоод журмыг нийслэлийн болон аймгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга батална.

Маягт-I

ТҮР САТГУУЛАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

д/д	Он, сар, өдөр цаг, минут	Марк	Үлсын дугаар	Жолоочийн овог, нэр	Саатуулагдсан үндэслэл	Саатуулсан албаа хаагчийн нэр, албан тушаал	Бүртгэсэн ерөнхий жижүүрийн гарын үсэг	Тайлбар зэрэгцэнь олгосон тухай

Маягт- II

ТҮР САТГУУЛАХ БАЙРАНД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭН АВСАН, ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БҮРТГЭЛ

Дэс дугаар	Хүлээн авсан Он, сар өдөр	Марк	Үлсын дугаар	Жолоочийн овог, нэр	Тээврийн хэрэгслийг хүлээн авсан байдал, гадна тал, эд анги, агрегатын бүрэн бүтэн байдал, бусад зүйл, ямар хөрөнгө шинэлэгээ г.м/ тодорхой бичнэ	Хүлээлгэн өгөхөөс өмнө тавьсан үзлэг	Саатуулсан албаа хаагчийн тавьсан үзлэг	Он, сар, өдөр	Тээврийн хэрэгсэл хүлээлгэн өгөв				ТАЙЛБАР
									Хүлээлгэн өгөхөөс өмнө жижүүрийн тавьсан үзэг	Он, сар, өдөр	Хүлээлгэн өгөв байдал	Хүлээн авсан хүний тавьсан үзэг	Хүлээлгэн өгөхөөс өмнө жижүүр

Хууль зүйн сайдын 1999 оны
73 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО БҮРТГЭЛИЙГ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.Энэ журам нь Монгол улсын нутаг, дэвсгэр дээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэрийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ, улсын дугаар олгох, бүртгэлээс хасах үйл ажиллагаат зохицуулна.

2.Тээвэрийн хэрэгслийн улсын бүртгэлийг Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтэс, нутаг дэвсгэрийн Замын цагдаагийн албад эрхлэн явуулна.

3.Тээвэрийн хэрэгслийг өмчлөх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр,хаяг дээр бүртгэж нийслэл, аймгийн ялгах тэмдэг бүхий улсын дугаар олгоно.

4. Улсын дугаарын өнгө, үсэг, тоо нь Монгол улсын стандартад нийцсэн байна.

5.Монгол улсад оршиж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, тээвэрийн хэрэгслийг өмчлөн авснаас 72 цагийн дотор бүртгүүлнэ.

6. Тээвэрийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, хаяг, эзэмшиж байгаа тээвэрийн хэрэгслийн зориулалт, хөдөлгүүрийн болон арал, бүхээгний дугаар, өнгө, өөрчлөгдөх бүрт нийслэлд Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтэст, орон нутагт тухайн аймгийн замын цагдаагийн албанд долоо хоногийн дотор бүртгүүлнэ.

7. Техникийн стандартын шаардлага хангаагүй, тогтоосон журмын дагуу улсын бүртгэл, техникийн үзлэгт ороогүй, улсын дугааргүй болон дугаарыг зохих байрлалд нь тавиагүй тээвэрийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулахгүй.

8.Бүх төрлийн автомашин, чиргүүл, мотоцикл, трактор, өөрөө явагч хэрэгслийн үйлдвэрлэсэн үйлдвэрийн стандартын загварыг өөрчлөхийг хориглоно.

9. Тээвэрийн хэрэгслийн ангиллыг гэрчилгээн дээр бичнэ.

10. Бүх төрлийн автомашинд улсын дугаарын тэмдэг хоёр ширхэг, мотоцикл, чиргүүл, трактор, өөрөө явагч хэрэгсэлд нэг ширхэгийг олгоно.

11. 16 насанд хүрсэн иргэний нэр дээр тээвэрийн хэрэгслийг бүртгэнэ.

12. Зохих материал бүрдэж, шаардлага хангасан тээвэрийн хэрэгсэлд тээвэрийн хэрэгслийн карт, гэрчилгээ бичиж, гэрчилгээн дээр байгууллага, иргэний регистрийн дугаарыг бичиж, картыг нь картын санд хадгалж, гэрчилгээ, улсын дугаарыг нь эзэмшигчдэд олгоно.

ХОЁР. Тээвэрийн хэрэгслийг бүртгэх

13.Тээвэрийн хэрэгслийг бүртгэж, улсын дугаар олгоход дараах материалыг үндэслэнэ. Үүнд:

а/ байгууллага, аж ахуйн нэгжийн албан бичиг, гэрчилгээ, иргэний өргөдөл, иргэний үнэмлэх;

б/ тээвэрийн хэрэгслийн техникийн паспорт, эх хувь, үйлдвэрийн дагалдах бичиг /транзит дугаар/;

в/ худалдсан байгууллагын тушаал, албан бичиг, иргэний өргөдөл, иргэний үнэмлэх;

г/ дипломат байгууллагын тухайд бол Гадаад харилцааны яамны ДБУААГ-ын албан бичиг;

д/ улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

е/ хуучин автомашинд Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн техникийн үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг нотолсон техникийн комиссын акт, оношлогооны дүгнэлт.

14. Үйлдвэрийн бус аргаар босгосон тээвэрийн хэрэгслийг дугаартай эд анги, хойд урд тэнхлэг, хурдны хайрцаг, дугуй, бусад эд ангийг хаанаас авсан тухай албан ёсны баримт материалыг техникийн бүртгэлийн хэлтэс хянаж шийдвэрлэнэ.

15. Монгол улсад байнга оршин суугаа болон удаан хугацаагаар зорчих гадаадын иргэдийн тээврийн хэрэгслийг энэ журмын 13 -д заасан нийтлэг журмын дагуу бүртгэж, улсын дугаарын тэмдэг олгоно.

16. Монгол улсад түр хугацаагаар зорчиж байгаа гадаадын иргэдийн тээврийн хэрэгслийг нийслэлд Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтэс, аймагт тухайн аймгийн Замын цагдаагийн алба бүртгэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээг хураан авч түр зорчих баримтыг уг иргэний визийн хугацаа, гэрээс үндэслэн 3 сар хүртэл хугацаагаар олгож, буцахад нь түр зорчих баримтыг хураан авч бичиг баримтыг нь буцаан олгоно.

Гурав. Тээврийн хэрэгслийн шилжилтийн хөдөлгөөн хийх

17. Дараах тохиолдолд тээврийн хэрэгслийн шилжилтийн хөдөлгөөн хийнэ. Үүнд:

а/ тээврийн хэрэгсэл өмчлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өөр байгууллага, аж ахуйн нэгж иргэнд худалдах, бэлэглэх, солих;

б/ эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжийн байршил, иргэний оршин суугаа хаяг өөрчлөгдөх;

в/ тээврийн хэрэгслийн бүхээг, арал, хөдөлгүүр, өнгө, зориулалт өөрчлөгдөх.

18. Тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилтийн хөдөлгөөн хийхэд доорхи материалыг үндэслэнэ. Үүнд:

а/ нэг байгууллага, аж ахуйн нэгжээс өөр байгууллага, аж ахуйн нэгжид тээврийн хэрэгслийг шилжүүлбэл худалдсан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирлын тушаал, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, тэмдэгтийн хураамж төлсөн баримт болон худалдаж авсан байгууллага, аж ахуйн нэгжийн тушаал, албан бичиг, гэрчилгээ;

б/ аж ахуйн нэгж, байгууллага, тээврийн хэрэгслийг иргэдэд худалдсан бол тухайн аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирлын тушаал, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, худалдан авсан иргэний үнэмлэх, өргөдөл, хураамж төлсөн баримт;

в/ иргэнээс аж ахуйн нэгж, байгууллагад шилжсэн бол иргэний өргөдөл, иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллагын бичиг, гэрчилгээ, хураамж төлсөн баримт;

г/ иргэд хоорондоо тээврийн хэрэгслээ худалдах, бэлэглэх зэргээр солилцсон бол иргэн тус бүрийн үнэмлэх, шилжүүлэх өргөдөл, хураамж төлсөн баримт;

д/ гадаад орноос Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газар, олон улсын болон хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн ажилтан, мөн Монгол улсад түр зорчиж буй гадаадын иргэд тээврийн хэрэгслээ Монгол улсын аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд шилжүүлсэн бол энэ журмын 13-д зааснаар баримтлан шилжилтийн хөдөлгөөн хийнэ.

19. Тахир дутуу иргэдэд улсаас хямдруулсан үнээр худалдсан тээврийн хэрэгслийг олгосон эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн тэр хүний нэр дээр бүртгэнэ.

20. Тээврийн хэрэгслийн эзэмшигч нь нас барсан бол өв залгамжлагчийн нэр дээр шүүхийн шийдвэрээр тээврийн хэрэгслийг хураасан буюу шилжүүлсэн бол шийдвэрт заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр дээр бүртгэнэ.

21. Тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн тохиолдол автозасварын үйлдвэр, техникийн оношлолын газрын акт, аймаг, дүүргийн техникийн комиссын дүгнэлт, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр зэргийг үндэслэн бүртгэнэ.

22. Дампуурсан, мөн бүртгэлээс хасагдсан аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийг нутаг дэвсгэрийн татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр дээр шилжүүлж бүртгэж болно.

23. Байнгын бүртгэлтэй газраас өөр аймаг, хотод 6 сараас дээш хугацаагаар ажиллах тээврийн хэрэгслийг тухайн нутаг дэвсгэрт шилжүүлэн бүртгүүлж, улсын дугаарыг солих ба 6 сар хүртэл түр хугацаагаар ажиллах бол тэр газрын Замын цагдаагийн албанд бүртгүүлж хугацаа дуусмагц бүртгэлээс хасуулна.

Төгсгөл нь дараагийн дугаарт нийтлэгдэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны зургадугаар сарын 30 №29 (108)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

262. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай (1999-6-10-ны хууль) 432

263. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-10-ны хууль) 435

264. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-10-ны хууль) 435

265. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-10-ны хууль) 435

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

266. Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай Дугаар 29 436

267. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 38 537

268. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 43 541

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

269. Г. П. Комаров, М. Я. Магро нарыг одон, медалиар шагнах тухай Дугаар 105 541

270. М. Алтайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 106 541

271. Монгол Улсын Ерөнхий прокурорын тухай Дугаар 107 542

272. Улсын Ерөнхий прокурорыг томилох тухай Дугаар 110 542

Дөрөв. Яам, агентлагийн акт

273. Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын төгсгөл, 4 дүгээр хавсралт 542

Уншигчдын анхааралд

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн № 26-д нийтлэгдсэн Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай 1999 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулийн 2 дугаар зүйлийг Малын албан татварын тухай хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдаагүйтэй холбогдуулан хасах ёстой байтал манай ажилтны буруугаар хасаагүй алдаатай хэвлэсэн байх тул уг хуулийг дараахь байдлаар залруулж хэрэглэхийг мэдэгдье. (Уг хуулийг 432 дугаар галд нийтлэв.)

х х х

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн №28-д нийтлэгдсэн Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1999 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд "25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг" гэснийг "25 ^{2} дугаар зүйлийн 1 дэх хэсэг" гэж залруулж хэрэглэнэ үү.

Улсын Их Хурлын Тамгын газар

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 5 дугаар сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Монгол Улсад байнга болон түр оршин суугч татвар төлөгчийн энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 9, мөн хэсгийн 5 дахь заалтын "в"-д заасан орлогын жилийн дүнд дараахь хэмжээгээр тооцож албан татвар ногдуулна.

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь, хэмжээ
0-2400000	10 хувь
2400001-4800000	240000 төгрөг дээр 2400000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ
4800001, түүнээс дээш	720000 төгрөг дээр 4800000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 40 хувийг нэмнэ

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль тогтоомж

2.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс /цаашид "нэрийн данс" гэх/-ны тухай хууль тогтоомж нь нийгмийн даатгалын тухай хуульд тогтоомж, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Нэрийн данс нээх нөхцөл, журам

3.1.Нэрийн данс нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ.

3.2.Даатгуулагчийн нэрийн данс нь дугаар давхардаагүй байх бөгөөд даатгуулагчийн овог, нэр, дансны эхний үлдэгдэл, сар бүрийн төлсөн шимтгэл, тооцсон хүү, олгосон тэтгэвэр зэрэг орлого, зарлагын талаар мэдээлэл өгөх нөхцөлийг хангана.

3.3.Нэрийн данс нээх болон энэ хуулийн 3.2-т заасан мэдээллийг даатгуулагчид өгөх журмыг нийгмийн даатгалын төв байгууллага батална.

4 дүгээр зүйл. Нэрийн дансны орлогын эх үүсвэр

4.1.Нэрийн дансны орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1.нэрийн дансны эхний үлдэгдэл;

4.1.2.даатгуулагчийн төлсөн шимтгэл;

4.1.3.ажил олгогчийн төлсөн шимтгэл;

4.1.4.төрөөс төлсөн шимтгэл;

4.1.5.нэрийн дансны орлогод тооцсон хүү.

5 дугаар зүйл. Нэрийн дансны эхний үлдэгдэл тооцох

5.1.Нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцоход дараахь үзүүлэлтийг харгалзана:

5.1.1.даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэл нийт ажилласан хугацаа;

5.1.2.нэрийн данс нээлгэх хүртэл ажилласан 10 жилийн доторхи дараалсан, аль илүү хөдөлмөрийн хөлс авч байсан 5 жилийн дундаж индексжүүлсэн хөдөлмөрийн хөлсний хэмжээ;

5.1.3.сард төлбөл зохих шимтгэлийн хувь, хэмжээ;

5.1.4.сүүлийн 5 жилийн улсын дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж индекс.

5.2.Нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцоход энэ хуулийн 5.1- д заасан үзүүлэлтийг харгалзан дараахь томъёогоор бодно:

5.2.1. А=БхВ, үүнд:

А-нэрийн дансны эхний үлдэгдэл;

Б-сард төлвөл зохих шимтгэлийн хэмжээ;

В-ажилласан нийт сар.

5.3.Сард төлвөл зохих шимтгэлийн хэмжээг дараахь томъёогоор бодно:

5.3.1. Б= Г х Д х Е, үүнд:

Г-даатгуулагчийн сарын хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ;

Д-сүүлийн 5 жилийн улсын дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж индекс;

Е-шимтгэлийн хувь.

5.4.Энэ хуулийн 5.1.1; 5.1.2-т заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн хөлсний хэмжээг нийгмийн даатгалын байгууллага тооцно.

5.5.Энэ хуулийн 5.1.3, 5.1.4-т заасан шимтгэлийн хувь, хэмжээ, хөдөлмөрийн хөлсний дундаж индекс, түүнийг хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

6 дугаар зүйл. Нэрийн дансанд хүү тооцох

6.1.Нэрийн дансны орлогод жилд нэг удаа хүү тооцно.

6.2.Нэрийн дансанд хүү тооцоход эхний үлдэгдэл, тухайн жилийн шимтгэлийн орлогын нийлбэрийг дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувиар үржүүлнэ.

6.3.Нэрийн дансанд тооцох хүү, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсний өсөлтийг нийгмийн даатгалын байгууллагын тайлан, мэдээ, Үндэсний статистикийн газрын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

7 дугаар зүйл. Нэрийн данснаас тэтгэвэр авах эрх

7.1. Дор дурдсан болзол хангасан даатгуулагч нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр авах эрхтэй:

7.1.1.1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн;

7.1.2. 60 нас хүрсэн даатгуулагч, эсхүл 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл;

7.1.3.нийтдээ 180 ба түүнээс дээш сар тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн;

7.1.4.тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж хөдөлмөрийн гэрээгээ дуусгавар болгосон буюу хөдөлмөр эрхлэх, төрийн алба хаах үйл ажиллагаагаа зогсоосон.

7.2.1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль[1]-д заасны дагуу тахир дутуугийн буюу тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах болзол хангасан даатгуулагч нь энэ хуулийн дагуу бодож тооцсон тахир дутуугийн буюу тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй.

8 дугаар зүйл. Тэтгэврийг тооцох

8.1.Өндөр насны сарын тэтгэврийг тооцоход нэрийн дансны орлого, даатгуулагчийн тэтгэвэр авах дундаж хугацаа харгалзан дараахь томъёогоор бодно:

8.1.1.

$$T = \frac{X}{K} : 12,$$

үүнд:

Т - сарын тэтгэврийн хэмжээ;

Х -нэрийн дансны нийт орлого;

К-тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл.

8.2.1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн тэтгэвэрт гарснаас хойшхи хугацаанд тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн газраас гаргасан тооцоо, саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

8.3.Тахир дутуугийн тэтгэврийг нэрийн данснаас тооцоход:

8.3.1. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиар;

---

[1]Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль- "Ардын эрх" сонины 1994 оны 141, 142; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 8 дугаарт тус тус нийтлэгдсэн.

8.3.2. хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хөдөлмөрийн чадвараа алдсан хувьд ногдох хэмжээгээр бодож тогтооно.

8.4.Тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг нэрийн даснаас тооцоход:

8.4.1. хөдөлмөрийн чадваргүй нэг хүнтэй бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4О хувиар;

8.4.2.хөдөлмөрийн чадваргүй хоёр ба түүнээс дээш хүнтэй бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй хүн тус бүрт энэ хуулийн 8.4.1-д заасан хувийг 1О хувиар нэмэгдүүлж бодож тогтооно.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасан тэтгэвэр нь сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6О хувиас хэтрэхгүй байна.

8.6.Тэтгэвэр бодох зааврыг нийгмийн даатгалын төв байгууллага батална.

9 дүгээр зүйл. Тэтгэврийн доод хэмжээ

9.1.Нэрийн даснаас олгох өндөр насны тэтгэврийн доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний улсын дундаж хэмжээний 20 хувиас багагүй байна.

9.2.Нийтдээ 15 ба түүнээс дээш жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн 15-аас дээш жил дутамд 0.5 хувиар бодож, энэ хуулийн 9.1-д заасан хувийг өсгөж тухайн даатгуулагчийн тэтгэврийн доод хэмжээг тогтооно.

9.3.Тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй адил байна.

10 дугаар зүйл. Тэтгэврийг индексчлэх

10.1.Нэрийн даснаас олгох тэтгэврийг мөнгөний ханш бууралтын түвшинтэй шууд хамааралтай тогтоосон индексээр өсгөнө.

10.2.Тэтгэврийн хэмжээг өсгөх индекс, түүнийг хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Үндэсний статистикийн газар тогтооно.

11 дүгээр зүйл. Тэтгэвэр олгох

11.1.Тэтгэврийг тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.

11.2.Тэтгэвэр авагчид даснаас тооцож олгосон тэтгэвэр, дасны үлдэгдлийн талаар түүнд мэдээлж байна.

12 дугаар зүйл. Хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагчийн шимтгэл төлөлт

12.1.Тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж байгаа бол ажил олгогч болон даатгуулагч /тэтгэвэр авагч/ төлвөл зохих шимтгэлийг нийгмийн даатгалын санд зохих журмаар төлнө.

13 дугаар зүйл. Шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах

13.1.Ажил олгогч, даатгуулагч шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох, тэдгээрийн гүйцэтгэлд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын тухай хууль[1], Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

14 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

14.1.Энэ хуулийг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

---

[1]Нийгмийн даатгалын тухай хууль-" Ардын эрх" сонины 1994 оны 141, 142; "Төрийн мэдээлэл" Сэтгүүлийн 1994 оны 8 дугаарт тус тус нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр — **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "5О нас хүрсэн бол" гэсний дараа "өөрийн хүсэлтээр" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.Даатгуулагч нь нийтдээ 2О-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 6О нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 2О-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно."

23.	Чингэлтэй	Нийслэлийн ЗД Тамгын газар	372815.1
24.	Чингэлтэй	Нийслэлийн хянан шалгах хороо	4350.9
25.	Чингэлтэй	Нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын алба	12100.0
26.	Чингэлтэй	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар	13404.4
27.	Чингэлтэй	Чингэлтэй дүүргийн Тамгын газар	89731.3
28.	Чингэлтэй	Цагдаагийн хэлтэс	36949.8
29.	Чингэлтэй	Хотын захирагчийн ажлын алба	38866.8
30.	Хотын цагдаагийн газар		220820.4
31.	Цагдаагийн 8О8-р анги		17512.2
32.	Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс, ангиуд		213797.0
33.	Нийслэлийн цагдаагийн 5-р хэсэг		32041.3
	Дүн		**2007110.7**
	НИЙТ ДҮН		**128448171.2**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 38 Улаанбаатар хот

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэлийг хавсралтын ёсоор батална тэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /С.Ламбаа/-д даалгасугай.

2.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжил-

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР 2021 ОН ХҮРТЭЛ БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. Өнөөгийн байдал, шинэчлэлтийн шаардлага

Төрөөс иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн даатгалыг боловсронгуй болгох, ялангуяа Монгол орны онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх явдал мөн.

Монгол оронд тэтгэврийг үндэсний нь улсын төсвөөс олгож байсан хугацаанд 1995 оноос өөрчилж, нийгмийн даатгалын хуваарилалтын зарчимд үндэслэсэн нийгмийн даатгалын багц хуулиудыг батлан мөрдүүлж, жил олгоч, даатгуулагчаас төлсөн шимтгэлээс тэтгэвэр олгодог шинэ тогтолцоог хэрэгжүүлээд гурван жил гаруй болж байна.

Тэтгэврийн даатгалын хуваарилалтын тогтолцоо /орлогоороо зарлагаа нөхөх/ нь хүн амын дийлэнх хэсэг нь залуу, ажилгүйдэл багатай, даатгуулагч, тэтгэвэр авагчын тооны харьцаа таламжтай нөхцөлд зөрж нөлөөлөл үзүүлж болох боловч өнөөдрийн ажил олгогч, даатгуулагчын төлж байгаа шимтгэл нь хүн ам наснихийн хэрээр дундаж наслалт өсч, тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэх тэр үеийн тэтгэврийн даатгалын санг санхүүжүүлж чадахгүй болох төлөвтэй байна.

Одоогийн тэтгэврийн тогтолцооны тэтгэвэр бодох арга нь төлсөн шимтгэлтэйгээ шууд хамааралгүйгээс хуваарилалт шударга бус, хувь хүний тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах болон өсгөж арвижуулах механизм бүрдээгүй, эдийн засгийн шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн хөгжилтэй шууд уялдаагүй байгаа зэрэг сөрөг үр дагавраас зайлсхийхийн тулд хуваарилалтын тогтолцоог үе шаттайгаар хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай байна.

Манай улсад макро ба микро түвшинд эдийн засгийн үзүүлэлт тогтворжоогүй, мөнгөний ханшийн уналт зогсоогүй, хөрөнгийн зах зээл, дэд бүтэц хөгжөөгүй, найдвартай хөрөнгө оруулалтын орчин бүрэлдэн тогтоогүй, банк, санхүүгийн механизм шилжилтийн үедээ байгаа зэргээс шалтгаалан хагас хуримтлалын тогтолцоонд шууд шилжих нөхцөл бүрдээгүй байна.

Тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоог хагас хуримтлалын тогтолцоонд аажмаар шилжүүлэхдээ "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс" /цаашид "нэрийн данс" гэх/-ны аргыг сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

2020 оноос цаашид манай улсын хүн амын дотор өндөр настны эзлэх хувь нэмэгдэж, ялангуяа 1960-аад оны хүн амын огцом өсөлтийн үеийнхэн тэтгэвэрт гарч, энэ үеийн тэтгэврийн даатгалын сангийн ачаалал хэт хүндрэх [illegible]агатай байна. Хүн амын бүтцийн хувьд 35

хүртэлх насны залуучууд нийт хүн амын болон эдийн засгийн идэвхтэй хүн амын дийлэнх олонхийг эзэлж байгаа боловч энэ нь 2011 оноос бууруй, ажлын байр дутагдалтай, ажилгүйдэл зохих түвшингээс дээгүүр, заавал даатгалд хамрах хүрээ мэдэгдэхүйц өсөх магадлал багатай зэрэг бодит нөлөөллүүдээс шалтгаалан тэтгэврийн даатгалын одоогийн тогтолцоог хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх шаардлага урган гарч байна.

Тэтгэврийн тогтолцооны одоогийн хямралаас гарах, төлсөн шимтгэлээ хуримтлалын зарчмаар өсгөж тэтгэвэртээ бүрэн эргүүлж авах иргэдийн сонирхлыг хөхүүлэн дэмжих, нийгмийн даатгалын хуримтлалыг эдийн засгийн идэвхтэй хөгжлийн бодлоготой шууд уялдуулах, нийгмийн шударга хуваарилалтыг баталгаажуулах зэрэг нийгмийн үр дүнтэй хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг иш үндэс болгон Монгол Улсын төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлох нь зүйтэй юм.

ХОЁР. Үндсэн үзэл баримтлал

1.Тэтгэврийн даатгалын тогтолцооны хуваарилалтын одоогийн зарчмыг үе шаттайгаар хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлнэ. Алс ирээдүйд бүх нийтийг хамарсан бүрэн хуримтлалын тогтолцооны зарчмаар тэтгэвэр авах нөхцөл, боломжийг эртэнээс хангах нь тэтгэврийн шинэчлэлийн үндсэн зорилт мөн.

2.Хагас хуримтлалын зарчмид шууд шилжих эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн таатай орчин нөхцөл бүрдээгүй байгаат иш үндэс болгон тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоонд нэрийн дансны аргыг хэрэглэж, 2005 оноос хойш хагас хуримтлалын тогтолцоонд шилжих үүргар нөхцөл бүрдүүлнэ.

3.Эдийн засгийн хөгжил, хөрөнгийн зах зээлийн таатай орчин бүрдсэн нөхцөлд хагас хуримтлалын тогтолцоог аажмаар бүрэн хуримтлалын тогтолцоо болгон өөрчлөх зорилтыг 2021 оноос хойш тавина.

4.Тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхээ 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн хүмүүст хуучин журмаар, түүнээс хойш төрсөн хүмүүст бүх төлсөн шимтгэлээс нь тооцож тэтгэврийг бодож олгох нь зохимжтой гэж үзэж байна. 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн хүмүүсийн ажилласан бүх хугацаанд төлсөн байвал зохих шимтгэлийг нэрийн дансанд шилжүүлэн тооцох аргыг хэрэглэнэ.

5.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, малчид, ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг сайн дураараа нийгмийн даатгалд даатгуулахыг төрөөс дэмжинэ.

6.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр авч байсан хүмүүсийн тахир дутуу байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн төлж байхыг зүйтэй гэж үзнэ.

7.Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг нийгмийн даатгалын харилцаанаас тусад нь бие даасан хуулиар зохицуулж, тэдний тэтгэвэр, тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас бус тухайн цэргийн албан хаагчийн ажиллаж байсан байгууллага эрхлэн олгоно.

I. Тэтгэврийн нас, хөнгөлөлттэй тэтгэвэр:

8.Хүн амын насны бүтэц, дундаж наслалтын хэтийн төлөвийг харгалзан иргэдийн нийгмийн хамгаалллыг баталгаатай бүрдүүлэх, нийгмийн шударга ёсыг дээлэх, хувь хүний оролцоонд тулгуурласан тогтолцоонд шилжих зорилтыг иш үндэс болгон өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг алс ирээдүйд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувьд адилхан байлгахыг зүйтэй гэж үзнэ.

9.Эмэгтэйчүүдийн хувьд 55 настай буюу олон хүүхэд төрүүлж өсгөсөн тохиолдолд 5О настайдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхээ өөрсдийн хүсэлтээр чөлөөтэй сонгодог болох замаар тэдний нийгмийн хамгаалллыг баталгаажуулна.

10.Олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн нийгмийн баталгаагаар хангах асуудлыг нийгмийн даатгалын харилцаагаар биш харин нийгмийн халамжийн бодлогын хүрээнд хуулиар зохицуулах нь илүү зохимжтой гэж үзнэ.

11.Хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөл, газрын дор ажиллаж байгаа хүмүүст хөнгөлөлттэй журмаар эрт тэтгэвэр тогтоодог одоогийн журмыг хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангах төрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох замаар салбарын тэтгэврийн нэмэгдэл даатгалын тогтолцоо бий болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

II. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хуримтлал:

12. Эдийн засгийн хөгжил тогтворжоогүй, хүн амын бодит орлого хангалттай биш байгаа өнөөгийн нөхцөлөөс шалтгаалан тэтгэврийн даатгалын шимтгэл 19 хувь байгааг ойрын жилүүдэд хэвээр мөрдөнө.

13. Цаашид хуримтлалын тогтолцоонд шилжихтэй холбогдуулан цалин хөлсийг нэмэгдүүлсэн нөхцөлд түүнтэй уялдаатайгаар нийт даатгуулагчийн төлөх шимтгэлийг 7.5 хувь, ажил олгогчийн төлөх шимтгэлийг 11.5 хувиар тогтооно. Үйл ажиллагааны зардал, тэтгэврийн доод хэмжээ, тэжээгч, тахир дутуугийн тэтгэвэрт зарцуулах зориулалтаар тэтгэврийн даатгалын сангийн нийт орлогын 4.0 хувийг тусгай дансанд төвлөрүүлнэ.

14. Хагас хуримтлалын тогтолцоонд аажмаар шилжих зорилгоор тэтгэврийн санд зохих нөөц хуримтлагдсан нөхцөлд 2005 оноос эхлэн төсөвт дарамт учруулахгүйгээр даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 3.0 хүртэл хувийг хуримтлалд оруулах, 2011 оноос энэ хувийг нэмэгдүүлэх асуудлыг тухайн үед нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.

15. Хагас хуримтлалын тогтолцоонд бүрэн шилжсэн нөхцөлд даатгуулагчийн болон ажил олгогчийн төлсөн шимтгэлийг хуримтлалд оруулна.

16. Хуримтлал бий болгох, сангийн чөлөөт үлдэгдлийг удирдахдаа гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд оролцох, Засгийн газрын бонд, ашигтай ажиллаж байгаа компанийн хувьцаа худалдан авах, арилжааны банкинд хөрөнгө хадгалуулж өсгөх, богино хугацаатай зээл олгох зэргээр сангийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн даатгалын санг үнэгүйдлээс хамгаалах найдвартай аргуудыг шаардлагатай нөхцөл бүрдсэн үед нь хууль тогтоомжоор баталгаажуулан хэрэглэнэ.

III. Шимтгэл тооцох орлогын хязгаар:

17. Тэтгэврийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд, доод хязгаар тогтоох нь зүйтэй бөгөөд энэ зарчмыг тэтгэврийн дээд, доод хэмжээг тогтоох бодлоготой уялдуулан авч үзнэ.

18. Шимтгэл ногдуулах орлогын дээд хязгаар нь шимтгэл төлсөн даатгуулагч, тэдний хөдөлмөрийн хөлсний талаархи нийгмийн даатгалын байгууллагын тайлан, мэдээг үндэслэн гаргасан улсын дундаж хөдөлмөрийн хөлсийг 3 дахин өсгөсөнтэй тэнцүү хэмжээтэй байхаар тогтооно.

19. Шимтгэл ногдуулах орлогын доод хязгаар нь нийгмийн даатгалын байгууллагын тайлан, мэдээг үндэслэн гаргасан дундаж хөдөлмөрийн хөлсний 25 хувиас багагүй байхаар тогтооно. Гэхдээ энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

IY. Тэтгэврийн доод хэмжээ:

20. Нэрийн дансны тэтгэврийн доод хэмжээ тогтоохтой холбогдуулан шимтгэл төлсөн байвал зохих хугацааны доод хязгаарыг 15 жилээр тогтооно. Энэ нь даатгуулагч дунджаар 30 ба түүнээс дээш жил шимтгэл төлнө гэж үзэж түүний 50 хувиас багагүй хугацаагаар шимтгэл төлөх хугацааны доод хязгаарыг тогтоох нь зохимжтой юм.

21. Тэтгэврийн доод хэмжээг 15 жил шимтгэл төлсөн бол улсын дундаж хөдөлмөрийн хөлсний 20 хувиар, 15-аас дээш жил шимтгэл төлсөн бол уг хувийг жил тутамд 0.5 хувиар өсгөн нэмэгдүүлж тогтооно.

22. Олон жил шимтгэл төлсөн даатгуулагч өндөр насалсан үедээ амьжиргаандаа хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр авч байх зорилгоор тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авах эрх нь 15-аас доошгүй жил шимтгэл төлсөн нөхцөлд үүсэх ба хувь тэнцүүлэх журмаар тэтгэвэр тогтоохгүй.

Гурав. Нэрийн данс хэрэглэх, түүгээр тэтгэвэр тогтоох, олгох

23.Тэтгэврийн даатгалын хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын зарчимд шилжихдээ 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчид нэрийн данс нээнэ. Харин 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн даатгуулагч нэрийн данс нээлгэхгүйгээр хуучин тогтолцоогоор тэтгэвэр авах эрх эдэлнэ. Нэрийн данс нээж, түүгээр тэтгэвэрт гарах хүний тэтгэвэр болон хуучин тогтолцоогоор тэтгэвэрт гарах хүний тэтгэврийн хэмжээг тэнцвэртэй байлгах зарчмыг баримтлах бөгөөд үүнтэй холбогдуулан холбогдох хуульд тухайн үед нь өөрчлөлт оруулна.

24.Нэрийн дансны эхний үлдэгдлийг тодорхойлохдоо тогтоосон индексээр есгесен даатгуулагчийн 5 жилийн дундаж хөдөлмөрийн хөлсөнд ногдох шимтгэлийг түүний нийт ажилласан сар /жил/-аар үржүүлж нэрийн дансанд хийсвэрээр хуримтлагдах хөрөнгийг тооцож гаргана. Өөрөөр хэлбэл 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн хүний нэрийн данс нээлгэх хүртэл ажилласан хугацаа, хөдөлмөрийн хөлсөнд ногдох шимтгэлийг нэрийн дансны эхний үлдэгдэл болгон тооцох зарчмыг баримтална.

25. Даатгуулагчийн өөрийн оролцоо, сонирхлыг хөхүүлэн дэмжих зорилгоор нэрийн дансны эхний үлдэгдэл болон түүний орлогод жил бүр хүү тооцно. Хүүг тооцоход нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтөөр дараагийн жилийн шимтгэлийг өсгех зарчмыг баримтлах бөгөөд энэ нь нэрийн дансны хөрөнгийг эрсдлээс хамгаалах бодлоготой нийцэж байвал зохино.

26. Даатгуулагчийн төлсөн шимтгэл тэтгэвэрт нь бүрэн зориулагдах шударга хуваарилалтын зарчмыг үндэслэн тэтгэврийн хэмжээг бодоход шимтгэлийн нэрийн дансны эхний үлдэгдэл, нийт төлсөн шимтгэл, тооцсон хүүгийн нийлбэрийг тэтгэвэр авах дундаж хугацаанд хуваах гаргах томъёог хэрэглэнэ.

27.Тэтгэврийг мөнгөний ханшийн өөрчлөлттэй шууд хамааралтайгаар тогтоосон индексээр өсгөж байна.

28.Тэтгэвэр авагч нь ажил хийх тохиолдолд өөрийн хуримтлал нэгэнт бий болгосон учир анх тогтоогдсон тэтгэврээ тэтгэврийн даатгалын сангаас авах эрх эдэлнэ. Тэтгэвэр авагч ажил хийж төлсөн шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд оруулна.

Дөрөв. Нийгмийн даатгалын байгууллага

29.Нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд шилжих үйл ажиллагаа, нэрийн дансыг хэрэглэх ажлыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага эрхэлнэ.

30.Нийгмийн даатгалын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, цахим тооцоолуурын нэгдсэн программ хангамж, сүлжээнд холбогдох нөхцөлийг хангах зорилгоор нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс үл хамаарсан төв, орон нутгийн салбар нэгжээс бүрдсэн, цомхон, чадварлаг алба байхаар шинэчлэн зохион байгуулна.

31.Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаат хагас хуримтлалын тогтолцоо нэвтрүүлэх, нэрийн дансны арга хэрэглэхэд чиглүүлэн өөрчлөн зохион байгуулж, шаардагдах боловсон хүчнийг шинээр болон давтан сургах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

32.Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг цахим тооцоолуурын нэгдсэн сүлжээ, технологийн орчин үеийн программ хангамж, технологи, техник хэрэгслээр хангах арга хэмжээг дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрээр үе шаттай хэрэгжүүлнэ.

33.Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон өндөр цалин хөлс авагчид, даатгалд хамрагдаагүй бусад иргэдийн нийгмийн хамгааллыг баталгаатай болгох бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын сайн дурын хэлбэр, нэмэгдэл тэтгэврийн даатгалыг хуулиар тогтоосон нөхцөл, шалгуурыг үндэслэн нийгмийн даатгалын хувийн байгууллага эрхлэн гүйцэтгэхийг төрөөс дэмжинэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 43 **Улаанбаатар хот**

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс тухай хууль болон "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл"-ийн зарим заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/тэтгэврийн даатгалд даатгагдсан 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, түүнтэй адил байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, эхний үлдэгдэл, шимтгэлийг уг данснаас тооцох, нийт даатгуулагчид мэдээлэх ажлыг 2000 оны эхний хагаст багтаан дуусгах;

2/холбогдох байгууллагаас баталж мөрдүүлэх журам, эрхийн актыг 1999 оны 10 дугаар сард багтаан батлан гаргах;

3/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх үйл ажиллагааг удирдан зохицуулах, эрхлэн гүйцэтгэхэд чиглүүлж 1999 онд багтаан шинэчлэн зохион байгуулах.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 105 **Улаанбаатар хот**

Г.П.Комаров, М.Я.Магро нарыг одон, медалиар шагнах тухай

Монгол-Оросын төмөр замын тээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, дамжин тээвэрлэх ачааны урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх ОХУ-ын Дорнод Сибирийн төмөр замын дарга, "УБТЗ" нийгэмлэгийн ерөнхий хорооны дарга Геннадий Павлович Комаровыг "Алтан гадас" одонгоор, УБТЗ-ын санхүүгийн албаны дарга, "УБТЗ" нийгэмлэгийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Майя Яковлевна Магрог "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 106 **Улаанбаатар хот**

М.Алтайд Монгол улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургууль олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, сургалтад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэн, сурагчдад гүн бат мэдлэг олгох, тэдний техникийн болон математик сэтгэлгээг хөгжүүлж, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургуулийн математикийн зөвлөх багш Мөнхжаргалын Алтайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 107** **Улаанбаатар хот**

Монгол Улсын ерөнхий прокурорын тухай

1.Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын ерөнхий прокурорын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Нанзадын Ганбаярыг Улсын ерөнхий прокурорын албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорыг шинээр томилох хүртэл ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэгчээр Улсын ерөнхий прокурорын орлогч Ж.Чойжанцанг түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 110** **Улаанбаатар хот**

Улсын ерөнхий прокурорыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол овогтой Алтанхуягийг Улсын ерөнхий прокуророор томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

Төгсгөл. Түрүүч нь 28 дугаарт нийтлэгдсэн.

ДӨРӨВ.Тээврийн хэрэгслийн улсын дугаар гэрчилгээг нөхөн олгох

24. Тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ үрэгдүүлсэн тохиолдолд тэдгээрийг нөхөж авахын тулд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

а/ үрэгдүүлсэн дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг нөхөж авахыг хүссэн бичиг, өргөдөл;

б/ үрэгдүүлсэн дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг зарлуулж, хүчингүй болгосон баримт;

в/ тэдгээрийг нөхөж авах үнийг тушаасан баримт.

25. Тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг үрэгдүүлсэн эзэмшигч нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хандаж, тэдгээрийг үрэгдүүлсэн эсэхээ тогтоолгосон тодорхойлолтыг гаргуулна.

26. Тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг нөхөж авах тухай өргөдлийг тээврийн хэрэгслийн улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн карт, гэрчилгээ хүлээн авах, олгох ажлыг зохион байгуулдаг албан тушаалтанд гаргана.

27. Өргөдлийг хүлээн авсан албан тушаалтан тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг нөхөж олгохоос өмнө тухайн тээврийн хэрэгслийг улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн карт, гэрчилгээ хүлээн авах, олгох ажлыг зохион байгуулдаг албан тушаалтанд үзүүлж, дараах зүйлийг шалгана.

а/ тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг үрэгдүүлсэн эсэх;

б/ тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг үрэгдүүлсэн эзэмшигчийн хүсэлтээр үнийг төлүүлэн сольж болно.

ТАВ. Тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах

28. Тээврийн хэрэгслийг цаашид ашиглах техникийн боломжгүй болсон үед эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж, иргэд уг тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулна.

29.Тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахын тулд дараах материалыг бүрдүүлж 30 хоногийн дотор Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ. Үүнд:

1.Байгууллага, аж ахуйн нэгж:

а/ данснаас хассан тухай байгууллага, аж ахуйн нэгжийн дарга /захирал/ -ын тушаалын хувь;

б/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

в/ улсын дугаарын тэмдэг.

2. Иргэд:

а/ тээврийн хэрэгслээ бүртгэлээс хасуулах тухай эзэмшигчийн өргөдөл;

б/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

в/ улсын дугаарын тэмдэг.

30. Энэ журмын 5 дугаар бүлгийн 29 дүгээрт заасан материал ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасаж гэрчилгээ, улсын дугаарыг хураажкартыг хаана.

31. Гадаад орноос тус улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар олон улсын болон хэвлэл мэдээллийн байгууллага, мөн тэдгээрийн ажилтны тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасахдаа Гадаад харилцааны яамны дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газрын шийдвэрийг үндэслэнэ.

32. Гадаад оронд байнга буюу удаан хугацаагаар ашиглах, худалдах, тээврийн хэрэгслийг эзэмшигч байгууллага, иргэдийн хүсэлтийг үндэслэн улсын бүртгэлээс хасаж, улсын дугаарын тэмдэг, гэрчилгээг хураажавуулын дугаар, түр гэрчилгээ олгоно.

33. Тээврийн хэрэгслээс хураагдсан улсын дугаарын тэмдгийг хяналт тавьж устгана.

ЗУРГАА. Тээврийн хэрэгслийн улсын тоо бүртгэлийн сан, лавлагаа

34. Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтэс Монгол улсад ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгслийн улсын тоо бүртгэлийн санг хөтөлж, шаардлагатай лавлагаа гаргана.

35. Эрүүгийн болон иргэний хэрэгтэй холбогдуулж, шүүх прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбогдсон лавлагааг бичгээр гаргаж өгнө.

36. Гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбогдуулан цагдаагийн байгууллага, албаны дарга нарт дотуур холбоогоор тээврийн хэрэгслийн эзэмшигчийн нэр, хаягийн лавлагааг тухай бүр нь гарган өгч бүртгэл хөтөлнө.

37. Энэ журмын 35, 36 дугаар зүйлээс бусад тохиолдолд байгууллага аж ахуйн нэгж, иргэний тээврийн хэрэгслийн хаягийн лавлагааг гаргаж өгөхийг хориглоно.

ДОЛОО. Улсын дугаар тэмдгийг хураах, буцааж олгох

38. Зам тээврийн ослын улмаас тээврийн хэрэгсэлд учирсан хохиролын хэмжээ эрүүгийн хэрэг үүсгэхээр тохиолдолд улсын дугаарын тэмдгийг түр хураан авч, техникийн шаардлага хангасан тохиолдолд буцааж олгоно.

39. Улсын дугаарын тэмдгийг хууль бусаар хийх хэрэглээн, бусдын дугаар ашиглаан тохиолдолд улсын дугаарыг хураажзахиргааны хариуцлага тооцно.

Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Замын хөдөлгөөний хяналтын зорилт нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гарсан дүрэм, журам, стандартын биелэлтийг сахиулж, хөдөлгөөн зохицуулах, зам тээврийн осол, гэмт хэргийг урьдчилан сэргийлэхэд оршино.

2.Замын хөдөлгөөнд хяналт тавьж, хөдөлгөөн зохицуулахдаа замын хөдөлгөөний хяналтын байцаагч, цагдаа энэхүү журмыг баримтална.

3. Замын цагдаагийн газрын дарга ерөнхий байцаагчийн, газрын хэлтэс, тасгийн болон аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нар улсын ахлах байцаагч, байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч улсын байцаагчийн эрх эдэлнэ.

4.Байцаагчийн үйл ажиллагаа нь хууль ёсыг дээдлэх, шударга, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчимд үндэслэгдэх бөгөөд өөрийн үүрэг, зорилтоо цагдаагийн бусад албад, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлнэ.

5. Цагдаагийн албаа хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэх явцдаа замын хөдөлгөөнд оролцогчдыг шалгах, хяналт тавих тохиолдолд энэхүү жүрмыг баримтална.

ХОЁР. Замын цагдаагийн эргүүл, харуулын ажлын томилолт, үүрэгжүүлэлт

6. Замын цагдаагийн эргүүл, харуулыг эргүүл, харуулын дүрэмд заасан журмын дагуу томилж, үүрэгжүүлж ажиллуулна.

7. Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх байцаагч, цагдаагийн ажилд гарахаас 15 минутын өмнө жагсаан, бүртгэж дор дурдсан албаны ба хувийн бэлтгэлийг шалгаж, үүрэгжүүлнэ.

а/ эргүүл, харуулын чиглэл, цагийн байдлын тухай мэдлэг ;

б/ мөрдөж ажиллах хууль тогтоомж, холбогдох эрхийн актын мэдлэг ;

в/ албаны техник хэрэгсэл (дохиур мод, шүгэл, цоолтуур, радио станц) ;

г/ алба хаагчийн болон жолоодох эрхийн үнэмлэх, торгуулийн тасалбар, зөрчлийн дэвтэр, үзэг, мэдээллэх хуудас, эд зүйл, үнэмлэх хураах тасалбар болон автомашин дайчлан ашиглахаар тухай тэмдэглэлийн хуудас;

д/ шаардлагатай тохиолдолд нэг бүрийн эзвэсэг, тусгай хэрэгсэл;

е/ улирал, цаг агаарын нөхцөлд тохируулж хувцасласан байдал;

ж/ эрүүл мэндийн хувьд үүрэг гүйцэтгэх чадвар.

8.Энэ зүйлийн 7 -д заасан шаардлагыг хангаагүй буюу дутагдлаа арилгаагүй байцаагч, цагдаагийн ажилд гаргахгүй ба ажил тасалсанд тооцно.

9.Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх байцаагч, цагдаа нарт хэв журмын болон замын хөдөлгөөний нөхцөл байдал, үүрэг гүйцэтгэх гудамж зам, чиглэлд замын хөдөлгөөний хамгаалалт, зохицуулалт хийгдэх эсэх, улсын хэмжээнд болон нийслэл, аймаг, дүүргийн хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйл, тэдгээрийн нэр, зүс царай, өнгө, марк, дугаар, содон тэмдэг болон анхаарвал зохих бусад зүйлийг заавarчилна. Заавarчлагыг хэрэхэн ойлгож мэдсэнийг шалгасны дараа үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгоно.

10.Байцаагч, цагдаа нь хүндэтгэх шалтгаанаар ажилд гарч чадахгүйд хүрвэл ажилд гарахаас 2-оос доошгүй цагийн өмнө тасаг, хэсгийн дарга, ахлах байцаагчид шалтгаанаа тодорхой илтгэж, өөр алба хаагчийг томилуулна.

11.Байцаагч, цагдаа ажиллах гудамж зам, чиглэл, хяналтын байранд очоод орчны замын гадаргууны болон тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөний байдлыг үнэлж замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэл, замын хаалт хашлага, гэрэлтүүлэг, холбооны хэрэгслийн хэвийн ажиллагаag биеэр үзэж нягтлан шалгаад илэрсэн гэмтэл, зөрчлийн талаар эргүүлийн ахлагч, байгуллага, албаны жижүүрт мэдэгдэнэ.

ГУРАВ. Байцаагч, цагдаа нарт тавигдах шаардлага

12. Замын цагдаагийн байцаагч, цагдаад хөдөлгөөн зохицуулах, хянаж шалгах явцдаа биеэ зөв авч явах, хөдөлгөөнд оролцогчидтой зөв харьцах талаар дараах шаардлага тавигдана.

а/ цагдаагийн дүрэмт хувцсыг зааврын дагуу цэвэр үзэмжтэй, зөв өмсөх;

б/ жолооч, зорчигчтой очиж уулзахда ёсолж, албан тушаал, цол, нэрээ хэлж мэндлэн, хэрэв харилцагч хүсвэл хувийн дугаарaа хэлж, албаны үнэмлэхээ гарт нь өгөгүйгээр харуулж байх;

в/ ажлын цагийн туршид байнга сонор сэрэмжтэй, ажил хэрэгч байх;

г/ албаны техник, хэрэгслийг ариг гамтай зөв хэрэглэж, радио станцаар зааврын дагуу товчхон, цэгцтэй харьцах;

д/ эргүүл, харуулын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлгах, орхиж явах зайлшгүй тохиолдолд ерөнхий жижүүрт заавал мэдэгдэн зөвшөөрөл авч байх;

е/ иргэнтэй уур уцааргүй, эелдэг харьцаж, албаны товч тодорхой үг хэллэг хэрэглэх;

ж/ асуудалд ухаалаг, хүнлэг, шударга хандаж, зөрчил гаргагч үүрлаж бачимдсан, айж балмагдсан тохиолдолд хүлээцтэй байх;

з/ тээврийн хэрэгслийг зогсоосон үндэслэл нотлогдохгүй байгаа болон бусад шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнд оролцогчдоос заавал уучлалт гуйж байх;

13. Эргүүл, харуулийн үүрэг гүйцэтгэж байгаа замын цагдаагийн байцаагч, цагдаад хориглох зүйл:

а/ эргүүл, харуулын байрыг дарга, жижүүрийн зөвшөөрөлгүйгээр түр болонч орхих, ажлын байранд гадны хүн байлгах;

б/ ажлын байранд, дүрэмт хувцастай, ажлын цагаар согтууруулах ундааны зүйл хэрэглэх;

в/ цагдаагийн дүрэмт хувцас өмсөх заавриг зөрчих;

г/ ажлын байр, замын хажууд зорилгогүй зогсох, бусадтай албаны бус яриа ярих, шаардлагагүй үед машины бүхээгт суух,бусдын автомашин жолоодох, хяналтын цэг байранд тамхи татах;

д/ замын голд болон хяналтын цэгт зорилгогүй олноороо байх;

е/ бусадтай хэргийн догшин харьцаж, хэл амаар доромжлох, бүдүүлэг үг хараал хэрэглэх, эрх чөлөөнд нь халдах;

ж/ хөдөлгөөнд оролцогчдыг үндэслэлгүй саатуулах;

з/ жолоочийн үнэмлэх, талоныг үндэслэлгүйгээр болон тасалбаргүйгээр хураах;

и/ иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн тухай гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахаас болон цагдаагийн байгууллагад дамжуулахаас татгалзах;

к/ зөрчил гаргагчид хууль бус шаардлага тавих, хувийн ажилд тээврийн хэрэгсэл ашиглах, элдэв болзол тавих.

ДӨРӨВ. Замын хөдөлгөөн зохицуулах

14. Гудамж замын хөдөлгөөнийг шуурхай бөгөөд ашуулгүй явуулах зорилгоор байцаагч, цагдаа нар хариуцан замын уулзвар, хэсгийн хөдөлгөөнийг санаачилгаараа биеэр зохицуулж болно.

15. Замын уулзвар, хэсэгт дохиур мод, шүглийн тусламжтайгаар хөдөлгөөнийг биечлэн зохицуулна.

Биеэр зохицуулах үйл ажиллагаа нь Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу уран чадмаг, хөдөлгөөнд оролцогчдод ойлгомжтой байвал зохино.

16. Замын гэрлэн дохио ажиллахгүй болсон буюу хагас дутуу ажиллаж байгаа болон замын хөдөлгөөн хаагдан саатаж болзошгүй өндөр ачаалалтай үед мөн замын тусгай хамгаалалтын үед хөдөлгөөнийг шуурхай болгох зорилгоор биечлэсэн зохицуулалтыг заавал хийнэ.

17. Замын хөдөлгөөнийг зохицуулахдаа урьдчилан анхааруулахгүйгээр хөдөлгөөнийг гэнэт хааж, тээврийн хэрэгслийг огцом тооромсуулах, зам хөндлөн гарч явааг явган зорчигчдыг сандралд оруулахгүй байхад анхаарвал зохино.

18. Хөдөлгөөнийг зохицуулахдаа гал унтраах, эмнэлгийн түргэн тусламж, цагдаагийн шуурхай албаны болон ослын дуудлагын авто машин, хамгаалалтын хөтөч авто машинтай цуваг эхлэн нэвтрүүлнэ.

19. Замын уулзвар, хэсэгт хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио ажиллаж байгаа тохиолдолд уулзвар хэсгээс 150-200 метрийн зайнд явж хөдөлгөөнд ажиглалт, зохицуулалт хийж болно.

20. Замын хөдөлгөөн ихтэй хэсэгт хүүхэд, жагсаалаар яваа хүмүүс, тахир дутуу хүн, өндөр настанг зам хөндлөн гарахад хамгаалалт, зохицуулалт хийж туслалцаалуулнэ.

21.Зам тээврийн осол гарч хөдөлгөөнийг явуулахад хүндрэл учруулсан тохиолдолд буюу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд аюул учруулахаар нүх, гэмтэл, замын гадаргууд гарсан үед хөдөлгөөнийг зохицуулах, түр хугацаагаар хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх буюу хориглож энэ талаар байгууллага, албаны жижүүр, холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, эвдрэл гэмтлийг засуулах арга хэмжээ авна.

ТАВ. Замын хөдөлгөөнд хяналт тавих

22. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн биелэлтийг гудамж замд машин, мотоциклтой болон явганаар ажиглалт хийх замаар хянана.

23. Дор дурьдсан тохиолдолд байцаагч, цагдаа нь тээврийн хэрэгслийн жолоочийг шүгэлдэн дохиур модоор дохиж зогсооно.

а/ хурд хэтрүүлсэн, замын гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэл болон хөдөлгөөний явцад эгнээ байр эзлэх, гүйцэж түрүүлэх, уулзвар нэвтрэх, гэрэл хэрэглэх, хүн ба ачаа тээвэрлэх, жолооны даллага хийх, тээврийн хэрэгслийг чирэх журам зөрчсөн ;

б/ утаа тортог ихтэй, хөдөлгөөнд аюул учруулахаар бүрэн бус машин жолоодож явааг нь илт мэдрэгдэж байгаа болон хог, хаягдал асгаж яваа, түүнчлэн замгүй газраар зорчиж байгаа;

в/ хэрэг, зөрчлийн улмаас марк, дугаар нь зарлагдаж эрэн сурвалжлагдсан;

г/ согтууруулах үндаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явааа сэжигтэй бол;

д/ улсын дугаар, бүртгэлийн зөрчилтэй, техникийн үзлэг, тооллогод ороогүй ;

ж/ жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодож явааа байдал нь бусдын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй;

з/ хулгайн эд зүйл тээвэрлэсэн болон гэмт хэрэг үйлдсэн сэжиглэлтэй бол.

24. Байцаагч, цагдаа нь нэг зэрэг хэт олон тээврийн хэрэгсэл зогсоох, түүнчлэн зөрчил гаргаснаас бусад хүн, машин удаан хугацаагаар хүлээлгэхээс аль болох зайлсхийвэл зохино.

25.Байцаагч, цагдаа нь зогсоосон тээврийн хэрэгсэлд ойртон очиж түүнийг зогсоосон шалтгаан, зөрчлийн байдлаас хамааруулж, цаашдын үйл ажиллагаагаа явуулна.

26. Дор дурьдсан тохиолдолд жолоочийг тээврийн хэрэгслийн бүхээгнээс гарч шалгуулах шаардлага тавина.

а/ Хүн ба ачаа тээвэрлэх дүрэм зөрчсөн болон тээврийн хэрэгслийн техникийн гэмтлийг арилгах;

б/ жолооч согтуу байгаа хангалттай үндэслэл байвал;

в/ тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, арлын дугаарыг жолоочийг байлцуулан тулгаж үзэх;

г/ тээврийн хэрэгсэл болон ачаанд (ачааны автомашины тэвш, суудлын автомашины арын суудал болон тээшийн хөндийд хулгайн эд зүйл зөөвөрлөн яваа эсэхийг шалгах зорилгоор) үзлэг хийх;

д/ жолооч болон зорчиж яваа хүн гэмт хэрэгт сэжиглэгдсэн.

27. Байцаагч, цагдаа нь тээврийн хэрэгслийг зогсоосон үндэслэлээ жолоочид заавал хэлж, жолоочийн үнэмлэх, талон автомашины техникийн гэрчилгээг үзэж, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн техникийн байдал, ачиж явааа ачаа, сууж явааа хүний бичиг баримтыг шалгана.

Зөрчил гаргасан жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн бичиг баримтыг уг зөрчлийг шийдвэрлэсний дараа буцааж өгнө.

28. Байцаагч, цагдаагаас өгсөн ойлгогдохуйц дохиог биелүүлээгүй зугатаасан тээврийн хэрэгслийг радио станцаар зарлан мэдээлнэ.

Хэрэв тээврийн хэрэгслийг хөөж зогсоох бол өөрийгөө болон бусдыг осол, аюулд өртөхгүй байх шаардлагатай арга хэмжээ авч ямар марк, дугаартай тээврийн хэрэгслийг, ямар тээврийн хэрэгслээр, хэдийд, аль чиглэлд хөөж яваа талаар шуурхай жижүүр, хяналтын цэгүүд, цагдаагийн байгууллагуудад мэдэгдэнэ.

29. Замын цагдаагийн байцаагч нь дор дурьдсан асуудлаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдэгдэл, амаар болон бичгээр шаардлага тавих үүрэгтэй.

а/ хариуцсан хэсэгт замын гадаргуу гэмтэж нүх, эвдрэл үүссэн;

/ худагны таг унасан гэх мэт/

б/ замын гэрэл дохио асахгүй буюу хагас дутуу асдаг болсон болон бусад гэмтэл эвдрэл үүссэн;

в/ замын тэмдэг гэмтэж хазайсан, унасан, халхлагдсан, будаг нь холцорсон, замын тэмдэглэл гэмтсэн;

г/ замын гэрэлтүүлэг эвдэрч гэмтсэн;

д/ замд цас, мөс тогтож хальтиргаа гулгаа үүссэн ;

е/ зам дээр буюу түүний ойролцоо барилга, байгууламж барих, худалдаа үйлчилгээ, уралдаан тэмцээн явуулж буй үйл ажиллагаа нь хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэхгүй байвал;

ж/ тээврийн хэрэгсэл нь техникийн стандартын шаардлагыг хангахгүй бол;

з/ авто зам түүний хиймэл байгууламжийг барих, засварлах, өргөтгөх ажил нь стандартын шаардлага хангахгүй байвал;

и/ аж ахуйн нэгж, байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг ажиллагсдад болон суралцагсаддаа судлуулах, сурталчлуулах талаар;

Байцаагч нь аж ахуйн нэгж, байгууллагаас ажиллагсад болон суралцагсдаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг судлуулах болон зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиохд арга зүйн тусламжаа үзүүлж болно.

30. Замын хөдөлгөөнийг зохицуулах, хянаж шалгах үед байцаагч, цагдаа нь өөрийн болон хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

а/хөдөлгөөнд оролцогчдод ил тод харагдах газрыг сонгон авч зохицуулалт хяналтаа явуулах;

б/ явган эргүүл нь замын захаар, зайлшгүй шаардлагатай үед замын голоор тусгаарлах зурвасаар явж ажиглалт хийх;

в/ иргэнийг зөвхөн замын гадна талд урьж уулзаж байх;

г/ харанхуй , үзэгдэх орчин хязгаарлагдмал болон хальтиргаа гулгаатай үед замын голд зогсож зохицуулалт хийхгүй байх;

д/ шөнийн эзлэхнд ажиллах байцаагч, цагдаа нар нэг цагаас доошгүй хугацаанд байгууллага, албаны жижүүртэй холбоо барьж, нөхцөл байдлыг илтгэж мэдээлж байх.

е/ эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгсэл, гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг илрүүлэн шалгаж, үзлэг хийхдээ гэнэтийн дайралт, довтолгооноос хамгаалах арга хэмжээ авах;

ЗУРГАА. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг шийдвэрлэх

31. Замын хөдөлгөөнд оролцогчдоос хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний Дүрэм зөрчсөн нь нотлогдвол зөрчил гаргагчдад хууль тогтоомжийн ямар заалтыг зөрчөөн, захиргааны хариуцлагын тухай хуулийн аль заалтаар, ямар шийтгэл ногдуулах талаар тайлбарлаж өгнө.

32. Хэрэв уг зөрчлийг байцаагч, цагдаа эрх хэмжээний хүрээнд газар дээр нь шийдвэрлэх боломжтой бол амаар сануулах, талон цоолох, торгох шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

Зөрчил гаргагчийн овог нэр, ажлын болон гэрийн хаяг, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, гаргасан зөрчлийн товч утга, хуулийн ямар заалтаар ямар шийтгэл ногдуулсан талаар өөрөө бичиж зөрчил гаргагчаар гарын үсэг зуруулна.

33. Жолооч, зорчигчид хууль заасны дагуу шийтгэл ногдуулах бол түүний хэмжээг зөрчлийн хүнд, хөнгөн, зөрчил гаргагчийн хувийн байдалд тохируулан тогтооно.

34. Дор дурьдсан зөрчилтэй жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулна.

а/ зам тээврийн осол, хэрэг гаргасан; /шаардлагатай тохиолдолд /

б/ согтуугаар буюу үнэмлэхгүйгээр автомашин жолоодсон ;

в/ хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй ноцтой бүрэн бус;

г/ улсын дугааргүй буюу дугаарын зөрчилтэй, үзлэг тооллогод ороогүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй;

д/ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхээс эрэн сурвалжилж байгаа;

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоныг түр саатуулах бол жолоодох эрх бүхий алба хаагчаар, бусад тохиолдолд уг тээврийн хэрэгслийг жолооч оор өөрөөр нь жолоодуулан түр саатуулах байранд шууд хүргэнэ.

Түр саатуулсан тээврийн хэрэгслийн талаар байцаагч, цагдаа цагдаагийн байгууллага, албаны ерөнхий жижүүрт танилцуулж түүний шийдвэрээр ажиллана.

35. Зөрчил гаргагч өөрийн буруу, цагдаагийн тайлбарыг ойлгохгүй тохиолдолд түүнд тайвшрах хугацаа, тайлбарлах боломж олгоно.

Хэрэв гаргасан зөрчил, цагдаагийн шаардлагыг ойлгохгүй, илт эсэргүүцэж байвал энэ талаар эргүүлийн ахлагч, тасаг, хэсгийн даргад илтгэж шийдвэрлүүлнэ.

36.Талон гурван удаа цоологдсон, мөн зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх боломжгүй тохиолдолд байцаагч, цагдаа үнэмлэх, талоныг хурааж энэ тухай тасалбар / хавсралт 3/ заавал олгоно. Үнэмлэх, талон хураасан тасалбараар тээврийн хэрэгсэл жолоодож болохгүй, эвөхөн граж, зогсоолд хүргэж болно.

37. Дор дурьдсан тохиолдолд тээврийн хэрэгслийг дайчилж болно.

а/ хүнд, онц хүнд гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт үүрэг томилолтын дагуу албан үүрэг гүйцэтгэхээр хүрэлцэн очих;

б/ гэмт хэрэгтнийг мөрдөн хөөх, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүнийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх;

Энэ зүйлийн а, б -д заасан тохиолдолд тээврийн хэрэгсэл дайчлан ашиглах бол тэр тухай цагдаагийн тухайн байгууллага, албаны дарга, ерөнхий жижүүрт мэдэгдэнэ.

38. Авто тээврийн хэрэгслийг дайчлан ашигласан алба хаагч хэдийд, хэний шийдвэрээр, ямар тээврийн хэрэгслийг, ямар хугацаанд, хаанаас хаа хүртэл, хэдэн километрт дайчилж ашигласан талаар тэмдэглэл /хавсралт 2/ -ийг хоёр хувь бичиж өөрийн албан тушаал, цол, нэр, гарын үсгийг гаргатай бичиж нэг хувийг жолоочид өгч, нөгөө хувийг анги , байгууллагын даргад танилцуулна.

39. Цагдаагийн байгууллага, албаны дарга бусдын авто тээврийн хэрэгслийг дайчлан ашигласан үндэслэлийг хянан үзэж дайчилснаас гарсан шууд зардлыг жолоочид олгох асуудлыг шийдвэрлэнэ.

ДОЛОО. Зам тээврийн осол гарсан үед гүйцэтгэх ажиллагаа

40. Хариуцсан гудамж, зам талбай, чиглэлд гарсан зам тээврийн ослын тухай байгуллага албаны жижүүрт мэдэгдэж, хэргийн газарт яаралтай очно.

41. Зам тээврийн ослын газар жижүүрийн бүрэлдэхүүн ирэх хүртэл доорхи арга хэмжээг авна.

а/ осолд нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хохирогчийн овог нэр, ажлын болон гэрийн хаягийг тэмдэглэж авах;

б/ эмнэлгийн түргэн тусламж дуудах. Түргэн тусламж дуудах боломжгүй нөхцөлд замын дагуу яваа тээврийн хэрэгслээр аль ойр байгаа эмнэлгийн газарт хүргүүлнэ.

Хохирогчийг суулгаж явуулсан тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, жолоочийн овог нэр, ажлын болон гэрийн хаягийг тэмдэглэж авах;

в/ ослын улмаас замын хөдөлгөөн хаагдаж, боогдоход хүрвэл осолд холбогдогчийг болон хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан тээврийн хэрэгслийг замаас зайлуулж мөрийг хамгаалж хөдөлгөөнийг тойруулж явуулах;

г/ осолд холбогдсон жолооч, зорчигчийн овог нэр, ажил ба гэрийн хаягийг тогтоож, баримт бичгийг хураан авч, ослын газрын үзлэгт байлцуулах;

д/ ослын байдлыг харсан гэрчүүдийг олж тогтоон тэдний тухай мэдээллийг тэмдэглэж авах;

е/ осолд холбогдол бүхий эд мөрийн баримт, бусад зүйлийг хамгаалах;

ж/ жижүүрийн бүрэлдэхүүнд осолд холбогдсон хүмүүс, гэрчүүдийн тухай мэдээлэл, тэдгээрийн баримт бичиг, ослын газрын эд мөрийн баримт болох зүйлсийг хүлээлгэн өгөх;

з/ жолооч ослын газраас нуугдан зайлсан тохиолдолд түүний зугатсан байж болох чиглэл, машины марк, улсын дугаар, өнгө, бусад содон тэмдгийг гэрч, хохирогчийн тусламжтайгаар тодруулан тэмдэглэж, ерөнхий жижүүр, эргүүл зарлан мэдээлж, энэ тухай мэдээллийг хэргийн газарт очсон жижүүрийн бүрэлдэхүүнд өгч, цаашид жижүүрийн зааврааар ажиллана.

НАЙМ. Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах ажиллагаа

42.Байцаагч, цагдаа нь замын хөдөлгөөн зохицуулах, хянаж шалгах явцдаа зам тээврийн осол, хэргийн газраас зугатан нуугдсан этгээд, хулгайлагдсан болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн байгууллагаас саатуулахаар зарласан тээврийн хэрэгслийг илрүүлэх арга хэмжээг ерөнхий жижүүрийн удирдлага дор хэрэгжүүлнэ.

43.Эрэн сурвалжлах ажиллагааг хариуцсан гудамж зам, талбай, чиглэл, хяналтын цэгийн ойролцоо байгаа хэв журмын цагдаагийн алба хаагч болон цагдаагийн туслах ажилтанд мэдээллийг өгч хамтран ажиллах замаар гүйцэтгэнэ.

44. Эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгсэлтэй адил төстэй тээврийн хэрэгслийг зогсоон марк,улсын дугаар,

өнгө , арал, хөдөлгүүр, бүхээгний дугаар, тээж явааа ачаа тээш, бусад баримт бичигтэй нь тулган шалгана.

45. Хариуцсан сум, хороо, хороолол, гудамж замд хулгайлагдсан тээврийн хэрэгсэл, зам тээврийн эзэнгүй осол, хэргийн холбогдогчийг илрүүлэх боломжтой арга хэмжээг нэн даруй авна.

ЕС. Хамгаалалтын үүрэг гүйцэтгэх ажиллагаа

46. Байцаагч, цагдаа нь төрийн тусгай хамгаалалтын үүргийг гүйцэтгэхдээ хамгаалуулагчийн талаар тодорхой мэдээлэл авч, 1 дүгээр зэрэглэлийн хамгаалалтад нэг цагийн өмнө, 2,3 дугаар зэрэглэлийн хамгаалалтад 30 минутын өмнө хуваарилагдсан маршрут, цэгт очиж байраа эзэлсэн байна.

47. Байцаагч, цагдаа нь ажиллах зам, маршрут, цэгийн замын нөхцөл, хөдөлгөөний байдалд үнэлэлт, дүгнэлт өгч хамгаалуулагчийн явж өнгөрөх зам, зогсох талбайн хөдөлгөөнд учирч болзошгүй саад бэрхшээлийг урьдчилан арилгах, арилгах боломжгүй нүх гарсан, зам эвдэрч, гэмтсэн тохиолдолд тухайн хамгаалалт удирдах байгаа албан тушаалтанд илтгэж түүний шийдвэрээр ажиллана.

48. Хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа байцаагч, цагдаа нь радио станцаар болон нүдэн баримжаа, шүгэлийн дуугаар хоорондоо холбоотой байж хөдөлгөөнийг цаг тухайд нь шуурхай, аюулгүй зохицуулна.

49. Хамгаалуулах цуваа (жагсаал) ойртон ирэхийн өмнө байцаагч, цагдаа нь хариуцсан маршрут, цэгтээ зогсох байрлалаа зөв сонгож тухайн зам, маршрут, цэгийн явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн чөлөөлсөний дараа, улмаар хөдөлгөөнийг хааж, зохицуулна.

Хөдөлгөөнийг хаах дохиог дохиур мод, шүгэлийн тусламжтайгаар хөдөлгөөнд оролцогчдод ойлгодохуйцаар өгөх бөгөөд тээврийн хэрэгсэл огцом зогсоох, явган зорчигдыг гэнэт сандрал, цочролд оруулахгүй байвал зохино.

50. Хамгаалалтын цуваа (жагсаал) явж өнгөрсний дараа явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг биечлэн зохицуулж тухайн зам, уулзвар, хэсгийн хөдөлгөөнийг бүрэн сийрэгжүүлнэ.

51. Хамгаалалт, зохицуулалтын үүрэг гүйцэтгэж байхдаа шаардлагагүй үед тээврийн хэрэгсэл зогсоохыг хориглоно.

Хэрэв зогсоох шаардлага гарвал замын зорчих хэсгийг бүрэн чөлөөлүүлж, жолоочийг өөр дээрээ дуудан шалгах бөгөөд зогсолгүй явсан тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийн марк, дугаар, өнгийг тэмдэглэн авч радио станцаар зарлан саатуулж зөрчлийн асуудлыг шийдвэрлэнэ.

Харин хамгаалалтын үүрэг гүйцэтгэх явцад тээврийн хэрэгслийг хөөхийг хориглоно.

52. Хамгаалалтын үед шаардлагатай гэж үзвэл уулзвар, гарцыг овор ихтэй тээврийн хэрэгслээр хааж болох бөгөөд энэ үед жолоочийг бүхээгээс гаргаж машиных нь дэргэд зогсооно.

53. Шөнийн цагт хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа байцаагч,цагдаа нь гэрэлтэй эрээн мод, цацруулагч бүхий өмсгөл, бусад хэрэгсэл ашиглан өөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Замын хөдөлгөөн зохицуулах,
хянаж шалгах журмын хавсралт № 1

ЗАМЫН ЦАГДААГИЙН БАЙЦААГЧИЙН ХӨТЛӨХ СУДАЛГАА, БҮРТГЭЛ

1. Хариуцсан объект,гудамж, зам чиглэлийн хил хязгаар хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэлийг үзүүлсэн зураг бүдүүвч;

2. Тээврийн хэрэгсэл бухий болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, авто засварын цэгийн байршлын судалгаа;

3. Цагдаагийн туслах ажилтан, тэдний ажлын тооцоо бүртгэл;

4. Хариуцсан объект, чиглэлийн гудамж замд гарсан зам тээврийн осол, хэрэг, түүний шалтгаан нөхцөлийн судалгаа;

5.Дэвсгэрийн автомашин бухий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс үйлдсэн зам тээврийн осол, хохирсон хүний бүртгэл судалгаа;

6. Илрүүлсэн хэрэг, зөрчлийн бүртгэл;

7. Өргөдөл, гомдол, мэдээлэл, захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэсэн бүртгэл;

8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын бүртгэл.

Замын хөдөлгөөн зохицуулах,
хянан шалгах журмын хавсралт№ 2

АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ ДАЙЧИЛЖ АШИГЛАСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

---------- ---------- аймаг / дүүрэг / - ийн цагдаагийн газар,
хэлтсийн ----------
/ албан тушаал / / цол /
---------- овогтой ---------- ---------- би 19---
оны ----------сарын ------- ний өдрийн ----------цаг ---- -----минутаас --------өдрийн -------- цаг
---- минут хүртэл ----------
үүрэг гүйцэтгэхээр / ямар зорилгоор / ----------
маркийн ---------- улсын дугаартай ----------
---------- ----------жолоочтой автомашиныг дайчлан ашиглаж ----------
---

/ хаанаас хаана хүртэл, хэдэн км явсан /
---------- км явсан болно.

Тэмдэглэл хийсэн ----------

Жолооч ----------
Тэмдэглэлтэй танилцаж, хянасан
дарга ---------- / /
Тээврийн хөлс төлсөн тухай байгууллагын санхүүгийн тэмдэглэл ----------
---

Тэмдэг, гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407